



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

**УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БАЙГАЛЬ ОРЧИН,
НИЙГМИЙН СТРАТЕГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ
ЭЦСИЙН ТАЙЛАН**

**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БАЙГАЛЬ
ОРЧИН, НИЙГМИЙН СТРАТЕГИЙН ҮНЭЛГЭЭ**

2014 оны 9 сар



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БАЙГАЛЬ ОРЧИН,
НИЙГМИЙН СТРАТЕГИЙН ҮНЭЛГЭЭ**

**БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН СТРАТЕГИЙН
ҮНЭЛГЭЭНИЙ ЭЦСИЙН ТАЙЛАН**



Энэхүү тайланг Монгол Улсын

Уул уурхайн яам болон

Дэлхийн банканд зориулан

Састэйнабилити Ийст Эйжия ХХК

боловсруулав.



WORLD BANK

2014 оны 9 сар



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

- Төслийг хэрэгжүүлэгч:** Састэйнабилити Ийст Эйжия ХХК
- Төслийн удирдагч:** Док. Дэвид Аннандэйл, Байгаль орчин, нийгмийн зөвлөх
- Төслийн менежмент:** Сюзан Жайлс, Гүйцэтгэх захирал, Састэйнабилити Ийст Эйжия ХХК
Б.Баярмаа, Ахлах зөвлөх, Састэйнабилити Ийст Эйжия ХХК
- Төслийн санхүүжилт:** Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техникийн туслалцааны төсөл (MSISTAP)
Дэлхийн банк
Монгол Улсын Засгийн газар

Ишлэл: Састэйнабилити Ийст Эйжия ХХК. 2014. Монгол Улсын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ. Уул уурхайн яам. Улаанбаатар хот, Монгол Улс.

Нэмэлт мэдээлэл:

Дэвид Аннандэйл

Байгаль орчин, нийгмийн зөвлөх

Имэйл: ddannandale@gmail.com

Сюзан Жайлс

Гүйцэтгэх захирал, Састэйнабилити Ийст Эйжия ХХК

501 Сан Бизнес Төв, Ерөнхий сайд Амарын гудамж 29,

Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Улаанбаатар хот, Монгол Улс

Утас: +976 7011 4921

Имэйл: susan.giles@sustainability.net.au

Бямбаагийн Баярмаа

Ахлах зөвлөх, Састэйнабилити Ийст Эйжия ХХК

501 Сан Бизнес Төв, Ерөнхий сайд Амарын гудамж 29,

Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Улаанбаатар хот, Монгол Улс

Утас: +976 7011 4921

Имэйл: bayarmaa.b@sustainability.net.au



ТАЛАРХАЛ

Монгол Улсын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ (БОНСУ)-г амжилттай гүйцэтгэж дуусгахад олон хувь хүн, албан байгууллага цаг хугацаа, мэдлэг, боломжоо дайчлан хамтран ажилласан билээ.

Юуны өмнө энэхүү үнэлгээг гүйцэтгэх явцад туслалцаа үзүүлж, мэдээллээр ханган, санал, бодлоо хуваалцсан Дэлхийн банк, Уул уурхайн яам, Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техникийн туслалцааны төслийн нийт мэргэжилтнүүдэд талархал илэрхийлье.

БОНСУ-ий багийн хамт олноос төслийг хэрэгжүүлэх хугацаанд зохион байгуулагдсан бүхий л хэлэлцүүлэг, уулзалтуудад өөрсдийн цаг заваа харамгүй зарцуулан оролцсон төрийн болон иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн төлөөллүүдэд мөн гүн талархал илэрхийлж байна. Нийгэмд тулгамдаад буй олон асуудлыг тусгасан, олон нийтийн хүсэл эрмэлзлийг шингээсэн БОНСУ-г гүйцэтгэхэд эдгээр хэлэлцүүлэг, уулзалтуудаас гарсан санал сэтгэгдэл, мэдлэг мэдээлэл нь манай багийн ажилд ихээхэн хувь нэмэр оруулсан юм. Энэ бүх мэдээлэл, оролцоогүйгээр БОНСУ үр дүнгүй ажил болох билээ.

Мөн энэхүү БОНСУ-ий багийг өгөгдөл, мэдээллээр ханган тусалсан Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Зам тээврийн яам, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга, Дэ Нэйче Консерванси (TNC), Тогтвортой бичил уурхай төсөл, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар (WWF) болон бусад байгууллагуудад бид талархалаа илэрхийлж байгааг хүлээн авна уу.

Бүсийн хэлэлцүүлгүүдэд идэвхтэй оролцон зохион байгуулалтын ажилд хүн хүч, цаг зав гарган тусалсан явдалд Ховд, Өмнөговь, Дорнод, Орхон аймгууд болон Цогтцэций сумын Засаг даргын Тамгын газруудад бид гүн талархалаа уламжилж байна.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Олборлох үйлдвэрлэлийн асуудал хариуцсан газрын захирал Жон Хобсд төслийн явцад мэргэжлийн зөвлөгөөгөөр ханган ажилласанд мөн талархал илэрхийлье.

Эцэст нь төслийн үйл ажиллагаанд ур чадвараа дайчлан ажилласан Састэйнабилити Ийст Эйжия ХХК-ий мэргэжилтнүүддээ баярласанаа илэрхийлье. Энэхүү тайланг Састэйнабилити Ийст Эйжия ХХК бэлтгэсэн бөгөөд док. Дэвид Аннандэйл үнэлгээг гүйцэтгэх үйл явцыг чиглүүлэн өөрийн үнэ цэнэтэй арга зүйн зааварчилгаагаар хангаж уг тайлангийн үндсэн зохиогчоор ажилласан юм. Сюзан Жайлс, Бямбаагийн Баярмаа, Жон Мираглиотта, Эйми Сэкстон, Катерин Грант, Мөнхтоогогийн Бямбабат, Саха Миянатан, Бямбын Мөнхсүрэн, док. Намжилдоржийн Нямдорж, Загдаагийн Янжинлхам, Баярлхагвын Мөнхжаргал, док. Даен Дуглас нарын олон улсын болон дотоодын зөвлөхүүдээс бүрдсэн судалгааны баг уг төсөл дээр ажилласан ба багийнхандаа дээд зэргийн хамтын хүчин чармайлтынх нь төлөө талархаж буйгаа илэрхийлье.

Сюзан Жайлс

Гүйцэтгэх захирал, Састэйнабилити Ийст Эйжия ХХК



АГУУЛГА

ТАЛАРХАЛ	I
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	I
ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ	II
ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	II
БОНСУ-ИЙН ЗОРИЛГО	II
БОНСУ-ИЙ АРГАЧЛАЛ	III
ОРОЛЦООНЫ ҮЙЛ ЯВЦ	IV
МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ	V
УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ӨСӨЛТИЙН ХУВИЛБАНУУД	VI
Дундаж өсөлттэй хувилбар	vi
Өндөр өсөлттэй хувилбар	vii
Бага өсөлттэй хувилбар	viii
ГОЛ АСУУДЛУУД БА ХОЛБОГДОХ НӨЛӨӨЛӨЛ	XI
Гол асуудлууд	xi
Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн гол нөлөөллүүд.....	xi
БОНСУ-ИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	XVI
ДҮГНЭЛТ	XLIV
1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	1
1.1 СУУРЬ НӨХЦӨЛ БАЙДАЛ	1
1.2 БОНСУ-ИЙ ЗОРИЛГО, БҮТЭЦ	2
1.2.1 БОНСУ-ий ажлын даалгавар	2
1.2.2 БОНСУ-ий зорилго	2
1.2.3 БОНСУ-ий үр дүн	2
1.2.4 ТӨСЛИЙН БАГ	3
1.2.5 УУСИБТТТ	3
1.3 БОНСУ-Г ГҮЙЦЭТГЭХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА	4
1.4 АРГАЧЛАЛ	6
1.5 ОРОЛЦООНЫ ҮЙЛ ЯВЦ	11
1.6 УРЬДЧИЛСАН НӨХЦӨЛ БОЛОН ТӨСЛИЙН ҮР ДҮНГ ХЯЗГААРЛАСАН ХҮЧИН ЗҮЙЛС	15
2. ОДООГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	16
2.1 ТАНИЛЦУУЛГА	16
2.2 МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ	16
2.3 САЛБАРЫН ХӨГЖИЛД НӨЛӨӨЛӨХ БҮС НУТГИЙН БОЛОН ГЛОБАЛ АСУУДЛУУД	18
2.4 АШИГТ МАЛТМАЛЫН ТӨРЛҮҮД БОЛОН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	19
2.5 УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН ИНСТИТУЦУУД	24



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

2.5.1	Танилцуулга	24
2.5.2	Институцийн үүрэг хариуцлагын тойм.....	24
2.5.3	Уул уурхайн салбартай холбогдох байгаль орчин, нийгмийн нөлөөллийг зохицуулах хууль эрх зүй зохицуулалтын орчны тойм	25
2.5.4	Хууль эрх зүйн зохицуулалтын болон институцийн орчны үнэлгээ.....	29
2.6	НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ	30
2.6.1	Байгаль орчны нөхцөл байдал	30
2.6.2	Нийгмийн нөхцөл байдал.....	38
2.6.3	Эдийн засгийн нөхцөл байдал.....	42
2.7	ДҮГНЭЛТ	48
3.	УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХУВИЛБАРУУД	49
3.1	СУУРЬ МЭДЭЭЛЭЛ.....	49
3.2	БОНСУ-Д АВЧ ҮЗСЭН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ХУВИЛБАРУУД.....	53
3.2.1	2025 он хүртэл дундаж өсөлттэй байх хувилбар	54
3.2.2	2025 он хүртэл өндөр өсөлттэй байх хувилбар	60
3.2.3	2025 он хүртэл бага өсөлттэй байх хувилбар.....	65
4.	ГОЛ АСУУДЛУУД БА АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖҮҮД.....	69
4.1	ТАНИЛЦУУЛГА: ХӨГЖЛИЙН ХУВИЛБАР, ГОЛ АСУУДАЛ БОЛОН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ ХООРОНДЫН УЯЛДАА ХОЛБОО	69
4.2	БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭН ТЭРГҮҮНИЙ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД БА ШИЙДВЭРЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖҮҮД	72
4.2.1	Ус	72
4.2.2	Газар ба бэлчээр ашиглалт	81
4.2.3	Агаарын чанар.....	89
4.2.4	Байгаль орчны менежмент.....	95
4.3	НИЙГМИЙН ЭН ТЭРГҮҮНИЙ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД БОЛОН ШИЙДВЭРЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖҮҮД	100
4.3.1	Хувиараа болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа	100
4.3.2	Соёлын өв.....	107
4.3.3	Хүний эрх ба олон нийтийн оролцоо.....	115
4.3.4	Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа.....	124
4.4	ЭДИЙН ЗАСГИЙН ЭН ТЭРГҮҮНИЙ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД БОЛОН ШИЙДВЭРЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖҮҮД	128
4.4.1	Засаглал ба орлогын менежмент	128
4.4.2	Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц	136
4.4.3	Хөдөлмөр эрхлэлт ба ур чадвар	144
4.4.4	Технологи	154
4.5	ДҮГНЭЛТ	158
5.	ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ИНСТИТУЦИ БА ЧАДАВХИЙН ДУТАГДАЛ, СУЛ ТАЛЫГ ТОДОРХОЙЛОХ ДҮН ШИНЖИЛГЭЭ БА БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖҮҮД.....	159
5.1	ОРШИЛ	159
5.2	БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛУУД	160
5.2.1	Ус	160
5.2.2	Газар ба бэлчээр ашиглалт	161
5.2.3	Агаарын чанар.....	164
5.2.4	Байгаль орчны менежмент.....	166



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

5.3	НИЙГМИЙН АСУУДЛУУД	168
5.3.1	Хувиараа болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа	168
5.3.2	Соёлын өв.....	171
5.3.3	Хүний эрх ба олон нийтийн оролцоо.....	171
5.3.4	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа	173
5.4	ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДЛУУД	175
5.4.1	Засаглал ба орлогын менежмент	175
5.4.2	Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц	177
5.4.3	Хөдөлмөр эрхлэлт ба ур чадвар	178
5.4.4	Технологи	179
5.5	ДҮГНЭЛТ	180
6.	ДҮГНЭЛТ БА БОНСУ-ИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	181
6.1	ТАНИЛЦУУЛГА	181
6.2	БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛУУД	182
6.2.1	Ус	182
6.2.2	Газар ба бэлчээр ашиглалт	183
6.2.3	Агаарын чанар	184
6.2.4	Байгаль орны менежмент	184
6.3	БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖҮҮД БА АРГА ХЭМЖЭЭ: НИЙГМИЙН АСУУДЛУУД	185
6.3.1	Хувиараа болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа	185
6.3.2	Соёлын өв.....	186
6.3.3	Хүний эрх ба олон нийтийн оролцоо.....	187
6.3.4	Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа.....	188
6.4	ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДЛУУД	189
6.4.1	Засаглал ба орлогын менежмент	189
6.4.2	Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц	189
6.4.3	Хөдөлмөр эрхлэлт ба ур чадвар	190
6.4.4	Технологи	191
6.5	ДҮГНЭЛТ	191
	АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ӨГӨГДЛИЙН ЖАГСААЛТ	192
A.	АШИГЛАСАН МАТЕРИАЛ	192
B.	ЗУРАГТ АШИГЛАСАН ӨГӨГДЛИЙН ЖАГСААЛТ	196
	ХАВСРАЛТ:	198
	ХАВСРАЛТ А: ОРОЛЦООНЫ ҮЙЛ ЯВЦЫН ТАЛААРХ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ, ТЭМДЭГЛЭЛ	199
	1-Р ҮЕ ШАТ	199
	2-Р ҮЕ ШАТ	206
	Талуудтай зөвлөлдөх бүсийн анхны хэлэлцүүлэг	206
	Талуудтай зөвлөлдөх бүсийн хоёр дахь хэлэлцүүлэг	217
	3, 4-Р ҮЕ ШАТ	232
	Гол талуудтай хийсэн ярилцлага.....	236
	ХАВСРАЛТ В: УУРХАЙН БАЙРШИЛ, ТОО (ӨСӨЛТИЙН ХУВИЛБАР ТУС БҮРЭЭР)	246
	ХАВСРАЛТ С: БОНСУ-ИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	268



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

ХҮСНЭГТ

ТХ-н хүснэгт 1	Эн тэргүүний 12 асуудлууд	xi
ТХ-н хүснэгт 2	БОНСУ-ий Үйл ажиллагааны тайлан	xvii
Хүснэгт 1.1	Талуудтай зөвлөлдөх бүсийн анхны хэлэлцүүлэг явагдсан газрууд.....	12
Хүснэгт 1.2	Талуудтай зөвлөлдөх уулзалтанд оролцсон эмзэг бүлгийн оролцогчид	12
Хүснэгт 2.1	Ашигт малтмалын төрлүүд болон эдгээрийн нөөцийн хэмжээ (2012 оны 1-р сарын 1-ий байдлаар).....	19
Хүснэгт 2.2	Монгол улсын томоохон ашигт малтмалын илрэлүүд	20
Хүснэгт 2.3	Стратегийн ач холбогдолтой ордууд	21
Хүснэгт 2.4	Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарт гарсан ослын тоо.....	42
Хүснэгт 3.1	Монгол улсын эдийн засгийн хөгжлийн хувилбарууд болон хувилбаруудад ашигласан таамаглал, 2014 - 2025.....	49
Хүснэгт 3.2	Дундаж өсөлттэй хувилбарын хүрээнд үйлдвэрлэх ашигт малтмалын тоо хэмжээ, 2013-2025 он	59
Хүснэгт 4.1	Эн тэргүүний 12 асуудлууд	69
Хүснэгт 4.2	Оролцооны явцад болон БОНСУ-ий багийн тодорхойлж үнэлсэн гол асуудлууд	71
Хүснэгт 4.3	Оролцогч талуудын тодорхойлсон усны эн тэргүүний асуудлууд	73
Хүснэгт 4.4	Ус: Арга хэмжээний зөвлөмжүүд	80
Хүснэгт 4.5	Оролцогч талуудын тодорхойлсон газар болон бэлчээр ашиглалттай холбоотой эн тэргүүний асуудлууд	85
Хүснэгт 4.6	Газар ба бэлчээр ашиглалт: Арга хэмжээний зөвлөмжүүд.....	88
Хүснэгт 4.7	Оролцогч талуудын тодорхойлсон агаарын чанартай холбоотой эн тэргүүний асуудлууд	92
Хүснэгт 4.8	Агаарын чанар: Арга хэмжээний зөвлөмжүүд.....	94
Хүснэгт 4.9	Оролцогч талуудын тодорхойлсон уул уурхайн компаниудын байгаль орчны менежментийн эн тэргүүний асуудлууд	96
Хүснэгт 4.10	Байгаль орчны менежмент: Арга хэмжээний зөвлөмжүүд	99
Хүснэгт 4.11	Оролцогч талуудын тодорхойлсон бичил уурхайн холбогдолтой эн тэргүүний асуудлууд	101
Хүснэгт 4.12	Уул уурхайн өндөр болон бага өсөлттэй хувилбарын үеийн хувиараа ашигт малтмал олборлох хөтөлгөч хүчин зүйл болон нөлөөлөл	102
Хүснэгт 4.13	Монгол улсад хувиараа ашигт малтмал олборлож байгаа гол газрууд	104
Хүснэгт 4.14	Бичил уурхай: Арга хэмжээний зөвлөмжүүд.....	106
Хүснэгт 4.15	Археологийн олдворын хураангуй	108
Хүснэгт 4.16	Оролцогч талуудын тодорхойлсон соёлын өвийн эн тэргүүний асуудлууд	110
Хүснэгт 4.17	Соёлын өв: Арга хэмжээний зөвлөмжүүд	114
Хүснэгт 4.18	Оролцогч талуудын тодорхойлсон хүний эрх ба олон нийтийн оролцоотой холбоотой эн тэргүүний асуудлууд	120
Хүснэгт 4.19	Хүний эрх ба олон нийтийн оролцоо: Арга хэмжээний зөвлөмжүүд	123
Хүснэгт 4.20	Оролцогч талуудын тодорхойлсон эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаатай холбоотой эн тэргүүний асуудлууд	125
Хүснэгт 4.21	Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа: Арга хэмжээний зөвлөмжүүд	127
Хүснэгт 4.22	Оролцогч талуудын тодорхойлсон засаглал, орлогын менежменттэй холбоотой эн тэргүүний асуудлууд	130
Хүснэгт 4.23	Засаглал ба орлогын менежмент : Арга хэмжээний зөвлөмжүүд	135
Хүснэгт 4.24	Оролцогч талуудын тодорхойлсон бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэцтэй холбоотой эн тэргүүний асуудлууд.....	138
Хүснэгт 4.25	Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц: Арга хэмжээний зөвлөмжүүд	143
Хүснэгт 4.26	Оролцогч талуудын тодорхойлсон хөдөлмөр эрхлэлт ба ур чадвартай холбоотой эн тэргүүний асуудлууд	149
Хүснэгт 4.27	Хөдөлмөр эрхлэлт ба ур чадвар: Арга хэмжээний зөвлөмжүүд.....	153



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

Хүснэгт 4.28	Оролцогч талуудын тодорхойлсон технологитой холбоотой эн тэргүүний асуудлууд	156
Хүснэгт 4.29	Технологи: Арга хэмжээний зөвлөмжүүд.....	157
Хүснэгт 5.1	Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Ус	161
Хүснэгт 5.2	Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Газар ба бэлчээр ашиглалт	162
Хүснэгт 5.3	Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Агаарын чанар.....	165
Хүснэгт 5.4	Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Байгаль орчны менежмент.....	167
Хүснэгт 5.5	Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Бичил уурхай.....	170
Хүснэгт 5.6	Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Хүний эрх ба олон нийтийн оролцоо	172
Хүснэгт 5.7	Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа	174
Хүснэгт 5.8	Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Засаглал ба орлогын менежмент.....	176
Хүснэгт 5.9	Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц	177
Хүснэгт 5.10	Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Хөдөлмөр эрхлэлт ба ур чадвар	179
Хүснэгт 6.1	Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Ус	182
Хүснэгт 6.2	Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Газар ба бэлчээр ашиглалт.....	183
Хүснэгт 6.3	Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Агаарын чанар	184
Хүснэгт 6.4	Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Байгаль орчны менежмент	185
Хүснэгт 6.5	Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Бичил уурхай	186
Хүснэгт 6.6	Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Хүний эрх ба олон нийтийн оролцоо	188
Хүснэгт 6.7	Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа.....	188
Хүснэгт 6.8	Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Засаглал ба орлогын менежмент	189
Хүснэгт 6.9	Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц	190
Хүснэгт 6.10	Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Хөдөлмөр эрхлэлт ба ур чадвар	190
Хавсралтын хүснэгт А.1	Уулзалтанд оролцогчдын нэрс	202
Хавсралтын хүснэгт А.2	Талуудтай зөвлөлдөх бүсийн анхны хэлэлцүүлэг явагдсан газрууд	206
Хавсралтын хүснэгт А.3	Талуудтай зөвлөлдөх бүсийн анхны хэлэлцүүлэгт оролцогсдын тоо.....	206
Хавсралтын хүснэгт А.4	Улс, аймаг, сумын түвшинд нийтлэг байгаа эерэг болон сөрөг эн тэргүүний асуудлууд	210
Хавсралтын хүснэгт А.5	Талуудтай зөвлөлдөх бүсийн хоёр дахь хэлэлцүүлэгт оролцогсдын тоо.....	217
Хавсралтын хүснэгт А.6	Талуудтай зөвлөлдөх бүсийн хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр оролцогчдоос ирүүлсэн саналууд.....	220
Хавсралтын хүснэгт В.1	Улсын хэмжээнд өсөлтийн хувилбар тус бүрийн хувьд 2025 он хүртэл үйл ажиллагаа явуулах уурхайн тоо, ашигт малтмалын төрлөөр	246
Хавсралтын хүснэгт В.2	Бага өсөлтийн хувилбарын хувьд 2025 он хүртэл үйл ажиллагаа явуулах уурхайн тоо ба төрөл, аймаг тус бүрээр	248
Хавсралтын хүснэгт В.3	Дундаж өсөлтийн хувилбарын хувьд 2025 он хүртэл үйл ажиллагаа явуулах уурхайн тоо ба төрөл, аймаг тус бүрээр	249



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

Хавсралтын хүснэгт В.4	Өндөр өсөлтийн хувилбарын хувьд 2025 он хүртэл үйл ажиллагаа явуулах уурхайн тоо ба төрөл, аймаг тус бүрээр	250
Хавсралтын хүснэгт В.5	Бага өсөлтийн хувилбарын хувьд 2025 он хүртэл үйл ажиллагаа явуулах уурхайн тоо ба төрөл, сум тус бүрээр.....	252
Хавсралтын хүснэгт В.6	Дундаж өсөлтийн хувилбарын хувьд 2025 он хүртэл үйл ажиллагаа явуулах уурхайн тоо ба төрөл, сум тус бүрээр.....	254
Хавсралтын хүснэгт В.7	Өндөр өсөлтийн хувилбарын хувьд 2025 он хүртэл үйл ажиллагаа явуулах уурхайн тоо ба төрөл, сум тус бүрээр.....	260

ЗУРАГ

ТХ-н зураг 1	Хувилбар бүрийн хувьд бий болох байгаль орчин, нийгмийн нөлөөлөл	iv
ТХ-н зураг 2	Дундаж өсөлттэй хувилбар, 2025	ix
ТХ-н зураг 3	Өндөр өсөлттэй хувилбар, 2025	x
ТХ-н зураг 4	Бага өсөлттэй хувилбар, 2025	x
Зураг 1.1	БОНСУ-ий аргачлал, шат дараалал	9
Зураг 1.2	БОНСУ-ий үйл явц БОНХЯ-аас баталсан БОСУ хийх аргачлалтай уялдах нь.....	10
Зураг 2.1	Монгол улсын стратегийн ач холбогдолтой ордуудын байршил.....	21
Зураг 2.2	Экспортын хэмжээ (2012, %)	23
Зураг 2.3	Газрын доорх усны ашиглалтын баримжаат нөөц	32
Зураг 2.4	Малчдын худаг болон лицензийн талбай, Дорноговь аймаг	33
Зураг 2.5	Хамгаалалттай болон хамгаалалтанд авахаар санал болгож буй газрууд	34
Зураг 2.6	Газар ашиглалтын байдал.....	35
Зураг 2.7	Ашигт малтмалын салбараас олсон орлого болон улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэгийн харьцуулалт, аймгийн түвшинд	44
Зураг 2.8	Уул уурхайн салбарт ажиллагсад болон ажилгүйдлийн түвшин	46
Зураг 2.9	Шилжин ирэгсэд болон дэд бүтцийн хүртээмж	47
Зураг 3.1	БОНСУ-нд авч үзсэн уул уурхайн салбарын хөгжлийн хувилбарууд	53
Зураг 3.2	Дундаж өсөлтийн хувилбарыг харуулсан зураг	57
Зураг 3.3	Өндөр өсөлтийн хувилбарыг харуулсан зураг	63
Зураг 3.4	Бага өсөлтийн хувилбарыг харуулсан зураг	67
Зураг 4.1	Хувилбар бүрийн хувьд бий болох нөлөөлөл, уялдаа холбоо	69
Зураг 4.2	Мэдэгдэж байгаа усны нөөц ба уурхайд шаардагдах усны эрэлт хэрэгцээ	77
Зураг 4.3	Уул уурхайн үйл ажиллагаа явагдаж болзошгүй хамгаалагдсан болон хамгаалахаар санал болгож буй газрууд.....	83
Зураг 4.4	Уул уурхайн үйл ажиллагаа явагдаж болзошгүй бэлчээрийн газар	84
Зураг 4.5	Бичил уурхай болон газар олголт, ашиглалт.....	104
Зураг 4.6	Аймгийн түвшинд уурхайн тоо, хөгжлийн хувилбар тус бүрээр.....	111
Зураг 4.7	Дэд бүтцэд бүрэн хамрагдсан хүм ам	136
Зураг 4.8	Хамгаалалттай газар нутаг ба одоогийн болон төлөвлөж буй шугаман дэд бүтэц	137
Зураг 5.1	Эн тэргүүний асуудлууд, арга хэмжээний зөвлөмж, сул тал, бодлогын зөвлөмжүүд хоорондын уялдааг харуулсан жишээ.....	159
Хавсралтын зураг А.1	Хэлэлцүүлэгт ашигласан газрын зургийн жишээ	231
Хавсралтын зураг В.1	Өсөлтийн хувилбар тус бүрийн хувьд 2025 он хүртэл үйл ажиллагаа явуулах уурхайн тоо, аймгийн хэмжээнд	247



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

ШИГТГЭЭ

Шигтгээ 1.1	БОНСУ-д эрсдэлийг үнэлэх нь	4
Шигтгээ 1.2	Капиталын төрөл	7
Хавсралтын шигтгээ А.1	Хөгжлийн хувилбарыг харуулсан газрын зурагт орсон мэдээлэл	219

ФОТО ЗУРАГ

Фото зураг 1.1	Ховд хотод зохиогдсон хэлэлцүүлэгт оролцогчид байгаль орчин, нийгмийн асуудлуудын талаар ярилцаж, эрэмбэлж байгаа нь.....	12
Фото зураг 1.2	Төслийн үр дүнг хэлэлцэх үндэсний зөвлөлдөх уулзалт	14
Фото зураг 2.1	Оюу Толгойн ил уурхайн үйл ажиллагаа.....	22
Хавсралтын фото зураг А.1	Улаанбаатар, Чойбалсан хотуудад болсон хэлэлцүүлэг.....	207
Хавсралтын фото зураг А.2	Хэлэлцүүлэгт оролцогчид хөгжлийн хувилбаруудын талаар ярилцаж байгаа нь	218



ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АМГ	Ашигт малтмалын газар
АХБ	Азийн хөгжлийн банк
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОНБНУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
БОНУ	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
БОНСУ	Байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БОСУ	Байгаль орчны стратегийн үнэлгээ
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГХГЗЗГ	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДБ	Дэлхийн банк
ДБХС	Дэлхийн байгаль хамгаалах сан
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
ЗГ	Монгол Улсын Засгийн газар
ЗТЯ	Зам, тээврийн яам
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
НОТ	Нийтийн он тоолол
НОТӨ	Нийтийн он тооллын өмнө
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
ОУВС	Олон улсын валютын сан
Састэйнабилити	Састэйнабилити Ийст Эйжия ХХК
ССАЖЯ	Спорт, соёл, аялал жуулчлалын яам
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
УУСИБТТТ	Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техникийн туслалцааны төсөл
УУЯ	Уул уурхайн яам
ҮХААЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
ХУУС	Хариуцлагатай уул уурхайн санаачилга
ХЯ	Хөдөлмөрийн яам
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
ЭМАА	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
ЭМААБО	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Энэхүү Тайлангийн хураангуй (ТХ)-д тус байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ (БОНСУ)-ий гол агуулгыг хураангуй хэлбэрээр нэгтгэн харуулсан ба төслийн ерөнхий агуулга, үнэлгээний зорилтууд, үнэлгээг гүйцэтгэсэн аргачлал, оролцооны үйл явц, өсөлтийн хувилбарууд, байгаль орчин, нийгмийн гол асуудлууд болон эдгээрийг шийдвэрлэх БОНСУ-ий багийн тодорхойлсон бодлогын зөвлөмжүүдийг тусгасан болно.

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол улсад уул уурхайн салбар хурдацтай хөгжиж байна. Уул уурхайн салбар нь Монгол улсын хөгжлийн суурь, эх үүсвэр бөгөөд ирээдүйд мөн энэ хандлага үргэлжлэх төлөвтэй байгаа ч уул уурхайн салбарын хөгжил нь Монгол улсын хөгжилд, түүнчлэн монголчуудын амьдралд яаж нөлөөлөх талаар тодорхой санал нийлсэн алсын хараа харагдахгүй байгаа юм. Энэ асуудалд хариу өгөхөөр Монгол улсын Засгийн газар нь Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээний төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн ба тус үнэлгээ нь байгаль орчин, нийгмийн асуудлыг уул уурхайн салбарын шинэчлэлд тусгах замаар Монгол улсын урт удаан хугацааны хөгжилд хувь нэмэр оруулна гэж үзэж байна. 2013 оны 10-р сард эхлэн 2014 оны 8 сард дууссан энэхүү үнэлгээг Састэйнабилити Ийст Эйжия ХХК гүйцэтгэсэн болно.

БОНСУ-ИЙН ЗОРИЛГО

Уг БОНСУ-ий гол зорилго нь Монгол улсын тогтвортой бөгөөд олон нийтийн оролцоотой хөгжилд уул уурхайн салбарын гүйцэтгэх үүргийн талаар нийтлэг ойлголтыг дээшлүүлэх, уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах, бодлогын хүрээнд гарч буй өөрчлөлтүүдийг мэдээлэх, Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд уул уурхайн салбарын гүйцэтгэх үүрэг, хувь нэмрийг өсгөх талаар Засгийн газраас гаргаж буй хүчин чармайлтанд дэмжлэг үзүүлэх явдал ба тодорхой зорилтуудыг дурдвал:

- Монгол улсын уул уурхайн салбарын хурдацтай өсөлттэй холбоотой байгаль орчин, нийгмийн гол гол асуудлууд болон боломжуудыг тодорхойлох.
- Уул уурхайн үйл ажиллагаа, холбогдох дэд бүтцийн хөгжилтэй холбоотой байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулж, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх бодлого, хууль эрх зүй, зохицуулалт, бүтцийн өөрчлөлт, чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг тодорхойлох.
- Монгол улсын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг сайжруулахад Монгол улсын Засгийн газрын зүгээс авч болох тодорхой арга хэмжээг санал болгох зэрэг болно.

БОНСУ-ий зорилго нь уул уурхайн салбарын шинэчлэл, байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг тодорхой арга хэмжээг санал болгон дэмжих явдал юм.




БОНСУ-ИЙ АРГАЧЛАЛ

БОНСУ нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (БОНУ)-ээс гаралтай үйл ажиллагаа юм. “Нөлөөлөл”, “суурь үзүүлэлт” болон “нөлөөллийг бууруулах” зэрэг БОНУ-тэй холбоотой олон уламжлалт нэр томъёо нь БОНУ-д өргөн хэрэглэгддэг ба эдгээр нь асуудлыг шийдвэрлэх, хэмжүүр үзүүлэлтүүд, нарийвчлан тодорхойлсон аргачлалтай ихээхэн холбогддог. Стратегийн түвшинд бодож сэтгэх нь биет бодит зүйлс бус харин үнэ цэнэ, хамтран ажиллаж ярилцах, ирээдүйд чиглэж бодоход илүү их анхаардгаараа онцлогтой байдаг. Өөрөөр хэлбэл, БОНСУ нь төслийн үнэлгээнд байдаг шиг аливаа төслийн саналын байгаль орчны нөлөөлөл (ус, агаар, хөрс г.м.)-ийн шууд үнэлгээ биш гэсэн үг бөгөөд харин байгаль орчин, тогтвортой байдлын талаарх шийдвэр гаргах орчин болон үр дүнг бий болгоход чиглэсэн, хөгжлийн бодлого (институци, бодлого, эдийн засгийн, нийгмийн асуудлууд г.м.)-ийн үнэлгээ юм. Уламжлалт БОНУ нь стандарт арга аргачлалын дагуу хийгддэг бол, БОНСУ нь ямар нэгэн стандарт, журманд баригддаггүй бөгөөд энэ үнэлгээг хийх цорын ганц арга гэж байдаггүй. БОНСУ нь онолын судалгаа гэхээсээ илүүтэйгээр тогтвортой байдлаар хөгжих биет, нийгмийн, байгаль орчны, эдийн засгийн орчныг бий болгох тухай юм. Энэ нь стратегийн түвшний үнэлгээ бол, БОНУ-д төслийн саналын байгаль орчны үр нөлөө болон эдгээр нөлөөллийг хэрхэн зохицуулж, бууруулах талаарх шууд үнэлгээ хийгддэг.

Дээрхтэй уялдуулан Састэйнабилити компаний БОНСУ-г хийж гүйцэтгэх аргачлалыг Монголын нийгмийн бүхий л цогц уялдаа холбоо, зөрчил маргаан, уул уурхайн салбарын сул талыг харгалзан үзсэн, уул уурхайн салбарыг байгаль орчны хувьд тогтвортой, нийгмийн хувьд шударгаар хөгжүүлэх эн тэргүүний арга замыг тодорхойлоход Засгийн газарт дэмжлэг үзүүлэх цогц аргачлал гэж хураангуйлан тодорхойлж болно.

Тус БОНСУ-д 2025 он хүртэлх Монгол улсын эдийн засгийн ерөнхий өсөлт, түүнд эзлэх уул уурхайн салбарын байр суурийг хөгжлийн хувилбаруудад авч үзсэн ба бага, дундаж, өндөр өсөлтийн 3 хувилбарыг боловсруулан тус үнэлгээнд ашиглалаа. Хувилбар бүр нь эдийн засгийн өсөлтийн өөр түвшнийг илтгэх бөгөөд энэхүү өсөлтийн хувьд тодорхой бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл ямар байх, тухайлбал, уурхайн төрөл, тоо хэмжээ болон 2025 он хүртэл уул уурхайн салбарыг дэмжих холбогдох дэд бүтэц хэрхэн хөгжсөн байхыг тодорхойлох юм. Цаашлаад хувилбар бүртэй холбогдон үүсэх байгаль орчин, нийгэм-эдийн засгийн нөлөөллийг тодорхойлж, түүнчлэн байгаль орчны хувьд тогтвортой, нийгмийн хувьд эрх тэгш, шударга үр дүнг бий болгохын тулд эдгээр нөлөөллүүдийг бууруулахад авах арга хэмжээний зөвлөмжүүдийг боловсруулах боломж бүрдэнэ (ТХ Зураг 1-ийг харна уу). Өнөөгийн нөхцөл байдлыг суурь болгон авч үзсэнээр, БОНСУ-ий хүрээнд санал болгож буй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд саад болж буй институцийн болон улс төр, эдийн засгийн сул талууд, мөн тэдгээрийг шийдэх бодлогын зөвлөмжийг боловсруулах боломжтой болно. Доор зурагт өсөлтийн хувилбарууд болон холбогдох байгаль орчин, нийгмийн нөлөөллийн уялдаа холбоог харуулав.



ТХ-н зураг 1 Хувилбар бүрийн хувьд бий болох байгаль орчин, нийгмийн нөлөөлөл

Тус аргачлал нь БОНСҮ-ий төслийн ажлын даалгавар, БОНСҮ-ий багийн санал, Дэлхийн банк, Засгийн газрын холбогдох байгууллагуудтай харилцан ярилцах үед гарсан санал, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас баталсан Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал зэрэгт тулгуурлагдсан болно. Товчхондоо, энэхүү аргачлалаар 1-р үе шатанд уул уурхайн салбар, тус салбарт үүсээд буй байгаль орчин, нийгэм-эдийн засгийн гол асуудлууд, түүнчлэн гол шийдвэр гаргагчдын талаарх суурь ойлголтыг бий болгох үүднээс одоогийн нөхцөл байдлын үнэлгээ, уул уурхайн салбарт оролцогч талуудын судалгааг гүйцэтгэлээ. Дараагаар нь, уул уурхайн салбарын хөгжлийн хувилбаруудыг боловсрууллаа. 2-р үе шатанд өсөлтийн хувилбаруудыг харгалзан тодорхойлсон байгаль орчин, нийгэм-эдийн засгийн асуудлуудыг улам судлан оролцогч талуудаар баталгаажуулж, эдгээр асуудлуудыг шийдвэрлэх арга хэмжээний зөвлөмжүүдийг боловсруулах ажил хийгдсэн болно. 3-р үе шатанд санал болгож буй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд саад болж буй институцийн болон улс төр, эдийн засгийн сул талуудыг шинжилж, тэдгээрийг шийдвэрлэх бодлогын зөвлөмжүүдийг боловсруулав. 4-р үе шатанд зөвлөмжүүдийг Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэлбэрт оруулсан ба энэхүү аргачлалын дагуу үнэлгээний явцад оролцогч талуудтай тогтмол зөвлөлдөж ажилласан болно.

ОРОЛЦООНЫ ҮЙЛ ЯВЦ

БОНСҮ-г амжилттай гүйцэтгэхэд талуудын үр дүнтэй оролцоо ихээхэн чухал байв. Оролцогч талуудын хувьд чухал байгаль орчин, нийгмийн эн тэргүүний асуудлуудыг хамгийн түрүүнд авч үзэхийн зэрэгцээ БОНСҮ-ий үйл явц нь дараах зорилтыг хангахыг зорьсон болно. Үүнд: (i) оролцогч талуудын хувьд чухал эн тэргүүний асуудалд хамгийн гол анхаарлыг хандуулах, (ii) бодлогын өөрчлөлтийн улмаас янз бүрийн оролцогч талуудад ялангуяа, эмэгтэйчүүд, өндөр настан зэрэг эмзэг бүлгийнхэнд учрах нөлөөллийг арилгах, бууруулах зорилгоор хэрэгжүүлэх үйл ажиллагаа, (iii) урт удаан хугацааны тогтвортой байдалд чухал, хүн амын олонхийн хувьд зүй ёсны гэж ойлгогдож, хүлээж авч байгаа зөвлөмжүүд.

БОНСҮ-ий хүрээнд оролцогч талуудтай дараах байдлаар хамтран ажиллав. Үүнд:

- Олон нийтийн уулзалтууд;
- Зорилтот бүлгийн ярилцлага;
- Гол талуудтай хийсэн ярилцлага;
- Утсаар авсан ярилцлага;



- Уул уурхайн яамнаас зохион байгуулсан Нээлттэй өдөрлөг арга хэмжээ;
- Талуудтай зөвлөлдөх бүс нутгийн хэмжээний хэлэлцүүлэг;
- Үр дүнг хэлэлцэх үндэсний зөвлөлдөх уулзалт;
- УУЯ, УУСИБТТТ болон Дэлхийн банкттай харилцан ярилцаж, зөвшилцөх зэрэг үйл ажиллагаа багтав.

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монгол улс нь нүүдлийн мал аж ахуй давамгайлсан социалист улсаас зах зээлийн эдийн засаг, олборлох үйлдвэрлэл бүхий олон намын системтэй ардчилсан нийгэмд шилжсэн юм. Монгол улс 2.9 сая хүн ам, 1.6 сая квадрат км нутаг дэвсгэртэй. 70 жилийн турш Социалист орнуудын эвслийн гишүүн байсан Монгол улс энэхүү систем задран унахад чухал дэмжлэгээ алдсан юм. Үүнтэй холбоотойгоор өргөн хэмжээний өмч хувьчлал явагдсан ба энэ нь богино хугацаанд ажилгүйдэл, инфляци, ядуурлын түвшинг нэмэгдүүлэх шалтгаан болсон байна. 1990-ээд оны сүүлээр ашигт малтмалын томоохон ордуудыг ашиглаж эхэлснээр Монгол улсын эдийн засагт томоохон өөрчлөлт гарч, энэ нь өнгөрсөн жилүүдэд уул уурхайн салбар хурдацтай хөгжин Монгол улсын эдийн засаг дэлхийн хамгийн өндөр өсөлттэй эдийн засаг болоход нөлөөлсөн юм. Цаашлаад, хөгжиж буй бусад орнуудын адилаар уул уурхайн салбарын хөгжил нь мөн зарим нэгэн бэрхшээлтэй асуудлыг бий болгож байна. Үүнд, гадаадын хөрөнгө оруулагчид ашигт малтмалын нөөцийг хяналтандаа авч байгааг эсэргүүцэх, хууль журмыг чангатгах, уул уурхайн ордуудыг төрийн мэдэлд авах зэрэг дарамт шахалттай Монгол улсын Засгийн газар тулгараад байгаа юм. Дэлхийн эдийн засгийн хүндрэл, улам бүр чангарч буй дотоодын хууль журам зэргээс шалтгаалан Монгол улсад оруулах ГШХО 2011 оны сүүл гэхэд хамгийн оргил үедээ хүрээд саарсан байна.

Монгол улсад одоогоор мэдэгдэж байгаагаар 80 гаруй төрлийн ашигт малтмалын 6,000 гаруй ордууд илрээд байна. 1920-оод оны үеэс хойш хийгдсэн геологийн судалгаагаар ашигт малтмалын арвин их нөөц илрүүлсэн ч тус улсын нутаг дэвсгэрийн 15%-д л бүрэн хэмжээний зураглал хийгдэж, илэрсэн ордуудын 600 орчим нь нарийвчлан судлагдсан байна. Одоогийн байдлаар, эдгээр ашигт малтмалын ордоос 200 гаруйг нь ашиглаж байгаа бөгөөд ихэвчлэн алт, зэс, нүүрс, давс олборлож байна.

Монгол улсад уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн зохицуулалтыг Уул уурхайн яам (УУЯ) болон тус яамны харьяа Ашигт малтмалын газар (АМГ), Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (БОНХЯ), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ) гэсэн төрийн 3 байгууллага ерөнхийдөө хариуцдаг. Бусад төрийн байгууллагууд чухал ч хоёрдугаар зэргийн оролцоотой байдаг. УУЯ болон БОНХЯ-д өнгөрсөн 5 жилийн хугацаанд ихээхэн шинэчлэл хийсэн боловч энэ хугацаанд бий болсон уул уурхайн салбарын огцом өсөлттэй харьцуулахад дээрх яамдын чадавхид хангалттай өөрчлөлт гараагүй байна. УУЯ нь ашигт малтмалын салбарын бодлого, хууль журмыг боловсруулдаг бол, АМГ нь тусгай зөвшөөрлийн асуудлыг хариуцдаг.

БОНХЯ нь өөрсдийн хариуцдаг байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхөн сэргээлт, уул уурхайн салбарын үйл ажиллагааг зохицуулах стандарт, журмаар дамжуулан уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, байгалийн нөөцөд үзүүлж буй нөлөөллийг удирддаг. Харин МХЕГ нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны асуудлыг хянах шалгах үүрэгтэй байгууллага



юм. Түүнээс гадна аймаг, сумын түвшний байгууллагууд мөн уур уурхайн салбарын асуудлыг зохицуулах үйл ажиллагаанд оролцдог.

Уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааг зохицуулсан гол хуулиудад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012), Ашигт малтмалын тухай хууль (2006), Төрийн хяналт шалгалтын тухай хууль (2003), болон Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль (2009) зэрэг орно.

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ӨСӨЛТИЙН ХУВИЛБАРУУД

Монголын уул уурхайн салбарын хөгжлийн бодлогын хувилбар болон холбогдох нөлөөллийг үнэлэх аргачлал нь Монгол улс хэдийгээр ашигт малтмалын арвин баялаг нөөцтэй боловч, дэлхийн зах зээлийн үнэ, хэрэглээнээс хамааралтай хэвээр байна гэсэн угтвар нөхцлөөс эхэлж байна. Монгол улсын цахилгаан станцуудад хэрэглэж байгаа багахан хэмжээний нүүрснээс бусад бүх олборлож буй ашигт малтмалыг экспортолдог. Тиймээс, хөгжлийн бодлогын хувилбаруудыг ашигт малтмалын салбарт юу тохиолдож болох, мөн уурхайн олборлолттой холбоотойгоор тус салбар ямар хариу үйлдэл үзүүлэх болоод энэ нь эдийн засгийн өсөлтөнд хэрхэн нөлөөлөх зэрэг асуудлуудад суурилан боловсруулав. Энэхүү үнэлгээнд авч үзсэн хөгжлийн хувилбар тус бүр нь олон таамаглалд үндэслэгдсэн бөгөөд ирэх 10 жилийн хугацаанд ашигт малтмалын үнэ ямар байх талаарх таамаглал хүлээлтийг хамгийн түрүүнд авч үзлээ. Учир нь энэхүү хүчин зүйл Монгол улсын эдийн засгийн өсөлтөнд өөр бусад хүчин зүйлээс хавьгүй илүүтэйгээр нөлөөлөхөөр байна. Ашигт малтмалын үнэ өндөр байх нөхцөл байдал нь уурхай, эрэл хайгуул, үйлдвэрлэлд хэдий хэрийн хөрөнгө оруулалт хийх асуудалд нөлөөлнө. Үүнтэй адилаар, ашигт малтмалын өндөр үнэ Засгийн газрын орлогод, цаашлаад Засгийн газар энэ орлогыг хэрхэн зарцуулж, эдийн засгийн ирээдүйн өсөлтийг бий болгох зэрэгт нөлөөлнө.

Дундаж өсөлттэй хувилбар

Дундаж өсөлттэй байх хувилбараар, 2025 он хүртэл хууль эрх зүйн орчны дараах таатай нөхцөл бүрдэнэ хэмээн таамаглав. Үүнд:

- Монголын хөрөнгө оруулалтын чиглэлийн хуулиуд нь хөрөнгө оруулагчдад ээлтэй байх бөгөөд уул уурхайн хуулиуд батлагдсан байна.
- Оюу Толгойн асуудлууд шийдэгдэж уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллана.
- Засгийн газрын зардал, санхүүгийн алдагдал тогтвортой болон боломжийн хэмжээнд байна (Монгол улсын Хөгжлийн банк өр төлөх чадвартай байна).
- Эдгээр дотоод бизнесийн нөхцлөөс гадна, Хятад улсын эдийн засаг ирэх 10 жилийн хугацаанд дундаж хэмжээнд өснө.

Дундаж өсөлттэй байх хувилбарын хүрээнд олон таамаглалыг дэвшүүлсэн. Үүнд, түүхий эд бүтээгдэхүүний үнийн хувьд, ОУВС (Олон улсын валютын сан)-ийн металлын индекс 180 (зэсийн үнийг метр тоннд 7200 ам.доллараар тооцсон) болон нүүрсний индекс 178 (үнэ нь метр тоннд 90 ам.доллараар тооцсон) зэргийг ашиглав. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн хувьд (Хятад улсыг оролцуулан) 3%-ийн өсөлттэй байхаар таамаглалаа. Уул уурхайн салбарын бодлогыг оролцуулан сүүлийн үед гадаадын хөрөнгө оруулалтын орчны талаар сөрөг уур амьсгал,



бодлого шийдвэрүүд гарах болсонтой холбоотойгоор ДНБ (дотоодын нийт бүтээгдэхүүн)-д эзлэх гадаадын хөрөнгө оруулалтыг 40% байна гэж таамаглав. Одоогийн хязгаарлагдмал гадаад нөхцөл байдал, олон улсын зах зээл дээр гаргасан бондыг оролцуулсан Засгийн газрын өр шир дээр үндэслэн ДНБ-д эзлэх Засгийн газрын зардлыг 45% байхаар тооцлоо.

Дээрх таамаглалын дагуу, ДНБ дэх ашигт малтмалын эзлэх хувийг (үйлдвэрлэл) 25% байхаар таамагласан. Хэрвээ бид дээрх байдлаар таамаглах аваас, дундаж өсөлттэй байх хувилбарын өсөлтийг дүн шинжилгээний зорилгоор ойролцоогоор 8% байхаар таамаглаж болно. Цаашлаад хэрэв бид 10 жил тутам болдог эдийн засаг, санхүүгийн хямралыг үл тооцвол энэ нь ОУВС болон Дэлхийн банкны Монгол улсын талаар гаргасан төсөөлөл таамаглалын дагуу боломжийн өсөлтийн хувь хэмжээнд орох юм.

Таамаглаж буй ашигт малтмалын үйлдвэрлэлийн хэмжээнд тулгуурлан дундаж өсөлттэй үед 330 уурхай үйл ажиллагаа явуулна хэмээн төсөөлөв. Дундаж өсөлттэй хувилбарын хувьд зэс, молибден, алт, төмөр, жонш, гөлтгөнө, хар тугалга, гантиг, хүхэр, цагаан тугалга, гянтболд, цайр, газрын тос, нүүрс, барилгын материал зэрэг олон төрлийн ашигт малтмал олборлохоор байна.

Өндөр өсөлттэй хувилбар

Өндөр өсөлттэй хувилбарын хувьд зэс, нүүрсний үнэ ханшийг өндрөөр, дэлхийн эдийн засгийн өсөлтийг 4%, ерөнхий эдийн засгийн болон уул уурхайн салбарын гадаад хөрөнгө оруулалтын орчин илүү сайн байхаар таамагласан бөгөөд улмаар гадаадын хөрөнгө оруулалт ДНБ-ий 50%-д хүрч, өөр бусад хөтөлөгч хүчин зүйл нэмэгдсэнээр ДНБ-д эзлэх уул уурхайн бүтээгдэхүүний хувь хэмжээ 35% хүрч өснө хэмээн төсөөллөө. Засгийн газрын зардал, зээлд хязгаар тавих тул Засгийн газрын зардлыг ДНБ-ий 45% байхаар авч үзсэн. Ингэснээр, 12 жилийн хугацаанд өсөлтийг дунджаар 11% байна хэмээн таамаглаж байна. Мөн энэ хувилбарын хүрээнд, Засгийн газар хувийн хэвшилтэй хамтран дэд бүтэц, аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх томоохон хэмжээний хөрөнгө оруулалтыг хийнэ гэж үзлээ.

ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагууд нь сайн макро болон үр дүнтэй менежментийн "хүчтэй бодлогын" хувилбарын дагуу Монгол улсын дунд хугацааны төлөв байдал ихээхэн өөдрөг байна гэсэн төсөөлөл таамаглалыг дэвшүүлээд байгаа юм. Монгол улсын байгалийн баялгийн асар их нөөц болон бүс нутаг дахь эдийн засгийн хамгийн өндөр өсөлттэй улс орнуудад ойрхон байршил зэрэг нь хөгжих боломжийг бий болгож байна. Оюу Толгойн ил уурхайн зэсийн үйлдвэрлэл эхэлж, Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт хийгдэж, Таван Толгойн уурхайн нүүрсний олборлолт тогтмол явагдсанаар 2013-2017 оны хооронд ашигт малтмалын ДНБ-д эзлэх хувь дунджаар жилийн 16% байхаар таамаглаж байна. Өндөр өсөлттэй хувилбарын хувьд, Монгол улсын Засгийн газрын хөгжлийн стратегид одоо байгаа төрийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх асуудал багтан орох бөгөөд үүнд гадны зээлээр санхүүжүүлэх тээврийн дэд бүтэц орно. Энэхүү дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эдийн засгийн хурдацтай өсөлт болон буцаж сэргэсэн экспортын орлогоор тогтвортой түвшинд барьж хөгжүүлнэ. Өндөр өсөлттэй хувилбарын хувьд эдийн засгийн өсөлтийг тогтвортой түвшинд барих үүднээс санхүүгийн тогтвортой байдлын талаарх хуулиудыг дагаж мөрдөнө хэмээн таамаглаж байна. Мөн энэ хувилбараар Монгол улсын Засгийн газар нь үйлдвэрлэлийн өндөр түвшинд хүрч, өртөг



нэмсэн ашигт малтмалын бүтээгдэхүүнүүд (салбар дундын болон хоорондын өртгийн сүлжээг хөгжүүлэх нүүрс, алт, зэс, жонш) үйлдвэрлэхээр төсөөллөө.

Өндөр өсөлттэй хувилбарын хүрээнд үйлдвэрлэл, экспортын хэмжээ өсөж уурхайн тоо 589 хүрэх ба ашигт малтмалын үйлдвэрлэл ДНБ-ий 35%-ийг бүрдүүлнэ хэмээн таамаглалаа. Дундаж өсөлттэй хувилбарын хувьд үйл ажиллагаа явуулах 330 уурхай дээр өндөр өсөлттэй хувилбарын хүрээнд 2025 он хүртэл 259 шинэ уурхай нэмэгдэхээр төсөөлж байна. Нөөц нь тогтоогдсон эсвэл техник-эдийн засгийн үндэслэл нь батлагдсан ордуудыг шинээр нээгдэж болзошгүй уурхайн тоонд орууллаа. Энэ хувилбарын үед зэс, молибден, алт, төмөр, жонш, гөлтгөнө, хар тугалга, гантиг, хүхэр, цагаан тугалга, хөнгөн цагаан, циолит, гянтболд, цайр, газрын тос, нүүрс, барилгын материал зэрэг ашигт малтмалууд олборлохоор төсөөлөв. Уул уурхайн салбарын өсөлт өндөр байх үед тус салбарын үйл ажиллагаатай холбогдуулан одоогоор төлөвлөөд буй бүх дэд бүтэц баригдана хэмээн төсөөлөв. Үүнд, Төмөр замын бодлогын хүрээнд төлөвлөгдсөн төмөр зам, техник-эдийн засгийн үндэслэл нь батлагдаад буй хувийн хэвшлийн санаачилсан ашигт малтмал тээвэрлэх зам болон 7 шинэ цахилгаан станц багтаж байгаа юм.

Бага өсөлттэй хувилбар

Ирэх 10 жилийн хугацаанд бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ бага байх тохиолдолд дэлхийн эдийн засгийн өсөлт 2.5% хүртэл буурч, гадаад хөрөнгө оруулалтын орчин муудсаны улмаас, гадаадын хөрөнгө оруулалт ДНБ-д эзлэх хувь 20 болж буурна. Энэ нь Засгийн газрыг зардлаа ДНБ-д 35% хүргэж бууруулахад хүргэх бөгөөд төсвийн алдагдал улам бүр нэмэгдэнэ (одоогийн байдлаар 12%-тай байгаа). Ийм таамаглалаар бага өсөлттэй байх хувилбарын хувьд эдийн засгийн өсөлт дунджаар 6.5%, ДНБ-д уул уурхайн бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээ 15% болж тус тус буурна. Энэ хувилбараар уул уурхайн салбарын бодлогын орчин сайжраагүй, улс төрийн орчинд "баялгаа өмчлөх үндсэрхэх үзэл" дахин гарч ирснээр цаашдын маргаан, зөрчил улам бүр нэмэгдсэн байна гэж таамаглалаа.


Бага өсөлттэй хувилбарын хувьд, түүхий эд, бүтээгдэхүүний гадаад эрэлт хэрэгцээ сул хэвээр байгаагаас үүдэлтэйгээр уул уурхайн экспортын орлого улам бүр буурна. Ихэнх өндөр хөгжсөн улс орнууд ихээхэн дэмжлэгийг хүлээн сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн мөнгөний бодлогоосоо татгалзана. Хятадын эдийн засаг хөрөнгө оруулалтанд илүү тулгуурласан өсөлтийн загвараасаа зайлсхийж, ашигт малтмалын хэрэглээнд ихээхэн нөлөө үзүүлэх, илүү их хэрэглээнд тулгуурласан өсөлтийн загвар руу шилжих таамаглал байна. Энэ хоёр хүчин зүйл нь дэлхийн хэмжээнд, ялангуяа Хойд Азийн бүс нутгийн хэмжээнд ихээхэн нөлөө үзүүлнэ гэж үзлээ. Хятад улс нь Монголын экспортын 90%-ийг бүрдүүлж байгаа учраас ОУВС болон Дэлхийн банк саяхны тайлан мэдээндээ Монгол улсыг Хятад улсын өөрийн эрэлт хэрэгцээг өөрчлөх үйл явцад хамгийн их өртөх магадлалтай эмзэг улсуудын тоонд оруулсан байна. Хятад улсын өсөлт удааширч байгаа нь Монголд худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалт, уул уурхайн салбарын эдийн засгийн өсөлтөнд оруулж буй хувь нэмэр зэрэг асуудалд нөлөөлнө.

Бага өсөлттэй хувилбарын хүрээнд бүтээгдэхүүний олборлолт, экспорт буурч нийт 165 (одоо ажиллаж байгаа уурхайн тал нь) уурхай ажиллаж, ашигт малтмалын үйлдвэрлэл ДНБ-ий 15%-д хүрч буурна хэмээн таамаглалаа. Өмнө дурдсанчлан бага өсөлттэй хувилбарын үед бүтээгдэхүүний үнэ дараагийн 10 жилд бага байна. Тиймээс, жонш, гөлтгөнө, хар тугалга, гантиг, хүхэр, цагаан тугалга, гянтболд, цайр зэрэг ашигт малтмалын эрэлт байхгүй болсноор




энэ төрлийн уурхай ажиллахгүй. Нүүрсний экспорт буурах ч одоо байгаа 93 нүүрсний уурхайнаас орон нутгийн хэрэглэгчдэд нүүрс нийлүүлдэг 38 уурхай ажиллаж үлдэнэ хэмээн таамаглав. Түүнээс гадна, орон сууцны хэрэгцээ байсаар байх тул хотуудтай ойр байрлах одоо байгаа барилгын материалын уурхайнуудаас тал нь үйл ажиллагаа явуулсаар байна. Энэ хувилбарын үед зэс, молибден, алт, төмөр, жонш, газрын тос, нүүрс, барилгын материал зэрэг ашигт малтмалын уурхайнууд олборлолт явуулахаар байна.

Уурхайн тоо, ашигт малтмалын төрөл, уурхайн холбогдох дэд бүтцийг харуулсан зургийг өсөлтийн хувилбар бүхий хувьд бэлтгэснийг доор харуулав. Үүнд:



ТХ-н зураг 2 Дундаж өсөлттэй хувилбар, 2025




ТАНИХ ТЭМДЭГ

Ажиллаж байгаа уурхай (уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоонд үндэслэсэн уурхайн тоо, 589)

- | | | | | |
|---------------------|-----------------------------|---------------------------|--------------------------------|--------------------|
| ● Газрын тос | ● Холимог металл (2) | ⊠ Гянтболд (4) | ⊗ Цеолит (1) | ⏏ Цахилгаан станц |
| ● Нүүрс (136) | ● Төмөр, холимог металл (1) | ⊙ Цайр (2) | ▲ Гангиг (1) | ⏏ Хилийн боомт |
| ■ Зэс, молибден (2) | ● Алт, мөнгө (1) | ⊙ Барилгын материал (107) | □ Хүхэр (1) | — Зам |
| ● Алт, зэс (4) | ● Алт (114) | ⊙ Гөлтгөнө (2) | ⊙ Цагаан тугалга (4) | — Төмөр зам |
| ● Молибден (2) | ▲ Төмөр (26) | ⊙ Хар тугалга (3) | ⊙ Шинээр бий болон уурхай (97) | ⏏ Аймгийн хил |
| ● Зэс (1) | ■ Жонш (75) | ⊙ Хөнгөн цагаан (1) | | ⏏ Монгол Улсын хил |

ТХ-н зураг 3 Өндөр өсөлттэй хувилбар, 2025



ТАНИХ ТЭМДЭГ

Ажиллаж байгаа уурхай (уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоонд үндэслэсэн уурхайн тоо, 165)

- | | | | | |
|------------------|---------------------|--------------------------|-------------|-------------------|
| ● Газрын тос (2) | ● Алт, зэс (2) | ▲ Төмөр (12) | — Зам | ⏏ Цахилгаан станц |
| ● Coal (38) | ■ Зэс, молибден (2) | ● Алт (76) | — Төмөр зам | ⏏ Аймгийн хил |
| | ■ Молибден (1) | ○ Барилгын материал (32) | | |

ТХ-н зураг 4 Бага өсөлттэй хувилбар, 2025



ГОЛ АСУУДЛУУД БА ХОЛБОГДОХ НӨЛӨӨЛӨЛ

Гол асуудлууд

БОНСУ-г гүйцэтгэх явцад зохион байгуулсан талуудтай зөвлөлдөх хэлэлцүүлгүүдийн үеэр тухайн авч үзэж буй хөгжлийн хувилбарын хувьд уул уурхайн салбартай холбогдон үүсэх доорх 12 гол асуудлыг тодорхойлон эцэслэсэн юм. Үүнд:

ТХ-н хүснэгт 1 Эн тэргүүний 12 асуудлууд

#	БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛУУД	
1	Ус	Усны нөөцийн тогтвортой бус ашиглалт Гидрологийн горимд гарах өөрчлөлтүүд Усны түвш. асуудал, малчид худгаа ашиглах боломж
2	Газар ба бэлчээр ашиглалт	Тусгай хамгаалалттай газруудын нөлөөлөл Газар/ бэлчээр ба хөрсний чанарын доройтол
3	Агаарын чанар	Агаарын чанарын доройтол
4	Байгаль орчны менежмент	Хог хаягдал Уул уурхайн компаниудын байгаль орчны менежмент Байгаль орчны эрх зүйн орчны ба институцийн чадавхи Уул уурхайн компаниудын нөхөн сэргээлт Биологийн олон янз байдлын доройтол
НИЙГМИЙН АСУУДЛУУД		
5	Хувиараа болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлолт	Бичил уурхайн салбарыг үл тоомсорлох асуудал Бичил уурхайн салбарын ЭМААБО-ны асуудлууд Бичил уурхайн салбарын эдийн засгийн нөлөө
6	Соёлын өв	Биет ба биет бус соёлын өв алдагдах
7	Хүний эрх ба олон нийтийн оролцоо	Олон нийтийн оролцоо, мэдээлэл Хүний эрх ба олон нийтийн оролцоо
8	Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа	Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа Малын эрүүл мэнд, аюулгүй байдал
ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДЛУУД		
9	Засаглал ба орлогын менежмент	Макро-эдийн засгийн нөлөө Орлогын менежмент Төсвийн орлого (эерэг асуудал)
10	Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц	Нийгмийн үйлчилгээ, дэд бүтцэд учрах нэмэлт дарамт Бүс нутгийн дэд бүтцийн хөгжил (эерэг асуудал)
11	Хөдөлмөр эрхлэлт ба ур чадвар	Уул уурхайн бүс нутаг дахь хүн амын шилж. хөдөлгөөн Орон нутгийн иргэдийн ажил эрхлэлт хангалтгүй байх Уул уурхайн салбарт хөдөлмөр эрхлэх боломж (эерэг асуудал) Амьжиргаа сайжрах (эерэг асуудал) ЖДҮ-ийн салбарын хөгжил ба ур чадварыг бэхжүүлэх (эерэг асуудал)
12	Технологи	Орчин үеийн УУ-н үйлдвэрлэлийн технологи ашиглах

Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн гол нөлөөллүүд

Тухайн өсөлтийн хувилбараас хамааран эдгээр асуудлуудын нөлөөллийн эрчим өндөр эсвэл бага байж болохын зэрэгцээ, уг асуудлууд нь мөн эерэг эсвэл сөрөг талтай байгааг талуудтай зөвлөлдөх хэлэлцүүлгүүдийн үеэр тодорхойлсон болно. БОНСУ-ий хүрээнд эдгээр асуудлыг шийдвэрлэх (хэрэв тухайн асуудал эерэг байх бол эерэг нөлөөллийг нь улам нэмэгдүүлэх) цогц "бодлогын зөвлөмж"-үүдийг боловсруулахыг зорьсон бөгөөд зөвлөмжүүд нь хууль эрх зүйн орчин, институцийн тогтолцоог сайжруулах, өөрчлөлт оруулах, эсвэл дагалдах хүний болон



байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд чиглэгдсэн байх юм. Доорх хүснэгтүүдэд сум, аймаг, улсын түвшинд бий болох байгаль орчин, нийгэм, эдийн засгийн гол асуудлуудыг тоймлон оруулав.

Ус:

Бага өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Сэлэнгэ, Хөвсгөл, Булган аймгуудад аймаг, сумын аль аль түвшинд ус ашиглалттай холбоотой маргаан үүсэх магадлалтай.
Дундаж / Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Өнөөгийн болон ирээдүйн ус ашиглагчдын дунд уурхайн усны ашиглалтын талаар томоохон зөрчил маргаан үүсэх магадлалтай.Хаягдаж орхигдсон уурхайгаас гадаргын усанд тунадас үүсэх, уурхайн хүдрийн хаягдал, хүчиллэг урсац зайлуулах системээс химийн бодис шүүрэх, уурхай орчимд гадаргын усны горим өөрчлөгдөх зэргээр байгаль орчинд их хэмжээтэй нөлөөлөл үүсгэж болзошгүй.Нөлөөлөлд өртөгсөдийн дунд усны нөөцийн хүртээмжийн талаар бодитой мэдлэг, мэдээллийг дэлгэрүүлэх хэрэгцээ шаардлага нь амин чухал асуудал болохыг тодорхойлов. Аль ч өсөлтийн үед усны нөөцийн талаарх мэдээллийн дутмаг байдал, уурхайн ус ашиглалтын нөлөөллийг тойрсон нөлөөлөлд өртөгч талуудын ойлголтын тодорхой бус байдал өссөөр байх ба уурхайн үйл ажиллагаа нэмэгдэхийн хамтаар эрсдэл мөн нэмэгдсээр байх болно.

Газар ба бэлчээр ашиглалт:

Бага өсөлтийн хувилбар	<ul style="list-style-type: none">Уурхайн нөлөөлөлд өртөх хамгаалалттай болон бэлчээрийн зориулалттай газар нутгийн талбай бага байна.
Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Уурхайн нөлөөлөлд өртсөн хамгаалалттай газар нутгууд ихэвчлэн Дорнод, Сүхбаатар, Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай аймгуудад байрлаж байна.Өмнөговь, Дорнод, Дундговь, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгуудад бэлчээрийн нутаг дэвсгэр илүүтэйгээр уурхайн нөлөөлөлд өртөхөөр байна.Газар зүйн байршлын хувьд үүсэж болзошгүй нөлөөлөл нь бүх аймаг, сумдад жигд тархахаасаа илүүтэйгээр тодорхой газар нутгуудад үүснэ.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Уурхайн тоо ихэссэнээр хамгаалалттай газар нутаг болон бэлчээрийн талбайд газар ашиглалттай холбоотой зөрчил маргааныг хурцатгаж болзошгүй (нөлөөлөлд хамгийн их өртсөн талбайг Дундаж өсөлтийн хувилбараас харна уу).Газрын төлөв байдал, хөрсний чанар нь ихэвчлэн бэлчээрийн талбай багасч даац хэтэрсэнээс муудна.

Агаарын чанар:

Бага өсөлттэй хувилбар:	<ul style="list-style-type: none">Энэ хувилбараар аваад үзвэл зам тээврийн нөхцөлөөс хамаараад цөөн тооны томоохон уурхайнууд агаарын чанарт нөлөөлнө.
Дундаж/ Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Дундаж/ өндөр өсөлтийн хувилбараар авч үзвэл Өмнөговь, Дорнод, Дундговь, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгийн сумдад уурхайн тоосжилтоос үүдсэн агаарын чанарын доройтол ихээхэн хэмжээгээр учирна.

Байгаль орчны менежмент:

Бага өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Уул уурхайн үйл ажиллагаа бага явагдах тул байгаль орчны ажилтнууд мэргэжлийн мэдлэг, ур чадварын хувьд туршлагажих ба салбар доторх эрэлтээс шалтгаалаад туршлагатай байгаль орчны ажилтнууд үнэд орох боломж харагдаж байна.Уул уурхайн бодлогын улмаас гадны хөрөнгө оруулалт саарч, хумигдсанаар түүнийг дагаж орж ирдэг олон улсын байгаль орчны тэргүүн туршлагын нөлөөлөл буурна. Гэхдээ цөөн тооны уурхай дээр төвлөрч ажиллах нь бас стандартыг сайжруулах боломжийг олгож болох юм.
-------------------------------	--



Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Олон улсын олборлох үйлдвэрлэлийн салбар, Монголд нэвтрүүлсэн байгаль орчны тэргүүлэх туршлагын нөлөө нь байгаль орчны удирдлагын талаарх мэдлэгийг дээшлүүлсэн бөгөөд дундаж өсөлттэй хувилбараар авч үзвэл гадны хөрөнгө оруулалт шаардагдахуйц томоохон уурхайнууд ажиллах магадлалтай тул үүнийг дагаад олон улсын стандарт ч хэрэгжсээр байх болно.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Уул уурхайн салбарын байгаль орчны удирдлагын шаардлагыг хангалттай түвшинд биелүүлэх мэргэжлийн боловсон хүчин болоод байгууллагын түвшний хөтөлбөр бэлтгэхэд хөрөнгө оруулалт хийхэд 5-10 жил шаардагдана.Олон улсын олборлох үйлдвэрлэлийн салбар, Монголд нэвтрүүлсэн байгаль орчны тэргүүлэх туршлагын нөлөө нь байгаль орчны удирдлагын талаарх мэдлэгийг дээшлүүлсэн бөгөөд өндөр өсөлтийн хувилбараар авч үзвэл гадны хөрөнгө оруулалт шаардагдахуйц томоохон уурхайнууд ажиллах магадлалтай тул үүнийг дагаад олон улсын стандарт ч хэрэгжсээр байх болно.

Хувиараа болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа:

Бага өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">БУ газар авах ба нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрөх явц удааширалтай байх магадлалтай.БУ-тай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд хүрэлцэхүйц нөөц санхүүжилт байхгүй байх ба байгаа орлогыг өөр тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд зарцуулна.Засгийн газар, уул уурхайн компаниуд болон бичил уурхай эрхлэгчдийн хооронд бичил уурхай эрхлэх талбайн асуудлаар маргаан гарах магадлал өндөр байна.
Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">БУ газар авах ба нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрөх явц удааширалтай байх магадлалтай.Сэлэнгэ, Дархан-Уул, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Увс, Өмнөговь, Дорноговь, Дундговь, Хөвсгөл аймаг, Улаанбаатарт хот БУ-н нөлөөлөлд илүүтэйгээр өртөнө.Засгийн газар, уул уурхайн компаниуд болон бичил уурхай эрхлэгчдийн хооронд бичил уурхай эрхлэх талбайн асуудлаар маргаан гарах магадлал өндөр байна.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">БУ газар авах ба нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрөх явц удааширалтай байх магадлалтай.Засгийн газар, уул уурхайн компаниуд болон бичил уурхай эрхлэгчдийн хооронд бичил уурхай эрхлэх талбайн асуудлаар маргаан гарах магадлал өндөр байна.Тус салбарыг үр дүнтэй удирдах, БУ-г хөтөлгч хүчин зүйлс, асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр илүү хүртээмжтэй байна.

Соёлын өв:

Бага өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Цөөн тооны уурхай ажиллаж, газар хөндөлт бага явагдах учраас дундаж болон өндөр өсөлтийн хувилбартай харьцуулахад бага өсөлтийн үед соёлын өвд үзүүлэх нөлөөлөл бага байна. Гэхдээ соёлын өөрчлөлтүүд байсаар л байна.
Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт хэзээд сул байсаар ирсэнээс үзэхэд уурхайн бүтээн байгуулалт, үйл ажиллагааны нөлөөгөөр мянга мянган археологийн өв бүхий газар нутаг устан үгүй болох магадлалтай бөгөөд өөр бусад хэдэн мянган соёл, өлгийн зүйлс гэмтэж, хохирол амсана.Гадны ажилчид олноор орж ирэн өөр өөр соёл, заншлыг нэвтрүүлсэнээр биет бус соёлын өвд нөлөөллөө үзүүлнэ.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт хэзээд сул байсаар ирсэнээс үзэхэд уурхайн бүтээн байгуулалт, үйл ажиллагааны нөлөөгөөр мянга мянган археологийн өв бүхий газар нутаг устан үгүй болох магадлалтай бөгөөд өөр бусад хэдэн мянган соёл, өлгийн зүйлс гэмтэж, хохирол амсана.Гадны ажилчид олноор орж ирэн өөр өөр соёл, заншлыг нэвтрүүлсэнээр биет бус соёлын өвд нөлөөллөө үзүүлнэ.Палеонтологийн олдвор бүхий тогтоц, ашигт малтмалын агууламжаар баялаг болох нь тогтоогдсон Өмнөговь, Баянхонгор аймгууд нөлөөлөлд хамгийн ихээр өртөнө.



Хүний эрх ба олон нийтийн оролцоо:

Бага өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Үр дүнтэй зохицуулалт дутагдвал хүний эрх болоод олон нийтийн оролцоотой холбоотой нөлөөлөл өндөр байсаар байна.Олон нийтийг зохих түвшинд оролцуулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх, турших ажлуудыг аажмаар гүйцэтгэх боломж гарна.
Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Дундаж өсөлттэй хувилбарын үед уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагын хэрэгжилтийг хянах ЗГ-ын чадавхи дорой, хяналт муутай байна.Газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааг зохистой зохион байгуулах аргачлал нэвтрээгүй, шилжилт хөдөлгөөний асуудлыг хангалттай шийдвэрлээгүй байна.Хүний эрхийн асуудал маш бага ач холбогдолтой, цаашлаад огт авч үзэхгүй хэмжээнд хүрнэ.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Хууль эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоонд ачаалал нэмэгдэх тул хүний эрхийн асуудалд нөлөөлөл ихээр үзүүлэх магадлалтай.Хурдацтай өөрчлөгдөж буй нөхцөл байдлыг удирдах хүний нөөцийн чадавхи сул байх тул төрийн байгууллагын халамж, үйлчилгээг зохицуулах, олон нийтийн идэвхтэй оролцоог хангах чадвар нь богино хугацаанд хязгаарлагдмал байна.Урт хугацаанд олон нийтийн оролцоог үр дүнтэй болгох, хүний эрхийг дээдэлсэн зарчмыг авч хэрэгжүүлэх чадвар нь нэмэгдэнэ.

Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа:

Бага өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">ЗГ-аас эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг нийгмийн үйлчилгээг сайжруулахад шаардлагатай хөрөнгө, орлого дутагдалтай байх ба хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, журмыг мөрдүүлэх төрийн албан хаагчдын ажлын чадавхи сул байна (одоо ч сул байгаа) эдгээр нь богино хугацаанд улам муудна.Ажлын байрны ЭМАА-ны бүхий л хүчин зүйлд уурхайгаас үзүүлэх нөлөө цөөхөн байна.Олон нийтийн ЭМАА-ны талаарх үзэл, хандлага аажмаар өөрчлөгдөнө.
Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Ажлын байран дахь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, журмыг мөрдүүлэх арга хэмжээ муу хэвээр байх ба хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн байцаагчдын нөөц, чадавхи доогуур байх тул хэрэгжилт жигд бус байна.Уул уурхай, дэд бүтцийн хөгжлөөс үүдсэн эрүүл мэндийн нөлөөлөл нь уурхайн үйл ажиллагаа ихээр явагдаж буй орон нутгуудад өндөр байна.Олон нийтийн ЭМАА-ны талаарх үзэл, хандлага аажмаар өөрчлөгдөнө.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Богино хугацаанд (5-10 жил) дараах болон өөр бусад сөрөг нөлөөллүүд улам тодоор илэрнэ. Үүнд:<ul style="list-style-type: none">Хууль, дүрэм, журмын хэрэгжилт, мөрдөлт сул байх;Ослын гаралт, нас баралт өндөр байх;Уурхайн эрчимтэй үйл ажиллагаа явуулж байгаа орон нутагт эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагууд ачааллаа даахгүй байх.Урт хугацаанд хөдөлмөрийн ЭМАА-ны салбарын нөөц, чадавхи нэмэгдэнэ.Олон нийтийн ЭМАА-ны эрсдлийн талаарх үзэл, хандлага нь сэргийлэх арга хэмжээг хэвшүүлэхээсээ түрүүлж өөрчлөгдөнө.

Засаглал ба орлогын менежмент:

Бага өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">ЗГ-ийн сайн засаглалыг хөгжүүлэх, чадавхийг бэхжүүлэх санаачилгад хөрөнгө оруулалт хийх нөөц бололцоо нь бүх түвшинд хумигдана.Засаглалыг бэхжүүлэхэд иргэний нийгмийн байгууллагын эзлэх байр суурь хязгаарлагдана.
Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">ЗГ-ын орлогын хуваарилалт, удирдлага, бүтээн байгуулалт, чадавхийг хөгжүүлэх нөөц багассанаар байршлын хувьд бүтээн байгуулалт бүс нутагт жигд бус тархсан байна.Засаглал, хариуцлагыг сайжруулахад хувь нэмэр оруулах талаарх иргэний нийгмийн хөгжил удаан байна.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Уул уурхайн салбар хурдацтай хөгжих эхний жилүүдэд засаглалын чадавхи сул байх ч урт хугацаанд буюу 2025 оноос хойш сайжирна.Уул уурхайн салбар хурдацтай хөгжих эхний жилүүдэд авлига, хээл хахууль, санхүү, мөнгөний шамшигдуулалт, захиргааны болон хөндлөнгийн хяналтын чадавхи сул



байх, сум, аймгийн түвшинд хууль, дүрэм, журмын биелэлт хангалтгүй байх, уурхайн орлогын тэгш бус хуваарилалт зэрэг үзэгдлүүд гарна.

- Иргэний нийгмийн байгууллагууд засаглалд эзлэх байр суурийг нь бэхжүүлэх, орлогын зохицуулалтад үүрэг хүлээх байдлыг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн гадны дэмжлэгийн ачаар үүрэг роль нь нэмэгдэнэ.

Бус нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц:

Бага өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">• Хөдөөгөөс хот суурин газар, тэр дундаа Улаанбаатар хот руу шилжих хөдөлгөөн нэмэгдэнэ.• ЗГ-т нийгмийн/олон нийтийн үйлчилгээг тэнцүү хүртээхэд хүндрэл учирна.
Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">• Бус нутгийн төлөвлөлт, энэ асуудлаарх салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагаа муу явагдаж ирсэний уршигаар зам тээврийн сүлжээ, орон зайн төлөвлөлт тааруу хийгдсэн байдаг.• Говийн бүсийн төв болон өмнөд хязгаар хамгийн ихээр нөлөөлөлд өртөнө.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">• Хөвсгөл, Баян-Өлгий, Өмнөговь, Өвөрхангай, Дорноговь, Сэлэнгэ аймгуудад хотжилт ихээр явагдаж, хүн ам төвлөрнө.• Уул уурхайн салбарын өсөлт бус нутгийн хөгжилд болон төвлөрлийг сааруулахад хувь нэмрээ оруулна.• Шугаман дэд бүтцийн бүтээн байгуулалт нь байгаль, зэрлэг амьтдад ихээхэн нөлөө үзүүлнэ.• Шугаман дэд бүтцийн бүтээн байгуулалт нь соёлын өвд ихээхэн нөлөө үзүүлнэ.

Хөдөлмөр эрхлэлт ба үр чадвар:

Бага өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">• Уурхайн салбарт мэргэжилтэй ажилтны эрэлт буурна.• Шууд хөдөлмөр эрхлэлтийн тоо уурхайн бүтээн байгуулалт бүхий сумдад хязгаарлагдмал байна.• Шууд бус хөдөлмөр эрхлэлтийн үр ашгийг олж харахад ЗГ болон иргэний нийгмийн байгууллагууд хоорондын идэвхтэй хамтын ажиллагаа шаардагдана.
Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">• Хөдөлмөрийн болон ажлын байрны ерөнхий нөхцөл хангагдсан байх ба бусад тэтгэмж, халамж хүртэх эсэх нь тодорхой ажил, мэргэжлийн өнөөгийн зах зээл дээрх эрэлт, ажил олгогч бүрийн үзэмжээс шалтгаална.• Өндөр үр чадвартай ажиллах хүчин Улаанбаатарт сууршин, онгоцоор ирэх, онгоцоор буцах байдлаар ажилдаа ирж очихыг илүүд үзнэ.• Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон дээд боловсролын тогтолцооны шинэчлэлт хийгдэж хараахан дуусаагүй байхтай холбогдуулан салбарын ажил мэргэжилд тавигдах ерөнхий шаардлага, эзэмшсэн байх гол үр чадварууд тодорхойгүй хэвээр байна. Хувийн хэвшлүүд энэ цоорхойг нөхсөөр байх ба ажил, мэргэжлийн шаардлагыг хангахын тулд хоёр дахин их хүчин чармайлт гаргана.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">• Уурхайн салбарт дутагдаад байгаа мэргэжил, үр чадварыг нөхөхөд чиглэсэн эх үүсвэрийг зохих ёсоор хуваарилах боломжтой болно.• Уурхайд шууд хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ.• ЖДҮ болон өртөг нэмсэн үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгөтэй болно.• Ажлын байрны нөхцөл эрс өөр өөр байх болно. Богино хугацаандаа бүтээн байгуулалтын явц нь үйл ажиллагааг хянах төрийн байгууллага болон иргэний нийгмийн нөөц, чадавхи сайжрах түвшингээс хурдацтай байна.

Технологи:

Бага / Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">• Дотоодын түвшинд судалгаа шинжилгээ явуулах технологийн эрэлт хэрэгцээ бага байх тул энэ боломжийг ашиглах магадлал доогуур байна.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">• Орон нутагт уул уурхайн салбар нөлөөллийг бууруулахад дэвшилтэт технологийг түлхүү ашиглана хэмээх хүлээлт ихэснэ.• Хууль эрх зүй, зохицуулалтын орчин сайжирснаар технологийн дэвшилд хөтөлнө.• Боловсрол, судалгааны байгууллагуудад уурхайн салбараас хөрөнгө оруулалт хийснээр дотооддоо явуулах судалгаа, шинжилгээ нэмэгдэнэ.



БОНСУ-ИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уул уурхайн салбарын хөгжлийн 3 хувилбарын хувьд бий болох байгаль орчин, нийгэм, эдийн засгийн эн тэргүүний чухал асуудлуудыг дээрх хүснэгтүүдэд тоймлон харууллаа. Дараах хүснэгтэнд нэгдүгээрт, уул уурхайн өсөлтийн хувилбаруудтай холбогдон үүссэн дээрх 12 асуудлуудыг шийдвэрлэх арга хэмжээний зөвлөмжүүд, хоёрдугаарт эдгээр арга хэмжээний зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд саад болж буй хууль эрх зүй, чадавхи, институцийн орчны дутагдал, сул талууд, эцэст нь, энэхүү сул талуудыг арилгахад хэрэгжүүлэх шаардлагатай бодлогын зөвлөмжүүдийг багтаасан болно. Дүн шинжилгээнээс харахад эдгээр сул талууд нь хууль эрх зүйн орчин, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх байгууллагын чадавхи, нөөц/урамшууллын хөшүүрэгтэй холбоотой байгааг анзаарч болохоор байна. Түүнчлэн, эдгээр санал болгож буй бодлогын зөвлөмжүүд нь өсөлтийн гурван хувилбарт ерөнхийдөө бүгдэд нь хамааралтай хэмээн дүгнэж болох юм.

Дээрх арга хэмжээний болон бодлогын зөвлөмжүүд, хууль эрх зүй, институцийн орчны дутагдал, сул талыг багцлан БОНСУ-ий Үйл ажиллагааны төлөвлөгөө (доорх хүснэгт) боловсруулсан ба зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацааг:

- Богино хугацааны: 2014 – 2017
- Дунд хугацааны: 2018 – 2020
- Урт хугацааны: 2021 – 2025 гэсэн хугацааг авч үзлээ.

ТХ-н хүснэгт 2 БОНСУ-ий Үйл ажиллагааны тайлан

Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
1	Ус								
1.1	Усны нөөцийн ашиглалт	Өсөлт өндөр байх тохиолдолд ирээдүйд хүндрэл үүсэх тул аймгуудад бий болох усны ирээдүйн эрэлт хэрэгцээг тодорхойлох.	Аймаг	Дундаж Өндөр	БОНХЯ	(i) усны нөөцийн шинж төлөв, (усны нөөцийн судалгааг үндэсний хэмжээний төлөвлөлтийн хүрээнд бус хэрэгжих гэж буй төсөл дээр алдаг оног хийдэг); (ii) уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй усны ирээдүйн эрэлтийн төсөөллийн талаар бүрэн дүүрэн ойлголт дутмаг.	5 жил тутамд: (i) үндэсний хэмжээний усны нөөцийн судалгаа; (ii) үндэсний хэмжээний усны эрэлтийн судалгаа гэсэн 2 төрлийн иж бүрэн судалгааг хийх.	Дунд, урт хугацаанд	БОНХЯ
		Уул уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй газрын доорх усны талаар иргэдийн дунд нэгдмэл ойлголтыг бий болгох үүднээс гүний хүдгийн хяналт шинжилгээний сүлжээг өргөтгөх.	Улс	Дундаж Өндөр	БОНХЯ "Ус" төрийн өмчит компани	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Дунд, урт хугацаанд	
		Усны салбарт ажиллаж буй байгууллага хоорондын усны нөөцийн удирдлагын чадавхи, зохицуулалт, хариуцлагыг дээшлүүлэх.	Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Дунд, урт хугацаанд	
		Усны үр ашигтай хэрэглээ, дахин ашиглах технологийг дэмжиж, санхүүгийн урамшуулал нэвтрүүлэх усны хэрэглээний үнэ тарифын шинэ журмын талаар уул уурхайн компаниудын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх (Ихэнх уул уурхайн компани бохир усыг дахин ашигладаг боловч ил уурхайгаас шавхсан газрын доорх усны урсацыг тэр болгон дахин ашигладаггүй).	Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Дунд, урт хугацаанд	



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
		(i) Бүх уурхайд усны тоолуур ашиглуулдаг болгох. (ii) Усны хяналт шинжилгээнд иргэдийг оролцуулах.	Аймаг	Бага Дундаж Өндөр	БОНХЯ	Нутгийн иргэдийг усны хяналт шинжилгээнд оролцох боломжоор хангасан эрх зүйн зохицуулалт байхгүй.	Нутгийн иргэдийг усны хяналт шинжилгээнд оролцуулах зохицуулалт бүхий өөрчлөлтийг байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой хууль, журамд оруулах.	Богино хугацаанд	БОНХЯ
		Усны нөөцийн удирдлагын талаарх ойлголтыг бүх оролцогч талууд түүний дотор төр, малчид, нутгийн иргэд, уул уурхайн компаниуд, иргэний нийгмийнхэний дунд дээшлүүлэх хөтөлбөрүүдийг хөхиүлэн дэмжих.	Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино хугацаанд	
		Нөхөн сэргээлт хийлгүй орхисон уурхайн компаниудаар уурхайн түр болон бүрэн нөхөн сэргээлт хийлгэхийг шаардах эрх зүй, хяналт, санхүүгийн хамгийн наад захын стандарт, боломжоор холбогдох байгууллагуудыг хангах.	Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Дунд, урт хугацаанд	
1.2	Гидрологийн нөхцлийн өөрчлөлт	Газрын дооорх усны орон зайн тархалтын (хэвтээ, босоо) талаарх илүү дэлгэрэнгүй (тоо хэмжээ, чанар) мэдээллийг бүрдүүлэх, усыг үр ашигтай болон дахин ашиглах боломжийг судлах.	Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ	Уул уурхайд ашиглахад тохиромжтой газрын доорх усны нөөцийн талаарх ойлголт муу. Уул уурхайн үйл ажиллагаанд их гүний уст давхаргаас ус ашигласаны улмаас нутгийн иргэд, малчдын хэрэглэж буй бага гүний уст давхаргын усны түвшин доошлох асуудлаарх ойлголт мэдлэгийн зөрүүтэй байдал.	Голуудын сав газрыг шаардлагатай судалгааг хийх эх үүсвэр, чадавхитай болгох.	Богино, дунд хугацаанд	БОНХЯ



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
1.3	Усны түвшин доошлох болон малчдын худаг ашиглалт	Малчдын ашиглаж буй худгийн хяналт шинжилгээнд нутгийн иргэдийг оролцуулах оролцоонд түшиглэсэн байгаль орчны хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Сум	Дундаж Өндөр	Сумын Засаг даргын Тамгын газар	Оролцоонд түшиглэсэн хяналт шинжилгээг зохион байгуулах, хэрэгжүүлэх чадавхи сул.	Оролцоонд түшиглэсэн хяналт шинжилгээг дэмжих үүднээс Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийг дагалдуулан холбогдох журмыг боловсруулах.	Богино хугацаанд	БОНХЯ
2	Газар								
2.1	Тусгай хамгаалалтай газарт үзүүлэх нөлөө	Бизнесийн хөгжил саарах үед хууль бусаар ан хийх, мод огтлох байдлыг нэмэгдүүлэхгүй байхад Тусгай хамгаалалтай газрын хамгаалалтын захиргаа анхаарч ажиллах нь зүйтэй.	Сум Аймаг	Бага	Тусгай хамгаалалтай газрын хамгаалалтын захиргаа	Эрсдэл: Орон нутгийн төсвийн орлого буурсаны улмаас тусгай хамгаалалттай газарт үйл ажиллагааг хэвийн явуулах орон нутгийн засаг захиргааны төсөв дутагдаж болзошгүй.	Эх үүсвэрийг нэн шаардлагатай арга хэмжээнд ашигладаг болгохын тулд төсвийн ил тод байдлыг сайжруулах.	Дунд хугацаанд	СЯ ЭЗХЯ
		Тусгай хамгаалалттай бүс нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулахгүй байх үүднээс Тусгай хамгаалалтай газрын хамгаалалтын захиргааны зохистой удирдлагыг хэвшүүлэн хэрэгжүүлэх.	Сум Аймаг	Өндөр	Тусгай хамгаалалтай газрын хамгаалалтын захиргаа	Орон нутгийн тусгай хамгаалалтай/хэрэгцээний газрын хил заагийн солбицол нарийвчлан тогтоогдоогүй.	Уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглох бүс нутгийг тогтоох талаар хэрэгжүүлж буй санаачилгыг эцэслэн олон нийтэд мэдээлэх.	Богино хугацаанд	БОНХЯ
2.2	Бэлчээрийн талхлагдал, алдагдал	Шаардлагатай бол төрийн өмчийн бэлчээрийн удирдлага, ашиглалтын чиглэлээр оролцогч бүх талууд түүний дотор малчид, тэдний нутаг усныхан, орон нутгийн засаг захиргааны үүрэг, хариуцлагыг тодорхой болгосон бодлого, хуулийг улам бүр боловсронгуй болгох.	Улс	Бага Дундаж Өндөр	БХБЯ	Малчид төрийн өмчийн бэлчээрийг үнэ төлбөргүй ашигладаг нь бэлчээрийг хамгаалах, үр ашигтай ашиглах хөшүүргийг алдагдуулж байна.	Бэлчээрийн үр дүнтэй менежментийн хууль эрх зүйн үндсийг бий болгох.	Богино, дунд хугацаанд	БХБЯ
		Газар ашиглах, эзэмших, өмчлөх эрхийг хамгаалах.	Сум	Бага Дундаж Өндөр	Сумын Засаг даргын Тамгын газар	Задгай бэлчээрийг малчдын бүлэгт түрээсээр эзэмшүүлэх эрх баталгаажуулахгүй.	Задгай бэлчээрийг малчдын бүлэгт түрээсээр эзэмшүүлэх эрх олгох хууль тогтоомжийг боловсруулан батлах.	Дунд хугацаанд	БХБЯ



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
		Уурхайн шууд нөлөөллийн бүсээс малчдыг нүүлгэх, байгалийн нөөц ашиглах боломжоо хязгаарлуулснаас алдсан алдагдалд нь нөхөн олговор олгох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх.	Улс	Бага Дундаж Өндөр	БХБЯ	Уул уурхайн шууд нөлөөллийн бүсээс малчдыг нүүлгэн шилжүүлэх, тэдэнд бэлчээрээ алдсаны нөхөн олговор олгох хууль эрх зүйн орчин бүрдээгүй.	Уул уурхайн салбарт нүүлгэн суурьшуулалтын үйл ажиллагаа, түүний дотор нөлөөлөлд өртсөн хүмүүст олгох нөхөн олговрыг зохицуулах хууль, журмыг боловсруулах, хэрэгжүүлэх.	Богино, дунд хугацаанд	БХБЯ
		Бэлчээр ашиглалтын уламжлалт эрхийг бүртгэх, бэлчээрийн ачаалал нэмэгдэж байгаагийн улмаас малчдын дунд бэлчээрийн газрын талаар маргаан үүсэхээс зайлсхийхийн тулд сумын түвшинд малчдын өөр өөр бүлгүүдийн ашиглаж буй задгай бэлчээрийн хилийг тодорхойлох.	Сум	Бага Дундаж Өндөр	Сумын Засаг даргын Тамгын газар	Бэлчээр ашигласны төлбөр, бэлчээрийг хамгаалах хариуцлагыг огт хүлээлгэхгүй байгаа өнөөгийн нөхцөл олон толгой малтай малчдад илүү ашигтай байгаа учраас өөр өөр малчдын бүлгүүдийн ашиглаж буй бэлчээрийг зааглан тогтоохыг дэмжих хөшүүрэг тэдэнд байхгүй байна.	Задгай бэлчээрийг малчдын бүлэгт түрээсээр эзэмшүүлэх эрх олгох хууль тогтоомжийг боловсруулан батлах.	Дунд хугацаанд	БХБЯ
		Бэлчээрээс үүдэлтэй зөрчилдөөнөөс сэргийлэх, бэлчээр хамгааллыг сайжруулах үүднээс задгай бэлчээрийг малчдын бүлэгт түрээсээр эзэмшүүлэх эрх олгох.	Улс	Бага Дундаж Өндөр	БХБЯ	Задгай бэлчээрийг малчдын бүлэгт түрээсээр эзэмшүүлэх эрх баталгаажуулахгүй.	Задгай бэлчээрийг малчдын бүлэгт түрээсээр эзэмшүүлэх эрх олгох хууль тогтоомжийг боловсруулан батлах.	Дунд хугацаанд	БХБЯ
		Уул уурхайн үйл ажиллагаанд хөндөгдсөн газрын хяналт шинжилгээнд малчдыг оролцуулах оролцоонд түшиглэсэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хөхиүлэн дэмжих.	Сум	Дундаж Өндөр	Сумын Засаг даргын Тамгын газар	Уул уурхайн үйл ажиллагааны бодит буюу жинхэнэ нөлөөллийн талаар нутгийн хүмүүст зохих ёсоор мэдээлдэггүй, иргэдийн оролцоотой газрын хяналт шинжилгээний тухай хууль эрх зүйн зохицуулалт байхгүй.	Оролцоонд түшиглэсэн хяналт шинжилгээг дэмжих үүднээс Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийг дагалдуулан холбогдох журмыг боловсруулах.	Богино хугацаанд	БОНХЯ
		Уул уурхайн нөлөөллийг бууруулах, бэлчээрийн удирдлагыг сайжруулахын тулд малчдын бүлэг байгуулах ажлыг хөхиүлэн дэмжих.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	Сумын Засаг даргын Тамгын газар	Малчдын бүлгээр дамжуулан бэлчээрийн удирдлагыг сайжруулах талаарх хууль эрх зүйн орчин бүрдээгүй.	Бэлчээрийн зүй зохистой менежментийн хууль эрх зүйн үндсийг бий болгох.	Богино, дунд хугацаанд	БХБЯ



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
		Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хүрээнд нутгийн иргэдийн оролцоотойгоор бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	Сумын Засаг даргын Тамгын газар	Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний хүрээнд уялдуулан боловсруулах асуудлыг онцолсон журам байхгүй.	Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг тооцон тусгах үүднээс сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулах журмыг эргэн харах.	Богино хугацаанд	БХБЯ
2.3	Газар, хөрсний чанарын доройтол	Уурхайн бүх талбайд нөхөн сэргээлтийг хийлгэх, нөхөн сэргээлт хийлгүйгээр орхих явдлыг гаргуулахгүй байх.	Сум Аймаг	Бага	Сумын Засаг даргын Тамгын газар	Нутгийн иргэдийг газрын нөхөн сэргээлтийн хяналт шинжилгээнд оролцуулах заалт хууль журманд байхгүй.	Ашигт малтмалын одоогийн хуулийн уурхайн хаалтын төлөвлөгөөний тухай заалтанд нутгийн иргэдийн саналыг оруулах заалтыг оруулах.	Богино хугацаанд	УУЯ
		Зайлсхийх, бууруулах, сааруулах арга хэмжээ авсан хэдий ч бууруулж чадаагүй уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах замаар сааруулах арга хэмжээний ил тод санаачлагыг хэрэгжүүлэх.	Аймаг Улс	Дундаж Өндөр	БОНХЯ	Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны журам байхгүй.	Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны журмыг боловсруулах, хэрэгжүүлэх.	Богино, дунд хугацаанд	БОНХЯ
		Уул уурхай, тээврийн шинэ бүтээн байгуулалтанд хөрс хамгаалах дизайн, технологи түүний дотор хатуу хучилттай зам, төмөр зам, уурхайн байнгын нөхөн сэргээлт, хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, замгүй газраар явдаг тээврийн хэрэгслийг хориглох, хэрэглэж болох тохиолдолд хөрс тогтворжуулах технологийг ашиглах хөшүүрэгтэй болгох	Улс	Дундаж Өндөр	БОНХЯ ЗТЯ	Арга хэмжээ явагдах хөшүүрэг байхгүй байна.	Хөшүүргийг бий болгох бодлого, аргачлалыг боловсруулах.	Богино, дунд хугацаанд	БОНХЯ
		Хөрсний чанарт үндэслэн уул уурхайн үйл ажиллагаанд тохиромжтой газрыг тогтоож, төлөвлөх	Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ ГХГЗГ	Хөрсний чанарын талаар мэдээлэл өгөх хөрсний чанарын үндэсний хэмжээний үнэлгээний систем, мэдээллийн сан байхгүй	Бизнесийн хөгжил болон бүсийн төлөвлөлтийг дэмжих үндэсний хэмжээний хөрсний чанарын үнэлгээний тогтолцоог бий болгох	Урт хугацаанд	БХБЯ



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
2.4	Газар зохион байгуулалт, хөрсний үржил шимийн өөрчлөлт	Уул уурхайн компаниудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан арга хэмжээг сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж хянах, тайлагнах.	Сум	Бага Дундаж Өндөр	Сумын Засаг даргын Тамгын газар	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй нийцүүлэх заалт, шаардлага байхгүй учраас энэ хоёр баримт бичиг уялдаа холбоогүй байна.	(i) Уул уурхайн компаниуд байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулахдаа сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг харгалзан тусгах шаардлага тавих нэмэлт өөрчлөлтийг БОНБУ-ий хуулийн дагуу холбогдох журамд оруулах. (ii) Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөг (Ашигт малтмалын хуулиар ийм шаардлага тавигддаг) оролцогч талуудтай зөвлөлдөн боловсруулах шаардлагыг оруулах нь зүйтэй.	Богино хугацаанд	БОНХЯ
		Уурхайн дэд бүтцийн улмаас хөрсний эвдрэл, бэлчээрийн доройтол үүсэх нь малчид, нутгийн иргэдийн санааг зовоосон асуудал болж байгааг анхааралдаа авах үүднээс тээврийн төлөвлөлтийн хүрээнд газар зохион байгуулалт, хөрс хамгаалах зорилтуудыг уялдуулан нэгтгэх.	Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ ЗТЯ	Тээврийн дэд бүтцийн төлөвлөлт болон газар зохион байгуулалтын төлөвлөлтийн байгууллага хоорондын уялдаа холбоо сул.	Төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг сайжруулах.	Богино хугацаанд	БХБЯ
3	Агаарын чанар								
3.1	Уурхайн нөлөөллийн бүс орчмын агаарын чанарын доройтол	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хүрээнд тоосжилтыг бууруулах арга хэмжээгээр дамжуулан уул уурхай, тээвэрлэлттэй холбоотой агаарын чанарын менежментийн хууль, тогтоомжийн мөрдөлтийг сайжруулах.	Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино хугацаанд	



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
		Хөрсний элэгдэл, тоосжилтыг бууруулдаг тээврийн төлөвлөлт, дэд бүтцийг хөхиүлэн дэмжих, жишээ нь, бүсийн тээврийн төлөвлөлт, хатуу хучилттай зам, төмөр зам г.м.	Улс	Дундаж	ЗТЯ БХБЯ	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах явцад орон нутгийн түвшинд иргэд, олон нийттэй ярилцаж, зөвлөлдөх ажиллагаа хангалттай сайн хийгддэггүй; Газар зохион байгуулалтын төлөвлөлтөнд салбарын уялдаа, нэгдмэл чанар байдаггүй;	Төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг сайжруулах.	Богино хугацаанд	БХБЯ
		Ард иргэдэд замгүй газраар олон салаа шинэ зам гарган зорчиж байгаагийн хор нөлөөний талаарх ойлголт өгөх, орчны тоосны түвшинг хэмжих, түүнчлэн олон нийтийн оролцоог хангасан тоосжилтыг хянах оролцооны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх.	Сум	Бага Дундаж Өндөр	Сумын Засаг даргын Тамгын газар Аймгийн Байгаль орчны газар	Нутгийн иргэд тоосжилтын хяналт шинжилгээнд оролцох боломжийг олгосон заалт байхгүй.	Нутгийн иргэдэд түшиглэсэн хяналт шинжилгээг дэмжих үүднээс Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийг дагалдуулан холбогдох журмыг боловсруулах.	Богино хугацаанд	БОНХЯ
		Уул уурхайн үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган бууруулах, уг төлөвлөгөөнд тоосны нөлөөллийн бүсийг тодорхойлох, нөлөөлөлд өртсөн хүмүүсийг нүүлгэн суурьшуулах арга хэмжээг уг төлөвлөгөөнд тусгах.	Сум	Бага Дундаж Өндөр	Сумын Засаг даргын Тамгын газар	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах явцад орон нутгийн түвшинд иргэд, олон нийттэй ярилцаж, зөвлөлдөх ажиллагаа хангалттай сайн хийгддэггүй; Газар зохион байгуулалтын төлөвлөлтөнд салбарын уялдаа, нэгдмэл чанар байдаггүй;	Төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг сайжруулах	Богино хугацаанд	БХБЯ
		Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй нөлөөлөл, бууруулах арга хэмжээний үр дүнг хэмжих үүднээс бүсийн хэмжээнд тоосжилтын хяналт шинжилгээний сүлжээг бий болгох.	Улс	Дундаж Өндөр	БОНХЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино хугацаанд	



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
		Уурхайн дэд бүтцийн улмаас хөрсний эвдрэл, бэлчээрийн доройтол үүсэх нь малчид, нутгийн иргэдийн санааг зовоосон асуудал болж байгааг анхааралдаа авах үүднээс тээврийн төлөвлөлтийн хүрээнд газар зохион байгуулалт, хөрс хамгаалах зорилтуудыг уялдуулан нэгтгэх.	Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ ЗТЯ	Тээврийн болон газар зохион байгуулалтын төлөвлөлтийн байгууллага хоорондын уялдаа, зохицуулалт сул.	Төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг сайжруулах.	Богино хугацаанд	БХБЯ
		Уул уурхайн үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган бууруулах, уг төлөвлөгөөнд тоосны нөлөөллийн бүсийг тодорхойлж тухайн газруудад (ашигт малтмалын тээврийн том замуудын ойролцоо г.м.) суурьшил бий болохоос урьдчилан сэргийлэх.	Сум	Бага Дундаж Өндөр	Сумын Засаг даргын Тамгын газар	Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тоосжилтод өртөх бүсийг тогтоон тусгадаггүй.	Тоосжилтод өртөх бүсэд бүтээн байгуулалт явуулахгүй байх үүднээс сумын төлөвлөлтийн байгууллагын чадавхийг дээшлүүлэх, түүнчлэн тоосжилтод өртөөд байгаа бүсэд одоо амьдарч байгаа оршин суугчдыг нүүлгэн суурьшуулах чиглэлийг боловсуулах.	Богино хугацаанд	БХБЯ
3.2	Хот суурингийн бүсийн агаарын чанарын доройтол	Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийг цаашид дэмжих.	Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
4	Уул уурхайн компаниудын байгаль орчны менежмент								
4.1	Уул уурхайн компаниудын байгаль орчны менежмент	Багийн хурлаар уул уурхайн компаниудын татвар төлөлт, орон нутгийг хөгжүүлэх чиглэлээр хийж буй ажил, санаачилгын талаар мэдээлэх замаар орон нутгийн удирдлагын зүгээс уул уурхайн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах.	Сум	Дундаж Өндөр	Сумын Засаг даргын Тамгын газар	Энэ үйл ажиллагаанд мөрдөх журам, дүрэм байхгүй.	Холбогдох журам, зааврыг боловсруулах.	Богино, дунд хугацаанд	ЭЗХЯ



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
		Орон нутгийн захиргаанаас хяналт шинжилгээг илүү ойр ойр хийдэг байх.	Аймаг	Дундаж Өндөр	Аймгийн Мэргэжлийн хяналтын алба	Уул уурхайн компаниудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавих хөрөнгө, хүч дутагдалтай.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянах үйл ажиллагаанд хуваарилах төсвийг нэмэгдүүлэх, сумын байгаль орчны байцаагчдыг чадавхижуулах.	Дунд хугацаанд	БОНХЯ
		Нутгийн засаг захиргаатайгаа хамтран ажилласанаар нутгийн иргэд уул уурхайн компаниудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад оролцохыг дэмжих.	Сум	Бага Дундаж Өндөр	Сумын Засаг даргын Тамгын газар	Нутгийн иргэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад оролцох асуудлыг зохицуулсан журам байхгүй.	(i) Нутгийн иргэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад оролцох бололцоо олгох нэмэлт өөрчлөлтийг БОНБУ-ий хуулийн дагуу холбогдох журманд тусгах. (ii) Ашигт малтмалын хуулинд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад талуудыг оролцуулах талаар заалт оруулах.	Богино хугацаанд	БОНХЯ ууя
		Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөг батлуулахын өмнө олон нийт, нутгийн иргэдээр хэлэлцүүлэхээр нээлттэй мэдээлэх.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	Сумын Засаг даргын Тамгын газар Аймгийн Байгаль орчны газар БОНХЯ	Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөг батлуулахын өмнө олон нийт, нутгийн иргэдээр хэлэлцүүлэхээр нээлттэй мэдээлэхийг хууль, журмаар шаарддаггүй.	i) Нутгийн иргэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад оролцох бололцоо олгох нэмэлт өөрчлөлтийг БОНБУ-ий хуулийн дагуу холбогдох журманд тусгах. (ii) Ашигт малтмалын хуулинд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад талуудыг оролцуулах талаар заалт оруулах.	Богино хугацаанд	БОНХЯ ууя



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
		Уурхайн байгаль орчны менежменттэй холбоотой одоогийн мөрдөгдөж буй байгаль орчны бодлогууд, хууль, журмуудын биелэлтийг талуудыг чадавхижуулах арга хэмжээ, санаачилгаар дамжуулан улам бүр хангах.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.		
4.2	Байгаль орчны журам	Дүйцүүлэн хамгаалах бодлогыг бэхжүүлэх.	Аймаг Улс	Дундаж Өндөр	БОНХЯ	Дүйцүүлэн хамгаалах асуудлыг БОНБУ-ий хуульд заасан хэдий ч нарийвчлан зохицуулсан журам, аргачлал байхгүй.	Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны журам, аргачлалыг боловсруулах.	Богино хугацаанд	БОНХЯ
4.3	Уул уурхайн компаниудын нөхөн сэргээлт	Уурхайн хаалтын бэлтгэлийг эртнээс тасралтгүй явуулах болон нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд урамшуулал хөшүүргийг бий болгох.	Сум	Дундаж Өндөр	БОНХЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
		Нутгийн иргэдийг газрын нөхөн сэргээлт хийхэд татан оролцуулах хөшүүргийг уул уурхайн компаниудад бий болгох.	Сум	Дундаж Өндөр	БОНХЯ	Урамшуулал, хөшүүрэг байхгүй.	Хөшүүргийг бий болгох холбогдох журам, зааврыг боловсруулах.	Богино, дунд хугацаанд	БОНХЯ
		Уурхайн хаалт, газрын нөхөн сэргээлтийн хяналт шинжилгээг сайжруулах.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	Сумын Засаг даргын Тамгын газар Аймгийн Байгаль орчны газар	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
4.4	Биологийн олон янз байдалд үзүүлж буй нөлөөлөл	Уул уурхайн компаниуд нутгийн иргэдийг биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах хөшүүргийг бий болгох	Сум	Дундаж Өндөр	БОНХЯ	Урамшууллын хөшүүрэг байхгүй.	Урамшууллын бодлого, журмыг боловсруулах.	Богино, дунд хугацаанд	БОНХЯ



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
4.5	Хог хаягдал	Аюултай хог хаягдлыг зайлуулах байгууламж байгуулах, уурхайн талбай дахь аюултай хаягдлыг зайлуулах асуудалд тавих хяналтыг сайжруулах.	Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ Аймгийн Байгаль орчны газар	Уул уурхайн салбараас гарч байгаа аюултай хог хаягдлыг зайлуулах байгууламж байдаггүй.	Аюултай хог хаягдлыг зайлуулах шаардлагад нийцсэн үндэсний хэмжээний байгууламж байгуулахад дэмжлэг үзүүлэх үүднээс бэлтгэл ажлын санхүүжилтийн зэрэгцээ урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Богино хугацаанд	БОНХЯ
5	Хувиараа ашигт малтмал олборлолт								
5.1	Хувиараа ашигт малтмал олборлох салбарыг гадуурхах	Одоогийн хууль эрх зүйн зохицуулалтыг мөрдүүлэх замаар бичил уурхайн салбарыг улам бүр албажуулах.	Улс	Бага Дундаж Өндөр	УУЯ	Одоогийн хууль эрх зүйн зохицуулалтыг үр дүнтэйгээр мөрддөггүй. Бичил уурхайн салбарын хууль эрх зүйн орчин, салбарын үр өгөөжийг сайжруулах улс төрийн хүсэл зориг үндэсний хэмжээнд бага.	Одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомжийг дараах чиглэлээр судалж үзэх: ○ Үндэсний хэмжээнд БУ-н хэвийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөх асуудлыг хэрхэн сайжруулж болох; ○ УУЯ-ны бүтцэд бичил уурхайн асуудлыг тусад нь эрхэлсэн дэд сайдтай болох. Үүнд энэхүү үйл ажиллагаанд зориулагдсан төсвийн эх үүсвэр мөн багтана.	Богино, дунд хугацаанд	УУЯ
		Чадавхижуулах, туршлага солилцох, бичил уурхайн салбарын удирдлага, зохицуулалтыг хариуцсан төрийн албаны ажилтнуудын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх сургалтыг явуулах.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	УУЯ	Төрийн байгууллагын ажилтнуудын мониторинг, үнэлгээний чадавхи тааруу. Адил түвшний байгууллагуудын уялдаа, хамтын ажиллагаа, сум, аймгийн хооронд, улсын хэмжээнд мэдлэг, туршлагаасаа хуваалцах нь бага.	Төрийн байгууллагын ажилтнуудын бичил уурхайн салбарын асуудлаар ажиллах чадварыг сайжруулах.	Богино хугацаанд	УУЯ



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
		Хувиараа ашигт малтмал олборлогчид нөхөн сэргээлтийг амжилттай хийсэн талаар болон тэдний орон нутгийн эдийн засагт оруулж буй хувь нэмрийн талаар мэдээлэх замаар бичил уурхайн тухай олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх.	Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	УУЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
		Уул уурхайн компаниуд, сумын захиргаа, бичил уурхайчдын хооронд туршлага солилцох замаар хамтран ажиллах.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	УУЯ Сумын Засаг даргын Тамгын газар Аймгийн Засаг даргын Тамгын газар	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж оруулах шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
5.2	Хувиараа ашигт малтмал олборлох салбарын эдийн засгийн нөлөөлөл	Хувиараа ашигт малтмал олборлох салбарын тогтвортой хөгжлийг дэмжих үүднээс уурхайн ажлын ур чадвар, мөнгөн үс хэрэглэхгүй байх зорилтот хөтөлбөрийг санхүүжүүлэх, нөхөрлөлийг албан ёсоор байгуулах.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ УУЯ	Бичил уурхайн салбарыг Монгол улсын эдийн засагт хувь нэмэр оруулж чадахуйц тогтвортой салбар хэмээн хүлээн зөвшөөрөхөөс илүү түр зуурын үзэгдэл гэж үздэгээс энэ салбарт зохистой санхүүжилтийн механизм, дэмжлэг байдаггүй.	Зорилтот хөтөлбөрүүдэд төсөв хуваарилах.	Дунд хугацаанд	УУЯ
		Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдэд бүтээгдэхүүний чанараа сайжруулах, өртөг нэмэх (үнэт эдлэл) талаар сургалт хийх.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	УУЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж оруулах шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
		Хувиараа ашигт малтмал олборлогч иргэд бусад салбарт хөдөлмөр эрхлэх чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	Сумын Засаг даргын Тамгын газар Аймгийн Засаг даргын Тамгын газар	Төрийн байгууллагын ажилтнууд хувиараа ашигт малтмал олборлогчдод хүрч, хамтран ажиллах туршлага, чадвар дутмаг.	Хувиараа ашигт малтмал олборлогчдын асуудлаар ажиллах төрийн байгууллагын ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх.	Богино хугацаанд	УУЯ
		Шударга худалдаа, шударга уурхай санаачилга зэрэг санаачилгын хэрэгжилтийг дэмжих.	Улс	Бага Дундаж Өндөр	УУЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж оруулах шаардлагагүй.	Богино хугацаанд	



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
5.3	Хувиараа ашигт малтмал олборлогчидт ойхолбоотой эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, байгаль орчны асуудал	Сургалт, дагалдуулан сургах замаар хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн байгаль орчны менежмент, нөхөн сэргээлт, аюултай бодис ашиглах чиглэлээр чадавхи, хариуцлагыг сайжруулах.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	БОНХЯ УУЯ	Хувиараа ашигт малтмал олборлогчдын мэргэжлийн чадавхи сул, боловсрол тааруу, ЭМАА-ны асуудалд хяналт тавьж, удирдах санхүүгийн эх үүсвэр хүрэлцээгүй.	Чадавхийг бий болгох хөтөлбөрийг санхүүжүүлэх төсөв хуваарилах.	Дунд хугацаанд	БОНХЯ
		Бичил уурхайн үйл ажиллагаанд зориулан газар хуваарилах тухай одоогийн мөрдөгдөж буй журмыг сайжруулах.	Улс	Бага Дундаж Өндөр	УУЯ	Одоогийн мөрдөгдөж буй журмаар бичил уурхайн салбарыг албажуулсан хэдий ч 2012 онд бичил уурхайд тохиромжтой ихэнх газруудыг геологийн хайгуул хийх зориулалтаар төрийн нөөцөд авсан тул шинээр талбай олгогдохгүй, цаашлаад энэ салбарт хууль, журмын дагуу үйл ажиллагаа явуулах боломж бүрдэхгүй байна.	Бичил уурхайн журмыг хэрэгжүүлэх нөхцлийг бий болгох.	Дунд хугацаанд	УУЯ
		Хувиараа ашигт малтмал олборлогчдын эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах.	Улс	Бага Дундаж Өндөр	ЭМЯ	Орон нутгийн эмнэлгүүд төсөв хүрэлцэхгүйн улмаас хэвтэж эмчлүүлэх зэрэг эрүүл мэндийн үйлчилгээг хувиараа ашигт малтмал олборлогчдод үзүүлдэггүй, хувиараа ашигт малтмал олборлогчдод хүргэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах бодлого байхгүй.	Орон нутгийн эмнэлгүүдийн төсвийн хуваарилалтад хувиараа ашигт малтмал олборлогчдыг тооцох.	Богино хугацаанд	ЭМЯ
		Хувиараа ашигт малтмал олборлогч хүмүүсийн эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийн судалгааг явуулах, бичил уурхайтай холбоотой өвчлөлөөс хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг урьдчилан сэргийлэх.	Улс	Бага Дундаж Өндөр	ЭМЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
		Бичил уурхайд мөнгөн усны хэрэглээний өнөөгийн байдал түүний дотор нийлүүлэлт, гарал үүслийн судалгааг цаашид дэмжих мэргэжлийн туслалцаа, сургалт, түүнчлэн мөнгөн ус ашиглахгүйгээр боловсруулах үйлдвэр байгуулах жижиг зээл олгох зэрэг нь төрийн бүх түвшний байгууллагууд судалж үзүүштэй стратеги юм.	Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ ууя	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
6	Соёлын өв								
6.1	Соёлын биет бус өв алдагдах	Соёлын өвийн дэд бүтэц, чадавхийг бий болгох хамтын ажиллагааг бэхжүүлэх.	Сум Аймаг	Дундаж Өндөр	ССАЖЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино хугацаанд	
		Соёлын биет бус өвийг хамгаалах, соёлын биет бус өв тээгчдийг дэмжих хөшүүргийг уул уурхайн компаниудад бий болгох.	Сум Аймаг	Дундаж Өндөр	ССАЖЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
		Соёлын өвд уул уурхайн үзүүлж буй нөлөөний тухай нэгдмэл ойлголтыг олон нийтэд хүргэхийн тулд уул уурхайн салбарын соёлын биет бус өвд үзүүлж буй нөлөөллийн судалгааг үндэсний хэмжээнд явуулах.	Улс	Дундаж Өндөр	ССАЖЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
		Уламжлалт мал ахуй эрхлэгчдийг сэргээгдэх эрчим хүч, мэдээллийн технологи зэрэг орчин үеийн технологиор бэхжүүлэх.	Сум Аймаг	Дундаж Өндөр	БОНХЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Дунд хугацаанд	



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
6.2	Соёлын биет өв алдагдах	Уул уурхайн үйл ажиллагааны дүнд их ба дунд хэмжээгээр хөндөгдөх газар нутагт суурь судалгаа (археологи ба палеонтологийн) явуулах. Уг суурь судалгааг ердийн судалгаа явуулахаас богино хугацаанд, бага зардлаар урьдчилан гаргасан загварчлалыг хэрэгжүүлэх замаар гүйцэтгэх. Эдгээр судалгаануудад үндэслэн нутгийн иргэдийн оролцоотойгоор хамгаалалтын бүсийг тодорхойлж уг биет соёлын өвийн бүсэд уурхайн үйл ажиллагаа явуулахгүй байхыг уурхайн компанид мэдэгдэх.	Улс	Дундаж Өндөр	ССАЖЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
		Их, дунд хэмжээгээр хөндөгдөж болзошгүй соёлын өвийн нөөц бүхий газар нутагт суурь судалгаа явуулах зардлыг уурхай болон бусад олборлох салбарын компаниудаар төлүүлэх, үүнд зориулсан сан байгуулах.	Улс	Бага Дундаж Өндөр	ССАЖЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
		Уул уурхай, аялал жуулчлалын компаниуд, нутгийн иргэдийг оролцуулан соёлын өвийг хамгаалах төслийг санаачлан хэрэгжүүлэх. Уурхайн үйл ажиллагаанаас археологи, палеонтологийн өвд үзүүлэх нөлөөллийг хянахад малчид, олон нийтийг оролцуулах ажлыг зохион байгуулах.	Сүм	Дундаж Өндөр	ССАЖЯ Сумын Засаг даргын Тамгын газар	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Дунд хугацаанд	
		Соёлын өвийг хамгаалах хуультай нийцээгүй тохиолдолд торгууль ногдуулан хэрэгжүүлэх.	Улс	Бага Дундаж Өндөр	ССАЖЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)	
		Уул уурхайн үйл ажиллагаа өрнөж буй газруудад уул уурхайн компаниудад зориулсан соёлын өвийн талаарх танилцуулга хөтөлбөр боловсруулахад сумын засаг захиргаанд туслалцаа үзүүлэх.	Сум	Дундаж Өндөр	Сумын Засаг даргын Тамгын газар	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд		
		Уурхайн нөлөөнд өртөх соёлын өвийн эрэл хайгуулыг хариуцах болон нөөцийг хянах олон тооны мэргэжлийн археологич, палеонтологич, биет бус соёлын өвийн мэргэжилтнүүдийг агентлагуудын хүрээнд соёлын өвийг хамгаалах олон улсын шилдэг туршлагад сургах, чадавхижуулах ажлыг зохион байгуулах.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	ССАЖЯ Сум/аймгийн Засаг даргын Тамгын газар	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд		
7	Хүний эрх, нийгмийн хариуцлага									
7.1	Нутгийн иргэдийн оролцоо, хүлээлтийг удирдах	Уул уурхайн үйл ажиллагааны талаарх шийдвэр гаргах үйл явцад нутгийн иргэдийн оролцоог сайжруулах, нутгийн иргэдэд хангалттай мэдээлэл өгч, мэдлэг, ойлголт, чиглэлтэйгээр оролцох бололцоог хангах	Сум	Бага Дундаж Өндөр	Сум/Аймгийн ИТХ	Нутгийн иргэдэд өнгөц мэдээлэл сонсгох төдийгөөр ёс төдий оролцуулдаг тул энэ нь жинхэнэ оролцоо буюу хамтын ажиллагаа болдоггүй.	Уул уурхайн салбарт нийгмийн хариуцлагын гүйцэтгэлийг зохицуулах хууль тогтоомжийг боловсруулах хэрэгжүүлэх, НҮБ-ын холбогдох олон улсын гэрээ, харгалзах салбарын жишиг стандартын (ОУСК, Аюулгүй ажиллагаа, Хүний эрхийн сайн дурын зарчмууд) заалтуудыг хэрэгжүүлэх.	Дунд, урт хугацаанд	ХАХНХЯ ЭЗХЯ УУЯ	
		Орон нутгийн засаг захиргаанд зориулан нутгийн иргэдийг шийдвэр гаргах үйл явцад оролцуулах тухай журам зааврыг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхийг дэмжих.		Бага Дундаж Өндөр	Ерөнхийлөгчийн Тамгын газар	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж оруулах шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд		



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сүл тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
		Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх.	Улс	Бага Дундаж Өндөр	ЭЗХЯ	Компаний нийгмийн хариуцлагын талаарх хууль эрх зүйн баримт бичиг байхгүй.	Компаний нийгмийн хариуцлагын талаарх хууль эрх зүйн баримт бичгийг гаргах.	Дунд хугацаанд	ЭЗХЯ
		Компаний нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж болох үйл ажиллагааны тухай нутгийн иргэд, уул уурхайн компаниудын дунд нэгдмэл ойлголттой болгох.	Улс	Бага Дундаж Өндөр	ЭЗХЯ УУЯ	Компаний нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж болох үйл ажиллагааны тухай нутгийн иргэд, уул уурхайн компаниудын дунд нэгдмэл ойлголтгүйгээс бизнест саатал үүсч, нутгийн иргэдийн хүртэх өгөөж нь бага байна.	Компаний нийгмийн хариуцлагын талаарх хууль эрх зүйн баримт бичгийг гаргах.	Дунд, урт хугацаанд	ЭЗХЯ
		Нутгийн иргэд, уул уурхайн компаниудын хооронд ажил хэрэгч хэлэлцүүлэг хийж, санал солилцох замаар уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн тухай нэгдмэл ойлголттой байх, хамтын ажиллагааг сайжруулах.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	УУЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
7.2	Нутгийн иргэдийн эрх	Уул уурхайн компаниудын явуулж буй нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааг стандартчлах.	Улс	Дундаж Өндөр	БХБЯ	Монгол улсад нүүлгэн суурьшуулалтыг зохицуулах хууль эрх зүйн орчин бүрдээгүйгээс уул уурхайн компаниудын явуулж буй нүүлгэн суурьшуулах үйл ажиллагаанд эмх замбараагүй байдал, ялгавартай байдал үүсэхэд хүргэж байна.	Уул уурхайн салбарт нүүлгэн суурьшуулах үйл ажиллагаа, түүний дотор нөлөөлөлд өртсөн хүмүүст эрх тэгш, шударга нөхөн олговор олгох асуудлыг зохицуулах хууль боловсруулан хэрэгжүүлэх.	Богино, дунд хугацаанд	БХБЯ



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
		Байгаль орчны өнөөгийн тогтоомж, журмуудад нийцүүлэн нийгмийн хариуцлагыг зохицуулах заалтуудыг нэмж оруулах.	Улс	Бага Дундаж Өндөр	ХАХНХЯ БОНХЯ УУЯ	Засгийн газраас байгаль орчны үр нөлөө бүхий хууль тогтоомжийг хэрэгжүүлэх сайн алхмууд хийсэн ч хүний эрх, нийгмийн асуудлыг хэрхэн зохицуулах тал дээр анхаарлаа хандуулаагүй, зохицуулалтууд дутмаг байна.	Уул уурхайн салбарт нийгмийн хариуцлагын гүйцэтгэлийг зохицуулах хууль тогтоомжийг боловсруулан хэрэгжүүлэх, НҮБ-ын холбогдох олон улсын гэрээ, харгалзах салбарын жишиг стандартын (ОУСК, Аюулгүй ажиллагаа, Хүний эрхийн сайн дурын зарчмууд) заалтуудыг хэрэгжүүлэх.	Дунд хугацаанд	ХАХНХЯ ЭЗХЯ УУЯ
		Уламжлалт газар ашиглах эрх, газар ашиглах эрхийн төрлүүдийн талаарх уул уурхайн компаниуд болон олон нийтийн ойлголт мэдлэгийг сайжруулах.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	БХБЯ	Монгол улсад хүний эрхийн талаарх ойлголт мэдлэг дутмаг, иргэд, уул уурхайн компаниудын аль аль нь өөрсдийн эрхийнхээ талаар нимгэн мэдлэгтэй байдаг.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
		Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр төлөвлөлтгүй үүссэн суурьшлын бүсэд амьдарч байгаа хүмүүсийг нийгмийн үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах.	Сум	Дундаж Өндөр	ХНХЯ	Шилжин ирэгсдэд нийгмийн үйлчилгээг хүргэхийн тулд уул уурхайн ойролцоох бүсэд байгаа хот, сууринд нэмэлт төсөв хуваарилагддаггүй.	Урт хугацаанд бүсийн төлөвлөлтийг боловсронгуй болгох, ойрын ирээдүйд уул уурхайн бүсийн ойролцоох хот, сууринд төсвийг нэмж хуваарилах.	Богино, дунд хугацаанд	БХБЯ ЭЗХЯ
		Уул уурхайн бүх компаниудын дунд компаний хэмжээний нийгмийн хариуцлагын үзэл санааг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр одоо явуулж буй ажиллагааг дэмжих.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	УУЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
8	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа								
8.1	Нутгийн иргэдийн эрүүл мэнд,	Бүх түвшинд олон нийтийн эрүүл мэндийн эрсдлийн талаар ойлголт мэдлэг өгөх хөтөлбөрийг сурталчлах, дэмжих.	Улс	Бага Дундаж Өндөр	ЭМЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сүл тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
	аюулгүй ажиллагаа	Осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нөхөн олговор, нөхөн сэргээх эмчилгээний тогтолцоог боловсруулан, хэрэгжүүлэх.	Улс	Бага Дундаж Өндөр	ЭМЯ	Тогтолцоо байхгүй.	Осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нөхөн олговор, нөхөн сэргээх эмчилгээний хууль, эсвэл журмыг боловсруулах.	Богино, дунд хугацаанд	ХЯ
		Байгаль орчны нарийвчилсан бүх үнэлгээнд нөлөөлөлд өртөх олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг тодорхойлох.	Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ Аймгийн Байгаль орчны газар	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
		Нөлөөлөлд өртсөн олон нийтэд зориулсан Эрүүл мэндийн санг үндэсний хэмжээнд байгуулж, уул уурхайгаас орсон орлогоос нөлөөлөлд өртсөн иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн үйлчилгээг хүргэх үйл ажиллагааг санхүүжүүлэх.	Улс	Дундаж Өндөр	ЭМЯ	Нөлөөлөлд өртсөн олон нийтэд зориулсан эрүүл мэндийн санг байгуулах зохицуулалт байхгүй.	Уул уурхайгаас орсон орлогоос нөлөөлөлд өртсөн иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, нөлөөлөлд өртсөн нутгийн иргэдийн эрүүл мэндийг сайжруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх. Нөлөөлөлд өртсөн олон нийтэд зориулсан эрүүл мэндийн санг байгуулах нэмэлт өөрчлөлтийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд оруулах.	Богино хугацаанд	СЯ
		Уурхайн ойролцоох нөлөөлөлд өртсөн нутгийн иргэдэд зориулан стандарт хангасан, шаардлагатай тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон эмнэлгүүдийг уул уурхайн компаниудтай хамтран барих, ажиллуулах.	Сум Аймаг	Дундаж Өндөр	ЭМЯ	Нөлөөлөлд өртсөн нутгийн иргэд үйлчлүүлэх стандарт хангасан эмнэлгийн хүртээмж муу.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
8.2	Ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа	Олон улсын тэргүүний туршлага, арга ажиллагааг одоогийн мөрдөж буй хуулиудад нэгтгэх	Улс	Бага Дундаж Өндөр	ЭМЯ	Нэгтгэн зангидах систем байхгүй.	Одоогийн мөрдөж буй хуулиудын хүрээнд бий болсон тэргүүний туршлага, арга ажиллагааг нэгтгэн зангидах үйл явцыг боловсруулах.	Богино хугацаанд	ХЯ ХАХНХЯ



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
		Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг чадавхижуулах.	Улс	Бага Дундаж Өндөр	МХЕГ	Чадавхижуулах хөтөлбөр байхгүй.	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг чадавхижуулах хөтөлбөрийг боловсруулах.	Богино хугацаанд	МХЕГ
8.3	Малын эрүүл мэнд, аюулгүй байдал	Мал зам хөндлөн гарах гарцыг төлөвлөх үүднээс малчдыг тээврийн төлөвлөлтөнд оролцуулах.	Сум Аймаг Улс	Дундаж Өндөр	ЗТЯ	Нэг мөр болж тогтсон зүйл үгүй.	Замын зураг төслийн болон төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх.	Дунд хугацаанд	ЗТЯ БХБЯ
9	Засаглал, орлогын менежмент								
9.1	Орлогын менежмент	Улс, аймаг, сумдын аль алины түвшинд баялгийн хуваарилалтын илүү үр нөлөөтэй, ил тод арга арга хэмжээг хэрэгжүүлэх. Үндэсний, аймаг болон сумын түвшинд ил тод байдал дээшилснээр орлогын хуваарилалтын талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болно.	Улс	Бага Дундаж Өндөр	СЯ ЭЗХЯ	Одоогийн байдлаар уул уурхайгаас орж байгаа орлогыг янз бүрийн түвшинд цуглуулан, зарцуулалт нь тодорхой бус, нутгийн иргэд, хүмүүст энэ талаар мэдээлдэггүй. Тиймээс нутгийн хүмүүс, иргэд уул уурхайн төсөл, хөгжил, орлогын өгөөжийн хоорондын холбоог тэр бүр олж харж чаддаггүй.	Улсын төсөв боловсруулах ажилд шинжилгээ хийх, аймгуудад оруулж буй хувь нэмрийг нь харгалзан төсөв хуваарилах хууль эрх зүйн үндсийг бүрдүүлэх, уул уурхайн орлогоос төсвийг нэмж хуваарилах замаар аймгуудад уул уурхайн компаниудтай хамтран ажиллах хөшүүрэг урамшууллыг бий болгох.	Богино хугацаанд	СЯ ЭЗХЯ
		Хөгжлийн бодлого, стратеги, төлөвлөгөөг боловсруулахдаа орон нутгийн удирдлага, иргэдэд мэдээлэн, саналыг авдаг байх, орон нутгийн түвшинд гаргасан бодлогын баримт бичгүүдийг үндэсний бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах механизмыг боловсруулан хэрэгжүүлэх.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	ЭЗХЯ	Орон нутгаас мэдээлэл авч оруулах механизм сул, Бодлого боловсруулах ажлыг төрийн байгууллагын хариуцах асуудал гэж үздэг. Засгийн газар солигдоход аймгийн хөгжлийн бодлогыг бие даан тогтвортой хэрэгжүүлэх боломжгүй.	Сум, аймаг, үндэсний хөгжлийг төлөвлөхөд иргэд, холбоод, орон нутгийнхан оролцож, түүнтэй танилцан судалж, саналаа өгөхийг хуулинд оруулах.	Богино хугацаанд	ЭЗХЯ
		Уул уурхайгаас орж байгаа орлогын дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд интернэтээр мэдээлэн хүргэх эхлэлийн суурь мэдээллийг бий болгох.	Улс	Бага Дундаж Өндөр	СЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
		Улс, аймаг, суманд уул уурхайгаас орж байгаа орлогоос бусад салбаруудад хуваарилж байгаа тухай мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх.	Улс	Бага Дундаж Өндөр	СЯ	Орлогын шинжилгээг засаг захиргааны өөр өөр түвшинд хийх систем байхгүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
		Аймгийн ОУИТБС-ын төлөөлөгчийн газрын чадавхийг бэхжүүлэх, ингэснээр иргэдийн дунд ОУИТБС-ын талаар ойлголт, мэдээлэл солилцоог нэмэгдүүлэн, ОУИТБС-ын талаар мэдээлэл авах боломжтой болгох.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	ОУИТБС	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Дунд хугацаанд	
		Уул уурхай ихээр хөгжин уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд илүү өртөж буй сум, аймгуудад нэмэлт төсөв хуваарилах.	Улс	Бага Дундаж Өндөр	СЯ ЭЗХЯ	Уул уурхайгаас орж буй орлогыг, орлого оруулснаар нь аймаг, сумуудад буцаан хуваарилах асуудлыг зохицуулсан заалт байхгүй.	Аймгуудын оруулсан орлогыг харгалзан төсөв хуваарилах хууль зүйн зохицуулалтыг бий болгох.	Богино хугацаанд	СЯ ЭЗХЯ
		Хариуцлагатай уул уурхайн санаачилга, ОУИТБС зэрэг байгууллагуудтай уул уурхайн компаниудын татвар, төлбөрийн мэдээллийг нутгийн иргэдэд нээлттэй мэдээлэх талаар нягт хамтран ажиллах.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	УУЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Дунд хугацаанд	
		ОУИТБС-аас гадна сайн засаглалыг дэмжин хөндлөнгийн ажиглагчид (watchdog)-ыг ажиллуулах иргэний нийгмийн үйл ажиллагааг дэмжих.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	УУЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Дунд хугацаанд	
9.2	Макро эдийн засгийн нөлөө	Эдийн засаг, бизнесийг хөгжүүлэх цогц хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр эрдэс баялгаас бусад салбарыг аймаг, сумуудад дэмжин хөгжүүлэх.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	ҮХААЯ ЭЗХЯ	Эрдэс баялгаас бусад салбарыг аймаг, сумуудад хөгжүүлэхэд санхүү, хүний нөөцийн чадавхи дутагдалтай.	Эрдэс баялгаас бусад салбарыг хөгжүүлэх орон нутгийн чадавхийг сайжруулах.	Урт хугацаанд	ҮХААЯ



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
		Бизнесийн үр чадварыг дээшлүүлэх зөвлөгөө өгөх, сургалтын үйлчилгээ үзүүлэх, санхүүгийн удирдлага, холбоодыг хөгжүүлэх, бизнесийн эрх зүйн орчин, ЖДҮ-ийг хөгжүүлэх зэрэгт чиглэгдсэн арга хэмжээ хэрэгжүүлэх замаар бизнес эрхлэлт, эдийн засгийг төрөлжүүлэх явдлыг хөхиүлэн дэмжих.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	ҮХААЯ ЭЗХЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Дунд хугацаанд	
10	Бүс нутгийн төлөвлөлт, тээврийн дэд бүтэц								
10.1	Инженерийн дэд бүтэц болон нийгмийн үйлчилгээний ачаалал нэмэгдэх	Хот байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд уул уурхайн онцлог асуудал, байгаль орчин, нийгмийн талаар анхаарал татаж буй асуудлыг тусган олон нийтийн оролцоотойгоор сайжруулж, хэрэгжүүлэх. Одоогийн байгаа газар зохион байгуулалт болон хот байгуулалтын төлөвлөгөөний үялдааг сайжруулах.	Сум Аймаг Улс	Дундаж Өндөр	БХБЯ	Газар зохин байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахад олон нийтэд мэдээлэн таниулах, хэлэлцүүлэх, тэдний саналыг авах ажиллагаа хангалтгүй хийгддэг. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг салбарын хэмжээнд зангиддаггүй.	Төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх.	Богино хугацаанд	БХБЯ
		Сумын засаг захиргааны орон нутгийн хөгжил, төлөвлөлтийн чадавхийг дээшлүүлэх.	Сум	Бага Дундаж Өндөр	БХБЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
		Уул уурхайн орлогоос санхүүжих аймгийн түвшний дэд бүтэц, орон сууцны сан байгуулах.	Аймаг	Дундаж Өндөр	ЭЗХЯ СЯ	Уул уурхайгаас орох орлогоос аймгийн дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхийг зөвшөөрсөн заалт байхгүй.	Уул уурхайгаас орох орлогоос аймгийн дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлэхэд ашиглахыг зөвшөөрөх тухай заалтыг Төсвийн тухай хуульд оруулах.	Богино, дунд хугацаанд	СЯ ЭЗХЯ БХБЯ
		Уул уурхайн хөгжилтэй холбоотойгоор хүн ам олноороо шилжин ирж буй аймаг, сумдад дэд бүтэц, үйлчилгээг хүртээмжтэй хүргэхийн тулд уул уурхайгаас орж буй орлогоос нэмэлт төсөв хуваарилах.	Сум Аймаг	Дундаж Өндөр	ЭЗХЯ СЯ	Уул уурхайн бүс нутаг дахь шилжилт хөдөлгөөнийг сааруулахад нэмэлт төсөв хуваарилахыг зөвшөөрөх тухай заалт байхгүй.	Уул уурхайн бүс нутаг дахь шилжилт хөдөлгөөнийг зохицуулах бодлого боловсруулах.	Богино хугацаанд	БХБЯ



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
		Дэд бүтэц, нийгмийн үйлчилгээг хөгжүүлэхэд эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэхэд уул уурхайн компаниудтай хамтран ажиллах.	Улс	Дундаж Өндөр	БХБЯ Аймгийн Засаг даргын тамгын газар	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
10.2	Уул уурхайн хөгжлийн бүс дэх хүн амын шилжин хөдөлгөөн	Одоо үүсээд буй уул уурхайн хот, тосгоныг тогтвортой байлгах үүднээс тухайн газруудад ЖДҮ-ийг дэмжих.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	ҮХААЯ БХБЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Дунд хугацаанд	
		Томоохон уурхайн ойролцоох хот, суурины газрын үнийг хөөрөгдөн бөөнөөр нь авахаас сэргийлэх үүднээс газар олголт, газар зохион байгуулалтын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах.	Сум	Дундаж Өндөр	БХБЯ	Газар олголтыг ил тод явуулдаггүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
		Уул уурхайн лицензийг бүсийн хөгжлийн бодлогод нийцүүлэн олгох.	Улс	Бага Дундаж Өндөр	БХБЯ ууя	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
		Бичил болон томоохон хэмжээний уурхайн үйл ажиллагаа аль аль нь явагдаж буй албан бус суурингуудыг хянах, уул уурхайн хэрэгцээг хангасан бүсийн цогц төлөвлөгөөг боловсруулсанаар албан бус сууринг шинээр үүсэхээс сэргийлэх.	Сум Аймаг	Дундаж Өндөр	БХБЯ ууя	Уул уурхайн хөгжлийг бүс нутгийн төлөвлөлтөнд зохих байдлаар авч үздэггүй.	Бүс нутгийн төлөвлөлтийг сайжруулах.	Богино, дунд хугацаанд	БХБЯ
10.3	Бүсийн дэд бүтцийн	Дэд бүтцийг хөгжүүлэхэд төр хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох.	Улс	Дундаж Өндөр	БХБЯ ЗТЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Дунд хугацаанд	



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
	хөгжил	Байгаль орчин нийгмийн асуудлаарх нөлөөллийг багасгахын тулд орон зайн төлөвлөлт, тээвэр, байгаль орчны асуудал хариуцсан байгууллагуудын уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулах	Улс	Бага Дундаж Өндөр	БХБЯ	Орон зайн төлөвлөлтийн тогтолцоо сул, төлөвлөлт, тээвэр, байгаль орчны асуудал хариуцсан байгууллагуудын уялдаа холбоо, зохицуулалт үндэсний хэмжээнд дутагддагаас орон зайн төлөвлөлт тааруу байна.	Бүс нутгийн төлөвлөлтийн системийг сайжруулах.	Богино, дунд хугацаанд	БХБЯ
10.4	Зэрлэг амьтдын нүүдэл	Орон зайн төлөвлөлтөд экосистемийн хамгааллыг тусгах.	Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	БХБЯ	Төлөвлөлт, байгаль орчны байгууллагуудын хооронд уялдаа, зохицуулалт байхгүй.	Төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх.	Богино хугацаанд	БХБЯ
		Уул уурхайн зориулалтаар байгуулах дэд бүтцийн тэнцвэрийг хангах үүднээс аймгийн Байгаль орчны газартай нягт хамтран ажиллах.	Аймаг Улс	Дундаж Өндөр	БХБЯ ЗТЯ	Төлөвлөлт, байгаль орчны байгууллагуудын хооронд уялдаа, зохицуулалт байхгүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
11	Хөдөлмөр эрхлэлт, үр чадвар								
11.1	ЖДҮ-ийг хөгжүүлэх	ЖДҮ-ийг дэмжих бичил зээлийн хүртээмжийг улам бүр нэмэгдүүлэх. ЖДҮ-ийг хөгжүүлэхэд санхүүгийн удирдлага, шаардлагатай зөвшөөрөл авах, тендерт оролцох, төслийн санал бэлтгэх зэрэг мэргэжлийн чадвар зэмшүүлэх сургалт явуулах.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	ҮХААЯ ЭЗХЯ	Зээлийн хүртээмж, зээл авах боломж тааруугийн дээр зээлийн удирдлага дулимаг, чанаргүй зээлийн хувь өндөр. Орон нутгийн ЖДҮ уул уурхайн компаниудаас шаардаж буй стандартыг (олон улсын түвшний) хангах чадавхи тааруу. Хөдөө орон нутгийн бизнесүүдийн мэргэжлийн үр чадвар тааруугаас ЖДҮ-үүд ажил авч чаддаггүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
		Тухайн аймаг, сумын онцлог болсон бүтээгдэхүүнийг тодотгосон "Нэг аймаг/Сум-нэг бүтээгдэхүүн" зэрэг санаачилгыг дэмжих. Ийм санаачилгуудыг уул уурхайн салбарын эрэлттэй уялдуулах.	Аймаг	Дундаж Өндөр	Аймгийн Засаг даргын тамгын газар	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
		Уул уурхайн компаниудтай хамтран ажиллаж байсан, эсвэл бүтээгдэхүүн нийлүүлж байсан ЖДҮ-ийн орон нутгийн тэргүүн туршлага, арга барилыг хөхиүлэн дэмжих (Жишээ нь, жуулчлал, хөдөө аж ахуйн бизнес, уурхайн хаалтын дараа уул уурхайн дэд бүтцийг ашиглах, г. м.).	Сум	Дундаж Өндөр	Сумын Засаг даргын Тамгын газар	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Богино, дунд хугацаанд	
11.2	Ур чадвар, чадамжийг хөгжүүлэх, уул уурхайн компаниудаас бий болгох ажлын байр	Олон улсын мэргэжлийн боловсролын байгууллагууд, их дээд сургуулиуд, хувийн байгууллагуудын түншлэлийг дэмжин, санхүүжүүлэх.	Улс	Дундаж Өндөр	БШУЯ	Ур чадвар, ялангуяа уул уурхайн салбарт эрэлттэй байгаа ур чадвар дутагддаг.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Урт хугацаанд	
		Их, дээд сургуулиуд Улаанбаатараас гадагш, аймгийн төвүүдэд салбараа нээн ажиллах нөхцлийг дэмжих. Их, дээд сургуулиудын болон үйлдвэрлэлийн салбар хоорондын харилцааг сайжруулах.	Улс	Дундаж Өндөр	БШУЯ	Их, дээд сургуулиуд ихэвчлэн Улаанбаатар хотод төвлөрдөг, энэ нь хөдөө орон нутгаас хүн амын шилжих хөдөлгөөнийг нэмэгдүүлэн, хөдөөгийн эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Их, дээд сургуулиуд чанар, мэргэжлийн шаардлагыг хангахгүй байна.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Урт хугацаанд	
		МСҮТ, их, дээд сургуулиудын сургалтын одоогийн хөтөлбөрт дадлагын цагийг нэмэж төгсөгчдийн ажлын байран дахь бэлэн байдлыг дээшлүүлэх.	Улс	Бага Дундаж Өндөр	БШУЯ	Оюутнуудад практик мэдлэг хангалттай өгдөггүй.	МСҮТ, их, дээд сургуулиудын сургалтын одоогийн хөтөлбөрийг өөрчлөх.	Богино хугацаанд	БШУЯ



Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
		Үндэсний хэмжээнд хөдөөгийн хөгжлийн бодлогыг хөхиүлэн дэмжиж мэргэшсэн залуу мэргэжилтнүүд хөдөө орон нутагт ажиллахыг урин дуудах амьдралын тав тух, ажлын орчинг бий болгох. Энэхүү бодлогод орон сууцжуулалт, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хөгжил, татварын хөнгөлөлт, хөдөөгийн нэмэгдэл болон хөнгөлөлт, татаас зэргийг оруулж болох юм.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	ХЯ ЭЗХЯ	Залуу мэргэжилтнүүдийг хөдөө орон нутаг руу татах цогц бодлого байхгүй.	Уул уурхайн хөгжил хөдөөгийн хөгжлийн нэг хөтөлөгч болохыг харгалзсан хөдөөгийн хөгжлийн цогц бодлогыг боловсруулах.	Богино, дунд хугацаанд	ЭЗХЯ БХБЯ
		Сумын түвшинд хөдөөгийн хөгжлийн төслүүдийн тоог нэмэгдүүлсэнээр уул уурхайгаас орох орлогыг уул уурхайн бус салбарт ажлын байрыг нэмэгдүүлэхэд ашиглах замаар эдийн засгийг төрөлжүүлэх.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	ҮХААЯ ЭЗХЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Урт хугацаанд	
		Монгол улсад стандартын шаардлага хангасан МСҮТ-ийн үйл ажиллагааг дэмжих, аж үйлдвэрлэлийн салбарын оролцоотойгоор төгсөгчдийн эзэмших, мэдлэг, ур чадварын шаардлагыг тодорхойлох.	Улс	Дундаж Өндөр	ЭЗХЯ	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Дунд хугацаанд	
12	Технологи								
12.1	Эрчим хүчний хэмнэлттэй, орчин үеийн олборлох үйлдвэрлэл, боловсруулалт, хог хаягдлын	Хямд өртөгтэй, практик ач холбогдолтой, богино хугацаанд хэрэгжүүлж болох технологийн судалгаа шинжилгээнд хөрөнгө оруулалт хийхийг дэмжих замаар уул уурхайн үйл ажиллагааны дүнд бий болох нөлөөлөл, тэр дундаа агаар, усны бохирдлыг бууруулах.	Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ ууя	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Дунд хугацаанд	



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

Д/д	Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж*	Түвшин	Өсөлтийн хувилбар	Хэрэгжүүлэгч (*)	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж**	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч (**)
	менежментийн технологийг ашиглах.	Нүүрс, нүүрсний хий болон түүхий нефтийн бүтээгдэхүүнээс дотоодын хэрэгцээний хямд үнэтэй, цэвэр эрчим хүчний бүтээгдэхүүн боловсруулах судалгаа шинжилгээ, технологийн хөрөнгө оруулалтанд урамшуулал олгох.	Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ ууя	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Дунд хугацаанд	
		Дадлагажих сургалтанд хамруулах, дагалдуулан сургах замаар технологийн дамжуулалт хийхийн тулд инженерчлэлийн компаниудтай уул уурхайнхан олон улсын түншлэл тогтоон ажиллахад онцлон анхаарах.	Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ ууя	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Урт хугацаанд	
		Эрчим хүч, усны үр ашигтай зарцуулалтыг сайжруулах болон уурхайн бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх явдлыг нэмэгдүүлэх технологийн хөрөнгө оруулалтыг цаашид хөхиүлэн дэмжиж, урамшуулал үзүүлэх.	Улс	Бага Дундаж Өндөр	БОНХЯ ууя	Нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.	Дунд хугацаанд	



ДҮГНЭЛТ

БОНСУ-ий Үйл ажиллагааны төлөвлөгөөнд ирээдүйд уул уурхайн тогтвортой үйл ажиллагааг хангахад байгаль орчин, нийгмийн талаас анхаарах бодлогын түвшний зөвлөмжүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, хариуцагч байгууллагыг тодорхойлон тусгалаа. Энэ бүлгээс 3 гол дүгнэлтийг хийж болохоор байна. Нэгдүгээрт, бодлогын зөвлөмжүүдийн ихэнх нь авч үзсэн хөгжлийн бүх хувилбарын хувьд хэрэгжүүлэх шаардлагатай буюу өөрөөр хэлвэл, өсөлт ямар ч байсан эдгээр шинэчлэл гарцаагүй хийгдэх шаардлагатай байгаа юм.

Хоёрдугаарт, хэдийгээр ихэнх зөвлөмжүүдийг хөгжлийн бүх хувилбарын хувьд хэрэгжүүлэх хэрэгтэй ч, уул уурхайн салбар өндөр өсөлттэй байвал эдгээр шинэчлэлийг даруй явуулах шаардлага илүү байх болно. Ялангуяа ус, газрын менежмент, хүний эрх, эрүүл мэндтэй холбоотой асуудлаар арга хэмжээнүүдийг яаравчлан авах хэрэгтэй байна. Эдгээр эн тэргүүний 4 асуудлын хувьд хэрэглээ (ус, газартай холбоотойгоор) хэт ихсэх, зөрчил, маргаан (газар, хүний эрх, эрүүл мэндтэй холбоотойгоор) гарах магадлал өндөр өсөлттэй хувилбарын үед онцгой их байж болзошгүй.

Эцэст нь, санал болгосон бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагуудыг шинжлэн үзвэл ирээдүйд сум, аймгийн захиргаадад ихээхэн ачаалал оногдохоор байгаа ба энэ ачааллын цар хүрээ, хэмжээг шийдвэр гаргагчид одоогоор тодорхой харах боломжгүй байж болох ч, хэрэв эдийн засгийн тогтвортой хөгжилд уул уурхайн салбар идэвхтэй үүрэг гүйцэтгэсэн хэвээр байх л бол энэ асуудалд анхаарлаа хандуулан шийдвэрлэх шаардлагатай байна.



1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 СУУРЬ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол улсад уул уурхайн салбар хурдацтай хөгжиж байна. Олон улсын валютын сан (ОУВС)-аас 2012 оноос 2016 оны хооронд Монгол улсын эдийн засаг жилд дунджаар 14 хувиар өснө гэж үзэж байгаа юм. Уул уурхайн салбар нь Монгол улсын хөгжлийн суурь, эх үүсвэр бөгөөд ирээдүйд мөн энэ хандлага үргэлжлэх төлөвтэй байгаа ч уул уурхайн салбарын хөгжил нь Монгол улсын хөгжилд, түүнчлэн монголчуудын амьдралд яаж нөлөөлөх талаар тодорхой санал нийлсэн алсын хараа харагдахгүй байна. Энэ асуудалд хариу өгөхөөр Монгол улсын Засгийн газар (ЗГ) нь Дэлхийн банкны (ДБ) дэмжлэгтэйгээр Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техникийн туслалцааны төсөл (УУСИБТТТ)-ийг хэрэгжүүлж байгаа билээ. Монгол улсын уул уурхайн салбарын одоогийн бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын орчныг үнэлэхэд ЗГ-т дэмжлэг үзүүлж буй УУСИБТТТ-ийн бүрэлдэхүүнд багтан орсон чухал төслийн нэг нь энэхүү Уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ (БОНСҮ)-ий төсөл юм.

БОНСҮ нь байгаль орчин, нийгмийн хүчин зүйлсийг уул уурхайн салбарын шинэчлэлд тусгах замаар Монгол улсын урт удаан хугацааны хөгжилд хувь нэмэр оруулах болно. ЗГ-аас Монгол улсын тогтвортой бөгөөд олон нийтийн оролцоотой хөгжилд уул уурхайн салбарын гүйцэтгэх үүргийн талаар нийтлэг ойлголтыг дээшлүүлэх, уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах, бодлогын хүрээнд гарч буй өөрчлөлтүүдийг мэдээлэх, Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд уул уурхайн салбарын гүйцэтгэх үүрэг, хувь нэмрийг өсгөх талаар Засгийн газраас гаргаж буй хүчин чармайлтанд дэмжлэг үзүүлэх үүднээс УУСИБТТТ-өөс Монгол улсын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ (БОНСҮ)-г гүйцэтгэх төслийг санхүүжүүлж байгаа юм. Нийгмийн асуудлыг байгаль орчны асуудалтай эн тэнцүү авч үздэг оролцоонд түшиглэсэн энэхүү үнэлгээг гүйцэтгэхээр 2013 оны 10-р сард Састэйнабилити Ийст Эйжия ХХК (Састэйнабилити) сонгогдсон болно.

Монголын нийгмийн нөхцөл байдал, уул уурхай болон байгаль орчны сайн боловч нарийн төвөгтэй бодлого бүрэлдэн бий болсон цаг үед энэхүү БОНСҮ-г хийж байгаа билээ. Монголын нийгэм цаашдын хөгжлийн чиглэлээ сайтар удирдан чиглүүлж, ойлгохыг зорьж байгаа учраас сайн гэж үзэж байгаа юм. Уул уурхайн салбарын эдийн засгийн ач холбогдол, байгаль орчин, нийгмийн сорилт бэрхшээл зэргээс шалтгаалан тус салбарын ирээдүй эрсдэлтэй нөхцөлд байна гэж хэлж болно. Тиймээс, тус БОНСҮ-ий зорилго нь уул уурхайн салбарын шинэчлэл, байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг тодорхой арга хэмжээг санал болгон дэмжих явдал юм. Монгол улсын уул уурхайн салбарт тулгарч буй байгаль орчин, нийгмийн асуудлын хамарч буй хүрээнээс шалтгаалан уг БОНСҮ-г холбогдох олон талууд, төрийн байгууллагууд болон аймаг, сумын түвшний байгууллагуудтай нягт хамтран ажиллаж гүйцэтгэв. Түүнчлэн, БОНСҮ нь УУСИБТТТ хэрэгжиж дууссаны дараа, БОНСҮ-ий зөвлөмжийг хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ хийхэд нь ЗГ-т хандивлагчдын зүгээс тусламж, дэмжлэг үзүүлэх санаачилга, үйл ажиллагааг уялдуулах боломжийг олгоно хэмээн үзэж байна.



1.2 БОНСУ-ИЙ ЗОРИЛГО, БҮТЭЦ

1.2.1 БОНСУ-ий ажлын даалгавар

БОНСУ-ий ажлын даалгаврыг Улаанбаатар хотод талуудын олон төлөөллүүд оролцсон уулзалтаар хамгийн анх 2012 оны 10-р сарын 10-12-нд хэлэлцсэн байна. “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинэ хуулийг дагалдан гарах байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх журмууд” сэдэвт тус уулзалтанд улсын хэмжээний болон орон нутгийн түвшний төр засгийн газрын байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, уул уурхайн салбар, судлаачид (эрдэм шинжилгээний байгууллагууд) болон хандивлагч байгууллагуудын төлөөлөгчид оролцсон юм. Улмаар УУСИБТТТ нь БОНСУ-ий албан ёсны ажлын даалгаврыг боловсруулсан бөгөөд уг бичиг баримтанд үндэслэн төслийн тендерийн бичиг баримтыг боловсруулж, БОНСУ-ий төслийг хэрэгжүүлэх зөвлөхийг сонгон авсан байна. БОНСУ-ий төслийг 2013 оны сүүл гэхэд дуусгахаар анх төлөвлөж байсан ч зарим нэг хуваарь төлөвлөгөө саатсаны улмаас уг үнэлгээг 2013 оны 9-р сард эхлэн 2014 оны 7-р сард дуусгах боломжтой болсон юм.

1.2.2 БОНСУ-ий зорилго

БОНСУ-ий гол зорилго нь Монгол улс болон монголчуудад үзүүлэх байгаль орчин, нийгэм-эдийн засгийн нөлөөлөл, боломжийг тооцон үзсэн, Монгол улсын уул уурхайн салбарын тогтвортой, зөв, зохистой хөгжлийг бий болгоход Монгол улсын Засгийн газрын зүгээс эн тэргүүнд авч болох үйл ажиллагааг тодорхойлох иж бүрэн, оролцоонд түшиглэсэн БОНСУ-г хийх явдал бөгөөд тодорхой зорилтуудыг дурдвал:

- Монгол улсын уул уурхайн салбарын хурдацтай өсөлттэй холбоотой байгаль орчин, нийгмийн гол гол асуудлууд болон боломжуудыг тодорхойлох;
- Уул уурхайн үйл ажиллагаа, холбогдох дэд бүтцийн хөгжилтэй холбоотой байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулж, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх бодлого, хууль эрх зүй, зохицуулалт, бүтцийн өөрчлөлт, чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг тодорхойлох;
- Монгол улсын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг сайжруулахад Монгол улсын Засгийн газрын зүгээс авч болох тодорхой арга хэмжээг санал болгох зэрэг болно.

1.2.3 БОНСУ-ий үр дүн

БОНСУ нь хоёр үр үр дүнд хүрэх бөгөөд эхнийх нь Монголын уул уурхайн салбарт нөлөөлж буй байгаль орчин, нийгмийн менежментийн гол асуудлуудын талаар оролцогч талуудын ойлголт мэдлэгийг сайжруулах бодлогын түвшний хэлэлцүүлгийг улам өргөжүүлэх явдал юм. Хоёр дахь үр дүн нь Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд уул уурхайн салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхээр Монгол улсын Засгийн газраас тавьж буй хүчин чармайлтыг дэмжиж, салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах, мөн уул уурхайн салбарыг шинэчлэх хугацаанд авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах явдал болно.



БОНСУ-ий үр дүнд дараах ашиг тус бий болох боломжтой юм. Үүнд, уул уурхайн салбарын шинэчлэлийн асуудал болон хөгжлийн хувилбаруудын талаар холбогдох гол талуудтай зөвшилцөх замаар төлөвлөлт, бодлогыг боловсруулах, байгаль орчин, нийгмийн тогтвортой байдалд нөлөөлж буй институцийн (бүтцийн) болон засаглалын сул талыг тодорхойлох, салбарын хэмжээний эдийн засгийн үйл ажиллагаа болон салбарын өсөлтийг дэмжих байгаль орчин, байгалийн нөөцийн чадавхийн талаар дүн шинжилгээ хийж, шинэ өгөгдөл мэдээлэлтэй болох зэрэг болно. БОНСУ-ий үр дүнг хэрэгжүүлснээр бодлогын чадавхи, хамрах хүрээг өргөжүүлж засаглалыг бэхжүүлэх боломжтой юм. Түүнчлэн БОНСУ-г гүйцэтгэснээр эмзэг бүлгийн холбогдох талуудыг адил тэгш, хүртээмжтэй оролцуулсан харилцан ярилцлага, хэлэлцүүлгийг өрнүүлж янз бүрийн, эсвэл сөргөлдөгч ашиг сонирхлыг шийдвэрлэх арга механизмыг бий болгож, шийдвэр гаргах ил тод үйл явц, хариуцлагын түвшинг нэмэгдүүлэхэд мөн хувь нэмэр оруулах боломжтой.

1.2.4 ТӨСЛИЙН БАГ

Састэйнабилити компаний Улаанбаатар дахь оффисын мэргэжилтнүүд голчлон уг төсөл дээр ажилласан ба Састэйнабилити компаний Пэрт хот дахь төв оффисын мэргэжилтнүүд мөн оролцож ажиллав. БОНСУ-ий үндсэн баг нь дараах гишүүдээс бүрдсэн болно. Үүнд:

Док. Дэвид Аннандэйл	Багийн ахлагч
Сюзан Жайлс	Төслийн менежер
Б.Баярмаа	Төслийн туслах менежер / Газар зүйн мэдээллийн системийн мэргэжилтэн
Жон Мираглиотта	Байгаль орчны мэргэжилтэн
Саха Миянатан	Эдийн засагч
Б.Мөнхсүрэн	Уул уурхайн мэргэжилтэн
З.Янжинлхам	Уул уурхайн мэргэжилтэн
Эйми Сэкстон	Нийгмийн хөгжлийн мэргэжилтэн
М.Бямбабат	Талуудын оролцооны мэргэжилтэн
Катерин Грант	Нийгмийн хөгжлийн мэргэжилтэн
Док. Н.Нямдорж	Байгаль орчны мэргэжилтэн
Б.Мөнхжаргал	Байгаль орчны мэргэжилтэн
Док. Даен Дуглас	Соёлын өвийн мэргэжилтэн

1.2.5 УУСИБТТТ

БОНСУ-ий Ажлын хэсэг байгуулагдаагүй нөхцөл байдалд УУСИБТТТ нь Уул уурхайн яам (УУЯ) болон Дэлхийн банкттай нягт хамтран ажиллаж БОНСУ-ий үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүргийг гүйцэтгэсэн юм. УУСИБТТТ-ийн саналыг 2007-2008 оны хооронд боловсруулан төслийг 2009 оноос хойш Дэлхийн банкны санхүүжилттэйгээр ЗГ-аас хэрэгжүүлж эхэлсэн байна. 2011 онд хийгдсэн УУСИБТТТ-ийн дунд хугацааны үнэлгээний үр дүнд үндэслэн тус төсөл нь уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн менежментийн орчныг БОНСУ хийн бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр шийдвэрлэжээ. Тус төслийн гол зорилго нь ЗГ, үйлдвэрлэгчид болоод иргэний нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангасан уул уурхай, олборлох салбарын бодлого, дүрэм журам, санхүүгийн болон институцийн тогтолцоог сайжруулахад ЗГ-т туслалцаа үзүүлэх явдал юм.



1.3 БОНСУ-Г ГҮЙЦЭТГЭХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

БОНСУ хийх үйл ажиллагааг арга аргачлал болгон хөгжүүлж боловсруулан аливаа үйл ажиллагаанд ашиглах нь сүүлийн жилүүдэд нэмэгдсэн. Байгаль орчин, нийгмийн үнэлгээг шийдвэр гаргах янз бүрийн үе шаттай уялдуулан ашиглах талаарх аргачлалаа олон улс орнууд шинэчлэн сайжруулаад зогсохгүй, олон улсын тавцанд хоёр чухал бичиг баримт буюу Европын Байгаль орчны стратегийн үнэлгээ (БОСУ)-ий заавар (2001/42/ЕС), НҮБ-ын Европын Эдийн засгийн комиссын 2003 оны БОСУ-ий журмыг баталсан нь БОНСУ-ий ач холбогдлыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Мөн олон улсын санхүүгийн, мөн хоёр талт болоод олог талт хамтын ажиллагааны байгууллагууд нь өөрсдийн БОНСУ-ий системийг бий болгож нэвтрүүлсэн бөгөөд ингэснээр зээлдэгч, ашиг тус хүртэгч улс орнууд БОНСУ-г өөрсдийн төлөвлөлт, шийдвэр гаргах үйл явцад тусган оруулж, ашиглах болсон байна (Шакер ба Эл-фадл, 2006).

Дэлхийн банк нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын баримталдаг байгаль орчны стратегийн үнэлгээний тодорхойлолтыг дагаж мөрддөг ба энэ нь "байгаль орчны асуудлыг бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрт тусган оруулж, эдийн засаг, нийгмийн асуудалтай хэрхэн уялдаж байгааг үнэлэхийг зорьдог оролцоонд түшиглэсэн аналитик дүн шинжилгээний аргачлал" гэсэн агуулгатай юм (ЭЗХАХБ, 2006). Дэлхийн банкны хувьд БОСУ-г нийгмийн асуудал болон байгаль орчны асуудлыг багтаан ач холбогдлыг нь онцгойлон авч үздэг БОНСУ гэдгээр нь ихэвчлэн ойлгодог. Үйл ажиллагаандаа БОНСУ-г илүү ашиглах зорилгоор, Дэлхийн банк нь 2000 оны дунд үеэс БОНСУ-г бодлогын түвшинд ашиглах туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн ба энэ үеэс БОНСУ-г улам бүр хэрэглэх болж, гарсан сургамжийг тусган БОНСУ-ий аргачлалыг улам бүр нарийвчлан боловсруулаад байна.

Шигтгээ 1.1 БОНСУ-д эрсдэлийг үнэлэх нь

БОНСУ нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (БОНУ)-ээс гаралтай үйл ажиллагаа юм. "Нөлөөлөл", "суурь үзүүлэлт" болон "нөлөөллийг бууруулах" зэрэг БОНУ-тэй холбоотой олон уламжлалт нэр томъёо нь БОНУ-д өргөн хэрэглэгддэг ба эдгээр нь асуудлыг шийдвэрлэх, хэмжүүр үзүүлэлтүүд, нарийвчлан тодорхойлсон аргачлалтай ихээхэн холбогддог. Стратегийн түвшинд бодож сэтгэх нь биет бодит зүйлс бус харин үнэ цэнэ, хамтран ажиллаж ярилцах, ирээдүйд чиглэж бодоход илүү их анхаардгаараа онцлогтой байдаг (До Розарио Партидарио, 2012).

Өөрөөр хэлбэл, БОНСУ нь төслийн үнэлгээнд байдаг шиг аливаа төслийн саналын байгаль орчны нөлөөлөл (ус, агаар, хөрс г.м.)-ийн шууд үнэлгээ биш гэсэн үг бөгөөд харин байгаль орчин, тогтвортой байдлын талаарх шийдвэр гаргах орчин болон үр дүнг бий болгоход чиглэсэн, хөгжлийн бодлого (институци, бодлого, эдийн засгийн, нийгмийн асуудлууд г.м.)-ийн үнэлгээ юм.

Уламжлалт БОНУ нь стандарт арга аргачлалын дагуу хийгддэг бол, БОНСУ нь ямар нэгэн стандарт, журманд баригддаггүй бөгөөд энэ үнэлгээг хийх цорын ганц арга гэж байдаггүй. БОНСУ нь онолын судалгаа гэхээсээ илүүтэйгээр тогтвортой байдлаар хөгжих биет, нийгмийн, байгаль орчны, эдийн засгийн орчныг бий болгох тухай юм. Энэ нь стратегийн түвшний үнэлгээ бол, БОНУ-д төслийн саналын байгаль орчны үр нөлөө болон эдгээр нөлөөллийг хэрхэн зохицуулж, бууруулах талаарх шууд үнэлгээ хийгддэг. Тиймээс аливаа БОНСУ-ий хүрээнд эрсдэлийг үнэлэхдээ стратегийн түвшний эрсдэлийг тооцох хэрэгтэй ба мөн цаашдын үр дүнг тодорхойлж бий болгоход оролцогчдын санал бодлыг тусгах ёстой.



Цар хүрээний хувьд энэхүү БОНСҮ-тэй төстэй хэд хэдэн БОНСҮ-ий жишээг доор тайлбарлав. Эдгээр жишээ нь БОНСҮ-д ашиглагддаг нийтлэг аргачлал болон Састэйнабилитигийн багийн энэ үнэлгээнд авч ашиглахыг зорьсон олон тооны сургамж жишээг багтаасан болно. Хэдийгээр улс орнууд адил төстэй аргачлалыг ашигладаг байж болох ч, тухайн улс орны хууль эрх зүй, институцийн орчин зэргээс хамаараад БОНСҮ-ий аргачлал өөр өөр байж болох юм (Шакер ба Эл-фадл, 2006).

Сьерра Леон: Уул уурхайн салбарын байгаль орчны, нийгмийн стратегийн үнэлгээ

Сьерра Леон улсын хууль эрх зүй, бодлогын шинэчлэлийг дэмжиж, эдийн засгийг сэргээхэд туслах зорилгоор тус улсын уул уурхайн салбарын БОНСҮ-г 2006-2007 оны хооронд хийсэн байна. Энэ БОНСҮ-ий аргачлалтай адилаар, Сьерра Леоны БОНСҮ нь уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн эн тэргүүний асуудлыг тодорхойлж, эдгээрийг шийдвэрлэх одоо байгаа чадавхийг үнэлэн, санал болгож буй уул уурхайн салбарын шинэчлэл болон одоо байгаа уул уурхайн салбарын улс төрийн тогтолцооны эдийн засаг нь эдгээр эн тэргүүний асуудлыг зохицуулан шийдвэрлэх тус улсын чадавхид хэрхэн нөлөөлөх талаар үнэлж, уул уурхайн салбарын шинэчлэлийг хэрэгжүүлэх үед энэ чадавхийг хэрхэн сайжруулах талаарх үйл ажиллагааны төлөвлөгөөг санал болгосон. Сьерра Леон улсын БОНСҮ-ий гол сургамжид дараах зүйлс багтан орж байгаа бөгөөд үүнд:

- БОНСҮ-ий тайланг эцэслэн хүргүүлсний дараа, бодлогын яриа хэлэлцүүлгийг үргэлжлүүлж, БОНСҮ-ий үр дүн болон зөвлөмжийг хэрэгжүүлэхэд тулгарах бэрхшээл.
- БОНСҮ-г шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөхөд ашиглах тайлан бэлтгэх богино хугацааны үйл явц гэж бодохоос зайлсхийх.

Вьетнам: Куанг Намын усан цахилгаан станцын төлөвлөгөөний байгаль орчны стратегийн үнэлгээ

Вьетнам улсын энэ жишээ нь БОНСҮ-г хийх шаардлагыг тусган оруулсан шинэ хууль Монгол улсад батлагдсаны дараа хийгдэж байгаагаараа тус БОНСҮ-тэй адил төстэй юм. Тус БОНСҮ-д хэтийн чиг хандлагыг үнэлэх аргыг голчлон ашигласан (энэ БОНСҮ-д авч үзэж буй хувилбаруудтай адил). Вьетнам улсын энэхүү БОНСҮ нь холбогдох олон талуудыг оролцуулан Ву Гиа-Ту Бон голын сав газрын хөгжилд чухал байгаль орчин, нийгэм, эдийн засгийн 80 гаруй асуудлыг тодорхойлох ажлыг эхний шатандаа хийсэн байна. Дараагаар нь эдгээр асуудлуудыг гидрологи буюу ус судлал, усны чанар, уур амьсгалын өөрчлөлт, эдийн засгийн салбарын хөгжил, ядуурал, эрүүл мэнд, газар болон усны экосистем зэргийг багтаасан 15 гол сэдэвт ангилжээ. Асуудлуудыг тус голын сав газрын өнгөрсөн хугацааны болон ирээдүйн нийгэм, эдийн засаг, байгаль орчны чиг хандлагыг усан цахилгаан станцтай болон станцгүйгээр судлан авч үзэх суурь нөхцөл болгон авч үзсэн байна. Энэ БОНСҮ-ээс үлдсэн үнэ цэнэтэй сургамжуудыг дурдвал (ЭЗХАХБ, 2006):



- Хэтийн чиг хандлагыг шинжлэх нь бодит үр дүнд хүргэдэг ба энэхүү тоон болон чанарын шинжилгээний арга, мөн газар зүйн мэдээллийн систем (GIS) ашиглан орон зайн дүн шинжилгээ хийснээр одоо байгаа суурь нөхцөл байдал болон усан цахилгаан станцтай, станцгүй ирээдүйн боломжит чиг хандлагыг системтэйгээр харьцуулсан. Энэ нь, усан цахилгаан станцаас шалтгаалсан нөлөөлөл болон ирээдүйн байгаль орчинд нөлөөлөх өөр бусад хүчин зүйлийг бодитойгоор үнэлэх боломжийг бүрдүүлсэн байна.

Ураны тэсрэлт: Төв Намибийн байгаль орчны стратегийн үнэлгээ

2006 онд ураны үнэ огцом өссөнөөс болж Намибид ураны ордууд нээгдэн уурхай байгуулагдах явдал нэмэгдсэн нь байгаль орчинд, улмаар олон нийтэд үндсэн хуулиар олгогдсон эрхэд нь олон хэлбэрээр аюул занал учруулж эхэлсэн. Монгол улсад уул уурхайн салбарын хөгжил оргил үедээ хүрсэн үетэй залгуулан тус БОНСҮ-г хийхээр шийдвэрлэсэн адилаар Намиби улсын Засгийн газар байгаль орчны стратегийн үнэлгээ (БОСҮ) хийх шийдвэрийг 2009 онд гаргасан ба энэ нь уул уурхайн бүс нутагт хийгдсэн анхны БОСҮ болсон байна (Уул уурхай, эрчим хүчний яам, 2010). Асуудал болоод байгаа хөгжил нь зүгээр аль нэг бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр биш харин бүхэл бүтэн салбар байсан тул уг БОСҮ нь энэхүү БОНСҮ-тэй ихээхэн төстэй байна. Аливаа тодорхой бодлого болон төлөвлөгөөг үнэлдэг БОНСҮ-ий хамрах хүрээнээс тус БОСҮ-ий цар хүрээ илүү өргөн далайцтай байв. Төв Намибийн тус БОСҮ-ий хүрээнд боловсруулсан зөвлөмжийг хэрэгжүүлж буй үйл явцаас суралцах гол зүйлд дараах асуудал орно. Үүнд:

- БОСҮ-г гүйцэтгэсний дараагаар хэрэгжилтийг хянах шаардлагатай. Тус БОСҮ-ий үр дүнг хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээг хийх үүрэг хариуцлагыг хүлээсэн хэрэгжүүлэгч газрыг байгуулсан байна. Тус газрын ажилтнуудын бүрэлдэхүүнд Уул уурхай, эрчим хүчний яам болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төлөөлөгчид оржээ.

1.4 АРГАЧЛАЛ

Нийгмийн зүгээс уул уурхайн салбар нь хуулийн хүрээнд хүлээсэн хамгийн наад захын үүрэг хариуцлагаа биелүүлж, хувьцаа эзэмшигчдэд ашиг хүртээгээд зогсохгүй, бүр их зүйл хийх ёстой гэсэн хүлээлттэй болж байна. Тогтвортой хөгжлийн үндсэн зарчим нь хүний сайн сайхан байх нөхцлийг сайжруулж, эдгээр гарсан үр дүнг цаг хугацааны явцад улам бүр тогтвортой байлгах явдал юм. Үүний тулд нөөцийг одоо болон ирээдүй үеийнхэнд нэмэгдүүлэх боломжгүй бол, ядахдаа бүрэн бүтнээр нь хадгалж дамжуулж, өвлүүлэх шаардлагатай. Түүнчлэн, стратегийн шийдвэр гаргах үйл явцад нийгэм, эдийн засаг, байгаль орчин, засаглалын зорилтуудыг уялдуулан тусгах шаардлагатай байдаг. Энэ тодорхойлолтын нэг цаад санаа бол шударга, зохистой хөгжилгүйгээр тогтвортой хөгжих боломжгүй (баялгийн хуваарилалтыг сайжруулах, бүх нийтээр адил шударга тэгш эрхтэй байх, баялаг болон төр засгийн үйлчилгээг адилхан авах боломжтой байх г.м.) гэсэн санаа юм.

Монголын түүхийн энэ цаг мөчид, шударга, тогтвортой хөгжлийн ач холбогдол маш их байна. Тогтвортой хөгжлийн цөм нь “капитал буюу баялаг” гэсэн ойлголт байдаг бөгөөд энэ ойлголт нь Састэйнэбилитигийн тус БОНСҮ-г хийж гүйцэтгэх аргачлалын үндсэн цөм нь юм (Шигтгээ 1.2-г үзнэ үү).



Шигтгээ 1.2 Капиталын төрөл

Капитал нь дараах таван үндсэн хэлбэрээр байдаг:

- **Байгалийн капитал** нь биологийн олон янз байдал, ашигт малтмал, цэвэр агаар, ус зэрэг экосистемийн ашиг тусыг бий болгож байдаг экологийн төрөлх шинж чанар;
- **Үйлдвэрлэсэн капитал** нь үйлдвэрлэлийн үйл явцад хувь нэмэр оруулдаг машин тоног төхөөрөмж, барилга байшин, дэд бүтэц зэрэг материаллаг бараа бүтээгдэхүүн, үл хөдлөх хөрөнгө зэргээс бүрддэг;
- **Хүний капитал** нь хүмүүсийн эрүүл мэнд, мэдлэг, ур чадвар, соёлын өв зэргээс бүрддэг;
- **Нийгмийн капитал** нь хувь хүмүүс болон олон нийтийн бүлгүүдэд хамтран хөгжих боломжийг олгодог бүтэц, зохион байгуулалтууд болно.

Тогтвортой хөгжлийг бий болгохын тулд, адил тэнцүү, эсвэл үүнээс давж гарсан капитал баялгийг ирээдүй үеийнхэнд заавал дамжуулах ёстой. Гэхдээ, зарим нөөц баялгийг зарцуулж, дуусах нь зайлшгүй байдаг бөгөөд эдгээр нөөц баялаг нь ирээдүй үеийнхэнд хүртэхгүй үлдэх нь бий. Өөр бусад чиглэлээр тэнцвэртэй хөрөнгө оруулалт (жишээ нь, хүний капитал болон тогтвортой ажиллах аж үйлдвэрлэл г.м.) хийж хүмүүст шинэ боломжийг олгох, ур чадварыг бий болгох тохиолдолд дээрх нөөц баялгийг зарцуулж дуусгах явдлыг зөвтгөж болох юм.

Уламжлалт БОНСУ нь аливаа бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн нөлөөллийг үнэлэх үйл явц юм. БОНСУ-г аливаа тодорхой бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс улбаалан гарах нөлөөллийг тухайн бодлого, хөтөлбөрийг төлөвлөх, баталж хэрэгжүүлэх үе шатанд тооцон авч үзэх зорилгоор ерөнхийдөө гүйцэтгэдэг. БОНСУ-г хийж гүйцэтгэдэг олон өөр өөр аргачлалууд байдаг. "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ" (БОНУ) хийх аргачлал бол нэг жишээ бөгөөд энэ нь хэдийнээ батлагдсан бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн дараах төслийн нөлөөллийг үнэлдэг (өөрөөр хэлбэл хариу үйлдэл үзүүлсэн эсвэл "үйл явдал болсны дараа"). Өөр нэг аргачлал нь тогтвортой хөгжлийн зорилгыг хангахыг зорьдог "тогтвортой байдалд тулгуурласан" аргачлал юм. Энэ нь илүү өөрчлөлтийг бий болгоход чиглэгдсэн цогц аргачлал бөгөөд асуудлыг бодлого болон төлөвлөлтийн үйл явцад уялдуулан тусгаж чаддаг. Хамгийн чухал нь, хөгжлийн явцад "боломж болон саад бэрхшээл" бий болдог гэсэн санааг багтаасан аргачлал ба үүнд, байгалийн нөөц баялаг болон экосистемийн үйлчилгээ зэргийг ерөнхийд нь хөгжил явагдах орчин хэмээн авч үздэг. Энэхүү БОНСУ-г аливаа тодорхой бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг үнэлэх зорилгоор хийгээгүй тул үнэлгээний аргачлалыг өөрчлөн боловсруулсан болно.

Дээрхтэй уялдуулан Састэйнабилити компаний БОНСУ-г хийж гүйцэтгэх аргачлалыг Монголын нийгмийн бүхий л цогц уялдаа холбоо (бүгдэд ашиг тустай), зөрчилтэй үр дүн (хожих, хохирох), уул уурхайн салбарын сул талыг харгалзан үзсэн, уул уурхайн салбарыг байгаль орчны хувьд тогтвортой, нийгмийн хувьд шударгаар хөгжүүлэх эн тэргүүний арга замыг тодорхойлоход ЗГ-т дэмжлэг үзүүлэх цогц аргачлал гэж хураангуйлан тодорхойлж болно.

Тус БОНСУ-д 2025 он хүртэлх Монгол улсын эдийн засгийн ерөнхий өсөлт, түүнд эзлэх уул уурхайн салбарын байр суурийг хөгжлийн хувилбаруудад авч үзсэн ба бага, дундаж, өндөр өсөлтийн 3 хувилбарыг боловсруулан тус үнэлгээнд ашиглалаа. Хувилбар бүр нь эдийн засгийн




өсөлтийн өөр түвшнийг илтгэх бөгөөд энэхүү өсөлтийн хувьд тодорхой бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл ямар байх, тухайлбал, уурхайн төрөл, тоо хэмжээ болон 2025 он хүртэл уул уурхайн салбарыг дэмжих холбогдох дэд бүтэц хэрхэн хөгжсөн байхыг тодорхойлох юм. Цаашлаад хувилбар бүртэй холбогдон үүсэх байгаль орчин, нийгэм-эдийн засгийн нөлөөллийг тодорхойлж, түүнчлэн байгаль орчны хувьд тогтвортой, нийгмийн хувьд эрх тэгш, шударга үр дүнг бий болгохын тулд эдгээр нөлөөллүүдийг зохицуулахад авах арга хэмжээний зөвлөмжүүдийг боловсруулах боломж бүрдэнэ. Өнөөгийн нөхцөл байдлыг суурь болгон авч үзсэнээр, БОНСҮ-ий хүрээнд санал болгож буй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд саад болж буй институцийн болон улс төр, эдийн засгийн сул талууд, мөн тэдгээрийг шийдэх бодлогын зөвлөмжийг боловсруулах боломжтой болно.

Уг БОНСҮ-ий аргачлалыг Зураг 1.1-т харуулав. Тус аргачлал нь зарим талаар ДБ-ны Уул уурхайн салбарын байгаль орчны стратегийн үнэлгээний 4-р тэмдэглэл (Лояза болон Албаррацин-Жордан, 2010) болон үүний 2011 оны хэвлэл "Бодлого болон салбарын шинэчлэлийн байгаль орчны стратегийн үнэлгээ"-д тулгуурлагдсан болно. Мөн олон тооны тайлан, адил төстэй судалгаа, БОНСҮ-г хийх ажлын даалгавар, БОНСҮ-ий багийн санал болон ДБ, ЗГ-ын холбогдох байгууллагуудтай харилцан ярилцах үед гарсан санал зэрэгт тулгуурлагдав. Товчхондоо, энэхүү аргачлалаар 1-р үе шатанд уул уурхайн салбар, тус салбарт үүсээд буй байгаль орчин, нийгэм-эдийн засгийн гол асуудлууд, түүнчлэн гол шийдвэр гаргагчдын талаарх суурь ойлголтыг бий болгох үүднээс одоогийн нөхцөл байдлын үнэлгээ (энэ тайлангийн 2-р бүлэг), уул уурхайн салбарт оролцогч талуудын судалгааг гүйцэтгэнэ. Дараагаар нь, уул уурхайн салбарын хөгжлийн хувилбаруудыг авч үзнэ (тайлангийн 3-р бүлэг). 2-р үе шатанд өсөлтийн хувилбаруудыг харгалзан тодорхойлсон байгаль орчин, нийгэм-эдийн засгийн асуудлуудыг улам судлан оролцогч талуудаар баталгаажуулж, эдгээр асуудлуудыг шийдвэрлэх арга хэмжээний зөвлөмжүүдийг боловсруулах (тайлангийн 4-р бүлэг) ажил хийгдэнэ. 3-р үе шатанд санал болгож буй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд саад болж буй институцийн болон улс төр, эдийн засгийн сул талуудыг шинжилж, тэдгээрийг шийдэх бодлогын зөвлөмжийг боловсруулна (тайлангийн 5-р бүлэг). 4-р үе шатанд зөвлөмжүүдийг Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэлбэрт оруулна (тайлангийн 6-р бүлэг). Энэхүү аргачлалаар Зураг 1.1-д үзүүлсний дагуу оролцогч талуудтай тогтмол зөвлөлдөж ажиллав.

Энэ нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу БОНХЯ-аас боловсруулан ЗГ-аас баталсан Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалтай¹ нилээд төстэй аргачлал юм. 2012 оны 10 сард Улаанбаатар хотод ДБ болон АХБ-аас хамтран зохион байгуулж холбогдох талуудын оролцсон хурлын үеэр БОНСҮ-г гүйцэтгэх ДБ болон дээрх БОНХЯ-ны арга, аргачлалын талаар дэлгэрэнгүй хэлэлцсэн байна. Шинээр боловсруулж хэрэгжүүлэхээр төлөвлөж буй тодорхой бодлого, төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөрөөс үзүүлэх нөлөөллийг үнэлэх байгаль орчны стратегийн үнэлгээг гүйцэтгэхэд БОНХЯ-ны журмыг ашиглахаар хуулинд заасан. Харин уул уурхайн салбарт хийгдэж буй энэхүү БОНСҮ нь дээр дурдсан аливаа бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөтэй хамаагүй тул дээрх журам энэ үнэлгээнд хамаарахгүй байгаа ч төслийн баг уг аргачлалыг аль болох дагаж ажиллахыг хичээсэн болно (Зураг 1.2-аас энэ хоёр аргачлал хэрхэн уялдаж байгаа талаар үзнэ үү).


¹ БОНХЯ нь Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалыг 2014 оны 1-р сарын 10-нд баталсан болно. www.mne.mn цахим хуудсыг үзнэ үү.



Зураг 1.1 БОНСУ-ий аргачлал, шат дараалал



Зураг 1.2 БОНСУ-ий үйл явц БОНХЯ-аас баталсан БОСУ хийх аргачлалтай уялдах нь



1.5 ОРОЛЦООНЫ ҮЙЛ ЯВЦ

БОНСУ-г амжилттай гүйцэтгэхэд талуудын үр дүнтэй оролцоо ихээхэн чухал байв. Оролцогч талуудын хувьд чухал байгаль орчин, нийгмийн эн тэргүүний асуудлуудыг хамгийн түрүүнд авч үзэхийн зэрэгцээ БОНСУ-ий үйл явц нь дараах зорилтыг хангахыг зорьсон болно. Үүнд: (i) оролцогч талуудын хувьд чухал эн тэргүүний асуудалд хамгийн гол анхаарлыг хандуулах; (ii) бодлогын өөрчлөлтийн улмаас янз бүрийн оролцогч талуудад ялангуяа, эмэгтэйчүүд, өндөр настан зэрэг эмзэг бүлгийнхэнд учрах нөлөөллийг арилгах, бууруулах зорилгоор хэрэгжүүлэх үйл ажиллагаа; (iii) урт удаан хугацааны тогтвортой байдалд чухал, хүн амын олонхийн хувьд зүй ёсны гэж ойлгогдож, хүлээж авч байгаа зөвлөмжүүд.

БОНСУ-ий хүрээнд оролцогч талуудтай дараах байдлаар хамтран ажиллав. Үүнд:

- Олон нийтийн уулзалтууд;
- Зорилтот бүлгийн ярилцлага;
- Гол талуудтай хийсэн ярилцлага;
- Утсаар авсан ярилцлага;
- Уул уурхайн яамнаас зохион байгуулсан Нээлттэй өдөрлөг арга хэмжээ;
- Талуудтай зөвлөлдөх бүс нутгийн хэмжээний хэлэлцүүлэг;
- Үр дүнг хэлэлцэх үндэсний зөвлөлдөх уулзалт;
- УУЯ, УУСИБТТТ болон Дэлхийн банкттай харилцан ярилцаж, зөвшилцөх зэрэг үйл ажиллагаа багтав.

Төслийн хүрээнд 2013 оны 12 сард **дотооддоо хийсэн уулзалтаар уул уурхайн салбарт оролцогч талуудыг тодорхойлон, шинжлэх** ажлыг эхлүүлсэн. Улсын хэмжээнд холбогдох талуудын төлөөллүүд оролцсон **Төслийн төлөвлөгөөг хэлэлцэх үндэсний зөвлөлдөх уулзалтыг** Улаанбаатар хотод зохион байгуулж, БОНСУ-ий Ажлын төлөвлөгөө, хэлэлцүүлгийн хуваарь, эхний үр дүн зэргийг танилцуулан зөвлөлдсөн юм.

БОНСУ-ий 2 дахь үе шатанд 5 бүс нутагт цуврал хэлэлцүүлгийг зохион байгуулсан (Хойд, Өмнөд, Зүүн, Баруун, Төв). 2014 оны 1 сард зохион байгуулагдсан **Талуудтай зөвлөлдөх бүсийн эхний уулзалтаар**, оролцогч талууд уул уурхайн салбартай холбогдон үүсээд буй байгаль орчин, нийгмийн эн тулгамдсан асуудлуудыг тодорхойлж, ач холбогдлоор нь эрэмбэлэн БОНСУ-нд тусгах шаардлагатай тулгамдсан асуудлуудыг санал болгов.

Харин 2014 оны 2, 3 сард зохиогдсон **Талуудтай зөвлөлдөх бүсийн хоёр дахь уулзалтаар**, оролцогч талууд БОНСУ-ий багийн боловсруулсан хөгжлийн хувилбаруудад дүн шинжилгээ хийн хөгжлийн тухайн хувилбар тус бүрийн хувьд гарах үр ашиг, хожих, алдах, хохирох зүйлсийг онцгойлон авч үзсэн болно. Түүнчлэн, хоёр дахь хэлэлцүүлгийн уулзалт нь оролцогч талуудад БОНСУ-ий үйл явцад тэдний санал хэрхэн тусгагдсан байгааг харах боломжийг олгосон. Фото зураг 1.1-аас Ховд хотод зохиогдсон хэлэлцүүлэгт оролцогчид байгаль орчин, нийгмийн асуудлуудын талаар ярилцаж байгааг харна уу.



Фото зураг 1.1 Ховд хотод зохиогдсон хэлэлцүүлэгт оролцогчид байгаль орчин, нийгмийн асуудлуудын талаар ярилцаж, эрэмбэлж байгаа нь

Нийгмийн бүх төлөөллийг БОНСУ-ий үйл явцад үр дүнтэйгээр оролцуулах зорилгоор, доорх хүснэгтэнд дурдсан бүс нутагт талуудтай зөвлөлдөх хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тус зөвлөлдөх уулзалтанд сум/аймгийн удирдлага, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ), төрийн бус байгууллагууд (ТББ), байгаль орчны болон нийгмийн тусгай ашиг сонирхлыг илэрхийлэгч иргэний нийгмийн байгууллагууд, уул уурхайн хувийн компаниуд, эрдэм шинжилгээний байгууллагууд, малчид, эмэгтэйчүүд, ахмад настай хүмүүс, хувиараа ашигт малтмал олборлогчид г.м. эмзэг бүлгийнхэн зэрэг нийгмийн бүхий л талуудын төлөөллийг оролцуулахад ихээхэн анхаарал хандуулсан юм. Хэлэлцүүлэгт оролцогчдын төлөөллийг заасан албан бичгийг аймаг/сумын удирдлага, ИТХ, ТББ-д явуулснаар эмзэг бүлгийнхний оролцоог хангасан. Зөвлөлдөх хэлэлцүүлэгт оролцогчдод бэлтгэх боломж олгохын тулд уулзалт болохоос өмнө холбогдох материалуудыг оролцогчдод явуулж байв.

Хүснэгт 1.1 Талуудтай зөвлөлдөх бүсийн анхны хэлэлцүүлэг явагдсан газрууд

Бүс	Хамрагдсан <i>аймаг</i> / орон нутгууд	Байршил
Баруун	Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай	Ховд
Говь	Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говь-Сүмбэр	Цогтцэций
Зүүн	Дорнод, Сүхбаатар, Хэнтий	Чойбалсан
Хойд	Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон	Эрдэнэт
Хангай болон Төвийн бүс	Төв, Архангай, Өвөрхангай, Улаанбаатар хот	Улаанбаатар

Хүснэгт 1.2 Талуудтай зөвлөлдөх уулзалтанд оролцсон эмзэг бүлгийн оролцогчид

Эмзэг бүлэг	Оролцогчдын тоо
Эмэгтэйчүүд	49 (нийт оролцогчдын 28%)
Малчид	6
Өндөр настан	55-аас дээш насны 20 оролцогч
Бичил уурхайчид	1



Үндсэн өгөгдөл мэдээллийг цуглуулахын тулд хэлэлцүүлгийн үеэр оролцооны аргыг ашиглав. Оролцооны арга болох Хөдөөгийн түргэвчилсэн үнэлгээний² арга нь эдгээр хэлэлцүүлгүүдэд ашигласан үндсэн арга байлаа. Чухал байдлаар нь жагсаах, оролцооны аргаар зураглах, зорилтот бүлгийн ярилцлага зэрэг аргуудыг хэлэлцүүлгийн үеэр ашиглаж, уул уурхайн үйл ажиллагааны улмаас гарсан нийгэм, байгаль орчин, эдийн засгийн асуудлыг үнэлэх, орон нутгийн ард иргэд эрсдэл, ашиг тусыг яаж биет байдлаар мэдэрч, ойлгож байгаа талаар үнэлэх зэргийг оролцуулан орон нутгийн түвшинд тулгараад байгаа гол гол асуудлыг тодруулж, ач холбогдлоор нь жагсаан авч үзэв.

Гол талуудтай хийсэн ярилцлага. Төслийг хэрэгжүүлэх бүхий л хугацаанд гол талуудтай уулзалт, ярилцлагуудыг зохион байгуулсаар ирсэн бөгөөд эдгээр сонгосон талууд нь төсөлтэй холбоотой асуудлаар мэдлэг бүхий, эсвэл уул уурхайн салбарт чухал үүрэгтэй оролцогч талууд байв. Талуудтай зөвлөлдөх явцад эмзэг бүлгүүдийн дуу хоолойг сонсох талаар онцгой анхаарал хандуулан ажилласан болно. Дараах гол талуудтай ярилцлагууд хийсэн. Үүнд:

- Монголын Уул уурхайн үндэсний ассоциаци;
- Тогтвортой хөгжлийн төлөөх хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ;
- Монголын Байгаль орчны иргэний зөвлөл;
- Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол улс дахь хөтөлбөрийн газар;
- Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Уул уурхайн инженерийн сургууль;
- Бодлого судлалын төв;
- Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөл;
- Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;
- Уул уурхайн яамны Уул уурхайн бодлогын хэлтэс;
- Энержи Ресурс ХХК-ийн Компанийн нийгмийн хариуцлага, орон нутгийн иргэдтэй харилцах хэлтэс;
- Олборлох үйлвэрлэлийн ил тод байдлын санаачилга.

Утсаар ярилцлага авах аргыг сум, аймгийн удирдлага болон ИТХ-ын төлөөлөгчидтэй өгөгдөл мэдээлэл цуглуулах, тодруулах үед ихэвчлэн ашиглав.

Монголын уул уурхайн салбарын Нээлттэй өдөрлөг: БОНСУ-ий төслийн баг 2014 оны 5-р сард Уул уурхайн яамнаас зохион байгуулсан уул уурхайн салбарын нээлттэй өдөрлөгт оролцсон. Иргэдэд уул уурхайн салбарын талаар илүү их мэдээлэл өгөх, тус салбарын төлөөлөгчидтэй уулзаж, ярилцах, салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн

²Хөдөөгийн түргэвчилсэн үнэлгээ нь олон нийтийн бүлэг, орон нутгийн нөөц боломжийг үнэлж, асуудлыг тодруулж, ач холбогдлоор нь жагсаан авч үзэх болон эдгээр асуудлыг шийдвэрлэх стратегийг үнэлэх оролцооны, мөн харах мэдрэхүйд тулгуурласан арга юм. Энэ нь орон нутгийн хүн амын санааг зовоож байгаа асуудлыг судлах, асуудлыг ач холбогдлоор нь жагсаан авч үзэх, асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг үнэлэх аргачлал ба Састэйнабилити компаний ашигласан энэхүү аргад нөхцөл байдлыг нарийвчилсан зургаар илэрхийлэх арга техник, эн тэргүүний асуудлыг эрэлт хэрэгцээгээр нь эрэмбэлэх, мөн зорилтот бүлгийн ярилцлага зэрэг багтан орсон болно.

талаар мэдээлэл өгөх зорилгоор тус арга хэмжээг УУЯ-аас Чингис хааны талбай дээр зохион байгуулсан юм.

БОНСУ-ий төслийн явцыг авч үзэх, гарч буй үр дүнг танилцуулж, асуудлыг харилцан ярилцаж байх зорилгоор ДБ, УУЯ, УУСИБТТТ зэрэг БОНСУ-ий **төслийн гол зохицуулагч байгууллагуудтай** тогтмол уулзаж, зөвшилцөж байв. Дээрх БОНСУ-ий төслийн гол зохицуулагч байгууллагууд нь үндэсний хэмжээнд зохион байгуулсан хэлэлцүүлгүүдэд оролцсон бөгөөд БОНСУ-г гүйцэтгэх явцад чухал цаг үед оновчтой санаа оноо, зөвлөгөө өгч байв. Уул уурхайн салбарын хөгжлийн бодлогын хувилбаруудын талаарх тайлангийн төсөл нь дунд хугацааны чухал тайлан байсан бөгөөд гарсан гол үр дүнг БОНСУ-нд оролцож байгаа гол төрийн байгууллагуудад (УУЯ, БОНХЯ, МХЕГ) болон УУСИБТТТ, ДБ-д танилцуулж саналыг энэхүү тайланд тусган орууллаа.

Төслийн үр дүнг хэлэлцэх үндэсний зөвлөлдөх уулзалтыг Улаанбаатар хотод 2014 оны 6 сард зохион байгууллаа. Тус хэлэлцүүлгийн зорилго нь оролцогч талуудад өмнө тодорхойлсон бүх асуудал, цаашлаад асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний зөвлөмжүүд, зохицуулалт/институцийн сул талууд, эдгээр сул талыг шийдвэрлэх бодлогын зөвлөмжүүдийг цогцоор танилцуулах явдал байв. Сул талууд болон бодлогын зөвлөмжүүдийн талаар дэлгэрэнгүй санал, тайлбарыг оролцогчид өгсөн ба энэхүү тайланд эдгээр саналыг мөн тусган оруулав.

Оролцооны үйл явцыг энэ тайлангийн Хавсралт А-д дэлгэрэнгүй тайлбарлав.



Фото зураг 1.2 Төслийн үр дүнг хэлэлцэх үндэсний зөвлөлдөх уулзалт



1.6 УРЬДЧИЛСАН НӨХЦӨЛ БОЛОН ТӨСЛИЙН ҮР ДҮНГ ХЯЗГААРЛАСАН ХҮЧИН ЗҮЙЛС

БОНСУ-г гүйцэтгэж эхлэх үед дараах нөхцөл бүрдэнэ хэмээн таамагласан³ юм. Үүнд:

- Байгаль орчны стратегийн үнэлгээ нь ямар нэгэн бүтээгдэхүүн болон тайлан биш бөгөөд харин бүхий л хэсэгтээ тодорхой үр дүнд хүрэхийг зорьсон үйл явц юм. Хэдийгээр гарсан үр дүнг багтаан энэхүү тайланг бэлтгэсэн боловч, БОНСУ-ий хүрээнд тодорхойлсон арга хэмжээний болон бодлогын зөвлөмжүүдийг хэрхэн хэрэгжүүлэх нь Монгол улсын Засгийн газрын хувьд ихээхэн чухал асуудал байх болно.
- Хэдийгээр Састэйнабилити компани нь тус БОНСУ-г гүйцэтгэсэн ч энэ нь холбогдох талуудтай хамтран ажиллаж, гол гол шийдвэрийг зөвлөлдөн гаргасан үйл явц байна. Гол оролцогч талуудын хувь нэмэр БОНСУ-г гүйцэтгэхэд ихээхэн чухал байна.

Үнэлгээний үр дүнг хязгаарласан хүчин зүйлсэд дараах асуудлууд багтав. Үүнд:

- БОНСУ-г гүйцэтгэх ажлын даалгаварт уул уурхайн салбартай холбоотойгоор суурь судалгаа буюу төлөв байдлын үнэлгээг хийх үйл ажиллагаа багтан ороогүй. Гэсэн хэдий ч гол талуудтай хийсэн ярилцлага болон хэлэлцүүлгийн үеэр тус үнэлгээний хүрээнд суурь судалгаа хийгдэнэ гэсэн хүлээлттэй байгаа нь ажиглагдсан юм. Иймээс БОНСУ-ий аргачлалын дагуу уул уурхайн салбартай холбоотой байгаль орчин, нийгмийн асуулаар одоогийн нөхцөл байдлын судалгааг хийж гүйцэтгэсэн болно. Састэйнабилитигийн баг одоо байгаа судалгаа, тайлангийн өгөгдөл мэдээллийг ашиглах боломжтой байсан ч, ихэнх тохиолдолд энэ нь хангалтгүй (жишээ нь, тодорхой чиглэл, ашигт малтмал болон төсөлтэй холбоотой), цаашлаад бодитоор тус үнэлгээнд ашиглагдах боломжгүй байв. Байгаль орчин, нийгмийн дэлгэрэнгүй өгөгдөл мэдээллийг цуглуулж, үнэлсэн бол тус БОНСУ-г илүү сайн гүйцэтгэх боломжийг олгох байлаа.
- БОНСУ-г гүйцэтгэхэд гарсан хамгийн том хүндрэл нь уг үнэлгээг ямар нэгэн тодорхой бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг үнэлэхээр гүйцэтгээгүй, иймээс бодлого боловсруулах үйл явцтай шууд холбож уяж чадаагүй ба улмаар тус үнэлгээний үр дүнгээс хамааруулан Монголын уул уурхайн салбарын хөгжлийн чиглэлийг өөрчилж нөлөөлөх боломж мөн дутагдаж байна. БОНСУ-ий үр дүн нь Монгол улсын Засгийн газар эдгээрийг хүлээн авч, санал болгосон зөвлөмжийг хэрэгжүүлэх улс төрийн хүсэл эрмэлзэлтэй эсэхээс хамаарахаар байгаа юм.

³Энд дурдсан урьдчилсан нөхцөл, таамаглал нь уул уурхайн салбарын хөгжлийн хувилбаруудад авч үзсэн таамаглалаас өөр ба хөгжлийн хувилбаруудад авч үзсэн таамаглалыг энэ тайлангийн 3-р бүлэгт оруулав.



2. ОДООГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

2.1 ТАНИЛЦУУЛГА

Нөхцөл байдлын үнэлгээ нь Монгол улсын уул уурхайн салбарын цаашдын шинэчлэл хийгдэх өнөөдрийн орчин, нөхцлийг тодорхойлсон ерөнхий *суурь үнэлгээ*⁴ бөгөөд, Бүлэг 3-т авч үзсэн уул уурхайн салбарын хөгжлийн хувилбаруудыг боловсруулах өнөөгийн суурь орчныг төлөөлж байгаа болно. Энэ бүлэгт Монгол улсын уул уурхайн салбарын түүхэн хөгжил, салбарын хөгжилд нөлөөлөгч бүс нутгийн болон глобал хүчин зүйлүүд, ашигт малтмалын гол төрлүүд, уул уурхайн үндсэн үйл ажиллагаа, байгаль орчин ба нийгмийн асуудлыг зохицуулах эрх зүйн болон институцийн тогтолцоог авч үзлээ. Бүлгийн төгсгөлд уул уурхайн салбарт тулгараад буй байгаль орчин, нийгэм, эдийн засгийн гол гол асуудлуудын үнэлгээг оруулсан болно.

2.2 МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монгол улс нь нүүдлийн мал аж ахуй давамгайлсан социалист улсаас зах зээлийн эдийн засаг, олборлох үйлдвэрлэл бүхий олон намын системтэй ардчилсан нийгэмд шилжсэн юм. Монгол улс 2.9 сая хүн ам, 1.6 сая квадрат км нутаг дэвсгэртэй.

Монгол улс 70 (1920-1970) жилийн турш Социалист орнуудын эвслийн гишүүн байсан бөгөөд энэ хугацаанд аж үйлдвэрлэлийн болон хөдөө аж ахуйн салбаруудыг төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн аргаар хөгжүүлж ирсэн юм. 1950-аад оны үеэс хөдөөгөөс төв суурин чиглэсэн хүн амын шилжилт нэмэгдэж хотжилт эрчимжиж эхэлсэн байдаг. Энэ үед төрөөс, хүн амын ихэнх хувийн амьжиргааны эх үүсвэрийг бүрдүүлж байсан мал аж ахуйн салбарыг улс орныг хамарсан нэгдэлжих хөдөлгөөнд хамруулж, томоохон хэмжээний төрийн мэдлийн сангийн аж ахуй, нэгдлүүдийг байгуулсан байна. 1990 оны ардчилсан хувьсгалын үр дүнд Монгол улс нь хуучин ЗХУ-ын дагуул улсаас олон намын тогтолцоотой, ардчилсан, зах зээлийн эдийн засаг бүхий орон болох шилжилтийг хийжээ. Энэ үед тус улсын худалдаа, хөрөнгө оруулалтын 90 хувийг бүрдүүлж байсан социалист эвсэл нуран унаснаар дээрх эвслээс авдаг байсан эдийн засгийн дэмжлэг үгүй болсон байна. Эдийн засгийг хөгжүүлэхийн тулд, Монгол улсын Засгийн газрын зүгээс тэр үеийн Олон улсын валютын сангийн зөвлөж байсан эдийн засгийн бүтцийг огцом өөрчлөх “цочир эмчилгээний” бодлогыг хэрэгжүүлсэн байдаг. Үүнтэй уялдуулан өргөн хэмжээний өмч хувьчлал явагдсан ба энэ нь богино хугацаанд ажилгүйдлийн түвшинг ихэсгэж, инфляцийг 30 хүртэл хувьд хүргэн ядуурлыг ихэсгэх шалтгаан болсон байна (Уул уурхай дахь нийгмийн хариуцлагын төв, 2014).

1990-ээд оны сүүлээр ашигт малтмалын томоохон ордуудыг ашиглаж эхэлснээр Монгол улсын эдийн засагт томоохон өөрчлөлт гарч, энэ нь өнгөрсөн жилүүдэд уул уурхайн салбар хурдацтай хөгжин Монгол улсын эдийн засаг дэлхийн хамгийн өндөр өсөлттэй эдийн засаг болоход нөлөөлсөн юм. 1990-ээд оны сүүлээс 2000-аад оны эхэн хүртэл, Монгол улсын Засгийн газар ашигт малтмалын салбарт чиглэсэн олон улсын хөрөнгө оруулалтыг татах талаар ихээхэн хүчин чармайлттай ажилласан байна. 1997 оны Ашигт малтмалын хууль нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгох, эдгээр тусгай зөвшөөрлийг ашиглах баталгааг олгосон

⁴ Нөхцөл байдлын үнэлгээ нь суурь судалгаа шиг дэлгэрэнгүй байх шаардлагагүй. Хоёр дахь эх үүсвэрээс авсан мэдээлэл болон мэргэжилтний санал бодол дээр голлон тулгуурлаж энэ үнэлгээг хийж болно (World Bank, et al, 2011).



ихээхэн тааламжтай орчныг бүрдүүлсэн. Энэ хууль уул уурхайн хөрөнгө оруулагчдын төлөх ашигт малтмал ашигласны төлбөр болон татварын дарамтыг бууруулснаар уул уурхайн салбарын хурдацтай хөгжих нэн таатай орчныг бий болгосон байдаг. 1990 оноос хойш уул уурхайн салбарт хийсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) бусад салбартай харьцуулахад ихээхэн нэмэгдсэн ба Монгол улсад хийгдсэн нийт ГШХО-ын 68% нь геологийн эрэл хайгуул, газрын тосны эрэл хайгуул болон уул уурхайд хийгдсэн байна (Эрнст энд Янг, 2012/2013). Уул уурхайн салбар нь Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 30 орчим хувь болон төсвийн багагүй хэсгийг бүрдүүлдэг.

Хөгжиж буй бусад орнуудын адилаар уул уурхайн салбарын хөгжил нь мөн зарим нэгэн бэрхшээлтэй асуудлыг бий болгож байна. Уул уурхайн салбараас хүртэх үр ашгийн шударга бус хуваарилалт, уурхайн нөлөөлөл болон ЗГ, уул уурхайн салбарын хэмжээнд өсөн нэмэгдэж байгаа авлига, уламжлалт амьдралын хэв маягт гарч буй өөрчлөлт, Монгол орны хэмжээнд, нэн ялангуяа томоохон уурхайнууд байгуулагдаж байгаа говь нутгийн ховор нөөц баялаг болох усны үнэт нөөцөд үзүүлэх нөлөөлөл зэргээс болж уул уурхайн үйлдвэрлэлд сэтгэл дундуур байх байдал иргэдийн дунд өсөн нэмэгдэж байна. Гадаадын хөрөнгө оруулагчид ашигт малтмалын нөөцийг хяналтандаа авч байгааг эсэргүүцэх, хууль журмыг чангатгах, уул уурхайн ордуудыг төрийн мэдэлд авах зэрэг дарамт шахалттай Монгол улсын Засгийн газар тулгарч байна. Дэлхийн эдийн засгийн хүндрэл, улам бүр чангарч буй дотоодын хууль журам зэргээс шалтгаалан Монгол улсад оруулах ГШХО 2011 оны сүүл гэхэд хамгийн оргил үедээ хүрээд саарсан юм.

2012 онд Монгол улсын Засгийн газар нь Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг баталсан билээ. Тус хуулиар, эрдэс баялаг, банк санхүү, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо зэрэг стратегийн ач холбогдолтой салбаруудад 100 сая төгрөг (76 сая ам.доллар)-өөс дээш дүнтэй, эсвэл гадаад улсын төрийн өмчит компаниудаас хийсэн хөрөнгө оруулалт нь тухайн аж ахуйн нэгжийн эзэмшлийн 49%-иас илүү гарах тохиолдолд хөрөнгө оруулалтыг Засгийн газраас зөвшөөрөл авах зохицуулалт орсон байна. Улсын Их Хурлын сонгуулийн өмнө яаран баталсан тус хуулинд олон чухал тодруулгыг орхигдуулсан бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчын дунд ойлгомжгүй байдлыг бий болгож, улмаар ГШХО буурахад нөлөөлсөн байна (АНУ дахь Монгол улсын Элчин сайдын яам, 2014). ГШХО буурч, эдийн засгийн өсөлт удаашрахад хүргэсэн өөр нэг зүйл бол тус улсын хамгийн том уурхайн төсөл болох Оюу Толгойн талаар Монгол улсын Засгийн газар болон түүний хөрөнгө оруулалтын түнш Туркойз Хилл Ресурс/ Рио Тинтогийн хоорондын санал зөрөлдөөнтэй байдал үргэлжилсээр байгаа явдал болно. Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээг өөрчлөх, ялангуяа өмчлөлийн бүтэц, ашиг хуваах тохироо, гэрээнд заагдсанаас илүү зарцуулсан зардал зэрэг нь маргааны сэдэв байсаар байна. Энэхүү маргаан нь Оюу Толгой төслийн цаашдын бүтээн байгуулалтад саад болсоор байгаа төдийгүй бусад хөрөнгө оруулагч компаниудын хувьд энэхүү маргаан яаж шийдэгдэхийг харгалзан хөрөнгө оруулах гэсэн хүлээлтийн байдал үүсгэсээр байгаа юм.



2.3 САЛБАРЫН ХӨГЖИЛД НӨЛӨӨЛӨХ БҮС НУТГИЙН БОЛОН ГЛОБАЛ АСУУДЛУУД

Хөрш улсууд болох Хятад, Орос нь Монгол улсын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд уул уурхайн салбарт ихээхэн нөлөө үзүүлдэг. Гурван зууны турш Монгол улс нь Орос болон Хятадын нөлөөлөл, харьяанд орж байсан түүхтэй. Хэдийгээр хуучин социалист систем задран унаснаар Монгол улс бие даасан, ардчилсан улс болсон хэдий ч, эдийн засгийн хувьд геополитикийн байдлаасаа шалтгаалан хөрш орнуудаасаа хамааралтай байсаар байна. Тухайлбал нийт нефтийн бүтээгдэхүүний 98.2%-ийг Орос улсаас импортолж байгаа бол нийт худалдааны 89%-ийг дан ганц Хятад улстай ихэвчлэн зэс болон нүүрсний экспортоор дамжуулан хийж байна (Бертельсманн сан, 2014). Монгол нь Орос улстай эдийн засгийн нягт холбоотой байдаг бөгөөд Улаанбаатар төмөр замыг 50:50 хувиар, мөн Эрдэнэтийн зэсийн уурхайг хамтран эзэмшиж, түүнчлэн хоёр улсын хооронд худалдааны олон тооны гэрээ хэлэлцээрийг байгуулсан байдаг.

Түүхийн хувьд авч үзвэл Хятад улстай харилцах харилцаа нь Монгол улсын хувьд Орос улстай харилцахаас илүү бэрхшээлтэй байсаар ирсэн. Монгол улсын эдийн засгийн хөгжилд үзүүлэх Хятад улсын нөлөө өндөр бөгөөд төрийн байгууллагын олон албан хаагчид энэ нөлөө ихсэн эдийн засгийн хувьд Хятад улсаас улам хараат болох вий хэмээн болгоомжилдог. Иймэрхүү болгоомжлол нь тийм ч үндэслэлгүй зүйл бас биш юм. Хуучин Зөвлөлт Холбоот улсын задрал, сүүлийн жилүүдийн Хятадын эдийн засаг хурдацтай өсөлт зэрэг нь Хятад улсыг нь Монголын хамгийн том худалдааны түнш болгосныг дээр дурдсан худалдааны тоо баримт харуулж байна. Далай тэнгисээс алслагдсан газар зүйн байрлалаас шалгаалсан тээврийн өндөр зардал нь Монголоос гарч буй ихэнх ашигт малтмалын бүтээгдэхүүнийг Хятадаар дамжуулан гаргахаас бусад тохиолдолд олон улсын экспортын зах зээл өрсөлдөх чадваргүй болгодог. Өмнөговийн нүүрс, зэсийн ордуудаас Оросын боомтууд хүртэл 4000 км бол, Хятадын хил хүртэл ердөө хэдхэн зуун км байдаг. Жишээ нь Овоот Толгойн нүүрсний ордоос Хятадын хил хүртэл ердөө л 40 км байдаг. Монгол улсын хойд нутгийн нүүрсний хувьд ч мөн ойролцоо дүр зураг харагдаж байна. Оросын боомтуудаар дамжуулан Зүүн Азийн зах зээлд хүргэхэд гарах нүүрсний тээврийн болон боомтын өндөр зардал нь Монголын хойд хэсгийн нүүрсийг Австрали болон бусад далайн тээвэр ашиглан дээрх зах зээлд нүүрс нийлүүлэгчидтэй өрсөлдөх чадваргүй болгож байна (Коллинс ба Эриксон, 2012). Өөр өнцгөөс нь харвал Монгол улс нь Хятадад эрэлт хэрэгцээтэй нүүрс, зэс, алт, жонш зэрэг олон ашигт малтмалыг бага зардлаар нийлүүлэх боломжтой байгаа явдал юм.

Том хөршүүдээсээ хамаарах хамаарлыг бууруулах зорилгоор Монгол улс 1990-ээд оны үеэс дэлхийн өөр бусад улс орнуудтай гадаад харилцаа болон эдийн засгийн харилцааг өргөжүүлэн тэлэх "гуравдагч хөршийн" бодлогыг хэрэгжүүлж ирсэн билээ. Бээжин болон Москва өөрсдийн дотоодын асуудалд илүүтэй анхаарч байсан 1990-ээд оны үед ашигт малтмалын асар их баялгийг олж илрүүлснээр Монгол улс гуравдах хөршүүдийн худалдааны түншүүдийн анхаарлыг татаж чадсан юм. Тэр үеэс хойш Монгол улсын Засгийн газар нь Америкийн Нэгдсэн Улс, Канад, Австрали, Өмнөд Солонгос, Европын Холбоо, Япон, Энэтхэг зэрэг олон улс орнуудтай идэвхтэй харилцааг бий болгон хөгжүүлж чадсан бөгөөд Монгол улсын уул уурхай, дэд бүтцийн томоохон төслүүдийг эдгээр гуравдахь хөршүүдийн байгууллага, компаниуд хэрэгжүүлж байна.

Дэлхийн том зах зээл болох Хятад улстай хөршлөн оршдог, ашигт малтмалын асар их нөөцтэй, ерөнхийдөө тайван тогтвортой байдалтай зэрэг нь Монгол улсын өрсөлдөх чадвар болох ч уул уурхайн салбарын дэлхийн чиг хандлага, эмзэг байдлаас ангид биш юм. Сүүлийн хорин жилийн хугацаанд, Азийн аж үйлдвэрлэлийн өндөр өсөлт, металл болон эрчим хүчний эрэлт хэрэгцээ өссөнөөс бий болсон “уул уурхайн супер мөчлөг”-ийн үед бараг бүх төрлийн ашигт малтмалын үнэ нэмэгдсэн байдаг. Өнгөрсөн түүхээс харахад түүхий эд, бүтээгдэхүүний үнэ өндөр байх нь хөгжиж буй улс орнуудын дунд хөрөнгө оруулагчдад ээлтэй уул уурхайн хууль журмыг баталж, санхүүгийн нөхцлийг бууруулах замаар уул уурхайн хөрөнгө оруулалтыг татах өрсөлдөөн бий болгодог. Харин 2000-аад оны үеэс өсөн нэмэгдэж буй ажиллах хүчний болон үйлдвэрлэлийн зардал, хувьцаа эзэмшигчдийн шаардлага, тухайн улс орны зүгээс тавьж буй татвар, хувь эзэмшлийн талаар тавих шаардлага, уул уурхайн нөлөөлөлд өртсөн орон нутгийнхний хүсэлт хүлээлт зэрэг нь уул уурхайн салбарын үр дүнтэй засаглал нь сайн дурын гэхээсээ зүй ёсны шаардлага болон хувирч байна (Дэлхийн банк, 2013). Монгол улсын уул уурхай хөгжил нь дэлхийн уул уурхайн салбарын гэнэтийн өөрчлөлтүүдийг даван туулж, нийгэмд тэгш хүртээмжтэй үр ашгаа өгч, байгаль орчны хувьд тогтвортой байх нь энэ салбарт цаашдын ямар бодлого хувилбарыг сонгон хэрэгжүүлэхээс хамаарна.

2.4 АШИГТ МАЛТМАЛЫН ТӨРЛҮҮД БОЛОН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол улсад одоогоор мэдэгдэж байгаагаар 80 гаруй төрлийн ашигт малтмалын 6,000 гаруй ордууд илрээд байна. 1920-оод оны үеэс хойш хийгдсэн геологийн судалгаагаар ашигт малтмалын арвин их нөөц илрүүлсэн ч (Хүснэгт 2.1-ийг үзнэ үү) тус улсын нутаг дэвсгэрийн 15 хувьд бүрэн хэмжээний зураглал хийгдэж, илэрсэн ордуудын 600 орчим нь нарийвчлан судлагдсан байна(АНУ дахь Монгол улсын Элчин сайдын яам, 2014). Эдгээр ордуудад 180 гаруй алт, 5 зэс молибден, 1 хар тугалга, 5 цагаан тугалга, 10 төмөр, 4 мөнгө, 42 хүрэн болон коксжих нүүрс, 42 жонш, 12 давс, 10 натри, хүхрийн хүчлийн давс, 6 үнэт чулуу, 9 болорын орд болон газрын ховор элементийн баялаг нөөцүүд багтан орж байгаа болно. Одоогийн байдлаар, эдгээр ашигт малтмалын ордоос 200 гаруйг нь ашиглаж байгаа бөгөөд ихэвчлэн алт, зэс, нүүрс, давс олборлож байна. Хүснэгт 2.2-д Монгол улсын томоохон ашигт малтмалын илэрцийн талаар нэмэлт дэлгэрэнгүй мэдээллийг харуулав.

Хүснэгт 2.1 Ашигт малтмалын төрлүүд болон эдгээрийн нөөцийн хэмжээ (2012 оны 1-р сарын 1-ий байдлаар)

Ашигт малтмал	Тогтоосон нөөц (2012 оны 1-р сарын 1)
Нүүрс (сая тонноор)	18,473.2
Төмөр (сая тонноор)	1,046.6
Зэс (мянган тонноор)	83,807.0
Хар тугалга (мянган тонноор)	1,740.0
Алт (шороон ордын) (тонноор)	221.5
Алт (үндсэн орд) (тонноор)	2,180.9

(АНУ дахь Монгол улсын Элчин сайдын яам, 2014)



Хүснэгт 2.2 Монгол улсын томоохон ашигт малтмалын илрэлүүд

Ашигт малтмал	Тодорхойлолт
Алт	Монгол улсын хэмжээнд алтны ордууд бүхий 10 газар байдаг. 1990-2005 оны хооронд алтны олборлолт ихээхэн нэмэгдсэн ч сүүлийн хэдэн жилийн хугацаанд байнга буурсан байна. Оюу Толгой зэрэг уурхайн үйлдвэрлэж буй зэсийн баяжмал зэргээр бусад ашигт малтмал илэрч эхэлсэнээр алтны олборлолт ихээр нэмэгдэх төлөвтэй байна.
Зэс болон Молибден	Монгол улсын хэмжээнд 3 зэс молибдений бүс нутаг байгаа бөгөөд эдгээр нь Алтай, Монголын хойд хэсэг, өмнөд хэсэг болно. Одоогоор Эрдэнэтийн уурхайд ихэнх олборлолт хийгдэж байна. Оюу Толгойн үйлдвэрлэл 2013 онд эхэлснээр зэсийн олборлолт ихээр нэмэгдсэн.
Жонш	Монгол улсын хэмжээнд хойд, төв, дорнод Монголын гэсэн 3 гол жоншны бүс нутгууд байдаг бөгөөд нийт 600 гаруй жоншны орд, илрэлүүд байна. Монгол улс нь дэлхийн нийт жоншны олборлолтын 4 хувийг нийлүүлдэг дэлхийн хэмжээний 5 дахь жонш олборлогч болно. Хүчиллэг болон хайлуур жоншны аль алийг нь үйлдвэрлэн гаргадаг.
Нүүрс	Монголын Төвийн болон Өмнөд бүс нутгуудад нүүрсний олон тооны илрэл байдаг бөгөөд Улаанбаатарын сав газрыг хамгийн их нөөцтэй гэж үздэг. 2004 оноос хойш Таван Толгой, Ухаа худаг, Бортолгой, Овоот толгой, Хөшөөт, Алтай нүүрс зэрэг өндөр чанартай коксжих нүүрсний ордууд нээгдсэнээр нүүрс экспортлох боломжууд ихээхэн нэмэгдээд байна.
Газрын ховор элемент	Алтай, Хэнтий, Хангай, зүүн өмнөд бүс нутаг, өмнөд бүс нутгуудад газрын ховор элементийн ихээхэн нөөц илэрсэн. Хамгийн нийтлэг бөгөөд эдийн засгийн хувьд олборлолт хийхэд ашигтай газрын ховор элементүүдэд танталум, ниобиум, иттриум, ториум, циркон зэрэг орж байна.
Уран	Томоохон ураны ордууд нь Монгол улсын зүүн хэсэгт байрлах Дорнод аймгийн Гурванбулаг, Мардай болон Өмнөд бүс нутгийн Хараат зэрэг газар байдаг. 1989-1993 оны хооронд Мардайн ил уурхайд уран олборлож байсан түүхтэй.

(World Bank, Mongolia, 2013) and (Ernst & Young, 2012/13)

Монгол улсын Ашигт малтмалын хуулиар, Монгол улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч бөгөөд төр өмчлөгчийн хувьд, энэ хуульд заасан нөхцөл, шаардлага, журмын дагуу ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрхийг бусад этгээдэд олгох эрхтэй. Ашигт малтмалын ордыг доор дурдсан байдлаар 3 ангилдаг. Үүнд:

- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд: стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд гэж Үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг;
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд: эдгээр нь зам, барилгын материалын зориулалтаар ашиглах боломжтой элбэг тархалт бүхий элс, хайрга, барилгын чулууны хуримтлалууд болно.
- Ердийн ашигт малтмалын орд: Стратегийн ач холбогдол болон түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хуримтлалыг ердийн ашигт малтмалын ордод хамааруулна.

Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны

хэмжээ 50 хүртэл хувьтай байж болно. Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болно.

Монгол улсын ЗГ нүүрс, уран, зэс, фосфат, алт, цайр, мөнгө зэрэг ашигт малтмалын 15 ордыг стратегийн ач холбогдолтой ордууд гэж тодорхойлоод байна (Хүснэгт 2.4.3; Зураг 2.1).

Хүснэгт 2.3 Стратегийн ач холбогдолтой ордууд

Стратегийн ач холбогдолтой ордууд	Ашигт малтмалын төрлүүд	Нөөцийн хэмжээ
Оюу Толгой	Зэс, молибден	Зэс 37 сая тонн, алт 1,300 тонн
Таван Толгой	Нүүрс	1.4 тэрбум тонн коксжих нүүрс
Нарийн сухайт	Нүүрс	500 сая тонн
Цагаан суварга	Зэс, молибден	324,000 тонн зэс
Шивээ овоо	Хүрэн нүүрс	554.7 сая тонн
Асгат	Мөнгө	Мөнгө 2,247 сая тонн, зэс 76,746 тонн
Төмөртэйн Овоо	Цайр, хар тугалга	885,300 тонн цайр
Дорнод	Уран	28,868 тонн уран
Гурванбулаг	Уран	16,073 тонн уран
Мардай	Уран	1,104 тонн уран
Багануур	Хүрэн нүүрс	240 сая тонн
Төмөртэй	Төмрийн хүдэр	229.5 сая тонн
Бороо	Алт	38 тонн алт, 5 тонн мөнгө
Эрдэнэт	Зэс, молибден	4.8 сая тонн зэс, 131,034 тонн молибден
Бүрэнхаан	Фосфорит	162.56 сая тонн фосфоритын хүдэр

(Эрнст энд Янг, 2012/2013)



Зураг 2.1 Монгол улсын стратегийн ач холбогдолтой ордуудын байршил⁵

⁵Бүх газрын зурагт ашигласан өгөгдлийн эх сурвалжийг Хавсралт А-д оруулав.

Одоогоор бүтээн байгуулалтын ажил явагдаж байгаа болон ашиглалтанд орсон томоохон уул уурхайн төслүүдэд дараах төслүүд орж байна. Үүнд:

Оюу Толгой: Оюу Толгой нь Монгол улсын хамгийн том уул уурхайн бүтээн байгуулалт бөгөөд 50 гаруй жилийн нөөцтэй гэж тооцогдож байна. Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ нь 6 жил орчим Улсын Их Хурал болон олон нийтээр хэлэлцэгдсэний эцэст 2009 оны 10 сарын 6-нд батлагдсан билээ. Өмнийн говьд байрлах тус уурхайн 34 хувийг Монгол улсын Засгийн газар, үлдсэн 66 хувийг Туркойз Хилл компани хамтран эзэмшдэг. Тус уурхайн төслийн үндсэн санхүүжүүлэгч Рио Тинто компани нь Туркойз Хилл компаний ихэнх хувийг эзэмшдэг. Уурхайн үйлдвэрлэл 2013 онд эхэлсэн бөгөөд 2015 он гэхэд жилд 450 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэнэ гэж тооцож байна⁶. Тус төсөл нь Монгол улсын урт удаан хугацааны эдийн засгийн өсөлт болон дэлхийн зэсийн ханган нийлүүлэлтэнд ихээхэн чухал үүрэгтэй байх болно.

Дээр дурдсанчлан, Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээний талаар Монгол улсын Засгийн газар болон Туркойз Хилл Ресурс/ Рио Тинто компаний хоорондын маргаан байсан хэвээр байна. Энэ маргаан Оюу Толгой төслийг, ялангуяа далд уурхайн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг удаашруулан саатуулсаар байгаа билээ.



Фото зураг 2.1 Оюу Толгойн ил уурхайн үйл ажиллагаа

(Оюу Толгой ХХК, 2014)


Эрдэнэтийн зэс-молибдений уурхай: 1970-аад оны үед байгуулагдсан тус уурхай нь дэлхийн хамгийн том зэсийн 10 уурхайнуудын нэг юм. Тус уурхай нь Монгол улсын ДНБ-ий 25%, нийт экспортын 40 гаруй хувийг тус тус бүрдүүлж Монгол улсын эдийн засагт чухал хувь нэмэр оруулдаг. Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр нь Монгол Оросын хамтарсан үйлдвэр бөгөөд Монгол улсын татварын орлогын ихэнхийг бүрдүүлж иржээ. Монгол улс өөрийн эзэмшлийн 51 хувийг стратегийн ач холбогдолтой болон төрийн хөрөнгөөр эрэл хайгуул хийгдсэн ордууд дахь төрийн хувь эзэмшлийг төлөөлөх зорилгоор байгуулагдсан төрийн өмчийн Эрдэнэс МГЛ ХХК-д 2013 онд шилжүүлсэн байна.

⁶ Оюу Толгой 2014 оны эхний улиралд 25,300 тонн зэс агуулсан 102,900 тонн зэс-алтны баяжмал олборлосон байна.

Таван Толгой: Таван Толгой нь дэлхийн хамгийн том нүүрсний орд юм. Улс тус ордыг 2 блокт хуваасан бөгөөд төрийн өмчит Эрдэнэс Таван Толгой компани нь нэг блокийг хариуцан авч, хоёрдахь блокийг хувийн хэвшлийн уул уурхайн компаниудад санал болгосон байна. 2011 онд Монгол, Хятад, Орос болон АНУ-ын компаниудын хамтарсан консорциумд хоёрдахь блокийг өгөхөөр гэрээг боловсруулсан боловч үйл ажиллагаагаа эхлүүлэхээс өмнө задарсан байна. Эрдэнэс Таван Толгой компанийн эхний блокийн хувьцааг 2013 онд Монголын болон Лондонгийн хөрөнгийн биржид гарган хөрөнгө оруулалт олох төлөвлөгөө хэрэгжээгүй бөгөөд дэд бүтэц байгуулагдах хүртэл хойшлогдоод байна.

Багануур: Багануурын хүрэн нүүрсний уурхай нь 1978 онд байгуулагдсан бөгөөд өнөөдрийг хүртэл 75 сая тонн нүүрс олборлоод байна. Багануур дүүрэгт байрлах энэхүү уурхай нь Монгол улсын хамгийн том нүүрсний хангагч бөгөөд Улаанбаатар хотыг оролцуулан төвийн бүс нутгийн нүүрсний ихэнх хэрэгцээг хангадаг. Тус компаний үндсэн үйлчлүүлэгчид нь төрийн өмчийн дулааны станцууд байдаг. Шинээр байгуулагдсан Багануурын Эрчим хүчний корпораци (Солонгосын цахилгаан эрчим хүч, гангийн үйлдвэрлэгч компани Поско (Posco) болон Монголын хамгийн том хувийн компани болох MCS-ийн хамтарсан компани) нь нүүрснээс шингэн түлш дизель, диметилийн эфир үйлдвэрлэх үйлдвэрийг Багануурт барихаар төлөвлөж байгаа ба тус уурхайн нүүрсийг ашиглах юм. Төсөл хэзээ хэрэгжиж дуусах нь одоогоор тодорхой болоогүй байна.

Томоохон уурхайн төслүүдээс гадна жижиг хэмжээний уурхайнууд нь мөн Монгол улсын уул уурхайн бүтээгдэхүүн, экспортын гол эх үүсвэр билээ. 2012 онд ашигт малтмалын экспорт улсын нийт экспортын бүтээгдэхүүний 89%-ийг бүрдүүлсэн бөгөөд ихэнхийг нь нүүрс (43.4%), зэсийн баяжмал (19.1%), түүхий нефть (7.7%) болон алт (2.8%) эзэлж байна. Ашигт малтмалын гол төрлүүд болох болох зэс, нүүрс болон алт нь улсын нийт экспортын 73%-ийг тус бүрдүүлдэг бол нийт экспортын 92.6% нь Хятад, 1.8% нь Орос улсад тус тус гарсан байна (Дэлхийн банк, 2013). Зураг 2.2-т 2012 онд экспортолсон бүтээгдэхүүний хэмжээг хувиар үзүүлэв.



Зураг 2.2 Экспортын хэмжээ (2012, %)

(Дэлхийн банк, 2013)



2.5 УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН ИНСТИТУЦУУД

2.5.1 Танилцуулга⁷

Өнгөрсөн хугацаанд уул уурхайн байгаль орчин, нийгмийн менежментийн хууль эрх зүйн зохицуулалтын болон институцийн орчин өөрчлөгдсөөр ирсэн байна. Энэ нь ихэвчлэн сонгуулийн мөчлөг буюу 4 жил тутам шинээр Засгийн газар байгуулан шинэ сайдууд томилогдохтой холбоотойгоор хувьсан өөрчлөгдөж байдаг улс төрийн шийдвэр, залгамж халаа болоод гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монголын төрийн бодлого, оролцоо ямар байх талаар нийтийг хамарсан маргаантай асуудлуудаас шалтгаалсан байдаг. Энэ тайланг бэлтгэж байх үед ч шинэ Ашигт малтмалын тухай хуулийн агуулга зэрэг олон зүйл тодорхойгүй хэвээр байсан ба энэхүү шинэ хууль эдгээр асуудлыг тодорхой болгоно хэмээн найдаж байна.

Энэ хэсэгт байгууллагуудын үүрэг хариуцлага, холбогдох хууль эрх зүйн орчны талаар товч тайлбарлан цаашлаад эдгээр орчинд үүсээд буй дутагдал, сул талын талаар тойм дүн шинжилгээ хийх явдал юм. Түүнчлэн энэ хэсэгт Бүлэг 3-т орсон байдлаар уул уурхайн салбар цаашид тогтвортойгоор хөгжихөд саад болохуйц хууль эрх зүйн зохицуулалт, институци, болон чадавхийн асуудлуудын үнэлгээг хийхэд шаадлагатай суурь ойлголтыг бий болгохыг зорьсон болно.

2.5.2 Институцийн үүрэг хариуцлагын тойм

Монгол улсад уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн зохицуулалтыг Уул уурхайн яам (УУЯ) болон тус яамны харьяа Ашигт малтмалын газар (АМГ), Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ) гэсэн төрийн 3 байгууллага ерөнхийдөө хариуцдаг. Өөр бусад төрийн байгууллагууд чухал боловч хоёрдугаар зэргийн оролцоотой байдаг.

УУЯ болон БОНХЯ-д өнгөрсөн 5 жилийн хугацаанд ихээхэн шинэчлэл хийгдсэн боловч энэ хугацааны уул уурхайн салбарын огцом өсөлттэй харьцуулахад дээрх яамдын чадавхид хангалттай өөрчлөлт гараагүй байна. БОНХЯ (өмнө нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам нэртэй байсан) нь өөрсдийн хариуцдаг байгаль орчны нөлөөллийн үнэлгээний үйл явцаар дамжуулан уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, байгалийн нөөцөд үзүүлж буй нөлөөлөл, газрын доорх усны нөөцийн асуудлыг удирдан хянадаг. Түүнчлэн уурхайн нөхөн сэргээлт, холбогдох байгаль орчны журам стандартыг боловсруулах, үндэсний хэмжээнд байгаль орчны асуудлаар судалгаа хийлгэх, холбогдох газрын зураг хийх, олон нийтэд мэдээлэл хүргэх, байгаль орчны чиглэлээр үзүүлж буй хандивлагч байгууллагуудын тусалцааг удирдан зохицуулах үүргийг тус тус хүлээдэг. Мөн аймаг, сумдад байгаль орчны чиглэлээр тусламж, дэмжлэгийг үзүүлж, хуулийн хэрэгжилт болон хохирлыг нөхөн сэргээж байгаа явцыг шалгадаг.

УУЯ нь ашигт малтмалын салбарын бодлого, хууль журмыг хариуцдаг бол, АМГ нь Цөмийн энергийн газрын хариуцдаг ураны эрэл хайгуул, ашиглалтаас бусад бүх төрлийн тусгай зөвшөөрлийн асуудлыг хариуцдаг.

⁷Тус тайлангийн энэ дэд бүлэг нь гол талуудтай хийсэн ярилцлага болон дараах судалгааны тайлангуудад тулгуурласан болно. Үүнд: Батчер ба Смит (2013), Австралийн Гадаад харилцаа, худалдааны газар (DFAT) (2014), НҮБХХ, Уул уурхайн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам (2012), Тортель, Боржигдхан, Найдансүрэн (2008), Ханнам (2009).



МХЕГ нь 2002 онд байгуулагдсан бөгөөд ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хяналт шалгалтын асуудал хариуцдаг. МХЕГ нь янз бүрийн салбарын яамдад тарсан байсан 13 агентлагын оронд байгуулагдсан. Хяналт, шалгалтын үйл ажиллагаанд нэгдсэн байр сууринаас хандах, үйл ажиллагааны давхцалаас зайлсхийх, бизнесийн байгууллагуудад олон шалгалт үзлэг хийж, үйл ажиллагааг нь тасалдуулах явдлыг бууруулах зорилгоор эдгээр агентлагуудыг нэгтгэсэн юм.

Дээрх яамд, агентлагуудаас гадна, аймаг, сумдын засаг захиргаа нь уул уурхайн салбарын асуудалд өөрсдийн эрх үүргийн дагуу оролцдог. Жишээ нь, аймгийн байгаль орчны байцаагч нарыг МХЕГ болон БОНХЯ томилдог бөгөөд аймгийнхаа Засаг даргатай хөдөлмөр эрхлэлтийн гэрээ байгуулдаг.

Уул уурхайн салбартай холбоотой асуудлууд хэд хэдэн байгууллагуудын эрх үүргийн хүрээнд зохицуулагдаж байгаа нь дээрх газруудын хооронд ажил үүргийн давхцал болон тодорхойгүй байдал үүсгэхээр байна. Энэ байдлыг Бүлэг 2.5.3-д илүү дэлгэрэнгүй авч үзнэ.

2.5.3 Уул уурхайн салбартай холбогдох байгаль орчин, нийгмийн нөлөөллийг зохицуулах хууль эрх зүй зохицуулалтын орчны тойм

Дээр дурдсан байгууллагууд нь холбогдох хууль, журам, бодлогыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хүлээдэг. Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ) болон Байгаль орчин, аялал жуулчлалын яам (одоо БОНХЯ)-ны судалгаанаас харахад байгаль орчны асуудлыг зохицуулдаг 30 гаруй хуулиуд байна (Ханнам, 2009). Дээрх судалгаагаар 1990-ээд оноос хойш байгаль орчны салбарт батлагдсан хуулиуд нь тус тусдаа бие даасан шинж чанартай байсан тул энэ нь байгаль орчны үр дүнтэй зохицуулалт, хэрэгжилтэнд саад болж байна гэж дүгнэсэн байдаг.

Уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааг зохицуулсан гол хуулиудад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012), Ашигт малтмалын тухай хууль (2006), Төрийн хяналт шалгалтын тухай хууль (2003), болон 2009 онд баталсан Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль (олон нийт "Урт нэртэй хууль" гэж нэрлэх нь бий) зэрэг орно. Энэ 4 хуулиас, урт удаан хэлэлцүүлэг явагдсаны эцэст Ашигт малтмалын тухай хууль 2014 оны 7 сарын 1-нд батлагдсан ч хараахан олон нийтэд хүргэгдээгүй байна (Блүмберг, 2014). Энэ хуулийн талаар энэ хэсэгт үргэлжлүүлэн товч тайлбарлах болно. Түүнээс гадна, "Урт нэртэй хууль"-д нэмэлт өөрчлөлт оруулах, эсвэл хүчингүй болгох талаар яригдаж байгаа ч хэзээ хийгдэх зэрэг тодорхой мэдээлэл байхгүй байна.

2.5.3.1 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль 1998 онд батлагдсан бөгөөд 2001 он болон 2006 онуудад энэ хуульд өөрчлөлт орсон байдаг. Монгол улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлийг батласан УИХ-ын 2009 оны 38-р тогтоол болон Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт⁸ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг шинэчлэх шаардлагыг багтаасан байв. 2012 оны 5 сарын 17-нд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга УИХ-аар

⁸ Монгол улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн 3.13.2-р заалтыг үзнэ үү, 2008-2012.



батлагдсан бөгөөд энэ хууль нь агуулга цар хүрээний хувьд анхны хуулиас ихээхэн өргөжсөн байна. Хуулийн хэрэгжилтийг хангах арга механизмыг сайжруулах, байгаль орчны менежментийг сайжруулах зорилгоор энэхүү хуулийн хүрээнд үнэлгээг гүйцэтгэх, үнэлгээний хүрээнд боловсруулсан баримт бичгийг мөрдөх, хянах зэрэг үнэлгээний бүхий л үе шаттай холбоотой нарийн зохицуулалтыг тусгажээ. Мөн БОНУ-тэй холбоотой журмыг сайжруулах, байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, дүйцүүлэн хамгаалал зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Энэ хууль батлагдсанаар олон нийтийн хувьд хамааралтай бий болсон нэг чухал өөрчлөлт нь нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах шаардлага бөгөөд төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс ард иргэдтэй зөвшилцөх, гарсан санал хүсэлтийг төслийн хэрэгжилтэнд тусган оруулах хуулийн үүрэгтэй болсон явдал юм. Түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас тухайн газрын нутаг дэвсгэрийн хэмжээнд ашиг олох зорилгогүйгээр ашиглагдаж байгаа түгээмэл тархацтай ашигт малтмал олборлохтой холбоотой үнэлгээг хариуцах бол бусад уул уурхайн төслийн байгаль орчны үнэлгээг БОНХЯ хариуцахаар өөрчилсөн байна.

Азийн хөгжлийн банк, НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр дээрх хуулийн хэрэгжилтийг хангах дараах журам, аргачлалыг Засгийн газраас батлаад байна. Үүнд:

- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам (Засгийн газрын 2013 оны 11 сарын 16 өдрийн 374-р тогтоолоор батлагдсан);
- Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам (Засгийн газрын 2013 оны 11 сарын 16 өдрийн 374-р тогтоолоор батлагдсан);
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам (БОНХ Сайдын 2014 оны 1-р сарын 6-ны өдрийн А-3 дугаар тушаалаар батлагдсан);
- Аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих тухай журам (Сайдын тушаал. № А-4: 2014 оны 1-р сарын 6);
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам (БОНХ сайдын 2014 оны 1-р сарын 6-ны өдрийн А-5 дугаар тушаалаар батлагдсан);
- Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний аргачлал (БОНХ-ийн сайдын 2014 оны 1-р сарын 10-ны өдрийн А-11 дугаар тушаалаар батлагдсан);
- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал (БОНХ-ийн сайдын 2014 оны 1-р сарын 10-ны өдрийн А-11 дугаар тушаалаар батлагдсан).

2.5.3.2 Ашигт малтмалын тухай хууль (2006)

Энэ хуулиар ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, нөхөн сэргээлт, хаалтын үйл ажиллагааг зохицуулагддаг. Хайгуулийн тусгай зөвшөөрлийг авахын тулд, уул уурхайн компаниуд нь АМГ-т хүсэлт гаргадаг. Улмаар АМГ нь тухайн газрын Засаг дарга, аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд дээрх хүсэлтийг явуулж, саналыг нь авдаг. Энэ үйл явцын дагуу хайгуулын лицензийн хүсэлт ерөнхийдөө шийдэгддэг. Хэрвээ тухайн уул уурхайн компани нь хайгуулын тусгай зөвшөөрлөө ашиглалтын тусгай зөвшөөрөл болгохыг хүсэж байгаа бол байгаль орчны нарийвчилсан үнэлгээ болон байгаль менежментийн төлөвлөгөөг боловсруулж



өгөх ёстой. Энэ үйл явцад иргэдийн бүрэн оролцоог хангасан байх ёстой ч бодит байдалд өөр өөрөөр хэрэгжих нь бий.

Энэ хуулиар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх ёстой бөгөөд үүнд байгаль орчныг хөндөх явдлыг бууруулах, бохирдлыг хянах, шинээр үүссэн зам зэрэг хайгуулын үйл ажиллагаанд хөндөгдсөн газрыг нөхөн сэргээх арга хэмжээг заавал тусган оруулах ёстой. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэн БОМТ-г бэлтгэх үүрэг хүлээдэг. БОНУ нь уул уурхайгаас газар, ус, агаар, ургамал, амьтан, хүнд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг тодруулж, эдгээр тодруулсан нөлөөллөөс зайлсхийх болон бууруулах арга хэмжээг багтаах ёстой байна. БОМТ нь байгаль орчны нөлөөллийн менежмент, байгаль орчныг хамгаалахад зориулах төсвийг дараахь чиглэлүүдээр гаргасан байх шаардлагатай. Үүнд:

- Аюултай бодис, материалын хяналт (тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт, зайлуулалт);
- Гадаргын болон газрын доорх усны ашиглалт ба хамгаалалт;
- Хаягдлын далан барих, ашиглах, аюулгүй ажиллуулах зардал;
- Тухайн төслийн үйл ажиллагааны онцлогт тохирсон бусад арга хэмжээ (агаарын чанар болон биологийн олон янз байдлыг хамгаалах г.м.);
- Ашигласан газрыг аюулгүй, ашиглалтын нөхцөл хангахуйц төлөв байдалд хүргэх нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны зардал.

Ашигт малтмалын тухай хуулийн 39, 40-р заалтад тусгагдсан БОНУ-ий талаарх заалтууд нь Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хуулийн олон заалттай давхцаж байгааг дурдах нь зүйтэй. Ийм давхцал гарсан тохиолдолд хамгийн сүүлд батлагдсан хуулийг нь давууд авч үздэг хууль зүйн ойлголтоор бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг давуу байдлаар мөрдөх ёстой гэсэн үг юм. Дээр нь, Ашигт малтмалын тухай хуулиар, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн БОНУ-г хянах үүрэг хариуцлагыг хүлээсэн төрийн байгууллага нь Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хуулинд тусгасан БОНУ-г хянадаг байгаль орчны төрийн захиргааны төв байгууллага байна гэж тодорхой заасан боловч бодит байдал дээр, уул уурхайн төслүүд дээр авч үзэхэд нэг их ялгаа байхгүй байна.

Ашигт малтмалын тухай хууль нь байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн асуудлыг зохицуулдаг. Ашигт малтмалын тухай хуулийн 39.1.9-д заагдсанаар уул уурхайн лиценз эзэмшигчид нь нөхөн сэргээлтийн ажлын баталгаа болгож тодорхой хөрөнгийг БОНХЯ-ны нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулдаг. Энд байршуулсан мөнгийг хэрхэн ашиглах, зарцуулах талаарх журмыг Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хуулийг дагалдан гарсан журманд тодорхой зааж өгсөн байна⁹.

⁹ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих (Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаал, А-04, 2014.01.06).



2.5.3.3 Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль (2009)

Уул уурхайн салбар хурдацтай хөгжиж эхэлсэн үеэс эхлэн уурхайн байгаль орчны асуудал орхигдож байгааг байгаль орчны бүлгүүд болон нөлөөлөлд өртөгсдийн зүгээс хөндсөөр иржээ. Уул уурхайн байгаль орчны асуудлаар үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын шахалт нь Урт нэртэй хууль хэмээн нэрлэгддэг Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг 2009 онд батлах үндэслэл болсон байдаг. Энэхүү шинэ хуулиар гол мөрний бүрэлдэх эх, голын дагуух эмзэг экосистем болон хамгаалалттай ойн сан бүхий газруудад үйл ажиллагаа явуулж байсан уул уурхайн үйл ажиллагааг цуцалж, эсвэл зогсоосон юм. Дээрх уурхайн лицензүүдийг цуцалсан хэдий ч компаниудыг байгаль орчны нөхөн сэргээлт хийх үүргээс нь чөлөөлөөгүй бөгөөд лиценз нь цуцлагдсан компаниудад нөхөн төлбөр олгох асуудал стратегийн бус ордуудад тодорхой бус байсаар байна (Австралийн Гадаад хэрэг, худалдааны газар, 2014). Энэ тайланг боловсруулж байх үед энэ хуулийг хэрхэн хэрэгжүүлэх арга замуудыг эргэн нягтлан үзэж байгаа гэсэн мэдээлэл байв¹⁰.

2.5.3.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008)

2008 оны энэ хуулиар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлууд зохицуулагддаг бөгөөд Хөдөлмөрийн яамны эрхлэх ажлын хүрээнд байдаг. Энэ хууль нь уул уурхайг оролцуулан бүх салбарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хамаардаг. Энэ хуулийг шинэчлэх асуудал олон талуудын оролцоотойгоор хийгдэж байна (Батчер ба Смит, 2013).

2.5.3.5 Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого (2014) ба Ашигт малтмалын тухай хуулийн өөрчлөлт

Төрөөс уул уурхайн салбарт баримтлах бодлоготой холбоотой маргаан сүүлийн 4-5 жилүүдэд гарсаар байна. Байгалийн баялгийн өмчлөл дэх гадаадын болон үндэсний оролцогсдын зөв харьцаа, байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн салбарын эрх зүйн зохицуулалтууд, Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэх зэрэг нь анхаарал татсан асуудлууд байв.

1997 онд батлагдаж 2006 шинэчлэгдсэн Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн боловсруулах үйл явц 2010 эхэлсэн бөгөөд тухайн үеийн Ашигт малтмалын хэрэг эрхлэх газарт байгуулагдсан ажлын хэсэг 2011 онд Ерөнхийлөгчийн тамгын газарт шилжсэн байна. 2012 оны сүүлээр Ерөнхийлөгчийн тамгын газраас дээрх хуулийн шинэчилсэн төслийг олон нийтэд танилцуулсан бөгөөд дараах гол өөрчлөлтүүд тусгагдсан байв. Үүнд:

- Стратегийн ашигт малтмал гэсэн шинэ нэр томъёоллыг оруулсан ба үүнд ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхит материал, газрын ховор элемент орсон байна;
- Одоогийн хэрэглэгдэж байгаа уул уурхайн хоёр төрөл (хайгуул, ашиглалт)-ийн тусгай зөвшөөрлийг 4 төрөл (эрэл, хайгуул, ашиглалт, боловсруулалт)-ийн зөвшөөрөл болгон лиценз эзэмшигчдийн эрх үүргийн хязгаарлалтыг зааж өгөх;

¹⁰ Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2014 оны 7 сарын 2-нд Улсын Их Хурлаар батлуулаад байна. Энэхүү тайланг бэлтгэж байх хугацаанд тус хуулийн шинэчилсэн найруулга албажаагүй байсан ч 4 жилээр зогсоосон байсан хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох асуудал, "Урт нэртэй хууль"-ийн дагуу цуцлагдсан тусгай зөвшөөрлүүдийг тухайн тохиолдлоос нь хамааруулан дахин зөвшилцөх зэрэг нэмэлт өөрчлөлтүүд тусгагдсан байв.



- Одоогийн мөрдөгдөж байгаа лицензийг өргөдөл авсан дарааллаар нь олгодог системийг өөрчилж өрсөлдөөнт тендерийн журмаар олгодог болох;
- Дотоодын аж ахуйн нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэх;
- Байгаль орныг хамгаалах, уурхайн хаалт, олон нийттэй болон орон нутгийн захиргаатай хийх зөвшилцөл, орон нутгийн шаардлага, албан даатгалын бодлого, байгалийн баялгийг сорчлон ашиглахыг хориглох (Австралийн Гадаад хэрэг, худалдааны газар, 2014).

Энэхүү хуулийн төслийг нийтээр хэлэлцэн санал авсаны үр дүнд хуулийн төслийн чиглэл болон агуулга нь тодорхойгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Ингэснээр, дээрх хуулийн төслийг түр хойшлуулж, шинэтгэлийн асуудлыг нэмэлт судалгааны ажилд үндэслэн ул суурьтай хийх нь зүйтэй гэсэн ерөнхий зөвшилцөлд хүрсэн гэж болно. Хуулийн шинэтгэлд нухацтай авч үзэх шаардлагатай төрийн оролцоо, тусгай зөвшөөрөл, стратегийн ашигт малтмал, олон нийтийн оролцоо болон байгаль орчны нөлөөллийг бууруулах зэрэг асуудлууд байв.

Дээрх асуудлуудыг шийдвэрлэхээр Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого боловсруулах ажлын хэсэг 2013 онд Уул уурхайн яаманд байгуулагдан ажилласнаар 2014 оны 1 сард УИХ-аас Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг баталсан байна. Энэхүү бодлого нь төрөөс энэ салбарт баримтлах тодорхой зарчмууд болон чиглэлүүдийг агуулсан ба Ашигт малтмалын хуулийн цаашдын шинэчлэлийг тодорхойлох суурь болох юм¹¹.

2.5.4 Хууль эрх зүйн зохицуулалтын болон институцийн орчны үнэлгээ

Гол талуудтай хийсэн ярилцлага болон байгаль орчны засаглалын тогтолцооны талаар сүүлийн үед хийсэн судалгаанаас харахад уул уурхайн байгаль орчны болон нийгмийн асуудлаарх эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа бөгөөд энэ нь салбарын урт хугацааны тогтвортой хөгжилд саад болохоор байна. Тухайлбал, өөр өөр түвшний төрийн байгууллагуудын үүрэг хариуцлага, хууль журмын хэрэгжилтийг хангахад БОНХЯ-ны үүрэг, байгаль орчны байцаагч нарын харьяаллын асуудал, эрүүл ахуй, аюулгүй байдал, байгаль орчны үйл ажиллагааны үүрэг хариуцлагын талаарх ойлголт, дүрэм, журмын хэрэгжилт, нийгмийн нөлөөллийн үүрэг хариуцлагын тодорхойгүй байдал болоод байгаль орчны мэдээллийн сангийн хангалтгүй байдал орно.

Ихэнх орнуудын жишгээр байгаль орчны менежментийн асуудал өөр өөр түвшний төрийн байгууллагуудын үүрэг хариуцлагад хуваарилагдсан байдаг ч сум, аймаг, болон төрийн захиргааны төв байгууллагуудын хоорондын үүрэг хариуцлагын уялдаа, зааг ялгааг тодорхой болгох шаардлагатай гэдгийг холбогдох талууд илэрхийлдэг.

Байгаль орчны хууль журмын хэрэгжилтийг хангахад БОНХЯ-ны үүрэг хариуцлагын асуудал мөн хөндөгдөж байна. БОНХЯ нь байгаль орчны менежменттэй холбоотой дүрэм, журмыг боловсруулж гаргадаг ч тэдгээрийн хэрэгжилтийг хянах бие даасан арга хэрэгсэл байдаггүй. Жишээ нь, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмаар төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулдаг бөгөөд уг төлөвлөгөөнд хог хаягдал, бохирдол, нөхөн сэргээлт зэрэг асуудлууд зайлшгүй ордог ч эдгээрийн хэрэгжилт ямар

¹¹ Өмнөх буюу 11-р зүүлтэд орсон тайлбартай адил.



байгааг хянах хүн хүчний бололцоо БОНХЯ-д байхгүй бөгөөд МХЕГ-ын хяналт, аймаг, сумдаас гаргасан байгаль орчны тайлангуудад найдах хэрэгтэй болдог. МХЕГ-ын байцаагч нарын тоо хангалттай бус, аймаг, сумдад байгаа ажилтнууд байгаль орчны менежментийн хяналт шинжилгээг явуулах талаар тэр бүр хангалттай түвшинд сургагдаж, бэлтгэгдээгүй байдаг зэргийг бодолцвол төслүүд байгаль орчны хууль журмыг хэрэгжүүлж буй эсэхийг хянахад хийдэл үүсгэхээр байна.

Дээрхтэй холбоотой өөр нэг асуудал бол байгаль орчны байцаагч нарын харьяаллын асуудал байна. Одоогийн тогтолцоогоор МХЕГ нь хяналтыг хэрэгжүүлэх гол төрийн байгууллага байгаа хэдий ч сүүлийн үед уул уурхайн хяналтын асуудлыг АМГ-т шилжүүлэх талаар яриа хэлэлцээ нилээд гарч байгаа юм. Хэрэв уул уурхайн хяналт шалгалтыг АМГ-т шилжүүлвэл дээрх газрууд болон БОНХЯ-ны хооронд үйл ажиллагааны давхцал, алдагдал гарч болзошгүй юм.

МХЕГ нь 2011 оноос эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хяналт шинжилгээг явуулах үйл ажиллагааны журмыг¹² нэвтрүүлээд байна. Уг журам нэвтэрснээр өмнө нь дутагдаж байсан хяналт, үнэлгээ явуулахад ашиглах нэгдсэн шалгуур үзүүлэлт бий болсон ч энэхүү журам, зааврыг хэрэгжүүлэх асуудлаар улсын байцаагчдын чадавхийг бэхжүүлэх, хяналт шалгалтын үр дүнг биелүүлэх, хэрэгжүүлэх асуудалд хүндрэл байсаар байгаа юм. Байцаагчдыг ажил үүргийн холбогдолтой сургалтанд хамруулах асуудал хангалтгүй байна. Түүнчлэн, БОНХЯ болон УУЯ нь байгаль орчны асуудлыг зохицуулах туршлагатай ч гарч буй зөрчлийн талаар эдгээр яамдад эргэн мэдэгдэж зөрчлийг бууруулах механизм бүрхэг, мөн үйл ажиллагааны хяналт, хэрэгжилт, гүйцэтгэлийн талаарх байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог зохицуулсан журам, зааварчилгаа байхгүй байна.

Энэ бүлгийн өмнөх хэсэгт дурдсанчлан¹³, мөн төслийн судалгаанд оролцогсдын илэрхийлж байсан нэг зүйл бол бодлого шийдвэр гаргахад суурь болох байгаль орчин, нийгмийн мэдээллийн нэгдсэн сангийн асуудал байлаа. Одоогийн байгаа мэдээллийн сангууд нь өөр өөр газарт байрласан тогтмол шинэчлэл хийгдэдгүй гар ажиллагаа ихтэй сангууд байна. Шаардлагатай мэдээлэлд (эрх зүй, үйлдвэрлэл, орлого г. м.) тулгуурлаагүй хийгдсэн эрх зүйн зохицуулалтаар сайн үр дүнд хүрэхэд бэхшээлтэй юм.

Хууль эрх зүйн болон институцийн өнөөгийн байдалд хийсэн энэхүү товч судалгаанаас гарсан бодлогын хувьд цоорхойтой байж болох зүйлүүдийг уул уурхайн салбарын цаашдын хөгжлийн хувилбаруудыг авч үзсэн 4, 5, 6-р бүлгүүдэд орууллаа.

2.6 НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.6.1 Байгаль орчны нөхцөл байдал

Усны нөөцийн ашиглалт: Уул уурхайн үйл ажиллагаанд ус ихээр шаардагддагаас энэ төрлийн төслүүдийг Монголд хэрэгжүүлэхэд, ялангуяа усны нөөцөөр хомс өмнийн говь нутагт, усны асуудал хурцаар тавигдаж байна. Уул уурхайн үйл ажиллагаа нь усны хэмжээ ба чанарын хууд

¹² МХЕГ-ын заавал дагаж мөрдөх эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт, хяналт шалгалтын хуудас, түүнийг ашиглах зааварчилгаа зэргийн талаар дурдаж байгаа болно.

¹³ Батчер ба Смит (2013), Австралийн Гадаад харилцаа, худалдааны газар (DFAT) (2014), НҮБХХ, Уул уурхайн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам (2012), Тортель, Боржигдхан, Найдансүрэн (2008), Ханнам (2009).




нөлөөлдөг. Хоцрогдсон технологи бүхий уул уурхайн үйл ажиллагаа, жишээ нь алтны шороон ордын олборлолт нь усыг үр ашиггүй ашигладгаас гадна их хэмжээний бохирдол үүсгэдэг (Дэлхийн банк, 2006). Өнөөдрийн байдлаар Монгол орны уул уурхайн томоохон төслүүд нь тус орны өмнөд хэсэгт төвлөрч тэжээгдэлгүй гүний усыг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Түүнчлэн уул уурхайгаас болж усны хомсдол үүснэ гэсэн түгшүүр олон нийтийн дунд, нэн ялангуяа говь нутгийн ард иргэдийн дунд бий болсноос уурхайн төслүүдэд дургүйцэх, эсэргүүцэх хандлага мөн ажиглагдаж байна (Дэлхийн банк, 2010).

Гидрологийн нөхцлийг өөрчлөх: Уул уурхайн үйлдвэрлэлээс усны нөөцөд үзүүлэх дарамт өөр өөр хэлбэрээр илэрч болно. Газрыг хөндсөнөөр гадаргын болон гүний усны урсгал тасрах зэргээр усны нөөцөд нөлөөлөл үзүүлэх бөгөөд уул уурхайн үйлдвэрлэл нь ашигт малтмал боловсруулах болон тоос дарахын тулд ихээхэн ус хэрэглэдэг ба хур тунадасны хэмжээ бага, усны ууршилтын хэмжээ ихтэй бол асуудлыг улам хүндрүүлдэг. Усны хэрэгцээ нь зөвхөн үйлдвэрлэлийн хэрэгцээгээр хязгаарлагддаггүй бөгөөд уурхайн ажиллагсад, уурхайн хөгжлийг даган нэмэгдэх хүн амын өсөлт, түүнчлэн энэхүү салбарыг даган шинээр бий болох эдийн засгийн бусад үйл ажиллагаа нь бүгд ус хэрэглэж энэ хэмжээгээрээ усны нөөцөд дарамт үүсгэдэг байна.

Ус нь уул уурхайн үйлдвэрлэлийн чухал нөөц болохын хувьд усны дутагдалтай байдал нь энэ салбарын хөгжлийг хязгаарлагч хүчин зүйл болдог. Энэ байдал нь усны нөөцийг тэтгэх хур тунадас дутагдалтай эх газрын уур амьсгал бүхий Монгол орны хувьд илүү асуудалтай байхаар байна. Монгол орны гадаргын усны нөөцийн ихэнх нь тус орны хойд хэсэгт байдаг бол уурхайн төслүүдийн ихэнх нь гадаргын усны нөөцөөр маш хомс өмнөд бүсэд байгаа нь мөн үүнд нөлөөлж байна.

Монгол орны өмнөд бүс нутагт гүний усыг уул уурхайд ашиглах нь дараах шалтгааны улмаас өөр бусад ус хэрэглэгч уламжлалт талуудтай зөрчилд хүргэж болох юм. Үүнд: уул уурхайн үйл ажиллагаанд ихээхэн хэмжээний ус шаардлагатай, гүний усны нөөцийн талаар ойлголт, мэдлэгийн хангалтгүй байдал, усны нөөцийн төлөвлөлтийн талаарх зохицуулалтын арга механизм учир дутагдалтай байдал зэрэг асуудлууд орно. Уул уурхайд ашиглаж байгаа газрын доорх усыг байгалийн нөхөн сэргэлт муутай буюу байхгүй уст давхаргаас ашиглаж байгаа усыг зохистой ашиглах нь чухал асуудал юм (Acacia Water, 2009). Усны тогтворгүй ашиглалт болон уул уурхайн үйл ажиллагаанаас гидрологийн нөхцөлд үзүүлэх нөлөөлөл нь уламжлалт мал аж ахуй болон биологийн олон янз байдалд шаардлагатай усанд нөлөөлдөг (Дэлхийн банк, 2010).




Зураг 2.3 Газрын доорх усны ашиглалтын баримжаат нөөц

Усны түвшин буурах, малчдын худаг усны хүртээмж: Монгол орны өмнөд бүсийн уул уурхайн ус ашиглалт, ил болон далд уул уурхайн бүтээн байгуулалт нь энэ бүс нутагт усны нөөцийг бууруулах, ялангуяа, бага гүний уст давхаргуудын усны түвшинд нөлөөлж болзошгүй. Малчид гар аргаар гаргасан бага гүнтэй худгийг, эсхүл булаг шанд зэрэг ил задгай усыг ундны болон малын усан хангамждаа ихэнхдээ ашигладаг. Монгол орны хуурай бүс нутгийн ард иргэдийн болон байгаль орчны (ан амьтад, ургамал ногоо) усны хэрэгцээг хангагч байгалийн усны эх үүсвэрүүд нь гангийн нөлөөлөлд өртөмтгий байдаг.


Уурхайн хэрэгцээнд ус авч ашиглаж буй их гүний уст давхарга болон бага гүний уст давхаргын хооронд гидрогеологийн холбоо маш бага, эсвэл бүр холбоогүй байдаг ч их гүний уст давхаргаас уурхайн хэрэгцээнд ус ашиглах нь малчдын худаг тэжээгддэг бага гүний уст давхаргад нөлөөлөл үзүүлнэ гэсэн ойлголт өргөн тархсан байдаг. Иймд, их гүний уст давхаргаас ашиглаж буй усны хэрэглээг удаан хугацаанд хянах шаардлагатай ба ингэснээр бага гүний уст давхаргад үзүүлж буй нөлөөлөл, уст давхарга хоорондын холбоог тогтоож болно.

Гидрологийн эмзэг нөхцөлтэй газраас үйлдвэрлэлийн болон уул уурхайн зорилгоор их хэмжээний ус ашиглах нь гидрологийн нөхцөл, малчид, орон нутгийн иргэдийн усан хангамж, мөн бүс нутгийн биологийн олон янз байдалд асуудал үүсгэж болзошгүй юм. Үүнийг Дорноговь аймгийн малчдын худгийн ихэнх нь уурхайн лицензит талбайд байгаагаас нөлөөлөлд өртөж байгаа доорх Зураг 2.4-аас харж болно.



Зураг 2.4 Малчдын худаг болон лицензийн талбай, Дорноговь аймаг

Тусгай хамгаалалттай газар нутаг: Улсын хэмжээнд, газар ашиглалттай холбоотой байгаль орчны асуудлууд гарч байна. Уул уурхай болон уурхайтай холбоотой бусад үйл ажиллагаанаас тусгай хамгаалалттай газар, мөн биологийн олон янз байдлын амьдрах орчинд дараах нөлөөллийг үзүүлж болно. Үүнд: уурхайн барилга байгууламж барьснаас амьдрах орчин алдагдах буюу доройтох, хамгаалалттай газрын хамгаалалтын статусыг өөрчлөхтэй холбоотой менежментийн зөрчилтэй асуудлууд үүсэх, уурхайн тээврийн дэд бүтэц барьснаар төрөл зүйлийн амьдрах орчин таслагдаж хуваагдах, усны нөөцөд нөлөөлөх, байгаль орчны бохирдол үүсгэх зэрэг байна. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ өргөжиж, нийт нутаг дэвсгэрийн бараг 18 хувийг хамрах болсон билээ. Хамгаалалттай газрын төрлүүд болох олон улсын хэмжээнд хамгаалагдсан газар нутаг, улсын тусгай хамгаалалттай газар нутаг, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг, улсын тусгай хэрэгцээний газар, хамгаалалтанд авахаар санал болгож байгаа газар нутгуудыг Зураг 2.5-д үзүүлэв. Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ нэмэгдсэн хэдий ч эдгээр газруудад биологийн олон янз байдал, амьдрах орчныг хамгаалах чадавхи, нөөц боломж зохих ёсоор нэмэгдээгүй болно. 2009 онд Монгол улсын Засгийн газар Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг баталсан бөгөөд энэ хуулиар усны эх үүсвэр, ойн сангаас 200 метрийн зайд олгогдсон байсан 200 гаруй уул уурхайн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байдаг. Энэ зохицуулалтын хүрээнд зарим тусгай хамгаалалттай газрын ангиллыг өөрчлөн уул уурхайн зорилгоор ашиглах боломжтой болгох санал гарч байгаа юм (2.5.3.3 Хэсгийг үзнэ үү).



Зураг 2.5 Хамгаалалттай болон хамгаалалтанд авахаар санал болгож буй газрууд


Газрын болон хөрсний чанар муудаж, доройтох: Уурхайн үйл ажиллагааны үед жишээ нь ил уурхай байгуулах, үйлдвэрлэлийн болон тээврийн дэд бүтэц барих, их хэмжээний талбайд газар хөндөх болдог. Ил уурхай нь том хэмжээний хоосон орон зай үүсгэхээс гадна хаягдал чулуулгийн овоолго, хаягдал усны сан байгуулснаар газрын гадаргыг их хэмжээгээр өөрчилдөг. Хөрс хуулалт болон хаягдал чулуулгийг зайлуулахад том хэмжээний ухмал нүх, овоолго үүсэх ба энэ нь газрын гадаргыг үзэгдэх байдлын болон бүтцийн хувьд өөрчилдөг (BirdLife Asia, 2009). Ингэж өөрчлөгдсөн газар нь салхи, усны нөлөөгөөр элэгдэлд орох нь хялбар болж, ингэснээр гадаргын ус тунадасаар бохирдох, хөрсний бохирдол үүсэх, тухайн газрын амьдрах орчин муудах, ургамлын ургалт муудах зэрэг явцыг үүсгэдэг. Далд уурхайн олборлолт, гүний усыг их хэмжээгээр хяналтгүйгээр соруулан ашиглах зэргээс шалтгаалж, газрын гадаргад суулт үүсэж, цөмөрч болох бөгөөд энэ нь газрын гадаргын бүтэц, гадаргын усны урсац, гүний усны чиглэлийг өөрчилж, хүн малын аюулгүй байдал, эрүүл мэндэд эрсдэл учруулж болно (BirdLife Asia, 2009). Хаягдал чулуулгийн овоолго болон хаягдлын сангаас гарч болох хүчиллэг урсац нь Монголд буй дундээс дээш хэмжээтэй уурхайнуудын хувь байгаль орчны эрсдэл үүсгэх хүчин зүйл болдог (Дэлхийн банк 2006). Менежментийн сайн төлөвлөгөө хэрэгжүүлэхгүй бол энэ урсац нь хөрс, усны ноцтой бохирдол үүсгэх бөгөөд энэ нь эдийн засаг болоод биологийн олон янз байдалд сөрөг нөлөө үзүүлэн алдагдалд хүргэж болно.

Уурхайн болон тээврийн хэрэгсэл бусад дэд бүтцийн улмаас газрын хөрс эвдрэн өнгөс газрын хөрс эвтоос босох, цаашлаад тоосны тархалт нь ургамлын бүрхэвчид сөргөөр нөлөөлж болзошгүй байдаг. Ургамалан бүрхэвч нь хөрсний өнгөн хөрсийг хамгаалах үүрэгтэй байдаг бөгөөд энэхүү бүрхэвч доройтсоноор тухайн газар хөрсний элэгдэлд өртөх байдал нь улам эмзэг болдог. Монгол улсын хэмжээнд одоогийн байдлаар бэлчээрийн 70-80% нь доройтсон гэсэн



үздэг. Үүнд нөлөөлсөн гол хүчин зүйлийг 1990-ээд оны шилжилтийн үед бэлчээрийн менежмент улсын хяналтаас гарч нийтээр ашиглах нөөц болсон, түүнчлэн мал сүргийн тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор үүссэнрбэлчээрийн даац хэтрэлт гэж үздэг (Швейцарийн хөгжлийн агентлаг, 2014). Мал сүргийн тоо ихэссэнээс бэлчээрийн даац хэтрэх шалтгаантай харьцуулахад уул уурхайн үйл ажиллагаанаас бэлчээрт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь орон нутагт хурцаар яригддаг асуудал юм.

Газар ашиглалт өөрчлөгдөж, биологийн төрөл зүйлийн үржил шим буурах: Монголд уул уурхайн салбарыг хөгжүүлэх нь холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг шаардах ба энэ нь газар ашиглалтын хувьд үржил шимт бэлчээрийн газрыг үйлдвэрлэлийн хэрэгцээний газарт шилжүүлэхэд хүргэдэг. Уурхайн дэд бүтцийн барилга байгууламж, зам, цахилгаан дамжуулах шугам болон шугам хоолой тавихад хөрсний шимт давхаргыг хөндөж, байгалийн тогтоцыг өөрчилдөг ба ингэснээр биологийн олон янз байдлын амьдрах орчныг өөрчлөн сүйтгэх болдог (Дэлхийн банк, 2009). Ургамлын бүрхэвч муудах, алдагдах, бэлчээргүй болох, хөрсний элэгдэл эвдрэл, тоос бий болгох, амьдрах орчин хөндөгдөх, хог хаягдлын болон хортой материалын бохирдол зэрэг нь газрын бүтээмжийн бууралтыг бий болгодог (Азийн сан, 2010). Доор үзүүлсэн зурагт (2.6) газар ашиглалтын зөрчил Монголд ямар байгааг одоо байгаа уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь малын бэлчээр, аялал жуулчлалын кэмгийн нутаг дэвсгэртэй хэрхэн давхцаж байгаа байдлаар харууллаа.



Зураг 2.6 Газар ашиглалтын байдал

Агаарын чанар муудах: Агаар бохирдох үндсэн шалтгааныг газрын хөрснөөс дэгдсэн тоос агаарт бөөгнөрснөөс үүсдэг хэмээн үздэг. Агаарын чанарыг доройтуулж буй хамгийн гол зүйл нь Монголд өрнөж байгаа уул уурхайн үйл ажиллагаа бөгөөд үндсэндээ хучилтгүй замаар уурхайн тээвэрлэлт хийж буй уурхайн машин механизмуудын хөдөлгөөнөөс үүссэн тоосжилтын нөлөөлөлтэй холбоотой. Тэдгээр нөлөөлөлд түүнчлэн хүн амын эрүүл мэнд, хөрс талхлагдаж



ургамлын гарц тарчиг болох болон малын эрүүл мэнд хамаарч байгаа юм. Агаарын бохирдол нь уул уурхайн салбарын ажлын байрны эрүүл мэндийн томоохон асуудал болно. Монгол улсын хүн ам өсөж хотжилт, үйлдвэржилт хурдацтай явагдаж байгаагаас Улаанбаатар хот дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой хотуудын нэг болсон байна (ДЭМБ, 2014). Дээр нь цаг агаарын эрс тэс нөхцөл, олон сараар үргэлжлэх хүйтэн өвөл зэргээс шалтгаалж гэр орноо халаах болон хоол үнд хийхэд гал түлдэг бөгөөд энэ нь агааржуулалт муутай гэр орчинд агаарын бохирдол үүсгэснээр хот суурин газрын ядуу хүмүүс, хүүхэд эмэгтэйчүүд зэрэг эмзэг бүлгийнхэн амьсгалын замын өвчин эмгэгтэй болох эрсдлүүд бий болгож байна.

Агаарын чанарыг тоос болон үйлдвэрлэлийн үед ялгарах бохирдуулагч бодисууд муутгадаг. Тоос нь том жижиг гэлтгүй бүх төрлийн уурхайн үйл ажиллагааны үед, мөн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, үйлдвэрлэлийн машин техникийн үйл ажиллагаа, тэсэлгээний үед болон салхины улмаас элэгдсэн газруудаас үүсэж байна. Уурхай дахь бусад үйл ажиллагааны улмаас, тухайлбал хүдэр бутлах процесс, машин техникийн хөдөлгүүрээс гарах хаягдал хий, хаягдлын сан болон хог хаягдлын овоолго зэргээс ялгарах төрөл бүрийн хий нь агаарын чанарт мөн нөлөөлдөг (Азийн сан, 2010). Ил уурхайн үйл ажиллагаагаар өнгөн хөрс хуулагдаж доор нь байсан чулуулаг ил агаарт гардаг бөгөөд энэ нь салхины элэгдэлд орж хийссэнээр зөвхөн үзэгдэх орчинд нөлөөлөх төдийгүй чулуулагт агуулагдаж байсан хүн, малын эрүүл мэндэд хортой байж болзошгүй хүн металл агуулсан нарийн ширхэгт тоосонцор салхины аясаар тархах нөхцлийг бүрдүүлдэг. Дээр нь, харагдах орчныг бууруулдаг. Уул уурхайн үйл ажиллагаанд нүүрсээр болон дизель түлшээр ажилладаг янз бүрийн хэмжээтэй цахилгаан станцууд шаардлагатай байдаг бөгөөд эдгээр нь агаар бохирдуулагч утаа, хий, дэгдэмхий үнс, тоос зэргийг ялгаруулж агаарын чанарт нөлөөлдөг (Дэлхийн банк, 2010).

Уул уурхайн компаниудын байгаль орчны менежмент: Монгол улсын байгаль орчны хууль журмаар уул уурхайн тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг явуулах ёстой байдаг. Тоо баримтаас харахад байгаль орчныг хамгаалах арга хэмжээ нь ерөнхийдөө хангалтгүй байдаг байна. Засгийн газраас 2010-2011 оны хооронд хийсэн хяналт шалгалтаар, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 47% нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хангалтгүй хэрэгжүүлсэн, 68% нь байгаль орчны мониторингийн хөтөлбөрийг хангалтгүй хэрэгжүүлсэн байна (Оюун, 2012). Эдгээр төлөвлөгөө болон хөтөлбөр нь байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийг бууруулах, хянах, улмаар зөв зохистойгоор хэрэгжүүлэх үйл ажиллагааны хуулийн үндсэн арга хэрэгсэл юм. Дээрх үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь уул уурхайн үйл ажиллагаа нэмэгдэж байгаатай холбогдуулан байгаль орчныг зохистой байдлаар хамгаалах бодлогын шинэчлэлийг хийн хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Хэдийгээр өнгөрсөн 10 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн хариуцлагатай уул уурхайн санаачилга нь уул уурхайн салбарт байгаль орчны сайн туршлагын талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд зарим талаар амжилтанд хүрсэн ч уул уурхайн байгаль орчны менежментэд олон улсын шилдэг тэргүүний туршлагыг хэрэгжүүлэх чадавхи Монгол улсын уул уурхайн салбарын хувьд ихээхэн хязгаарлагдмал байна. Энэ салбарт гадаадын хөрөнгө оруулалт ихээр орж ирснээр олон улсын сайн туршлага нэвтэрч байгааг салбарын "стандарт үйл ажиллагаа" болгох хэрэгтэй байна. Байгаль орчны сайн менежментийн талаарх мэдлэг, ойлголт уул уурхайн салбарын мэргэжилтнүүдийн дунд ерөнхийдөө тааруухан, байгаль орчны мэргэжлийн боловсон хүчин ажиллуулдаггүй байдал түгээмэл байна.



Уурхай байгуулж ашиглахад шаардагдахаас их хэмжээний газрыг эвддэг, их хэмжээний тоос гаргадаг, хог хаягдлын муу менежмент, хаягдал усыг хяналтгүйгээр асгадаг, аюултай химийн бодис болон нүүрстөрөгчийн нэгдлүүдээр газрыг их хэмжээгээр бохирдуулдаг, уурхайн хүчиллэг урсац, уурхайн хаягдлаас хяналтгүй гарч байгаа шүүрэл, хаягдлын сангаас хяналтгүй гарах тоос, газрын нөхөн сэргээлт байхгүй эсвэл хангалтгүй байдаг зэрэг нь уул уурхайн байгаль орчны менежментийн тааруу байдлыг илтгэх нийтлэг асуудлууд юм.

Байгаль орчны зохицуулалт: Уул уурхайн технологийн болон уурхайн нөлөөллийн талаар ойлголт бага, уул уурхайн байгаль орчны менежментийн талаарх туршлага дутмаг байдаг зэргээс байгаль орчны хууль журмын хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй бүх шатны байцаагчдын чадвар хязгаарлагдмал байдалтай байна. Энэ байдал нь уул уурхайн үйл ажиллагаа түгээмэл бус, эсвэл томоохон хэмжээний уурхай байхгүй алслагдсан бүс нутгуудад энэ байдал илүү ажигдагддаг. Цаашилбал, төрийн хоёр агентлаг тус бүрийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагын зааг ялгаа нь тодорхойгүйгээс зохицуулалтыг үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлэхэд саад тотгор болдог, хоёр агентлаг ижил төрлийн үүрэг хариуцлагыг гүйцэтгэдэг нь зохицуулалт, шийдвэрийг будлиантай, ойлгомжгүй болгох, давхардал үүсгэх эсвэл тэдгээрийг бүхэлд нь сахиулах болон гүйцэтгэлийг хянахад хүндрэл үүсгэдэг. Эдгээр бэрхшээлийг агентлагуудын ажиллагсдын тоо хангалттай бус, тэдний мэргэжлийн чадвар дутагдалтай байдал улам даамжруулах нөхцөл болдог.

Уул уурхайн компаниудын нөхөн сэргээлт: Нөхөн сэргээлт нь уул уурхайн байгаль орчны менежментийн нэг чухал асуудал байдаг. Өмнө нь ашиглаж байсан томоохон уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй нэг асуудал бол нөхөн сэргээлт хийгдэлгүй орхигдож хаягдсан, бүс нутгийн хэмжээнд нөлөө бүхий хуучин уурхайнууд байна.

Өнгөрсөн арваад жилийн хугацаанд тоо болоод хэмжээний хувьд уул уурхайн салбар ихээхэн өргөжсөн хэдий ч байгаль орчныг хамгаалах талын асуудлуудад, тухайлбал нөхөн сэргээлтэд дээрх өсөлттэй нийцсэн ахиц дэвшил гараагүй болно. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2010 онд хийсэн судалгаагаар нөхөн сэргээлт хийгдэлгүй хаягдаж орхигдсон 4 мянга орчим га газар 21 аймгийн 15 аймагт байв. Хаягдаж орхигдсон газрын 60%-ийг нь албан ёсны тусгай зөвшөөрөл эзэмшигчид, үлдсэнийг нь хууль бусаар хувиараа ашигт малтмал олборлогчид ашиглаж байжээ. Ажиллагсдын дадлага туршлага, үр чадвартай холбоотойгоор уул уурхайн зохистой нөхөн сэргээлт нь ихэнхдээ хангалтгүй байдалтай байна. Уул уурхайн нөхөн сэргээлт нь Монголд харьцангуй шинэлэг зүйл бөгөөд олон улсын шилдэг туршлагыг шууд нэвтрүүлэх нь тус орны уур амьсгалын онцлог байдалд нь тэр бүр тохирдоггүй байна. Уул уурхайн нөхөн сэргээлт хийхэд холбогдох бүх ажиллагсад, тухайлбал уурхайн инженерүүд, төрийн байгууллагын ажилтнууд, байгаль орчны компаниуд болон судалгаа шинжилгээний ажилтнуудын чадавхийг бий болгож, хөгжүүлэн мөн олон нийттэй үр дүнтэй харилцах шаардлагатай.

Биологийн олон янз байдлыг хадгалж, хамгаалах нь: Монгол улс нь Ази тивийн цэвэр онгон төрхөөрөө үлдсэн байгальтай цөөн хэдэн улсын нэг билээ. Ерөнхийдөө алслагдсан газар орон нь зам тээвэр, хүн амын суурьшил, аж үйлдвэрийн хөгжил зэрэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хөндөгдөөгүй, харин нүүдлийн мал аж ахуйн нөлөөлөлд өртсөн байдаг. Эдгээр хүний нөлөөлөлд өртөөгүй газруудад байгаа биологийн олон янз байдлын зүйлүүд, жишээ нь хулан (*Equus*



hemionus), хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*) зэрэг томоохон нүүдлийн зүйлүүд, нүүдлийн шувууд болох жороо тоодог, идлэг шонхор зэрэг нь олон улсын ач холбогдол бүхий ховордсон амьтад байдаг. Эдгээр амьтдын оршин амьдрах сүүлийн орон зайг алдагдуулах нь дээрх зүйлүүд бүрмөсөн устаж үгүй болох аюулд хүргэх тул амьдрах орчин, орон зайг хамгаалах нь олон улсын ач холбогдолтойд тооцогддог. Алслагдсан бүс нутгууд дахь уул уурхайгаас үзүүлэх шууд болон шууд бус нөлөөлөл, тухайлбал ашигт малтмалын тээврийн зам барих, цахилгаан дамжуулах шугам тавих, усан хангамж болон шинэ суурин газрын бүтээн байгуулалт зэрэг дэд бүтцийн хөгжил нь тухайн газар нутгийн биологийн олон янз байдлын амьдрах орчинд нөлөөлөх хүний үйл ажиллагааг нэмэгдүүлсээр байна. Нүүдлийн зүйлүүдийн амьдрах орчин хэрхэн хуваагдаж болохыг сүүлийн жилүүдэд Өмнөговь аймгийн уул уурхайн бүс нутгаас Хятадын хил хүртэл барьсан ашигт малтмалын тээврийн замаас харж болно.

Ашигт малтмалын орд болон биологийн олон янз байдлын амьдрах орчны давхцал, уурхайн хөгжилтэй холбоотойгоор шилжин ирэгсдийн тоо нэмэгдсэнээр үүсэх ан амьтдын хууль бус агнуур ихсэх болон алслагдсан газарт тээврийн хэрэгслээр зорчих байдал хяналтгүй болох зэрэг нь биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулах үйл ажиллагаанд хязгаарлагч хүчин зүйл болж байна. Биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллөөс зайлхийх болон бүрэн бууруулах боломжгүй тохиолдолд учруулсан нөлөөллөө өөр газарт дээрх зүйлүүдийг хамгаалах хөтөлбөрөөр дамжуулан бууруулах дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг авдаг. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах асуудлыг Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний хуульд саяхан тусгасан хэдий ч энэ асуудал одоогоор эхлэлийн байдалтай, дүйцүүлэн хамгаалах ямар нэгэн томоохон хөтөлбөр хэрэгжээгүй байна.

2.6.2 Нийгмийн нөхцөл байдал

Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа: Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн шилжилтийн үед Монгол улсад олон тооны хүмүүс ажилгүй болж ажилгүйдлийн түвшин нэмэгдсэн нь хувиараа болон бичил уурхай (БУ)-аар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа бий болоход нөлөөлсөн гэж үздэг. Үүн дээр 1992-2002 оны хооронд дараалан болсон зуданд олон малчид мал сүрэг, орлогын эх үүсвэрээ барснаар бичил уурхай бараадахад хүрчээ (Навч, Болормаа, Энхцэцэг, Хүрэл, 2006). Монгол улсын хэмжээнд бичил уурхайн чиглэлээр 100 мянга гаруй хүн ажиллаж байгаа гэсэн тооцоо байна. Олон тооны хүмүүс ашиг орлого олохоор ирэгсэд, наймаа арилжаа хийх зэргээр хувиараа хөдөлмөр эрхлэгчид, оюутнууд, орон нутгийн төрийн байгууллагын ажилтнуудын хувьд амралтаараа хувиараа ашигт малтмал олборлож нэмэлт орлого олдог болсон нь олон хүний амьжиргаа БУ-аас хамааралтайг харуулж байна (Тогтвортой бичил уурхай төсөл, 2011). Өдөр бүр шахам олох бэлэн мөнгөний орлого, нэг л өдөр амьжиргаанаасаа салах бий гэсэн эрсдэлгүй амьдрал, элбэг хангалуун амьдрах хүсэл эрмэлзэл зэрэг нь малчдын хувьд мал маллахад байнга тулгарч байдаг бэлчээрийн доройтол, цөлжилт, гал түймэр, зуд зэрэг байнгын эрсдлээс хол байж, хэцүү ч гэсэн хувиараа ашигт малтмал олборлох амьдралд татагдахад хүргэдэг байна (Дэлхийн банк, 2006).

Маш олон тооны Монгол иргэд хувиараа алт, нүүрс олборлох уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг учраас Засгийн газар хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдсэн байгаль орчин, нийгмийн асуудлыг олон жилийн турш шийдвэрлэж чадахгүй байгаа юм.



Хувиараа ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагаа нь хууль ёсоор хүлээн зөвшөөрөгддөггүй, төр засгийн байгууллагуудад бүртгүүлэх боломжгүй байдаг зэрэг олон саад бэрхшээлтэй тулгардаг бөгөөд энэ нь тэдгээр хүмүүсийг нийгмийн наад захын үйлчилгээг авах боломжгүй болгодог гэсэн үг юм. Бичил уурхайнуудад ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандарт гэж байдаггүй бөгөөд эрүүл мэндийн стандарт шаардлагыг сахих явдал ихээхэн муу байдгаас өвчин эмгэг гарах байнгын айдастай байдаг (Тогтвортой бичил уурхай төсөл, 2011). Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа эрхлэгчид нь боловсруулалтандаа мөнгөн ус, цианид болон бусад химийн бодис ихэвчлэн ашигладаг тул гол ус, хөрс болон агаар, газар нутаг, байгаль орчныг хордуулан сүйрүүлэх эрсдэл үүсгэдэг. Хувиараа ашигт малтмал олборлогчид байгалийн нөөцийг (бэлчээр, ус) доройтуулснаас малчид ба бичил уурхайгаар ашигт малтмал олборлогчдын хооронд байнга зөрчил үүсдэг бөгөөд уурхайн ойр орчимд амьдардаг иргэдийн бүлгүүдийн дунд нийгмийн нэгдмэл байдал, хүмүүсийн харилцаанд сэв сууж болзошгүй байдаг. Түүнчлэн хувиараа ашигт малтмал олборлогчид зөвшөөрөлтэй уурхайн талбайд нэвтрэн олборлох боломж эрэлхийлдэг тул бичил уурхай эрхлэгчид болон зөвшөөрөлтэй уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн хооронд бас зөрчил гардаг байна.

2010 оны 4-р сард Монгол улсад бичил уурхайн салбарыг журамлаж, албан ёсны хэлбэрт шилжүүлэх санаачилгыг УИХ олонхийн саналаар баталжээ. Энэ нь бичил уурхай эрхлэгчид олборлолт явуулах газар авч, тогтвортой ажлын байрыг бий болгож, тогтмол орлоготой болох боломжийг бүрдүүлсэн юм. Мөн түүнчлэн ажлын байрны аюулгүй байдал болон нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээг авах боломжийг бүрдүүлж байгаа болно (Тогтвортой бичил уурхай төсөл, 2011). Гэхдээ, бодит байдал дээр, хууль журмын зохицуулалт болон дэмжих тал дээр бичил уурхайг шоовдорлосон байдал төр засгийн болон нийгмийн түвшинд байсаар байна (SAMP KII, 2014).

Соёлын өв: Монголын нийгэм биет болон биет бус соёлын өвийн аль алиных нь ач холбогдлыг чухалчлан авч үздэг. Биет соёлын өвийг "археологи, (балар эртний) палеонтологи, түүх, соёл, урлаг, гоо сайхан болон шашны үнэ цэнэ бүхий хөдөлгөөнт болон суурин байдалтай эд өлгийн зүйлс, дурсгалт газрууд" гэж тодорхойлсон байна. Шүтлэгтэй газар, хад чулуу, нуур ус, усан хүрхрээ зэрэг соёлын өвийг агуулсан байгалийн ховор тогтоц, зүйлс мөн биет соёлийн өвд орно. Харин соёлын биет бус өвийн төрөлд соёлын мэдлэг, уламжлалт амьдралын хэв маягийг тусгасан ард иргэдийн зан үйлүүд ордог. Монгол улс нь баялаг түүх болон нүүдэлчин уламжлал бүхий соёлоороо ихээхэн танигдаж, алдаршсан билээ. Нийгмийн өөрчлөлтүүд, даяарчлал болон хурдацтай явагдаж байгаа хотжилт зэрэг нь Монголын соёлын уламжлалд улам бүр нөлөөлөх болсон бөгөөд тус улсад тулгарч байгаа чухал сорилтуудын нэг нь хурдацтай өсөлт болон соёлын өвөө хэрхэн хадгалан хамгаалахыг уялдуулж, тэнцвэртэйгээр авч явах вэ гэдэг асуудал болно. Уул уурхайн үйл ажиллагаа нь газрыг их хэмжээгээр хөнддөг болон зарим тохиолдолд түүхэн болон шинжлэх ухааны ач холбогдолтой газруудыг сүйтгэдэг, нүүдлийн соёлыг алдагдуулах буюу өөрчилдөг байдлаараа Монголын соёлын өвд ихээхэн эрсдэл учруулж байна. Ялангуяа, уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж байгаа Өмнөговь аймаг зэрэг уул уурхайн салбар хурдацтай хөгжиж байгаа бүс нутгуудад дээрх аюул, эрсдэл ихээхэн тулгарч байна. Уурхайн бүс нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн ба дэд бүтцийн хөгжил зэрэг бусад үйл ажиллагаа соёлын өвд мөн давхар нөлөөлөл үзүүлж байгаа юм.



Онцгой тод жишээ бол уламжлалт аргаар нүүдлийн мал аж ахуй эрхлэн малаа бэлчээдэг газар нутагт уурхайн зөвшөөрөл олгосноос үүссэн нөлөөлөл юм. 2012 оны 5-р сарын байдлаар Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутгийн 40%-д тусгай зөвшөөрлийн дор уурхайн үйл ажиллагаа явуулахаар тогтоосон байна. Зөвшөөрөл олгосон эдгээр бүх талбайд уурхайн үйл ажиллагаа явагдаж эхэлвэл мал маллан амьдардаг уламжлалт амьжиргааны хэлбэрт аюул нүүрлэх нь ойлгомжтой (Бямбадорж, 2012 он). Оюу Толгойн Соёлын өвийн хөтөлбөр боловсруулах¹⁴ явцад хийгдсэн үндэсний хэлэлцүүлгээр уул уурхайн салбар нь “малчдыг уурхайчид болгож байна” гэсэн асуулт гарч ирсэн. Түүнчлэн аливаа шийдвэр гаргах үйл явцад малчид байнга орхигддог нь тэдний малын бэлчээрт нөлөөлөхөөс гадна газраа эдийн засгийн эсвэл амьжиргаагаа залгуулах зорилгоор ашиглах эсвэл соёлын болон шашны зан үйлийн зорилгоор газраа ашиглах эрхэд заналхийлж байгаа ажээ.

Хүний эрх болон олон нийтийн оролцоо: Төр уул уурхайн салбарыг холбогдох хууль тогтоомж, хөрөнгө оруулалтын гэрээ зэргээр дэмжиж ирсэн боловч Үндсэн хуулийн дагуу орон нутгийн иргэдийг уул уурхайн салбарын сөрөг нөлөөллөөс хамгаалах тал дээр дутуу ажилласан байдаг. Эдгээр сөрөг нөлөөлөлд экологийн доройтол, нутгийн иргэдийн амьжиргаа нь хамаарч байдаг экосистемийн үйлчилгээг хүртэх боломжоор хязгаарлагдах гэх мэт асуудлууд багтана. Уул уурхайн хөгжлөөс эдийн засгийн үр ашиг хүртэнэ хэмээх орон нутгийн иргэдийн хүлээлт нь тэр болгон биелдэггүй. Учир нь уул уурхайн үр ашгийг тэнцүү хүртэж чадахгүй байх, цөөн ажлын байр бий болох, бэлчээр, ус зэрэг байгалийн нөөц ашиглах боломж буурах зэрэг үйл явдал гардаг (Ганхуяг, 2012).

Монгол улсын хууль тогтоомж хүний эрхийг хамгаалах тал дээр сул. Иймээс ч уул уурхайн төслөөс гарах эдийн засгийн үр ашгийг чухалчилснаар тусгай зөвшөөрөл бүхий талбай доторх малчдын эрхийг өнгөрсөн хугацаанд ихэнхдээ орхигдуулдаг байв. Одоогийн байдлаар Монгол улсын уул уурхайн салбарт хүний эрхийн асуудлыг зохицуулах талаар хууль эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа (Бямбадорж 2012) нь орон нутгийн иргэдийн мэдээлэл хүртэх эрх, мөн тэдний эрхийг хөндөж болзошгүй асуудлуудад иргэд оролцох нөхцөл хангалттай баталгаажаагүй байгааг илэрхийлж байна (Куаначэйн, 2012). Жишээлбэл зарим тохиолдолд тодорхой уул уурхайн компаниуд нь Монгол улсын уул уурхайн салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин хөлс өгдөг тухай мэдээлэл байна.

Монгол улс дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаар илтгэлд ялангуяа уул уурхайн салбартай холбоотой хүний эрхийн олон асуудал байгааг дурдсан бөгөөд үүнд ардчилсан, эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлж байгаа өргөн хүрээнд тархсан авлига, ил тод бус буюу ялангуяа Засгийн газрын хууль эрх зүйн салбарт байгаа хаалттай, ил тод бус байдал нь төр засгийн үр дүнтэй байдал болон олон нийтийн итгэлийг бууруулж байгаа явдал, хэвлэл мэдээлэл дахь төрийн оролцоо, гадаадын иргэдэд виз олгохгүй болон хүлээлгэх, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлийг зогсоох хангалттай арга хэмжээг авахгүй байгаа болон өөр бусад асуудлууд багтан орж байгаа болно (АНУ-ын Төрийн департамент, 2013). Монгол улс дахь уул уурхай болон Хүний эрхийн талаар Олон улсын хурлын зөвлөмжид (2013) уул уурхайн бодлого болон үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан аргачлалаар хандахгүй байгаа болон одоо байгаа хууль журмын хэрэгжилт мүү, хүний эрхийн талаар төр засаг болон хувийн хэвшил нэг

¹⁴ Өнгөрснийг хамгаалж, ирээдүйг хадгалах нь: Өмнөговь аймагт зориулсан Оюу Толгой төслийн соёлын өвийн хөтөлбөрийн 1-р үе шатны үйл ажиллагааг төлөвлөх ажлын тайлан (2011 оны 2 сар)



адилхан байдлаар ойлгохгүй байгаа зэргээс болж Монголд хүний эрх зөрчигдөж байгааг онцгойлон дурдсан байдаг.

Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар Монголд өнөөдөр ямар нэгэн заавар журам байхгүй байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7-р зүйлд нийгмийн болон эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх журмыг Засгийн газраас батална гэсэн байгаа нь нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагыг тусгасан ганц зохицуулалт хэдий ч үүнийг хэрхэн хийх журам, зааврыг одоогоор боловсруулаагүй байна. Үнэлгээний энэ журам гараагүй үед уурхайн БОНБУ нь эрүүл мэндийн статистик сумын хэмжээнд ямар байгаагаар хязгаарлагдаж, олон улсын түвшний шаардлагад нийцсэн эрүүл мэнд, аюулгүй байдлын нөлөөлөл хийгддэггүй¹⁵. Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулах нийгмийн лицензтэй байхыг хүссэн компаниуд өөрсдийн санаачилгаар өөрсдийн үйл ажиллагаанаас олон нийтэд учруулж болох эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж болох хэдий энэ нь одоогийн хууль тогтоомжуудаар шаардагдаагүй асуудал юм.

Уул уурхайн бүс нутаг болон дэд бүтцийг барьж хөгжүүлж байгаа газар нутагт хүн ам нэмэгдсэнээр бэлгийн замаар халдварладаг өвчин, амьсгалын замын өвчин, аюулгүй ажиллагаатай холбоотой гэмтэл бэртэл, өөр бусад халдвартай болон халдваргүй өвчний гаралт нэмэгддэг. Ялангуяа албан бус, бага хэмжээний бичил уурхай бүхий газар нутагт эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны асуудал ихээхэн түгээмэл гардаг. Агаарын бохирдол, усны хангамж муу байх, ариун цэвэр, химийн аюулгүй байдал зэрэг өөр бусад байгаль орчны хүчин зүйлүүд нь олон нийтийн, ялангуяа хот суурин газруудын оршин суугчдын эрүүл мэндтэй холбоотой чухал асуудал болно. Уул уурхайн салбарын хурдацтай хөгжил дээр хөдөө орон нутгаас хот суурин газар руу шилжин нүүх асуудал нэмэгдсэнээр Монгол улсын Засгийн газраас үзүүлдэг эрүүл мэндийн үйлчилгээнд тодорхой бэрхшээлийг бий болгоод байна. Үндэсний хэмжээний эрүүл мэндийн цогц бодлого, стратеги болон төлөвлөгөөгөөр дамжуулан олон нийтийн эрүүл мэндийг сайжруулах хүчин чармайлтыг авч байгаа хэдий ч, сорил бэрхшээлүүд байсаар байгаа бөгөөд үүнд хот хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн зөрөөтэй байдал, эрүү мэндийн салбарын ажиллах хүчний хуваарилалт ихээхэн муу, эрүүл мэндийн гэнэтийн нөхцөл байдал, гамшигт бэлтгэл муутай болон шуурхай хариу үзүүлэх чадвар сул зэрэг орж байгаа болно (ДЭМБ, 2010).

Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 2008 онд батлагдсан хуулийн дагуу Хөдөлмөрийн яам хариуцдаг. Энэхүү хууль нь ажиллагсдын эрүүл мэнд, ажлын байран дахь эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хамардаг бөгөөд бүхий л салбарт мөрдөгдөх ёстой. Уурхайн салбарт мөрдөгдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг тусгайлан зохицуулсан хууль байхгүй байгаа нь улсын хэмжээнд тавигдаж байгаа асуудал бөгөөд одоогийн хуулийг олон байгууллагууд хянан боловсруулж байна. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудын хэрэгжилт муу, хэрэгжүүлэх хүчин чадал хүрэлцэхгүй байгаа нь ослын тоо маш өндөр байгаагаар нотлогдож байгаа юм. Хүснэгт 2.4-д уул уурхайн салбарт 2007-2012 онуудын хооронд гарсан ослын байдлыг харуулав. Дээрх хугацаанд уул уурхайн салбарт гарсан ослоор нас барагсдын тоо хамгийн их (191) буюу барилгын үйлдвэрлэлийн ослоор нас

¹⁵ Олон улсын эсвэл бүс нутгийн хэмжээнд яг ижил, эсвэл ижил төстэй тохиолдолд адилхан ажлыг гүйцэтгэж байгаа мэргэжлийн туршлагатай мэргэжилтнүүдийн явуулдаг хяналт шалгалтыг хэлнэ.

барагсдаас (166) өндөр байв. 2011 оноос хойш уул уурхайн салбарын үйл ажиллагаа удааширсан хэдий ч уул уурхайн салбарт гарсан осол, золгүй явдал өндөр хэвээр байна. Түүнээс гадна Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас гаргасан үзүүлэлтээс харахад гарч буй ослын хэмжээ бүх салбаруудад байнга өссөөр байгаа ажээ (Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, 2013 он). Энэ мэдээлэл нь зөвхөн бүртгэгдсэн үзүүлэлт бөгөөд бүртгэгдээгүй ослын (жишээлбэл хувиараа ашигт малтмал олборлогчид) тоог оруулбал дээрх тоо улам өндөр болох нь ойлгомжтой гэдгийг санах нь зүйтэй. Бичил уурхайн салбарт аюулгүй байдлыг хангах явдал улам их анхаарал татаж буй асуудал болоод байгаа нь уг ажлыг эрхлэх нь албан бус шинжтэй, ажлын байрны болон нийгмийн хамгаалал, аюулгүй ажиллагааны анхан шатны арга хэмжээг үндсэндээ бараг хэрэгжүүлдэггүйтэй холбоотой.

Хүснэгт 2.4 Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарт гарсан ослын тоо

	2007	2008	2009	2010	2011	2012
Нийт ослын тоо	62	123	54	42	65	69
Олон хүнийг хамарсан ослын тоо	2	8	1	3	2	2
Гэмтсэн хүмүүсийн тоо	67	149	55	52	72	72
Эмэгтэй	3	23	4	5	6	7
Тахир дутуу болсон	16	37	8	2	3	10
Хөдөлмөрийн чадвараа түр алдсан	29	48	31	29	38	34
Эндсэн хүмүүсийн тоо	18	63	11	21	25	28

(Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, 2013)

Малын эрүүл мэнд, аюулгүй байдал: Малчдын амьжиргаанд тэдний малын эрүүл мэнд ихээхэн чухал ба уул уурхайн олборлолт, холбогдох тээврийн хөдөлгөөнөөс үүдсэн тоосжилт, бохирдол нь малыг амьсгалын замын, нүдний болон хоол боловсруулах эрхтэний өвчин эмгэгээр өвчлүүлэх нөхцөл болоод байгаа юм (Бодлогын судалгааны төв, Хүн амын сургалт судалгааны төв, 2009). Цаашилбал, хүнд металл (ялангуяа хувиараа алт олборлох үйл ажиллагаатай холбоотой мөнгөн усны хэрэглээ), тоос, хаягдал, хувиараа ашигт малтмал олборлолт болон бичил уурхайн үйл ажиллагаа, оршин суугчдын ахуйн салхинд хийссэн хаягдлаас болж усны нөөц улам ихээр бохирдож байгаа ба эдгээр нь бүгд малын эрүүл мэнд, малчдын амьжиргаанд нөлөөлөх хүчин зүйлс болж болзошгүй байдаг. Малын бэлчээрийн талбай нь уурхайн талбайтай ойр байрладаг, мөн цардаагүй зам, уурхайн хаягдал хаях талбайг хашаагүй зэрэг нь эдгээр асуудлыг улам хурцатган хүндрэлтэй болгож байна.

2.6.3 Эдийн засгийн нөхцөл байдал


Макро-эдийн засгийн үр нөлөө: Бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ өндөр байх үед эдийн засаг өндөр хурдацтай өсөж, улмаар үнэ буурах үед буурдаг бөгөөд тиймээс, аливаа бүтээгдэхүүн, түүхий эдээс хамааралтай байх нь макро-эдийн засгийн хэлбэлзлийг бий болгодог. Одоогийн уул уурхайн хөгжлийн эрчим оргилдоо хүрэхээс өмнө Монгол улс нь Европ, Төв Азийн улс орнуудаас хамгийн өндөр инфляцитай улс болсон байсан нь макро-эдийн засгийн тогтворгүй байдал Монгол улсын хувьд ихээхэн асуудал болсон байгааг харуулж байв. Дээр нь, Монгол улсын экспортын гол бүтээгдэхүүн болох зэсийн үнэ өнгөрсөн хэдэн жилийн турш ихээхэн савлагаатай байгаа нь эдийн засгийн огцом өсөлтөөс бууралт мөчлөгийг хурдасгасан байна. Үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарыг давамгайлсан уналтанд оруулах байдлаар байгалийн



баялаг нь эдийн засгийн бүтцийг өөрчилдөг. Энэ нөхцөл байдлыг “Голланд өвчин” хэмээн нэрлэдэг ба энэ үед эрдэс баялгийн салбараас олох орлого нэмэгдсэнээр өөр бусад улсын валюттай харьцуулахад тухайн улсын валютын ханшийг нэмэгдүүлж өөр бусад салбарууд бүтээгдэхүүнээ экспортлоход илүү үнэтэй болж, өрсөлдөх чадварыг нь бууруулдаг (Исакова, Плеханов, Зэттелмэйэр, 2012). Монгол улсын хувьд энэ үзэгдэл хэдийнээ илрээд байгаа бөгөөд энэ нь уул уурхайн салбараас олж байгаа орлого мал аж ахуй, дотоодын аж ахуйн нэгж болон төрийн байгууллагад ажилладаг хүмүүсийн цалингаас ерөнхийдөө илүү байдгаас харагдаж байна. Үнэ ханшийн уналт нь уул уурхайн бус салбарт ажилладаг хүмүүст амьжиргаагаа залгуулахад улам бүр хүндрэлтэй байдлыг бий болгож байна.

Орлогын менежмент: Төсвийн орлого нэмэгдсэнээр үүнийг тогтвортой хөгжил, ард иргэдэд ашиг тустайгаар хэрхэн зарцуулах талаар шийдвэр гаргах шаардлагатай болдог. Хөгжиж буй бусад орнуудын туршлагаас харахад улсын орлого нэмэгдсэнээр нэг талаас авлига, хээл хахуулийг нэмэгдүүлж, нөгөө талаас үр ашигтай хөрөнгө оруулалт хийх, Засгийн газраас орон нутаг руу санхүүжилт хийх сонирхлыг бууруулдаг байна. Орлогын урсгал нэмэгдсэнээр Засгийн газар хөрөнгө зарцуулахдаа олон нийтээс зөвшөөрөл авах дарамт шахалт буурч, ингэснээр олон нийтийн өмнө хүлээх хариуцлага сулардаг. Ингэснээр уул уурхайн салбарын хөгжлийн ашиг тусыг өргөн хүрээнд хүртэх явдалд саад болдог байна (Чени, 2012).

Одоогоор ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр, байгалийн нөөц ашигласны зэрэг төлбөрөөс олсон орлогыг орон нутгийн удирдлага цуглуулдаг ч, Татварын тухай хуулийн 56.2-р заалтын дагуу доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлдэг. Орон нутгаас улсын төсөвт оруулж байгаа хувь нэмэр болоод уул уурхайгаас орон нутагт оруулж буй мэдэгдэхүйц ашиг тус тэр бүр олон нийтэд харагддаггүй (Зураг 2.7-ийг харна уу). Уул уурхайн компаниуд болон Засгийн газрын аль аль нь орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулдаггүй гэсэн ойлголт орон нутагт байдаг нь орон нутгийн түвшинд зөрчил, үл ойлголцол үүсгэх шалтгаан болдог. Ялангуяа, уул уурхайн салбараас ихээхэн орлогыг бүрдүүлдэг ч өөрийн зардалд л ногдсон төсвийг өөрт үлдээн бусад орлогоо бүгдийг нь улсын төсөвт шилжүүлдэг аймгууд уул уурхайгаас орон нутгийн хөгжилд хувь нэмэр орохгүй байгаа гэсэн дүгнэлтийг илүүтэйгээр хийх болдог.



Зураг 2.7 Ашигт малтмалын салбараас олсон орлого болон улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэгийн харьцуулалт, аймгийн түвшинд


Дэд бүтцийн хөгжил: Уул уурхайн салбар хурдацтай хөгжиж байгаа боловч, дагалдах дэд бүтэц, ялангуяа ашигт малтмалыг тээвэрлэхтэй холбоотой дэд бүтэц адилхан хурдтай хөгжиж чадахгүй байна. Монголын айл өрхүүдийн гуравны нэгээс бага хувь нь инженерийн шугам сүлжээ бүхий цэвэр усаар хангагдсан байдаг бол хөдөө орон нутгийн оршин суугчдын багахан хувь нь л цахилгааны шугам сүлжээнд холбогдсон байдаг. Ялангуяа, тээврийн дэд бүтэц сул байгаа нь байгаль орчны хувьд ихээхэн үр дагавар авчирч байна. Жишээ нь, Энержи Ресурс, Эрдэнэс Таван Толгой компаниудаас бусад компаниудын нүүрсний тээвэрлэлт нь Таван Толгойгоос Хятадын хил хүртэл хүнд даацын машинаар тусгай зориулалтын замгүй газраар хийгдэж байна. Ийм замгүй газраар нүүрсний тээвэрлэлтийг хийснээр эмзэг газрыг улам бүр доройтуулж, олон тооны шороон замыг бий болгож, их хэмжээний тоос (жишээ нь, эргэн тойрны газар харагдахгүй болох, ургамлын бүрхэвч тоосоор хучигдах, агаарын чанар доройтох, г.м.) үүсгэж байна. Монголын нийт замын сүлжээний зөвхөн 1900 км нь хатуу хучилттай, 1900 км нь хайрган, 1800 км нь сайжруулсан шороон зам болно. Үлдсэн 43,600 км (ойролцоогоор) зам нь шороон зам байна (BirdLife Asia, 2009). Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгийн харьяа Монголын төмөр зам нь 1815 км урт өргөн царигийн төмөр замаас бүрдэх бөгөөд үүний 1110 км нь Орос Хятадыг холбосон үндсэн төмөр зам, 238 км нь Монголын Дорнод хэсгээс Оросын төмөр зам руу холбогдсон тусдаа сүлжээ, 477 км нь үндсэн шугамаас салаалсан төмөр замууд болно (BirdLife Asia, 2009). Монголын төмөр замын үндсэн шугам нь зөвхөн нэг шугамаас бүрдэх тул хязгаарлагдмал нэвтрүүлэх чадавхитай, тоног төхөөрөмж нь хуучирч муудаж байгаагаас уул уурхайн салбарт ачаа тээврийн үйлчилгээ үзүүлэх чадвар муутай юм. Төмөр замын салбарт хувийн хэвшил үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн нөхцөл нь байгаа боловч хэрэгжүүлэх арга механизм тодорхой бус, мөн Улаанбаатар Төмөр зам компанийн зүгээс хүчтэй эсэргүүцэлтэй тулгардаг.



Дэд бүтцээс зэрлэг амьтдын хөдөлгөөнд, ялангуяа хулан болон зээрийн сүргийн хөдөлгөөнд нөлөө үзүүлж байна. Одоогоор Монголын өмнөд хэсэгт, ялангуяа Таван Толгойн уурхай болон Гашуун сухайтын хилийн боомтын хооронд Хятад улс руу нүүрс тээвэрлэх зорилгоор олон салаа замууд үүсээд байгаа юм. Замын хөдөлгөөний оргил ашиглалтын үедээ эдгээр замууд нь зэрлэг амьтад, мал сүргийн хувьд нэвтрэн гарах аргагүй саад бэрхшээл болдог. Дэлхийн банкны судалгаагаар, өдөр тутмын ачааны машины хөдөлгөөн 1300-2000 машин болж ихсэх төлөвтэй байсан бөгөөд зам тээврийн үр дүнтэй, уялдсан менежмент болон дэд бүтцийг зэрлэг амьтад тохиромжтой, ээлтэй байдлаар хөгжүүлэхгүй бол, төлөвлөсөн уур уурхайн төслүүд бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэх үед ашигт малтмалын тээвэрлэлт нь зэрлэг амьтад улам бүр нөлөө үзүүлсээр байх болно (Дэлхийн банк, 2010).

Уул уурхайн салбар дахь хөдөлмөр эрхлэлт болон үр чадвар: Хэдийгээр уул уурхайн салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний 20%-ийг, экспортоос орох орлогын 89%-ийг (Ганхуяг, 2012) тус тус бүрдүүлж улсын эдийн засагт чухал хувь нэмэр оруулж байгаа ч уул уурхайн салбарт хөдөлмөр эрхлэгчдийн хувь хэмжээ нийт хөдөлмөр эрхлэгчдийн 4%-ийг бүрдүүлж байгаа нь энэ салбарт ажил хөдөлмөр эрхлэх боломж одоогоор хязгаарлагдмал байгааг харуулж байгаа юм (Санжмятав, 2012). Дээр нь, уул уурхайн салбарт ажил хөдөлмөр эрхлэх боломжийн талаар орон нутгийн иргэдийн хүлээлт болон бодит байдлын талаар том ялгаа байгаа болно. Уул уурхайн салбарын шаардлага хангахуйц мэргэжил, чадварыг эзэмшээгүй нутгийн иргэд төдийлөн олон тоогоор ажилд орж чаддаггүй бөгөөд улмаар уул уурхай нь байгаль орчныг сүйтгэдэг хэдий ч орон нутгийн иргэд, хүрээлэн буй орчинд ашиг тус хүргэдэггүй үйл ажиллагаа хэмээн тооцогдох хандлага түгээмэл ажиглагддаг (Дэлхийн банк, 2006). Ажилгүйдлийн түвшин болон уул уурхайн салбарт ажиллаж буй ажиллаж буй иргэдийн тоог Зураг 2.8-д үзүүлэв. Уул уурхайтай газруудад ч гэсэн ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь дээрхээс харагдаж байна.

Ур чадварын хувьд, уул уурхайн салбарыг шинжлэх ухааны талаас нь судалдаг, зөвхөн энэ чиглэлээр ажилладаг институцийн тоо Монгол улсад 1996 оноос хойш байнга буурч ирсэн. Ур чадварын хөгжилд саад болж байгаа хоёр дахь том бэрхшээл бол боловсролын систем дэх хоцрогдсон сургалтын хөтөлбөр болон заах арга зүй бөгөөд тэдгээр нь олон улсын стандартын түвшингээс үлэмж доогуур байгаа нь төгсөгчид ажлын байрны шаардлагыг хангах мэдлэг, ур чадварыг эзэмшиж чадахгүйд хүргэж байгаа юм. Түүнчлэн, одоогоор олгож байгаа техник мэргэжлийн боловсрол болон мэргэших сургалтууд нь ихэвчлэн хоцрогдсон бөгөөд уул уурхайн салбарын шаардлагыг хангахгүй байна (Азийн хөгжлийн банк, 2009).




Зураг 2.8 Уул уурхайн салбарт ажиллагсад болон ажилгүйдлийн түвшин

Технологи: Монголын үйлдвэрлэлийн технологийг шинэчлэх шаардлагатай ба учир нь одоо ашиглагдаж буй технологи нь ихээхэн цахилгаан эрчим хүч, түүхий эд шаарддаг. Уул уурхайн салбарын ихэнх нь эрчим хүчний хэмнэлттэй, орчин үеийн үйлдвэрлэлийн арга технологийг ашигладаггүй (Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, 2013). Энэхүү асуудлыг шийдвэрлэх Монгол улсын Засгийн газрын нэг гол стратеги бол илүү дэвшилтэт, байгаль орчинд ээлтэй технологийг уул уурхайд ашиглан Монгол улсыг “ногоон” болгох явдал юм. Үүнд хаягдал усыг боловсруулж, дахин ашиглах шилдэг тэргүүний технологи, ашигт малтмалыг боловсруулах, химийн бодис ашиглах, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, нүүрс ашигладаг халаалт дулаанаас хамаарах явдлыг бууруулах болон өөр бусад зүйл багтан орж байна. Монгол улс дээр дурдсан чиглэлүүдээр хоцорч байгаа боловч, Монголын амжилтын түүхийн нэг болох мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбар буюу гар утас, интернетийн хүртээмж, ашиглалтын чиглэлээр ихээхэн амжилт ололтонд хүрсэн билээ (Азийн хөгжлийн банк, 2009).

Уул уурхай хөгжиж байгаа газар нутгуудад хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэх асуудал: Хөдөөгөөс хот суурин газар руу нүүх хүн амын шилжилт хөдөлгөөн, ялангуяа нэг уурхайгаас нөгөөруурхай руу шилжих хөдөлгөөн нэмэгдсээр байна. Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдсэн хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор хүчирхийлэл болон нийгмийн дарамт, нутгийн иргэдэд түр эсвэл тогтвортой бус ажлын байрууд олдох, эрүүл мэндийн эрсдэл нэмэгдэх зэрэг зарим сөрөг нөлөөллүүд бий болсон (Азийн сан, 2010). Төлөвлөсөн албан болон төлөвлөөгүй албан бус байдлаар уурхайн талбайн ойр орчимд суурин газар бий болох нь одоогийн байгаа дэд бүтэц, нийгмийн үйлчилгээнд дарамт үзүүлэх байна. Хүн амын тоо өсөн нэмэгдснээр цахилгаан эрчим хүч, ус, хүнс, дулаан, эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээнд дарамт үзүүлдэг. Түүнчлэн, Монгол улсад ахуйн хатуу болон шингэн хаягдлыг зайлуулах менежмент



муу хөгжсөний дээр хүн амын шилжилт хөдөлгөөн ихэссэнээр хог хаягдлыг нэмэгдүүлж тухайн орон нутгийн байгаль, хүрээлэн буй орчныг улам ихээр бохирдуулж, доройтуулж байна (Дэлхийн банк 2009 он). Зураг 2.9-т сүүлийн 5 жилд уул уурхай болон дэд бүтэц эрчимтэй хөгжиж буй бүс нутагт шилжин ирсэн, тус бүс нутгаас шилжин явсан хүн амын шилжилт хөдөлгөөнийг харуулав.



Зураг 2.9 Шилжин ирэгсэд болон дэд бүтцийн хүртээмж

Цаашилбал, хүн амын шилжилт хөдөлгөөн нь төслийн үе шатаас хамаарч байгаа нь харагддаг. Уурхай барих, уурхайн үйл ажиллагаа явагдах болон түүнтэй холбоотой дэд бүтэц барих шатанд ажиллагсадын эрэлт хэрэгцээ өндөр байх тул хүн амын тоо түр хугацаагаар өсдөг. Төслийн эрэлт шаардлагаар эсвэл хүмүүс өөрсдөө ажлын байрны боломж эрэлхийлэн төсөл явагдаж буй орон нутагт шилжин ирж байна. Төсөл хэрэгжүүлэгчид шилжилт хөдөлгөөнийг орон нутгийн удирдлагуудтай хамтран зөв зохион байгуулахгүй бол шинээр ирсэн ажиллах хүчин, ажил хайж буй иргэд өөрсдөд нь хэрэгцээтэй орон сууц, ус, цахилгаан, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээг бүх оршин суугчдад ижил хүртээмжтэй байлгахыг орон нутгийн удирдлагаас шаардаж дарамт үзүүлдэг (Бодлогын судалгааны төв, Хүн амын сургалт, судалгааны төв, 2009). Хүртээмжтэй холбоотой хамгийн гол анхаарал татсан асуудал бол шилжин ирж тухайн орон нутагт суурьшиж буй иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ буюу эмнэлэг, боловсролын байгууллагын хүрэлцээ юм. Жишээлбэл, Оюу Толгой төслийн БОНУ-г гүйцэтгэх явцад олон нийт уурхай байгуулагдсанаар тус нутагт ирэх хүний амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэж нийгмийн үйлчилгээний хүчин чадлыг бууруулах нь тэдний хувьд хамгийн санаа зовоосон асуудал болно гэсэн байна.

Уул уурхайн салбарын өсөлт нь уурхайн талбайн орчимд хоёрдогч бизнес хөгжин өргөжих шууд нөлөөллийг бий болгодог. Уурхайн ажиллагсад, тэдний гэр бүлийн худалдан авах чадвар, мөн хоол хүнс, жижиглэн худалдааны дэлгүүр, шатахүүн түгээгүүрийн станц зэрэг хэрэгцээ нь бизнес эрхлэгчид болон ажлын байр хайж буй иргэдийг уурхайн талбайд суурьшин бизнес эрхлэх эсвэл шинэ бизнесүүдэд ажилд ороход түлхэц болдог. Одоогийн байдлаар хэдий алслагдмал аймагт ч уурхайн ажиллагсдын эдгээр эрэлт хэрэгцээний бараа бүтээгдэхүүн,



үйлчилгээг ханган нийлүүлдэг гол төв нь Улаанбаатар хот хэвээр байгаа юм. Олон улсын уурхайн компаниуд өөрсдийн худалдан авалтын бодлого, журамд өөрчлөлт оруулан аймаг, сумдаас бараа, үйлчилгээг нийлүүлэх явдлыг дэмжиж байгаа тул бараа нийлүүлэгч байгууллагууд орон нутагт бүртгүүлэн хүн амын шилжилт хөдөлгөөнд мөн нөлөөлж байна.

2.7 ДҮГНЭЛТ

Энэ бүлэгт Монголын уул уурхайн салбарын түүх, байгаль орчин, нийгэм эдийн засаг болон хууль эрх зүйн зохицуулалтын орчныг тоймлон тодорхойлов. Өнгөрсөн хугацаанд Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлийн эдийн засаг бүхий нийгэмд шилжихтэй холбоотой үүссэн эерэг болон сөрөг нөлөөлөл нь уул уурхайн салбар өргөжих, гадаадын хөрөнгө оруулалт өсөх үйл явцтай давхацсан ба эдийн засгийг төрөлжүүлэн "Голланд өвчин"-тэй тэмцэхийн зэрэгцээ уул уурхайн салбарыг удирдан чиглүүлэх тус улсын хууль эрх зүйн зохицуулалтын орчныг сайжруулах шинэчлэлийг энэхүү шилжилтийн энэ цаг мөчид мөн хийх шаардлагатай болсон юм. Дээр дурдсан нийгэм-эдийн засгийн бодит хүндрэл, санаа зовоож буй бэрхшээлүүдийг Монголын иргэд уул уурхайн салбарын хөгжлийг хэрхэн харж байгаатай уялдуулан тодорхойлсон ба мөн энэ бүлэгт уул уурхайн салбар, үндэсний хөгжилд авч үзэх шаардлагатай асуудлуудыг багтаалаа. Дараачийн Бүлэг 3-т Монголын уул уурхайн салбарын хөгжлийн өндөр, дунд эсвэл бага өсөлтийн хувилбаруудыг авч үзэх ба эдгээр хөгжлийн хувилбарууд нь уул уурхайн салбар болон холбогдох хууль эрх зүйн орчин хэрхэн хөгжих, мөн хөгжлийн хувилбар тус бүрийн хувьд үүсэх байгаль орчин, нийгмийн асуудлуудаас хамаарах болно.



3. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХУВИЛБАРУУД

3.1 СУУРЬ МЭДЭЭЛЭЛ

БОНСУ-г хийж гүйцэтгэхэд уул уурхайн салбар эдийн засагт хэрхэн нөлөөлөх, тэр дундаа нийт эдийн засагт үзүүлэх уул уурхайн салбарын эдийн засгийн нөлөөллийг ойлгох шаардлагатай. Эдийн засаг болон уул уурхайн салбар хурдацтай өссөнөөр уул уурхайн салбараас байгаль орчин, нийгэмд нөлөөлөл учруулна.

Монголын уул уурхайн салбарын хөгжлийн бодлогын хувилбар болон холбогдох нөлөөллийг үнэлэх аргачлал нь Монгол улс хэдийгээр ашигт малтмалын арвин баялаг нөөцтэй боловч, дэлхийн зах зээлийн үнэ, хэрэглээнээс хамааралтай хэвээр байна гэсэн угтвар нөхцлөөс эхэлж байна. Монгол улсын цахилгаан станцуудад хэрэглэж байгаа багахан хэмжээний нүүрснээс бусад бүх олборлож буй ашигт малтмалыг экспортолдог. Тиймээс, хөгжлийн бодлогын хувилбаруудыг ашигт малтмалын салбарт юу тохиолдож болох, мөн уурхайн олборлолттой холбоотойгоор тус салбар ямар хариу үйлдэл үзүүлэх болоод энэ нь эдийн засгийн өсөлтөнд хэрхэн нөлөөлөх зэрэг асуудлуудад суурилан боловсруулав. Тус тайланд өндөр, дундаж, бага өсөлт гэсэн гурван хувилбарыг тоймлон авч үзсэн ба хувилбар тус бүр нь олон таамаглалд үндэслэгдсэн болно (Хүснэгт 3.1-ийг харна уу).

Хүснэгт 3.1 Монгол улсын эдийн засгийн хөгжлийн хувилбарууд болон хувилбаруудад ашигласан таамаглал, 2014 - 2025

Хүчин зүйлс	Дундаж өсөлт	Өндөр өсөлт	Бага өсөлт
Бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ-ялангуяа нүүрс/цахилгаан эрчим хүч болон металл (ОУВС-ийн индекс) Алт	ОУВС: Металл (180) Индекс=Зэс=Метр Тонн нь 7200 ам. доллар, 2014 Нүүрсний индекс (178) = Метр тонн нь 90 ам.доллар, 2014	ОУВС: Металл (200) Индекс=Зэс = Метр Тонн нь 8800 ам. доллар (2011 онтой адилхан) Нүүрсний индекс \$130 (2011 онтой адилхан)	Металл (160) ОУВС-ийн индекс Зэс =3300 ам.доллар (2005 онтой адилхан) Нүүрс 60 ам. доллар (2009 онтой болон ОУВС-ийн нэг хувилбартай адилхан)
Дэлхийн өсөлт Өндөр хөгжсөн улсууд АНУ, (БРИК эвсэл) (Хятад), Япон Шинээр хөгжиж байгаа улс орнууд	3%	4.0%	2.5%
Гадаадын хөрөнгө оруулалт болон бодлого	ДНБ-ий 40%	ДНБ-ий 50%	ДНБ-ий 20%
Дотоодын хөрөнгө оруулалт болон бодлого	Засгийн газрын зардал ДНБ-ий 45%	Засгийн газрын зардал ДНБ-ий 45%	Засгийн газрын зардал ДНБ-ий 35%
Ашигт малтмалын үйлдвэрлэл (ДНБ-д эзлэх хувь хэмжээ) ОТ, ТТ Өөр бусад+түүхий нефть, Алт	25%	35%	15%
Дундаж өсөлтийн талаарх таамаглал	8%	11.0%	6.5%



Бид ирэх 10 жилийн хугацаанд ашигт малтмалын үнэ ямар байх талаарх таамаглал хүлээлтийг хамгийн түрүүнд авч үзлээ. Учир нь энэхүү хүчин зүйл Монгол улсын эдийн засгийн өсөлтөнд өөр бусад хүчин зүйлээс хавьгүй илүүтэйгээр нөлөөлөхөөр байна. Ашигт малтмалын үнэ өндөр байх нөхцөл байдал нь уурхай, эрэл хайгуул, үйлдвэрлэлд хэдий хэрийн хөрөнгө оруулалт хийх асуудалд нөлөөлнө. Үүнтэй адилаар, ашигт малтмалын өндөр үнэ Засгийн газрын орлогод, цаашлаад Засгийн газар энэ орлогыг хэрхэн зарцуулж, эдийн засгийн ирээдүйн өсөлтийг бий болгох зэрэгт нөлөөлнө. Эдийн засгийн өндөр өсөлттэй байх хувилбарын таамаглалыг ОУВС, Дэлхийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) зэрэг байгууллагуудын хийсэн таамаглал, төсөөлөлд тулгуурлан гаргалаа.

Ирээдүйг таамаглахын тулд бид дараах хоёр үндсэн асуултыг асуух шаардлагатай. Үүнд:

- Монгол улсын эдийн засаг өнгөрсөн 10 жилийн хугацаанд хэрхэн өсөж, хөгжсөн бэ?
- Монгол улс ирэх 10 жилийн хугацаанд хэрхэн өсөж, хөгжих вэ?

Өнгөрсөн цаг хугацаа Монгол улсын эдийн засаг, хүн ам ирэх 10 жилийн хугацаанд (2025 он хүртэл) хэрхэн өсөж, хөгжиж болох, мөн дэлхийн зах зээлээс хэрхэн хамаарах талаар зарим нэг ойлголтыг өгч болох юм. Монгол улс цөөн хүн амтай тул хүн ам ихтэй улс орнуудтай харьцуулахад эдийн засаг нь уул уурхайн бус болон уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн эрэлт хэрэгцээнээс хамаарч байдаг. Ирээдүйг төсөөлөхийн тулд сүүлийн жилүүдийг Монгол улс хэрхэн өнгөрүүлсэн талаар авч үзье. Монголын эдийн засгийн хамгийн өсөлттэй жилүүд нь 2004 оноос 2009 оны хооронд байсан бөгөөд эдийн засаг дунджаар 9% өсөж байв. Эдийн засгийн энэ өсөлтөнд олон хүчин зүйл нөлөөлсөн бөгөөд үүнд, ашигт малтмалын өндөр үнэ ханш, дэлхийн эдийн засгийн өсөлт, уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт их хэмжээгээр нэмэгдсэн байдал, дотоодын хөрөнгө оруулалтын бодлого зэрэг орно. Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудаас (АНУ болон Европ) 2007-2008 онуудад эхэлсэн санхүүгийн хямрал дэлхийн улс орнуудын эдийн засагт хүстэй нөлөөлсөн бөгөөд Монгол ч мөн үүнд нэрвэгдсэн юм. Тус улсын эдийн засаг 2009 онд 1.3%-ийн сөрөг өсөлттэй болж, санхүүгийн хямралыг давахын тулд ОУВС, Дэлхийн банк, АХБ-аас тусламж авсан. Азаар энэ хямрал богино хугацааг хамарсан бөгөөд Хятадын өсөлтөөс хамаарч 2010 онд эдийн засаг 6.4% хүртэл өссөн байв. Гадаадын хөрөнгө оруулалт болон өндөр үнээс шалтгаалж, эдийн засаг цаашаа улам бүр өсөж, нүүрс, зэсийн экспорт нэмэгдсэнээр 2011 онд Монголын эдийн засгийн үзүүлэлт хамгийн өндөрт буюу (мөн дэлхийд) 17.5%-д хүрсэн байна. Гэсэн хэдий ч, хөрөнгө оруулагчдад сөргөөр нөлөөлсөн хөрөнгө оруулалтын болон уул уурхайн хуулиудад гарсан өөрчлөлт, мөн Хятадын эдийн засгийн өсөлт удааширснаас 2013 онд Монголын эдийн засгийн өсөлт 11.8% болон буурсан бөгөөд 2014 онд дээрх шалтгаануудын улмаас бүр ч буурах төлөвтэй байна. Монголын эдийн засгийн өсөлт буурч, удааширах явдлыг багасгасан хоёр хүчин зүйл байгаа нь 2014 онд Засгийн газраас авч хэрэгжүүлсэн санхүү, мөнгөний тэлэх бодлого болон Оюу Толгой уурхайгаас зэсийн баяжмалын экспорт аажмаар нэмэгдсэн явдал болно.

Монгол улсын экспортод уул уурхайн бүтээгдэхүүн ихээхэн давамгайлдгаас Монгол улсын эдийн засаг дэлхийн түүхий эд, бүтээгдэхүүний зах зээлийн шуурганаас ихээхэн хамааралтай, эмзэг байдаг гэдгийг дурдах нь зүйтэй. 2013 онд нийт экспортын 83%-ийг, 2012 онд 89%-ийг ашигт малтмалын экспорт тус тус эзэлж байв. Тиймээс, түүхий эд, бүтээгдэхүүний үнэ буурахад, экспортын хэмжээ буурч эдийн засгийн өсөлтөнд нэн даруй нөлөөлдөг. Үүн дээр нэмээд, Хятад



руу чиглэсэн түүхий эд, бүтээгдэхүүний, ялангуяа нүүрсний ложистикийн зардал болон татвар нь экспортын үнийн дүнгийн 50 гаруй хувийг эзэлж буй нөхцөл байдал нэмэр болж байна. Энэ нөлөөлөл нь цагаан тугалга, алт г.м. зарим өндөр үнэтэй, бага овортой түүхий эд бүтээгдэхүүний хувьд арай бага байдаг. Ашигт малтмалын хувьд дэлхийн үнийн тогтворгүй байдлаас зайлсхийх аргагүй юм. Тиймээс, Монголын ашигт малтмалын нөөц асар их ч, эдгээрийг хайж олж, олборлож, экспортлох шаардлагатай болно. Ашигт малтмалын бүтээгдэхүүний үнэ нь зөвхөн экспортын үнэ өртөгт нөлөөлөөд зогсохгүй, ашиглалтанд оруулахаар төлөвлөж байгаа уурхайнуудад оруулах хөрөнгө оруулалтанд нөлөөлдөг. Хэрвээ үнэ үйлдвэрлэлийн зардлаас бага хэмжээнд хүрэх тохиолдолд үйлдвэрлэлийг зогсооно. Ашигт малтмалын үнэ өндөр байх үед уул уурхайн хайгуул хийх, хөрөнгө оруулалт хийгдэх нөхцөл илүү өндөр байдаг ба мөн гадаадын хөрөнгө оруулалтын орчин ч таатай байдаг. Дараах нөхцөл байдал сүүлийн үеийн Монголын эдийн засагт нөлөөлөөд байна. Үүнд:

- Ашигт малтмалын экспортын үнэ цэнэ буурсан байдал;
- Хөрөнгө оруулалт болон уул уурхайн хуулиудад орсон өөрчлөлт хөрөнгө оруулалтыг дэмжээгүй нөхцөл байдал;
- Санхүүгийн болон төсвийн бодлого нь бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс хамаарсан байдал. Дунд хугацаанд Чили, Норвеги зэрэг ашигт малтмалаас хамааралтай улс орнууд нь ашигт малтмалын үнэ өндөр байх үед гадаад валютын урсгалаа тогтворжуулах арга замыг олсон бөгөөд ашигт малтмалын үнэ бага үед тус хуримтлуулсан тогтвортой хөрөнгөө ашигладаг байна. Мөн Засгийн газрын зардлыг бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс хамааруулан авч явах төсвийн сахилга батыг сахидаг. Урт хугацаанд, Чили зэрэг зарим улс орнууд нь эдийн засгаа олон бүтэцтэй болгон төрөлжүүлэх буюу хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарыг дэмжиж, боловсролын салбарт ихээхэн хөрөнгө оруулалт хийж чадсан байна.

Өсөлтийг чиглүүлэгч

Монгол улсын эдийн засаг ихээхэн өсөлттэй байсан ба энэ өсөлтийг бий болгоход олон хүчин зүйл нөлөөлсөн байдаг. Үүнд:

- *Ашигт малтмалын өндөр үнэ:* Эдийн засаг өндөр өссөн шалтгаан нь уул уурхайтай холбоотой томоохон гадны хөрөнгө оруулалт хийгдэж, ашигт малтмалын экспортын үнэ цэнэ өндөр, төр засгийн хөрөнгийн зарцуулалт өндөр байсан зэрэг байв.



- *Дэлхийн эдийн засгийн өсөлт:* Дэлхийн эдийн засгийн ерөнхий өсөлт, хөгжил ашигт малтмалын үнээр дамжуулан Монгол улсад ихээхэн чухал нөлөө үзүүлдэг. Ашигт малтмалыг аж үйлдвэрлэлд ашигладаг бол алтны хувьд үнэ цэнэтэй металл гэдэг утгаар ашиглаж ирсэн. Дэлхийн эдийн засгийн сүүлийн үеийн хөтлөгч нь БРИК эвслийн улс орнууд (Бразиль, Орос, Энэтхэг, Хятад) байж ирлээ. Монгол улсын хувьд, дэлхийн хэмжээний ашигт малтмалын ерөнхий хэрэглээ, эрэлт нийлүүлэлт, үнэ ханшийн чиг хандлага, Хятад улс дахь ашигт малтмалын үнэ ханш, чиг хандлага нь шууд нөлөө үзүүлдэг. Хятад улсын өсөлт хөгжил нь Монгол улсын экспортын үндсэн хөтлөгч хүчин зүйл болно. Эдийн засаг нь жилд ойролцоогоор 12% өсөж байгаа Хятад улс нь дэлхийн хэмжээний түүхий эд, ашигт малтмалын томоохон хэрэглэгч болно. Гэхдээ одоо тус улсын эдийн засгийн өсөлт нь ойролцоогоор 7.5% болж буурсан үзүүлэлттэй байна.
- *Гадаад хөрөнгө оруулалтын тэсрэлт:* Дэлхийн хэмжээнд уул уурхайн салбарт хийсэн хөрөнгө оруулалт бага байснаас ашигт малтмалын үнэ өссөн бол, ашигт малтмалын асар их нөөцтэй Монгол улс нь гадаадын хөрөнгө оруулалтыг татсан улс болж чадсан юм. Ашигт малтмал, түүхий эдийн үнэ өссөн оргил үе (2004-2008) болоод гадаадын хөрөнгө оруулалтын боломжийн бодлоготой байсан үед, Монгол улсад хийгдэж байсан гадаадын хөрөнгө оруулалт ДНБ-ий 40% байсан бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчдын хувьд ихээхэн эерэг үзүүлэлт билээ.
- *Дотоодын хөрөнгө оруулалтын бодлого:* Ашигт малтмалын үнийн тэсрэлтээс гадна, төр засгийн хөрөнгө оруулалт нь Монгол улсын эдийн засгийн өсөлтөнд нөлөөлж байв. Төрийн нийт зардал, хөрөнгө оруулалт нь 2011 онд ДНБ-ий 45%-ийг бүрдүүлсэн байдаг.

Уул уурхайн салбар нь экспорт, гадаад валют, татвар, төлбөрийн орлого, хөдөлмөр эрхлэлт, уул уурхайн салбарт бүтээгдэхүүн нийлүүлдэг ханган нийлүүлэлтийг дэмжих зэргээр эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулдаг. Тэсрэлтийн жилүүдэд, Монгол улсад тулгарсан өөр нэг хүчин зүйл бол инфляци, үнэ ханшийн уналт байв. Цаашлаад, валютын ханшийн хөдөлгөөн нь уул уурхайн салбарын бий болгосон валютын нөөцөөс хамаардаг өөр нэг хүчин зүйл юм. Уул уурхайн орлогоос хамааралтай дэлхийн олон улс орнууд олсон орлогоо зөв зохистой зарцуулахын оронд үр ашиггүй үрээд дуусдагаас, уул уурхайн тэсрэлт нь "хишиг буян" уу, эсвэл "хараал" уу гэсэн ерөнхий асуултыг эдийн засагчид тавьдаг.

Энэ тайлангийн хувьд уул уурхайн салбарын өсөлт Монгол улсын эдийн засгийн ерөнхий өсөлттэй хэрхэн холбогдож байгааг ойлгохыг зорив. Эдийн засгийн өсөлт хөгжлийн дээрх бүх 4 "чиглүүлэгч" нь Монгол улсын ашигт малтмалын үйлдвэрлэлийн мөн чанар, хэмжээ, төрөлд нөлөө үзүүлдэг бөгөөд ДНБ-д эзлэх ашигт малтмалын үйлдвэрлэлийн хувь хэмжээ нь тэсрэлтийн он жилүүдэд 25%-д хүрсэн байдаг.


Уул уурхайн салбарын хөгжилд нөлөөлөх эдгээр хүчин зүйлсээс гадна, тусгай зөвшөөрлийн талаарх аль нэг салбарт зориулсан бодлого, аль нэг тодорхой ашигт малтмалын чиглэлээрх гадаадын хөрөнгө оруулалт, дэд бүтцийн бодлого, хөрөнгө оруулалт, хот суурин газруудад хөрөнгө оруулалт хийх зэрэг нь тус салбарын өсөлт хөгжил ДНБ-д оруулах хувь нэмэрт нөлөөлдөг.

Ирээдүйд Монгол улсын эдийн засгийн өсөлтийн ямар хувилбарууд байж болох вэ? Монгол улсын эдийн засаг өндөр эсвэл бага түвшинд өсөхөд ямар чухал хүчин зүйлүүд нөлөөлөх вэ? Үүнд, гадаад хүчин зүйлүүд нь дэлхийн түүхий эд, бүтээгдэхүүний үнэ болон Монгол улсын гадаадын хөрөнгө оруулалтыг татах чадвараас ихээхэн хамаарахаар байна.

3.2 БОНСУ-Д АВЧ ҮЗСЭН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ХУВИЛБАРУУД

Талуудтай зөвлөлдөх явцад, оролцогч талуудад 3 хувилбарыг танилцуулсан бөгөөд эдгээр нь дундаж, өндөр, бага өсөлттэй хувилбарууд байв.

Энэхүү БОНСУ-ий хувьд эдгээр 3 өөр өсөлт, хөгжлийн хувилбаруудтай холбогдон гарах байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөллийг бодитоор тодорхойлох нь хамгийн хүндрэлтэй асуудал байв. Эдгээр нөлөөллийг тодорхойлохын тулд өөр өөр өсөлт, хөгжлийн хувилбарууд нь аливаа нэг бүтээгдэхүүн, түүхий эдийг тодорхой хугацаанд үйлдвэрлэж, нийлүүлнэ гэж авч үзэж болох юм. Улмаар, эдгээр хэмжээний бүтээгдэхүүн, түүхий эдийг үйлдвэрлэж гаргахад шаардлагатай уурхайн тоог тооцоолон гаргая. Бид ерөнхийдөө эдгээр нөөц баялаг хаана байгааг мэдэх тул байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөллийн талаар таамаглал дэвшүүлж чадах юм. Энэ санаа болон Дэлхийн эдийн засгийн форум байгууллагаас Монгол улсын хөгжлийн талаар гаргасан хувилбаруудад үндэслэн энэхүү үнэлгээнд авч үзэх хөгжлийн хувилбаруудыг боловсруулсан болно (Дэлхийн эдийн засгийн форум, 2014). Зураг 3.1-т БОНСУ-д авч үзсэн хувилбаруудыг боловсруулахад ашигласан үндэслэлийг тайлбарлав.



Зураг 3.1 БОНСУ-нд авч үзсэн уул уурхайн салбарын хөгжлийн хувилбарууд



3.2.1 2025 он хүртэл дундаж өсөлттэй байх хувилбар

Дундаж өсөлттэй байх хувилбараар, 2025 он хүртэл хууль эрх зүйн орчны дараах таатай нөхцөл бүрдэнэ хэмээн таамаглав. Үүнд:

- Монголын хөрөнгө оруулалтын чиглэлийн хуулиуд нь хөрөнгө оруулагчдад ээлтэй байх бөгөөд уул уурхайн хуулиуд батлагдсан байна¹⁶;
- Оюу Толгойн асуудлууд шийдэгдэж уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллана;
- Засгийн газрын зардал болон санхүүгийн алдагдал тогтвортой болон боломжийн хэмжээнд байна (Монгол улсын Хөгжлийн банк өр төлөх чадвартай байна).
- Эдгээр дотоод бизнесийн нөхцлөөс гадна, Хятад улсын эдийн засаг ирэх 10 жилийн хугацаанд дундаж хэмжээнд өсөж, эдийн засаг нь гадагшаа хандсан болон хөрөнгө оруулалтанд тулгуурласан эдийн засгийн хэлбэрээр дотоодын хэрэглээнд тулгуурласан өсөлт бүхий эдийн засгийн хэлбэр рүү шилжин орж, тогтворжсон байхаар таамаглаж байна. Энэ нь түүхий эд бүтээгдэхүүний хэрэглээний хэмжээ буурахад хүргэж, дэлхийн хэмжээнд түүхий эд бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ буурч, дэлхийн түүхий эд бүтээгдэхүүний үнэнд Хятад улсын зүгээс үзүүлэх нөлөөллийг бууруулна.

Дундаж өсөлттэй байх хувилбарын хүрээнд олон таамаглалыг дэвшүүлсэн (Хүснэгт 3.1-ийг үзнэ үү). Үүнд, түүхий эд бүтээгдэхүүний үнийн хувьд, ОУВС-ийн металлын индекс 180 (зэсийн үнийг метр тоннд 7200 ам.доллараар тооцсон) болон нүүрсний индекс 178 (үнэ нь метр тоннд 90 ам.доллараар тооцсон) зэргийг ашиглав (Олон улсын валютын сан, 2014). Дэлхийн эдийн засгийн өсөлтийн хувьд (Хятад улсыг оролцуулан) 3%-ийн өсөлттэй байхаар таамагласан бөгөөд энэ нь аж үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэл болон эрчим хүчний эрэлт хэрэгцээ нэмэгдсэнээр ашигт малтмалын хэрэглээг улам бүр нэмэгдүүлнэ (ЭЗХАХБ, 2012). Уул уурхайн салбарын бодлогыг оролцуулан сүүлийн үед гадаадын хөрөнгө оруулалтын орчны талаар сөрөг уур амьсгал, бодлого шийдвэрүүд гарах болсонтой холбоотойгоор ДНБ-д эзлэх гадаадын хөрөнгө оруулалтыг 40% байна гэж таамаглав. Одоогийн хязгаарлагдмал гадаад нөхцөл байдал, олон улсын зах зээл дээр гаргасан бондыг оролцуулсан Засгийн газрын өр шир дээр үндэслэн ДНБ-д эзлэх Засгийн газрын зардлыг 45% байхаар тооцлоо.


¹⁶ 2012 оны Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль нь уул уурхайн бодлогын орчинд одоог хүртэл хамгийн их сөргөөр нөлөөлсөн бодлого байв. Энэ хуулиар стратегийн ач холбогдолтой салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аливаа компанийн хувьцааны 33%-ийг олж авах эрхтэй хэлцэл, стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүний олонхийг томилох болон төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний олонхийг аливаа нөхцөлгүйгээр сонгох эрхтэй болох хэлцэл, стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн удирдлагын шийдвэрт хориг тавих боломжтой болох хэлцэл, олон улсын болон Монгол улсын уул уурхайн түүхий эд, бүтээгдэхүүний зах зээлийн арилжаанд худалдан авагчийн болон борлуулагчийн монополь тогтоож магадгүй хэлцэл, Монгол улсын уул уурхайн экспортын бүтээгдэхүүний зах зээл, үнийн түвшинд шууд болон шууд бусаар нөлөөлж болзошгүй хэлцэл, стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж болох компанид эзэмшдэг хувьцааны хэмжээ нь буурах үр дагавар бүхий гэрээ хэлцэл зэргийг төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрөх ёстой болсон. Мөн энэ хуулийн 4.7-р заалтаар стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа эрхлэх, эсхүл үйл ажиллагаа явуулж байгаа 100 тэмбум төгрөгийн үнэ цэнэтэй (2012 оны байдлаар 76 сая ам.доллар) аж ахуйн нэгжийн гадаадын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хөрөнгө оруулагчийн эзэмших хувь хэмжээ 49 хувиас илүү гарах тохиолдолд Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж заасан байна.




Дээрх таамаглалын дагуу, ДНБ дэх ашигт малтмалын эзлэх хувийг (үйлдвэрлэл) 25% байхаар таамагласан. Хэрвээ бид дээрх байдлаар таамаглах аваас, дундаж өсөлттэй байх хувилбарын өсөлтийг дүн шинжилгээний зорилгоор ойролцоогоор 8% байхаар таамаглаж болно. Цаашлаад хэрэв бид 10 жил тутам болдог эдийн засаг, санхүүгийн хямралыг үл тооцвол энэ нь ОУВС (Олон улсын валютын сан, 2014) болон Дэлхийн банкны (Дэлхийн банк, 2014) Монгол улсын талаар гаргасан төсөөлөл таамаглалын дагуу боломжийн өсөлтийн хувь хэмжээнд орох юм.

Дундаж өсөлттэй хувилбарын хүрээнд Хүснэгт 3.2-д харуулсан хэмжээний ашигт малтмалыг үйлдвэрлэнэ хэмээн таамаглаж байна. Энэ төсөөллийг Уул уурхайн яам одоо үйл ажиллагаа явуулж буй уурхайн хүчин чадалд үндэслэн боловсруулсан юм. Тиймээс, дундаж өсөлттэй хувилбарын хувьд одоо ажиллаж байгаа нийт 330 уурхай¹⁷ эдгээр заасан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ хэмээн таамаглалаа. Энэхүү 330 уурхай олборлолт явуулан бүрээгдэхүүн экспортолсноор ашигт малтмалын үйлдвэрлэл ДНБ-ий 25%-ийг бүрдүүлнэ хэмээн таамаглаж байна. Уг тооцоо нь Хавсралтын хүснэгт В.3-д харуулсан уурхайн тоо (уурхайн төрөл, байршлыг аймгийн хэмжээнд мөн харуулав)-г тусгасан болно. Дундаж өсөлттэй хувилбарын хувьд зэс, молибден, алт, төмөр, жонш, гөлтгөнө, хар тугалга, гантиг, хүхэр, цагаан тугалга, гянтболд, цайр, газрын тос, нүүрс, барилгын материал зэрэг олон төрлийн ашигт малтмал олборлохоор байна. Уул уурхайн салбарт ашиглагдах дэд бүтцийн хувьд шинээр дэд бүтэц баригдахгүй бөгөөд одоо байгаа дэд бүтцийг ашиглана. Зураг 3.2-т дундаж өсөлттэй байх уул уурхайн салбарын дүр зургийг харуулав.

¹⁷ Одоогоор хүчин төгөлдөр уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоонд үндэслэв.



<p>ХӨГЖЛИЙН ХУВИЛБАР ДУНДАЖ ӨСӨЛТ: 2025 ОН</p> <p>0 100 200 km АЗ дээрх М 1:6,000,000 UTM (Zone 48N)</p> 	<p>ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ Одоо ажиллаж байгаа уурхай - АМГ (Мета өгөгдөл - 2014) Улсын хил, аймгийн хил - БОАЖЯ (Мета өгөгдөл - 1942/1:500,000) Төмөр зам, зам - БОАЖЯ (Мета өгөгдөл - байхгүй) Хилийн боомт - Састэйнабилити Ийст Эйжия ХХК (Мета өгөгдөл - Google Earth) Цахилгаан станц - ЭХЯ (Мета өгөгдөл - 2014)</p>	<p>ТАНИХ ТЭМДЭГ Ажиллаж байгаа уурхай (уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоонд үндэслэсэн уурхайн тоо, 330)</p> <table border="0"> <tr> <td>■ Зэс, молибден (2)</td> <td>▲ Төмөр (20)</td> <td>⊕ Цагаан тугалга (3)</td> <td>⊞ Цахилгаан станц</td> </tr> <tr> <td>● Алт, зэс (2)</td> <td>⊕ Гөлтгөнө (2)</td> <td>⊗ Гянтболд (4)</td> <td>⊞ Хилийн боомт</td> </tr> <tr> <td>● Молибден (1)</td> <td>⊕ Хар тугалга (2)</td> <td>⊗ Цайр (1)</td> <td>— Зам</td> </tr> <tr> <td>■ Жонш (56)</td> <td>⊕ Гантг (1)</td> <td>⊗ Барилгын материал (64)</td> <td>— Төмөр зам</td> </tr> <tr> <td>● Алт (76)</td> <td>⊕ Хүхэр (1)</td> <td>⊗ Газрын тос (2)</td> <td>— Аймгийн хил</td> </tr> <tr> <td></td> <td></td> <td>● Нүүрс (93)</td> <td>— Монгол Улсын хил</td> </tr> </table>	■ Зэс, молибден (2)	▲ Төмөр (20)	⊕ Цагаан тугалга (3)	⊞ Цахилгаан станц	● Алт, зэс (2)	⊕ Гөлтгөнө (2)	⊗ Гянтболд (4)	⊞ Хилийн боомт	● Молибден (1)	⊕ Хар тугалга (2)	⊗ Цайр (1)	— Зам	■ Жонш (56)	⊕ Гантг (1)	⊗ Барилгын материал (64)	— Төмөр зам	● Алт (76)	⊕ Хүхэр (1)	⊗ Газрын тос (2)	— Аймгийн хил			● Нүүрс (93)	— Монгол Улсын хил
■ Зэс, молибден (2)	▲ Төмөр (20)	⊕ Цагаан тугалга (3)	⊞ Цахилгаан станц																							
● Алт, зэс (2)	⊕ Гөлтгөнө (2)	⊗ Гянтболд (4)	⊞ Хилийн боомт																							
● Молибден (1)	⊕ Хар тугалга (2)	⊗ Цайр (1)	— Зам																							
■ Жонш (56)	⊕ Гантг (1)	⊗ Барилгын материал (64)	— Төмөр зам																							
● Алт (76)	⊕ Хүхэр (1)	⊗ Газрын тос (2)	— Аймгийн хил																							
		● Нүүрс (93)	— Монгол Улсын хил																							

Зураг 3.2 Дундаж өсөлтийн хувилбарыг харуулсан зураг

Хүснэгт 3.2 Дундаж өсөлттэй хувилбарын хүрээнд үйлдвэрлэх ашигт малтмалын тоо хэмжээ, 2013-2025 он¹⁸

Ашигт малтмал	Хэмжих нэгж	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Түүхий нефть	Сая тонн	772.9	1141.8	1345.8	1438.2	1483.4	1487.1	1496.1	1513.3	1517.7	1540.9	1562.8	1579.1	1591.7
Нүүрс	Сая тонн	33.3405	41.7923	50.5561	54.4641	57.9062	57.9062	57.9062	57.9062	66.3547	69.7188	73.0025	76.2876	79.6518
Төмрийн хүдэр	Сая тонн	8	10	10	10	10	10	10	10	10	10	10	11	11
Зэсийн баяжмал, 35%	Сая тонн	1	1.2	1.3	1.8	2.3	3.4	3.5	3.2	4	4.4	4.8	5.2	5.6
Жонш	Сая тонн	0.294	0.2940	0.2940	0.3675	0.3675	0.3675	0.4900	0.4900	0.4900	0.4900	0.4900	0.4900	0.4900
Цайрын баяжмал	Сая тонн	0.0956	0.0956	0.0956	0.0905	0.0905	0.0905	0.0905	0.0905	0.0883	0.0874	0.0864	0.0855	0.0846
Алт	Сая тонн	0.000000 018	0.000000 030	0.000000 019	0.000000 029	0.000000 022	0.000000 036	0.000000 030	0.000000 024	0.000000 030	0.000000 031	0.000000 032	0.000000 0033	0.000000 0034
Молибдений баяжмал, 47%	Сая тонн	0.0047	0.0052	0.0058	0.0057	0.0057	0.0057	0.0055	0.0055	0.0058	0.0059	0.0060	0.00612	0.0062
Зэс, 99%	Сая тонн	0.00264	0.00264	0.00264	0.00264	0.00264	0.00264	0.00264	0.00264	0.00264	0.00264	0.00264	0.00264	0.00264
Гянтболд	Сая тонн	0.000000 15	0.000000 150	0.000000 150	0.000000 150	0.000000 150	0.000000 150	0.000000 150	0.000000 150	0.000000 150	0.000000 150	0.000000 150	0.000000 0150	0.000000 0150
Нийт	Сая тонн	815.6374 402	1195.189 74	1408.054 14	1504.930 44	1554.072 54	1558.872 54	1568.094 84	1584.994 84	1598.641 44	1625.604 74	1651.187 54	1672.17 186	1688.53 524

Эх сурвалж: Уул уурхайн яамны Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс, 2013

¹⁸ Дундаж өсөлттэй хувилбарын хувьд 2013 оноос цааш олборлохоор төсөөлж буй ашигт малтмалын тоо хэмжээг Уул уурхайн яамны тооцоолсноор авч ашиглав. Таамагласан бүтээгдэхүүний хэмжээг тонноор илэрхийлэн харууллаа. Зарим ашигт малтмалын олборлохоор төсөөлсөн тоо хэмжээ нь дэлхийн зах зээл дээр борлуулагдаж буй тухайн ашигт малтмалын тоо хэмжээтэй уялдахгүй байж болохыг анхаарсан болно. Дундаж өсөлттэй хувилбарын хүрээнд 2013-2025 оны хооронд үйл ажиллагаа явуулахаар төсөөлж буй нийт уурхайгаас олборлох ашигт малтмалын тоо хэмжээ нь энэхүү БОНСУ-ий хувьд хамгийн чухал байв. Түүнчлэн, дундаж өсөлттэй хувилбарын хувьд Уул уурхайн яамны боловсруулсан тус өгөгдлийг авч ашиглахдаа эдгээр төсөөлөл нь нилээд өөдрөг буюу бүтээгдэхүүний хэмжээг өндрөөр тооцсон байгааг анхааран үзсэн ба дээрх тоо хэмжээ нь дундаж өсөлттэй байх үед бодит байдал дээр энэ хэмжээнээс бага түвшинд байж болзошгүй тухайд мөн санал нийлж байна. Энэхүү БОНСУ-ий хувьд хамгийн чухал нь олборлох бүтээгдэхүүний хэмжээнд тохирсон уурхайн тоо, байршил болон эдгээр байршилд буй уурхайн үйл ажиллагаанаас үзүүлэх байгаль орчин, нийгмийн нөлөөллийг тодорхойлох асуудал байсан тул энэ асуудлыг тайланд илүү анхааран үзсэн болно.



3.2.2 2025 он хүртэл өндөр өсөлттэй байх хувилбар

Өндөр өсөлттэй хувилбарын хувьд зэс, нүүрсний үнэ ханшийг өндрөөр, дэлхийн эдийн засгийн өсөлтийг 4%, ерөнхий эдийн засгийн болон уул уурхайн салбарын гадаад хөрөнгө оруулалтын орчин илүү сайн байхаар таамагласан бөгөөд улмаар гадаадын хөрөнгө оруулалт ДНБ-ий 50%-д хүрч, өөр бусад хөтөлөгч хүчин зүйл нэмэгдсэнээр ДНБ-д эзлэх уул уурхайн бүтээгдэхүүний хувь хэмжээ 35% хүрч өснө хэмээн төсөөллөө. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар¹⁹, Засгийн газрын зардал, зээлийг хязгаарлах тул Засгийн газрын зардлыг ДНБ-ий 45% байхаар авч үзсэн. Ингэснээр, 12 жилийн хугацаанд өсөлтийг дунджаар 11% байна хэмээн таамаглаж байна. Мөн энэ хувилбарын хүрээнд, Засгийн газар хувийн хэвшилтэй хамтран дэд бүтэц, аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх томоохон хэмжээний хөрөнгө оруулалтыг хийнэ гэж үзлээ.

ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагууд нь сайн макро болон үр дүнтэй менежментийн “хүчтэй бодлогын” хувилбарын дагуу Монгол улсын дунд хугацааны төлөв байдал ихээхэн өөдрөг байна гэсэн төсөөлөл таамаглалыг дэвшүүлээд байгаа юм. Монгол улсын байгалийн баялгийн асар их нөөц болон бүс нутаг дахь эдийн засгийн хамгийн өндөр өсөлттэй улс орнуудад ойрхон байршил зэрэг нь хөгжих боломжийг бий болгож байна. Оюу Толгойн ил уурхайн зэсийн үйлдвэрлэл эхэлж, Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт хийгдэж, Таван Толгойн уурхайн нүүрсний олборлолт тогтмол явагдсанаар 2013-2017 оны хооронд ашигт малтмалын ДНБ-д эзлэх хувь дунджаар жилийн 16% байхаар таамаглаж байна. Уул уурхайгаас бусад салбарууд тогтвортой байна гэж таамаглаж болох бөгөөд гэхдээ үүний тулд эдгээр салбарыг эдийн засгийн суурь болон бизнесийн орчинг бэхжүүлж, шинэчлэх бодлогоор дэмжих шаардлагатай болно (Олон улсын валютын сан, 2014). Өндөр өсөлттэй хувилбарын хувьд, Монгол улсын Засгийн газрын хөгжлийн стратегид одоо байгаа төрийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх асуудал багтан орох бөгөөд үүнд гадны зээлээр санхүүжүүлэх тээврийн дэд бүтэц орно. Энэхүү дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эдийн засгийн хурдацтай өсөлт болон буцаж сэргэсэн экспортын орлогоор тогтвортой түвшинд барьж хөгжүүлнэ. Өндөр өсөлттэй хувилбарын хувьд эдийн засгийн өсөлтийг тогтвортой түвшинд барих үүднээс санхүүгийн тогтвортой байдлын талаарх хуулиудыг дагаж мөрдөнө хэмээн таамаглаж байна.

¹⁹ 2008-2009 оны хооронд төлбөрийн тэнцэл алдагдах хямрал үүссэний дараагаар 2010 онд Монгол улс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталсан юм. Энэ хууль нь байгалийн нөөцийг зөв зохиистой, хянамгай ашиглах болон удирдахад тулгарч буй бэрхшээл хүндрэл, тэр дундаа макро эдийн засгийн тогтвортой байдал, үнэ ханшийн хэт өсөлт, төр засгийн зүгээс оруулж буй хөрөнгө оруулалт болон түүний үр ашигтай байдал, нөөцийг тогтвортой ашиглах асуудлыг зохицуулахыг зорьсон байна. Уг хуулийг боловсруулахад ОУВС-аас ихээхэн хувь нэмэр оруулсан юм (Олон улсын валютын сан, 2014).




Мөн энэ хувилбараар Монгол улсын Засгийн газар нь үйлдвэрлэлийн өндөр түвшинд хүрч, өртөг нэмсэн ашигт малтмалын бүтээгдэхүүнүүд (салбар дундын болон хоорондын өртгийн сүлжээг хөгжүүлэх нүүрс, алт, зэс, жонш ²⁰) үйлдвэрлэхээр төсөөллөө.

Өндөр өсөлттэй хувилбарын хүрээнд үйлдвэрлэл, экспортын хэмжээ өсөж уурхайн тоо 589 хүрэх ба ашигт малтмалын үйлдвэрлэл ДНБ-ий 35%-ийг бүрдүүлнэ хэмээн таамаглалаа. Дундаж өсөлттэй хувилбарын хувьд үйл ажиллагаа явуулах 330 ²¹ уурхай дээр өндөр өсөлттэй хувилбарын хүрээнд 2025 он хүртэл 259²² шинэ уурхай нэмэгдэхээр төсөөлж байна. Нөөц нь тогтоогдсон эсвэл техник-эдийн засгийн үндэслэл нь батлагдсан ордуудыг шинээр нээгдэж болзошгүй уурхайн тоонд орууллаа. Энэ хувилбарын үед зэс, молибден, алт, төмөр, жонш, гөлтгөнө, хар тугалга, гантиг, хүхэр, цагаан тугалга, хөнгөн цагаан, циолит, гянтболд, цайр, газрын тос, нүүрс, барилгын материал зэрэг ашигт малтмалууд олборлохоор төсөөлсөн ба уурхайнуудын тоо, байршлыг **Хавсралт В**-д дэлгэрэнгүй харуулав. Зураг 3.3-т өндөр өсөлттэй байх уул уурхайн салбарын дүр зургийг харуулсан ба уурхайн үйлдвэрлэлд шаардлагатай нэмэлт дэд бүтцийн байршлыг мөн зурагт үзүүллээ. Уул уурхайн салбарын өсөлт өндөр байх үед тус салбарын үйл ажиллагаатай холбогдуулан одоогоор төлөвлөөд буй бүх дэд бүтэц баригдана хэмээн төсөөлөв. Үүнд, Төмөр замын бодлогын хүрээнд төлөвлөгдсөн төмөр зам, техник-эдийн засгийн үндэслэл нь батлагдаад буй хувийн хэвшлийн санаачилсан ашигт малтмал тээвэрлэх зам болон 7 шинэ цахилгаан станц багтаж байгаа юм.

²⁰ Уул уурхайн яамны мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагад тулгуурлав. Монгол улсын Засгийн газрын холбогдох эх сурвалжуудын мэдэгдэж байгаагаар өндөр өсөлттэй хувилбарын хувьд эдгээр үйл ажиллагааг санхүүжүүлэх бие даасан баялгийн сан байгуулагдана үзэж байна. Түүнчлэн энэ сан нь занарын тос, түүхий нефть боловсруулах үйлдвэр, нүүрснээс шингэн түлш гаргаж авах төсөл, үйлдвэр, шугам хоолойгоор дамжуулан SINOPEC, Хятад улсын газрын тос, химийн корпораци компани руу экспортлох илүүдэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэрэгт хөрөнгө оруулалт хийнэ. Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Монгол улсын Засгийн газарт зориулан 2010 оны 6-р сард боловсруулсан "Mongolia Industrialization and Downstream Processing Study" судалгааны тайлангаас дээрх үйлдвэрүүдийн байршлуудыг харж болно. Өндөр өсөлттэй хувилбарын үед Монгол улсын Засгийн газар нь уран экспортлоно гэж мөн тооцож байна.

²¹ Одоогоор хүчин төгөлдөр уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоонд үндэслэв.

²² Шинээр бий болох уурхайн тоо нь одоо байгаа уурхай болон хайгуулын лицензийн тоонд үндэслэгдэв.



ХӨГЖЛИЙН ХУВИЛБАР
ӨНДӨР ӨСӨЛТ: 2025 ОН

0 100 200
км

АЗ дээрх М 1:6,000,000
UTM (Zone 48N)

SUSTAINABILITY
EAST ASIA LLC

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Ажиллаж байгаа уурхай - АМГ (Мета өгөгдөл - 2014)
Улсын хил, аймгийн хил -
БОАЖЯ (Мета өгөгдөл - 1942/1:500,000)
Төмөр зам, зам - БОАЖЯ, ЗТЯ (Мета өгөгдөл - байхгүй)
Хилийн боомт - Састэйнабилити Ийст Эйжия ХХК
(Мета өгөгдөл - Google Earth)
Цахилгаан станц - ЭХЯ (Мета өгөгдөл - 2014)

ТАНИХ ТЭМДЭГ
Ажиллаж байгаа уурхай (уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоонд үндэслэсэн уурхайн тоо, 589)

● Газрын тос	⊕ Холимог металл (2)	⊗ Гянтболд (4)	⊗ Цеолит (1)	⊕ Цахилгаан станц
● Нүүрс (136)	⊕ Төмөр, холимог металл (1)	⊙ Цайр (2)	⊕ Гангиг (1)	⊕ Хилийн боомт
■ Зэс, молибден (2)	● Алт, мөнгө (1)	⊕ Барилгын материал (107)	⊕ Хүхэр (1)	— Зам
● Алт, зэс (4)	● Алт (114)	⊕ Гөлтгөнө (2)	⊕ Цагаан тугалга (4)	— Төмөр зам
● Молибден (2)	▲ Төмөр (26)	⊕ Хар тугалга (3)	⊕ Шинээр бий болох уурхай (97)	⊕ Аймгийн хил
● Зэс (1)	■ Жонш (75)	⊕ Хөнгөн цагаан (1)		⊕ Монгол Улсын хил

Зураг 3.3 Өндөр өсөлтийн хувилбарыг харуулсан зураг

(

]



3.2.3 2025 он хүртэл бага өсөлттэй байх хувилбар


Бага өсөлттэй байх хувилбарын хувьд эдийн засгийн өсөлт дунджаар 6.5% байх хэмжээнд хүрч буурахад олон хүчин зүйлс нөлөөлнө. Үүнд, ирэх 10 жилийн хугацаанд бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ бага байх тохиолдолд дэлхийн эдийн засгийн өсөлт 2.5% хүртэл буурч, гадаад хөрөнгө оруулалтын орчин муудсаны улмаас, гадаадын хөрөнгө оруулалт ДНБ-д эзлэх хувь 20 болж буурна. Энэ нь Засгийн газрыг зардлаа ДНБ-д 35% хүргэж бууруулахад хүргэх бөгөөд төсвийн алдагдал улам бүр нэмэгдэнэ (одоогийн байдлаар 12%-тай байгаа). Ийм таамаглалаар бага өсөлттэй байх хувилбарын хувьд эдийн засгийн өсөлт дунджаар 6.5%, ДНБ-д уул уурхайн бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээ 15% болж тус тус буурна.

Энэ хувилбараар уул уурхайн салбарын бодлогын орчин сайжраагүй, улс төрийн орчинд “баялгаа өмчлөх үндсэрхэх үзэл” дахин гарч ирснээр цаашдын маргаан, зөрчил улам бүр нэмэгдсэн байна гэж таамаглалаа.

Бага өсөлттэй хувилбарын хувьд, түүхий эд, бүтээгдэхүүний гадаад эрэлт хэрэгцээ сул хэвээр байгаагаас үүдэлтэйгээр уул уурхайн экспортын орлого улам бүр буурна. Ихэнх өндөр хөгжсөн улс орнууд ихээхэн дэмжлэгийг хүлээн сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн мөнгөний бодлогоосоо татгалзана. Хятадын эдийн засаг хөрөнгө оруулалтанд илүү тулгуурласан өсөлтийн загвараасаа зайлсхийж, ашигт малтмалын хэрэглээнд ихээхэн нөлөө үзүүлэх, илүү их хэрэглээнд тулгуурласан өсөлтийн загвар руу шилжих таамаглал байна. Энэ хоёр хүчин зүйл нь дэлхийн хэмжээнд, ялангуяа Хойд Азийн бүс нутгийн хэмжээнд ихээхэн нөлөө үзүүлнэ гэж үзлээ. Хятад улс нь Монголын экспортын 90%-ийг бүрдүүлж байгаа учраас ОУВС (Олон улсын валютын сан, 2014) болон Дэлхийн банк (Дэлхийн банк, 2013) саяхны тайлан мэдээндээ Монгол улсыг Хятад улсын өөрийн эрэлт хэрэгцээг өөрчлөх үйл явцад хамгийн их өртөх магадлалтай эмзэг улсуудын тоонд оруулсан байна. Хятад улсын өсөлт удааширч байгаа нь Монголд худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалт, уул уурхайн салбарын эдийн засгийн өсөлтөнд оруулж буй хувь нэмэр зэрэг асуудалд²³ нөлөөлнө.

Бага өсөлттэй хувилбарын хүрээнд бүтээгдэхүүний олборлолт, экспорт буурч нийт 165 уурхай ажиллаж, ашигт малтмалын үйлдвэрлэл ДНБ-ий 15%-д хүрч буурна хэмээн таамаглалаа. Өмнө дурдсанчлан бага өсөлттэй хувилбарын үед бүтээгдэхүүний үнэ дараагийн 10 жилд бага байна. Тиймээс, жонш, гөлтгөнө, хар тугалга, гантиг, хүхэр, цагаан тугалга, гянтболд, цайр зэрэг ашигт малтмалын эрэлт байхгүй болсноор энэ төрлийн уурхай ажиллахгүй. Нүүрсний экспорт буурах ч одоо байгаа 93 нүүрсний уурхайнаас орон нутгийн хэрэглэгчдэд нүүрс нийлүүлдэг 38 уурхай ажиллаж үлдэнэ хэмээн таамаглав. Түүнээс гадна, орон сууцны хэрэгцээ байсаар байх тул хотуудтай ойр байрлах одоо байгаа барилгын материалын уурхайнуудаас тал нь үйл ажиллагаа явуулсаар байна. Энэ хувилбарын үед зэс, молибден, алт, төмөр, жонш, газрын тос, нүүрс, барилгын материал зэрэг ашигт малтмалын уурхайнууд олборлолт явуулах ба уурхайнуудын тоо, байршлыг **Хавсралт В**-д харуулав. Уул уурхайн салбарт ашиглагдах дэд бүтцийн хувьд шинээр дэд бүтэц баригдахгүй бөгөөд одоо байгаа дэд бүтцийг ашиглана. Зураг 3.4-т уул уурхайн салбар бага өсөлттэй байх үеийн уурхайн байршил, дэд бүтцийн байдлыг харуулав.

²³ Бага өсөлттэй хувилбарын хувьд гадаад өр ширнээс болж төлбөрийн тэнцэл алдагдах шинж тэмдэг гарах үед ОУВС Монгол улсын эдийн засгийг тогтворжуулахаар туслана гэж үзэж болох юм.



ХӨГЖЛИЙН ХУВИЛБАР
БАГА ӨСӨЛТ: 2025 ОН

0 100 200
 km

АЗ дээрх М 1:6,000,000
 UTM (Zone 48N)



ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Ажиллаж байгаа уурхай - АМГ (Мета өгөгдөл - 2014)
 Улсын хил, аймгийн хил - БОАЖЯ (Мета өгөгдөл - 1942/1:500,000)
 Төмөр зам, зам - БОАЖЯ (Мета өгөгдөл - байхгүй)
 Хилийн боомт - Састэйнабилити Ийст Эйжия ХХК (Мета өгөгдөл - Google Earth)
 Цахилгаан станц - ЭХЯ (Мета өгөгдөл - 2014)

ТАНИХ ТЭМДЭГ
 Ажиллаж байгаа уурхай (уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоонд үндэслэсэн уурхайн тоо, 165)

● Газрын тос (2)	■ Молибден (1)	⚡ Цахилгаан станц
● Нүүрс (38)	▲ Төмөр (12)	⦶ Хилийн боомт
● Алт, зэс (2)	● Алт (76)	— Зам
■ Зэс, молибден (2)	○ Барилгын материал (32)	— Төмөр зам
		⦶ Аймгийн хил
		⦶ Монгол Улсын хил

Зураг 3.4 Бага өсөлтийн хувилбарыг харуулсан зураг

(


]



4. ГОЛ АСУУДЛУУД БА АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖҮҮД

4.1 ТАНИЛЦУУЛГА: ХӨГЖЛИЙН ХУВИЛБАР, ГОЛ АСУУДАЛ БОЛОН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ ХООРОНДЫН УЯЛДАА ХОЛБОО

Уул уурхайн салбарт үүсэх холбогдох нөлөөллийг тодорхойлж, нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмжүүдийг боловсруулахын тулд энэхүү 4-р бүлэгт өмнөх 3-р бүлэгт авч үзсэн уул уурхайн хөгжлийн хувилбаруудтай холбоотой бий болох эн тэргүүний асуудлуудыг үнэллээ. Зураг 4.1-т өсөлтийн хувилбарууд болон байгаль орчин, нийгэм-эдийн засгийн нөлөөлөл хоорондын уялдаа холбоог дүрслэн харуулав.



Зураг 4.1 Хувилбар бүрийн хувьд бий болох нөлөөлөл, уялдаа холбоо

БОНСУ-ий багийн хийсэн уул уурхайн салбартай холбоотой байгаль орчин, нийгэм-эдийн засгийн гол гол асуудлыг тодорхойлсон нөхцөл байдлын үнэлгээ буюу 2-р бүлэгт дурдагдсан асуудлуудад үндэслэн энэхүү бүлэгт орсон үр дүнг боловсрууллаа. Эдгээр 12 эн тэргүүний асуудлуудыг БОНСУ-ий бүхий л үйл явцын турш холбогдох талуудтай хийсэн хэлэлцүүлгээр баталгаажуулж, дэлгэрүүлэн судалж улмаар эцэслэн тодорхойлсныг энэ бүлэгт танилцуулав.

Хүснэгт 4.1 Эн тэргүүний 12 асуудлууд

Байгаль орчны асуудлууд	Ус
	Газар, бэлчээрийн ашиглалт
	Агаарын чанар
	Байгаль орчны менежмент
Нийгмийн асуудлууд	Хувиараа болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа
	Соёлын өв
	Хүний эрх, орон нутгийн оролцоо
	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
Эдийн засгийн асуудлууд	Засаглал, орлогын менежмент
	Бүс нутгийн төлөвлөлт, тээврийн дэд бүтэц
	Хөдөлмөр эрхлэлт, ур чадвар
	Технологи

Хүснэгт 4.2-д хэлэлцүүлгийн явцад тодруулсан болон БОНСУ-ий багаас асуудлыг эрэмбэлэх аргыг ашиглан үнэлгээ хийн тодорхойлсон эн тэргүүний асуудлууд тухайн хувилбар бүрийн хувьд хэр их нөлөөтэй, ач холбогдолтой байгааг үнэлэн харууллаа. Өөрөөр хэлвэл,



хэлэлцүүлгүүдийн үеэр талуудтай зөвлөлдөх замаар хөгжлийн 3 хувилбар бүрийн хувьд улс, аймаг, сумын түвшинд үүсэх эн тэргүүний 5 асуудлыг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөлөөлөл, газар зүйн хамрах хүрээ, хүн амд үзүүлж буй нөлөөллийн цар хүрээ, хэмжээ зэрэг чанарын хүчин зүйлс ашиглан үнэлэн тодорхойлсон юм. Хамгийн эн тэргүүний чухал хэмээн 1, 2-р байранд эрэмбэлэгдсэн асуудлуудын нөлөөллийн эрчмийг их, 3, 4, 5-р байранд эрэмбэлэгдсэн чухал асуудлуудын эрэмбийг дунд, харин хамгийн эн тэргүүний 5 асуудал хэмээн эрэмбэлэгдээгүй ч БОНСУ-ий багаас, эсвэл талуудын чухал хэмээн үзсэн асуудлын нөлөөллийн эрчмийг бага буюу бага нөлөөлөл үзүүлнэ хэмээн тодорхойлов. Доорх хүснэгтэд асуудлыг эрэмбэлэх аргыг тайлбарласаныг харна уу.

Хүснэгттэй танилцахдаа тухайн асуудал эерэг, эсвэл сөрөг талтай байж болохыг анхаарна уу. Энэхүү БОНСУ-ий хүрээнд эдгээр асуудлыг шийдвэрлэх (хэрэв тухайн асуудал эерэг байх бол эерэг нөлөөллийг нь улам нэмэгдүүлэх) цогц "бодлогын зөвлөмж"-үүдийг боловсруулахыг зорьсон бөгөөд зөвлөмжүүд нь хууль эрх зүйн орчин, институцийн тогтолцоог сайжруулах, өөрчлөлт оруулах, эсвэл дагалдах хүний болон байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд чиглэгдсэн байх юм.

Нөлөөллийн эрчим		Эрэмбийн арга
Эерэг	Сөрөг	Тайлбар
Их	Их	1, 2-р байранд эрэмбэлэгдсэн асуудал.
Дунд	Дунд	3, 4, 5-р байранд эрэмбэлэгдсэн асуудал.
Бага	Бага	Хамгийн эн тэргүүний 5 асуудал хэмээн эрэмбэлэгдээгүй ч талуудын чухал хэмээн үзсэн асуудал.

Энэхүү бүлэгт хөгжлийн хувилбар бүртэй холбогдон гарах дээрх эн тэргүүний асуудал, нөлөөллүүд, мөн тухайн асуудлуудын талаарх талуудын үзэл бодлыг тус тус танилцуулан, уг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөлөөллүүд сум, аймаг, үндэсний хэмжээнд хэр эрчимтэй байх үнэлгээг гүйцэтгэж, улмаар эдгээр нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмжүүдийг боловсруулан оруулав. Тус бүлэгт нөлөөллүүдийг аль болох тодорхой үнэлэхийг (жишээ нь, газарзүйн байршлаар, холбогдох талууд, төр засгийн түвшний г.м.) зорьсон бөгөөд ингэснээр тухайн тодорхой нөлөөлөл бүрт чиглэсэн, тодорхой арга хэмжээний зөвлөмжүүдийг санал болгохыг мөн зорьсон болно.

Оролцогч талуудын тодорхойлсон эн тэргүүнд анхаарах асуудлууд нь мэргэжилтнүүд болон нотолгоонд тулгуурласан үр дүнтэй харьцуулвал зарим талаар өөр байгааг тэмдэглэх нь зүйтэй. Энэ нь тухайн асуудлаарх мэдлэг, туршлага бага, эсвэл баталгаатай эх сурвалж бүхий мэдээлэл авах боломж байгаагүй, мөн бодит мэдээлэл байхгүй байсантай холбоотой байж болох талтай. Энэ бүлэгт оролцогч талуудын санал бодлыг тусгасан ба дээр өгүүлсэнчлэн эдгээр нь мэргэжилтнүүдийн дүн шинжилгээнээс зөрүүтэй байж болох тул зарим арга хэмжээний зөвлөмжүүд нь эдгээр зөрүүтэй асуудлуудад хариу өгөхөд чиглэгдэв.



Хүснэгт 4.2 Оролцооны явцад болон БОНСУ-ий багийн тодорхойлж үнэлсэн гол асуудлууд

#	Гол асуудлууд	Дэд асуудлууд	Эерэг	Сөрөг	Нөлөөллийн эрчим									
					БАГА ӨСӨЛТ			ДУНД ӨСӨЛТ			ӨНДӨР ӨСӨЛТ			
					Сум	Аймаг	Улс	Сум	Аймаг	Улс	Сум	Аймаг	Улс	
БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛУУД														
1	Ус	Усны нөөцийн тогтвортой бус ашиглалт		X	Бага	Бага	Бага	Их	Их	Их	Их	Их	Их	
		Гидрологийн горимд гарах өөрчлөлтүүд		X	Бага	Бага	Бага	Дунд	Дунд	Дунд	Их	Их	Их	
		Усны түвш. асуудал, малчид худгаа ашиглах боломж		X	Бага	Бага	Бага	Дунд	Бага	Дунд	Их	Их	Их	
2	Газар ба бэлчээр ашиглалт	Тусгай хамгаалалттай газруудын нөлөөлөл		X	Бага	Бага	Бага	Бага	Дунд	Дунд	Их	Их	Их	
		Газар/ бэлчээр ба хөрсний чанарын доройтол		X	Дунд	Дунд	Дунд	Их	Их	Их	Дунд	Дунд	Бага	
3	Агаарын чанар	Агаарын чанарын доройтол		X	Бага	Бага	Бага	Их	Бага	Бага	Дунд	Бага	Бага	
4	Байгаль орчны менежмент	Хог хаягдал		X	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	
		Уул уурхайн компаниудын байгаль орчны менежмент		X	Бага	Бага	Бага	Бага	Дунд	Бага	Бага	Дунд	Бага	
		Байгаль орчны эрх зүйн орчны ба институцийн чадавхи		X	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Их	Дунд	Дунд
		Уул уурхайн компаниудын нөхөн сэргээлт		X	Дунд	Дунд	Дунд	Их	Их	Их	Дунд	Дунд	Бага	
		Биологийн олон янз байдлын доройтол		X	Бага	Бага	Бага	Их	Их	Дунд	Их	Их	Их	
НИЙГМИЙН АСУУДЛУУД														
5	Хувиараа болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлолт	Бичил уурхайн салбарыг үл тоомсорлох асуудал		X	Дунд	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	
		Бичил уурхайн салбарын ЭМААБО-ны асуудлууд		X	Дунд	Бага	Бага	Бага	Бага	Дунд	Дунд	Бага	Бага	
		Бичил уурхайн салбарын эдийн засгийн нөлөө		X	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	
6	Соёлын өв	Биет ба биет бус соёлын өв алдагдах		X	Бага	Бага	Бага	Их	Бага	Их	Их	Их		
7	Хүний эрх ба олон нийтийн оролцоо	Олон нийтийн оролцоо, мэдээлэл		X	Бага	Бага	Бага	Дунд	Дунд	Дунд	Дунд	Бага	Дунд	
		Хүний эрх ба олон нийтийн оролцоо		X	Бага	Бага	Бага	Их	Дунд	Их	Их	Их	Их	
8	Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа	Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа		X	Бага	Бага	Бага	Их	Их	Дунд	Их	Дунд	Дунд	
		Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа		X	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	
		Малын эрүүл мэнд, аюулгүй байдал		X	Бага	Бага	Бага	Их	Дунд	Дунд	Дунд	Бага	Бага	
ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДЛУУД														
9	Засаглал ба орлогын менежмент	Макро-эдийн засгийн нөлөө		X	Бага	Бага	Бага	Дунд	Дунд	Дунд	Дунд	Дунд	Дунд	
10	Бүс нутгийн төлөв./дэд бүтэц	Орлогын менежмент		X	Бага	Бага	Бага	Дунд	Дунд	Дунд	Дунд	Дунд	Дунд	
11		Нийгмийн үйлчилгээ, дэд бүтцэд учрах нэмэлт дарамт		X	Бага	Бага	Бага	Дунд	Бага	Бага	Дунд	Дунд	Бага	
11		Уул уурхайн бүс нутаг дахь хүн амын шилж. хөдөлгөөн		X	Бага	Бага	Бага	Дунд	Бага	Бага	Дунд	Дунд	Бага	
		Орон нутгийн иргэдийн ажил эрхлэлт хангалтгүй байх		X	Бага	Бага	Бага	Дунд	Бага	Бага	Дунд	Бага	Бага	
9	Засаг. ба орлогын менеж.	Төсвийн орлого		X	Бага	Бага	Бага	Бага	Бага	Дунд	Дунд	Их	Их	
10	Бүс нутгийн төлөв./дэд бүтэц	Бүс нутгийн дэд бүтцийн хөгжил		X	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Дунд	Их	Дунд	
11		Уул уурхайн салбарт хөдөлмөр эрхлэх боломж		X	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Дунд	Дунд	Дунд	
11	Хөдөлмөр эрхлэлт ба ур чадвар	Амьжиргаа сайжрах		X	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Дунд	Дунд	Дунд	
		ЖДУ-ийн салбарын хөгжил ба ур чадварыг бэхжүүлэх		X	Бага	Бага	Бага	Дунд	Дунд	Дунд	Их	Дунд	Дунд	
12	Технологи	Орчин үеийн УУ-н үйлдвэрлэлийн технологи ашиглах		X	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Бага	Дунд	Дунд	



4.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭН ТЭРГҮҮНИЙ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД БА ШИЙДВЭРЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖҮҮД

4.2.1 Ус

4.2.1.1 Нөлөөлөл ба хувилбаруудын танилцуулга

Монголын уул уурхайн салбарын усны нөөцийн ашиглалт болон менежмент нь оролцогч талуудын санааг зовоосон чухал асуудал болохыг БОНСҮ-ий үед оролцогч бүх талуудаас авсан саналууд харуулж байна (Хүснэгт 4.3-ийг үзнэ үү). Ерөнхийдөө, уурхайн усны хэрэглээ хэтэрхий их байна гэсэн ойлголт түгээмэл байгаа бөгөөд өндөр өсөлттэй хөгжлийн хувилбар нь сум орон нутгийн түвшинд уламжлалт мал аж ахуйд эрсдэл учруулна гэж үзэж байгаа бол уурхайн ус ашиглалтын байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хөгжилд шаардлагатай усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл нь аймаг болон улсын хэмжээний түвшинд илүү анхаарал татсан асуудал байлаа.

Уурхайн усны менежментийн олон асуудалд талууд санаа зовж байсан бөгөөд үүнд, ашигт малтмалын боловсруулалт болон тоос дарахад ашиглах усны хэмжээ, уул уурхайн үйл ажиллагаанаас ус бохирдуулах эрсдэл, газрын гадаргыг өөрчилснөөр усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл, жишээ нь, усны урсац болон ил уурхайн гүний усны өөрчлөлт зэрэг асуудал багтан орсон байна. Уурхайн ус ашиглалтаас учруулах нөлөө нь ус хэрэглэгчид, газарзүйн байршил болон уурхайн төрлөөс шалтгаалан өөр өөр байх хэдий ч эдгээрийг нэгтгэн уурхайн усны асуудлууд гэсэн нэг ангилалд оруулан бүлэглэсэн байв.

Ус ашиглалтын мэдээнээс харахад уул уурхайг оролцуулсан аж үйлдвэрийн салбарын усны хэрэглээ Монгол улсын нийт ус хэрэглээний 31 орчим хувийг, хөдөө аж ахуйн салбар 50 орчим хувийг тус тус эзэлдэг байна (Үндэсний статистикийн хороо, 2012). Гадаргын ус хомс байдгаас усны нөөцөөр бага хэмээн тооцогддог Монголын говийн бүс нутагт томоохон уурхайнууд төвлөрөн газрын доорх усыг ашиглаж байгаа нь тус бүс нутгийг уул уурхайгаас усны нөөцөд учруулж байгаа нөлөөллийн хувьд ихээхэн анхаарал татсан газар болгож байна. Орон нутгийн иргэд, малчид зөвхөн газрын доорх усаар усны хэрэгцээгээ хангадаг өмнийн говь нутгийн тэжээгдэл бараг байхгүй газрын доорх уст давхаргыг уул уурхайн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нь оролцогч талуудын зовиолыг улам нэмэгдүүлж байгаа юм. Уламжлалт мал аж ахуйд ашигладаг бага гүнт уст давхарга болон уурхайн усан хангамжинд ашиглаж байгаа газрын доорх уст давхаргуудын хоорондын гидрологийн болон гидрогеологийн холбоос нь ихэнхдээ төвөгтэй, нарийн ойлгоход мэргэжлийн бус хүмүүст хүндрэлтэй байдаг.



Хүснэгт 4.3 Оролцогч талуудын тодорхойлсон усны эн тэргүүний асуудлууд²⁴

Түвшин	Бага өсөлттэй хөгжлийн хувилбар	Дундаж өсөлттэй хөгжлийн хувилбар	Өндөр өсөлттэй хөгжлийн хувилбар
Эн тэргүүний асуудлууд:			
<ul style="list-style-type: none"> • Усны нөөц ашиглалт • Гидрологийн нөхцлийн өөрчлөлт • Усны түвшин буурах, малчид худгаа ашиглах боломж хязгаарлагдах асуудал 			
Сум	<ul style="list-style-type: none"> • Уул уурхайн салбарын усны эрэлт хэрэгцээ буурна. • Уул уурхайн үйл ажиллагаа буурснаас, малчдын худгийн усны хэмжээ одоогийн түвшиндээ байж, худаг усны хүрэлцээ сайжирна. • Усны түвшин хадгалагдаж, бүр сайжрах боломжтой. 	<ul style="list-style-type: none"> • Дундаж өсөлтийн хувилбарт усны нөөцөд, ялангуяа гүний усны эх үүсвэрт уул уурхайгаас үзүүлэх нөлөөлөл ерөнхийдөө сөрөг байна. 	<ul style="list-style-type: none"> • Хамгийн их санаа зовоож байгаа асуудал бол уул уурхай эрчимтэйгээр хөгжиж байгаагаас усны хүрэлцээ хомсдож, гадаргын усны чанар буурах явдал юм. • Гидрологийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлтөөс үүдэлтэй усны хомсдол дутагдал болон уул уурхайн бохирдлоос үүдэлтэйгээр ус бохирдож улмаар хүний эрүүл мэнд, мал сүргийн эрүүл мэнд, уламжлалт нүүдлийн мал аж ахуйд учирч буй нөлөөлөл нь бүх сумдын хэмжээнд хамгийн их санаа зовоосон асуудал байна.
Аймаг	<ul style="list-style-type: none"> • Янз бүрийн ойлголттой байна. Нэг талаас, уул уурхайн үйл ажиллагаа багассанаас усны хэрэгцээ шаардлага буурна. Нөгөө талаас, бага өсөлттэй үед уул уурхайн компаниуд нөхөн сэргээлтийг хийхгүйгээр уурхайг хаяж, орхих явдал гарснаас усны нөөц бохирдож, муудах явдал гарч болзошгүй. • Уул уурхайн компаниудын усны хэрэглээ буурснаас үүдэн бага өсөлттэй хөгжлийн хувилбарын үед усны нөөц эх үүсвэрт үзүүлэх цэвэр нөлөөлөл нь эерэг байна. 	<ul style="list-style-type: none"> • Талууд усны хомсдолын талаар ихээхэн санаа зовниж байгаа бөгөөд усны нөлөөллийг аль болох бууруулахын тулд усыг боловсруулан дахин ашиглах өндөр түвшний технологийг ашиглах шаардлага хэрэгцээ нэмэгдэж байгаа талаар дурдлаа. • Усны нөөцөд үзүүлэх уул уурхайн салбарын цэвэр нөлөөлөл мөн сөрөг байхаар байна. 	<ul style="list-style-type: none"> • Усны түвшин буурч, худаг, гол горхи усны эх үүсвэрүүд багасаж, бохирдоно. • Усны нөөцийн асуудал бүх бүсүүдэд тулгамдсан асуудал болно. • Байгаль орчинд ээлтэй уул уурхайн олборлолтын болоод боловсруулах арга технологи, хог хаягдлыг боловсруулах байгууламж, усыг дахин ашиглах үйл ажиллагаа, тоног төхөөрөмж зэргийг нэвтрүүлэх нь Монгол улсын усны нөөцөд үзүүлж байгаа уул уурхайн сөрөг нөлөөллийг тодорхой түвшинд бууруулна.

²⁴ Бага, дундаж, өндөр өсөлттэй хувилбарын хувьд энд (мөн доорх бүлгүүдэд) дурдагдсан зүйлс хэлэлцүүлгийн болон гол талуудтай хийсэн ярилцлагын үеэр илэрхийлсэн оролцогчдын санал бодол болно.



Түвшин	Бага өсөлттэй хөгжлийн хувилбар	Дундаж өсөлттэй хөгжлийн хувилбар	Өндөр өсөлттэй хөгжлийн хувилбар
Улс	<ul style="list-style-type: none">Бага өсөлттэй үед байгаль орчинд цэвэр эерэг нөлөө үзүүлнэ, ялангуяа энэ хувилбарын үед усны эх үүсвэрт бага дарамт учирна гэсэн ойлголттой байна.	<ul style="list-style-type: none">Бүс нутгаас хамааран усны нөөцөд уул уурхайн салбараас үзүүлэх нөлөөлөл өөр өөр байна гэж холбогдогч талууд үзэж байна. Өмнөд говийн бүсийн хувьд усны асуудал өөр бусад аймгуудтай харьцуулахад ихээхэн тулгамдсан асуудал болох бөгөөд өмнөд говьтой адилхан усны асуудал бүх аймаг, сумдад тулгарахгүй.Усны эх үүсвэрт дундаж өсөлттэй хувилбарын үзүүлэх цэвэр нөлөөлөл нь дунд зэргийн байна.	<ul style="list-style-type: none">Уул уурхайн хурдацтай өсөлт нь усны нөөцийн ашиглалтыг улсын хэмжээнд эн тэргүүний тулгамдсан асуудал болгож байна. ЗГ нь өргөн хүрээний эдийн засгийн хөгжлөөс байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийг зохицуулах амаргүй үүрэг хүлээнэ. Үүнд, усны асуудал хамгийн чухалд тооцогдож байна. Усны хэрэглээг бууруулах, дахин боловсруулж, ашиглах зэргийг багтаасан арга хэмжээг авч хэрэгжүүлснээр уурхайнууд усны хэрэглээгээ бууруулж болно.Холоос ус ханган нийлүүлэх цогц сүлжээг нэвтрүүлэх талаар нухацтай судлан үзэж байгаа бөгөөд одоогоор хэрэгжүүлээгүй байна.Байгаль орчинд ээлтэй уул уурхайн арга техник, хог хаягдлыг боловсруулах байгууламж болон усыг дахин ашиглах зэрэг арга ажиллагаа, технологийг боловсруулан ашиглах нь улсын хэмжээнд усны нөөцийн ашиглалтыг сайжруулж, зохицуулахад хүргэнэ.



4.2.1.2 Сум, аймаг, үндэсний түвшинд үзүүлэх нөлөөллийн эрчим

Үндэсний хэмжээн дэх ус ашиглалтын хэтийн төлөв, гарах хүндрэлүүд

Зураг 4.2-т уул уурхайн ус ашиглалтын цаашдын эрэлт хэрэгцээ болон одоогоор мэдэгдэж байгаа усны нөөцийн мэдээллийг үзүүлэв. Энэ мэдээллийг Нидерландын Вант улсын санхүүжүүлтээр БОНХЯ-ны хэрэгжүүлсэн Усны нэгдсэн менежмент төслийн Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан судалгаа (2012 онд хэвлэгдсэн)-аас авсан болно (Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, 2013). Төлөвлөж буй уурхайнуудын ус ашиглалтын хэрэгцээг Монгол орны 29 сав газрын усны баримжаат нөөцтэй харьцуулсан бөгөөд аймаг, сумаар гаргаагүй болно. Оюу Толгой, Таван Толгой, Асгат, Цагаан суварга гэсэн 4 уурхайн усны эрэлт хэрэгцээний мэдээллийг (БОНХЯ, 2012) дундаж болон өндөр өсөлтийн хувилбаруудад шаардагдах усны эрэлт дээр нэмсэн. Уул уурхайн салбарт ашиглагдах одоогоор мэдэгдэж байгаа усны эрэлт хэрэгцээний мэдээлэлд үндэслэн доорх зургийг хийсэн болно. Өмнөговь аймгийн уул уурхайн усны ашиглалтын талаар өөр бусад шинжилгээ судалгаа мөн хийгдсэн байдаг (Туйнхоф, Буянхишиг, 2010). Хэдийгээр өсөлтийн өөр өөр хувилбаруудад уул уурхайн ус ашиглалтын тооцоонд ялгаатай болон тодорхойгүй зүйлүүд гарч байгаа ч Зураг 4.2-аас уул уурхайн цаашдын хөгжил одоо мэдэгдэж байгаа усны нөөцөд хамгийн их нөлөөлөх сав газруудыг харж болно.


Сэлэнгэ болон Булган аймгийн нутаг дэвсгэрийг хамардаг Сэлэнгэ мөрний сав газар нь 90.3 сая м³/жил ус ашиглалтын нөөцтэй бөгөөд дундаж өсөлтийн хувилбарын үед энэ нөөцийн 50% нь уул уурхайд ашиглагдахаар байна. Өндөр өсөлтийн хувилбараас харахад энэ сав газраас жилд ашиглах усны эрэлт хэрэгцээ 2021 он гэхэд газрын доорх ус ашиглалтын нөөцийн 163%-д хүрэхээр байна. Хөвсгөл нуур, Эгийн голын сав газар (Хөвсгөл болон Булган аймгууд), Улзын голын сав газар (Дорнод болон Хэнтий аймгууд), Бууцагаан нуур, Байдрагийн голын сав газрын (Баянхонгор аймаг) хувьд ч иймэрхүү дүр зураг харагдахаар байгаа юм. Таван Толгой, Оюу Толгой, Цагаан Суваргын томоохон орд газрууд байдаг Галба-Өөш Долоодын говийн усны сав газарт (Өмнөговь болон Дорноговь аймгууд) дундаж өсөлтийн хувилбарын үед 2021 он гэхэд жилд ашиглах усны хэрэгцээ нөөцийнх нь ойролцоогоор 65%, өндөр өсөлтийн хувилбарын үед 2021 он гэхэд энэ нөөцийн 70%-д хүрэхээр байна. Усны нөөцийн группэд (Water Resource Групп 2030) зориулан Прайсвотерхаускуперс (PWC)-ийн хийсэн саяхны судалгаанаас үзвэл уул уурхайн салбар өндөр өсөх үед усны эрэлт хэрэгцээ Өмнөговийн Умард Говийн Гүвээт Халхын Дундал тал, Галба-Өөш-Долоодын Говийн сав газар болон Алтайн Өвөр Говийн усны сав газруудад ашиглаж болох нөөцөөс 2026 он гэхэд давж гарахаар байна.

Энэхүү нөлөөллийн үнэлгээнд ашигласан дээрх тоо, мэдээлэл нь төгс биш гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, одоогийн болон ирээдүйн уул уурхайн хөгжлийн хувилбаруудын усны хэрэгцээний таамаглал болон зөвхөн усны хайгуул судалгаагаар тогтоосон усны ашиглаж болох нөөцийг тооцоонд орууллаа. Газрын доорх усны хайгуул судалгаа нь ихэнхдээ уул уурхайн усны хэрэгцээнд зориулан хийгдэж байгаа, түүнчлэн эдгээр хайгуул судалгаа нь тооцоонд орсон өнөөгийн болон ирээдүйн усан хангамж шаардлагатай газруудад л хийгдсэн байдгийг бодолцвол Өмнийн говийн усны нөөцийн талаарх мэдэгдэж байгаа мэдээлэл бүрэн бус гэдгийг харуулж буй хэрэг юм.


Өмнийн говийн 3 сав газруудын одоогоор мэдэгдэж байгаа, ашиглаж болох нөөц нь жилийн 170 сая м³ байна. Эдгээр нөөцийн ихэнх нь Цэрдийн галавын үеийн тунамал хурдаст хийсэн уул уурхайн компаниудын гидрогеологийн судалгаанд үндэслэн тодорхойлогдсон болно. Эдгээр ус агуулагч цэрдийн хурдас нь өмнийн говийн 143,000 км² газрыг хамарч байгаа бөгөөд 715,000 сая м³ (уст давхаргын шинж чанарт үндэслэлэсэн тооцоогоор) усны боломжит нөөцийг агуулж байна. Усны нөөцийн цаашдын эрэл хайгуул нь энэ бүс нутагт ашиглаж болох усны нөөцийн хэмжээг ихээр нэмэгдүүлэх төлөвтэй байна.




БАГА ӨСӨЛТ



ДУНДАЖ ӨСӨЛТ



ӨНДӨР ӨСӨЛТ



ТАНИХ ТЭМДЭГ

- Уурхай
- Голуудын сав газрын хил
- Газрын доорх усны ашиглалтын нөөц, сая м³/ жил
- 2021 он хүртэлх уул уурхайн салбарын усны эрэлт хэрэгцээний таамаглал, сая м³/ жил

0 150 300 KM



Зураг 4.2 Мэдэгдэж байгаа усны нөөц ба уурхайд шаардагдах усны эрэлт хэрэгцээ



Усны асуудлаар үүсэж болзошгүй маргаан

Үнэлгээнд оролцсон талуудын харж байгаагаар уул уурхайн бага өсөлттэй хувилбарын үед уурхайн ус ашиглалтын нөлөө нь сумын түвшинд бага байхаар байна. Мөн сум, аймгийн түвшинд уул уурхайн үйл ажиллагаанд зориулан ус ашиглах нь хөдөө аж ахуй, мал сүрэг, байгаль орчны хэрэгцээт усны нөөцөөс хомсдуулдаг гэж үздэг тул энэ асуудалтай холбоотойгоор орон нутгийн чанартай зөрчил маргаан гарах магадлал өндөр байна. Ялангуяа гадаргын усны их хэмжээний нөөцийг уул уурхайн зориулалтаар ашигласнаар орон нутгийн өөр бусад ус хэрэглэгчидтэй өрсөлдөөн үүсгэж байгаа Сэлэнгэ, Хөвсгөл, Булган аймгуудад энэ үзэгдэл гарах магадлал ихээхэн өндөр байгаа юм. Төслийн хүрээнд хийгдсэн ерөнхий дүн шинжилгээгээр усны үр дүнтэй төлөвлөлт байхгүй байгаа нь харагдсан ба оролцогч талууд мөн энэ асуудлыг хөндөж байв. Энэ нөхцөлд уул уурхайн салбарын бага өсөлттэй хувилбарын үед орон нутгийн хэмжээний усны нөөцтэй холбоотой зөрчил маргаан үүсэхээр байгаа ч эдгээр нь дундаж болон өндөр өсөлтийн хувилбарын үед багасахаар байна.

Уул уурхайн дундаж болон өндөр өсөлттэй хувилбаруудын үед уурхайн ус ашиглалт нь зарим аймгуудын хувьд одоогийн болон ирээдүйн ус хэрэглэгчидтэй (байгаль орчны усны хэрэгцээ мөн орно) зөрчилдөхөөр байгаа нь Зураг 4.2-аас харагдаж байна. Иймэрхүү зөрчил өмнөд говийн аймгуудад, ялангуяа, газрын доорх усны нөөцийг уул уурхайд ашиглах нь малчдын усны хангамж болон энэ нутгийн цаашдын хөгжилд сөрөг нөлөө үзүүлнэ гэсэн ойлголт өргөнөөр тархсан Өмнөговь аймагт хэдийнээ гарч эхлээд байгаа билээ. Өмнөговь аймгийн уул уурхайн компаниуд нь нөхөн сэргээгдэл бараг үгүй газрын доорх хурдас дахь уст давхаргын усыг ашиглаж байна. Уламжлалт мал аж ахуй нь газрын гадаргын ойролцоо орших аллювийн давхаргад орших гар худгийн усыг ашигладаг. Энэ аллювийн давхаргын усны эх үүсвэрүүд нь бороо хур орсны дараа гадаргын урсацаар тэжээгдэж, сэргээгддэг бөгөөд гангийн нөлөөлөлд амархан өртдөг. Цэрдийн галавын үеийн хурдаст байрлах уст давхаргаас уул уурхайн зориулалтаар ус ашигласнаас малчдын ашигладаг бага гүний даралтгүй уст давхаргад үзүүлэх нөлөөг бага гэж үзэж байгаа бөгөөд тусгаарлаж болох давхаргуудаас сонголт хийн бага гүнтэй ус давхаргад нөлөөлөхгүй байдлаар зохицуулан ашиглах боломжтой гэж үздэг. Гэхдээ дээрх асуудлууд нь мэргэжлийн шинжтэй, нарийн төвөгтэй цогц асуудлууд байдгаас энэ бүс нутгийн газрын доорх ус ашиглагчдын хооронд ойлголцол, итгэлцэл байхгүй болоод байгаа билээ.

Хаягдаж, орхигдсон уурхайнуудаас усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл

Оролцогч талуудаас хэлэлцүүлгийн үеэр хөндөж ярьсан аймгийн түвшний асуудлуудад бага өсөлттэй хувилбарын үед хаягдаж, орхигдсон уурхайнуудаас усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл орж байна. Бага өсөлттэй хувилбарын үед санхүүгийн хүндрэлээс шалтгаалан уурхайнууд хаагдах нь ихсэх бөгөөд хаагдах үедээ байгаль орчны менежментийн үйл ажиллагааг бага явуулна хэмээн таамагласан. Хаягдсан уурхайгаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл бага биш бөгөөд гадаргын усны седимент, уурхайн хаягдлын сангаас гарч болох химийн бодис болон хүчиллэг урсац, мөн тухайн газрын гадаргын усанд үзүүлэх өөрчлөлт гэх зэрэг байж болно. Цианид, мөнгөн усыг ашиглах явдал одоог хүртэл гарч, ундны усны хангамж болон байгаль орчинд ихээхэн эрсдэл учруулсан хэвээр байгаа алт олборлож буй нутаг оронд хаягдсан уурхайгаас усны эх үүсвэрт үзүүлэх нөлөөлөл илүү их байна. Өндөр өсөлттэй хувилбарын үед хаягдсан уурхайтай холбоотой гарах асуудлуудын цар хүрээ нь уурхайн хаалтыг хариуцлагатайгаар явуулахад



чиглэсэн хуулийн орчныг сайжруулах, хэрэгжилтийг үр дүнтэйгээр хангах чадвар ямар байхаас хамаарах болно. Усны эх үүсвэрүүдийг хамгаалсан байдлаар уурхайг хаах үр дүнтэй арга ажиллагааг хэрэгжүүлэх чадвар ямар байх нь мэдлэг мэдээлэл, техник технологид энэ салбараас хийх хөрөнгө оруулалтаас ихээхэн хамааралтай байх болно.

Усыг хэмнэлттэй ашиглах

Оролцогч талууд аймаг болон үндэсний түвшинд дунд, өндөр өсөлттэй хувилбарын үед уурхайн зориулалтын усыг хэмнэлттэйгээр нөөцлөх, дахин ашиглах асуудлыг хөндсөн. Эдгээр оролцогч талууд уурхайн зориулалтаар усыг их хэмжээгээр ашигласнаас үүсэх нөлөөллийг усыг хэмнэлттэйгээр дахин ашиглах, нөөцлөх зэрэг технологи, туршлагыг хэрэгжүүлэх замаар бууруулах шаардлагатай гэж үзлээ. Одоогоор уурхайн салбарын хэмжээнд усыг хэмнэлттэй ашиглаж байгаа үйл ажиллагааг тооцоолон тогтоосон мэдээлэл Монголд ерөнхийдөө байхгүй. Гэсэн хэдий ч саяхнаас Өмнөговийн нүүрс угаах үйлдвэр бохир усаа эргүүлэн ашиглах шинэ технологи нэвтрүүлсэн жишээ байгаа юм. Мөн ахуйн бохирын ус, технологийн усыг цэвэршүүлэн тоосжилтыг дарахад ашиглах, ууршилтын алдагдлыг бууруулахын тулд ус хадгалах даланг хаан бүтээх зэрэг арга хэмжээ авч байна. Усыг нөөцлөх, дахин ашиглах технологийн талаарх оролцогч талуудын ойлголт мэдлэг өндөр байхын хэрээр уул уурхайн салбарт усны эрэлт хэрэгцээг бууруулах тэргүүний туршлагыг ашиглана гэсэн тэдний хүлээлт илүү өндөр байх хандлагатай байна. Усыг дахин ашиглах болон хэмнэлттэй ашиглах технологи ашигласан тохиолдолд урамшуулал үзүүлэх, усны төлбөрт хөнгөлөлт үзүүлэх хуулиуд батлагдаад байгаа билээ.

Нөлөөллийн хураангуй

Бага өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none"> Сэлэнгэ, Хөвсгөл, Булган аймгуудад аймаг, сумын аль аль түвшинд ус ашиглалттай холбоотой маргаан үүсэх магадлалтай.
Дундаж / Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none"> Өнөөгийн болон ирээдүйн ус ашиглагчдын дунд уурхайн усны ашиглалтын талаар томоохон зөрчил маргаан үүсэх магадлалтай. Хаягдаж орхигдсон уурхайгаас гадаргын усанд тунадас үүсэх, уурхайн хүдрийн хаягдал, хүчиллэг урсац зайлуулах системээс химийн бодис шүүрэх, уурхай орчимд гадаргын усны горим өөрчлөгдөх зэргээр байгаль орчинд их хэмжээтэй нөлөөлөл үүсгэж болзошгүй. Нөлөөлөлд өртөгсөдийн дунд усны нөөцийн хүртээмжийн талаар бодитой мэдлэг, мэдээллийг дэлгэрүүлэх хэрэгцээ шаардлага нь амин чухал асуудал болохыг тодорхойлов. Аль ч өсөлтийн үед усны нөөцийн талаарх мэдээллийн дутмаг байдал, уурхайн ус ашиглалтын нөлөөллийг тойрсон нөлөөлөлд өртөгч талуудын ойлголтын тодорхой бус байдал өссөөр байх ба уурхайн үйл ажиллагаа нэмэгдэхийн хамтаар эрсдэл мөн нэмэгдсээр байх болно.

4.2.1.3 Ус: Арга хэмжээний зөвлөмжүүд

Хэлэлцүүлгийн үеэр оролцогч талуудаас гаргасан санал болон байгаа мэдээлэл, судалгааны дүн шинжилгээний үр дүнд, уул уурхайгаас усны нөөцөд учруулах нөлөөллийг бууруулах гол чиглэлүүдийг дараахь байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Ус ашиглалтын хуваарилалтыг зөвшилцөх, оролцооны аргаар шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх үндэсний хэмжээний ус төлөвлөлтийн талаарх хууль эрх зүйн орчныг боловсруулах шаардлагатай. Сав газрын захиргааг байгуулж, Усны тухай Монгол улсын хуулийг саяхан шинэчлэн найруулснаар энэ чиглэлийн ажил хийгдэж эхлээд байна.



- Ус ашиглалтын төлөвлөлт болон хуваарилалтын талаар шийдвэр гаргахад хангалттай мэргэжлийн боловсон хүчнээр хангах үүднээс үндэсний хэмжээний чадавхийг бэхжүүлэх.
- Монгол улсын хэмжээний, ялангуяа уул уурхайн бүс нутгуудийн усны эх үүсвэрийн талаар цогц ойлголттой болох талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд шаардагдах нөөц хангалтгүй байдаг бөгөөд ихэнхдээ уул уурхайн компаниудаас хэрэгжүүлж байгаа усны эрэл хайгуул болон судалгаанд түшсэн байдалтай байдаг.

Сум болон аймгийн түвшинд, дээр авч үзсэн усны асуудлаарх арга хэмжээний зөвлөмжүүд нь байршлаас хамааран өөр өөр байна. Өмнийн говийн бүс нутагт гарч байгаа устай холбоотой зөрчил маргаан нь газрын доорх усны шинж чанарын талаар хэрэглэгчдийн дунд байгаа өөр өөр ойлголтууд, үүнээс үүдэлтэйгээр орон нутаг, уул уурхайн компаниуд, төрийн байгууллагууд болон бүх шатны шийдвэр гаргагчдын хооронд үүсч буй үл итгэлцэлтэй холбоотой байна. Хамтын оролцоотой усны мониторинг, ус ашиглалтын төлөвлөлт болон шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоог хангах нь мэдээлэл болон мэдлэг солилцох боломжийг бүрдүүлнэ.

Уул уурхайн хэрэгцээнд гадаргын ус ашигладаг, ялангуяа уул уурхайн өндөр өсөлтийн хувилбарын үед ашиглагдах усны хэмжээ нэмэгдэхээр байгаа хойд зүгийн аймгуудад ус ашиглалтыг төлөвлөх, мониторингийн оролцооны арга механизмыг мөн нэвтрүүлэх боломжтой. Уул уурхайн өсөн нэмэгдэж буй усны хэрэглээ нь одоогийн усны хуваарилалт байгаль орчин, ирээдүйн газар ашиглалтын төлөвлөлт, нийгэм-эдийн засгийн хөгжилд хэрхэн нөлөөлөх талаар авч үзэх хэрэгцээг бий болгож байна.

Уурхайд ус бага зарцуулдаг технологи боловсруулах үзэл баримтлалыг цаашид урамшуулан дэмжиж ус хэмнэлттэй ашигладаг технологи хэрэгжүүлж байгаа тохиолдолд усны төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх боломжтой юм. Холбогдох байгууллагууд нөхөн сэргээлт хийлгүй орхисон уурхайн компаниудаар уурхайн түр болон бүрэн нөхөн сэргээлт хийлгэхийг шаардах эрх зүй, хяналт, санхүүгийн хамгийн наад захын стандарт, боломжоор хангагдсан байх шаардлагатай.

Хүснэгт 4.4 Ус: Арга хэмжээний зөвлөмжүүд

Арга хэмжээний зөвлөмж	
	<ul style="list-style-type: none">• Чадавхийг бэхжүүлэх• Усны хэтийн эрэлт хэрэгцээг тодорхойлох• Усыг үр ашигтай, дахин ашиглах арга хэмжээг нэмэгдүүлэх
Сум	<ul style="list-style-type: none">• Малчдын ашиглаж буй худгийн хяналт шинжилгээнд нутгийн иргэдийг оролцуулах оролцоонд түшиглэсэн байгаль орчны хөтөлбөрийг хэрэгжүүлэх• Газрын доорх усны орон зайн тархалтын (хэвтээ, босоо) талаарх илүү дэлгэрэнгүй (тоо хэмжээ, чанар) мэдээллийг бүрдүүлэх, усыг үр ашигтай болон дахин ашиглах боломжийг судлах. Ингэснээр их гүний уст давхаргаас уурхайн хэрэгцээнд ус ашигласнаар малчдын худаг тэжээгддэг бага гүний уст давхаргад хэрхэн нөлөөлж буй асуудлыг ойлгож тодорхойлох нөхцөл бүрдэнэ.
Аймаг	<ul style="list-style-type: none">• Өсөлт өндөр байх тохиолдолд ирээдүйд хүндрэл үүсэх тул аймгуудын усны ирээдүйн эрэлтийг тодорхойлох.• Усны үр ашигтай хэрэглээ, дахин ашиглах технологийг дэмжиж, санхүүгийн урамшуулал нэвтрүүлэх усны хэрэглээний үнэ тарифын шинэ журмын талаар уул уурхайн компаниудын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх (Ихэнх уул уурхайн компани бохир усыг дахин ашигладаг боловч ил уурхайгаас шавхсан газрын доорх усны урсацыг тэр болгон дахин ашигладаггүй).• Бүх уурхайд усны тоолуур ашиглуулдаг болгох.



Арга хэмжээний зөвлөмж	
	Газрын доорх усны орон зайн тархалтын (хэвтээ, босоо) талаарх илүү дэлгэрэнгүй (тоо хэмжээ, чанар) мэдээллийг бүрдүүлэх, усыг үр ашигтай болон дахин ашиглах боломжийг судлах.
Улс	<ul style="list-style-type: none">Уул уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй газрын доорх усны талаар иргэдийн дунд нэгдмэл ойлголтыг бий болгох үүднээс гүний худгийн хяналт шинжилгээний сүлжээг өргөтгөх.Усны салбарт ажиллаж буй байгууллага хоорондын усны нөөцийн удирдлагын чадавхи, зохицуулалт, хариуцлагыг дээшлүүлэх.Усны үр ашигтай хэрэглээ, дахин ашиглах технологийг дэмжиж, санхүүгийн урамшуулал нэвтрүүлэх усны хэрэглээний үнэ тарифын шинэ журмын талаар уул уурхайн компаниудын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх (Ихэнх уул уурхайн компани бохир усыг дахин ашигладаг боловч ил уурхайгаас шавхсан газрын доорх усны урсацыг тэр болгон дахин ашигладаггүй).Усны нөөцийн удирдлагын талаархи ойлголтыг бүх оролцогч талууд түүний дотор төр, малчид, нутгийн иргэд, уул уурхайн компаниуд, иргэний нийгмийнхэний дунд дээшлүүлэх хөтөлбөрүүдийг хөхиүлэн дэмжих (4.3.3 буюу Хүний эрх ба олон нийтийн оролцоо хэсгийг харна уу).Газрын доорх усны орон зайн тархалтын (хэвтээ, босоо) талаарх илүү дэлгэрэнгүй (тоо хэмжээ, чанар) мэдээллийг бүрдүүлэх, усыг үр ашигтай болон дахин ашиглах боломжийг судлах.Нөхөн сэргээлт хийлгүй орхисон уурхайн компаниудаар уурхайн түр болон бүрэн нөхөн сэргээлт хийлгэхийг шаардах эрх зүй, хяналт, санхүүгийн хамгийн наад захын стандарт, боломжоор холбогдох байгууллагуудыг хангах.

4.2.2 Газар ба бэлчээр ашиглалт

4.2.2.1 Нөлөөлөл ба хувилбаруудын танилцуулга

Нийгэм, эдийн засгийн асуудлуудтай харьцуулахад уул уурхайгаас газарт биет буюу бодит нөлөөлөл үзүүлдэг бөгөөд ашигт малтмалын төрөл, шаардагдах дэд бүтцээс хамрах талбай нь шалтгаалдаг. Нөлөөлөлд тусгай хамгаалалттай газар нутгуудад явагдаж байгаа уул уурхайн үйл ажиллагаа, газрын болон хөрсний чанарын доройтол, газар ашиглалтанд орж байгаа өөрчлөлт болон хөрсний үржил шим буурах зэрэг багтан орно. Доорх Хүснэгт 4.5-т хэлэлцүүлгийн үйл явцын үеэр хөгжлийн хувилбаруудтай холбоотойгоор тодорхойлсон эн тэргүүний тулгамдсан асуудлууд болон нөлөөллийг харуулав.

Дээр нь, 3 хувилбар тус бүрийн хувьд газар ашиглалт болон тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлж болзошгүй нөлөөллийг тодорхойлох зорилгоор газар зүйн мэдээллийн систем ашиглан 2 төрлийн орон зайн шинжилгээг хийлээ. Эхний дүн шинжилгээгээр сум, аймаг болон үндэсний хэмжээнд (Зураг 4.3) одоо байгаа тусгай хамгаалалттай болон хамгаалалтанд хамруулахаар санал болгож буй газруудад явагдаж болзошгүй уул уурхайн үйл ажиллагааг авч үзэв. Энэ шинжилгээний хүрээнд авч үзсэн тусгай хамгаалалттай газруудад олон улсын конвенцийн дагуу хамгаалагдсан газрууд, шувуудад чухал газрууд, улсын тусгай хамгаалалттай газрууд, Газрын тухай хуулиар улсын тусгай хэрэгцээнд авсан, мөн орон нутгийн хамгаалалттай газруудыг тус тус оруулав. Монгол улсад улсын тусгай хамгаалалттай газруудад уул уурхайн үйл ажиллагааг хатуу хориглодог бөгөөд биологийн төрөл зүйлийн хувьд чухал газруудыг хамгаалах зорилгоор Засгийн газрын зүгээс уул уурхайн үйл ажиллагаа явуулахгүй байх газар нутгийн судалгааг өргөжүүлэн хийж байна. Тиймээс, энэхүү дүн шинжилгээнд Монгол улсын Засгийн газраас албан



ёсоор батлаагүй боловч, БОНХЯ болон Дэ Нэйче Консерванси (TNC)²⁵ байгууллагын зүгээс тодорхойлон хамгаалалтанд авахаар санал болгож буй газруудыг мөн хамруулсан болно. Эдгээр хамгаалалттай газруудыг ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайтай давхцуулан авч үзсэнээр, бага, дунд, өндөр өсөлттэй хувилбарын үед уул уурхайн үйл ажиллагаа явагдаж болзошгүй хамгаалалттай газруудын байршил, хэмжээг тодорхойлсон юм.

Зураг 4.4-т харуулсан 2 дахь орон зайн дүн шинжилгээгээр сум, аймаг, үндэсний түвшинд уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж болзошгүй бэлчээрийн газар нутгийг тодорхойлсон ба мөн дээрх давхцуулах аргыг ашиглан гүйцэтгэсэн болно. Бүх малчдын өвөлжөөнөөс 5 км татсан тойрог газрыг идэвхтэй бэлчээр гэж үзсэн бөгөөд ашиглагдаж байгаа уурхайгаас²⁶ 5 км татсан тойргийг уурхайн нөлөөллийн бүс²⁷ гэж авч үзлээ. Малчдын идэвхтэй ашигладаг бэлчээрийг уул уурхайн нөлөөллийн бүстэй давхцуулснаар уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж болзошгүй бэлчээрийн талбайг тодорхойлсон юм.

²⁵ TNC нь дэлхийн хэмжээнд байгаль орчныг хадгалж, хамгаалах менежментийн чиглэлээр ажилладаг олон улсын байгууллага болно.


²⁶ АМГ-аас олгосон уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн дагуу ашиглалт хийгдэж байгаа уурхайнуудыг оруулав.

²⁷ 5 км радиус бүхий уурхайн нөлөөллийн бүсийг ойролцоогоор авсан ба практикт энэхүү бүсийн талбай нь ашигт малтмалын төрөл, тухайн уурхайн үйл ажиллагаанд шаардагдах талбайгаас хамаарна.




БАГА ӨСӨЛТ

0.03 сая га 




ДУНДАЖ ӨСӨЛТ

4.21 сая га 





ӨНДӨР ӨСӨЛТ

4.32 сая га 




ТАНИХ ТЭМДЭГ




 Аймгийн хил

 Уул уурхайн үйл ажиллагаа* явагдаж болзошгүй хамгаалалттай, хамгаалахаар санал болгож буй** газар

* Уул уурхайн ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай
** Дэлхийн өвд бүртгэгдсэн газар, хүн шим мандлын нөөц газар, ус намгархаг газар, улсын тусгай хамгаалалттай газар, орон нутгийн тусгай хамгаалалттай газар, шувуудад чухал газар, хамгаалахаар санал болгож буй газар/БОНХЯ&TNC.



Зураг 4.3 Уул уурхайн үйл ажиллагаа явагдаж болзошгүй хамгаалагдсан болон хамгаалахаар санал болгож буй газрууд



ТАНИХ ТЭМДЭГ

Уул уурхайн үйл ажиллагаа* явагдаж болзошгүй бэлчээрийн газар**

Аймгийн хил

* Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн төв цэгээс 5км зай бүхий тойрог талбай

** Малчдын өвөлжөөнөөс 5км зай бүхий тойрог талбай



Зураг 4.4 Уул уурхайн үйл ажиллагаа явагдаж болзошгүй бэлчээрийн газар



Хүснэгт 4.5 Оролцогч талуудын тодорхойлсон газар болон бэлчээр ашиглалттай холбоотой эн тэргүүний асуудлууд

Түвшин	Бага өсөлттэй хөгжлийн хувилбар	Дундаж өсөлттэй хөгжлийн хувилбар	Өндөр өсөлттэй хөгжлийн хувилбар
Эн тэргүүний асуудлууд:			
<ul style="list-style-type: none"> • Тусгай хамгаалалттай газрууд • Газар, бэлчээрийн доройтол, хөрсний элэгдэл • Газрын төлөв байдлын өөрчлөлт, үржил шимийн бууралт 			
Сум	<ul style="list-style-type: none"> • Уул уурхайн үйл ажиллагаа багасаж, улмаар бэлчээр хадгалагдана. • Уул уурхай болон уул уурхайн ханган нийлүүлэлтийн салбарт ажиллах боломж хаагдаснаар бэлчээр, хөдөө аж ахуйн газрын ачаалал, ашиглалт ихэснэ. Учир нь хүмүүс орлогоо нэмэгдүүлэхийн тулд малынхаа тоо толгойг нэмэгдүүлнэ. • Түлшинд зориулан хүмүүс мод огтолж, түлснээр ой мод багасах, амьжиргаагаа залгуулахын тулд хууль бус ан агнуур хийх зэрэг үзэгдлүүд гарна. • Цэвэр нөлөөлөл нь эерэг байна. 	<ul style="list-style-type: none"> • Мал сүргийн тоо нэмэгдсэнээс сумын түвшинд уурхайнууд болон малчдын хооронд, эсвэл малчдын дунд бэлчээрийн ашиглалтын талаар байнгын асуудал байсаар байх болно. • Уул уурхайн салбарын бий болгодог бизнесийн боломжууд өндөр өсөлттэй хувилбартай харьцуулахад бага байна. Энэ нь мал сүргийн тоо нэмэгдэхэд хүргэж, бага өсөлттэй хувилбартай адилаар бэлчээрийн дарамт, ашиглалт илүү их нэмэгдэнэ. • Уурхайгаас бэлчээр болон тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлж байгаа нөлөөллийн хэмжээ буурахгүй. • Цэвэр нөлөөлөл сөрөг байна. 	<ul style="list-style-type: none"> • Уул уурхай, дэд бүтцийн хөгжилд зориулж газар чөлөөлөн цөлжилтээс сэргийлдэг олон наст ургамлыг устгах ба энэ бүхнээс өндөр өсөлттэй хувилбарын хувьд бэлчээрийн доройтол ихсэнэ. • Малчдын бэлчээрийн хүртээмж болон бэлчээрийн чанар буурснаар малчдын нөхцөл байдал улам бүр эмзэг болж ирнэ. • Уурхайн үйл ажиллагааны улмаас олон малчдын өвөлжөөг нүүлгэн шилжүүлэхэд хүргэх ба бэлчээр хомсдосноос өвөлжөөнүүд нь хоорондоо шигүү байрлан бэлчээрийн даацад сөргөөр нөлөөлж, малчдын хооронд бэлчээр, усны төлөөх зөрчил, тэмцэл бий болоход хүргэнэ. • Уул уурхайн үйл ажиллагаа өргөжиснөөр тусгай хамгаалалттай газруудын статус өөрчлөгдөх магадлалтай. • Дэд бүтэц сайжирч, зах зээлтэй холбогдсоноор, уул уурхайн салбарын эрэлт хэрэгцээг хангах ЖДҮ-ийн бизнесийн боломжууд бий болсноор малын тоо толгой нэмэгдэж, улмаар бэлчээрийн даац хэтэрч, газрын үржил шим буурна. • Цэвэр нөлөөлөл сөрөг байна.
Аймаг	<ul style="list-style-type: none"> • Үр дүн сумын түвшинтэй адил байна. • Тусгай хамгаалалттай газар нутаг болон малчдын бэлчээрийн талбайн хэмжээ ихэснэ. • Орон нутгийн нүүрсний уурхайнууд үйл ажиллагаагаа багасгаж, улмаар түлшний нүүрс авах боломж багаснаар ой мод устгах явдал нэмэгдэнэ. 	<ul style="list-style-type: none"> • Цэвэр нөлөөлөл сөрөг байна. • Бэлчээр ашиглалтын асуудлыг зохицуулахад бүр илүү хэцүү байх болно. • Аймгийн түвшинд бэлчээрийг нөөцөлж, хадгалах уламжлал бараг тасарсан бөгөөд, энэ нь сумын удирдлагад бэлчээрийн менежментийг сайжруулах талаар үзүүлэх аймгийн дэмжлэг бүр бага байна гэсэн үг. 	<ul style="list-style-type: none"> • Цэвэр сөрөг нөлөө бий болно. • Гэхдээ аймгийн түвшинд төсөв нэмэгдэж, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах (Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар боломжтой болсон) болон байгаль орчны менежментийн сайн туршлагыг аймгийн түвшинд хэрэгжүүлэх боломжтой болно. Энэ нь тодорхой хэмжээгээр нөлөөллийг бууруулна.



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

Түвшин	Бага өсөлттэй хөгжлийн хувилбар	Дундаж өсөлттэй хөгжлийн хувилбар	Өндөр өсөлттэй хөгжлийн хувилбар
Улс	<ul style="list-style-type: none">Уул уурхайн өсөлт буурснаас мал аж ахуй, хөдөө аж ахуйн салбар эдийн засаг болон хүмүүсийн амьжиргаанд чухал байр суурь эзэлнэ.Бэлчээр, хамгаалалттай газруудыг хадгалж, хамгаалах нь эко-аялал жуулчлалын салбар өсөж хөгжинө гэсэн үг юм.Байгаль орчинд ашиг тустай байна.	<ul style="list-style-type: none">Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой улсын хэмжээний газрын асуудал одоо байгаатай адил байна. Цэвэр нөлөөлөл сөрөг байна.	<ul style="list-style-type: none">Цэвэр нөлөөлөл нь аймаг болон сумын түвшний ойлголт, төсөөлөлтэй адилаар сөрөг байна.Уул уурхайн салбарын өндөр өсөлтийн улмаас хууль журам, зохицуулалтын тогтолцооны дарамт, ачаалал нэмэгдсэнээр байгаль орчны хууль журмын хэрэгжилт учир дутагдалтай болж ирнэ.



4.2.2.2 Сум, аймаг, үндэсний түвшинд үзүүлэх нөлөөллийн эрчим

Бага өсөлттэй хувилбар: Бага өсөлттэй хувилбарт одоо байгаа уурхайнуудын тал орчим нь үйл ажиллагаа явуулна гэж үзсэн бөгөөд тиймээс, дундаж болон өндөр өсөлттэй хувилбаруудтай харьцуулахад уул уурхайн нөлөөлөлд өртөж болзошгүй тусгай хамгаалалтай газрууд болон бэлчээрийн нутаг дэвсгэрийн хэмжээ бага байхаар байна. Талуудын үүрэг роль, хариуцлага тодорхойгүй нөхцөл байдал олон тооны малтай малчдад илүү ашигтай байдаг. Засгийн газрын зүгээс мал аж ахуйг дэмжих зорилгоор бэлчээр ашигласны төлбөрийг малчдаас авдаггүй тул илүү бэлчээр ашиглаж байгаа малчид илүү ашиг тусыг хүртдэг. Бодлого судлалын төвийн хийсэн судалгаанд дурдсанаар нийт малчдын 9% нь 500 гаруй малтай бөгөөд нийт малчдын ойролцоогоор 70% нь 200-аас бага тооны малтай байна (Бодлого судлалын төв, 2013). Тиймээс, бүх малчид энэ бодлогоос эрх тэгш ашиг тус хүртэхгүй байгаа ба чинээлэг малчид чанарт анхаарахаасаа илүүтэйгээр малынхаа тоо толгойг улам бүр нэмэгдүүлэх байдлаар үнэгүй ашигладаг бэлчээрээ улам бүр тэлж байгаа одоогийн энэ бодлого нь малчдын дунд орлогын тэгш бус байдлыг нэмэгдүүлж байна.

Дундаж өсөлттэй хувилбар: Одоогоор хамгаалалтанд авахаар санал болгоод байгаа газруудаас гадна БОНХЯ болон ТНС-ийн зүгээс Монгол улсын баруун, хойд, төвийн бүс нутгуудад судалгаа хийн хамгаалах шаардлагатай нэмэлт газруудыг тодорхойлж байгаа ба судалгааны ажил арай дуусаагүй байгаа юм. Тиймээс, орон зайн дүн шинжилгээнд эдгээр баруун, хойд, төвийн бүсүүдэд нэмэж хамгаалахаар санал болгож буй нутаг дэвсгэрийг оруулаагүй болно. Зураг 4.3-т үзүүлсэнчлэн, дундаж өсөлттэй хувилбарын хувьд 4.21 га хамгаалалттай (мөн хамгаалахаар санал болгож буй) газар нутгууд уул уурхайн ашиглалтын болон хайгуулалтын тусгай зөвшөөрөл бүхий газар нутгуудтай давхцаж байгаа бөгөөд Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Баянхонгор болон Говь-Алтай аймгуудад ихэнх газрууд нь байрлаж байна. Бэлчээрт үзүүлэх нөлөөллийн хувьд Өмнөговь, Дорнод, Дундговь, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгуудад нөлөөллийг бууруулахад илүү анхаарах шаардлагатай байна. Зураг 4.4-т харагдаж байгаагаар газар зүйн байршлын хувьд дээрх нөлөөлөл нь бүх аймаг болон сумдад жигд тархаагүй, харин тодорхой газар нутгуудад илүү төвлөрсөн байгаа нь харагдаж байгаа юм. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын бэлчээрийн нөлөөллийг тусад нь харуулсан бөгөөд өсөлтийн хувилбар бүрийн хувьд өөр өөр нөлөөлөл үүснэ гэж дүгнэлээ. Тиймээс, байршил, талбайн хэмжээ, уурхайн төрөл, өсөлтийн хувилбараас хамааран бэлчээрийн асуудлаар өөр өөр арга хэмжээ авах шаардлагатай байна.

Өндөр өсөлттэй хувилбар: Зураг 4.3 болон Зураг 4.4-т харуулсанчлан өндөр өсөлттэй хувилбарын үед уул уурхайгаас бэлчээр болон хамгаалалттай газар нутагт үзүүлэх дарамт өндөр байна. Нээгдэж болзошгүй уурхайнуудын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий газар нутаг (өндөр өсөлттэй үеийн бодит уурхайнууд) тийм их том биш тул, дундаж өсөлттэй болон өндөр өсөлттэй хувилбаруудын үед ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн бүс нутагтай давхцсан тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ ойролцоо байхаар байна. Эсрэгээрээ бэлчээрийн хувьд уурхайн талбай гэхээсээ тоо хэр олон байгаагаас нөлөөллийн цар хүрээ шалтгаална. Иймд дундаж болон өндөр өсөлттэй үед уул уурхайн нөлөөлөлд өртөж болзошгүй бэлчээрийн нутаг дэвсгэрийн хэмжээ ихээхэн ялгаатай байхаар байна (ашиглагдаж болох уурхайн тоо ихээхэн зөрүүтэй тул). Өндөр өсөлттэй хувилбарын хувьд одоо байгаа 330 уурхай дээр нэмээд 259 шинэ уурхай ашиглалтанд орж уурхайнуудын тоо бараг хоёр дахин



нэмэгдэж болзошгүй байна. Уул уурхайн үйл ажиллагаанд тодорхой хэмжээний газар нутаг, дэд бүтэц зайлшгүй шаардлагатай байдгаас уурхайн тоо ингэж огцом нэмэгдэх нь тусгай хамгаалалттай болон бэлчээрийн газар нутагтай холбоотой маргаан зөрчил ихээхэн нэмэгдэхэд хүргэж болзошгүй юм. Үүнд, тусгай хамгаалалттай газар нутаг болон бэлчээрийн хуваагдал орж болно. Цаашлаад, өндөр өсөлттэй хувилбарын үед бэлчээрийн талбай багассанаас бэлчээрийн даац хэтрэх байдлаар газрын төлөв байдал, хөрсний чанарт хамгийн их нөлөөлөл үзүүлэхээр байна. Газар ашиглах эрх хамгаалагдаагүй тохиолдолд бэлчээрийн даац хэтрэх эрсдэл нэмэгдэнэ. Энэ талаар 4.3.3 буюу Хүний эрх ба олон нийтийн оролцоо хэсгээс харна уу.

Нөлөөллийн хураангуй

Бага өсөлтийн хувилбар	<ul style="list-style-type: none"> Уурхайн нөлөөлөлд өртөх хамгаалалттай болон бэлчээрийн зориулалттай газар нутгийн талбай бага байна.
Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none"> Уурхайн нөлөөлөлд өртсөн хамгаалалттай газар нутгууд ихэвчлэн Дорнод, Сүхбаатар, Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай аймгуудад байрлаж байна. Өмнөговь, Дорнод, Дундговь, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгуудад бэлчээрийн нутаг дэвсгэр илүүтэйгээр уурхайн нөлөөлөлд өртөхөөр байна. Газар зүйн байршлын хувьд үүсэж болзошгүй нөлөөлөл нь бүх аймаг, сумдад жигд тархахаасаа илүүтэйгээр тодорхой газар нутгуудад үүснэ.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none"> Уурхайн тоо ихэссэнээр хамгаалалттай газар нутаг болон бэлчээрийн талбайд газар ашиглалттай холбоотой зөрчил маргааныг хурцатгаж болзошгүй (нөлөөлөлд хамгийн их өртсөн талбайг Дундаж өсөлтийн хувилбараас харна уу). Газрын төлөв байдал, хөрсний чанар нь ихэвчлэн бэлчээрийн талбай багасч даац хэтэрсэнээс муудна.

4.2.2.3 Газар ба бэлчээр ашиглалт: Арга хэмжээний зөвлөмжүүд

Хүснэгт 4.6 Газар ба бэлчээр ашиглалт: Арга хэмжээний зөвлөмжүүд

Арга хэмжээний зөвлөмж	
Газар ашиглалт, зохион байгуулалтын хууль эрх зүйн орчин, хэрэгжилтийн орчныг сайжруулах:	
<ul style="list-style-type: none"> Бэлчээр ашиглах эрх Олон нийтийн оролцоотой газар зохион байгуулалтын төлөвлөгөө Бүс нутгийн хэмжээнд газар ашиглалтын төлөвлөлтийг зохион байгуулах, чадавхийг бэхжүүлэх 	
Сум	<ul style="list-style-type: none"> Бизнесийн хөгжил саарах үед хууль бусаар ан хийх, мод огтлох байдлыг нэмэгдүүлэхгүй байхад Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа анхаарч ажиллах нь зүйтэй. Газар ашиглах, эзэмших, өмчлөх эрхийг хамгаалах (4.3.3 буюу Хүний эрх ба олон нийтийн оролцоо хэсгийг харна уу). Бэлчээр ашиглалтын уламжлалт эрхийг бүртгэх, бэлчээрийн ачаалал нэмэгдэж байгаагийн улмаас малчдын дунд бэлчээрийн газрын талаар маргаан үүсэхээс зайлсхийхийн тулд сумын түвшинд малчдын өөр өөр бүлгүүдийн ашиглаж буй бэлчээрийн хилийг тодорхойлох. Уул уурхайн үйл ажиллагаанд хөндөгдсөн газрын хяналт шинжилгээнд малчдыг оролцуулах оролцоонд түшиглэсэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хөхиүлэн дэмжих. Уул уурхайн нөлөөллийг бууруулах, бэлчээрийн удирдлагыг сайжруулахын тулд малчдын бүлгийг байгуулахыг хөхиүлэн дэмжих Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хүрээнд нутгийн иргэдийн оролцоотойгоор бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, бүс



	Арга хэмжээний зөвлөмж <ul style="list-style-type: none">нутгийн төлөвлөлттэй уялдуулах.Уурхайн бүх талбайд нөхөн сэргээлтийг хийлгэх, сэргээлт хийлгүйгээр орхих явдлыг гаргуулахгүй байхБэлчээр, тариалангийн газрын ачааллыг бууруулахын тул ЖДҮ-ийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх.Уул уурхайн компаниудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан арга хэмжээг сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөтэй уялдуулах, хянах, тайлагнах.
Аймаг	Дээр дурдсанаас гадна: <ul style="list-style-type: none">Зайлсхийх, бууруулах, сааруулах арга хэмжээ авсан хэдий ч бууруулж чадаагүй уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах замаар сааруулах арга хэмжээний ил тод санаачлагыг хэрэгжүүлэх.Уурхайн дэд бүтцийн улмаас хөрсний эвдрэл, бэлчээрийн доройтол үүсэх нь малчид, нутгийн иргэдийн санааг зовоосон асуудал болж байгааг анхааралдаа авах үүднээс тээврийн төлөвлөлтийн хүрээнд газар зохион байгуулалт, хөрс хамгаалах зорилтуудыг уялдуулан нэгтгэх.
Улс	<ul style="list-style-type: none">Уурхайн шууд нөлөөллийн бүсээс малчдыг нүүлгэх, байгалийн нөөц ашиглах боломжоо хязгаарлуулснаас алдсан алдагдалд нь нөхөн олговор олгох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх.Шаардлагатай бол төрийн өмчийн бэлчээрийн удирдлага, ашиглалтын чиглэлээр оролцогч бүх талууд түүний дотор малчид, тэдний нутаг усныхан, орон нутгийн засаг захиргааны үүрэг, хариуцлагыг тодорхой болгосон бодлого, хуулийг улам бүр боловсронгуй болгох.Бэлчээрээс үүдэлтэй зөрчилдөөнөөс сэргийлэх, бэлчээр хамгааллыг сайжруулах, удирдах үүднээс задгай бэлчээрийг малчдын бүлэгт түрээсээр эзэмшүүлэх эрх олгох.Зайлсхийх, бууруулах, сааруулах арга хэмжээ авсан хэдий ч бууруулж чадаагүй уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах замаар сааруулах арга хэмжээний ил тод санаачлагыг хэрэгжүүлэх.Уул уурхай, тээврийн шинэ бүтээн байгуулалтанд хөрс хамгаалах дизайн, технологи түүний дотор хатуу хучилттай зам, төмөр зам, уурхайн байнгын нөхөн сэргээлт, хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, замгүй газраар явдаг тээврийн хэрэгслийг хориглох, хэрэглэж болох тохиолдолд хөрс тогтворжуулах технологийг ашиглах хөшүүрэгтэй болгохХөрсний чанарт үндэслэн уул уурхайн үйл ажиллагаанд тохиромжтой газрыг тогтоож, төлөвлөхУурхайн дэд бүтцийн улмаас хөрсний эвдрэл, бэлчээрийн доройтол үүсэх нь малчид, нутгийн иргэдийн санааг зовоосон асуудал болж байгааг анхааралдаа авах үүднээс тээврийн төлөвлөлтийн хүрээнд газар зохион байгуулалт, хөрс хамгаалах зорилтуудыг уялдуулан нэгтгэх.

4.2.3 Агаарын чанар

4.2.3.1 Нөлөөлөл ба хувилбаруудын танилцуулга

Уурхайтай холбоотойгоор үүсч буй тоосжилт, уурхайн зам тээврийн үйл ажиллагаанаас үүдсэн агаарын чанарын нөлөөлөл нь уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн сумдаас хэлэлцүүлэгт оролцсон талуудын хөндөж тавьсан гол асуудал байв. Хэдийгээр уурхайн үйл ажиллагаанаас үүдсэн агаарын чанарын асуудлыг талууд аймаг, улсын түвшинд мөн чухал



хэмээн тодорхойлсон ч улам нэмэгдсээр байгаа орчны тоосжилтын шууд нөлөөнд автсан сумдын иргэдийн асуудалтай харьцуулахад цар хэмжээний хувьд адилгүй юм.

Монгол улсын ихэнх газар нутаг хөрсний элэгдэлд өртөх магадлал өндөртэй, хур багатай тул улирлын чанартай хүчтэй шороон шуурганд өртөмтгий. Барилгажилт, ашигт малтмалын тээвэрлэлт зэрэг уурхайн үйл ажиллагаанаас үүдсэн хэсэг газруудын хөрсний эвдрэлүүд нь агаарын тоосжилтод өртсөн газар нутгийн иргэдийн, ялангуяа малчдын нөхцөл байдлыг улам дордуулдаг. Уурхайн тоосжилт нь говийн бүсэд ихээхэн хохирол учруулж байгаа ба ялангуяа, нүүрсний уурхайгаас хатуу хучилттай замгүй газраар Хятад улс руу нүүрс тээвэрлсэнээс уг асуудал үүсч байна. Уурхайд шаардлагатай түлш, бусад эд барааг муу тавигдсан засмал зам, эсвэл шороон замаар, мөн түүнчлэн замгүй газраар олон салаа зам (хуучин зам дээр саад тотгороос зайлсхийхийн тулд тойрч шинэ мөр үүсгэх) гарган тээвэрлэж байгаа нь томоохон уурхайнуудын санааг зовоож байна. Өмнөд говийн бүсэд 2005-2012 оны хооронд нүүрсний олборлолт эрчимтэй хөгжсөнөөс уурхайг тойрон нутаглах ард иргэдийг нэлэнхүйд нь тоосжилтын нөлөөлөлд өртүүлж, хилийн боомт хүртэлх хэдэн зуун километр үргэлжлэх нүүрсний тээврийн шороон замыг дагасан тоосжилтын асуудлыг бий болоход хүргэсэн. Энэ нь зөвхөн говийн бүсийн асуудал болоод зогсохгүй уурхайн үйл ажиллагаа явагдаж буй өөр бүс нутгуудад ч урган гарч ирж байгаа бөгөөд улирлын чанартай шороон шуурга ч үүнд нэрмээс болж байна.

Уурхай болон уурхайн замаас үүдсэн тоосжилттой холбоотой олон нийтийн асуудлын гол нь хүн, малын эрүүл мэндтэй холбоотой байна. Бэлчээрийн нутаг дэвсгэрт үүсгэх тоосжилтын нөлөөлөл нь мөн адилхан асуудал үүсгэж байна. Түүнчлэн, олон нийтийн зүгээс тавьж буй өөр нэг асуудал нь уурхайн замаас үүдсэн тоосжилт үзэгдэх орчинг хязгаарлаж, олон нийтийн аюулгүй ажиллагаанд заналхийлж байна гэж үзэж байгаа явдал юм.

Уурхайн компаниудын агаарын чанарын зохицуулалтын хүрээнд авч байгаа гол арга хэмжээ нь ихэвчлэн тоосны дэгдэлтийг дарах арга байдаг. Уурхайн ил хэсэг болон шороон зам дээр ус цацаж тоосыг дарах нь түгээмэл хэрэглэдэг арга. Гэхдээ хөрсний ус багатай говийн аймгуудад, ялангуяа хүн ам сийрэг хэсэгт агаарын чанарын асуудлаас илүүтэйгээр усны нөөцийн асуудал чухалд тооцогдож байна. Ургамлын бүрхэвч бий болгох, хөрс нягтаршуулах бодис ашиглах, уурхайн бүтээгдэхүүний овоолгыг бүтээх, салхины хаалт барих, нүүрсийг тоосонцор үүсэхгүй болтол боловсруулах, мөн боловсруулах, бутлах, тээвэрлэх хэсгүүдэд тоос шүүх байгууламж суурилуулах зэрэг нь уурхайн агаарын чанарын зохицуулалтын хүрээнд авч хэрэгжүүлж байгаа тэргүүлэх туршлагауд юм.

Бага өсөлтийн хувилбар нь тоосжилтын тархалтыг газар зүйн хувьд хумиж байгаа боловч уурхайн үйл ажиллагаа ихтэй, газар зохион байгуулалт муу, тээврийн дэд бүтэц хөгжөөгүй газруудад асуудлууд хэвээр байх болно. Тоосжилтод шууд өртдөөгүй, эсвэл уурхайн тоосжилтын талаар мэдлэггүй аймаг, үндэсний түвшний оролцогч талууд тоосны асуудлыг чухалд үл тооцон хамаагүй доогуур эрэмбэлсэн юм. Нөгөөтэйгүүр Улаанбаатар хот, томоохон бүсийн төвүүдийн уурхайтай холбоогүй, төлөвлөлт муутай хотжилтоос үүдсэн агаарын чанарын асуудал нь үүнтэй холбоотой эрүүл мэнд, эрүүл ахуйн асуудлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх хөшүүрэг болно.

Тунгаагуур, цөөрөм зэрэг уурхайн хаягдлын байгууламжаас үүдсэн тоосжилт нь зарим уурхайн хувьд тухайн орчиндоо илүү хамааралтай асуудал болж байгаа бөгөөд энэ төрлийн хаягдлаас гарч буй тоосжилтын химийн найрлагаас шалтгаалсан онцгой төрлийн эрүүл мэндийн асуудал ч бий болж болох юм. Гэвч энэ нь Дархан, Эрдэнэт гэх мэт хүн амын нягтаршилтай суурин газрын ойролцоо байрших томоохон уурхай, боловсруулах үйлдвэрүүдэд тохиолдох харьцангуй хязгаарлагдмал асуудал юм.

Уурхайн талбай дээрх, ихэвчлэн нүүрсэн галлагаатай эрчим хүчний үүсвэр, халаах станц зэргээс үүсэх хийн ялгарал нь тухайн хэсгийн орчны агаарын чанарыг муутгах ба оролцогч талуудын хувьд ноцтой асуудалд тооцогдоогүй болно.



Хүснэгт 4.7 Оролцогч талуудын тодорхойлсон агаарын чанартай холбоотой эн тэргүүний асуудлууд

Түвшин	Бага өсөлттэй хөгжлийн хувилбар	Дундаж өсөлттэй хөгжлийн хувилбар	Өндөр өсөлттэй хөгжлийн хувилбар
Эн тэргүүний асуудлууд:			
• Агаарын чанарын доройтол			
Сум	<ul style="list-style-type: none"> Цэвэр нөлөөлөл нь эерэг байна. Уул уурхайн салбарын хөгжил удааширнаар, ашигт малтмалын тээвэрлэлт багасаж, улмаар агаарын бохирдлын хэмжээ өмнөх хэмжээндээ, эсвэл бүр буурч болох юм. Агаарын чанарын асуудал нь тулгамдсан асуудал биш байна. 	<ul style="list-style-type: none"> Агаарын чанарын асуудал ялангуяа, уул уурхайн талбайн эргэн тойрон болон Улаанбаатар хотод ихээхэн нөлөөлөл үзүүлэх ноцтой асуудал болно. Тоосжилт болон бохирдол хүний болон амьтдын эрүүл мэндэд нөлөөлдөг бөгөөд төр засаг болон уул уурхайн компаниуд энэ асуудлыг үр дүнтэй байдлаар зохицуулах арга хэмжээ авахгүй бол энэ асуудал улам бүр ноцтой болно. 	<ul style="list-style-type: none"> Уул уурхайн үйл ажиллагаа ихэссэнээс үүдэлтэй агаарын бохирдол нь нутгийн иргэдэд тулгарах гол асуудал болно. Уул уурхайн үйл ажиллагаа, ашигт малтмалын тээвэрлэлт ихэссэнээс үүдэж тоосжилтын түвшин өснө. Агаарын чанар доройтох нь хүн, малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.
Аймаг	<ul style="list-style-type: none"> Дээрхтэй адилхан. 	<ul style="list-style-type: none"> Агаарын чанар нь аймгийн түвшинд нэг их том асуудал биш байна. Одоогийн болон цаашдын агаарын чанар муу байхаас үүдэн мал сүргийн эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөлөл нь хамгийн том санаа зовоосон асуудал болно. 	<ul style="list-style-type: none"> Агаарын чанарын асуудлыг одоо байгаа олон шороон замыг хатуу хучилттай болгож, ашигт малтмалын тээвэрлэлтээс гарах тоосжилтын хэмжээг бууруулснаар багасгана. Агаарын чанарын асуудал нь хүн, малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөн асуудал хэвээр байна. Гэвч, уул уурхайн өндөр өсөлт гарснаар аймгийн төсвийн орлого нэмэгдэж, баталгаажих бөгөөд энэ нь байгаль орчны менежмент болон нөлөөллийг бууруулах арга хэмжээнд зориулсан санхүүжилт ихэснэ гэсэн үг. Цэвэр нөлөөлөл нь сөрөг байна.
Улс	<ul style="list-style-type: none"> Дээрхтэй адилхан. 	<ul style="list-style-type: none"> Дээрхтэй адилхан. 	<ul style="list-style-type: none"> Уул уурхайн өсөлттэй холбоотой агаарын чанарын нөлөөлөл нь улсын хэмжээнд эн тэргүүний тулгамдсан асуудал биш байна. Төсөв нэмэгдсэнээр уул уурхайн үйл ажиллагааг уялдуулж, байгаль орчны нөлөөллийн хяналт шинжилгээ, менежмент хийх чадавхи нэмэгдэнэ.



4.2.3.2 Сум, аймаг, улсын түвшинд үзүүлэх нөлөөллийн эрчим

Сумын түвшинд үзүүлэх нөлөөллийн эрчим

Уурхайн тоосжилт нэмэгдсэнээс агаарын чанар доройтож буй нь сумын түвшинд хамгийн тулгамдсан асуудал болоод байна. Ялангуяа уурхайн тээвэр дайран өнгөрдөг орон нутгийн ард иргэд өөрсдийн биеээр мэдэрсэн туршлага, олон нийтэд цацагдаж, мэдэгдсэн тохиолдлуудад үндэслэн асуудлыг гаргаж тавьдаг. Нүүрс, төмрийн хүдэр, газрын тос зэрэг овор ихтэй ашигт малтмалаар баялаг сумдад шороон замаар уурхайн тээвэрлэлт хийгдэх нь маш их байна. Уурхайгаас үүдсэн тоосжилтоос агаарын чанар муудах байдал нь газрын хөрсийг хэр их хөндсөнөөс ихээхэн шалтгаалдаг. 4.2.2.2-р хэсэгт газрын төлөв байдалд үзүүлэх нөлөөллийг тодорхойлсон дүн шинжилгээ нь энэхүү агаарын чанарын асуудалд мөн хамааралтай. Өмнөговь, Дорнод, Дундговь, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын уурхайтай сумдад дундаж, өндөр өсөлттэй үеийн уурхайн үйл ажиллагаанаас үүдсэн тоосжилт агаарын чанарт ноцтой сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна. Бага өсөлтийн үед агаарын чанарын доройтол тийм ч ноцтой асуудалд тооцогдохгүй гэж хэлэлцүүлгүүдэд сумдаас оролцсон талууд үзэж байгаа ч тээврийн дэд бүтэц, хатуу хучилттай зам ашиглах тухай хууль, журмын мөрдөлт хангалтгүй зэргээс шалтгаалан бага өсөлтийн үед ч цөөн тооны томоохон уурхайнуудаас ирэх зарим нөлөөллүүд ихээхэн хэмжээний хор, хохирол учруулж болзошгүй юм.

Аймгийн түвшинд үзүүлэх нөлөөллийн эрчим

Аймгийн түвшинд нөлөөлөлд өртөгч талууд уул уурхайн үйл ажиллагааны орлого нэмэгдэхийн хэрээр хөрөнгө оруулалт ихэсч, улмаар дундаж болон өндөр өсөлтийн үед уурхайн тээвэрлэлтийн дэд бүтэц хөгжин агаарын чанарын асуудалд эерэг нөлөө үзүүлнэ хэмээн үзлээ. Саяхан Өмнөговь, Дундговь, Төв аймгууд зэрэг томоохон уул уурхайн бүс нутгуудад төмөр зам, хатуу хучилттай замын дэд бүтэцэд хөрөнгө оруулалт хийгдсэн. Орон нутгийн иргэдийн агаарын чанарын доройтлын талаар дэвшүүлсэн асуудлын хариу болгож аймаг, үндэсний түвшний засаг захиргаанаас уурхайн үйл ажиллагаанд заавал хатуу хучилттай зам ашиглах саналыг дэмжиж, журамласан. Аймгийн засаг захиргааны газар ашиглалтын төлөвлөгөөний хүрээнд хүлээх үүрэг, хариуцлагад уурхайн хотхоны хот төлөвлөлтөд агаарын чанарын асуудлыг тусгах, бүсийн зам, тээврийн төлөвлөлт хийх зэргээр дамжуулан уурхайн тоосжилттой холбоотой асуудлыг шийдэх зэрэг үйл ажиллагаа багтана.

Улсын түвшинд үзүүлэх нөлөөллийн эрчим

Зам, тээврийн дэд бүтцийг хөгжүүлэхэд үндэсний хэмжээнд хөрөнгө оруулалт хийх нь агаарын чанарын нөлөөллийг бууруулахад шаардлагатай гол хүчин зүйл ч хэлэлцүүлэгт оролцогч талууд уурхайгаас үүдэлтэй агаарын чанарын доройтлыг үндэсний хэмжээний асуудал гэж үзээгүй юм. Уурхайн тоосжилттой холбоотой асуудалд үндэсний түвшинд шийдвэр гаргагч талууд ихээхэн нөлөөтэй. Газрын элэгдэл, эвдрэлийг бууруулах, бэлчээрийн менежментийг сайжруулах үндэсний санаачилга нь тоосжилтын нөлөөллийг бууруулахад чиглэсэн үндэсний хэмжээний идэвх санаачилга юм. Мөн үүний нэгэн адилаар ашигт малтмалыг хатуу хучилттай замаар тээвэрлэх, уурхайн нөхөн сэргээлтэд тавигдах зөвлөмж шаардлага гаргах замаар уурхайгаас үүдсэн тоосжилттой тэмцэх төрийн бодлогууд хэрэгжиж эхэлсэн. Газар ашиглалтын төлөвлөлтийг сайжруулснаар тээврийн дэд бүтэц ба агаарын чанарын нөлөөллийг бууруулах



арга хэмжээнүүд үр дүнтэй уялдан хэрэгжих болно (4.4.4 буюу Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц хэсгийг үзнэ үү).

Нөлөөллийн хураангуй

Бага өсөлттэй хувилбар:	<ul style="list-style-type: none"> Энэ хувилбараар аваад үзвэл зам тээврийн нөхцөлөөс хамаараад цөөн тооны томоохон уурхайнууд агаарын чанарт нөлөөлнө.
Дундаж/ Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none"> Дундаж/ өндөр өсөлтийн хувилбараар авч үзвэл Өмнөговь, Дорнод, Дундговь, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгийн сумдад уурхайн тоосжилтоос үүдсэн агаарын чанарын доройтол ихээхэн хэмжээгээр учирна.

4.2.3.3 Агаарын чанар: Арга хэмжээний зөвлөмжүүд

Хүснэгт 4.8 Агаарын чанар: Арга хэмжээний зөвлөмжүүд

Арга хэмжээний зөвлөмж	
<ul style="list-style-type: none"> Хөрсний элэгдэл, тоосжилтыг бууруулах тээврийн төлөвлөлт, дэд бүтцийг хөхиүлэн дэмжих Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийг цаашид дэмжих 	
Сум	<ul style="list-style-type: none"> Жил бүрийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хүрээнд тоосжилтыг бууруулах арга хэмжээгээр дамжуулан уул уурхай, тээвэрлэлттэй холбоотой агаарын чанарын менежментийн хууль, тогтоомжийн мөрдөлтийг сайжруулах; Ард иргэдэд замгүй газраар олон салаа шинэ зам гарган зорчиж байгаагийн хор нөлөөний талаарх ойлголт өгөх, орчны тоосны түвшинг хэмжих, түүнчлэн олон нийтийн оролцоог хангасан тоосжилтыг хянах оролцооны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх; Уул уурхайн үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган бууруулах, уг төлөвлөгөөнд тоосны нөлөөллийн бүсийг тодорхойлж тухайн газруудад (ашигт малтмалын тээврийн том замуудын ойролцоо г.м.) суурьшил бий болохоос урьдчилан сэргийлэх.
Аймаг	Уурхайн дэд бүтцийн улмаас хөрсний эвдрэл, бэлчээрийн доройтол үүсэх нь малчид, нутгийн иргэдийн санааг зовоосон асуудал болж байгааг анхааралдаа авах үүднээс тээврийн төлөвлөлтийн хүрээнд газар зохион байгуулалт, хөрс хамгаалах зорилтуудыг уялдуулан нэгтгэх.
Улс	<ul style="list-style-type: none"> Хөрсний элэгдэл, тоосжилтыг бууруулдаг тээврийн төлөвлөлт, дэд бүтцийг хөхиүлэн дэмжих, жишээ нь, бүсийн тээврийн төлөвлөлт, хатуу хучилттай зам, төмөр зам г.м. Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй нөлөөлөл, бууруулах арга хэмжээний үр дүнг хэмжих үүднээс бүсийн хэмжээнд тоосжилтын хяналт шинжилгээний сүлжээг бий болгох. Уурхайн дэд бүтцийн улмаас хөрсний эвдрэл, бэлчээрийн доройтол үүсэх нь малчид, нутгийн иргэдийн санааг зовоосон асуудал болж байгааг анхааралдаа авах үүднээс тээврийн төлөвлөлтийн хүрээнд газар зохион байгуулалт, хөрс хамгаалах зорилтуудыг уялдуулан нэгтгэх. Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийг цаашид дэмжих.



4.2.4 Байгаль орчны менежмент

4.2.4.1 Нөлөөлөл ба хувилбаруудын танилцуулга

Энэ хэсэгт уул уурхайн компаниудын үйл ажиллагааныхаа нөлөөллийг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа байгаль орчны менежментийн арга хэмжээнд уул уурхайн салбарын өсөлтийн өөр өөр хувилбарууд ямар нөлөөлөл үзүүлэх талаар авч үзлээ. Орон нутаг, төрийн байгууллагуудын шахалт, шаардлага уул уурхайн салбарын байгаль орчны асуудалд ихээхэн анхаардаг болсноос сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд уурхайн байгаль орчны менежмент нь дэлхийн даяар энэ салбарын хэрэгжүүлэх гол зарчмуудын нэг болжээ. Ашигт малтмалын эрэл хайгуул ихэссэнээс дээрх асуудлууд Монгол улсын хувьд өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд бий болоод байна. Өнөөдөр Монгол улсад үүсээд буй байгаль орчны асуудлуудтай олон арван жилийн өмнө тулгарч байсан, уул уурхайн салбар олон жилийн өмнөөс хөгжсөн өөр бусад улс орнуудтай харьцуулахад Монгол улсын уул уурхайн салбарын байгаль орчны менежментийн чадавхи сул байна. БОНСҮ-д оролцогч талууд ч мөн уул уурхайн байгаль орчны менежментийг Монгол улс дахь уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн нөлөөллийн цар хүрээ, ач холбогдлыг тодорхойлох гол хүчин зүйл гэж үзсэн юм (Хүснэгт 4.9-г үзнэ үү).

Энд авч үзсэн уул уурхайн байгаль орчны менежментийн бүрдэл хэсгүүдэд дараах асуудлууд орж байна. Үүнд, уул уурхайн байгаль орчны менежментийн боловсон хүчний болон санхүүгийн нөөц боломж, байгаль орчны асуудлуудыг тодорхойлж, тэдгээрт тохирсон менежментийн арга хэмжээг авах салбарын мэдлэг, чадвар, уул уурхайн салбарын байгаль орчны менежментийн олон улсын тэргүүн туршлагыг хэрэгжүүлэх зэрэг болно. Энэ 3 бүрдэл хэсгүүд нь оролцогч талуудтай хэлэлцүүлэг хийх үеэр гарсан асуудлуудыг багтааж байгаа юм. Уул уурхайн салбарын байгаль орчны менежментэд хөгжлийн хувилбар бүрийн үзүүлэх нөлөөллийн талаар нарийвчилсан шинжилгээ хийхэд ашиглахуйц байгаль орчны менежментийн үзүүлэлтийг хэмжих салбарын хэмжээний болон тодорхой судалгаа Монголд байхгүй байна. Гэхдээ, Монгол болон олон улсад уул уурхайн салбарт ажиллаж байгаа байгаль орчны мэргэжилтнүүдийн туршлагыг энэ үнэлгээнд ашиглалаа.

Хүснэгт 4.9 Орлоцгогч талуудын тодорхойлсон уул уурхайн компаниудын байгаль орчны менежментийн эн тэргүүний асуудлууд

Түвшин	Бага өсөлттэй хөгжлийн хувилбар	Дундаж өсөлттэй хөгжлийн хувилбар	Өндөр өсөлттэй хөгжлийн хувилбар
Эн тэргүүний асуудлууд:			
	<ul style="list-style-type: none"> Уул уурхайн компаниудын байгаль орчны менежмент Байгаль орчны хууль, тогтоомж 		<ul style="list-style-type: none"> Уул уурхайн компаниудын нөхөн сэргээлт Биологийн олон янз байдлын хамгаалал
Сум	<ul style="list-style-type: none"> Биологийн олон янз байдал, экологийн тогтолцоо, амьтдын амьдрах орчин ерөнхийдөө хадгалагдаж үлдэх бөгөөд сөрөг нөлөөлөл бага байна. Хүмүүс хөдөө аж ахуй, мал аж ахуйд илүү их анхаарч бизнесийн боломж хайх болсноор байгаль орчинд илүү их дарамт учирч, ой мод устах, бэлчээрийн даац хэтрэх зэргээр байгаль орчны доройтол нэмэгдэнэ. ЗГ уул уурхайн нөлөөлөл болон уул уурхайн салбарт мониторинг, үнэлгээ хийх одоогийн чадавхитай хэвээр байна. Энэ хувилбарын үеийн цэвэр нөлөөлөл нь бага зэрэг эерэг байна. 	<ul style="list-style-type: none"> Уул уурхайн компаниудын байгаль орчны нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа муу, төрийн байгууллагын ажилтнуудын байгаль орчны нөхөн сэргээлт, биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааг зохицуулж, мониторинг хийх чадавхи сул хэвээр байна. 	<ul style="list-style-type: none"> Олон тооны уурхай байна гэдэг нь уул уурхайн компаниудын байгаль орчны менежмент болон нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд хяналт сул байна гэсэн үг. Олон уурхайнууд байгаль орчны тэргүүний туршлагыг хэрэглэхгүй байгаа тул экологийн эмзэг тогтолцоонд ихээхэн хохирол учирч, биологийн олон янз байдал болон зэрлэг амьтад алга болж, устана. Байгаль орчинд цэвэр сөрөг нөлөөлөл учирна.
Аймаг	<ul style="list-style-type: none"> Дээрхтэй адилхан. 	<ul style="list-style-type: none"> Дээрхтэй адилхан. Дээр нь, дундаж өсөлттэй үед орлогын түвшин, албан тушаалтнуудын чадавхи, хүсэл эрмэлзэл багаас хуучирч орхигдсон уурхайн талбайг нөхөн сэргээх үйл ажиллагаа хийгдэхгүй. 	<ul style="list-style-type: none"> Сумын түвшинтэй адил өөрчлөлтүүд бий болно. Гэхдээ мониторинг, менежмент хийх илүү боломжтой аймгийн удирдлага эдгээр нөлөөг тодорхой түвшинд бууруулж, урьдчилан сэргийлнэ. Уул уурхайн өсөлт, хөгжлөөс болж биологийн олон янз байдалд сөрөг нөлөөлөл учирч, эрсдэлд учраад байсан амьтдын амьдрах орчин, орон зай устаж, экологийн эмзэг тогтолцоо сүйдэнэ. Энэ тохиолдолд цэвэр алдагдал гарна.
Улс	<ul style="list-style-type: none"> Дээрхтэй адилхан. 	<ul style="list-style-type: none"> Дээрхтэй адилхан. 	<ul style="list-style-type: none"> Биологийн олон янз байдал алга болон устаж, эрсдэлд учраад байсан экологийн тогтолцоо сүйдэж, Монгол улсын ихэнх зэрлэг амьтдын амьдрах орон зай, орчин нөлөөлөлд өртөнө. Уурхайн үйл ажиллагаанаас ихээхэн хэмжээний газарт сөрөг нөлөөлөл учирч, эдгээр газарт нөхөн сэргээлтийн ажил бага хийгдэнэ. Байгаль орчны менежмент, мониторинг хийх ЗГ-ын төсөв нэмэгдэх ч, ЗГ хөгжлийн хурдыг гүйцэж чадахгүй. Байгаль орчинд цэвэр алдагдал гарна.



4.2.4.2 Сум, аймаг, улсын түвшинд үзүүлэх нөлөөллийн эрчим

Уул уурхайн салбарын хөгжлийн хувилбарууд болон уул уурхайн компаниудын авч хэрэгжүүлэх уурхайн байгаль орчны менежментийн үр дүнтэй байдалд дараах хүчин зүйлс нөлөөлнө. Үүнд:

Хууль эрх зүйн шаардлага болон орон нутгийнхны хүлээлт - Уул уурхайн байгаль орчны менежмент нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, зөвшөөрөл авахад тавигддаг шаардлагуудыг хангах, орон нутгийнхны хүсэлт шаардлага болон холбогдох талуудаас гаргасан асуудлуудыг шийдвэрлэхэд ихэнхдээ чиглэгдсэн байдаг. Уул уурхайн үйл ажиллагаа нэмэгдэхийн хэрээр тус салбарын байгаль орчны асуудлууд өндөр ач холбогдолтой болж байгаа нь хуулиар зохицуулсан болон орон нутгийнхны шаардлагад нийцэх байгаль орчны менежментийн арга хэмжээг нэмэгдүүлэх төлөвтэй байна.

Туршлага, мэдлэгтэй байгаль орчны ажилтнуудтай байх - Энэ асуудал нь Монголын байгаль орчны мэргэжилтнүүд уул уурхайн салбарын мэдлэг болон дадлага туршлагатай болоход шаардагдах цаг хугацаа, хэрэгцээт мэдлэг, судалгаагаар хангах их дээд, сургуулиудын хүртээмжтэй байдал, уул уурхайн байгаль орчны үндэсний мэргэжилтнүүдэд туршлага эзэмшүүлэхэд олон улсын байгаль орчны мэргэжилтнүүдийн оролцоо зэрэг хүчин зүйлүүдээс хамаарна. Бага өсөлттэй хувилбарын хувьд цөөн тооны уурхайн байгаль орчны мэргэжилтнүүдэд мэдлэг, ур чадвартай болох болон салбарын эрэлт хэрэгцээ нэмэгдсэнээс дадлага туршлагатай мэргэжилтнүүдэд мэргэжлийн хувьд өсөж хөгжих боломж олдоно. Монгол улсын сүүлийн үеийн жишээнээс үзэхэд уул уурхайн хурдацтай өсөлтийн үед уурхайн байгаль орчны менежментийн харьцангуй цөөн тооны мэргэжилтнүүдийн эрэлт хэрэгцээ асар их болсноор жижиг уурхайнууд туршлагатай мэргэжилтэнтэй болох боломж ихээхэн хязгаарлагддаг. Мөн нөгөө талаар, уул уурхайн салбар өндөр өсөх үед олборлох салбарын байгаль орчны менежментийн болон институцийн хөгжлийн хөтөлбөрт хийх хөрөнгө оруулалт нэмэгдэж болох юм. Гэхдээ, өндөр өсөлттэй үед уул уурхайн байгаль орчны менежментийн шаардлагыг хангах хангалттай мэдлэг, туршлагатай мэргэжилтнүүдтэй болох хүртэл 5-10 жилийн хугацаа шаардлагатай байж болох ба аюултай хаягдлын хувьд байгаль орчинд 5-10 жилийн хугацааны дараа гарч болзошгүй урт хугацааны нөлөөллийг бууруулах менежмент хийх нь онцгой чухал.

Олон улсын дадлага туршлагатай томоохон уул уурхайн компаниудын оролцоо – Туршлагаас харахад томоохон уул уурхайн компаниуд, ялангуяа, олон улсын уул уурхайн компаниуд нь байгаль орчны менежментийн чадавхийг хөгжүүлэх, байгаль орчны менежментийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх хөрөнгө оруулалт хийх нь түгээмэл байдаг ба энэ нь олон улсын хувьцаа эзэмшигчдээс үзүүлэх нөлөөлөл болон бусад орнуудад ажилласан тэдний туршлагад үндэслэгдсэн байдаг. Ихэнх тохиолдолд олон улсын уул уурхайн том компаниуд нь тухайн улсын хууль ба газар зүйн байршлаас үл хамаарсан, байгаль орчны үйл ажиллагааны наад захын стандартыг хангах бодлого, стандарттай байдаг. Олон улсын уул уурхайн компаниудын үйл ажиллагаа болон байгаль орчны менежментийн олон улсын туршлага Монголд нэвтэрч байгаа нь байгаль орчны менежментийн талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулж байна. Гэхдээ энэ нь олон улсын хөрөнгө оруулалт шаардагдах уул уурхайн дундаж болон өндөр өсөлттэй байх үед л хадгалагдахаар төлөвтэй байна. Уул уурхайн бодлогын улмаас уул уурхайн салбар дахь олон улсын хөрөнгө оруулалт буурсан тохиолдолд, бага өсөлттэй уул уурхайн хөгжлийн хувилбарын үед олон улсын стандартын байгаль орчны менежмент дээрх



байдлаар нэвтрэх бололцоо багасах болно. Нөгөө талаас, байгаль орчны сайн менежмент шаардлагатай байгааг өргөн хүрээнд нэгэнт ойлгож байгаа учраас стратегийн орд газрыг цөөн тооны жижиг, сайн компаниар гүйцэтгүүлэхийг зорьвол зохих ёсоор анхаарал тавьж байгаль орчны сайн менежментийг хэрэгжүүлэх явдлыг баталгаажуулах боломжтой.

Байгаль орчны менежментэд орон нутгийнхан ямар байдлаар хэрхэн оролцох асуудлыг талуудтай хийсэн хэлэлцүүлгийн үеэр сумын оролцогчид хөндөж байв. Үүнийг байгаль орчны менежментийн сайн туршлага нэвтэрч байгаагийн нэг хэлбэр гэж үзэж болох юм. Учир нь олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн байгаль орчны стандарт, туршлагыг мөрддөг компаниудын хувьд эдгээр стандартаар шаардагддаг олон нийтийн оролцоог ханган ажилладаг. Уур уурхайн салбар хэрхэн өсөх нь байгаль орчны менежментэд бага нөлөөлөл үзүүлэх ба харин компаний үйл ажиллагааны талаарх оролцогч талуудын санаа зовоосон асуудал, уурхайн компаниудын байгаль орчны зохицуулалт, стандарт, бодлого журмаас шалтгаалан тэдний байгаль орчны менежмент өөрчлөгдөж болзошгүй юм.

Нөлөөллийн хураангуй

Бага өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Уул уурхайн үйл ажиллагаа бага явагдах тул байгаль орчны ажилтнууд мэргэжлийн мэдлэг, ур чадварын хувьд туршлагажих ба салбар доторх эрэлтээс шалтгаалаад туршлагатай байгаль орчны ажилтнууд үнэд орох боломж харагдаж байна.Уул уурхайн бодлогын улмаас гадны хөрөнгө оруулалт саарч, хумигдсанаар түүнийг дагаж орж ирдэг олон улсын байгаль орчны тэргүүн туршлагын нөлөөлөл буурна. Гэхдээ цөөн тооны уурхай дээр төвлөрч ажиллах нь бас стандартыг сайжруулах боломжийг олгож болох юм.
Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Олон улсын олборлох үйлдвэрлэлийн салбар, Монголд нэвтрүүлсэн байгаль орчны тэргүүлэх туршлагын нөлөө нь байгаль орчны удирдлагын талаарх мэдлэгийг дээшлүүлсэн бөгөөд өндөр өсөлтийн хувилбараар авч үзвэл гадны хөрөнгө оруулалт шаардагдахуйц томоохон уурхайнууд ажиллах магадлалтай тул үүнийг дагаад олон улсын стандарт ч хэрэгжсээр байх болно.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Уул уурхайн салбарын байгаль орчны удирдлагын шаардлагыг хангалттай түвшинд биелүүлэх мэргэжлийн боловсон хүчин болоод байгууллагын түвшний хөтөлбөр бэлтгэхэд хөрөнгө оруулалт хийхэд 5-10 жил шаардагдана.Олон улсын олборлох үйлдвэрлэлийн салбар, Монголд нэвтрүүлсэн байгаль орчны тэргүүлэх туршлагын нөлөө нь байгаль орчны удирдлагын талаарх мэдлэгийг дээшлүүлсэн бөгөөд өндөр өсөлтийн хувилбараар авч үзвэл гадны хөрөнгө оруулалт шаардагдахуйц томоохон уурхайнууд ажиллах магадлалтай тул үүнийг дагаад олон улсын стандарт ч хэрэгжсээр байх болно.

4.2.4.3 Байгаль орчны менежмент: Арга хэмжээний зөвлөмжүүд

Уул уурхайн компаниудын байгаль орчны менежментийг сайжруулахад хөшүүрэг болох арга хэмжээнүүдийг дараах байдлаар ангилж болно. Үүнд, хуулийн хэрэгжилтийг хангах, стандартыг хэрэгжүүлж, сайжруулахад салбарын хамтын ажиллагааг дэмжих, уул уурхайн компаниудын байгаль орчны менежментийн хариуцлага, ил тод байдлыг дээшлүүлэх, уурхайн байгаль орчны менежментийн ур чадварыг хөгжүүлэн дэмжих арга хэмжээнүүд байна.

Сум, аймаг, улсын түвшинд байгаль орчны засаглал болон зохицуулалт сайжирснаар компаниудаас уул уурхайн байгаль орчны менежментэнд зарцуулах хөрөнгө нэмэгдэх нөлөө үзүүлнэ. Байгаль орчны шилдэг менежментийн арга туршлагаас суралцах бололцоо сумын болон аймгийн байгаль орчны байцаагчид, холбогдох төрийн байгууллагуудын ажилтнуудад бага байдаг нь тэдний чадвар, чадавхийг хязгаарладаг. Байгаль орчны менежментийн



шаардлагууд өнөөгийн хууль журамд тусгагдсан байдаг ч хуулийн хэрэгжилтийг хяналт шалгалт, аудитын арга хэрэгслээр үр дүнтэй хэрэгжүүлэх чадавхи бололцоо дутуу байдаг нь орон нутгийн, ялангуяа уул уурхай шинээр байгуулагдаж буй газруудын байгаль орчны байцаагч нарын уул уурхайн үйл ажиллагааны талаарх ойлголт, туршлага сул байдагтай нэг талаар холбоотой. 4.4.3 буюу Хөдөлмөр эрхлэлт ба үр чадвар хэсгийг үзнэ үү. Уул уурхайн компаниудын байгаль орчны менежментийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд үзүүлэх олон нийт, бусад холбогдогч талуудын нөлөөлөл нь ерөнхийдөө ил тод байдлын санаачилгаар дамжин хэрэгждэг. Эдгээр санаачилга нь байгаль орчны хууль журмын хэрэгжилт болон үйл ажиллагааны үзүүлэлтийг ил тод болгож, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг олон нийтэд танилцуулж, шалгуулдаг сум, аймгийн түвшинд хамгийн их үр дүнтэй байдаг. 4.3.3 буюу Хүний эрх ба олон нийтийн оролцоо хэсгийг үзнэ үү.

Хүснэгт 4.10 Байгаль орчны менежмент: Арга хэмжээний зөвлөмжүүд

Арга хэмжээний зөвлөмж	
	<ul style="list-style-type: none">• Чадавхийг бэхжүүлэх• Орон нутгийн олон нийттэй хамтын ажиллагааг бэхжүүлэх
Сум	<ul style="list-style-type: none">• Багийн хурлаар уул уурхайн компаниудын татвар төлөлт, орон нутгийг хөгжүүлэх чиглэлээр хийж буй ажил, санаачлагын талаар мэдээлэх замаар орон нутгийн удирдлагын зүгээс уул уурхайн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах.• Нутгийн засаг захиргаатайгаа хамтран ажилласанаар нутгийн иргэд уул уурхайн компаниудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад оролцохыг дэмжих.• Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөг батлуулахын өмнө олон нийт, нутгийн иргэдээр хэлэлцүүлэхээр нээлттэй мэдээлэх.• Уурхайн байгаль орчны менежменттэй холбоотой одоогийн мөрдөгдөж буй байгаль орчны бодлогууд, хууль, журмуудын биелэлтийг талуудыг чадавхижуулах арга хэмжээ, санаачилгаар дамжуулан улам бүр хангах• Уурхайн хаалтын бэлтгэлийг эртнээс тасралтгүй явуулах болон нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд урамшуулал хөшүүргийг бий болгох.• Нутгийн иргэдийг газрын нөхөн сэргээлт хийхэд татан оролцуулах хөшүүргийг уул уурхайн компаниудад бий болгох.• Уурхайн хаалт, газрын нөхөн сэргээлтийн хяналт шинжилгээг сайжруулах.• Уул уурхайн компаниуд нутгийн иргэдийг биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах хөшүүргийг бий болгох
Аймаг	<ul style="list-style-type: none">• Орон нутгийн захиргаанаас хяналт шинжилгээг илүү ойр хийдэг байх, үр дүнг олон нийтэд мэдээлэх.• Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөг батлуулахын өмнө олон нийт, нутгийн иргэдээр хэлэлцүүлэхээр нээлттэй мэдээлэх.• Уурхайн байгаль орчны менежменттэй холбоотой одоогийн мөрдөгдөж буй байгаль орчны бодлогууд, хууль, журмуудын биелэлтийг талуудыг чадавхижуулах арга хэмжээ, санаачилгаар дамжуулан улам бүр хангах• Дүйцүүлэн хамгаалах бодлогыг бэхжүүлэх.• Уурхайн хаалт, газрын нөхөн сэргээлтийн хяналт шинжилгээг сайжруулах.
Улс	<ul style="list-style-type: none">• Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөг батлуулахын өмнө олон нийт, нутгийн иргэдээр хэлэлцүүлэхээр нээлттэй мэдээлэх.• Уурхайн байгаль орчны менежменттэй холбоотой одоогийн мөрдөгдөж буй байгаль орчны бодлогууд, хууль, журмуудын биелэлтийг талуудыг чадавхижуулах арга хэмжээ, санаачилгаар дамжуулан улам бүр хангах• Дүйцүүлэн хамгаалах бодлогыг бэхжүүлэх.• Аюултай хог хаягдлыг зайлуулах байгууламж байгуулах, уурхайн талбай дахь аюултай хаягдлыг зайлуулах асуудалд тавих хяналтыг сайжруулах.



4.3 НИЙГМИЙН ЭН ТЭРГҮҮНИЙ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД БОЛОН ШИЙДВЭРЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖҮҮД

4.3.1 Хувиараа болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа

4.3.1.1 Нөлөөлөл ба хувилбаруудын танилцуулга

Бичил уурхайн салбарыг Монголд үл ойшоон дорд үзэх нь хэвшмэл зүйл бөгөөд энэ тухай ярихаас төвөгшөөн буруу ойлголттой байх нь түгээмэл. Уг үл ойшоон, дорд үздэг байдал нь БОНСҮ-ий хүрээнд хийгдсэн уулзалтуудын үеэр бас харагдаж байсан ба оролцогч талууд хувиараа ашигт малтмал олборлох асуудлыг эн тэргүүнд авч үзэх ёстой асуудлуудад багтаахгүй, уул уурхайн хууль бус үйл ажиллагаа хэмээн үзэж байв.

Гол талуудтай хийх ярилцлагын хүрээнд Тогтвортой бичил уурхай төслийн²⁸ ажилтнуудтай хийсэн ярилцлага болон бичил уурхайн талаар БОНСҮ-ий багийн хийсэн үнэлгээ, мөн энэ салбар нь уул уурхайн салбарын нийгмийн шударга ёс болон байгаль орчны тогтвортой хөгжилд чухал ач холбогдолтой гэсэн БОНСҮ-ий багийн ойлголтод үндэслэж, бичил уурхайн салбарыг БОНСҮ-д эн тэргүүний ач холбогдолтой асуудал хэмээн багтаан авч үзлээ.

Бичил уурхайн салбарын талаар холбогдох талуудын БОНСҮ-ий хэлэлцүүлгийн үеэр илэрхийлсэн ойлголтууд нь бичил уурхайн салбарын хөтлөгч хүчин зүйл болон нөлөөллийг хэрхэн бууруулж болох талаар сайн ойлголтгүй байгааг харуулж байв. Доорх хүснэгтэнд бичил уурхайн салбарын талаар холбогдогч талуудын илэрхийлсэн санал бодол, ойлголтыг хураангуйлан оруулав.

²⁸ Тогтвортой бичил уурхайн төслийг Швейцарын хөгжлийн агентлаг хэрэгжүүлж байгаа бөгөөд Монгол улсад хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах, гар аргаар ашигт малтмал олборлогч эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх, хөдөө орон нутгийн хөгжил, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилготой болно.



Хүснэгт 4.11 Оролцогч талуудын тодорхойлсон бичил уурхайн холбогдолтой эн тэргүүний асуудлууд

Түвшин	Бага өсөлттэй хөгжлийн хувилбар	Дундаж өсөлттэй хөгжлийн хувилбар	Өндөр өсөлттэй хөгжлийн хувилбар
Эн тэргүүний асуудлууд:			
<ul style="list-style-type: none"> • Хувиараа ашигт малтмал олборлох, бичил уурхайн салбарыг үл тоомсорлох • Бичил уурхайн салбартай холбоотой эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны асуудлууд • Бичил уурхайн салбарын эдийн засгийн нөлөө 			
Сум	<ul style="list-style-type: none"> • Өмнө нь уурхайд ажиллаж байсан уурхайчид БУ-н салбарт ирж ажиллах болсноор БУ өргөжинө. • Уул уурхайн хангамж үйлчилгээний салбарт (хоол хүнсний хангамж, хүнс үйлдвэрлэл, зочид буудал г. м.) ажиллах боломж хомс тул эдгээр хүмүүсийн ихэнх нь орлогын эх үүсвэр болгож хувиараа болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлоход хүрнэ. • Бичил уурхайн салбарт илүү олон туршлагагүй хүмүүс орсноор эрүүл ахуй, аюулгүй ажиллаганы асуудлууд ихсэх болно. • Засгийн газрын нөхөн сэргээлт явуулах санхүүжилт буурснаар байгаль орчны доройтол нэмэгдэнэ. 	<ul style="list-style-type: none"> • Бичил уурхайн салбар нь анхаарлаас гадуур хаягдах, гадуурхагдах явдал үргэлжилнэ. Тус салбар нь хууль эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн боловч, бодит байдал дээр төр засгийн бүх түвшинд анхаарлаас орхигдсон хэвээр байна. • Уул уурхайн салбар нь бичил уурхайн салбарыг орхигдуулж, тоохгүй хэвээр байх бөгөөд ихэнх уул уурхайн компаниуд бичил уурхайн салбарыг дайсагнан үзэх бөгөөд гэрээ байгуулах (орон нутгийн удирдлага, бичил уурхайн салбар, хувийн хэвшил хооронд) боломж хязгаарлагдмал байна. • Бичил уурхайчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны менежментийн чиглэлээр сайжрал гарах боловч эдгээр нь харилцан адилгүй байна. 	<ul style="list-style-type: none"> • Уул уурхайн үйлдвэрлэл хөгжсөнөөр хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа алга болох буюу цаашид асуудал гэж тооцогдохоо болих хүртэл хэмжээнд хүрч буурна. • Улмаар энэ нь уул уурхайн салбарын өсөлт өндөр байсны дүнд уул уурхайгаас орох орлого нэмэгдэн бичил уурхайг зохицуулах төрийн бүх шатны байгууллагуудын санхүүгийн нөөц хангамж сайжирч хувиараа болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох салбараас үүсч буй эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа ба байгаль орчны асуудлууд огцом буурна гэсэн үг юм.
Аймаг	• Дээрхтэй адилхан.	• Дээрхтэй адилхан	• Дээрхтэй адилхан.
Улс	• Дээрхтэй адилхан.	• Дээрхтэй адилхан	• Дээрхтэй адилхан.



4.3.1.2 Сум, аймаг, улсын түвшинд үзүүлэх нөлөөллийн эрчим

Бичил уурхайн салбарыг нийгэмд хүлээн зөвшөөрөх нь

Бодлого боловсруулагчид болон олон нийт Монгол улсад хувиараа ашигт малтмал олборлох талаар энэ нь зогсоох ёстой тээртэй үйл ажиллагаа гэсэн нийтлэг ойлголттой байна. Дээрх ойлголтоор бол хувиараа ашигт малтмал олборлох нь 100 (хөдөө орон нутгийн ажиллах хүчний 20%) мянга гаруй монголчуудыг ядуурлаас гаргаж, хөдөө орон нутагт аж төрөх боломжийг олгож буй байнгын хөдөлмөр эрхлэлт гэхээсээ илүүтэйгээр түр зуурын үзэгдэл гэж үзэж байгаа юм. Доор жагсаасан хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааны хөтлөгч хүчин зүйл нь тус салбар одооны хэлбэрээрээ бүх хөгжлийн хувилбарууд буюу өндөр, дундаж, бага өсөлттийн хувилбаруудад байсаар байх бөгөөд нийгэм, байгалийн адилхан нөлөөллийг үзүүлсээр байна (SAMP KII, 2014). Мөн хөтлөгч хүчин зүйл нь янз бүр байгааг харж болно. Хэдийгээр ядуурал нь хувиараа ашигт малтмал олборлох явдлын үндсэн хөтлөгч хүчин зүйл боловч, энэ нь Монгол улсын хүн амын томоохон хувь нь яагаад хувиараа ашигт малтмал олборлож байгаа талаарх олон тайлбарын нэг л юм.

Хүснэгт 4.12 Уул уурхайн өндөр болон бага өсөлттэй хувилбарын үеийн хувиараа ашигт малтмал олборлох хөтлөгч хүчин зүйл болон нөлөөлөл

<p>Бага</p> <ul style="list-style-type: none"> • Ашигт малтмалын үнэ өндөр (өөр бусад ажил төрөлтэй харьцуулахад, жишээ нь мал маллах) • Албан ёсны мэргэжлийн ур чадвар байхгүй, тиймээс өөр бусад салбарт ажиллах боломж муутай • Хувиараа ашигт малтмал олборлох боломж болон мэдэгдэж буй газруудад ажиллах чадавхи албан ёсны уул уурхайн компаниуд бага байдаг • Ядуурал • Өөр бусад ажил хөдөлмөр эрхлэхээс илүү их орлого олох боломж (хувиараа ашигт малтмал олборлогчид нь сард дунджаар 176 ам.доллар олдог нь Монгол улсын хөдөлмөрийн хөлсний хамгийн доод үнэлгээнээс 57% илүү байна) • Орлогод нэмэр болдог /улирлын чанартай хөдөлмөр эрхлэлт • Газрын гадаргад ойр байдаг баялаг ордыг ашигладаг • Хувиараа ашигт малтмал олборлосноороо гэр бүлээ дэмжих боломж илүү олддог/ хүүхдүүдээ сургуульд оруулах г.м. 	<p>Сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> • Мөнгөн усыг нууцаар ашиглах • Мөнгөн усанд хордох (хүн/мал) • Хөрс, ус мөнгөн усаар бохирдох • Цианидын бохирдол • Нөхөн сэргээлт муу хийдгээс бэлчээр доройтож муудах (санхүүжилт болон техникийн ноу-хау технологи муутай) • Цөлжилт • Тусгай хамгаалалттай газар нутаг доройтох • Нийгмээс тусгаарлагдах болон нийгмийн үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал • Хөдөө орон нутгийн дотоодын шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, нийгмийн тогтвортой, нэгдмэл чанарыг алдагдуулах • Сургалтанд хамрагдсан байдал дутмаг, ЭМАА-ны стандартуудыг муу мөрддөг зэргээс шалтгаалсан ЭМАА-тай холбоотой осол ихсэх • Хүүхдүүд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд оролцох (Хүний эрхийн талаар 4.3.3-р хэсгээс харна уу) • Архидан согтууралт, гэр бүлийн хүчирхийлэл зэргээр илрэх ядуурлын нөлөөлөл • Зохион байгуулалттай гэмт хэрэг <p>Эерэг нөлөөлөл</p> <ul style="list-style-type: none"> • Хувиараа ашигт малтмал олборлосноороо гэр бүлээ дэмжих
---	--



	<p>боломж илүү олддог/ хүүхдүүдээ сургуульд оруулах г.м.</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөө орон нутагт бодитой эдийн засгийн хувь нэмэр оруулдаг • Хөдөөгөөс хот руу шилжин нүүх явдлыг бууруулдаг
<p>Өндөр</p> <ul style="list-style-type: none"> • Ашигт малтмалын үнэ өндөр байдгаас энэ салбар өсөж байна • Албан ёсны мэргэжил байхгүйгээс албан ёсны уул уурхайн салбарт ажиллах боломж муутай (эрэлт хэрэгцээ байгаа хэдий ч) • Албан ёсны уурхайн хөрш зэргэлдээ, хажуугийн нүх/хаягдмал хад чулуулаг дээрээс хувиараа ашигт малтмал олборлох боломжтой • Ядуурал • Өөр бусад ажил хөдөлмөр эрхлэхээс илүү их орлого олох боломж • Орлогод нэмэр болдог /улирлын чанартай хөдөлмөр эрхлэлт • Газрын гадаргад ойр байдаг баялаг ордыг ашигладаг • Хувиараа ашигт малтмал олборлосноороо гэр бүлээ дэмжих боломж илүү олддог/ хүүхдүүдээ сургуульд оруулах г.м. 	<p>→</p> <ul style="list-style-type: none"> • Дээрхтэй адилхан, мөн <u>Сөрөг нөлөөлөл</u> • Албан ёсны уул уурхайн компаниудтай ашигт малтмалын ашиглалтын талаар улам бүр зөрчилдөх


Ямар ч хувилбар байсан, хувиараа ашигт малтмал олборлох нь Монголын хүн амын тодорхой хувьд амжиргаагаа залгуулах чухал ажил хэвээр байна. Хувиараа ашигт малтмал олборлох салбарын үр дүнтэй засаглал нь улс төрийн хүсэл эрмэлзэл болон өнөөдрийг хүртэл хамгийн том саад бэрхшээл болж байсан, цаашид хувиараа ашигт малтмал олборлох салбарын чиглэлийг тодорхойлох, нийгэм хүлээн авах эсэхээс ихээхэн шалтгаална.

Хуулийн дагуу олгогдсон эрх

Дээрх саналтай холбоотой өөр нэг зүйл бол тус салбарыг хуульчилснаар илүү амархан болох ёстой байсан бичил уурхайн зориулалтаар ашиглах газрын асуудал ба газрыг хууль ёсоор ашиглахад хувиараа ашигт малтмал олборлогчдод одоогоор тодорхой саад бэрхшээл тулгараад байна. Доорх зураг дээр тус улсын газар нутгийн ихэнх нь геологийн судалгаа, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн газар нутаг, мөн тусгай хамгаалалтай газар нутаг болон цаашид тусгай хамгаалалтанд хамруулахаар санал болгосон газар нутаг байдлаар бүрхэгдсэн байгааг харж болно. Энэ нь одоо гардаг, цаашид гарах газар ашиглалтын талаарх гол зөрчил юм. Тус салбарыг зохицуулахаар бий болгосон журмын дагуу хувиараа ашигт малтмал олборлогчид нь бичил уурхайн олборлолт явуулах талбайдаа хүсэлт гарган зөвшөөрөл авах ёстой боловч, тухайн газрыг хувиараа ашигт малтмал олборлохоос бусад ямар нэгэн тодорхой болон өөр бусад үйл ажиллагаанд зориулсан байдгаас зөвшөөрөл авах боломжгүй байдаг.

Хувиараа ашигт малтмал олборлогчид нь тэдний үйл ажиллагааг албан ёсны болгож хуульчлахаар боловсруулсан хууль зохицуулалтын тогтолцооны хүрээнд ажиллах боломжгүй бол улам бүр анхаарлын гадуур үлдэж, орхигдож байгаагаас дээрх асуудал нь ирэх жилүүдэд илүү их дурдагдаж, хөндөгдөх болно.

Цаашилбал, сумын захиргаа, уурхайн үйл ажиллагаа явуулагч компани болон бичил уурхай эрхлэгч нөхөрлөлүүд хуулийн дагуу 3 талт гэрээ байгуулан түншлэн ажиллах боломжтой бөгөөд бичил уурхай эрхлэгчид лицензитэй талбайн харилцан зөвшөөрөлцсөн хэсэгт үйл ажиллагаа явуулах боломжтой юм. Гэвч үүний тулд бүх талуудын хооронд харилцан итгэлцэл үүсэх, зөвшөөрөлтэй талбайд тавигдах хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны асуудлыг ойлгох шаардлагатай ба энэ асуудлаас шалтгаалан дээрх гэрээг байгуулан ажиллах боломж бий болохгүй байна.



Зураг 4.5 Бичил уурхай болон газар олголт, ашиглалт

Дээр нь, тодорхой газар зүйн байршилтай холбоотойгоор хэлэхэд одоогоор хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа ихээр явагдаж байгаа орон нутгууд нь ирээдүйд гурван хувилбарын аль алинд нь хувиараа ашигт малтмал олборлох гол газрууд хэвээр байсаар байна. Үүнд, дараах аймаг, сумд орох бөгөөд гэхдээ хэрвээ шинэ газруудад ашиглаж болох ашигт малтмалын орд нээгдсэн үед тэнд мөн хувиараа ашигт малтмал олборлогчид бий болох болно. Үүнд:

Хүснэгт 4.13 Монгол улсад хувиараа ашигт малтмал олборлож байгаа гол газрууд

Аймаг	Сум
Сэлэнгэ	Заамар
	Баянгол
	Мандал
Дархан-Уул	Шарын гол
Өвөрхангай	Уянга
Баянхонгор	Бөмбөгөр



	Жаргалант
	Баян-Овоо
Говь-Алтай	Чандмань
Увс	Түргэн
Өмнөговь / Дорноговь	Айраг
	Хатанбулаг
	Мандал-Овоо
	Цогт-Овоо
Дундговь	Өлзийт
Хөвсгөл	Ринчинлхүмбэ
Улаанбаатар	Налайх

Өндөр өсөлттэй хувилбар: Өндөр өсөлттэй хувилбарын хувьд барьж байгуулж, ашиглаж байгаа олон тооны уурхай, дэд бүтэц нь хувиараа ашигт малтмал олборлогчдод мөн адилхан боломжийг бий болгох бөгөөд үүнд, ашигт малтмалын эрэлт хэрэгцээ, олон тооны ухсан нүх, хаягдал чулуулаг, эдгээрийг хувиараа ашигт малтмал олборлогчдод ашиглах боломж, дэд бүтэц, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэнээр хувиараа ашигт малтмал олборлогчид үргэлжлүүлэн ашиг олох г.м. орно. Уул уурхайн салбарын өсөлтийн нэг чухал үзүүлэлт гэвэл хувиараа ашигт малтмал олборлогчид болон уул уурхайн компаниуд (дунд, том хэмжээний) хоорондын зөрчил мөргөлдөөн улам бүр нэмэгдэх явдал болно. Уул уурхайн салбар нь хувиараа ашигт малтмал олборлогчдыг ашигт малтмалын орд, байгаль орчныг хариуцлагагүйгээр устгаж, доройтуулж байгаа хүмүүс гэж байнга үзсээр ирсэн. Уул уурхайн компани болон хувиараа ашигт малтмал олборлогчдын хоорондын харилцаа ихэнхдээ түгшүүртэй бөгөөд уурхайн компаний талбайн хамгаалалт, талуудын оролцооноос ихээхэн хамааралтай байдаг. Уул уурхайн тусгай зөвшөөрлийн талбай ихэвчлэн хувийн эсвэл төрийн хамгаалалтанд байдаг бөгөөд шууд сөргөлдөх, заримдаа хүний эрх зөрчигдөх тохиолдол гардаг (Швейцарийн хөгжлийн агентлаг, 2011). Үүний нэг жишээ бол хувиараа ашигт малтмал олборлогч 20 хүн 2010 оны 6-р сард Хятадын уул уурхайн Эжүмэн компани руу дайрсан бөгөөд энэ үеэр хувиараа алт олборлогч нэг хүнийг машинаар дайрч үхэлд хүргэсэн тохиолдол гарсан (IRIM, 2011). Бусад тохиолдлуудад уурхайн компаний хүсэлтээр цагдаагийн байгууллага тэдний талбайгаас хувиараа ашигт малтмал олборлогчдыг хүч хэрэглэхгүй боловч зөвшилцөл хийлгүйгээр зайлуулдаг.

Өндөр өсөлттэй хувилбарын хувьд хувиараа ашигт малтмал олборлогчид нь сум, аймаг, улсын түвшний төрийн байгууллагуудад уул уурхайн салбарыг илүү тогтвортой, үр дүнтэй байдлаар удирдахад хамгийн том саад бэрхшээлийг учруулна. Тус салбарыг үр дүнтэй удирдахад шаардлагатай нөөц боломж нь (өөрөөр хэлбэл, зөвхөн хувиараа ашигт малтмал олборлогчдын үзүүлэх нөлөөллийг бууруулаад зогсохгүй, гол хөтөлөгч хүчин зүйлсийг шийдвэрлэх) орлого хязгаарлагдмал, эсвэл олсон орлогоо өөр бусад эн тэргүүний хэрэгцээтэй чиглэлээр зарцуулах уул уурхайн дундаж болон бага өсөлттэй хувилбаруудтай харьцуулахад уул уурхайн өндөр өсөлттэй хувилбарын үед илүү хүртээмжтэй байна. Гэсэн хэдий ч аль ч хувилбарын хувьд ниймэг өөрчлөгдөхөд тодорхой хугацаа шаардагдана.

Бага өсөлттэй хувилбар: Өөр бусад боломжууд бага болон салбар, ажил мэргэжил сольж өсөж хөгжих чадвар сул зэргээс шалтгаалан хувиараа ашигт малтмал олборлогчид нь Монгол улсад хаа сайгүй байсаар байх төлөвтэй байна. Түүнээс гадна, уул уурхайн компаниудтай



өрсөлдөх явдал байхгүй учраас хувиараа ашигт малтмал олборлох боломжууд нь хамгийн элбэг байдаг.

Уурхайн компаниас хувиараа ашигт малтмал олборлогч болж шилжих магадлал бага байдаг. Бэлтгэгдсэн уурхайн ажилчид ажил эрхлэхийн тулд уурхайн компаниас хувиараа ашигт малтмал олборлох гэж явдаггүй бөгөөд мэргэжлийн ажилчид ажлын аюулгүй орчин, журам, тогтмол цалинтай, бүтэцтэй ажлын орчноор хангагдсан байдаг. Эдгээр хүчин зүйлс бичил уурхайн салбарт дутагдалтай тул олон тооны уурхайн компани үйл ажиллагаа явуулаагүй үед бичил уурхайн салбар луу шилжин ажиллах сонголтыг ажилчид хийхгүй.

Өндөр өсөлтийн хувилбарын нэгэн адил бага өсөлтийн хувилбарын үед хувиараа ашигт малтмал олборлогчид сум, аймаг болон үндэсний түвшний удирдлагуудад хүндрэл учруулсан хэвээр байх болно. Гэхдээ өндөр өсөлтийн хувилбарын үед уг салбарыг үр дүнтэй удирдах нөөц хангалттай байх бол харин бага өсөлтийн үед ийм нөөц бололцоо тийм элбэг байхгүй (уурхайгаас олох орлогын түвшингээс шууд хамааралтай) байна.

Нөлөөллийн хураангуй

Бага өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none"> • БУ газар авах ба нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрөх явц удааширалтай байх магадлалтай. • БУ-тай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд хүрэлцэхүйц нөөц санхүүжилт байхгүй байх ба байгаа орлогыг өөр тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд зарцуулна. • Засгийн газар, уул уурхайн компаниуд болон бичил уурхай эрхлэгчдийн хооронд бичил уурхай эрхлэх талбайн асуудлаар маргаан гарах магадлал өндөр байна.
Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none"> • БУ газар авах ба нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрөх явц удааширалтай байх магадлалтай. • Сэлэнгэ, Дархан-Уул, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Увс, Өмнөговь, Дорноговь, Дундговь, Хөвсгөл аймаг, Улаанбаатарт хот БУ-н нөлөөлөлд илүүтэйгээр өртөнө. • Засгийн газар, уул уурхайн компаниуд болон бичил уурхай эрхлэгчдийн хооронд бичил уурхай эрхлэх талбайн асуудлаар маргаан гарах магадлал өндөр байна.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none"> • БУ газар авах ба нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрөх явц удааширалтай байх магадлалтай. • Засгийн газар, уул уурхайн компаниуд болон бичил уурхай эрхлэгчдийн хооронд бичил уурхай эрхлэх талбайн асуудлаар маргаан гарах магадлал өндөр байна. • Тус салбарыг үр дүнтэй удирдах, БУ-г хөтөлгч хүчин зүйлс, асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр илүү хүртээмжтэй байна.

4.3.1.3 [Бичил уурхай: Арга хэмжээний зөвлөмжүүд](#)

Хүснэгт 4.14 Бичил уурхай: Арга хэмжээний зөвлөмжүүд

Арга хэмжээний зөвлөмж	<ul style="list-style-type: none"> • Одоогийн хууль эрх зүйн зохицуулалтыг мөрдүүлэх замаар бичил уурхайн салбарыг улам бүр албажуулах • Төрийн албаны ажилтнуудын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх сургалтыг явуулах • Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн чадавхи, хариуцлагыг сайжруулах
Сум	<ul style="list-style-type: none"> • Чадавхижуулах, туршлага солилцох, бичил уурхайн салбарын удирдлага, зохицуулалтыг хариуцсан төрийн албаны ажилтнуудын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх сургалтыг явуулах. • Хувиараа ашигт малтмал олборлох салбарын тогтвортой хөгжлийг дэмжих үүднээс уурхайн ажлын үр чадвар, мөнгөн ус хэрэглэхгүй байх зорилтот хөтөлбөрийг



Арга хэмжээний зөвлөмж	<p>санхүүжүүлэх, нөхөрлөлийг албан ёсоор байгуулах.</p> <ul style="list-style-type: none">• Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдэд бүтээгдэхүүний чанараа сайжруулах, өртөг нэмэх (үнэт эдлэл) талаар сургалт хийх.• Хувиараа ашигт малтмал олборлогч иргэд бусад салбарт хөдөлмөр эрхлэх чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах.• Сургалт, дагалдуулан сургах замаар хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн байгаль орчны менежмент, нөхөн сэргээлт, аюултай бодис ашиглах чиглэлээр чадавхи, хариуцлагыг сайжруулах.• Уул уурхайн компаниуд, сумын захиргаа, бичил уурхайчдын хооронд туршлага солилцох замаар хамтран ажилллах.
Аймаг	<p>Дээр дурдсанаас гадна:</p> <ul style="list-style-type: none">• Хувиараа ашигт малтмал олборлогчид нөхөн сэргээлтийг амжилттай хийсэн талаар болон тэдний орон нутгийн эдийн засагт оруулж буй хувь нэмрийн талаар мэдээлэх замаар бичил уурхайн тухай олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх.
Улс	<p>Дээр дурдсанаас гадна:</p> <ul style="list-style-type: none">• Одоогийн хууль эрх зүйн зохицуулалтыг мөрдүүлэх замаар бичил уурхайн салбарыг улам бүр албажуулах• Шударга худалдаа, шударга уурхай санаачилга зэрэг санаачлагын хэрэгжилтийг дэмжих.• Бичил уурхайн үйл ажиллагаанд зориулан газар хуваарилах тухай одоогийн мөрдөгдөж буй журмыг сайжруулах.• Хувиараа ашигт малтмал олборлогчдын эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах.• Хувиараа ашигт малтмал олборлогч хүмүүсийн эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийн судалгааг явуулах, бичил уурхайтай холбоотой өвчлөлөөс хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг урьдчилан сэргийлэх.• Бичил уурхайд мөнгөн усны хэрэглээний өнөөгийн байдал түүний дотор нийлүүлэлт, гарал үүслийн судалгааг цаашид дэмжих мэргэжлийн туслалцаа, сургалт, түүнчлэн мөнгөн ус ашиглахгүйгээр боловсруулах үйлдвэр байгуулах жижиг зээл олгох зэрэг нь төрийн бүх түвшний байгууллагууд судалж үзүүштэй стратеги юм.

4.3.2 Соёлын өв

4.3.2.1 [Нөлөөлөл ба хувилбаруудын танилцуулга](#)

Монгол улс нь баялаг түүхтэй бөгөөд энэ нь тус улсын биет болон биет бус соёлын өв уламжлалд хадгалагдан үлдсэн байдаг. 2010 онд Оюу Толгой урт хугацааны Соёлын өвийн хөтөлбөр²⁹-ийг Монгол улсад анх удаа боловсруулж эхэлсэн бөгөөд тус хөтөлбөрийн зорилго нь “Оюу Толгой төслийн улмаас соёлын өвд учирч буй аюул заналыг багасгах, соёл заншилд гарч болзошгүй өөрчлөлтөд мониторинг хийх, ойлгох; соёлын өвийг хадгалж хамгаалах боломжийг эрэлхийлэхэд энэ чиглэлээр ажилладаг ашгийн болон ашгийн бус, түүнчлэн төрийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэхэд оршиж” байна (Гүнчинсүрэн, Алчул, Олсен, 2011).

Археологийн олдвор бүхий газрууд: Соёлын өвийн хөтөлбөрийн судалгааны хүрээнд олон улсын болон дотоодын эрдэмтэн судлаачдаас бүрдсэн Монголын олон улсын өвийн баг Монгол

²⁹ Оюу Толгой компаний Соёлын өвийн хөтөлбөрийг боловсруулахад Састэйнабилити Ийст Эйжия ХХК хамтран ажилласан юм.



улсад мэдэгдэж байгаа археологийн олдвор бүхий газруудад нарийвчилсан судалгаа хийсэн байдаг (Гүнчинсүрэн, Алчул, Олсен, 2011). Хүснэгт 4.4.5-д эдгээр олдвор бүхий газрууд болон тэдгээрийн он цагийн хэлхээсийн хураангуйг харуулав. Хэдийгээр уул уурхайн компаниудыг соёлын өвд үзүүлж буй нөлөөллөө үйл ажиллагаандаа тооцон үзэх талаар заасан хууль журам Монгол улсад байдаг ч дээрх Соёлын өвийн хөтөлбөрийг эцэслэх үеийн байдлаар Монголд байгаа уул уурхайн компаниудын 3.7% нь л энэ заалтыг биелүүлсэн байв (Гүнчинсүрэн, Алчул, Олсен, 2011). Монгол улсын баялаг түүх зөвхөн Оюу Толгой төслийн археологийн судалгаагаар олдсон өв газруудын тоо (2001-2008 оны хооронд нийтдээ 149) зэргээс харахад Монгол улсын түүхийг судлах, бүтээхэд хувь нэмрээ оруулах зуу зуун мянган олдворууд улсын хэмжээнд байгаа гэдэг нь илэрхий билээ.

Хүснэгт 4.15 Археологийн олдворын хураангуй

Соёлын үечлэл	Цаг хугацаа	Олдворын төрөл	Газарзүйн хамрах хүрээ (мэдэгдэж буй талбай)
Хуучин Чулуун зэвсгийн доод үе	800,000 to 100,000 жилийн өмнө	Чулуун зэвсэг хэрэгсэл	Баянхонгор, Өмнөговь, Баян-Өлгий аймгууд
Хуучин Чулуун зэвсгийн дунд үе	100,000–40,000 жилийн өмнө	Хэд хэдэн жижиг суурин газрууд	Баянхонгор, Өмнөговь, Өвөрхангай аймгууд
Хуучин чулуун зэвсгийн дээд үе	40–12,000 жилийн өмнө	Голдуу чулуун зэвсэг зэрэг хийж байсан олдвор, ул мөр бүхий газрууд	Булган, Хэнтий, Өвөрхангай аймгууд
Дундад чулуун зэвсгийн үе	12,000–8,000 жилийн өмнө	Дундад чулуун зэвсгийн үеийн янз бүрийн чулуун зэвсгүүд	Монгол улсын ихэнх аймгууд
Шинэ чулуун зэвсгийн үе	НТӨ 8,000-3,000 жил*	Неолитийн үеийн янз бүрийн чулуун зэвсгүүд болон сав суулга	Монгол улсын ихэнх аймгууд
Хүрэл зэвсгийн үе	НТӨ 2000 оны үед эхэлсэн	Хүрэл хайлуур, дөрвөлжин булш, хиригсүүр, буган хөшөө, хадны зосон зураг, хадны сийлмэл зураг г.м. дурсгалууд	Монгол улсын хэмжээнд
Чандманий соёл	Төмөр зэвсгийн эхэн үе	Тодорхой нэг овог аймгийн дурсгал бүхий өвөрмөц хэлбэрийн булшууд	Увс аймгийн Улаангом сумын Чандмань уул
Пазырыкын соёл	НТӨ 6-2-р зуун	Өндөр хөгжсөн гар урлалын эд өлгийн зүйлс бүхий булш	Монгол улсын Алтайн өндөр уулын бүс
Хүннү гүрний үе	НТӨ 3-р зуун	Булш бунхан (язгууртны болон жирийн иргэдийн), томоохон хот суурин газрууд болон хадны зураг.	Монгол улсын хэмжээнд
Түрэгийн үе	НТ 6-10-р зуун*	Хаад ноёд, жирийн иргэдэд зориулсан тахил тайлгын онгон, тэдгээрийн бүрэлдэхүүнд багтах хүн чулуу, адгуус амьтны дүрс, руни бичээст пайлууур хөшөө, уран барилгын холбогдолт дурсгал, хад чулуу, бусад эд зүйлд сийлбэрлэн гаргасан элдэв зураг, их	Хэнтийн уулсаас Алтайн их уулсыг хүртлэх нутагт элбэг тохиолддог



		бага бичээсийн зүйл, нас барагсдыг оршуулсан булш хиргисүүр	
--	--	---	--

Тэмдэглэл: НТӨ – Нийтийн тооллын өмнөх, НТ – Нийтийн тоолол

Биет бус өв: Археологийн арвин баялаг өвөөс гадна, монголчууд нь уламжлалт дуу хөгжим, гар урлал, хэл, шашны зан үйл, нүүдлийн мал аж ахуй, адууг өөрийн соёлын нэгэн хэсэг болгосон чадвар, мөн бусад уралдаан наадам зэргээс бүрдсэн биет бус арвин баялаг өвтэй билээ. Соёлын өвийн хөтөлбөр (Гүнчинсүрэн, Алчул, Олсен, 2011)-т монголчууд энэ уламжлалаа хадгалан хамгаалах, орчин үеийн хөгжилтэй холбоотой нөлөөллөөс эдгээр биет бус өвөө хадгалан авч үлдэх арга замыг тодруулахаар найдаж байгааг дурдсан байна.

Палеонтологийн дурсгалууд: Монгол улс нь археологи, биет бус өвийн арвин баялаг өв уламжлалтайн адилаар, мөн палеонтологийн арвин баялаг дурсгалтай орон юм. Дэлхийд алдартай олон палеонтологийн дурсгалууд Монгол улсад байдаг бөгөөд Соёлын өвийн хөтөлбөр нь Оюу Толгойн шууд нөлөөллийн бүс болох Ханбогд сум, мөн Оюу Толгойн шууд бус нөлөөллийн бүс болох Манлай, Баян-Овоо сумдуудад байх эдгээр палеонтологийн дурсгалуудын талаар судлан авч үзсэн (Гүнчинсүрэн, Алчул, Олсен, 2011). Эдгээр сумдын нутагт байдаг Байшин цав, Хуурай цав, Амтгай, Үрэлбэ худаг, Шар цав хэмээх олдворт газрууд Монгол орны Мезозойн эриний Хожуу цэрдийн галавын эхэн үеийн (145 сая жилийн өмнөх) амьтан ургамлын хувьсал, хөгжлийн үндсэн баталгаа болдог үлэг гүрвэлийн зарим бүлгийн эх нутаг болох нь тогтоогдсон байна. Энэ бүс нутгаас олдож байгаа үлэг гүрвэлийн олдворууд нь Хойд Америкт хамгийн өргөн дэлгэр тархан хөгжиж байсан гадрозавридын овгийн амьтдын үүслийн төв хөгжлийн голомт нь Төв Ази байсан гэдгийг баталж байдаг.

Тус бүс нутагт чулуужсан амьтдын яс үлдэгдлээс гадна, үлэг гүрвэлийн мөр бүхий олдвор газрыг нээн илрүүлсэн байдаг. Шар цавын үлэг гүрвэлийн мөр, зам, хөлийн дардас нь байгальд бүтээгдсэн хэв маягаараа хатуу элсжингийн үе давхаргадас дээр хадгалагдсан бөгөөд уг элсжингийн үе нь том ширхэгтэй элсэн чулуунаас бүрдсэн байдаг. Үлэг гүрвэлийн мөр, жим нь хэлбэр хэмжээний хувьд олон янз болох нь тогтоогдсон ба багаар тооцоход 4-5 өөр төрлийн үлэг гүрвэлийнх гэдэг нь батлагдсан билээ. Үлэг гүрвэлийн сайн хадгалагдсан зам, мөр, жим нь эрт галавын амьтны аймгийн экологи (тухайн амьтдын сүргийн бүтэц, тоо хэмжээ), зан араншин, хөдөлгөөн зэргийг тогтооход маш чухал мэдээ баримт болдог.

Говь цөлд байгаа үлэг гүрвэлийн чулуужсан яс, үлдэгдэл бүхий эдгээр газруудад эволюци хувьслын талаар нэмэлт мэдээлэл өгдөг эртний сүүн тэжээлт амьтдын үлдэгдэл, олдоц мөн олддог. Түүнчлэн, Монгол улсад одоо байгаа геологийн сүүлийн үеийн олдворуудад амьтдын чулуужсан яс, үлдэгдэл байх магадлал өндөр байгаа бөгөөд (жишээ нь 2.4 сая жилийн өмнөх 4 дэх галавын үеийн цаг хугацааны) энэ нь тухайн үед амьдарч байсан амьтдын эволюци, дасан өөрчлөгдөж байсан талаар олж мэдэх боломжийг олгох юм.

БОНСУ-ий хэлэлцүүлэг уулзалт болон хийсэн ярилцлагууд дээр үндэслэн дүгнэхэд соёлын өв нь оролцогчдын хувьд эн тэргүүний ач холбогдолтой асуудал байсан бөгөөд үүнийг соёлын өвд уул уурхайн үзүүлэх нөлөөллийн талаар оролцогчдын бодлыг хураангуйлан тусгасан доорх хүснэгтээс харж болно.




Хүснэгт 4.16 Оролцогч талуудын тодорхойлсон соёлын өвийн эн тэргүүний асуудлууд

Түвшин	Бага өсөлттэй хөгжлийн хувилбар	Дундаж өсөлттэй хөгжлийн хувилбар	Өндөр өсөлттэй хөгжлийн хувилбар
Эн тэргүүний асуудлууд:			
• Биет болон биет бус соёлын өвийг хадгалах асуудлууд			
Сум	<ul style="list-style-type: none">Монголын уламжлалт соёл, амьдралын хэв маяг хадгалагдаж, бүр цэцэглэн хөгжинө гэж үзэж байна.	<ul style="list-style-type: none">Дундаж өсөлттэй хувилбарын хувьд уул уурхайн өсөлтийн түвшин харьцангуй өндөр байж, олон уурхай, холбогдох дэд бүтэц болон үйлчилгээ бий болсон байна. Энэ нь дундаж өсөлттэй хувилбарын үед соёлын өв устах явдал үргэлжилж нилээн эрсдэл, аюулд учирсан байна гэсэн үг юм.	<ul style="list-style-type: none">Уул уурхайн салбар хөгжсөнөөр Монголын уламжлалт амьдралын хэв маяг, нүүдлийн соёл (биет бус өв) алдагдана. Барууны соёл давамгайлахын хэрээр Монголын соёл суларч, доройтно. Газар нутгийн нэр ус солигдох, гадаад үг хэллэг ярианы хэлэнд нэвтрэх зэргээр биет бус өвд харийн хэл нөлөөлөхөөр байна.Энэ алдагдал нь амьжиргааны түвшин, эдийн засгийн боломж сайжрах зэргээр нөхөн төлөгдөнө.Эдийн засгийн (уул уурхайн) хөгжил нь уламжлалт амьдралын хэв маяг, соёл алдагдахад зайлшгүй хүргэнэ.
Аймаг	<ul style="list-style-type: none">Дээрхтэй адилхан.	<ul style="list-style-type: none">Дээрхтэй адилхан.	<ul style="list-style-type: none">Дээрхтэй адилхан. Оролцогчдын хэлснээр: "Нэг бэлчээрээс нөгөө бэлчээр рүү нүүх нь нүүж суух, нүүж ирж буй хүмүүсийг угтан авах, тэмээ, үхэр тэргийг ачаалах г.м. олон соёлын бүрдэл хэсгүүдийг агуулж байдаг. Хотжилт явагдсанаар нүүдэлчин малчид эдгээр уламжлалаа алдаж, залуучууд мал маллахаас зайлсхийж, уул уурхайд ажиллаж, илүү их мөнгө олохыг бодож байна. Уул уурхайгаас олсон мөнгө нь хүмүүсийн зан ааш, хандлагыг өөрчилнө. Малчид морио унахаас илүүтэйгээр мотоцикл унах болоод байна" гэв.Уул уурхайн хөгжил болон Монголын уламжлалт соёл, амьжиргаа нь хоорондоо зохицохгүй. Тиймээс, өндөр өсөлт, уламжлалт соёл зэрэгцэн орших боломжгүй.
Улс	<ul style="list-style-type: none">Дээрхтэй адилхан.	<ul style="list-style-type: none">Дээрхтэй адилхан.	<ul style="list-style-type: none">Дээрхтэй адилхан.

4.3.2.2 Сум, аймаг, улсын түвшинд үзүүлэх нөлөөллийн эрчим

Арвин баялаг нөөцтэй, урт удаан хугацаанд ашиглах уурхайг байгуулахад ихээхэн хэмжээний дэд бүтцийг барьж байгуулах шаардлагатай бөгөөд энэ талаар уул уурхайн хөгжлийн 3 хувилбарыг харуулсан зургаас харж болно (Зураг 3.2, 3.3 болон 3.4-ийг үзнэ үү). Өнөөдрийн байдлаар уул уурхайн хөгжлөөс үүдэн уурхай байгуулагдаж байгаа аймгуудад ажилчид, иргэд шилжин ирэх шалтгаан болж байна. Цаашдын уул уурхайн хөгжилд ч гэсэн энэ хувилбар давтагдах буюу уурхайг барьж байгуулах, ашиглах ажилчид шилжин ирсээр байх төлөвтэй байна. Тухайн ордын нөөц хэр их баялаг вэ гэдэг нь барьж байгуулах уурхайн хэмжээ, уурхайн ашиглалтын хугацаа, уурхайг барьж байгуулах, ашиглахад шаардлагатай ажилчдын тоо, шаардлагатай дэд бүтцийн түвшин зэрэгт шууд хамааралтай байна. Доорх Зураг 4.6-т хувилбар бүрийн хувьд Монгол улсын ашигт малтмалын нөөц, уурхайн тоо ашиглалтыг харуулсан бөгөөд хамгийн баялаг орд газрууд нь дараах аймгуудад байна. Үүнд: Баянхонгор, Дорноговь, Өмнөговь, Төв, Хэнтий, Улаанбаатар, Сэлэнгэ аймгууд багтан орж байна. Тиймээс, бага болон өндөр өсөлттэй аль ч хувилбарын үед соёлын өвд учирч болзошгүй хамгийн их нөлөөлөл эдгээр аймгуудад гарна.



Зураг 4.6 Аймгийн түвшинд уурхайн тоо, хөгжлийн хувилбар тус бүрээр

Түүхийн дурсгалт соёлын өвийн хувьд бага болон өндөр өсөлтийн хувилбаруудын аль алинд үзүүлж болзошгүй нөлөөллийг авч үзвэл:

- Уурхайн шууд нөлөөлөл (археологи, палеонтологийн өв гэмтэх, устаж үгүй болох).
- Барилга байгууламж ба түүний дэд бүтцийг байгуулах явцад археологи, палеонтологийн өв шууд нөлөөллөөр гэмтэх, устаж үгүй болох (жишээ нь: цэвэр бохир усны байгууламж, сургууль, эмнэлэг, жижиглэн худалдаа, шатахуун түгээх станц, зам, төмөр зам).
- Хууль бусаар (археологи ба палеонтологийн) олдвор бүхий талбайд малтлага хийх магадлал өсөх ба олзворуудыг хар зах дээр худалдаалах.



- Археологи ба палеонтологийн талбайг хорлон сүйтгэж бусниулах магадлал өсөх.
- Зохион байгуулалт муутай аялал жуучлалын нөлөөгөөр археологи ба палентологийн талбай элэгдэж хорогдох магадлал өсөх.
- Эдийн засгийн хөгжлийн нөлөөгөөр соёлын уламжлал устаж үгүй болох магадлал өсөх (жишээ нь: нүүдлийн мал аж ахуй).
- Уламжлалт буюу эмчилгээний зориулалтаар ашиглаж ургамал, амьтны аймгийг багасгах, устгах магадлал өсөх.
- Орон нутгийн хэл аялгад нөлөөлөх.
- Орон нутгийн ард иргэдийн шашин шүтлэгт нөлөөлөх.
- Хоол ундны уламжлалд нөлөөлөх.
- Дуу хөгжим, ардын бүжиг, тоглоом наадгай, спортод нөлөөлөх.
- Орон нутгийн уламжлалт үнэ цэнэд нөлөөлөх.

Өсөлтийн аль ч хувилбарын үед соёлын өвийг хамгаалах асуудлаар тулгарах хамгийн гол асуудал нь Монгол улсад мэргэшсэн боловсон хүчин дутагдах явдал юм. Оюу Толгойн Соёлын өвийн хөтөлбөр дуусах үед улсын хэмжээнд 20-хон археологичид байсан бөгөөд түүнээс ч цөөн палеонтологич болон биет бус соёлын өвийн мэргэжилтэн байсан. Соёлын өвийн бэлтгэгдсэн, мэргэшсэн эдгээр цөөн тооны мэргэжилтнүүд заасан хугацаанд маш том хэмжээний газар нутгийг хамарсан археологи, палеонтологийн судалгаа явуулах болон шаардлагатай үед малталт хийх үүргийг шууд гүйцэтгэж байв. Тухайн талбайд уурхайн хайгуул, олборлолт хийх, мөн холбогдох дэд бүтцийг барьж байгуулах боломжтой эсэхийг тодорхойлох судалгаа явуулахад шаардлага хангасан боловсон хүчин бэлэн байх шаардлагатай тул чадавхийг бэхжүүлэх онцгой хэрэгцээ байгаа юм.

Өндөр өсөлтийн хувилбар: Энэхүү хувилбарын хувьд ашигт малтмалын нөөц, нээгдэж болзошгүй уурхайнууд нэг дор их хэмжээгээр нээгдэж ашиглагдах ба үүнтэй холбоотой дэд бүтцийг барьж байгуулах үед соёлын өвд сөргөөр нөлөөлөх магадлал ихээхэн өндөр байна. Соёлын өвийн хуулийг муу дагаж мөрдсөнөөс барилга байгууламж, түүний ашиглалт (уул уурхай болон дэд бүтэц)-ын шууд нөлөөгөөр олон мянган археологийн өв устаж үгүй болох, мөн эвдэрч сүйдэж болох юм. Олон зуун түүхийн үнэт өв ба хөшөө дурсгал барилга байгууламж барих явцад устаж үүрд алга болох ба түүхэн чанараа алдана. Уурхайн ойр орчимд хүн ам нэмэгдсэнээр дагалдан гарч ирэх хоёрдогч хүчин зүйлсийн нөлөөгөөр гидрологи ба усны хагалбарт үзүүлэх нөлөөлөл нь зарим соёлын өвийг элэгдүүлэхийн сацуу агаарын бохирдол нь чулуун хөшөө түүнчлэн барилгыг элэгдүүлэх сөрөг нөлөөтэй (Халлаф, 2011). Уул уурхай хөгжсөн ашигт малтмалын арвин их нөөцтэй аймгуудын уурхай дээр ажилчид, тэдгээрийн гэр бүл олноор суурьснаар хууль бус малтлага хийх, соёлын өвийн газруудыг сүйтгэх, эд өлгийн зүйлс ба булшнаас олдсон араг ясыг хар зах дээр борлуулах гэх мэт үйлдлүүд олширдог. Өндөр өсөлтийн хувилбар нь палеонтологийн өвд адилхан нөлөөлөл авчирна. Одоогийн байдлаар археологийн хамгийн том өв сан нь Өмнөговь болон Баянхонгор аймгуудад олноор байгаа бөгөөд эдгээр аймгууд ашигт малтмалын арвин их нөөцтэй билээ. Тус бүс нутагт суурьших хүн амын тоо нэмэгдсэнээс үүдэн хууль бус малтлага хийх, чулуужсан биетийг хар зах дээр



худалдаалах эрсдэл ихсэх нь Монгол улсын нутаг дэвсгэр дээрх үнэт өв, амьтдын хувьсал ба экологийн өөрчлөлтийг харуулсан дахин давтагдашгүй хосгүй өвийг устгах аюултай билээ. Өндөр өсөлтийн хувилбар нь биет бус өвд сөргөөр нөлөөлдөг. Уул уурхайн хөгжлийг дагаж гадны ажиллах хүчин Монгол руу цагаачлахаас гадна мөн Монгол ажилчид уурхай дээр ажиллах болно. Гадны ажилчид Монголын ёс заншил, хэл, шашин шүтлэг, үндэсний хоол унд, дуу хөгжим, тоглоом наадгай, спорт, боловсролын талаар мэдлэг тааруу байдаг. Гадны ажилчдын тоо нэмэгдэх нь Монголын уламжлал аажмаар алга болох аюулыг дагуулж байдаг. Түүнчлэн, хот суурин газраас хөдөө орон нутаг руу ажиллахаар шилжин очсон Монгол хүмүүс мөн л ижил нутгийн иргэдийн соёл уламжлалд нөлөөлөх эрсдэлтэй байдаг. Цаашилбал, олон нийт монголчуудын уламжлалт зан заншил, хэв маягийг өөрчилж буй гол хүчин зүйл нь уул уурхай гэж үздэг ч уурхайн нөлөөллийг үл харгалзан, уул уурхай нь технологийн өөрчлөлтийг авчрах, монголчуудыг дэлхий нийттэй холбох, өөр соёлын тухай мэдлэг ойлголт өгөх боломжийг мөн бий болгож байна хэмээн үздэг. Уул уурхай бол Монгол орны соёл, зан заншилд нөлөөлж буй олон хүчин зүйлсийн нэг юм.

4.3.3 буюу Хүний эрх ба олон нийтийн оролцоо хэсгийг үзнэ үү.

Бага өсөлтийн хувилбар: Бага өсөлтийн хувилбарын үед соёлын үнэт өвд тохиолдох эрсдэл нь өндөр өсөлтийн хувилбартай харьцуулахад харьцангуй бага байна. Энэ тохиолдолд сүйтгэгдэх талбайн хэмжээ бага байх ба энэ нь цөөн тооны ажилчид уурхай ба түүний дэд бүтэц, туслан гүйцэтгэх ажилд оролцохтой холбоотой. Бага өсөлтийн хувилбарын үед хамгийн их өртөгдөх магадлалтай соёлын өвийг ашигт малтмалын нөөц бүхий эсвэл газрын тосны олдоц бүхий талбай дээр уурхай байгуулах, зам харгуй, төмөр зам тавих төлөвлөгөөнд оруулан устгахаас урьдчилан сэргийлэх боломжтой. Бага өсөлтийн үед биет бус соёлын өвд өөрчлөлт үргэлжлэн гарч өөр соёл, зан заншлын талаар (хотоос хөдөөг чиглэсэн, мөн гадаадын) мэдлэг, мэдээлэл орж ирсээр байх бөгөөд тэдгээр өөрчлөлтүүд нь уурхайн үйл ажиллагаа явагдах сумдын ойр орчимд гарах болно.

Нөлөөллийн хураангуй

Бага өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Цөөн тооны уурхай ажиллаж, газар хөндөлт бага явагдах учраас дундаж болон өндөр өсөлтийн хувилбартай харьцуулахад бага өсөлтийн үед соёлын өвд үзүүлэх нөлөөлөл бага байна. Гэхдээ соёлын өөрчлөлтүүд байсаар л байна.
Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт хэзээд сул байсаар ирсэнээс үзэхэд уурхайн бүтээн байгуулалт, үйл ажиллагааны нөлөөгөөр мянга мянган археологийн өв бүхий газар нутаг устан үгүй болох магадлалтай бөгөөд өөр бусад хэдэн мянган соёл, өлгийн зүйлс гэмтэж, хохирол амсана.Гадны ажилчид олноор орж ирэн өөр өөр соёл, заншлыг нэвтрүүлсэнээр биет бус соёлын өвд нөлөөллөө үзүүлнэ.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт хэзээд сул байсаар ирсэнээс үзэхэд уурхайн бүтээн байгуулалт, үйл ажиллагааны нөлөөгөөр мянга мянган археологийн өв бүхий газар нутаг устан үгүй болох магадлалтай бөгөөд өөр бусад хэдэн мянган соёл, өлгийн зүйлс гэмтэж, хохирол амсана.Гадны ажилчид олноор орж ирэн өөр өөр соёл, заншлыг нэвтрүүлсэнээр биет бус соёлын өвд нөлөөллөө үзүүлнэ.Палеонтологийн олдвор бүхий тогтоц, ашигт малтмалын агууламжаар баялаг болох нь тогтоогдсон Өмнөговь, Баянхонгор аймгууд нөлөөлөлд хамгийн ихээр өртөнө.



4.3.2.3 Соёлын өв: Арга хэмжээний зөвлөмжүүд

Хүснэгт 4.17 Соёлын өв: Арга хэмжээний зөвлөмжүүд

Арга хэмжээний зөвлөмж	
	<ul style="list-style-type: none">• Соёлын өвийн дэд бүтэц, чадавхийг бий болгох хамтын ажиллагааг бэхжүүлэх.• Уул уурхайн салбарын соёлын биет бус өвд үзүүлж буй нөлөөллийн судалгааг үндэсний хэмжээнд явуулах• Уламжлалт мал ахуй эрхлэгчдийг сэргээгдэх эрчим хүч, мэдээллийн технологи зэрэг орчин үеийн технологиор бэхжүүлэх
Сум	<ul style="list-style-type: none">• Соёлын өвийн дэд бүтэц, чадавхийг бий болгох хамтын ажиллагааг бэхжүүлэх.• Соёлын биет бус өвийг хамгаалах, соёлын биет бус өв тээгчдийг дэмжих хөшүүргийг уул уурхайн компаниудад бий болгох.• Уламжлалт мал ахуй эрхлэгчдийг сэргээгдэх эрчим хүч, мэдээллийн технологи зэрэг орчин үеийн технологиор бэхжүүлэх.• Уул уурхай, аялал жуулчлалын компаниуд, нутгийн иргэдийг оролцуулан соёлын өвийг хамгаалах төслийг санаачлан хэрэгжүүлэх.• Уурхайн үйл ажиллагаанаас археологи, палеонтологийн өвд үзүүлэх нөлөөллийг хянахад малчид, олон нийтийг оролцуулах ажлыг зохион байгуулах.• Уул уурхайн үйл ажиллагаа өрнөж буй газруудад уул уурхайн компаниудад зориулсан соёлын өвийн талаарх танилцуулга хөтөлбөр боловсруулахад сумын засаг захиргаанд туслалцаа үзүүлэх.• Уурхайн үйл ажиллагаа явуулж буй компаниуд, сумын засаг захиргаа шинэ ажилчид, шилжин суурьшигсдад орон нутгийн соёл, зан заншлыг танилцуулж, мэдээлэл өгөх ажлыг дэмжих.
Аймаг	<ul style="list-style-type: none">• Биет бус соёлын өвийн дэд бүтэц, чадавхийг бий болгох хамтын ажиллагааг бэхжүүлэх.• Соёлын биет бус өвийг хамгаалах, соёлын биет бус өв тээгчдийг дэмжих хөшүүргийг уул уурхайн компаниудад бий болгох.• Уурхайн үйл ажиллагаанаас археологи, палеонтологийн өвд үзүүлэх нөлөөллийг хянахад малчид, олон нийтийг оролцуулах ажлыг зохион байгуулах.• Уламжлалт мал ахуй эрхлэгчдийг сэргээгдэх эрчим хүч, мэдээллийн технологи зэрэг орчин үеийн технологиор бэхжүүлэх.
Улс	<ul style="list-style-type: none">• Соёлын өвд уул уурхайн үзүүлж буй нөлөөний тухай нэгдмэл ойлголтыг олон нийтэд хүргэхийн тулд уул уурхайн салбарын соёлын биет бус өвд үзүүлж буй нөлөөллийн судалгааг үндэсний хэмжээнд явуулах.• Уул уурхайн үйл ажиллагааны дүнд их ба дунд хэмжээгээр хөндөгдөх газар нутагт суурь судалгаа (археологи ба палеонтологийн) явуулах. Уг суурь судалгааг ердийн судалгаа явуулахаас богино хугацаанд, бага зардлаар урьдчилан гаргасан загварчлалыг хэрэгжүүлэх замаар гүйцэтгэх (Оюу Толгойн 2011 оны Соёлын өвийн хөтөлбөрийг үзнэ үү). Эдгээр судалгаануудад үндэслэн нутгийн иргэдийн оролцоотойгоор хамгаалалтын бүсийг тодорхойлж уг биет соёлын өвийн бүсэд уурхайн үйл ажиллагаа явуулахгүй байхыг уурхайн компанид мэдэгдэх.• Их, дунд хэмжээгээр хөндөгдөж болзошгүй соёлын өвийн нөөц бүхий газар нутагт суурь судалгаа явуулах зардлыг уурхай болон бусад олборлох салбарын компаниудаар төлүүлэх, үүнд зориулсан сан байгуулах.• Соёлын өвийг хамгаалах хуультай нийцээгүй тохиолдолд торгууль ногдуулан хэрэгжүүлэх.• Уурхайн нөлөөнд өртөх соёлын өвийн эрэл хайгуулыг хариуцах болон нөөцийг хянах олон тооны мэргэжлийн археологич, палеонтологич, биет бус соёлын өвийн мэргэжилтнүүдийг агентлагуудын хүрээнд соёлын өвийг хамгаалах олон улсын шилдэг туршлагад сургах, чадавхижуулах ажлыг зохион байгуулах.



4.3.3 Хүний эрх ба олон нийтийн оролцоо

4.3.3.1 Нөлөөлөл ба хувилбаруудын танилцуулга

Уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд дотоод, гадаадын операторууд оролцох ба олон улсын стандартыг мөрдөн орон нутгийн шаардлагад нийцүүлэн хүний эрх орон нутаг, олон нийтийн оролцоог хангах тал дээр ажилладаг. Уул уурхайн үйл ажиллагаан дахь хүний эрх ба олон нийтийн оролцооны хүрээг доор тодорхойлов.

Олон нийтийн оролцоо: Уул уурхайд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь чухал боловч хууль эрх зүйн орчин болон амьдрал дээр хэрэгжих тал дээр хангалтгүй байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 18-р бүлэгт, зөвшөөрөл олгохоос өмнө юуны түрүүнд үнэлгээнд олон нийтийг оролцуулан орон нутгийн иргэдийн саналыг тусгаж төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ)-д оруулахаар тусгагдсан байдаг. Олон нийтийн оролцоо нь байгаль орчны асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулагддаг. Түүнчлэн олон нийтийн санаа бодлыг стратегийн үнэлгээнд оруулсан байх шаардлагатай ч байгаль орчны нөлөөллийн болон стратегийн үнэлгээний аль алинд (мөн нийгмийн нөлөөллийн үнэлгээний хэсэгт) эдгээр саналыг хэрхэн тусгах тал дээр нарийвчилсан аргачлал зааварчилгаа байдаггүй.

Бодит байдал дээр БОНБНУ-нд олон нийтийн санал бодлыг хожуу буюу төслийн үр дүн хэдий нь гарсан хойно авах нь бий. Үнэлгээг гүйцэтгэх явцад судалгааны төгсгөл орчимд хийгддэг ИТХ-ын үеэр гол төлөв олон нийтийн санал бодлыг цуглуулдаг ба эдгээр авсан саналыг тайланд хавсаргаж, харин тухайн дэвшүүлж тавьсан асуудалд хариулт өгөх нь бага байдаг. Оршин суугаа иргэдийн саналыг үл ойшоох нь тухайн уул уурхайн төсөл цаашид орон нутгийн дэмжлэгийг авахгүй байх магадлалыг ихэсгэдэг. Энэ нь компаний нэр хүнд, тусгай зөвшөөрөлтэй холбоотой ба орон нутгийн олон нийтийн дунд төслийг хүлээн зөвшөөрүүлэх боломжийг эрэлхийлдэхийн зэрэгцээ Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар мөн төслийг хүлээн зөвшөөрүүлэн албан ёсоор зөвшөөрөл авах нь ихээхэн чухал асуудал юм.

Иргэний нийгмийн байгууллагууд нь нийтэд болон гишүүддээ үйлчилдэг ба 2013 оны байдлаар 22,177 байгууллага бүртгүүлээд байгаагаас дөнгөж 404 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. “2012-2022³⁰ оны дундаас урт хугацааны шууд ардчилал ба иргэдийн оролцоонд суурилсан төвлөрлийг сааруулах стратегийн бодлогын баримт бичиг” нь Монгол улсын Үндсэн хуулийн “Монгол хүн төрийн эрхийг өөрсдийн сонгосон төлөөллийн дагуу барина” гэсэн заалтад үндэслэдэг. Энэхүү стратеги нь иргэдийн оролцоог хуулийн дагуу чиглүүлэх төрийн систем ба дэмжлэг үзүүлэх байгууллагын бүтцийг бий болгох юм.

Ашигт малтмалын тухай хууль нь хамтын хөгжлийн санг байгуулах тухай заасан боловч одоогийн байдлаар хэрхэн байгуулах талаарх дэмжлэг болон зааварчилгаа алга байна. Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлого нь хөрөнгө оруулагч ба орон нутгийн иргэд уул уурхайн төсөл хэрэгжихээс өмнө харилцан ойлголцож орон нутгийн өөрөө удирдах байгууллага тус уурхайн төсөл орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөг урьдчилан тооцсон байхаар заасан. Орон нутагтай байгуулах гэрээний дагуу хөрөнгө оруулагч ба орон нутаг одоогийн Ашигт малтмалын хуулийн дагуу ил тод байлдыг ханган талуудыг уул уурхайн төсөлд

³⁰ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 176-р зарлигаар батлагдсан (2012.09.21).

оролцуулна. Талуудыг оролцуулах энэхүү үйл ажиллагааны аргачлал боловсруулагдаж дуусах хүртэл уул уурхайн компани энэ ажиллагааг өөрсдийн бодлогын дагуу явуулж олон нийттэй ажиллана.

Хуулинд заагаагүй бол олон нийтийн оролцооны асуудлыг компани ба орон нутаг өөрсдөө шийдэхээр байна. Ихэвчлэн тэдгээрийн хоорондын харилцаа холбоо нь ИТХ ба орон нутгаас сонгогдсон удирдлага хооронд хязгаарлагдаж байгаа бөгөөд цаашдын хамтын ажиллагаа компаниас түлхүү хамаарахаар байна. Холбогдох журам, аргачлал байхгүй байх тохиолдолд нийгмийн харилцааг зохицуулах асуудал нь компаниас голчлон шалтгаалах бөгөөд энэ асуудлаар тухайн компаний биелүүлэх шаардлагатай наад захын заалтууд гэж байдаггүй.

Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр, иргэний нийгэм, иргэдийн оролцоо, хууль журмын биелэлт сайжирснаар компани, орон нутаг, Засгийн газар, иргэний нийгэм хоорондын итгэлцэл бэхжиж Монгол улсын баялгийн талаарх шийдвэрийг олон нийтийг өндөр түвшинд оролцуулан гаргадаг болох нь тодорхой.

Газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулах: Газрын хэвлий, байгалийн баялгийг эзэмшүүлэх, ашиглуулах, шилжүүлэх тухай харилцааг дараах хуулиуд зохицуулна:

- Үндсэн хууль (1992);
- Газрын тухай хууль (2002);
- Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2003);
- Иргэний хууль (2002).

Одоогийн хууль тогтоомжийн дагуу сумын Засаг дарга малчдад өвөлжөөний газрыг эзэмших эрх олгох эрхтэй боловч энэ нь орчны задгай бэлчээрийн талбайд хамааралгүй зөвхөн өвөлжөөний доорх газарт нь хамааралтай байдаг. Үндсэн хуулийн дагуу бэлчээр нь ард түмний мэдэлд байх ба төрийн өмч юм. Задгай бэлчээрийг иргэд эзэмших, өмчлөх эрхгүй, харин Газрын тухай хуулийн дагуу бэлчээрийг хамгаалах, бэлчээрийн сэлгээг зохицуулах, хатуу, ширүүн улиралд мал сүргийг бэлчээх зорилгоор өвөлжөөг задгай бэлчээрийн хамт малчдад гэрээний дагуу ашиглуулдаг ба зуслан, намаржааны газар энэ заалтанд хамаардаггүй.

Мөн Монгол улсын хуулийн дагуу газрыг иргэд байгууллага өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй ч бэлчээрийн хувьд оршин сууж байгаа буюу өвөлжөөний газарт л эрх үүсдэг. Газрын эрхийн бүртгэл хийгддэг ч задгай бэлчээрийн хувьд иргэдэд ашиглах, эзэмших эрх үүсээгүй тул бэлчээр ашиглагчид газраа алдахад хуулийн дагуу нөхөн олговор авах эрхгүй байдаг. Өвөлжөөний газрыг эзэмших эрхийн маргаан үүсэхэд уламжлалт газар ашиглах эрх буюу уг газрыг уламжлан ашиглаж ирсэн талд эзэмших эрхийг олгодог.

Үндсэн хуулийн зарчмыг эс тооцвол Монголд нөхөн олговор, нүүлгэн суурьшуулалтын асуудлыг хууль журмаар нарийвчлан зохицуулаагүй байна. Газрыг улсын тусгай хэрэгцээнд л зориулан чөлөөлөх боломжтой. Газрыг чөлөөлөх явцад нүүлгэн суурьшуулалтад өртөгч иргэдтэй нөхөн олговор олгох талаар харилцан тохиролцож болох ч хөрөнгийн үнэлгээг гүйцэтгэх тал дээр асуудлууд байсаар байна. Үүнд, олон улсын нүүлгэн суурьшуулалтын стандартын дагуу алдсан хөрөнгийг дахин орлуулан бий болгох зардлыг тооцон нөхөн олгох (прагтик барилгын өртгийг үнэлэхдээ элэгдлийг тооцон үнэлэснээр тухайн олгогдсон нөхөн олговрын үнээр зах зээл дээр



өмнөх өөрийн амьдарч байсан хэмжээний барилга авч чаддаггүй), эсвэл зөвшөөрөлгүй газар ашиглаж буй иргэдийн асуудлыг тооцон үзэх (практикт нөхөн олговоргүйгээр албадан нүүлгэдэг) зарчмыг баримталдаггүй. Уул уурхайн төслийн хөрөнгө оруулагчид одоогийн газар ашиглагчдад бэлчээр болон ундны усны эх үүсвэрээ алдсаны нөхөн төлбөрийг олгох (гол төлөв малчид) арга хэмжээг авахаар санаачилж болох ч энэхүү арга хэмжээг зохицуулсан хууль, журам дутагдалтай байна. Энэ нь эдийн засаг болон биет нүүлгэн суурьшуулалтад өртсөн өрхүүд болон газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулах үйл ажиллагаа, тэр дундаа олон уурхайгаас нөлөөлөл нь хуримтлагдсан газруудад энэ ажиллагааг хэрэгжүүлж буй компаниудын хувьд цаашид олон асуудлыг үүсгэхээр байна.

Газар болон бэлчээр ашиглалт хэсгийг үзнэ үү (4.2.2-р хэсэг).

Амьжиргаа: Олон нийтийн оролцооны талаарх дээрх хэсэгт дурдсан хамтран ажиллах гэрээ болон Олон нийтийн хөгжлийн сан нь уул уурхайн төсөл хэрэгжиж байгаа сумдын оршин суугчдын амьжиргааг дээшлүүлэх нэг хөшүүрэг юм. Энэхүү сан нь бэлчээрийн менежмент, уул уурхайн сүлжээ, жижиг дунд үйлдвэрийг дэмжих, дэд бүтцийн хөтөлбөр гэх мэт үйл ажиллагааг дэмжих боломж чадавхитай байна. Үйл ажиллагааны хүрээг сумын түвшинд тодорхойлох ба тодорхой нөхцөлтэй байвал зохино.

Аймаг, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ нь Ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд хийгдэнэ. Хуулинд зааснаар:

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн захиргааны эрх бүхий этгээдтэй хамтран ажиллах ба гэрээг байгуулахдаа байгаль орчин хамгаалах асуудал, уул уурхайн олборлолт, уул уурхайн бүтээн байгуулалт, ажлын байр бий болгохтой холбоо бүхий дэд бүтцийг барьж байгуулах асуудал тусгагдана. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран дээрх асуудлаар олон нийтийн форум зохион байгуулж болно. Орон нутгийн иргэд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг хянах үүрэг бүхий төлөөлөгчийг сонгож болох юм.

Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэх заавар удирдамж байхгүйгээс компаниуд нийгмийн хариуцлагаа биелүүлэх үүднээс орон нутгийн нийгмийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг харилцан тодорхойлж хэрэгжүүлэх, хянахаар гэрээ байгуулах хандлагатай байна. Сум\аймгийн түвшний хамтран ажиллах гэрээ нь зарим тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн заалт, нөхцлүүд хүчин төгөлдөр болохоос өмнө хийгджээ (Састэйнабилити Ийст Эйжия, 2014). Зарим компаниудын хувьд өмнө нь Монголд байсан наад захын шаардлагад нэмэлт болгож нийгмийн хариуцлагыг биелүүлэх менежментийн хэрэгслийг өөрийн үйл ажиллагааны үр дүнг хүртэх болон үр нөлөөллийг нь хүртэж буй нийгэмдээ нэр хүндээ хадгалах сайн туршлага болгон ашиглахыг санал болгож байна. Энэ нь компаниудын хувьд оролцогч талуудтай тохиролцоо үйл ажиллагааг тодорхойлох арга хэрэгслүүд юм.

Хүн амын шилжилт хөдөлгөөн ба иргэдийн нэгдмэл байдал: Монгол улсын Үндсэн хуулиар (16.3 дугаар зүйл) улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, оршин амьдрах газраа өөрөө сонгох эрхийг олгосон байдаг. Уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр төлөвлөсөн эсвэл аз сорьсон байдлаар ажил хайн уурхайтай газрууд луу шилжин явагсдын урсгал бий болсон. Уурхайн компаниуд дараах байдлаар хүн амын шилжилт хөдөлгөөнийг нэг талаас идэвхтэй өөгшүүлж нөгөө талаас хязгаарлаж байна. Үүнд:



- Тухайн орон нутагт суурьшин амьдарч ажиллах иргэдийг ажилд авахын тулд шилжилт хөдөлгөөнийг дэмжих.
- Тодорхой хугацаагаар тухайн орон нутагт аль хэдийн оршин амьдраад ирсэн иргэдийг (жишээ нь: хайгуулын ажил эхлэхээс эхлээд) ажлын байраар хангахын тулд гаднаас ажил хайн шилжин ирэгсдийн урсгалыг хязгаарлах.

Хоёр үзэгдлийн аль аль нь орон нутагт ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, цөөн хүн амтай нутгийн иргэдийн нэгдмэл байдал, уурхайн дайвар орлого (уурхайн салбарт хөдөлмөр эрхлэгчид, уурхайн бус салбарт хөдөлмөр эрхлэгчид), эрүүл мэнд, боловсрол гэх мэт нийгмийн үйлчилгээний хүртээмж зэрэг өөр олон хүчин зүйлст хүн ам зүйн талаасаа тодорхой нөлөөлөл үзүүлж, үр дагавар авчирна.

Социализмийн үед Монголд уурхай нь өөрсдийн “уурхайн хотхоныг” бүхий л талаас нь харж үздэг байсан (жишээ нь: ажилчид болон тэдний ар гэрийг орон байраар хангах гэх мэт). Зарим тохиолдолд Засгийн газрынхаа ард иргэддээ эдгээр үйлчилгээг үзүүлэх үүргээ хэрхэн биелүүлж байгааг шалгаж үзээгүй хэрнээ уурхайн компаниудад дээр үеийнхээ ойлголтоор ийм шаардлага тавих нь бий. Эсрэгээрээ олон улсын тэргүүн туршлагаар бол уурхайгаас хараат хот бий болох үзэгдлийг аль болох бууруулах бүхий л арга замыг эрэлхийлж, уурхай хаагдсанаас хойш биеэ даан орших чадвартай орон нутгийн бүтцийг бий болгож, чадавхи муутай орон нутгийн засаг захиргааг эдгээр нийгмийн үйлчилгээг иргэддээ зохих ёсоор үзүүлэх тал дээр чадавхижуулах арга замыг хайдаг. Цаашлаад орон нутгийн ажилгүйдлийг багасгах, өөр өөр ёс заншил, соёл, нийгмийн хэв маягтай (мөн 4.3.2 Соёлын өв хэсгийг харна уу) гадны иргэдийн шилжилт хөдөлгөөний улмаас орон нутгийн ард иргэдийн нэгдмэл байдлыг алдагдуулах заналхийллийг бууруулахад чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний бодлогыг хэрэгжүүлдэг.

Бодит байдал дээр компаниуд болон сумын засаг захиргааны хүн амын шилжилт хөдөлгөөний асуудал дээр хамтран ажиллах байдал нь тохиолдол бүрт харилцан адилгүй байгаа бөгөөд цаашлаад нэг аймагт байгаа компани өөр өөрийн гэсэн аргачлал ашиглаж тэр нь тухайн орон нутагт албан болон албан бус байдлаар мөрдөгдсөнөөс төрөл бүрийн түвшний хэм хэмжээ бүхий үйлчилгээг иргэдэд хүргэж, мөн их бага янз бүрийн хэмжээний зөрчлийг үүсгэдэг. Жишээ нь Цогтцэций (Ухаа Худаг уурхайн төсөл байрлаж буй) сумын хүн амын өсөлт албан ёсны тоон мэдээгээр 2008-2012 онд 130% байхад Ханбогдод (Оюу Толгойн уурхай байрлах) 42% гэж гарчээ (Үндэсний статистикийн хороо, 2014). Уугуул оршин суугчид дээр нэмэгдээд тус суманд 15,000 иргэн амьдарч, хэсэг суурьшаад буцсан гэсэн тоо баримт байна.

Орон нутгийн иргэдэд үзүүлэх нийгмийн үйлчилгээний талаар 4.4.2 Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц хэсгээс үзнэ үү.

Хүний эрх: Монгол улс Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Олон улсын иргэний болон улс төрийн эрхийн хэлэлцээр, үүнээс гадна 11 олон улсын хүрээлэн буй орчны конвенц, бүс нутгийн 3 гэрээ зэрэг 24 хүний эрхийн конвенц, олон улсын гэрээнд гарын үсэг зурсан байна. Улсынхаа нутаг дэвсгэр дээр шилжин суурьших эрхээс гадна, эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцлөөр хангуулах, хүрээлэн буй орчны бохирдол, байгаль орчны тэнцвэргүй байдлаас хамгаалуулах эрхтэй. Эдгээр заалтууд байгаа ч Монголын Засгийн газрын энэ үүрэг, амлалтаа хэрхэн биелүүлж байгаа нь аль ч түвшинд үл үзэгдэнэ. Үр дүнд нь уул, уурхайн нөлөөлөлд хамгийн ихээр өртсөн иргэд уурхайн хөгжлийн үр шимээс хамгийн багаар хүртэж байна. Жишээ нь



аймгийн түвшинд (Усны талаарх 4.2.1 хэсгийг үзнэ үү) уурхайн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдэд төлөх хураамжийн төлбөрт зөвхөн хэрэглэсэн усны төлбөр орсон бол сумын түвшинд компаниудаас суманд шууд хөрөнгө оруулалт хийнэ гэсэн хамтран ажиллах гэрээний хараахан ажил хэрэг болоогүй цаасан дээрх заалт л байна.

Хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай, эмэгтэйчүүд гэх мэт эмзэг, ядуу бүлгийн хүмүүсийг уурхайн салбарын хөгжлийн үр ашгаар харж хандаж байгаа зүйл байхгүй. Жишээ нь дөнгөж сүүлийн 5 жилд л эмэгтэй хүн ажиллуулахыг хориглосон хэд хэдэн уурхайн ажил, мэргэжлийн хоригийг цуцалсан. Тийм боловч эмэгтэйчүүдийн тэтгэвэрийн нас 55 байдаг нь эрэгтэйчүүдээс таван жилийн өмнө тэднийг идэвхтэй хөдөлмөрлөх хүчнээс хасч байгаа хэрэг юм.

Өмнөговь аймагт уурхайн үйл ажиллагаа явагдаж эхэлсэнээс хойш хүйсээс хамааралтай хүчирхийллийн гаралт нэмэгдсэн гэсэн судалгааны дүн гарчээ (Квинслэндийн их сургууль, 2014.). Ялангуяа, мэдээлэгч болон хохирогчдын мэдээлж буйгаар гэр бүлийн хүчирхийлэл, биеэ үнэлэлт, архилдалтаас үүдсэн хүчирхийлэл нэмэгдсэн бөгөөд хувь хүний сэтгэл санааны хямрал, гэр бүл салалт, эрүүл мэндийн асуудал, ард иргэдийн амгалан тайван байдал алдагдах зэрэг үр дагаваруудыг авчирч байна. Хүйсээс хамааралтай хүчирхийллийн хэлбэр, гаралтын түвшин нь дэд бүтцийн төрөл, хөрш зэргэлдээ сум, суурингийн зай зэрэг хүчин зүйлсээс шалтгаалдаг.

Малчдын хувьд уурхайн үйл ажиллагааны (Нүүлгэн суурьшуулалтыг харна уу.) нөлөөллөөр бэлчээр, усны эх үүсвэрээ орхин шилжиж суурьших, эсвэл чанартай бэлчээр нутаг, усны нөөцийг ашиглах боломжгүй болох зэргээр хохирч байна. Ингэснээр үржил шимтэй нутаг бэлчээр, усны эх үүсвэрийнхээ төлөө тэмцэх эсвэл боловсрол, нийгмийн үйлчилгээ зэргээс холдон удаан хугацаагаар нүүдэллэх үү гэсэн хоёр сонголттой хүчээр тулгарч байна (Хүний эрхийн үндэсний комисс, 2012).

Эцэст нь хувиараа ашигт малтмал олборлогч нар нийгмийн хамгааллын арга хэмжээгээр дамжуулан хамгаалуулах ёстой хүний эрхээ хагас дутуу эдэлж байна. Хуулиар зөвшөөрөгдсөн ганц боломж нь уурхайн компани, орон нутгийн захиргаа, бичил уурхайн нөхөрлөл нар харилцан зөвшилцсөнөөр бусдын эзэмшилт уурхайд бичил уурхай эрхлэхийг зөвшөөрөх явдал юм. Гэсэн хэдий ч хувиараа ашигт малтмал олборлогч иргэд ихэвчлэн гадуурхагддаг. Тэд хамгаалагч нарын зүгээс хүчирхийллийн шинжтэй ялгаварлан гадуурхалтад өртөж, насанд хүрээгүй хүүхдээр хөдөлмөр эрхлүүлсэн (жишээ нь: сургуулийн насны хүүхдээр биеийн хүчний хүнд ажил хийлгэх) хэрэгт ордог (Тогтвортой бичил уурхайн төсөл, 2012). Бичил уурхайн талаар 4.3.1-р хэсгээс харна уу.

Монголд хүний эрхийг хамгаалах хуул эрх зүйн үндэс нь бүрдсэн хэрнээ бодит байдал дээр тэдгээр нөхцлүүдийг биелүүлэх тогтолцоо нь байхгүй байна хэмээн дүгнэж болно.



Хүснэгт 4.18 Оролцогч талуудын тодорхойлсон хүний эрх ба олон нийтийн оролцоотой холбоотой эн тэргүүний асуудлууд

Түвшин	Бага өсөлттэй хөгжлийн хувилбар	Дундаж өсөлттэй хөгжлийн хувилбар	Өндөр өсөлттэй хөгжлийн хувилбар
Эн тэргүүний асуудлууд:			
	• Олон нийтийн оролцоо, хүлээлт		• Олон нийтийн эрх
Сум	<ul style="list-style-type: none"> Нийгэм, орон нутгийн менежмент, хүний эрхийн асуудлууд нь эн тэргүүний тулгамдсан асуудалд тооцогдохгүй. Төр засгийн зүгээс компаниудын нийгмийн үйл ажиллагаанд мониторинг хийж, зохицуулах одоогийн чадавхиа хадгална. Уул уурхайн цөөн компаниуд ажиллаж байх учраас хүний эрх дарагдаж, зөрчигдөх асуудал бага гарна. 	<ul style="list-style-type: none"> Илүү дэвшилтэт компаниуд/орон нутгийн засаг захиргааны санаачилгаар хийгдсэн олон нийтийн зөвшилцөл/ хэлэлцүүлгээр дамжуулан иргэдийн хурлаас эхлээд БОНУ хүртэл олон нийтийг янз бүрийн түвшинд оролцуулна. Сумын удирдлагын уул уурхайн компаниудын нийгмийн гүйцэтгэлийг хянах чадамж, анхаарал тааруу байна. Нүүлгэн суурьшуулах нэгдсэн журам, аргачлал байхгүй тохиолдол янз бүрээр шийдвэрлэнэ. Уурхайн нөлөөлөлд өртсөн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, амьжиргааг хамгаалах арга нь компани, компаний дотоод стандарт болон тухайн компани сумын засаг захиргаа, иргэний нийгмийн байгууллагууд, төрийн байгууллагуудтай хэр сайн харилцаатайгаас шалтгаалан янз бүр байна. Хүний эрхийг сахин хамгаалах тал дээр ажилладаг хэдхэн сумыг эс тооцвол хүний эрхийн хамгаалалт маш бага буюу бараг байхгүй байна. 	<ul style="list-style-type: none"> Монгол улсын ЗГ-ын зүгээс уул уурхайн компаниудын нийгэм, орон нутгийн менежментийн үйл ажиллагаанд хяналт тавих боломж, чадвар суларна. Энэ нь уул уурхайн компаниудын нийгмийн үйл ажиллагаа буурч, уул уурхай явагдаж буй орон нутгуудын нөхцөл байдал урт удаан хугацаанд муудаж, доройтоно гэсэн үг юм. Хүний эрхийн асуудлыг анхаарч үзэх нь бага буюу бараг байхгүй болно. Уул уурхайтай холбоотой үйл ажиллагаанаас үүдэн сумын уугуул иргэдийн уламжлалт газар, усаа эзэмшин ашиглах эрх, эрүүл орчинд амьдрах эрх, ариун дагшин уул, толгод, гол усаа шүтэх зэрэг эрхүүд зөрчигдөнө. Уурхайн талбайд орших зарим уул толгод үгүй болсноор сумын уугуул иргэдийг архинд донтох, зүрхний шигдээс, стресстэй болох, сэтгэл гутралд автах зэрэгт хүргэх сэтгэл зүйн асуудлууд ихсэнэ. Гэвч, уул уурхай нь шинэ боломжууд бий болгож, амьдралын түвшинг сайжруулж, нийгмийн хөгжлийг бий болгоно.
Аймаг	<ul style="list-style-type: none"> Дээрхтэй адилхан. 	<ul style="list-style-type: none"> Дээрхтэй адилхан. 	<ul style="list-style-type: none"> Сумын түвшний нөхцөл байдал нь хүн ам ихтэй, илүү их хяналт, хариуцлага шаардагдах аймгийн түвшинд томоор давтагдана.
Улс	<ul style="list-style-type: none"> Дээрхтэй адилхан. 	<ul style="list-style-type: none"> Дээрхтэй адилхан. 	<ul style="list-style-type: none"> Хариуцлагатай уул уурхай, компанийн нийгмийн хариуцлагын хууль журмыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн төр засгийн байгууллагууд уул уурхайн өсөлтийг гүйцэхгүй бөгөөд Монголын хууль зохицуулалт, хэрэгжүүлэлтийн тогтолцоонд ачаалал, дарамт үүснэ. Үр дүнд нь, уул уурхайн компаниуд хяналтгүйгээр үйл ажиллагаа явуулж, уул уурхайн бүсэд амьдарч байгаа орон нутагт сөрөг нөлөө үзүүлнэ. Уул уурхайн салбарын нийгмийн нөлөөллийг зохицуулж, хянах чадавхи бага байх хэдий ч уул уурхайн салбар нь мөн том хэмжээний нийгмийн хөгжлийн боломжуудыг бий болгоно.



4.3.3.2 Сум, аймаг, үндэсний түвшинд үзүүлэх нөлөөллийн эрчим

Өндөр болон бага өсөлтийн үед хүний эрх, олон нийтийн оролцоонд үзүүлж болзошгүй нөлөөллүүдийг дараах байдлаар авч үзэв. Үүнд:

- Уурхайн эзэмшлийн бүсэд орсон бэлчээр, усны эх үүсвэрийг ашиглах эрхгүй болсон малчдын шууд хохирол, уурхайн үйл ажиллагаатай (уурхайн эзэмшлийн бүс, зам тээвэр гэх мэт холбогдох дэд бүтэц, эрчим хүчний зурвас газрууд гэх мэт) холбоотойгоор эдийн засгийн хохиролд өртсөн малчдын шууд бус хохирол.
- Бэлчээр, усны эх үүсвэрээ алдсаны улмаас хүний эрх зөрчигдөх магадлал ихэссэн.
- Уурхайнууд нэмэгдэхийн хэрээр хүйсээс хамааралтай хүчирхийлэл гарах магадлал ихсэх.
- Иргэдийн шилжилт хөдөлгөөн ихэссэнээс нийгмийн зөрчил үүсэх магадлал нэмэгдэх (хүртээмж муутай нөөц, ажлын байр, нийгмийн дэд бүтцийн төлөө өрсөлдөх, тухайн нутаг дэвсгэрт халдварт өвчин дэлгэрэх, соёлын ялгаа үүсэх гэх мэт).
- Уурхайн болон уурхайн бус салбарын хөдөлмөр эрхлэлтэд дайвар эдийн засгийн боломжууд бий болох.
- Халдварт өвчин, хүн амын шилжин ирэх урсгал, уурхайтай холбоотой зам тээвэр нэмэгдэх зэргээс шалтгаалан хүн амын эрүүл мэнд доройтож, аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа ихээр алдагдах.
- Орон нутгийн иргэдийн уурхайтай холбоотой асуудлуудаар шийдвэр гаргах түвшинд оролцох чадавхид нөлөөлөх.
- Бэлчээрийн мал аж ахуй эрхлэх, ЖДҮ-ийн хангамжийн сүлжээ, үйлдвэрлэл, барилга болон бусад төрлийн салбар буюу уурхайгаас өөр эх үүсвэрийн үйл ажиллагаа эрхлэх боломжид нөлөөлөх.

Өндөр өсөлтийн хувилбар: Энэ хувилбарын үед уурхайн үйл ажиллагаа, түүнийг дагасан дэд бүтэц эрчимтэй нэмэгдэх тул олон нийтийн оролцоо, хүний эрх чухал ач холбогдолтой болох магадлал бий. Олон нийтийн оролцоо, хүний эрхийг хамгаалах асуудал байнга сул байсаар ирсэн нөхцөл байдал нь Монголын хууль эрх зүйн тогтолцооны хүрээнд нийгмийн нөлөөллийн үнэлгээ гүйцэтгэх, холбогдох шаардлага, удирдамжийг боловсруулах, тэдгээрийг үр дүнтэйгээр бүх түвшинд хэрэгжүүлэх сайтар бэлтгэгдсэн боловсон хүчнийг бэлтгэх шаардлага нэмэгдэнэ гэдгийг харуулж байгаа юм.

Хамгийн их эрсдэл хүлээж байгаа нь уурхай, түүний дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр бэлчээр нутаг нь хуваагдах, улмаар үлдсэн нутаг, бэлчээртээ амьдрах дарамт нэмэгдсэн, уурхайн үйл ажиллагаатай нэг дор, эсвэл дэд бүтцийн байгууламж ялангуяа томоохон дэд бүтцийн (зам, эрчим хүч, усан хангамжийн) зэргэлдээ орших орон нутгууд юм. Цаашлаад гадны иргэд олноор ирж суурьшсанаар шинэ ирсэн иргэдийн үзүүлэх нөлөөллийн улмаас (орон нутгийн соёлыг үгүй болгох аюул, хүйсийн хамааралтай хүчирхийлэл нэмэгдэх, оршин суугчдын амар амгаланг алдагдуулсан аюулууд, ард иргэдийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг алдагдуулах эрсдэл нэмэгдэх зэргээр олон нийтийн нэгдмэл байдлыг алдагдуулах) уурхайтай хамгийн ойр баг, сум хамгийн их эрсдэлд өртөнө.



Өндөр өсөлтийн хувьд хурдацтай өсөлт, үйл ажиллагааны өргөн цар хүрээний улмаас үүссэн цаг хугацаатай өрсөлдөх дарамтаас шалтгаалан компани, ард иргэд, засаг захиргааны бүрэн дүүрэн оролцоог хязгаарлах магадлалтай. Уурхайтай холбоотой шийдвэр гаргах түвшний бүрэн оролцоо нь ихээхэн цаг хугацаанаас гадна нөлөөлөлд өртсөн олон нийтийг хамгаалсан тогтвортой үр дүнд хүрэхэд зориулагдсан тогтолцоо, эсвэл олон нийтийн гэрээ, хэлцэлд хамтран оролцох хөрөнгө мөнгө шаарддаг. Өндөр өсөлтийн үед нийгмийн олон үйл ажиллагааг шууд санхүүжүүлэх боломжтой болох ч аливаа үйлчилгээг явуулахад техникийн хувьд (техникийн хувьд шууд дэмжлэг авах, бусад төсөлтэй холбоотой дэмжлэгүүд) гарч буй өөрчлөлтөд дасан зохицох хүний нөөцийн чадавхи, мөн тогтолцоог тогтвортой байлгахын тулд олон нийтийн дэмжлэг авах замаар Монгол улсын соёлд нэвтрэх зэрэг Монгол улсын өөрийнх нь чадварт даатгах шаардлагатай, санхүүжилтээс шалтгаалахгүй хийгдэх ёстой асуудлууд байсаар байх болно. Ялангуяа, Монголын ашигт малтмалын баялаг “малчдыг уурхайчин болоход хүргэж байгаа”, мөн үндэсний аж байдлын онцлог, цаашдын хөгжлийн зам мөр гээд үндэсний хэмжээнд авч хэлэлцэхүйц асуудлуудын шийдлийг олоход ихээхэн цаг хугацаа шаардагдана. Цаашлаад янз бүрийн улс орноос үйл ажиллагаагаа явуулж буй компаниуд уул уурхайн салбарт мөрддөг олон улсын сайн туршлагыг Монголд ямар замаар хэрэгжүүлэх гэж байгаа талаар зохих ойлголт өгөхийг шаардана.

Бага өсөлтийн хувилбар: Бага өсөлттэй хувилбарын үед үзүүлэх нөлөөлөл нь ерөнхийдөө бага байх төлөвтэй боловч энэ үед сумын түвшинд цөөн тооны уурхайн идэвхтэй үйл ажиллагаа явагдана. Сайтар зохицуулахгүй аваас дээр дурдсан нөхцөл байдлуудаас гадна хүний эрхийн болон олон нийтийн оролцооны нөлөөллийн асуудал ноцтой хэвээр байсаар байх болно.

Уул уурхайн хөгжлийн түвшин гарч болзошгүй нөлөөллийг шийдвэрлэх нөөц бололцоо, чадавхийг бий болгож чадахгүй тул (өндөр өсөлттэй хувилбартай ижил) орон нутгийн иргэдийн оролцоо, хүний эрхийн удирдлагыг зохих түвшинд аажмаар сайжруулах, дэлгэрүүлэх арга хэмжээг авах боломжийг олгоно.

Нөлөөллийн хураангуй

Бага өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">• Үр дүнтэй зохицуулалт дутагдвал хүний эрх болоод олон нийтийн оролцоотой холбоотой нөлөөлөл өндөр байсаар байна.• Олон нийтийг зохих түвшинд оролцуулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх, турших ажлуудыг аажмаар гүйцэтгэх боломж гарна.
Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">• Дундаж өсөлттэй хувилбарын үед уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагын хэрэгжилтийг хянах ЗГ-ын чадавхи дорой, хяналт муутай байна.• Газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааг зохистой зохион байгуулах аргачлал нэвтрээгүй, шилжилт хөдөлгөөний асуудлыг хангалттай шийдвэрлээгүй байна.• Хүний эрхийн асуудал маш бага ач холбогдолтой, цаашлаад огт авч үзэхгүй хэмжээнд хүрнэ.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">• Хууль эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоонд ачаалал нэмэгдэх тул хүний эрхийн асуудалд нөлөөлөл ихээр үзүүлэх магадлалтай.• Хурдацтай өөрчлөгдөж буй нөхцөл байдлыг удирдах хүний нөөцийн чадавхи сул байх тул төрийн байгууллагын халамж, үйлчилгээг зохицуулах, олон нийтийн идэвхтэй оролцоог хангах чадвар нь богино хугацаанд хязгаарлагдмал байна.• Урт хугацаанд олон нийтийн оролцоог үр дүнтэй болгох, хүний эрхийг дээдэлсэн зарчмыг авч хэрэгжүүлэх чадвар нь нэмэгдэнэ.



4.3.3.3 Хүний эрх ба олон нийтийн оролцоо: Арга хэмжээний зөвлөмжүүд

Хүснэгт 4.19 Хүний эрх ба олон нийтийн оролцоо: Арга хэмжээний зөвлөмжүүд

Арга хэмжээний зөвлөмж	
	<ul style="list-style-type: none">• Шийдвэр гаргах түвшин дэх иргэдийн оролцоог нэмэгдүүлэх• Одоогийн мөрдөгдөж байгаа байгаль орчны хууль, тогтоомжид нийцүүлэн дүрэм, журам, зохицуулалт, нөлөөллийн үнэлгээнд дараа дараагийн нөхцлүүдийг тусгах;• Олон нийтийн оролцооны үр дүнд хөндөгдсөн асуудлыг шийдвэрлэх байгууллагад тавигдах ерөнхий шаардлага.
Сум	<ul style="list-style-type: none">• Оролцооны аргад тулгуурлан нөхцөл байдалд тохирсон газар зохион байгуулалтын төлөвлөгөө (бэлчээр, уурхай, дэд бүтэц, тусгай хамгаалалттай газрууд гэх мэтийг оролцуулаад), (4.2.2 буюу Газар ашиглалт, бэлчээрийн тухай хэсгийг харна уу)-г боловсруулах• Хувиараа ашигт малтмал олборлогчид болон бичил уурхай эрхлэгчдийг бизнесээ хууль ёсны дагуу эрхлэх, нийгмийн үйлчилгээ хүртэх эрхийг хамгаалах (4.3.1 буюу Бичил уурхайн хэсгийг харна уу)• Компаниудыг нийгмийн хариуцлага, хүрээлэн буй орчин, санхүүгийн хөрөнгө оруулалтын байдлаа уурхайн үйл ажиллагааны шууд нөлөөлөлд өртдөг иргэдэд тайлагнахыг шаардах (4.4.1 буюу Засаглал, орлогын менежмент хэсгийг харна уу.)• Шаардлагыг зөрчсөн аливаа үйлдэлтэй холбоотой гомдлыг барагдуулах хараат бус төлөөлөгчийн газар (4.4.1 буюу Засаглал, орлогын менежмент хэсгийг харна уу.)-ыг байгуулах• Олон улсын уул уурхайн тэргүүн туршлагын талаар мэдлэг хуримтуулж, олон улсын уул уурхайн салбарынханд Монголын уурхайн салбарын үйл ажиллагааны (нийгмийн, хүрээлэн буй орчны, соёлын, эдийн засгийн, улс төрийн) орчны талаар ойлголт өгөх• Шийдвэр гаргах түвшинд мэдлэгтэйгээр оролцох бололцоог олгохын тулд нөлөөлөлд өртсөн ард иргэд, орон нутгийн удирдлага, иргэний нийгмийн байгууллагуудыг хангалттай мэдээлэл, оролцооны боломжуудаар хангах
Аймаг	<p>Дээр дурдсанаас гадна:</p> <ul style="list-style-type: none">• Бүсийн газар ашиглалтын төлөвлөлтийн хүрээнд (4.4.2 буюу Бүс нутгийн төлөвлөлт, тээврийн дэд бүтэц хэсгийг харна уу) уурхай дагасан иргэдийн албан бус суурин үүсэхээс сэргийлэх, бичил уурхай болон үйлдвэрлэлийн түвшний уурхайн орчимд үүссэн албан бус суурингуудыг хянах;• Урьдчилан тооцоогүй сөрөг үр дагаварыг (жишээ нь: нүүлгэн суурьшуулалтаас шалтгаалсан орон нутгийн хүн амд ирэх дарамт гэх мэт) бууруулахын тулд аймаг/бүсийн түвшинд хуримтлагдсан/бүсийн нийгмийн үзүүлэх нөлөөллүүдийг шийдвэрлэх
Улс	<p>Дээр дурдсанаас гадна:</p> <ul style="list-style-type: none">• Дээр дурдсанаас гадна өөр бусад уул уурхайгаас үүдэлтэй нийгмийн чанартай болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулахын тулд одоо хэрэгжиж буй уурхайн салбарын хууль, тогтоомжуудын мөрдөлтийг сайжруулж, хэрэгжилт, мөрдөлтийн үр дүнг дээшлүүлэхэд зохих нөөцөөр хангах шаардлагатай. Үүнд:<ul style="list-style-type: none">○ Уул, уурхайтай холбоотой шийдвэр гаргах явцад олон нийтийн бодит оролцоог хангах○ Хүний эрхийг дээдлэх;○ Газартай холбоотой эрхүүд, газар ашиглалтын төлөвлөлт, газар олголт, нүүлгэн суурьгуулалт;○ Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал ба○ Хүн амын шилжилт хөдөлгөөний зохицуулалт• Одоо мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хүрээнд уурхайн үйл ажиллагаанаас үүсч буй нийгмийн үр дагаварыг зохицуулах, үнэлгээ, ажиглалт судалгааг сайжруулах



Арга хэмжээний зөвлөмж

- Уул, уурхайн салбарын бодлого, хууль, журмуудыг бий болгох хэрэгжүүлэх, холбогдох НҮБ-ын олон улсын гэрээ, салбарын хуулиуд, түүнчлэн хүний эрх, аюулгүй байдлыг хангах Сайн дурын зарчмуудыг батлах, мөрдүүлж эхлэх;
- Уурхайн үйл ажиллагаанд мэдээлэлжсэн оролцогч бүхий оролцооны аргыг хэрэгжүүлэхийн тулд дараах асуудлаар хязгаарлагдахгүйгээр компаниуд, иргэний нийгмийн байгууллага, төрийн байгууллагууд, хувь хүмүүсийг уурхайгаас үүдсэн нийгмийн асуудлууд, боломжит хариу арга хэмжээнүүдийн талаар мэдлэг, ойлголттой болгох; Үүнд:
 - Газар ашиглалтын төлөвлөгөө, газын эрх, үүнтэй холбоотой үүргүүд
 - Уурхайн төслийн үе шатууд
 - Нийгмийн хариуцлагын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ, зохицуулалт

4.3.4 Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа

4.3.4.1 Нөлөөлөл ба хувилбаруудын танилцуулга

2-р бүлэгт баримтаар харуулсанчлан Монгол улсын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа (ЭМАА)-ны байдлын талаар статистик тоо баримт маш ховор. Үүний дотор хөдөлмөрийн ЭМАА, ялангуяа уурхайн салбарын нөлөөлөлд буй олон нийтийн болон малын ЭМАА-ны талаарх үзүүлэлт, тайлан бүр ч бага. Байгаа ховорхон ЭМАА-ны тоон үзүүлэлт нь ослын гаралт маш өндөр (нэмэгдсээр) байдгийг харуулж байгаа ба олон улсын олборлох үйлдвэрлэлийн сайн туршлагатай харьцуулахад эрсдлийн талаар янз бүрийн ойлголтууд байна. Цаашлаад бага хэмжээгээр цуглуулсан тоон мэдээ нь зөвхөн бүртгэгдсэн ослыг тусгасан бөгөөд ихэнх ослуудыг (ялангуяа хувиараа ашигт малтмал олборлогчдын дунд гарсан осол) бүртгэж мэдээлдэггүй тул эрсдлийг дутуу үнэлж байгааг харуулж байна. Уурхайн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа олон нийт болон уурхайн компаниудын дунд яагаад эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа чухал, аюулгүй ажиллагаа гэж юу болох талаар мэдлэг муутай байдаг нь ажлын байран дахь ЭМАА-ны мэдээлэл хомс байгаагийн шууд тусгал, үр дагавар билээ. Энэ нь хэлэлцүүлгүүдэд оролцсон талууд аюулгүй ажиллагаа нэн чухал биш харин нөлөөлөлд өртсөн мал амьтан, олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа нэн тэргүүнд гэж тодорхойлноос харахад баримттайгаар нотлогдож байгаа юм. Хэлэлцүүлэгт оролцсон талууд уг асуудлыг хэрхэн доогуур үнэлсэнээс аваад үзэхэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа харьцангуй шинэ ойлголт бөгөөд туршлага соёлын хувьд ч бага хүлээн зөвшөөрөгдсөн асуудал юм. Цаашлаад бичил уурхайн талаарх хэсэгт дурдсанаар хувиараа ашигт малтмал олборлогчдын ЭМАА-ны асуудал уурхайн салбарын толгойн өвчин болоод зогсохгүй ЭМАА-г муу сахиулсан нь аюултай ажлын байр нэмэгдэх, наад захын нийгмийн үйлчилгээг хүртэж чадахгүй байх, ялангуяа эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй байх зэрэг сөрөг нөлөөллүүдийг бий болгож байгаа юм.

Хүснэгт 4.20 Оролцогч талуудын тодорхойлсон эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаатай холбоотой эн тэргүүний асуудлууд

Түвшин	Бага өсөлттэй хөгжлийн хувилбар	Дундаж өсөлттэй хөгжлийн хувилбар	Өндөр өсөлттэй хөгжлийн хувилбар
Эн тэргүүний асуудлууд:			
<ul style="list-style-type: none"> • Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа • Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа • Малын эрүүл мэнд, аюулгүй байдал 			
Сум	<ul style="list-style-type: none"> • Хүн, малын эрүүл мэндэд ашиг тустай байна. • Эрүүл мэндийн бүх нөхцөл байдал сайжирч, эрүүл саруул амьдрах орчинг хадгалж, хамгаална. 	<ul style="list-style-type: none"> • Олон нийтийн болон малын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа нэн тэргүүний санаа зовоох асуудал. Уурхайгаас үүсч буй бохирдол, тоосжилт малчид болоод малыг янз бүрээр хордуулна. • Уурхай ихтэй газруудад шилжин ирэгсэдийн тоо их байгаагаас шалтгаалан иргэд нийгмийн үйлчилгээнд хамрагдах байдал төдий чинээ доогуур байна. 	<ul style="list-style-type: none"> • Уул уурхайн салбарын өндөр өсөлт нь тоосжилт, ус, агаарын бохирдлыг нэмэгдүүлэх зэргээр хүн, малын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлнэ. • Шилжин ирсэн ажиллагсадын тоо нэмэгдсэнээр халдварт өвчний гаралт өсөж сумын түвшний орон нутгийн ард иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл учруулна.
Аймаг	<ul style="list-style-type: none"> • Агаар, газар, усны бохирдол бага байх тул хүн, малын эрүүл мэнд илүү сайн байна. Энэ нь аймгийн түвшинд эн тэргүүний ач холбогдолтой гэж үзсэн асуудлуудын нэг байв. 	<ul style="list-style-type: none"> • Дээрхтэй адилхан. 	<ul style="list-style-type: none"> • Дээрхтэй адилхан. • Аймгийн түвшний хувьд хүний эрүүл мэнд нь нэн тулгамдсан асуудалд тооцогдоогүй.
Улс	<ul style="list-style-type: none"> • Агаар, газар, усны бохирдол багассанаар хүн малын эрүүл мэндийн нөхцөл байдал сайн байна. Энэ нь улсын хэмжээнд гаргаж тавьсан ач холбогдолтой асуудлуудын нэг байв. 	<ul style="list-style-type: none"> • Уурхайн үйл ажиллагаа явагдаж буй газруудын ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаандаа тавих шаардлагыг биелүүлэхэд хэрэгцээтэй нийгмийн үйлчилгээг хүргэх чадамж хангалтгүй, уурхайн үйл ажиллагаанаас үүдсэн эмх замбараагүй байдлын улмаас үндэсний түвшинд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа нэн тэргүүний шийдвэрлэх ёстой асуудал болно. 	<ul style="list-style-type: none"> • Дээрхтэй адилхан.



4.3.4.2 Сум, аймаг, үндэсний түвшинд үзүүлэх нөлөөллийн эрчим

Гурван түвшний өсөлтөд харгалзуулан уурхайн хөдөлмөрийн ЭМАА, олон нийтийн ЭМАА, малын ЭМАА-ны өнөөгийн байдлыг дүгнэхэд дараах хэд хэдэн гол нөлөөлөл ажиглагдаж байна.

Бага өсөлтийн хувилбараар аваад үзвэл уурхайн үйл ажиллагаа бага явагдах тул түвшин түвшиндээ олон нийтийн, хөдөлмөрийн, малын ЭМАА-д үзүүлэх сөрөг нөлөө бага байна. Гэсэн хэдий ч уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх сумдад ЭМАА-тай холбоотой нөлөөлөл их гарна. Түүнчлэн, хөдөлмөрийн ЭМАА-ны хууль, журмыг хэрэгжүүлэх төрийн албан хаагчдын чадавхийг нэмэгдүүлэх (одоо ч гэсэн сул байгаа), эрүүл мэндийн үйлчилгээ зэрэгт оруулах Засгийн газрын орлого бага байх тул энэ хоёр хүчин зүйл дээр ажлын чанар муу хэвээр байх төлөв ажиглагдаж байна. Ялангуяа сумын түвшинд тод ажиглагдана. Энэ нөхцөл байдал ялангуяа бичил уурхайчдын хувьд ихээхэн хурцадмал байх бөгөөд энэ нь сум, аймгийн түвшинд өнөөдөр ч гэсэн хөдөлмөрийн ЭМАА-ны дүрэм, журмын хэрэгжилтийг хангах нөөц, чадавхи муутай Засгийн газрын байцаагч нарын чадавхи болон эрүүл мэндийн үйлчилгээнд дарамт болно. Бага өсөлтийн хувилбарын үед уурхайн тоо бага байх тул хөдөлмөрийн болон иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг хангах чадавхи нь нэмэгдэх ч хариуцсан хэлтэс, хариуцсан албан хаагчдын ажиллах чадварт бодит өөрчлөлт авчрах эсвэл улс орны хэмжээнд эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг хэвшүүлэх хэмжээнд авчрах далайцтай арга хэмжээ болж чадахгүй.

Дундаж өсөлтийн хувилбарын хувьд одоогийн байдлаар салбарт үүсээд байгаа нөлөөлөл хэвээр үргэлжлэхээр байна. Хөдөлмөрийн ЭМАА-ны үүднээс аваад үзвэл ялангуяа улс оронд хэвшээгүй, улсын байцаагч нарын ажлын чадвар муу байдлаас шалтгаалан дүрэм, журмын хэрэгжилт сул, алаг цоог мөрдөлттэй байна. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн дүрэм, журмыг нутагшуулах, хэрэгжүүлэх асуудал сул байгаа нь дундаж өсөлтийн үеийн уурхайн эрчимтэй үйл ажиллагаа бүхий сум, аймаг дахь олон улсын компаниудыг бодвол Монголын үндэсний компаниуд болон тэдгээрийн ажилчид (нас баралт, ослын тоо эрс нэмэгдсээр байна), түүнчлэн хувиараа ашигт малтмал олборлогчдод харьцангуй байдлаар нөлөөлнө. Олон нийтийн эрүүл мэндийн хувьд өмнөд говийн бүс (4.4.2 буюу Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц хэсгийг үзнэ үү), бичил уурхайчид ихтэй сум, аймгууд зэрэг уурхайн үйл ажиллагаа эрчимтэй явагдаж байгаа газруудад эрүүл мэндийн үйлчилгээг түлхүү үзүүлсэнээр нийт иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж алаг цоог байна. Уурхайн үйл ажиллагаа идэвхтэй явагдахын хэрээр тэдгээр газар нутгуудад уурхайн тоосжилт, усны бохирдол зэргээс улбаатай эрүүл мэндийн асуудал, бэлгийн замаар дамжих халдвар гэх мэт иргэдийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой халдварт өвчнүүд ихээр гарна. Замын осол, архидалттай холбоотой гэмт хэрэг, орон байрны хулгай, гэмт хэргийн гаралт мөн энэ бүс нутагт нэмэгдэнэ. Хамгийн ноцтой аюул нь уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор ялангуяа Өмнөговийн Хятадын хилийг чиглэсэн төмөр зам болон авто зам ихээр баригдах үед дэд бүтцээр хязгаарласан тодорхой орон зайд хашигдан нүүдэллэж чадахгүйд хүрэх мал сүрэг болон зэрлэг амьтад ба эдгээр амьтад машинд дайруулах зэргээр замын осол ихсэж болзошгүй байна (4.4.2 буюу Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц хэсгийг харна уу).

Өндөр өсөлттэй хувилбарын үед хөдөлмөрийн, олон нийтийн болон малын ЭМАА-д үзүүлэх нөлөөлөл богино хугацаанд огцом ихэснэ. Хөдөлмөрийн ЭМАА-ны үүднээс авч үзэх юм бол өндөр өсөлтийн үеийн хэрэгцээ шаардлагыг байцаагч нар хангаж чадахгүйд хүрсэнээр дүрэм, журмын мөрдөлт сул байна. Уурхайн компаниуд хөдөлмөрийн ЭМАА-ны менежментдээ анхаарал



бага хандуулснаар нас баралт, ослын тоо өндөр хэвээр байх болно. Бага, дундаж өсөлтийн үед тодорхой хэмжээний уул уурхайн ажил явагдах ч үүнээс шалтгаалсан иргэдийн шилжилт хөдөлгөөнөөс үүдэн одоо байгаа олон нийтийн эрүүл мэндийн үйлчилгээний газруудын ачаалал ихэссэнээр олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа тэр хэрээр доройтно. Эдгээр нөлөөллүүд нь газар зүйн шинж чанартай бөгөөд уул уурхай ихтэй газруудад илүү хамааралтай байна. Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдсэн мал, амьтны осол, дэд бүтцийн байгууламжаар хуваагдсанаас нүүдэл, бэлчээрийн сэлгээ багасна. Говийн бүстэй харьцуулахад малын тоо толгой өндөр байдаг Монгол орны хойд хэсэгт нөлөөлөл өндөр байхаар байна. Өндөр өсөлтийн үед дээр дурдсан нөлөөллүүд сумын түвшинд, ялангуяа уурхай эрчимтэй явагдаж байгаа сумдад хурцаар илэрнэ. Өндөр өсөлтийн үед орлого нэмэгдсэнээр дээр дурдсан нөлөөллүүд дунд хугацаанд огцом нэмэгдэнэ. 2025 он хүртэл, урт хугацаанд орлого нэмэгдэхийн хэрээр өссөн улсын төсөв нь Засгийн газрын түвшинд ЭМАА-ны хууль журмыг сахиулах сум, аймгийн түвшинд хэрэгжүүлэх шаардлагатай ЭМАА-ны арга хэмжээний эрэлтийг хангах боломжийг олгоно.

Нөлөөллийн хураангуй

<p>Бага өсөлттэй хувилбар</p>	<ul style="list-style-type: none"> ЗГ-аас эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг нийгмийн үйлчилгээг сайжруулахад шаардлагатай хөрөнгө, орлого дутагдалтай байх ба хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, журмыг мөрдүүлэх төрийн албан хаагчдын ажлын чадавхи сул байна (одоо ч сул байгаа) эдгээр нь богино хугацаанд улам муудна. Ажлын байрны ЭМАА-ны бүхий л хүчин зүйлд уурхайгаас үзүүлэх нөлөө цөөхөн байна. Олон нийтийн ЭМАА-ны талаарх үзэл, хандлага аажмаар өөрчлөгдөнө.
<p>Дундаж өсөлттэй хувилбар</p>	<ul style="list-style-type: none"> Ажлын байран дахь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, журмыг мөрдүүлэх арга хэмжээ муу хэвээр байх ба хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн байцаагчдын нөөц, чадавхи доогуур байх тул хэрэгжилт жигд бус байна. Уул уурхай, дэд бүтцийн хөгжлөөс үүдсэн эрүүл мэндийн нөлөөлөл нь уурхайн үйл ажиллагаа ихээр явагдаж буй орон нутгуудад өндөр байна. Олон нийтийн ЭМАА-ны талаарх үзэл, хандлага аажмаар өөрчлөгдөнө.
<p>Өндөр өсөлттэй хувилбар</p>	<ul style="list-style-type: none"> Богино хугацаанд (5-10 жил) дараах болон өөр бусад сөрөг нөлөөллүүд улам тодоор илэрнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> Хууль, дүрэм, журмын хэрэгжилт, мөрдөлт сул байх; Ослын гаралт, нас баралт өндөр байх; Уурхайн эрчимтэй үйл ажиллагаа явуулж байгаа орон нутагт эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагууд ачааллаа даахгүй байх. Урт хугацаанд хөдөлмөрийн ЭМАА-ны салбарын нөөц, чадавхи нэмэгдэнэ. Олон нийтийн ЭМАА-ны эрсдлийн талаарх үзэл, хандлага нь сэргийлэх арга хэмжээг хэвшүүлэхээсээ түрүүлж өөрчлөгдөнө.

4.3.4.3 [Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа: Арга хэмжээний зөвлөмжүүд](#)

Хүснэгт 4.21 Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа: Арга хэмжээний зөвлөмжүүд

	<p>Арга хэмжээний зөвлөмж</p> <ul style="list-style-type: none"> Халдварт бус, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх. Осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нөхөн олговор, нөхөн сэргээх эмчилгээний тогтолцоог боловсруулан хэрэгжүүлэх. Олон улсын тэргүүний туршлага, арга ажиллагааг одоогийн мөрдөж буй хуулиудад нэгтгэх.
<p>Сум</p>	<ul style="list-style-type: none"> Халдварт бус, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаарх олон нийтийн ойлголт мэдлэг, арга хэмжээг сайжруулах БОНБНУ-ий хүрээнд нөлөөлөлд өртөх олон нийтийг тодорхойлдог байх. Мөн түүнчлэн, олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг хамгаалах арга хэмжээг энэхүү үнэлгээний хүрээнд тодорхойлох.



Арга хэмжээний зөвлөмж	<ul style="list-style-type: none">• Уурхайн ойролцоох нөлөөлөлд өртсөн нутгийн иргэдэд зориулан стандарт хангасан, шаардлагатай тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон эмнэлгүүдийг уул уурхайн компаниудтай хамтран барих, ажиллуулах (4.4.4 буюу Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц хэсгийг харна уу).• Мал зам хөндлөн гарах гарцыг төлөвлөх үүднээс малчдыг тээврийн төлөвлөлтөнд оролцуулах (4.4.4 буюу Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц хэсгийг харна уу).• Бүх түвшинд олон нийтийн эрүүл мэндийн эрсдлийн талаар ойлголт мэдлэг өгөх хөтөлбөрийг сурталчлах, дэмжих.
Аймаг	Дээр дурдсантай адил:
Улс	Дээр дурдсанаас гадна: <ul style="list-style-type: none">• Осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нөхөн олговор, нөхөн сэргээх эмчилгээний тогтолцоог боловсруулан, хэрэгжүүлэх.• Нөлөөлөлд өртсөн олон нийтэд зориулсан эрүүл мэндийн санг үндэсний хэмжээнд байгуулж, уул уурхайгаас орсон орлогоос нөлөөлөлд өртсөн иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн үйлчилгээг хүргэх үйл ажиллагааг санхүүжүүлэх.• Олон улсын тэргүүний туршлага, арга ажиллагааг одоогийн мөрдөж буй хуулиудад нэгтгэх• Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг чадавхижуулах.

4.4 ЭДИЙН ЗАСГИЙН ЭН ТЭРГҮҮНИЙ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД БОЛОН ШИЙДВЭРЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖҮҮД

4.4.1 Засаглал ба орлогын менежмент

4.4.1.1 Нөлөөлөл ба хувилбаруудын танилцуулга

Дэлхийн банкны “Хөгжиж буй орны уул уурхай баялаг уу, бэрхшээл үү?” гарчигтай тайланд Батчэр, Смит нар (2013) Монголын уул уурхайн салбарын талаар авч үзжээ. Уг тайланд эдийн засгийн өндөр үзүүлэлтүүд нь баялаг ихтэй улс орнууд эдийн засгаа хэрхэн зохицуулж авч явахаас хамааралтай болохыг тогтоосон бөгөөд үүгээрээ улс орны эдийн засгийн өсөлт, түүний таатай байдалд (цаашлаад байгаль орчны тогтвортой байдал, нийгмийн эрх тэгш байдал) уул уурхайн салбарын оруулах хувь нэмрийн хэмжээг тодорхойлдог ашигт малтмалын орлого гэхээсээ илүүтэй засаглалын чанар чухал болохыг онцолсон байна. Халамжийн үйлчилгээний санхүүжилт, тэдгээрийн иргэдэд хүртээлтэй байдлыг нэмэгдүүлэх, эдийн засгийн үйл ажиллагааны суурь болсон дэд бүтцийн хөгжлийг түргэсгэх, үйлдвэрлэгч болон борлуулагч бизнесүүдийн өсөлтийг дэмжих зэргээр уул уурхайн салбарт шууд хамаарагдах орлого багатайчуудад орлогын эх үүсвэр бий болгож өгөх нь газрын баялгийн үр дүнтэй зохицуулалтын нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөллийн зарим нэг жишээ юм (Дэлхийн банк, Олон улсын санхүүгийн корпораци, 2002). Үүний зэрэгцээ буруу зохицуулвал ашигт малтмалын орлого нь хээл хахууль, хөнгөлөлт, чөлөөлөлт эрэлхийлэн улс төрчдийг ятган өөрт ашигтай шийдвэр гаргуулах хандлагыг нэмэгдүүлэх, улс орны ашигт малтмалын бус эдийн засгийн эх үүсвэр бүхий хэсгийн нуруун дээр цэцэглэсэн бүлэглэлүүд бий болох зэргээр ихэвчлэн ард иргэдийн амьжиргаанд амин чухал хүчин зүйлст сөрөг нөлөө үзүүлэх замаар нийгэм-эдийн засгийн нөхцлийг хүндрүүлж болзошгүй байдаг.



Засаглал ба орлогын менежментийн асуудал нь энэхүү БОНСУ-ий хүрээнд авч үзэх ёстой гол асуудлуудын нэг мөн бөгөөд үүнээс хүрээлэн буй орчин, нийгэм-эдийн засгийн өөр бусад олон асуудлуудын шийдэл хамааралтай байдаг. Чухамдаа Монголын Засгийн газрын засаглалын чадавхи нь нэгэн зэрэг улс орныхоо эдийн засгийн цар хэмжээ, нэг үгээр хэлвэл уул уурхайгаас олох орлогын түвшинг тодорхойлж байхад, уул уурхайгаас олох орлого нь тус Засгийн газрын байгаль орчинд ээлтэй, нийгмийн эрх тэгш байдлыг хангасан засаглалыг бий болгоход шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр нь болж байдаг юм. Тогтвортой, эрх тэгш хуваарилалт явагдахгүй л болохоос сайн засаглалгүй байсан ч гэсэн орлого орж ирсээр байх болно. Уул уурхайн салбарын бага эсвэл өндөр өсөлттэй хөгжлийн хувилбарын хүрээнд засаглал ба орлогын менежментэд үзүүлэх нөлөөлөл нь хэд хэдэн гол үр дагаварыг бий болгож болох юм гэдгийг санууштай. Эдгээр нөлөөллүүдийг засаглалын идэвхийг сааруулсан, авлига, хээл хахууль цэцэглэсэн зэрэг сөрөг үр дагаварууд, түүнчлэн төсвийн хэмжээг нэмэгдүүлэх, орлогын нээлттэй байдал, байгалийн баялгийн ил тод, тогтвортой, оролцоог хангасан зохицуулалтыг дэмждэг засаглалын тогтолцоо бий болгох гэсэн зэрэг хүчин чармайлтуудыг ЗГ-аас гаргаж байгааг харуулсан засаглал ба орлогын менежментийн өнөөгийн үнэлгээн дээр тулгуурлан тооцсон юм.

Түүнчлэн, дараах нөлөөллийн үнэлгээг хөгжлийн хувилбарууд бүрийн хувьд бий болох нөлөөллийн талаар талуудтай зөвлөлдөх үед гарсан санал мэдээлэлд тулгуурлан гүйцэтгэсэн ба талуудын санал бодлыг хураангуйлан Хүснэгт 4.22-д харуулав. Дүгнэж хэлэхэд одоогийн засаглалын орлогын зарцуулалтын чадавхи, уул уурхайн орлогын өсөлтийн байдал дээр тооцон өндөр өсөлттэй хувилбарыг авч үзвэл засаглалын үзүүлэлтүүд богиноос дунд хугацаанд зогсонги байдалтай сайжрахгүй төлөвтэй ч 2025 он хүртэлх урт хугацаанд засаглалын үзүүлэлтүүд өссөн үр дүн харагдахаар байна. Асуудлын гол нь сайжруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд цаг их авах ба хэр их цаг авах нь засаглал ба орлогын менежментийн хөтөлбөрүүдэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээтэй шууд хамааралтай юм. Дундаж болон бага өсөлттэй хувилбаруудыг аваад үзвэл уул уурхайн орлогын засаглалыг дорвитой сайжруулах зэрэг ЗГ-ын чадавхийг бэхжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр хангалтгүй байх дүр зураг харагдаж байгаа юм.

Хүснэгт 4.22 Оролцогч талуудын тодорхойлсон засаглал, орлогын менежменттэй холбоотой эн тэргүүний асуудлууд

Түвшин	Бага өсөлттэй хөгжлийн хувилбар	Дундаж өсөлттэй хөгжлийн хувилбар	Өндөр өсөлттэй хөгжлийн хувилбар
Эн тэргүүний асуудлууд:			
<ul style="list-style-type: none"> • Макро эдийн засгийн нөлөө • Орлогын менежмент 			
Сум	<ul style="list-style-type: none"> • Улсын төсвийн орлого буурснаар хөгжлийн төсөл, үйлчилгээнд зарцуулах төрийн зардал багасаж, уул уурхайн засаглалын чадавхи тааруу байна. 	<ul style="list-style-type: none"> • Сумын төсөв нь хязгаарлагдмал хүрээний хөгжлийн төслүүд, нийгмийн үйлчилгээг санхүүжүүлэх төдий хэмжээтэй байна. • Сумын иргэдэд ирэх уурхайн үйл ажиллагааны цаашдын нөлөөлөл хүртээмжгүй, тэгш бус байгаа шиг уурхай дагасан хөгжил ч харьцангуй байна. • Сумын түвшний төрийн төлөөллүүдийн уурхайн салбараа хянах, зохицуулах, захирах чадавхи нэмэгдүүлэх боломж нь хязгаарлагдана. 	<ul style="list-style-type: none"> • Сумын төсөвт орох орлого нэмэгдэж, улмаар сумын хөгжилд зарцуулж болох төсөвтэй болно. • Гэхдээ орлогын хуваарилалт нь тэнцвэртэй бус байх бөгөөд уул уурхайн хөгжлөөс зарим сумдууд илүү их ашиг тус хүртэнэ.
Аймаг	<ul style="list-style-type: none"> • Дээрхтэй адилхан. 	<ul style="list-style-type: none"> • Дээрхтэй адилхан. 	<ul style="list-style-type: none"> • Төсөв нэмэгдсэнээр бүх аймгуудын чадавхи сайжирна.
Улс	<ul style="list-style-type: none"> • Улсын төсвийн орлого буурснаар сум болон аймгийн төсөвт сөргөөр нөлөөлнө. • Уул уурхайн засаглалын чадавхийг бэхжүүлэх тал дээр ЗГ-ийн нөөц бололцоо санхүүгийн бэрхшээлээс шалтгаалан ихээр хязгаарлагдана. • ЗГ-ын зүгээс эдийн засгийг уул уурхайн салбараас хараат байх явдлыг бууруулж, өөр бусад чиглэлээр төрөлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, мал аж ахуй зэрэг салбаруудад дэмжлэг үзүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> • Орлогын хязгаарлагдмал түвшнээс хамааран улсын төсөв хумигдана. • ЗГ-т төсвийн хуваарилалтыг ач холбогдлоор нь хэрхэн эрэмблэх вэ гэдэг өрсөлдөөнт шаардлага тулгарна. • Уул уурхайн салбарын засаглалын чадавхи төрийн түвшинд хязгаарлагдмал болж ирнэ. 	<ul style="list-style-type: none"> • Улсын төсөвт орох орлого нэмэгдэж, зөвхөн уул уурхай төдийгүй өөр бусад салбарт эдийн засгийн өсөлт хөгжил гарна. • Эдийн засгийн эерэг ашиг тусад орлогын муу менежмент болон орлогын үр дүн муутай, шударга бус хуваарилалт зэрэг нь сөрөг нөлөөлөл үзүүлнэ. • Уул уурхайн салбарын өндөр хөгжлөөс үүдэлтэй инфляцийн нөлөөг өөр бусад салбарууд мэдэрч, хөдөө аж ахуй, мал аж ахуй, ноолуурын үйлдвэрлэл болон бусад үйлдвэрлэл зэрэг олон салбаруудын өрсөлдөх чадвар муудаж, хувь хүмүүсийн худалдан авалт муудах зэргээр улс орон Голланд өвчний нөлөөнд автана.



4.4.1.2 Улс, аймаг, сумын түвшин дахь нөлөөллийн эрчим

Монгол улс нь хуучин Зөвлөлт холбоот улсад багтаж байсан орнуудыг бодвол эрдэс баялгийн салбарын тэсрэлтийг харьцангуй хүчирхэг төрийн байгууламжтайгаар хүлээж авсан юм. Гэсэн хэдий ч нийтлэг хэмжүүрээр аваад үзвэл Австрали, Норвеги гэх мэт баялаг ихтэй хөгжингүй орнуудтай харьцуулахад засаглал нь хамаагүй сул байсаар ирсэн. Дэлхийн банкны засаглалын итгэлцүүрийн тайланд 2002³¹ оноос хойш Монгол улсын итгэлцүүр тасралтгүй буурсаар ирсэн гэж гарсан нь авлигын итгэлцүүрийн үзүүлэлт доогуур байсантай шууд холбоотой (Дэлхий дахины засаглалын индикаторууд, 2012). Үүний хариуд Монгол улс авлигатай тэмцэх хараат бус байгууллагыг 2007 онд байгуулсан бөгөөд энэ байгууллага нь Улсын Их Хуралд жил бүр тайлагнадаг, мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу Ерөнхий прокурорын газрын хяналтан дор байдаг. Авлигатай тэмцэх газар нь мөрдөн байцаах, тагнах, хөрөнгө битүүмжлэх болон олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Сүүлийн жилүүдэд хуулийн хэрэгжилт, улс төрийн тогтвортой байдал, Засгийн газрын үйл ажиллагааны үнэлгээ буурсаар байгаа нь Монгол улсын баялгийн хараалд өртөхгүй байх дархлаа нь муудаж байж болзошгүй гэдгийг харуулж байна. 2025 он хүртэл өсөлтийн хувилбар бүрийн хувьд баялгийн засаглалд үзүүлэх нөлөөлөл нь Засгийн газрын өсөлт, хөгжлийг хангах, дэмжих татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн аргуудыг ашиглах улс төрийн хүсэл зориг, улс орны улс төрийн болон эдийн засгийн институцийн байдал, үйл ажиллагаа зэргээс ихээхэн хамааралтай. Энэ тал дээр ЗГ-аас төсвийн хэмжээг нэмэгдүүлэх, орлогын нээлттэй байдал, байгалийн баялгийн ил тод, тогтвортой, оролцоог хангасан зохицуулалтыг дэмждэг засаглалын тогтолцоо бий болгох гэсэн эерэг хүчин чармайлтуудыг гаргасан зэрэг хэд хэдэн сайжруулах арга хэмжээнүүдийг аваад байгаа юм.

ЗГ-аас урьд өмнө нь олон нийтэд хаалттай байсан төсвийн зарцуулалтын баримт бичгүүдийг нийтэлж, цахим төсөв интернет хуудас нээн түүгээр дамжуулан орлого, зарлагын мэдээллийг дэлгэрэнгүй танилцуулдаг болсон бөгөөд энэ нь 2010 оноос хойш ОУИТБС-ын шаардлагыг хангасаар ирсэн. Түүнчлэн Монголын улсын Аудитын ерөнхий газар хөндлөнгийн шалгалтын баримтуудаа өөрийн цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд нээлттэй харуулдаг болоод байна. Төсвийн болон санхүүгийн зохицуулалтын хуулийн орчныг сайжруулахын тулд Төсвийн тухай 2002 онд батлагдсан хууль, өөр олон чухал асуудлуудыг шийдсэний дотор, нийгмийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд, улсын төсөвт суулгах төслүүдийн улсаас тогтоосон эрэмбийг мөрдөх, техник эдийн засгийн үндэслэл шаардах, төсөв тогтоох явц дахь ард иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн Нийгмийн салбарын удирдлага санхүүгийн тухай хуульд тус тус нийцүүлэн Нэгдсэн төсвийн тухай хуулийг (НТХ) 2011 онд баталсан юм. Засгийн газраас төсөв, санхүүгийн ил тод байдлыг дэмжсэн, ил тод байдлын үзүүлэлт, шалгууруудыг заасан 17, 143 дугаар тогтоол, захирамжийг мөн гаргасан (Ариунаа, 2012). Энэ шинэчлэлийн хүрээнд 2009 оны бодит хугацааны зарцуулалттай харьцуулахад Засгийн газрын зардал 2011 онд хоёр дахин нэмэгдэнэ гэж үзсэн (Чени, 2012).

³¹ Дэлхийн банкны засаглалын индекс нь засаглалын 6 үзүүлэлтээр (ард иргэдийн дуу хоолой ба хариуцлага хүлээх чадвар, улс төрийн тогтвортой байдал ба хүчирхийллийн түвшин, Засгийн газрын үр дүнтэй үйл ажиллагаа, хууль эрх зүйн, зохицуулалтын тогтолцооны чанар, хуулийн хэрэгжилт, авлигад тавих хяналт) улсуудыг хувиар гарган байр эзлүүлдэг. Хувиар илэрхийлсэн байр нь тухайн орон дэлхийн орнуудын нийт хэдэн хувиас үзүүлэлтээрээ илүү байгааг харуулдаг, өөрөөр хэлбэл байр нь өндөр байх тусам засаглалын оноо нь сайн байна гэсэн үг юм.



Нөхцөл байдлын үнэлгээ буюу 2-р бүлэгт тэмдэглэснээр одоогоор ЗГ уурхайн орлогыг улсдаа төвлөрүүлээд улсын төсвөөр дамжуулан аймгуудад хуваарилж байна. Аймаг тус бүрийн оруулж байгаа ашигт малтмалын орлогын зөрүү, улсын төсвөөр дамжуулан аймаг бүрт буцаан хуваарилж байгаа төсвийн хэмжээ анхаарал татаж байгааг тэмдэглүүштэй. Уул уурхайн орлогыг хамгийн их хэмжээгээр оруулж байгаа аймгууд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг хамгийн бага авч байна. Эдгээр аймгуудын бүтээн байгуулалтын өндөр хэрэгцээг хангах дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ ихээр шаардагдсаар байгааг тооцож үзвэл хамгийн их өгсөн буцааж хамгийн багыг авч байгаа нь логикгүй мэт санагдана. Энэ үзэгдлийг тодорхой хэмжээгээр уурхай дагасан хөгжлөөс хүртэх боломж багатай гэдгээрээ уурхайгүй сумд Засгийн газраас илүү санхүүгийн дэмжлэг авдаг хэмээн тайлбарлаж болох юм. Гэсэн хэдий ч энэ нь хангалттай тайлбар биш бөгөөд уурхайн ашгийг Монгол улс даяар тэгш хуваарилахгүй байгаа, ЗГ-аас хувийн хэвшил орон нутагт хөрөнгө оруулж хөгжүүлнэ гэсэн хүлээлттэй байгаа, мөн уул уурхай эрчимтэй явагдаж байгаа аймаг, сумдын ард иргэд хүсэн хүлээж байсан уурхайгаас олох ашгийн хэмжээгээр өсөн нэмэгдэх ёстой улсын төсвийн ахиу хуваарилалтаа ч хүртэж чадахгүйгээр барахгүй уурхайгаас үүдсэн олон сөрөг үр дагаварыг эдэлж байна гэсэн ард иргэдийн эсэргүүцлийн дуу хоолойг өдөөж байна. Яваандаа төсвийн энэхүү хуваарилалтын нөлөөгөөр уурхай эрчимтэй явагдаж байгаа газруудын тогтвортой, эрх тэгш ашгийн хуваарилалт бий болгоход шаардлагатай засаглалын арга хэмжээг авч хэрэгжүүлэх чадвар нь доройтож болох юм.

Өндөр өсөлттэй хувилбар: Өндөр өсөлттэй хувилбарыг бага өсөлттэй хувилбартай харьцуулахад гарах нөлөөллийн гол ялгаа нь эерэг болоод сөрөг нөлөөллийн аль алиныг нэмэгдүүлж байгаа уурхайгаас олох орлогын хүртээмжийн түвшин юм. Өндөр өсөлттэй хувилбар нь сөрөг нөлөөллийн нилээдийг богиноос дунд хугацааны туршид ихэсгэх хандлагатай байна. Гэвч өнөөгийн засаглалын чадавхийн хүрээнд олох орлогын зарцуулалт, тоо нь өсөн нэмэгдэх уурхайгаас олох орлогын хэмжээнээс харахад богино, дунд хугацааны зогсонги байдлын дараагаар засаглалын үзүүлэлтүүд 2025 он хүртэлх урт хугацааны туршид өсөх магадлалтай байна. Дараах сөрөг нөлөөллүүд байна. Үүнд:

- **Авлига газар авах, хөрөнгийн шамшигдуулалт, лоббидолт.** Жишээ нь, 2013 оны Дэлхийн банк/ОУСК-ийн аж ахуйн нэгжийн судалгааны тайлангаас харахад судалгаанд оролцсон компаниудын 20% гаруй нь Засгийн газрын төсөл олж авахын тулд бэлэг өгөхөөс буцахгүй гэсэн бол 43.3% нь барилга барих зөвшөөрөл найдвартай олж авахын тулд бэлэг өгнө гэсэн байна (Дэлхийн банк/Олон улсын санхүүгийн корпораци, 2013). Монголын Улсын уул уурхайн үйл ажиллагаатай (сум, аймаг, улсын түвшинд) холбоотой томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төслүүдийн тендерийн сонгон шалгаруулалт, гэрээт байгууллага сонгох үйл явцуудын аль аль нь авлигажсан шинжтэй байх бөгөөд ингэсэнээрээ үйлдвэрлэгчид, шинээр бизнес эрхлэгчид төрж гарах үйл явцыг хааж, улмаар салбарын хөгжлийн эерэг хандлагыг боомилох юм. Өсөн нэмэгдэх орлогын улмаас бий болсон хөрөнгийн шамшигдуулалт, авлигын орчин цэцэглэх байдал ажиглагдаж байгаагаас өндөр өсөлтийн үед ч эдгээр нь үндсэн бэрхшээл хэвээр байхаар байна. ЗГ авлигатай үр дүнтэй тэмцэх чадвар дутагдалтай байгаагаас богино хугацааны туршид ч санаа зовоох асуудлын нэг байсаар байна.



- **Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, бусад татвар, төлбөрийг хураах, зохицуулахтай холбоотой хэт нарийн төвөгтэй дүрэм, журмуудыг мөрдүүлэх үүрэгтэй албан хаагчдын ажлын үр чадвар муу, захиргааны болон хөндлөнгийн хяналт хийх чадавхийн сул байдал.** Өнөөгийн байдлаар компаниудын 20% гаруй нь Монголын татварын байцаагч нар гар хардаг гэсэн байна (Дэлхийн банк/Олон улсын санхүүгийн корпорац, 2013). Өндөр өсөлтийн хувилбарыг авч үзвэл дүрэм, журмын биелэлтийг хангуулахад шаардлагатай захиргааны болон хөндлөнгийн хяналтын чадавхи дутмаг байдал нь богино хугацааны туршид ихээр илэрч, улмаар аймаг, сумын түвшинд байгаль орчны болон нийгмийн сайн сайханд чиглэсэн үйл ажиллагаа явуулахад хувь нэмэр болох ёстой уул, уурхайн хөрөнгө оруулалтаар босох хөгжлийн бүтээн байгуулалтад сөргөөр нөлөөлнө.
- **Ил тод, хариуцлагатай байдлыг хангахад шаардлагатай зохицуулалтын бодлого сул, засаглалын бүтэц дорой.** Жишээ нь уул, уурхайтай холбоотой гэрээ, тендерийн үйл ажиллагаа нь ил тод бус байгааг эсэргүүцсэн тэмцэл үе үе гардгийг баримт болгоод үзэхэд Монголд гэрээ байгуулах хэлэлцээрийн явц, гэрээний нөхцөл зэрэг нь ерөнхийдөө далдуур, хэтэрхий төвөгтэй байдаг. Мөн түүнчлэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой зөрчилд оногдуулсан шийтгэлийг эдлүүлэх, газар ашиглах зөвшөөрөл олгох гэх мэтчилэн ялангуяа орон нутгийн засаг захиргааны авч хэрэгжүүлэх арга хэмжээний тал дээр уул уурхайн хууль, дүрэм, журмыг мөрдүүлэх чадавхи сул байна (Чени, 2012). Нэмж хэлэхэд улс, аймаг, сумын түвшинд авлига, хээл хахуулийг гааруулах эх үүсвэрүүд бий болох тул өндөр өсөлтийн үед төрөл бүрийн яамдын, ялангуяа уул уурхайн салбарын үйл ажиллагааг хянах үүрэг бүхий цалин багатай албан хаагчид өөр нэг асуудал болж гарч ирнэ (БиллитерПартнерс Лтд, 2012).
- **Уурхайн баялгийн зохисгүй хуваарилалт ба аймгуудын улсын төсвөөс авч буй санхүүгийн дэмжлэг.** 2-р бүлэгт орсон нөхцөл байдлын үнэлгээний Зураг 2.7-д үзүүлсэнээр уул уурхайн орлогын гол хэсгийг бүрдүүлж буй аймгуудыг цөөн уурхайтай, уурхайн нөлөөлөлд бага өртдөг аймгуудтай харьцуулахад төсвөөс олгож буй дэмжлэг тэдгээр аймгуудынхаас бага байдаг тэгш бус хуваарилалттай байна.
- **Мөнгөний ханшийн уналт ба бусад салбарын өрсөлдөх чадвар.** Уул уурхайн салбараас хамааралтай байх болон уурхайн түүхий эд Монголын экспортод давамгайлж байгаа хоёр нь дунд өсөлттэй хувилбарын үед нийлвэл өндөр өсөлттэй хувилбар шиг томорч харагдана. Монголын ажиллах хүчний ойролцоогоор 4% нь уул уурхайн салбарт ажиллаж байхад хөдөө аж ахуйн салбарт ажиллах хүчний ойролцоогоор 40% ажиллаж байгаа юм. Өндөр өсөлт мөнгөний ханшийн уналт, хүн амын ихэнх хэсэг нь ажилладаг уурхайн бус салбар болох хөдөө аж ахуй болон үйлдвэрлэлийн салбарыг өрсөлдөх чадваргүй сул дорой харагдуулах байдлаар тэгш бус байдлыг гүнзгийрүүлж болзошгүй. Гэвч Монголын Засгийн газар урт хугацаандаа үр дүнтэй удирдах чадвартай болохын хэрээр засаглалын чадавхийн нөлөөлөл шингэх боломжтой (4.4.3 буюу Хөдөлмөр эрхлэлт ба үр чадвар хэсгийг үзнэ үү).

Өндөр өсөлтийн үед орон нутгийн болоод улсын түвшинд засаглалын чадавхи нэмэгдсэний үр дүнд өсөн нэмэгдэх орлогын үр шимийг хүртэх болж, ялангуяа урт хугацааны туршид дээр

өгүүлсэн сөрөг нөлөөллүүдээс эсрэгээр дээр дурдсанаас гадна хэд хэдэн эерэг нөлөөлөл ажиглагдана. Үүнд:

- **Уурхайн засаглалын чанар урт хугацаанд сайжрах (2025 он гэхэд).** Богино хугацааны зогсонги байдалд байсны улмаас гацаанаас гарах арга хэмжээнүүд бага багаар явагдсаар улс, аймаг, сумын засаглалын түвшинд хүртэх уурхайн орлогыг бий болгохын хамтаар уул, уурхайн эрчимтэй өсөлтийн дараах эерэг нөлөөллүүд ажиглагдана. Аймаг/сумын засаг захиргаанаас ард иргэддээ илүү дээр нийгмийн үйлчилгээ үзүүлэх, уул уурхайн салбарт үүсэх нийгэм, байгаль орчны нөлөөллийг хянах, зохицуулах албан хаагчдынхаа чадамжийг дээшлүүлж засаглалын болон хөндлөнгийн хяналтын өндөр чадавхитай болохын тулд орон нутгийн хөгжлийн далайцтай хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой болно. Үүнд, одоо хэрэгжиж буй санаачилгууд, сайн засаглалыг дэмжин хөндлөнгийн ажиглагчдыг ажиллуулах иргэний нийгмийн үйл ажиллагаа багтана. Зөвхөн засаглалын бүтэц, чадавхид хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд л энэ бүхэн бодит ажил хэрэг болох ба ингэж чадахгүй бол дээр дурдсан бүх эерэг нөлөөллүүд биелэлээ олохгүй гэдгийг онцлон анхаарах ёстой.

Бага өсөлттэй хувилбар: Бага өсөлтийн үед өндөр өсөлттэй үед ажиглагдах бүх сөрөг нөлөөллүүд мөн илэрсээр байх ба орлогын хувь бага байх тул ЗГ-ын засаглал болон чадавхийг хөгжүүлэхэд оруулах хөрөнгө оруулалт хязгаарлагдмал байна. Хуваарилах төсвийн хэмжээ багасах нь ялангуяа уул уурхайн салбараас үүдсэн нийгмийн болоод байгаль орчны асуудлуудыг зохистой шийдвэрлэхтэй холбоотой аймаг/сумын орон нутгийн захиргааны чадавхийг сулруулна. Аймаг/сумын засаг захиргааны нийгмийн үйлчилгээ үзүүлэх, хөгжлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх нөөц бололцоо бага байх ба иргэний нийгмийн байгууллагууд цаашид улам хөгжиж бодлогын хэлэлцүүлэгт хувь нэмрээ үргэлжлүүлэн оруулна гэсэн баталгаа байхгүй харин үйлчилгээ үзүүлэхэд анхаарлаа илүү хандуулж болзошгүй юм.

Нөлөөллийн хураангуй

Бага өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none"> • ЗГ-ийн сайн засаглалыг хөгжүүлэх, чадавхийг бэхжүүлэх санаачилгад хөрөнгө оруулалт хийх нөөц бололцоо нь бүх түвшинд хумигдана. • Засаглалыг бэхжүүлэхэд иргэний нийгмийн байгууллагын эзлэх байр суурь хязгаарлагдана.
Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none"> • ЗГ-ын орлогын хуваарилалт, удирдлага, бүтээн байгуулалт, чадавхийг хөгжүүлэх нөөц багассанаар байршлын хувьд бүтээн байгуулалт бүс нутагт жигд бус тархсан байна. • Засаглал, хариуцлагыг сайжруулахад хувь нэмэр оруулах талаарх иргэний нийгмийн хөгжил удаан байна.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none"> • Уул уурхайн салбар хурдацтай хөгжих эхний жилүүдэд засаглалын чадавхи сул байх ч урт хугацаанд буюу 2025 оноос хойш сайжирна. • Уул уурхайн салбар хурдацтай хөгжих эхний жилүүдэд авлига, хээл хахууль, санхүү, мөнгөний шамшигдуулалт, захиргааны болон хөндлөнгийн хяналтын чадавхи сул байх, сум, аймгийн түвшинд хууль, дүрэм, журмын биелэлт хангалтгүй байх, уурхайн орлогын тэгш бус хуваарилалт зэрэг үзэгдлүүд гарна. • Иргэний нийгмийн байгууллагууд засаглалд эзлэх байр суурийг нь бэхжүүлэх, орлогын зохицуулалтад үүрэг хүлээх байдлыг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн гадны дэмжлэгийн ачаар үүрэг роль нь нэмэгдэнэ.



4.4.1.3 Засаглал ба орлогын менежмент : Арга хэмжээний зөвлөмжүүд

Хүснэгт 4.23 Засаглал ба орлогын менежмент : Арга хэмжээний зөвлөмжүүд


Арга хэмжээний зөвлөмж	
<ul style="list-style-type: none">• Эрдэс баялгаас бусад салбарыг хөгжүүлэх• Улс, аймаг, сумдын аль алины түвшинд баялгийн хуваарилалтын илүү үр нөлөөтэй, ил тод арга арга хэмжээг хэрэгжүүлэх.	
Сум	<ul style="list-style-type: none">• Хөгжлийн бодлого, стратеги, төлөвлөгөөг боловсруулахдаа орон нутгийн удирдлага, иргэдэд мэдээлэн, саналыг авдаг байх, орон нутгийн түвшинд гаргасан бодлогын баримт бичгүүдийг үндэсний бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах механизмыг боловсруулан хэрэгжүүлэх.• Аймгийн ОУИТБС-ын төлөөлөгчийн газрын чадавхийг бэхжүүлэх, ингэснээр иргэдийн дунд ОУИТБС-ын талаар ойлголт, мэдээлэл солилцоог нэмэгдүүлэн, ОУИТБС-ын мэдээлэл авах боломжтой болгох.• Хариуцлагатай уул уурхайн санаачилга, ОУИТБС зэрэг байгууллагуудтай уул уурхайн компаниудын татвар, төлбөрийн мэдээллийг нутгийн иргэдэд нээлттэй мэдээлэх талаар нягт хамтран ажиллах.• Бизнесийн ур чадварыг дээшлүүлэх зөвлөгөө өгөх, сургалтын үйлчилгээ үзүүлэх, санхүүгийн удирдлага, холбоодыг хөгжүүлэх, бизнесийн эрх зүйн орчин, ЖДҮ-ийг хөгжүүлэх зэрэгт чиглэгдсэн арга хэмжээ хэрэгжүүлэх замаар бизнес эрхлэлт, эдийн засгийг төрөлжүүлэх явдлыг хөхиүлэн дэмжих.• Бага өсөлтийн үед, аймаг сумдын захиргааны удирдлагын нөөц чадамжаа хөгжүүлэх боломж боллоцоо болон төсвийн санхүүжилт багасах тул, хандивлагч байгууллагуудын тусламж уул уурхайн засаглалын чадавхийг (захиргаа, удирдлага, аудит, хяналт шинжилгээ болон менежмент) дээшлүүлэх хөтөлбөрүүдээр хангахад хэрэгцээтэй болж ирнэ.
Аймаг	Дээр дурдсантай адил.
Улс	<ul style="list-style-type: none">• Улс, аймаг, сумдын аль алины түвшинд баялгийн хуваарилалтын илүү үр нөлөөтэй, ил тод арга арга хэмжээг хэрэгжүүлэх. Үндэсний, аймаг болон сумын түвшинд ил тод байдал дээшилснээр орлогын хуваарилалтын талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болно.• Уул уурхайгаас орж байгаа орлогын дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд онлайн мэдээлэн хүргэх эхлэлийн суурь мэдээллийг бий оруулах.• Улс, аймаг, суманд уул уурхайгаас орж байгаа орлогоос бусад салбаруудад хуваарилж байгаа тухай мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх (4.3.3 буюу Хүний эрх ба олон нийтийн оролцоо хэсгийг харна уу).• Аймгийн ОУИТБС байгууллагын төлөөлөгчийн газрын чадавхийг бэхжүүлэх, ингэснээр иргэдийн дунд ОУИТБС-ын талаар ойлголт, мэдээлэл солилцоог нэмэгдүүлэн, мэдээлэл авах боломжтой болгох.• ОУИТБС-аас гадна сайн засаглалыг дэмжин хөндлөнгийн ажиглагчид (watchdog)-ыг ажиллуулах иргэний нийгмийн үйл ажиллагааг дэмжих.• Уул уурхай ихээр хөгжин уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд илүү өртөж буй сум, аймгуудад нэмэлт төсөв хуваарилах.• Хариуцлагатай уул уурхайн санаачилга, ОУИТБС зэрэг байгууллагуудтай уул уурхайн компаниудын татвар, төлбөрийн мэдээллийг нутгийн иргэдэд нээлттэй мэдээлэх талаар нягт хамтран ажиллах.• Эдийн засаг, бизнесийг хөгжүүлэх цогц хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр эрдэс баялгаас бусад салбарыг аймаг, сумуудад дэмжин хөгжүүлэх.



4.4.2 Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц

4.4.2.1 Нөлөөлөл ба хувилбаруудын танилцуулга

Монголын хөдөөгийн хүн ам 2000 онд 43% байсан бол 2010 онд 32% хүртэл буурч, Улаанбаатараас гадна 5 аймагт (Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр, Төв, Орхон) л хүн ам өсчээ (4.7-р зургийг үзнэ үү). Эдгээр нь бүгд олон тооны уурхай ажиллаж, эсвэл нээгдэхээр төлөвлөж байгаа нутаг юм (UNFPA; MED; & MDSP, 2012). Нэг талаас ажилгүйдлээс шалтгаалан, эсвэл илүү орлого олохыг эрэлхийлэн хүн ам хөдөөгөөс шилжин нүүж, нөгөө талаас эдгээр ирж буй нэмэлт хүн ам нь хот тосгодод, ялангуяа уурхайн ойролцоох хотуудад инженерийн шугам сүлжээ, нийгмийн үйлчилгээнд нэмэлт дарамт үзүүлж байна. Зураг 4.7-аас үзвэл дэд бүтцэд бүрэн хамрагдсан хүн амын хувь Өмнөговь, Ховд, Сүхбаатар аймагт ижил байгаа хэдий ч 2005-2010 оны хооронд Өмнөговь руу шилжин ирсэн хүн амын тоо нөгөө хоёр аймгаасаа 3 дахин их байна. Ийм дүгнэлтийг мөн Дорноговь, Дорнод аймагт хийж болно. Гол нь, энэ бүс нутгийн орон сууц, үйлчилгээний нэмэлт дарамтыг хангах төсөв сум, аймагт хүрэлцээгүй тул шилжин суурьшиж буй иргэд бүгд дэд бүтэц, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа гэдгийг харуулж байгаа юм (Аймаг тус бүрийн уул уурхайгаас олж байгаа орлого ба улсын төсвөөс авч буй санхүүгийн дэмжлэгийг харуулсан 2.7-р зургийг үзнэ үү).




Зураг 4.7 Дэд бүтцэд бүрэн хамрагдсан хүн ам

Шилжилт хөдөлгөөний ихээхэн хэсэг нь Өмнөговь, Дорноговь аймагт оногдож байгаа нь говийн бүсэд 13 стратегийн орд газрын 4 нь буюу Оюу Толгой, Таван Толгой, Ухаа Худаг оршдогтой холбоотой юм. 2013 онд Өмнөговь аймагт 58,555 хүн бүртгэгдсэн байтал аймгийн захиргааны

байгууллагууд шилжин суурьшсан иргэдийг оруулан ойролцоогоор 100,000 хүнд нийгмийн үйлчилгээ үзүүлж байна (Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар, 2014). Монголд аймгийн жилийн төсвийг албан ёсны бүртгэлтэй хүн амын тоогоор хуваарилдаг. Өмнөговь аймгийн тохиолдолд 60,000 хүн амд зориулсан хүчин чадлаар ойролцоогоор 100,000 хүнд нийгмийн үйлчилгээ үзүүлж байна.

Бус нутгийн төлөвлөлтийн өөр нэг асуудал бол уул уурхайг дэмжиж Монгол орон даяар баригдах тээврийн дэд бүтэц юм. Улс оронд одоогоор хөдөөгийн болон уул уурхайн хөгжлийн хэрэгцээг тусган тооцсон бүсийн нэгдсэн төлөвлөлтийн систем сайн хөгжөөгүй байна (Газар ашиглалтын талаар 4.2.2-р хэсгээс үзнэ үү). Доорх зурагт ирээдүйн ашигт малтмалын тээвэрлэлт болон нийтийн тээврийг дэмжин баригдах тээврийн зам, төмөр замыг харуулав. Эдгээр шугаман дэд бүтцийн зарим нь хэд хэдэн хамгаалалттай газар, бэлчээрийг дайрч гарах тул зэрлэг амьтан, малын нүүдэл, хөдөлгөөнд нөлөөлөх төлөвтэй байна. Зам болон төмөр зам, дэд бүтцийн бусад байгууламж барих ажлаас шалтгаалан археологи, палеонтологийн нөөц цаашид ч гэмтэх, устах эрсдэлтэй. Шинээр барих тээврийн зам, төмөр зам, дэд бүтцийн бусад бүтээн байгуулалт, тэдгээрийн хамарч буй асар том талбай, мөн нөлөөллийн бүс нутагт археологи, палеонтологийн суурь судалгаа явуулах олон тооны мэргэжилтнүүдийн хүрэлцээ Монголд муу, эдгээр нөөцөд малтлага хийх шаардлага зэрэг бэрхшээл, нөхцөл байдлаас шалтгаалан соёлын өв бүхий олон тооны талбай устаж үгүй болж болзошгүй юм. Үүний дээр шугаман дэд бүтцэд (ялангуяа зам) ойр өрхүүд хулгайд өртөх болон нийгмийн/хүмүүсийн харилцаа/холбоо буурах өндөр магадлалтай байна. Нөгөө талаас, уул уурхайг дэмжсэн дэд бүтцийн хөгжил хөдөөгийн хүмүүс болоод бизнесийн салбарт бас ашгаа өгөх ёстой ба энэхүү зорилтыг энэ бүс нутгийн хүн амын суурьшил, хотжилтын хандлагатай тухайн төлөвлөж буй дэд бүтцийг уялдуулан зохицуулах замаар хангаж болох юм (4.8-р зургийг үзнэ үү).



Зураг 4.8 Хамгаалалттай газар нутаг ба одоогийн болон төлөвлөж буй шугаман дэд бүтэц

Хүснэгт 4.24 Оролцогч талуудын тодорхойлсон бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэцтэй холбоотой эн тэргүүний асуудлууд

Түвшин	Бага өсөлттэй хөгжлийн хувилбар	Дундаж өсөлттэй хөгжлийн хувилбар	Өндөр өсөлттэй хөгжлийн хувилбар
Эн тэргүүний асуудлууд:			
<ul style="list-style-type: none"> • Нийгмийн үйлчилгээ, дэд бүтэцэд учрах нэмэлт дарамт • Уул уурхайн бүс нутаг дахь хүн амын шилжилт хөдөлгөөн • Хүн амын шилжилт хөдөлгөөн • Зэрлэг амьтдын хөдөлгөөн 			
Сум	<ul style="list-style-type: none"> • Дэд бүтэц, төрийн үйлчилгээний нөхцөл байдал одоо байгаа хэвэндээ үлдэж, эсвэл бүр буурч магадгүй. • Хүн амын өсөлт тогтвортой байна. 	<ul style="list-style-type: none"> • Аймгийн төвөөс 25 хүрэхгүй км зайд оршдог сумдад төсвийн хөрөнгийг ихээр үр бүтээлгүй зарцуулдаг нь асуудал мөн. Голдуу сумдын иргэд ижил нийгмийн үйлчилгээг сумдаасаа биш аймгийн төвөөсөө авдаг. • Эрдэс баялгийн орлого одоогийнх шигээ үргэлжлэх нөхцөлд бүсийн тогтвортой хөгжлийг хангах үүднээс ЗГ хүн амын нутагшил суурьшил, засаг захиргааны нэгжийн хуваарийг эргэн харахыг шаардаж байна. 	<ul style="list-style-type: none"> • Хатуу хучилттай зам болон төмөр замууд нэмэгдсэнээр сум, аймгууд хоорондоо илүү холбогдож чадна. • Нийтийн тээврийн үйлчилгээ, эрүүл мэнд, халамжийн үйлчилгээ зэрэг төрийн үйлчилгээ сайжирна. • Сумын түвшинд хүн ам нэмэгдсэнээр орон нутгийн иргэдийн бизнес эрхлэх боломж сайжирна. Уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй сумдад хүн ам ихээр ирж суурьшсанаар гэмт хэрэг, өвчин эмгэг нэмэгдэж, төрийн үйлчилгээний ачааллыг ихэсгэнэ. • Зам тээврийн дэд бүтэц сайжирснаар хүн амд эерэгээр тусах боловч шилжилт хөдөлгөөн явагдах гол замнал хуваагдаж зэрлэг амьтдын популяцид (жишээ нь, хулан) сөргөөр нөлөөлнө. • Тусдаа уурхайнуудад зориулж олон зам баригдах бөгөөд эдгээрийн хооронд замын тоо болон тоос, амьдрах орчны эвдрэл доройтол гэх мэт олон замын нөлөөллийг бууруулахад чиглэгдсэн уялдаа холбоо, төлөвлөлт тааруу хийгдсэн байна. • Цэвэр нөлөөлөл нь ашиг тустай байна.
Аймаг	<ul style="list-style-type: none"> • Дээрхтэй адилхан. • Мөн түүнчлэн, ядуурал болон хүн амын шилжин суурьшил зэрэг нь сургууль цэцэрлэг зэрэг төрийн үйлчилгээнд ачаалал дарамтыг илүү их үзүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> • Талууд Улаанбаатарын эдийн засгийн хөгжлийг Эрдэнэт, Даланзадгад зэрэг уул уурхайн хотуудтай харьцуулж байв. Эдгээр уул уурхайн хотуудад суулийн хэдэн арван жилд иргэд нь аймгийн түвшинд өндөр хөгжлийг хүлээж байсан боловч ерөнхий хөгжил доогуур биш байсан хэдий ч хэзээ ч өндөр байсангүй. Одоогийн орлогын менежментийн бодлого хэвээр байвал аймгийн түвшинд нийгмийн үйлчилгээ тоймтой сайжирч чадахгүй гэж оролцогч 	<ul style="list-style-type: none"> • Дэд бүтэц, төрийн үйлчилгээний хангамж сайжрах нь гарах ашиг тусуудын нэг юм. • Сум, аймгийн төвүүдийг холбосон хатуу хучилттай зам, төмөр замыг шинээр барина. • Аймгийн түвшинд, ялангуяа аймгийн төвүүдэд хүн ам нэмэгдсэнээр гарах нөлөөлөл нь дээрх ашиг тусыг бууруулна. Тээвэр, эрүүл мэнд, сургууль цэцэрлэг зэрэг төрийн үйлчилгээний дарамт, ачаалал нэмэгдэж, нэмэгдсэн эрэлт хэрэгцээг хангахад төрийн байгууллагуудад хүндрэл учирна. Барилга байшин, орон сууц барих явдал хөгжлийн хурдтай нийлэхгүй.



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

Түвшин	Бага өсөлттэй хөгжлийн хувилбар	Дундаж өсөлттэй хөгжлийн хувилбар	Өндөр өсөлттэй хөгжлийн хувилбар
		талууд үзэж байна.	<ul style="list-style-type: none">Хөдөө орон нутгаас хүн ам шилжин ирж, аймгийн төвийн хүн ам нэмэгдсэнээр гэмт хэрэг, өвчин эмгэг нэмэгдэх зэрэг нийгмийн асуудлууд нэмэгдэнэ.
Улс	<ul style="list-style-type: none">Хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, ялангуяа Улаанбаатар хот руу чиглэсэн хөдөлгөөн нэмэгдсэнээр гэмт хэрэг, өвчин эмгэг зэрэг үзэгдэл нэмэгдэж, хэдийнээ ачаалалтай ажиллаж байгаа төрийн үйлчилгээ, дэд бүтцэд улам их дарамт учруулна. Зам, төмөр зам зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалт, үйлчилгээний хангамжийн адил удааширна.Ядуурал нэмэгдэнэ.Цэвэр сөрөг нөлөөллийг бий болно.	<ul style="list-style-type: none">Хөгжлийн бодлого, төлөвлөөгөөнд гол анхаарал аймагт төвлөрч, аймгийн хилээс цаашир нөхцлийг анхаардаггүй. Нийтийн замаас өөр нэмэлт уурхайн зам баригдахгүй тул шугаман дэд бүтцийн зэрлэг амьтад, малд үзүүлэх үр нөлөө дунд зэрэг байх юм. Нийтийн үйлчилгээ, дэд бүтцийн хангамж одоогийнхтой адил түвшинд байх болно.	<ul style="list-style-type: none">Дээрхтэй адилхан.Мөн, төр засгийн үйлчилгээний төлөвлөлт уул уурхайн салбарын өсөлтийг гүйцэхгүй бөгөөд улмаар ус, цахилгаан хангамжийн нийлүүлэлт муудаж, хот суурин газруудын төлөвлөлт учир дутагдалтай явагдаж, төрийн үйлчилгээ муудна. Улсын хэмжээнд гэмт хэрэг, өвчин эмгэгийн гаралт нэмэгдэнэ.



4.4.2.2 Сум, аймаг, улсын түвшинд үзүүлэх нөлөөллийн эрчим

Бага өсөлттэй хувилбарын дагуу одоо ажиллаж байгаа уурхайнууд үйл ажиллагаагаа багасгах буюу зогсоосон ч, уул уурхайг дэмжин барьж байгуулсан дэд бүтэц, нийгмийн үйлчилгээг өмнөх түвшинд нь хадгалж байх нь чухал. Сум, аймгийн түвшинд тогтвортой ирээдүйг хангах үүднээс одоогийн уул уурхайн хотуудад байгаа бизнесийг төрөлжүүлэх хэрэгцээ байна. Бага өсөлттэй хувилбарын үед хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгдэж Монголын 90-ээд онд Улаанбаатарын хүн амыг ихээхэн өсгөсөн байдлыг давтах магадлалтай юм. Хүн амын нягтрал уул уурхайн хотуудад, мөн хилийн гол боомтуудад илүү байх болно (4.9-р зургийг харна уу). Цаашлаад, эдгээр хотуудад нийгмийн үйлчилгээг шилжин ирж буй иргэдэд ижил тэгш хүргэх асуудалд хүндрэл учирч, ингэснээр нийгмийн тогтвортой, нэгдмэл чанар алдагдаж, гэмт хэрэг, өвчин ихэснэ.


Дундаж өсөлтийн хувилбарын үед олон хот тосгодод уул уурхайн үйл ажиллагааг дэмжсэн шинэ дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ (цахилгаан станц, ашигт малтмал тээвэрлэх зам, ус цэвэршүүлэх станц, сургууль, цэцэрлэг г.м.) баригдана. Гэвч уул уурхайн дэд бүтцийн хөгжлийг бүс нутгийн газар ашиглалтын төлөвлөлтэй тэр болгон уялдуулж байсангүй. Ийм ч учраас одоогийн бүсийн төлөвлөлтийн баримт бичгүүдэд биологийн төрөл зүйлийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалал, экосистемийн хамгаалал, соёлын өвийг хадгалж хамгаалах, уул уурхайд зориулсан тээврийн үр ашигтай сүлжээ зэрэгтэй холбоотой асуудлыг тооцоогүй байна. Орон зайн төлөвлөлтийн системийн сул байдал, улсын түвшин дэх төлөвлөгөө, тээвэр, байгаль орчны байгууллагуудын салбар хоорондын зохицуулалт дутмаг байгаагаас шалтгаалан орон зайн төлөвлөлтийг хангалтгүй хийж байна. Иймээс дундаж өсөлтийн хувилбарын хувьд инженерийн дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хувьд төв болон өмнөд говийн бүсэд нөлөөлөл хамгийн илүү байх болно.

Өндөр өсөлттэй хувилбарын үед, Монгол улсын эрдэс баялаг давамгайлсан эдийн засаг руу шилжих хөгжил нь хотжилтыг бууруулах бус харин ихэсгэхэд хүргэнэ гэж НҮБ-ын Хүн амын сангийн (2012) хүн ам зүйн судалгаанд дүгнэсэн байна. Үндэсний статистикийн хорооны хүн амын 2025 он хүртэлх төсөөллийн дагуу, Хөвсгөл, Баян-Өлгий, Өмнөговь, Өвөрхангай, Дорноговь, Сэлэнгэ зэрэг аймгийн хүн ам бусад аймгийнхаас илүү ихсэх ба Улаанбаатарыг эс тооцвол, орон зайн хувьд хүн ам илүү тэгш суурьшсан байна (4.9-р зургийг үзнэ үү). Түүнээс гадна, өндөр өсөлттэй хувилбарын үед уул уурхайн өсөлт хөдөөд ажлын байр, бизнесийн боломж, чадавхийг нэмэгдүүлж төвлөрлийг сааруулахад нөлөөлнө. Бүсийн эл байдал нь хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулна. Уул уурхайн салбарын цаашдын өндөр өсөлтийг хангахад шаардлагатай дэд бүтцийн цар хүрээ, шугаман дэд бүтцийг барьж байгуулах ажлаас зэрлэг ан амьтдын хөдөлгөөнд үзүүлэх нөлөөлөл хоёр нь өндөр өсөлттэй хувилбарын хувьд бага болон дундаж өсөлтийн хувилбаруудаас их байх ба энэ нь хөгжлийн цар хүрээ, хамгаалалттай нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах юм (4.2.2 буюу Газар ба бэлчээр ашиглалт хэсгийг харна уу). Мөн улсын хэмжээнд дэд бүтцийн хөгжлөөс соёлын өвд сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна (4.3.2 буюу Соёлын өв хэсгийг харна уу).



Нөлөөллийн хураангуй

Бага өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">• Хөдөөгөөс хот суурин газар, тэр дундаа Улаанбаатар хот руу шилжих хөдөлгөөн нэмэгдэнэ.• ЗГ-т нийгмийн/олон нийтийн үйлчилгээг тэнцүү хүртээхэд хүндрэл учирна.
Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">• Бүс нутгийн төлөвлөлт, энэ асуудлаарх салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагаа муу явагдаж ирсэний уршигаар зам тээврийн сүлжээ, орон зайн төлөвлөлт тааруу хийгдсэн байдаг.• Говийн бүсийн төв болон өмнөд хязгаар хамгийн ихээр нөлөөлөлд өртөнө.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">• Хөвсгөл, Баян-Өлгий, Өмнөговь, Өвөрхангай, Дорноговь, Сэлэнгэ аймгуудад хотжилт ихээр явагдаж, хүн ам төвлөрнө.• Уул уурхайн салбарын өсөлт бүс нутгийн хөгжилд болон төвлөрлийг сааруулахад хувь нэмрээ оруулна.• Шугаман дэд бүтцийн бүтээн байгуулалт нь байгаль, зэрлэг амьтдад ихээхэн нөлөө үзүүлнэ.• Шугаман дэд бүтцийн бүтээн байгуулалт нь соёлын өвд ихээхэн нөлөө үзүүлнэ.



Зураг 4.9 Хүн ам ихсэж, нийгмийн үйлчилгээнд нь дарамт нэмэгдэж болзошгүй хот суурин



4.4.2.3 Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц: Арга хэмжээний зөвлөмжүүд

Хүснэгт 4.25 Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц: Арга хэмжээний зөвлөмжүүд

Арга хэмжээний зөвлөмж	
	<ul style="list-style-type: none">• Бүс нутгийн төлөвлөлтийн системийг сайжруулах замаар бүсийн газар ашиглалтын төлөвлөгөөг шинэчлэх• Уул уурхайн орлогоос санхүүжих аймгийн түвшний дэд бүтэц, орон сууцны сан байгуулах• Орон зайн төлөвлөлтөд экосистемийн хамгааллыг тооцох• Одоо үүсээд буй уул уурхайн хот, тосгоныг тогтвортой байлгах үүднээс тухайн газруудад ЖДҮ, амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөрүүдийг дэмжих• Дэд бүтцийг хөгжүүлэхэд төр хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох
Сум	<ul style="list-style-type: none">• Хот байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд уул уурхайн онцлог асуудал, байгаль орчин, нийгмийн талаар анхаарал татаж буй асуудлыг тусган олон нийтийн оролцоотойгоор сайжруулж, хэрэгжүүлэх. Одоогийн байгаа газар зохион байгуулалт болон хот байгуулалтын төлөвлөгөөний уялдааг сайжруулах (4.2.2 буюу Газар ба бэлчээр ашиглалт хэсгийг харна уу).• Орон нутгийн хөгжил, төлөвлөлтийн чиглэлээрх сумын засаг захиргааны чадавхийг дээшлүүлэх.• Уул уурхайн хөгжилтэй холбоотойгоор хүн ам олноороо шилжин ирж буй аймаг, сумдад дэд бүтэц, үйлчилгээг хүртээмжтэй хүргэхийн тулд уул уурхайгаас орж буй орлогоос нэмэлт төсөв хуваарилах (4.3.3 буюу Хүний эрх ба олон нийтийн оролцоо хэсгийг харна уу).• Одоо үүсээд буй уул уурхайн хот, тосгоныг тогтвортой байлгах үүднээс тухайн газруудад ЖДҮ-ийг дэмжих (4.3.3 хэсгийг мөн харна уу).• Томоохон уурхайн ойролцоох хот, суурины газрын үнийг хөөрөгдөн бөөнөөр нь авахаас сэргийлэх үүднээс газар олголт, газар зохион байгуулалтын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах.• Бичил болон томоохон хэмжээний уурхайн үйл ажиллагаа аль аль нь явагдаж буй албан бус суурингуудыг хянах, уул уурхайн хэрэгцээг хангасан бүсийн цогц төлөвлөгөөг боловсруулсанаар албан бус сууринг шинээр үүсэхээс сэргийлэх.
Аймаг	<p>Дээр дурдсанаас гадна:</p> <ul style="list-style-type: none">• Уул уурхайн хөгжилтэй холбоотойгоор хүн ам олноороо шилжин ирж буй аймаг, сумдад дэд бүтэц, үйлчилгээг хүртээмжтэй хүргэхийн тулд уул уурхайгаас орж буй орлогоос нэмэлт төсөв хуваарилах.• Уул уурхайн зориулалтаар байгуулах дэд бүтцийн тэнцвэрийг хангах үүднээс аймгийн Байгаль орчны газартай нягт хамтран ажиллах.
Улс	<p>Дээр дурдсанаас гадна:</p> <ul style="list-style-type: none">• Дэд бүтэц, нийгмийн үйлчилгээг хөгжүүлэхэд эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэхэд уул уурхайн компаниудтай хамтран ажиллах.• Уул уурхайн лицензийг бүсийн хөгжлийн бодлогод нийцүүлэн олгох.• Дэд бүтцийг хөгжүүлэхэд төр хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох.• Байгаль орчин нийгмийн асуудлаарх нөлөөллийг багасгахын тулд орон зайн төлөвлөлт, тээвэр, байгаль орчны асуудал хариуцсан байгууллагуудын уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулах• Орон зайн төлөвлөлтөд экосистемийн хамгааллыг тусгах.



4.4.3 Хөдөлмөр эрхлэлт ба үр чадвар

4.4.3.1 Нөлөөлөл ба хувилбаруудын танилцуулга

Монголд уул уурхайн төсөл санаачлах, хэрэгжүүлэхийн тулд уурхайн салбарын хөгжилд шаардлагатай боловсрол, сургалт, түүнчлэн үндэсний ажиллах хүчний чадавхийг бий болгоход ихээхэн хөрөнгө оруулалт шаардагдаж байна. Хөдөлмөр эрхлэлт, мэргэжилтэй боловсон хүчин, ажиллах хүч, хөдөлмөрийн нөхцөл зэрэг нь салбарын хөгжилд ихээхэн нөлөөтэй төдийгүй Монгол улсын уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй үндэсний болоод олон улсын аж ахуйн нэгжүүдийн гол анхаарах ёстой хүчин зүйлс болоод байна.

Боловсрол ба үр чадвар: 2025 хүртэл Монгол орон даяар “хүн ам зүйн цонх үе” буюу эдийн засгийн болон нийгмийн хөгжилд хөрөнгө оруулалт, хүний хөгжлийн түлхэц болсон хүн ам зүйн таатай нөхцөл байдал бий болох шинжтэй байна. Энэ нь хүн амын насжилтын нөлөө илрэхээс өмнө Монгол улс дараагийн 15-20 жилийн дотор эдийн засгаа хөгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, мэргэжлийг эзэмшүүлэхэд энэ давуу талыг ашиглах хэрэгтэй гэсэн үг. Ялангуяа говийн бүсүүдэд дараагийн арав түүнээс дээш жилийн хугацаанд сургагдаж бэлтгэгдээд ажиллахад бэлэн залуусын тоо улсын дунджаас дээгүүр байна (Састэйнабилити Ийст Эйжия, 2010).

Зах зээлийн тогтолцоонд шилжихээс өмнө Монголчууд баталгаатай ажлын байр, тэтгэвэр, нийгмийн даатгал гэх мэт боловсрол, нийгмийн үйлчилгээг үнэ төлбөргүй хүртдэг байсан бол одоо нөхцөл байдал өөрчлөгдөөд байна. Хувийн дээд сургуулиудыг хуулиар зөвшөөрснөөр улсын хэмжээнд хувийн дээд боловсролын байгууллагын тоо зуу илүү гарсан ч төгсөгчдийн дөнгөж 40% гаран нь ажлын байртай болдог (ADB, 2011). Энэ нийтлэг үзэгдлээс гадна эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүд дээд боловсрол эзэмших нь бага болсноос ажиллах хүчний бүтээмжийг бууруулсан. Эсрэгээрээ үндэсний болоод шийдвэр гаргах түвшинд оролцож буй эмэгтэйчүүдийн тоо бага байна.

Өнөөгийн Монголын хөдөлмөрийн зах зээл байгаа хэрнээ ашиглагддаггүй хүн-хөрөнгөтэй, бүтээмж муутай ажлын байруудаар дүүрэн, харин мэргэжлийн боловсон хүчнээр дутмаг байна. Залуу ажиллах хүчний 60% орчим нь албан бусаар хөдөлмөр эрхэлдэг бөгөөд ихэнх албан бус хөдөлмөр эрхлэлтийн 71% орчим нь хөдөө орон нутагт байгаагаас тэдгээр ажлуудын 45%-ийг эмэгтэйчүүд гүйцэтгэж байна. Албан бусаар бүртгэлгүй ажил эрхлэж буй иргэд ажилгүйдлийн тэтгэмж огт авдаггүй (Састэйнабилити Ийст Эйжия, 2010). Хөдөлмөр эрхлэлт ба ядуурлын талаар гаргасан Хүний хөгжлийн тайланд (2007) тусгаснаар малчдын зээлийн бараг гуравны хоёр хувь нь оюутны сургалтын төлбөрт зарцуулагддаг ба шинэ төгсөгчид ажил олгогчдын тавьсан шаардлагыг хангадаггүйн улмаас ажилгүйдлийн түвшин өндөр (ADB, 2010), дээд боловсролтой ажиллах хүчний хэрэгцээ хөдөлмөрийн зах зээлд эрэлт муутай байдаг зэрэг нь ерөнхийдөө малчдын ядууралд нөлөөлдөг.

Монголын эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт нь сэтгэлгээний (бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээ), хэрэглээний (англи хэл, мэдээллийн технологи), техникийн мэдлэг, үр чадваруудыг ихээр шаардах болсон байна. Техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллагын төгсөгчид хөдөлмөрийн зах зээлд эрэлт ихтэй. Уул уурхайн салбарын өсөлт хөгжил нь аж ахуйн нэгжүүдийг ажиллах хүчинд тавигдах шаардлагыг бүрэн хангахад улам бүр хэцүү болгож байна. Ажиллах хүчин нь мэргэжлийн үр чадвартай байсан ч ажлын туршлага дутмаг байдал нэлэнхүйдээ ажиглагддаг тул ялангуяа инженер, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн



ажилтан, дунд шатны удирдах ажилтан зэрэг дээд түвшний мэдлэг, мэргэжил бүхий ажиллах хүчин олоход бэрхшээлтэй (Састэйнабилити Ийст Эйжия, 2010). Сүүлийн таван жилд явагдсан уул уурхайн үйл ажиллагаа, гадаадад сурч, ажиллаж байсан монголчууд энэхүү өрсөлдөөнтэй, шилжин өөрчлөгдөж буй цаг үед улс орондоо хувь нэмэрээ оруулахаар эргэн ирж байгаагийн ачаар ажиллах хүчний туршлагын түвшин дээшилсэн байна.

Шаардлагатай мэргэшсэн ажилчид болон одоо байгаа бэлтгэгдсэн ажиллах хүчний тоо хоорондын зөрүүг нөхөх тал дээр олон улсын байгууллагуудтай байгуулсан зорилтот түншийн харилцаагаар дамжуулж, мөн Монголдоо сургах замаар одоогийн уул уурхайн үйл ажиллагаанд шаардлагатай байгаа дээд мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэхэд ахиц гарсаар байна. Үүнд Засгийн газрын болон хувийн хэвшлийн санхүүжилттэй олон улсын тэтгэлэгт хөтөлбөрүүдийг дурдаж болно. Бодит байдал дээр монголчууд олон улсын уул уурхайн салбарын туршлагатай харьцуулахад ажлын дадлага туршлагыг дутуу үнэлж, салбартаа ажиллаж хуримтлуулсан хэрэглээний туршлага гэхээсээ дээд боловсролын зэрэг олж авахыг илүүд үздэг.

Мэргэжлийн сургалтын тал дээр шийдвэрлэгдээгүй үлдэж байгаа томоохон бэрхшээлүүд нь стандартчилал, зарим мэргэжлээр сургадаггүй, сурсанаа ажилд ашиглахад бэлэн бус байдал зэрэг юм. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, уурхайн төслийн шаардлагад нийцсэн дээд мэргэжлийн болон техник мэргэжлийн боловсрол олгохыг хичээж байгаа ч тэдгээр нь үндэсний стандарт биш. Жишээ нь уурхайн компаниуд зах зээл дээр байгаа хамгийн шилдэг гэсэн ажил горилогчдыг авч, түвшин бүрийн ажлын байран дээрх болон компаний онцлогт тохирсон техник мэргэжлийн сургалтанд хамруулдаг. Гэсэн хэдий ч энэ нь тухайн боловсон хүчин салбарын өөр нэг компанид очоод ажиллахад шаардлагыг нь хангана гэсэн үг биш юм. Хөгжиж буй мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг дэмжих Үндэсний чанар-стандарт-мэргэжлийн-хөтөлбөр нь дараах хүчин зүйлсүүд дээр төвлөрсөнөөр хөдөлмөр эрхлэлт, төгсөгчдийн чадварыг нэмэгдүүлж байгаа юм. Үүнд:

- Аж үйлдвэрийн салбарын сүлжээ, зорилтот салбарын зөвлөхүүд;
- Багш нарын ур чадварыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр;
- Сургалтын хөтөлбөр бий болгох;
- Хөдөлмөр зохицуулалтын тогтолцоо ба МСҮТ-ийн байр суурь;
- Сургалт болоод сургалтын төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмжийн санхүүжилт;
- Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн зохицуулалт.

Дээд шатны боловсрол олж авах нь чухал гэдэг ойлголтын улмаас техник мэргэжлийн сургалт нь сургууль төгсөгчдийн дунд “сүүлчийн сонголт” болж байна. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-үүдийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулснаараа энэ ойлголтыг халж мэргэжлийн ажлууд нь нэр хүндтэй, ашиг орлоготой ажил гэдэг ойлголтыг нийгэмд бий болгох, түүнчлэн хөдөлмөрийн зах зээл дээрх мэргэжилтэй ажилчдын эрэлт, нийлүүлэлтийг нэмэгдүүлэхийг зорьж байгаа юм. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд ажлын талбар дээр тавигдах ерөнхий стандарт, аюулгүй ажиллагааны шаардлагууд, ажил олгогчийн зүгээс тавьж байгаа ур чадварын шалгууруудыг хангасан ажилчныг бэлтгэж байгаагаараа цаашлаад төгсөгчдийн ажлын байранд очоод ажиллахад бэлэн байдал хангагдах болно.



Хөдөлмөр эрхлэлт: Албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж буй уурхайн компанид ажиллаж байгаа ажилчдын тоо 2001 оноос хойш гурав дахин өссөн ба одоогоор 48,000 гадаад, монгол ажилчид энэ салбарт хөдөлмөр эрхэлж байгаа судалгаа байна. Тус улсын нийт хөдөлмөр эрхлэгчдийн дөнгөж 4 хүртэлх хувийг уурхайтай холбоотой хөдөлмөр эрхлэгчид бүрдүүлж байгаа бөгөөд тэдгээр нь ДНБ-ий нилээдгүй хувийг бүрдүүлдэг.

Уурхайн салбар дахь ажлын байрны ихэнх нь мэргэжилгүй, дунд мэргэжлийн (жишээ нь: цахилгаанчин, механик, туслах ажилчин, засварчин, оператор гэх мэт) ажиллах хүч эсвэл геологи, төмөрлөг, нягтлан бодох, бизнесийн удирдлага, механик, уурхайн инженер гэх мэт цөөн тооны мэргэшсэн ажилтан шаарддаг орон тоонууд байна.

Хөдөлмөр эрхлэлтийн зохицуулалт нь ихэвчлэн ОИ-ОБ (онгоцоор ирэх-онгоцоор буцах), МИ-МБ (машинаар ирэх-машинаар буцах) гэх мэт ажилчдын ажилдаа ирж, очих байдлаас хамааралтай. Орон нутгаас ажиллах хүчин авах, эсвэл ОИ-ОБ, МИ-МБ ажилтны алийг сонгох нь газар зүйн байрлалаас ихээхэн хамаарна. Жишээ нь, Сентерра Бороо Гоулдын уурхайн тогтвортой хөдөлмөр эрхлэлт, цалингийн орлого нь хотоос уурхай хүртэл зам богино, ээлж солигдоход машинаар ирж, машинаар буцдаг зэрэг боломжоос шалтгаалан орон нутгаас авсан ажилчид бүсийн төв болох нийслэл Улаанбаатар луу шилжин суурьших нөхцлийг бүрдүүлсэн. Эсрэгээрээ Цогтцэций суман дахь Ухаа худгийн уурхай орон нутгийн ажиллах хүчинд тулгуурладаг ба цөөн тооны өндөр мэргэжил шаардсан ажлуудад ОИ-ОБ ажилтнуудыг авч ажиллуулдаг байна.

Уурхайд шууд хөдөлмөр эрхлэхээс гадна хөдөлмөр эрхлэлтийн шууд бус хэлбэрийн дараах боломжууд байдаг. Үүнд:

- Шууд бус ажлууд (жишээ нь: нийлүүлэгчид);
- Өсөлтийн нөлөөгөөр бий болсон ажил (нийт эдийн засаг сэргэсний үр дүнд бий болсон ажлууд).

Эдгээр нөлөөллүүдийн цар хүрээ нь төрөл бүрийн улс төр, эдийн засаг, зан үйлийн хүчин зүйлсээс хамаарна. Жишээ нь, шууд бус ажлууд бий болж байгаа нь л гэхэд тухайн нэгжийн орон нутагтаа ажлын байр нэмж байгааг илэрхийлж, цаашлаад компани нэг бүрийн хангамжийн бодлогоос хамааралтай байх ба жишээ нь орон нутгаас нийлүүлэх эрэлттэй бараа бүтээгдэхүүний хангамжийн сүлжээ сайжрах нь шинэ ажлын байр бий болоход нөлөөлнө. Ажлын байр бий болгох өсөлтийн нөлөө нь хуримтлуулсан эх үүсвэртэй зарцуулсан орлогыг харьцуулсан үзүүлэлтээс хамаарах ба түүнчлэн орон нутагтаа зарцуулсан орлогын хувиас шалтгаална. Шууд бус болон өсөлтийн нөлөөгөөр ажлын байр бий болгох нөлөөллийн итгэлцүүр нь эрс тэс өөр байж болно. Жишээ нь Шотланд 2 байхад Гвана 28 байх жишээтэй (Олон улсын валютын сан). Энэ үнэлгээнд Монголыг оролцуулаагүй. Гэсэн хэдий ч Монголын бизнес эрхлэгчдийн 70% нь жижиг бизнес төдийгүй ихэнх нь орон нутагт байршилтай гэдэг хүчин зүйлсийг тооцоод үзвэл хэдийгээр бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг орон нутгийн нөөцөөр хангах чадавхи хараахан бүрдээгүй байгаа ч тэдгээр орон нутгийн жижиг нийлүүлэгч нарт хөгжих (жишээ нь Оюу Толгойн хувьд ажиглагдсанаар (2014)) боломж харагдаж байна. Улаанбаатарт бүртгэлтэй олон тооны аж ахуйн нэгжүүд орон нутгаас нийлүүлэгч сонгоно гэсэн шалгуурт тэнцэхийн тулд аймгуудад бүртгэлтэй болж байна. Ерөнхийдөө шууд бус болон өсөлтийн нөлөөгөөр ажлын байр үүснэ гэдэг нь бодит боломж юм.



Ажиллах хүч ба хөдөлмөрийн нөхцөл: Бичиг үсэг тайлагдалтын түвшин Монгол улсад 97.5% байгаагаас үзэхэд ажиллах хүч ерөнхийдөө боловсролтой, залуу, суралцах арга барил эзэмшсэн байна. Хэдий тийм боловч мэргэжлийн өндөр зэрэг шаардлагатай эсвэл МСҮТ-ийн диплом шаардсан ажлууд дээр мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай байгаа нь харагддаг. Мэргэшсэн, сургагдсан боловсон хүчин бэлтэхэд цаг, хөрөнгө шаардагдана. Гадны хөрөнгө оруулалттай компаниуд сургагдсан, мэргэшсэн техникийн ажилтнууд дутагдалтай байдлыг нөхөхийн тулд дотоодын сургагч нарыг бэлтгэх, ажилтны тогтвортой байдлыг хангахын тулд цалинг нэмэгдүүлэх эсвэл Монголд байхгүй мэргэжил, мэргэжилтнийг гадаад ажиллах хүчнээр нөхөх гэх мэт арга хэмжээ авч байна.

Мэргэжилгүй ажилчдын тоо хаа сайгүй, ялангуяа хөдөө орон нутаг, алслагдмал газруудад хангалттай боловч зөвхөн ажиллах явцдаа сурах, албан тушаалын хувьд ахих боломжгүй жолооч, цэвэрлэгч гэх мэт ажлууд байгаад орон нутгийнхан сэтгэл дундуур байдаг. Уул уурхайн салбарын ажиллах хүчний хэрэгцээ нь барилгын шатны үед ихэсдэг бөгөөд төслийн үргэлжлэх хугацаанаас хамаараад янз янз байна. Эдгээр ажлууд нь түр зуурын шинжтэй байх агаад үйлдвэрлэлийн шатны ажлын байрыг бодвол харьцангуй богино хугацаатай. Уурхайн төслийн үргэлжлэх хугацаа нь ойлгомжгүй байдгаас, ялангуяа барилгын шат дууссаны дараа ажил хайгчдын тоо нээлттэй ажлын байрны тооноос илүү гардаг (ялангуяа Монголын хөдөө орон нутгуудаар).

Монгол улсын Хөдөлмөрийн хууль нилээд чөлөөтэй, хориг саад багатай хууль. Уурхайн компаниудын ажилтан авах журам нь Монгол улсын Хөдөлмөрийн хуулинд л нийцэж байвал хөндлөнгийн хөдөлмөр зуучийн оролцоогүйгээр ажилчдаа сонгон авдаг. Нэг заавал мөрдөх ёстой заалт нь компаниуд ажлын бүх л талбар дээр монгол, гадаад ажилчдын аль аль нь хийж чадах ажил байлаа гэхэд заавал Монгол ажилчныг нь авч ажиллуулах ёстой гэсэн заалт юм. Энэ нь зөвхөн мэргэжил шаардахгүй ажлуудад хамаатай бөгөөд мэргэжлийн шаардлагыг хангах боловсон хүчин нь Монголын зах зээлд байхгүй ажлуудад хамааралгүй. Түүнчлэн Хөдөлмөрийн хуулинд хувийн хэвшилд ажиллах Монгол улсын иргэний эзлэх хамгийн доод хувийг заасан байдаг. Ерөнхийдөө уурхайн салбарт үндэсний ажиллах хүчний эзлэх хувь нь нийт орон тооны ажилчдын 80% байх ёстой гэж заасан ба энэ нь Монгол ажилчдын эзэмшсэн мэргэжлийн чадвараас болон тухайн бизнесийн төрлөөс хамаараад янз янз болох нь бий. Гэхдээ, өнгөрсөн 2010-2011 оны оргил үеийн ажиллах хүчний хэрэгцээг хангахын тулд Хятад болон бусад газраас барилгын ажилчид авах гэх мэтээр шаардлагатай хөдөлмөрлөх хүчнийг бүрдүүлсэн байдаг.

Саяхан батлагдсан Хөрөнгө оруулалтын турай хууль (2013)-д олборлох салбар дахь ажиллах хүчний асуудлыг зохицуулах заалтууд орсон байв. Уг хуулиар гадаадын хөрөнгө оруулагчдыг дотоодын ажиллах хүчнийг ашиглах боломж олгож байгаа ба гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах нэрээр Монголын Засгийн газар хөдөлмөр эрхлэлтийн байдалд нь хөндлөнгөөс оролцож болно гэсэн эрхийг нээж өгч байгаа юм. Хууль, журмын хувьд үүнийг хэрхэн хэрэгжүүлэх нь одоохондоо тодорхойгүй байгаа бөгөөд ажиллах хүчний зохицуулалтын эрхээ Засгийн газарт өгөх үү үгүй юу гэдэг дээр мэтгэлцээн үүсгэх магадлалтай байна.

Хөдөлмөрийн нөхцлийн ерөнхий шаардлагуудыг хангахаас гадна дараах нэр дурдсан хүчин зүйлсүүдийн хувьд компани бүр өөр өөр нөхцөлтэй байна. Үүнд:

- Ажилчдын цалин, хөлс;



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

- Гэрээний хугацаа (туршилтын хугацаа, чөлөө, халах нөхцөл гэх мэтийг оролцуулаад);
- Тэтгэмж (урамшуулал, амралт, чөлөөт цагаа өнгөрөөх газартай байх гэх мэт);
- Ажлын ээлж;
- Хөдөлмөрийн ЭМАА-ны стандарт;
- Мэргэжил дээшлүүлэлт.

Жишээ нь 2010-2011 оны зах зээлийн өрсөлдөөнт нөхцөлд зарим компаниуд санхүүгийн урамшуулал дээр тулгуурлан мэргэжилтэй боловсон хүчнийг татаж байсан бол цалин нэмэх боломжгүй зарим нь ажилчдаа ажлын ээлжийг нь уртасгах (энэ нь ОИ-ОБ, МИ-МБ ажилчдад ар гэртээ удаан байж, гэр бүлээ тогтвортой байлгах томоохон боломж болж өгөв) замаар тогтоож байв. Энэ үед уул уурхайн салбарт ажиллагсад ажлаа өөрчлөн шинээр ажил олоход амар, мөн ажлаа солих нь элбэг байсан ба хөдөлмөрийн зах зээл нилээд хөдөлгөөнтэй байв (Састэйнабилити Ийст Эйжия, 2010). Эсрэгээрээ, өнөөгийн (2014) хямралын үед уул уурхайн хөдөлмөрийн зах зээл хөдөлгөөн багатай байгаа ба ажлын байр цөөн байгаа тул ажилтай нэг нь тухайн ажлын байраа хадгалахыг хичээж байна.

Хүснэгт 4.26 Оролцогч талуудын тодорхойлсон хөдөлмөр эрхлэлт ба ур чадвартай холбоотой эн тэргүүний асуудлууд

Түвшин	Бага өсөлттэй хөгжлийн хувилбар	Дундаж өсөлттэй хөгжлийн хувилбар	Өндөр өсөлттэй хөгжлийн хувилбар
Эн тэргүүний асуудлууд:			
<ul style="list-style-type: none"> • Уул уурхайн салбар дахь хөдөлмөр эрхлэлт • Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил • Ур чадвар, чадавхийг бэхжүүлэх 			
Сум	<ul style="list-style-type: none"> • Сумын мэргэжилтэй ажилчид уул уурхайн салбарт ажиллах боломжгүй болсноор ажилгүйдэл нэмэгдэнэ. • Эдийн засгийн удаан өсөлт хүмүүсийн ажиллах, шинээр бизнес эхлүүлэх сэдлийг бууруулж, идэвхгүй болгоно. • Уул уурхайн салбарын өсөлт бүүрснаас бизнесийн өөр бусад салбарууд бий болж хөгжих бөгөөд бизнес эрхлэгчид уул уурхайн ханган нийлүүлэлтийн салбараас аялал жуулчлал болон хөдөө аж ахуй зэрэг салбарт орох шаардлагатай болно. • Эрэлт хэрэгцээ багассанаар ЖДҮ-ийн салбарын өсөлт удааширна. 	<ul style="list-style-type: none"> • Боловсрол, мэргэжлийн байдал доогуур, орон нутгийнхан уурхайн компанид голдуу мэргэжил шаардаагүй, эсвэл бага шаардагдах ажил хийнэ. • ЖДҮ-үүдийн хүчин чадлаас хамаараад шууд бус байдлаар сумын хэмжээнд ажлын байр хомс, орон нутгийн хангамжийн үйл ажиллагаа, сүлжээнд оролцож буй компаниуд ажлын орон тоо зарлах байдлаас ихээхэн хамааралтай. • Хөдөлмөрийн нөхцөл, ажлын байрны нөхцөл нь хуулиар заасан ерөнхий шаардлагуудыг хангаж байгаа бөгөөд өөр бусад даатгал, тэтгэмж зэрэг нэмэлт нөхцөлүүд нь ажил олгогч, тухайн шаардагдаж буй мэргэжлийн эрэлтээс шалтгаалж байна. • МСҮТ болон дээд боловсрол олгогч хоорондын хамтын ажиллагаа байгууллага, компаниудын хэрэгцээ, шаардлагыг хангах хэмжээнд хүрэхгүй. 	<ul style="list-style-type: none"> • Уул уурхайн салбарт болон уул уурхайн ханган нийлүүлэлтийн салбарт ажил хөдөлмөр эрхлэх, ажилтай болох шинэ боломжууд бий болно. Гэхдээ, уул уурхайн салбарт гарч байгаа ажлын байруудад гадаад ажилчид болон тухайн сумын гаднаас ирж байгаа ажилчид ажиллах болсноор дээрх боломжийг үр дүнтэй ашиглаж чадахгүй явдал гарч магадгүй. • Цалингийн ялгааны улмаас орон нутгийн иргэдийн ихэнх ур чадвартай хүмүүс түүний дотор төрийн албан хаагч нар уул уурхайн салбарт ажиллахыг илүүд үзэж магадгүй. Энэ нь орон нутгийн төрийн албаны чадавхийг сулруулахад хүргэж болзошгүй. • Жижиг, дунд үйлдвэрлэлд бизнесийн илүү таатай боломж нээгдэнэ. Гэвч орон нутгийн жижиг, дунд үйлдвэрүүдийн хувьд нийслэл хотоос ирж үйл ажиллагаагаа шинээр нээж буй том сүлжээ бизнестэй өрсөлдөхөд хэцүү болно. Орон нутгийн жижиг дэлгүүр, цайны газар, зочид буудлуудын үйлчлүүлэгч нарыг том бизнесийн сүлжээнүүд эзэлнэ. • Хөдөлмөр эрхлэлт болон мэргэжлийн ур чадварт үзүүлэх цэвэр нөлөөлөл нь эерэг байна.
Аймаг	<ul style="list-style-type: none"> • Дээрхтэй адилхан. 	<ul style="list-style-type: none"> • Дээр дурдсан нөхцөл байдлаас гадна: • Уурхайн чиглэлээр мэргэжил олгож буй одоогийн МСҮТ болон түүнээс дээшх боловсролын байгууллагуудын сургалтын хөтөлбөр нь уурхайн талбар дээр шууд гараад ажиллахад шаардлагатай салбарын мэдлэг, ур чадварыг эзэмшсэн төгсөгч бэлтгэх чадамжгүй байна. 	<ul style="list-style-type: none"> • Дээрхтэй адилхан.



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

Түвшин	Бага өсөлттэй хөгжлийн хувилбар	Дундаж өсөлттэй хөгжлийн хувилбар	Өндөр өсөлттэй хөгжлийн хувилбар
Улс	<ul style="list-style-type: none">Дээрхтэй адилхан.Уул уурхайн салбар болон уул уурхайн ханган нийлүүлэгчдийн салбарт ажилгүйдэл нэмэгдсэнээс хөдөө орон нутгаас төв суурин газар руу (ялангуяа Улаанбаатар) шилжиж, нүүх явдал нэмэгдэнэ. Мөн нөхцөл байдалд дургүйцэх явдал гарч, нийгмийн тогтворгүй байдал нэмэгдэнэ.	<ul style="list-style-type: none">Мэргэшсэн техникийн ажилчдыг Улаанбаатар болон уурхайн туршлагатай бусад бүс нутгаас эсвэл зөвхөн Улаанбаатарт юмуу гадаадад суралцаж эзэмшсэн зарим онцгой дээд мэргэжлийн ажилтнуудыг авч ажиллуулж байна. Орон тооны өндөр мэргэжсэн мэргэжилтнүүд Улаанбаатарт суурьшиж, онгоцоор ирж буцан ажлаа хийхийг илүүд үздэг.МСҮТ болон түүнээс дээд мэргэжлийн сургуулийн шинэчлэл хараахан явагдаж дуусаагүй ба салбарын мэргэжлийн стандарт, мэргэжлийн ерөнхий шаардлагууд, эзэмшсэн байх ерөнхий үр чадварууд мөн тодорхой бус байгаа. Хувийн хэвшийнхэн энэ орон зайг нөхөн ажилласаар байгаа бөгөөд тулгараад байгаа мэргэжлийн ажилчдын дутагдлыг нөхөх тал дээр хүчин чармайлт гарган ажиллаж байна.	<ul style="list-style-type: none">Уул уурхайн үйлдвэрлэл болон бусад хангамж үйлчилгээний салбаруудад мөн адил шинээр олон төрлийн ажил хөдөлмөр эрхлэх боломж нээгдэнэ. Ажилчдын үр чадвар ба хөдөлмөр эрхлэлтэнд өндөр өсөлттэй хувилбарын нөлөөлөх цэвэр нөлөө нь эерэг байна.



4.4.3.2 Улс, аймаг, сумын түвшинд үзүүлэх нөлөөллийн эрчим

Ажлын байрны нөхцөл, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн үр чадварт өндөр болон бага өсөлттэй хувилбараас дараах нөлөөллийг үзүүлж болзошгүй байна. Үүнд:

- Бүсийн болон орон нутгийн хэмжээнд бий болсон ханган нийлүүлэлтийн сүлжээ гэх мэт уурхайн салбарын хөгжлийн нөлөөгөөр шууд, шууд бус, өсөлтийн нөлөөгөөр үүссэн ажлын байрууд шинээр гарч ирэх;
- Уурхайн талбар дээр аюулгүй ажиллахад тавигдах ерөнхий шаардлага, мэдлэгийг эзэмшсэн ажилтныг бэлтгэх, уурхайн салбарын хөгжилд чиглэсэн зохих эх үүсвэр, техникийн нөөц бүхий сургалт, боловсролын төвүүдийн хүртээмжтэй байдалд нөлөөлөх;
- Уурхайд болон түүнтэй холбоотой гарсан ажлын байранд ажиллахаар бүсийн болон аймгийн төвүүд рүү нүүдэллэн ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх;
- Салбар дахь өрсөлдөөний улмаас уурхайн компаниуд болон тэдгээрийн сайн ажил олгогч гэсэн нэр хүндтэй байхад нь нөлөөлөх;
- Хувийн болон улсын уурхайн байгууллагуудын хоорон дахь мэргэжилтэй ажилтнуудын шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх;
- Улаанбаатарт бус байрлалтай МСҮТ болон дээд мэргэжлийн байгууллагуудын сургалтын үйл ажиллагааны чанарт нөлөөлөх, ингэснээр хүн амын бараг гуравны хоёр хувийн боловсрол олж авах боломжийг нэмэгдүүлж улс орон даяар үйлчилгээний салбарын хөгжлийг дэмжинэ (Бертельсманн сан, 2014).

Өндөр өсөлттэй хувилбар: Өндөр өсөлтийн үед Монголд явагдаж буй уурхайн үйл ажиллагааны онцлогт тохирсон сүүлийн үеийн тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт хийх гэх мэтээр Монголын уул, уурхайн салбарт дутагдаж байгаа мэргэжилтэй боловсон хүчний орон зайг зохих ёсоор нөхөхөд эх үүсвэрийг зохистой зарцуулна. Гэхдээ үүнийг мөн мэргэжилтэй ажиллах хүч илүү богино хугацаанд бэлтгэгдэж гарах боломжтой болно гэж ойлгож болохгүй.

Монгол ажилчдад хөдөлмөрийн зах зээл дээр нээлттэй, эрэлттэй байгаа ажилд орохын тулд зохих сургалтанд суухыг шаардахын хажуугаар шууд уурхайн салбарт ажиллах ажлын байрууд нэмэгдэнэ. Өөр нэг хувилбар нь мэргэжил шаардаагүй ажлуудад орон нутгийн иргэдийг авч ажиллуулдаг хандлага нь хэвээр байсаар байх ба ингэснээр салбараас орох нийт үр ашгийн хэмжээг хязгаарлаж, үр дүнд нь энэ хэрэгцээг хангах гадны ажиллах хүчний тоо нэмэгдэнэ.

Хоёрдогч болон нэмүү өртгийн зах зээл, түүнчлэн бие даан нийлүүлэлт хийдэг хувийн аж ахуйн нэгжүүдийн нийлүүлэлтийн сүлжээ бий болгох, хангамжийн бодлогыг дэмжсэн орон нутгийн болон бүсийн засаг захиргааны бодлого нь шууд бус ажлын байруудад нөлөөлнө. Салбар эрчимтэй хөгжинө гэдэг нь ЖДҮ болон нэмүү өртгийн зах зээлийн өсөлтийг дэмжих нөөц байгааг харуулна. Цаашлаад хангамж, нийлүүлэлтийн сүлжээ болон нэмүү өртгийн зах зээлийн төвүүд (аймгийн эсвэл бүсийн) нь шууд бус ажлын байрны эх үүсвэр болж өгнө. Энэ нь уурхайн салбарын хөгжилд (Засаглал ба орлогын менежмент хэсгийг үзнэ үү) тулгуурласан Засгийн газрын дэмжлэг (газар ашиглалтын төлөвлөлт, инженерийн болон нийгмийн дэд бүтэц, сайн засаглалын бүтэц гэх мэт) ихээр шаардагдана гэсэн үг. Энэ мэт эдийн засгийн үүсмэл үр ашгуудыг зохистойгоор нэмэгдүүлж чадах эсэхэд амжилтын үндэс оршино.



Салбарын хөдөлмөрийн нөхцлийн ерөнхий шаардлагуудыг хангахын хажуугаар хөдөлмөрийн нөхцөл ихээхэн ялгаатай болж ирнэ. Өөр өөр байршил, хэмжээ, шинж чанар бүхий уурхайн үйл ажиллагаатай байгууллагын дотоод нөөц бололцоо, тавьж буй шаардлагаас хамаараад уурхай бүр өөр өөрийн гэсэн стандартуудтай байна. Эрчимтэй өсөлт нь уурхайн зарим нэг таатай хөгжлийг авч ирэхийн хажуугаар, хяналт, шалгалтын тогтолцоо сул байвал зальтай компаниудад хуулиас гадуур аашлахыг оролдох боломж олгоно. Энэ нь Засгийн газрын болон иргэний нийгмийн байгууллагууд албан болон албан бус хяналтын тогтолцооны үүргээ гүйцэтгэх чадавхийн өсөлтөөс эрчимтэй өсөлтийн хэмжээ хурдацтай байх үед тохиолдоно.

Нөгөө талаас мэргэжилтэй болон тууштай ажиллах хүчнээ хадгалаж үлдэх гэсэн компаниуд зөвхөн хуульд заасан наад захын шаардлагуудыг хангахаас илүү зүйлийг хөдөлмөрийн нөхцлийн тал дээр амлаж хэрэгжүүлэх нь уурхайн салбарт ажиллах монгол ажилчдад тавигдах стандартыг ч ерөнхийд нь өндөрсгөнө.

Бага өсөлттэй хувилбар: Мэргэжлийн ерөнхий шаардлага хангасан уурхайн салбарын ажиллах хүчнийг бэлтгэхийн тулд сургалт, боловсролын материаллаг баазад зарцуулах хөрөнгийн хэмжээг тодорхойлсон, шаардлагатай хэмжээгээр нь батлуулсан байх ёстой. Салбар даяар мэргэшсэн ажилтны хэрэгцээ бага байх нь мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр, сургалтын байгууллагуудаа сайтар төлөвлөж, давхардуулан сургах болон хэрэгцээгүй мэргэжлээр сургаж хөрөнгө гарздахаас зайлсхийхийг шаардаж байна.

Хэдийгээр улс орон даяар тархмал байдалтай олон тооны жижиг уурхайнуудын ажлын байрыг нийлүүлсэнтэй харьцуулахад стратегийн ордууд ажлын байрны ихэнх хувийг бүрдүүлж байгаа ч уурхайн салбарт шууд хөдөлмөр эрхлэлт уурхайтай хэдэн сумдаар хязгаарлагдана. Цаашлаад олон улсын уул уурхайн салбарын сайн жишээг авсан стратегийн ордууд нийлүүлэлтийн сүлжээ/орон нутгийн нөөцөд тулгуурласан хангамжийн үйл ажиллагааг дэмжсэнээр шууд болон шууд бус хөдөлмөр эрхлэлтийн боломж нэмэгдэнэ гэсэн үг. Засгийн газар дангаараа ижил хэмжээний үр нөлөөг бий болгох хангалттай эх үүсвэргүй тул иргэний нийгмийн байгууллага болон Засгийн газартай нягт хамтарч ажиллах нь хамтын ажиллагааны шугамаар шууд болон шууд бус ажлын байрыг нэмэгдүүлэх шаардлагыг бий болгоно.

Өндөр өсөлтийн үед уурхайн компаниуд ажиллах хүч татах, байгаа ажилчдаа тогтоон барихын тулд хөдөлмөрийн нөхцлөөрөө бие биенээсээ ялгарч өрсөлдөх бол бага өсөлтийн үед үйл ажиллагаа явуулж байгаа жижиг уурхайнуудын хөдөлмөрийн нөхцөл муудахгүй. Энэ нь зөвхөн ашигтай нөхцлүүд (өндөр цалингаас гадна) санал болгохоос гадна, нэр хүнд нь сайн байхын хэрээр компанийн үйл ажиллагаанд учрах саад бэрхшээл багасах, ажилчдын хүртэх урамшуулал, хөдөлмөрийн таатай нөхцөл нэмэгдэх зэргээр илэрч болох юм. Өндөр өсөлтийн үед уурхайн салбарт ажиллах монгол ажилчдад тавигдах шаардлага өндөрсөнө.

Нөлөөллийн хураангуй

Бага өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Уурхайн салбарт мэргэжилтэй ажилтны эрэлт буурна.Шууд хөдөлмөр эрхлэлтийн тоо уурхайн бүтээн байгуулалт бүхий сумдад хязгаарлагдмал байна.Шууд бус хөдөлмөр эрхлэлтийн үр ашгийг олж харахад ЗГ болон иргэний нийгмийн байгууллагууд хоорондын идэвхтэй хамтын ажиллагаа шаардагдана.
Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none">Хөдөлмөрийн болон ажлын байрны ерөнхий нөхцөл хангагдсан байх ба бусад тэтгэмж, халамж хүртэх эсэх нь тодорхой ажил, мэргэжлийн өнөөгийн зах зээл дээрх эрэлт, ажил олгогч бүрийн үзэмжээс шалтгаална.



	<ul style="list-style-type: none"> Өндөр үр чадвартай ажиллах хүчин Улаанбаатарт сууршин, онгоцоор ирэх, онгоцоор буцах байдлаар ажилдаа ирж очихыг илүүд үзнэ. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон дээд боловсролын тогтолцооны шинэчлэлт хийгдэж хараахан дуусаагүй байхтай холбогдуулан салбарын ажил мэргэжилд тавигдах ерөнхий шаардлага, эзэмшсэн байх гол үр чадварууд тодорхойгүй хэвээр байна. Хувийн хэвشلүүд энэ цоорхойг нөхсөөр байх ба ажил, мэргэжлийн шаардлагыг хангахын тулд хоёр дахин их хүчин чармайлт гаргана.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none"> Уурхайн салбарт дутагдаад байгаа мэргэжил, үр чадварыг нөхөхөд чиглэсэн эх үүсвэрийг зохих ёсоор хуваарилах боломжтой болно. Уурхайд шууд хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ. ЖДҮ болон өртөг нэмсэн үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгөтэй болно. Ажлын байрны нөхцөл эрс өөр өөр байх болно. Богино хугацаандаа бүтээн байгуулалтын явц нь үйл ажиллагааг хянах төрийн байгууллага болон иргэний нийгмийн нөөц, чадавхи сайжрах түвшингээс хурдацтай байна.

4.4.3.3 Хөдөлмөр эрхлэлт ба үр чадвар: Арга хэмжээний зөвлөмжүүд

Хүснэгт 4.27 Хөдөлмөр эрхлэлт ба үр чадвар: Арга хэмжээний зөвлөмжүүд

Арга хэмжээний зөвлөмж	
<ul style="list-style-type: none"> ЖДҮ-ийг дэмжих бичил зээлийн хүртээмжийг улам бүр нэмэгдүүлэх ЖДҮ-ийн сургалт явуулах Олон улсын мэргэжлийн боловсролын байгууллагууд, их дээд сургуулиудийн түншлэлийг дэмжих 	
Сум	<ul style="list-style-type: none"> ЖДҮ-ийг дэмжих бичил зээлийн хүртээмжийг улам бүр нэмэгдүүлэх. ЖДҮ-ийг хөгжүүлэхэд санхүүгийн удирдлага, шаардлагатай зөвшөөрөл авах, тендерт оролцох, төслийн санал бэлтгэх зэрэг мэргэжлийн чадвар эзэмшүүлэх сургалт явуулах. Уул уурхайн компаниудтай хамтран ажиллаж байсан, эсвэл бүтээгдэхүүн нийлүүлж байсан ЖДҮ-ийн орон нутгийн тэргүүн туршлага, арга барилыг хөхиүлэн дэмжих (Жишээ нь, жуулчлал, хөдөө аж ахуйн бизнес, уурхайн хаалтын дараа уул уурхайн дэд бүтцийг ашиглах, г. м.). Сумын түвшинд хөдөөгийн хөгжлийн төслүүдийн тоог нэмэгдүүлсэнээр уул уурхайгаас орох орлогыг уул уурхайн бус салбарт ажлын байрыг нэмэгдүүлэхэд ашиглах замаар эдийн засгийг төрөлжүүлэх.
Аймаг	<p>Дээр дурдсанаас гадна:</p> <ul style="list-style-type: none"> Тухайн аймаг, сумын онцлог болсон бүтээгдэхүүнийг тодотгосон “Нэг аймаг/Сум – нэг бүтээгдэхүүн” зэрэг санаачилгыг дэмжих. Ийм санаачилгуудыг уул уурхайн салбарын эрэлттэй уялдуулах.
Улс	<p>Дээр дурдсанаас гадна:</p> <ul style="list-style-type: none"> Үндэсний хэмжээнд хөдөөгийн хөгжлийн бодлогыг хөхиүлэн дэмжиж мэргэшсэн залуу мэргэжилтнүүд хөдөө орон нутагт ажиллахыг урин дуудах амьдралын тав тух, ажлын орчинг бий болгох. Энэхүү бодлогод орон сууцжуулалт, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хөгжил, татварын хөнгөлөлт, хөдөөгийн нэмэгдэл болон хөнгөлөлт, татаас зэргийг оруулж болох юм. Дээд боловсролын чанар болоод ажлын байран дахь бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор олон улсын мэргэжлийн боловсролын байгууллагууд, их дээд сургуулиуд, хувийн байгууллагуудын түншлэлийг дэмжин, санхүүжүүлэх. Их, дээд сургуулиуд Улаанбаатараас гадагш, аймгийн төвүүдэд салбараа нээн ажиллах нөхцлийг дэмжих. Их, дээд сургуулиудын болон үйлдвэрлэлийн салбар хоорондын харилцааг сайжруулах. МСҮТ, их, дээд сургуулиудын сургалтын одоогийн хөтөлбөрт дадлагын цагийг нэмэж төгсөгчдийн ажлын байран дахь бэлэн байдлыг дээшлүүлэх. Монгол улсад стандартын шаардлага хангасан МСҮТ-ийн үйл ажиллагааг дэмжих, аж үйлдвэрлэлийн салбарын оролцоотойгоор төгсөгчдийн эзэмших, мэдлэг, үр чадварын шаардлагыг тодорхойлох.



4.4.4 Технологи

4.4.4.1 Нөлөөлөл ба хувилбаруудын танилцуулга

Уул уурхайн болон ашигт малтмал боловсруулах технологийн хөгжил нь Монгол улсын бүхий л салбарт байгаль орчин, эдийн засгийн ихээхэн хувь нэмрийг оруулна. Уул уурхайн салбарын технологийн хөгжилд дараах зүйлс багтаж болно. Үүнд:

- Ус их хэмжээгээр ашигладаг ялангуяа нүүрс угаах үйлдвэр, буталж тээрэмдэх ажиллагаатай, хөвөх болон шүлт ашигладаг үйлдвэрийн усыг дээд хэмжээнд дахин ашиглах технологи хэрэглэх. Өтгөрүүлэгч, шүүлтүүр болон шахах технологи ашиглах нь хаягдлын нягтралыг нэмэгдүүлж ус дахин боловсруулах ажиллагааг сайжруулан, ус уурших, шүүрэх алдагдлыг мэдэгдэхүйц бууруулна.
- Хатуу хучилтгүй уурхайн замын тоосжилтыг бууруулахад ус бага ашиглах эдийн засгийн засгийн үр ашигтай органик полимер болон бусад холбогч бодис ашиглах нь тээвэрлэлтээс үүсэх тоосжилтыг бууруулах технологийн шийдэл байж болно.
- Эрчим хүчний бусад эх үүсвэрийг ашиглалтын хугацаа нь харьцангуй богино байдаг олборлох үйлдвэрлэлд ашиглах нь салхи, нарны эрчим хүч үйлдвэрлэх хөрөнгө оруулалтын өндөр өртөгөөс хамааран үргэлж хязгаарлагдмал байдаг. Нарны дулааны эрчим хүч, салхины турбин үүсгүүр зэрэг сайжруулсан технологи ашиглавал ялангуяа алслагдсан уурхайн орчмын нутгийн иргэдийн дунд эрэлт нэмэгдэх хэрээр илүү тохиромжтой байж юм.
- Нүүрсийг баяжуулан шингэн болон хийн түлш үйлдвэрлэх дэвшилтэт технологийг Монголд бий болгох нь хямд үнэтэй түлш үйлдвэрлэн дотоодын хэрэгцээг хангахын зэрэгцээ байгаль орчинд ээлтэй утаагүй, бүрэн шаталттай түлш хэрэглэх боломжийг бүрдүүлнэ. Бүрэн шаталттай, хямд үнэтэй түлш дотооддоо бий болгох нь түүхий нүүрс түлж халаадаг зуухнаас үүдсэн Улаанбаатар хотын агаарын чанарын асуудлыг шийдэх бодит шаардлагатай холбоотой.
- Дахин боловсруулах, хаягдлыг бууруулах, эрчим хүч, химийн бодис бага ашиглах замаар олборлох болон баяжуулах технологийг хөгжүүлж ашигт малтмалын бүтээгдэхүүнд өртөг нэмэгдүүлэх ихээхэн боломж байна. Ашигт малтмалын бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлэх нь Монголд илүү их орлого оруулна. Хог хаягдал боловсруулах, дахин боловсруулан ашиглах дэвшилтэт технологи Монголд хөгжөөгүй бөгөөд энэ чиглэлийн технологийг хөгжүүлэх эрэлт хэрэгцээ үйлдвэрлэлийн салбарт бага байв. Сүүлийн арав гаруй жилийн хугацаанд уул уурхайн өсөлттэй холбоотойгоор аюултай хог хаягдлыг боловсруулах, зайлуулах технологийн эрэлт хэрэгцээ гарч байна.

Технологийн асуудлуудыг оролцогч талуудтай хийсэн зөвлөлдөх уулзалтын үеэр хэлэлцэж уул уурхайд дэвшилтэт технологи хэрэглэх нь уг салбарын өсөлтөнд шууд нөлөөлнө гэсэн ерөнхий ойлголтонд хүрсэн. Дэвшилтэт технологи ашиглах нь уг салбарын эдийн засгийн хүчин зүйлээс бүхэлдээ хамааралтай буюу үйл ажиллагаа явуулж байх хугацаанд дээрх өндөр хөрөнгө оруулалтын зардлыг эргүүлэн олох нарийн төвөгтэй шаардлага болон уул уурхайн бүтээгдэхүүний үнэ тодорхойгүй хэлбэлзэж байдгаас хамааралтай. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулинд ус дахин ашиглах, дахин боловсруулах болон ус нөөцлөх технологи

хэрэглэхэд урамшуулал үзүүлдэг байхаар саяхан оруулсан өөрчлөлт нь байгаль орчинд ээлтэй технологи ашиглахыг дэмжихэд түлхэц болсон. Үүнтэй ижил агаар, усны хаягдал, эрчим хүчний төлбөрийн зохицуулалтаар дамжуулан технологийн санаачилгыг чиглүүлэх боломжтой. Эцэст нь, дэвшилтэт технологи ашигласнаар оролцогч талуудын хувь нэмэр, үйл ажиллагааг ажиглах, удирдах, програм хангамж ашиглах, уурхайн төлөвлөлт хийхдээ газар зүйн мэдээллийн систем ашиглан уурхайн зориулалтаар ашиглах газрын хэмжээг багасгах зэрэг нийгмийн нөлөөллийг илүү сайн удирдах, бууруулах хэрэгсэл болж чадна.



Хүснэгт 4.28 Оролцогч талуудын тодорхойлсон технологитой холбоотой эн тэргүүний асуудлууд

Түвшин	Бага өсөлттэй хөгжлийн хувилбар	Дундаж өсөлттэй хөгжлийн хувилбар	Өндөр өсөлттэй хөгжлийн хувилбар
Эн тэргүүний асуудлууд:			
• Эрчим хүчний хэмнэлттэй, орчин үеийн уул уурхайн үйлдвэрлэл (олборлох, баяжуулах), хог хаягдлын технологийг ашиглах			
Сум	<ul style="list-style-type: none">Эдийн засгийн өсөлт удаан, уул уурхайн үйл ажиллагаа бага үед санхүүжилт, хөрөнгө мөнгөний асуудал үүсч, ногоон технологийг хөгжүүлж, ашиглахад анхаарах явдал багасна.	<ul style="list-style-type: none">Энэ түвшинд дурдагдаагүй.	<ul style="list-style-type: none">Энэ түвшинд дурдагдаагүй.
Аймаг	<ul style="list-style-type: none">Дээрхтэй адилхан.	<ul style="list-style-type: none">Энэ түвшинд дурдагдаагүй.	<ul style="list-style-type: none">Өндөр өсөлт нь Монголын уул уурхайн салбарыг ногооруулах технологийг боловсруулж, нэвтрүүлэх хөшүүрэг болох бөгөөд уул уурхайн салбарт хаягдал усыг боловсруулж ашиглах, ашигт малтмалыг боловсруулах, химийн бодисын ашиглалт, өөр бусад инженерийн арга шийдлийг нэвтрүүлнэ. Энэ нь уул уурхайн компаниуд технологи болон олон улсын туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт хийж, ЗГ-ын зүгээс ийм технологийг дэмжсэнээр үр дүн гарна.
Улс	<ul style="list-style-type: none">Дээрхтэй адилхан.	<ul style="list-style-type: none">ЗГ-аас уул уурхайд ногоон, болон дэвшилтэт технологийг ашиглахыг дэмжиж буй нь дундаж өсөлтийн хувилбар дахь нэг эерэг хүчин зүйл боловч ийм технологийг нэвтрүүлэх үйл ажиллагаа жигд бус, мөн боловсролын байгууллагуудын шинжлэх ухаан, технологийн суурь дутмаг байгаа байдал энэ санаачилгыг хязгаарлана.	<ul style="list-style-type: none">Дээрхтэй адилхан.Дээр нь, БОНХЯ ногоон технологийг хөгжүүлж, боловсруулж, нэвтрүүлэхэд идэвхтэй дэмжлэг үзүүлнэ.



4.4.4.2 Улс, аймаг, сумын түвшинд үзүүлэх нөлөөллийн эрчим

Уул уурхайн технологийг өндөр өсөлттэй хувилбарын үед үр ашгийг дээшлүүлэх, байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулахуйц байдлаар төлөвлөх нь аймаг, үндэсний түвшинд ихээхэн чухал юм. Дунд болон бага өсөлттэй хувилбаруудын үед өндөр технологийн эрэлт хэрэгцээ дотооддоо судалгаа, шинжилгээ явуулахад хангалттай бус байх учраас тийм таатай нөхцөл бүрэлдэх боломж бага байна. Түүнчлэн, өндөр өсөлттэй хувилбарын үед орон нутагт уул уурхайн салбар нөлөөллийг бууруулахад дэвшилтэт технологийг түлхүү ашиглана гэсэн хүлээлт бий болно. Хууль эрх зүй, зохицуулалтын орчныг сайжруулснаар агаар, усны хаягдлын стандартад нийцэх дэвшилтэт технологи ашиглах боломж нэмэгдэх ба мөн, нийгмийн болон байгаль орчны нөлөөллийг илүү сайн зохицуулахад одоогоор ашиглагдаж буй зураглал, газар зүйн мэдээллийн системийн аргуудыг илүү ихээр ашиглах боломж олдоно. Өндөр өсөлттэй хувилбарын үед түүнчлэн, уул уурхайн салбар боловсрол, судалгааны байгууллагуудад хөрөнгө оруулалт хийснээр дотооддоо судалгаа шинжилгээ хийх нөхцлийг бүрдүүлэхэд илүү түлхэц өгнө. Үндэсний боловсролын салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэх нь дотоодын шинжээч, мэргэжилтнүүдийг хөгжүүлэн технологи болон судалгаа шинжилгээг дэмжиж улмаар олон улсын зах зээлд гарах нөхцлийг өргөжүүлэх боломжтой.

Нөлөөллийн хураангуй

Бага / Дундаж өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none"> Дотоодын түвшинд судалгаа шинжилгээ явуулах технологийн эрэлт хэрэгцээ бага байх тул энэ боломжийг ашиглах магадлал доогуур байна.
Өндөр өсөлттэй хувилбар	<ul style="list-style-type: none"> Орон нутагт уул уурхайн салбар нөлөөллийг бууруулахад дэвшилтэт технологийг түлхүү ашиглана хэмээх хүлээлт ихэснэ. Хууль эрх зүй, зохицуулалтын орчин сайжирснаар технологийн дэвшилд хөтөлнө. Боловсрол, судалгааны байгууллагуудад уурхайн салбараас хөрөнгө оруулалт хийснээр дотооддоо явуулах судалгаа, шинжилгээ нэмэгдэнэ.

4.4.4.3 Технологи: Арга хэмжээний зөвлөмжүүд

Хүснэгт 4.29 Технологи: Арга хэмжээний зөвлөмжүүд

Арга хэмжээний зөвлөмж	
<ul style="list-style-type: none"> Өртөг багатай технологийн судалгааг гүнзгийрүүлэх Инженерчлэлийн компаниудтай уул уурхайн салбар олон улсын түншлэл тогтоох 	
Сум	
Аймаг	
Улс	<ul style="list-style-type: none"> Хямд өртөгтэй, практик ач холбогдолтой, богино хугацаанд хэрэгжүүлж болох технологийн судалгаа шинжилгээнд хөрөнгө оруулалт хийхийг дэмжих замаар уул уурхайн үйл ажиллагааны дүнд бий болох нөлөөлөл, тэр дундаа агаар, усны бохирдлыг бууруулах. Нүүрс, нүүрсний хий болон түүхий нефтийн бүтээгдэхүүнээс дотоодын хэрэгцээний хямд үнэтэй, цэвэр эрчим хүчний бүтээгдэхүүн боловсруулах судалгаа шинжилгээ, технологийн хөрөнгө оруулалтанд урамшуулал олгох. Инженерингийн компани болон уул уурхайн байгууллагуудтай олон улсын хэмжээнд түншлэн мэргэжилтэн сургах, дадлагажуулах замаар технологи дамжуулахад анхаарах. Эрчим хүч, усны үр ашигтай зарцуулалтыг сайжруулах болон уурхайн бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх явдлыг нэмэгдүүлэх технологийн хөрөнгө оруулалтыг цаашид хөхиүлэн дэмжиж, урамшуулал үзүүлэх.

4.5 ДҮГНЭЛТ


4-р бүлэгт бид өмнөх бүлэгт тайлбарласан уул уурхайн хөгжлийн хувилбаруудтай холбогдон үүсэх эн тэргүүний асуудлуудыг авч үзэн холбогдох нөлөөлөл, тэдгээр нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмжийг тодорхойлохыг зорилоо. Дараагийн хэсэг буюу 5-р бүлэгт энэ бүлэгт тодорхойлсон арга хэмжээний зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд тулгарах одоогийн хууль эрх зүй, институцийн орчны дутагдал, сул талыг үнэлэх юм.



5. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ИНСТИТУЦИ БА ЧАДАВХИЙН ДУТАГДАЛ, СУЛ ТАЛЫГ ТОДОРХОЙЛОХ ДҮН ШИНЖИЛГЭЭ БА БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖҮҮД

5.1 ОРШИЛ

4-р бүлэгт уул уурхайн салбарын хөгжлийн 3 хувилбартай холбогдон үүсэх эн тэргүүний асуудлуудыг авч үзсэн ба мөн эдгээр 12 эн тэргүүний асуудлуудыг шийдвэрлэхэд авч болох арга хэмжээний зөвлөмжүүдийг тодорхойллоо. Уг асуудлуудаас шалтгаалан хэр их нөлөөлөл үүсэх нөлөөллийн эрчмийг Хүснэгт 4.2-т мөн харуулав. Энэхүү БОНСҮ-ий хүрээнд эдгээр асуудлыг шийдвэрлэх (хэрэв тухайн асуудал нь эерэг байх бол эерэг нөлөөллийг нь улам нэмэгдүүлэх) цогц “бодлогын зөвлөмж”-үүдийг боловсруулахыг зорьсон бөгөөд бодлогын зөвлөмжүүд нь хууль эрх зүйн орчин, институцийн тогтолцоог сайжруулах, өөрчлөлт оруулах, эсвэл дагалдах хүний болон байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд чиглэгдсэн байх юм. Бодлогын зөвлөмжүүдийг нарийвчлан тодорхойлохын өмнө одоо байгаа хууль эрх зүй, зохицуулалтын орчин, институцийн хүрээнд байгаа сул тал, дутагдлыг ойлгох шаардлагатай. Ингэснээр 4-р бүлэгт тодорхойлсон арга хэмжээний зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд хууль эрх зүй, институци, чадавхийн талаас ямар хүндрэл, дутагдал, сул тал байгааг илрүүлэх юм. Эн тэргүүний асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний зөвлөмжүүд, хэрэгжүүлэх зохицуулалтын орчны сул тал, дутагдал болон бодлогын зөвлөмжүүд хоорондын уялдааг 5.1-р зурагт жишээгээр харуулав.



Зураг 5.1 Эн тэргүүний асуудлууд, арга хэмжээний зөвлөмж, сул тал, бодлогын зөвлөмжүүд хоорондын уялдааг харуулсан жишээ

БОНСҮ-ий эхний үе шатанд хийгдсэн нөхцөл байдлын үнэлгээний явцад дээрх зохицуулалтын орчны сул талуудыг анх тодорхойлсон ба улмаар 2-р үе шатанд (“байгаль орчин, нийгмийн эн тэргүүний асуудлууд”) сайжруулж, дараагаар нь 2014 оны 6 дугаар сарын 12-нд Улаанбаатарт болсон үндэсний зөвлөлдөх уулзалтын үеэр хэлэлцүүлэн эцэслэсэн юм. Энэ бүлэгт эдгээр сул талуудыг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн сонгосон 12 асуудал тус бүр, мөн хувилбар тус бүрт холбогдох байдлаар нь авч үзэх болно. Мөн эдгээр сул талуудыг нөхөх, шийдвэрлэх бодлогын зөвлөмжүүдийг мөн санал болгов.



Хавсралт С (БОНСУ-ий Үйл ажиллагааны хөтөлбөр)-д тодорхойлсон бүх сул талуудыг оруулсан ба хууль эрх зүйн орчин, чадавхийг сайжруулах, эсвэл нөөц/хөшүүргийг бий болгох дэмжлэг шаардсан эсэхээр нь эрэмбэлэн харуулав.

5.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛУУД

5.2.1 Ус

Хүснэгт 4.2-т харуулснаар өндөр өсөлттэй хувилбарт маш их, дундаж өсөлтийн хувилбарын хувьд мөн нилээд их нөлөөлөл устай холбоотойгоор үүсэхээр байгаа ба усны хэрэгцээ их биш байх тул усны асуудлын нөлөөллийн эрчим нь бага өсөлттэй хувилбарын хувьд бага байх төлөвтэй байна.

Устай холбоотой 3 гол асуудлаар (усны нөөцийн ашиглат, гидрологийн горимын өөрчлөлтүүд, усны түвшний багасалт, малчдын худгийн хүртээмж) хууль эрх зүйн орчин, чадавхийн дутагдал, сул талууд байна гэж үзлээ. **Хамгийн гол 2 сул тал нь усны баримжаат нөөц, хэрэглээний талаарх мэдлэг, мөн олон нийтийн оролцоонд түшиглэсэн хяналт шинжилгээг хэрэгжүүлэх чадавхитай холбоотой байна.** Сүүлийн үеийн судалгаагаар сонгосон зарим аймгийн усны эрэлт хэрэгцээг тодорхойлсон байдаг. Өдийг хүртэл усны нөөцийн судалгаанууд нэг төслөөс нөгөө төслийн хүрээнд явцуухан хийгдэж байв. Эл байдлыг шийдвэрлэх нэг оролдлого нь Усны нөөц 2030 тайланд³² орсон судалгаа юм. Гэхдээ усны эрэлт хэрэгцээний (мөн усны нөөцийн) төсөөллийг улсын болон бүс нутгийн түвшинд тогтмол шинэчлэх хэрэгцээ хэвээр байна. Уг төсөөлөл таамаглал нь дундаж болон өндөр өсөлтийн хувилбарын аль алинд хийгдэх шаардлага байгаа юм.

Дүн шинжилгээ хийн **тодорхойлсон хууль эрх зүйн орчны өөр нэгэн сул тал нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн хяналт шинжилгээг хэрэгжүүлэх** явдал юм. Төрийн байгууллагад алслагдсан хөдөө орон нутагт хяналт тавих нөөц бололцоо тэр болгон байхгүй тохиолдолд уул уурхайн компаниудын үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн үр дүнг үнэлэхэд иргэдийн оролцоог хангах нь нэн чухал байна. Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995) болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)-д иргэдийн оролцоотой хяналт шинжилгээг гүйцэтгэх, тухайн хяналт шинжилгээний үр дүнг үйл ажиллагаандаа тусгах талаарх зохицуулалтууд ороогүй байгаа билээ.

Усны менежментийн чиглэлээрх чадавхийн гол сул тал нь усны талаарх мэдээлэлтэй холбоотой асуудал байна. Жишээ нь, уул уурхайн зориулалтаар их гүний уст давхаргаас ашиглаж буй усны хэмжээнээс шалтгаалан малчид, иргэдийн ашигладаг бага гүний уст давхаргад үзүүлэх нөлөөллийн талаарх шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээлэл байхгүй байгаа юм.

Дээрх сул тал, дутагдлыг шийдвэрлэх бодлогын зөвлөмжүүдийг Хүснэгт 5.2.1-д харуулав. Эдгээр зөвлөмжүүдэд хууль эрх зүйн орчныг шинэчлэх, чадавхийг бэхжүүлэх санаачилгууд багтаж байгаа ба уул уурхайн салбарт усны асуудал ихээхэн чухал тул энэхүү санал болгож буй зөвлөмжүүдийг **хамгийн эн тэргүүнд** хэрэгжүүлэх шаардлагатай.

³² Прайсвотерхаускуперс. 2014. Монгол дахь усны нөөцийн менежментийн асуудлуудын талаарх зорилтот шинжилгээ: 2030 Water Resources Групп. Энэтхэг: PWC.



Хүснэгт 5.1 Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Ус

Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Сул талыг нөхөх бодлогын зөвлөмж
Усны нөөцийн ашиглалт	Өсөлт өндөр байх тохиолдолд ирээдүйд хүндрэл үүсэх тул аймгуудад бий болох усны ирээдүйн эрэлт хэрэгцээг тодорхойлох.	Аймаг	Дундаж Өндөр	(i) усны нөөцийн шинж төлөв, (усны нөөцийн судалгааг үндэсний хэмжээний төлөвлөлтийн хүрээнд бус хэрэгжих гэж буй төсөл дээр алдаг оног хийдэг); (ii) уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй усны ирээдүйн эрэлтийн төсөөллийн талаар бүрэн дүүрэн ойлголт дутмаг.	5 жил тутамд: (i) үндэсний хэмжээний усны нөөцийн судалгаа; (ii) үндэсний хэмжээний усны эрэлтийн судалгаа гэсэн 2 төрлийн иж бүрэн судалгааг хийх.
	(i) Бүх уурхайд усны тоолуур ашиглуулдаг болгох. (ii) Усны хяналт шинжилгээнд иргэдийг оролцуулах.	Аймаг	Бага Дундаж Өндөр	Нутгийн иргэдийг усны хяналт шинжилгээнд оролцох боломжоор хангасан эрх зүйн зохицуулалт байхгүй.	Нутгийн иргэдийг усны хяналт шинжилгээнд оролцуулах зохицуулалт бүхий өөрчлөлтийг байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой хууль, журамд оруулах.
Гидрологийн нөхцлийн өөрчлөлт	Газрын дооорх усны орон зайн тархалтын (хэвтээ, босоо) талаарх илүү дэлгэрэнгүй (тоо хэмжээ, чанар) мэдээллийг бүрдүүлэх, усыг үр ашигтай болон дахин ашиглах боломжийг судлах.	Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	Уул уурхайд ашиглахад тохиромжтой газрын доорх усны нөөцийн талаарх ойлголт муу. Уул уурхайн үйл ажиллагаанд их гүний уст давхаргаас ус ашигласаны улмаас нутгийн иргэд, малчдын хэрэглэж буй бага гүний уст давхаргын усны түвшин доошлох асуудлаарх ойлголт мэдлэгийн зөрүүтэй байдал.	Голуудын сав газрыг шаардлагатай судалгааг хийх эх үүсвэр, чадавхитай болгох.
Усны түвшин доошлох болон малчдын худаг ашиглалт	Малчдын ашиглаж буй худгийн хяналт шинжилгээнд нутгийн иргэдийг оролцуулах оролцоонд түшиглэсэн байгаль орчны хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Сум	Дундаж Өндөр	Оролцоонд түшиглэсэн хяналт шинжилгээг зохион байгуулах, хэрэгжүүлэх чадавхи сул.	Оролцоонд түшиглэсэн хяналт шинжилгээг дэмжих үүднээс Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийг дагалдуулан холбогдох журмыг боловсруулах.

5.2.2 Газар ба бэлчээр ашиглалт

Одоогийн нөхцөл байдлын үнэлгээнд газартай холбоотой 4 чухал асуудлыг тодорхойлсон ба үүнд, хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөөлөл, бэлчээрийн алдагдал, газар болон хөрсний чанарын доройтол, газар ашиглалтын зориулалт өөрчлөгдөх, үржил шим буурах асуудал орж байна. Усны асуудлын адил, газар ашиглалтын хувьд дундаж болон өндөр өсөлттэй хувилбарын үед ихээхэн нөлөөлөл үүснэ хэмээн оролцогч талууд тодорхойллоо (Хүснэгт 4.2).

Хууль эрх зүйн орчин, чадавхи, нөөц/хөшүүрэгтэй холбоотой хэд хэдэн дутагдал, сул тал байгааг Хүснэгт 5.2-т харуулав. Эдгээр тодорхойлсон сул талын ихэнх нь 3 хувилбарт бүгдэд хамаарах ба сум, аймгийн түвшинд голчлон хамааралтай. **Бэлчээрийн газрыг эзэмшүүлэх, бэлчээрийн менежментийн талаарх эрх зүйн орчны тодорхой зохицуулалт дутмаг байгаа асуудал нь хамгийн гол сул тал** болж байна. Үүнд, газрыг албадан чөлөөлөх талаарх хууль эрх зүйн орчин бүрдээгүй, мөн дээр нь задгай бэлчээрийг эзэмших эрх малчдад



байхгүй байгаа асуудал орно. Төрийн өмчийн бэлчээрийн газрыг мэдчид үнэгүй ашиглаж байгаа тул бэлчээрээ хамгаалах хөшүүрэг тэдэнд үүсэхгүй байна. Мөн, уул уурхайн нөлөөлөлд өртсөн газраас малчдыг нүүлгэн шилжүүлэх, бэлчээрээ алдсаны нөхөн төлбөрийн талаарх эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Түүнчлэн, **менежментийн төлөвлөгөөтэй холбоотой өөр олон дутагдал, сул тал** байна. Жишээ нь, компаниудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг газар ашиглалтын тухайн жилийн төлөвлөгөөтэй уялдуулахыг шаардсан эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа, цаашлаад, **тээврийн дэд бүтцийн болон газар ашиглалтын төлөвлөлтийн байгууллагуудын хоорондын уялдаа зохицуулалт сул** байна.

Нөөц, хөшүүргийн хувьд, хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулах төсөв орон нутгийн захиргаанд хомс байдгаас гадна газрыг төлбөргүй ашигладаг, мөн бэлчээрийг хамгаалах асуудлаар хариуцлага тооцохгүй байгаа нөхцөлд бэлчээрээс илүү ашиг хүртэж байгаа их малтай малчдад бэлчээрээ зааглан албажуулах хөшүүрэг үүсэхгүй байна.

Бэлчээр ашиглах эрхийг тодорхой болгох талаар нилээд олон бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байгаа (Хүснэгт 5.2) бөгөөд бусад хоёр хувилбартай харьцуулахад өндөр өсөлттэй үед газар ашиглалттай холбоотой маргаан илүү их гарахаар байгаа юм. Усны асуудлын адилаар газар ашиглалт Монголын нөхцөлд ихээхэн чухал тул санал болгож буй зөвлөмжүүдийг мөн **эн тэргүүнд** хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 5.2 Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Газар ба бэлчээр ашиглалт

Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж
Тусгай хамгаалалттай газарт үзүүлэх нөлөө	Бизнесийн хөгжил саарах үед хууль бусаар ан хийх, мод огтлох байдлыг нэмэгдүүлэхгүй байхад Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа анхаарч ажиллах нь зүйтэй.	Сум Аймаг	Бага	Эрсдэл: Орон нутгийн төсвийн орлого буурсаны улмаас тусгай хамгаалалттай газарт үйл ажиллагааг хэвийн явуулах орон нутгийн засаг захиргааны төсөв дутагдаж болзошгүй.	Эх үүсвэрийг нэн шаардлагатай арга хэмжээнд ашигладаг болгохын тулд төсвийн ил тод байдлыг сайжруулах.
	Тусгай хамгаалалттай бүс нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулахгүй байх үүднээс Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны зохистой удирдлагыг хэвшүүлэн хэрэгжүүлэх.	Сум Аймаг	Өндөр	Орон нутгийн тусгай хамгаалалттай/хэрэгцээний газрын хил заагийн солбицол нарийвчлан тогтоогдоогүй.	Уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглох бүс нутгийг тогтоох талаар хэрэгжүүлж буй санаачилгыг эцэслэн олон нийтэд мэдээлэх.
Бэлчээрийн талхлагдал, алдагдал	Шаардлагатай бол төрийн өмчийн бэлчээрийн удирдлага, ашиглалтын чиглэлээр оролцогч бүх талууд түүний дотор малчид, тэдний нутаг усныхан, орон нутгийн засаг захиргааны үүрэг, хариуцлагыг тодорхой болгосон бодлого, хуулийг улам бүр боловсронгуй болгох.	Улс	Бага Дундаж Өндөр	Малчид төрийн өмчийн бэлчээрийг үнэ төлбөргүй ашигладаг нь бэлчээрийг хамгаалах, үр ашигтай ашиглах хөшүүргийг алдагдуулж байна.	Бэлчээрийн үр дүнтэй менежментийн хууль эрх зүйн үндсийг бий болгох.
	Газар ашиглах, эзэмших, өмчлөх эрхийг хамгаалах.	Сум	Бага Дундаж Өндөр	Задгай бэлчээрийг малчдын бүлэгт түрээсээр эзэмшүүлэх эрх баталгаажуулахгүй.	Задгай бэлчээрийг малчдын бүлэгт түрээсээр эзэмшүүлэх эрх олгох хууль тогтоомжийг боловсруулан батлах.



Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж
	Уурхайн шууд нөлөөллийн бүсээс малчдыг нүүлгэх, байгалийн нөөц ашиглах боломжоо хязгаарлуулснаас алдсан алдагдалд нь нөхөн олговор олгох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх.	Улс	Бага Дундаж Өндөр	Уул уурхайн шууд нөлөөллийн бүсээс малчдыг нүүлгэн шилжүүлэх, тэдэнд бэлчээрээ алдсаны нөхөн олговор олгох хууль эрх зүйн орчин бүрдээгүй.	Уул уурхайн салбарт нүүлгэн суурьшуулалтын үйл ажиллагаа, түүний дотор нөлөөлөлд өртсөн хүмүүст олгох нөхөн олговрыг зохицуулах хууль, журмыг боловсруулах, хэрэгжүүлэх.
	Бэлчээр ашиглалтын уламжлалт эрхийг бүртгэх, бэлчээрийн ачаалал нэмэгдэж байгаагийн улмаас малчдын дунд бэлчээрийн газрын талаар маргаан үүсэхээс зайлсхийхийн тулд сумын түвшинд малчдын өөр өөр бүлгүүдийн ашиглаж буй задгай бэлчээрийн хилийг тодорхойлох.	Сум	Бага Дундаж Өндөр	Бэлчээр ашигласны төлбөр, бэлчээрийг хамгаалах хариуцлагыг огт хүлээлгэхгүй байгаа өнөөгийн нөхцөл олон толгой малтай малчдад илүү ашигтай байгаа учраас өөр өөр малчдын бүлгүүдийн ашиглаж буй бэлчээрийг зааглан тогтоохыг дэмжих хөшүүрэг тэдэнд байхгүй байна.	Задгай бэлчээрийг малчдын бүлэгт түрээсээр эзэмшүүлэх эрх олгох хууль тогтоомжийг боловсруулан батлах.
	Бэлчээрээс үүдэлтэй зөрчилдөөнөөс сэргийлэх, бэлчээр хамгааллыг сайжруулах үүднээс задгай бэлчээрийг малчдын бүлэгт түрээсээр эзэмшүүлэх эрх олгох.	Улс	Бага Дундаж Өндөр	Задгай бэлчээрийг малчдын бүлэгт түрээсээр эзэмшүүлэх эрх баталгаажуулахгүй.	Задгай бэлчээрийг малчдын бүлэгт түрээсээр эзэмшүүлэх эрх олгох хууль тогтоомжийг боловсруулан батлах.
	Уул уурхайн үйл ажиллагаанд хөндөгдсөн газрын хяналт шинжилгээнд малчдыг оролцуулах оролцоонд түшиглэсэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хөхиүлэн дэмжих.	Сум	Дундаж Өндөр	Уул уурхайн үйл ажиллагааны бодит буюу жинхэнэ нөлөөллийн талаар нутгийн хүмүүст зохих ёсоор мэдээлдэггүй, иргэдийн оролцоотой газрын хяналт шинжилгээний тухай хууль эрх зүйн зохицуулалт байхгүй.	Оролцоонд түшиглэсэн хяналт шинжилгээг дэмжих үүднээс Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийг дагалдуулан холбогдох журмыг боловсруулах.
	Уул уурхайн нөлөөллийг бууруулах, бэлчээрийн удирдлагыг сайжруулахын тулд малчдын бүлэг байгуулах ажлыг хөхиүлэн дэмжих.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	Малчдын бүлгээр дамжуулан бэлчээрийн удирдлагыг сайжруулах талаарх хууль эрх зүйн орчин бүрдээгүй.	Бэлчээрийн зүй зохистой менежментийн хууль эрх зүйн үндсийг бий болгох.
	Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хүрээнд нутгийн иргэдийн оролцоотойгоор бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний хүрээнд уялдуулан боловсруулах асуудлыг онцолсон журам байхгүй.	Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг тооцон тусгах үүднээс сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулах журмыг эргэн харах.
Газар, хөрсний чанарын доройтол	Уурхайн бүх талбайд нөхөн сэргээлтийг хийлгэх, нөхөн сэргээлт хийлгүйгээр орхих явдлыг гаргуулахгүй байх.	Сум Аймаг	Бага	Нутгийн иргэдийг газрын нөхөн сэргээлтийн хяналт шинжилгээнд оролцуулах заалт хууль журманд байхгүй.	Ашигт малтмалын одоогийн хуулийн уурхайн хаалтын төлөвлөгөөний тухай заалтанд нутгийн иргэдийн саналыг оруулах заалтыг оруулах.
	Зайлсхийх, бууруулах, сааруулах арга хэмжээ авсан хэдий ч бууруулж чадаагүй уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах замаар сааруулах арга хэмжээний ил тод санаачлагыг хэрэгжүүлэх.	Аймаг Улс	Дундаж Өндөр	Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны журам байхгүй.	Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны журмыг боловсруулах, хэрэгжүүлэх.



Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж
	Уул уурхай, тээврийн шинэ бүтээн байгуулалтанд хөрс хамгаалах дизайн, технологи түүний дотор хатуу хучилттай зам, төмөр зам, уурхайн байнгын нөхөн сэргээлт, хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, замгүй газраар явдаг тээврийн хэрэгслийг хориглох, хэрэглэж болох тохиолдолд хөрс тогтворжуулах технологийг ашиглах хөшүүрэгтэй болгох	Улс	Дундаж Өндөр	Арга хэмжээ явагдах хөшүүрэг байхгүй байна.	Хөшүүргийг бий болгох бодлого, аргачлалыг боловсруулах.
	Хөрсний чанарт үндэслэн уул уурхайн үйл ажиллагаанд тохиромжтой газрыг тогтоож, төлөвлөх	Улс	Бага Дундаж Өндөр	Хөрсний чанарын талаар мэдээлэл өгөх хөрсний чанарын үндэсний хэмжээний үнэлгээний систем, мэдээллийн сан байхгүй	Бизнесийн хөгжил болон бүсийн төлөвлөлтийг дэмжих үндэсний хэмжээний хөрсний чанарын үнэлгээний тогтолцоог бий болгох
Газар зохион байгуулалт, хөрсний үржил шимийн өөрчлөлт	Уул уурхайн компаниудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан арга хэмжээг сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж хянах, тайлагнах.	Сум	Бага Дундаж Өндөр	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй нийцүүлэх заалт, шаардлага байхгүй учраас энэ хоёр баримт бичиг уялдаа холбоогүй байна.	(i) Уул уурхайн компаниуд байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулахдаа сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг харгалзан тусгах шаардлага тавих нэмэлт өөрчлөлтийг БОНБУ-ий хуулийн дагуу холбогдох журамд оруулах. (ii) Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөг (Ашигт малтмалын хуулиар ийм шаардлага тавигддаг) оролцогч талуудтай зөвлөлдөн боловсруулах шаардлагыг оруулах нь зүйтэй.
	Уурхайн дэд бүтцийн улмаас хөрсний эвдрэл, бэлчээрийн доройтол үүсэх нь малчид, нутгийн иргэдийн санааг зовоосон асуудал болж байгааг анхааралдаа авах үүднээс тээврийн төлөвлөлтийн хүрээнд газар зохион байгуулалт, хөрс хамгаалах зорилтуудыг уялдуулан нэгтгэх.	Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	Тээврийн дэд бүтцийн төлөвлөлт болон газар зохион байгуулалтын төлөвлөлтийн байгууллага хоорондын уялдаа холбоо сул.	Төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг сайжруулах.

5.2.3 Агаарын чанар

Дундаж өсөлттэй хувилбарын үед сумын түвшинд агаарын чанар хамгийн чухал асуудал буюу агаарын чанарын нөлөөллийн эрчим хамгийн их байгааг Хүснэгт 4.2 харуулж байна. Түүнчлэн өндөр өсөлттэй үед агаарын бохирдол (тоосжилт) ихээхэн санаа зовоосон асуудал болохоор байгаа ч ашигт малтмал болон бусад бараа бүтээгдэхүүн тээвэрлэх замыг хатуу хучилттай болгох, эсвэл төмөр зам тавих хэмжээний орлоготой байх тул агаарын чанарын нөлөөллийг урт хугацаанд бууруулна гэж үзэж байна. **Төлөвлөлтийн байгууллагуудын чадавхи доогуур байгаа нь гол сул тал** болж байна (Хүснэгт 5.3). Агаарын бохирдлын асуудлыг шийдвэрлэхээр

жишээлбэл, уурхайн орчин дахь агаарын чанарын доройтолтой холбоотойгоор газар ашиглалтын төлөвлөгөөг сайжруулах, тоосжилтын нөлөөлөлд өртсөн газруудыг тодорхойлох, нөлөөллийн бүсээс иргэдийг нүүлгэн шилжүүлэх зэрэг хариу арга хэмжээ авч болох юм. Оролцогч талуудын хэлж байгаагаар газар ашиглалтын төлөвлөгөө боловсруулах явцад орон нутагт зөвлөгөөн хэлэлцүүлгийг зохих ёсоор явуулдаггүй, мөн газар ашиглалтын төлөвлөлтөнд бусад салбаруудын асуудлыг тооцдоггүй байна. Цаашлаад, **тээврийн дэд бүтцийн төлөвлөлт болон газар ашиглалтын төлөвлөлтийн байгууллагын хоорондын уялдаа холбоо сул байна.**

Агаарын чанартай холбоотой бодлогын зөвлөмжүүд бүгд чухал ч төлөвлөлтийн байгууллагын чадавхийг дээшлүүлэх асуудал бүх гурван хувилбарын хувьд хамгийн чухалд тооцогдож байна. Зохицуулалтын орчинтой холбоотой бодлогын нэг зөвлөмжийг дурдвал Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийг дагалдуулан орон нутгийн иргэдийн оролцоотой хяналт шинжилгээний аргачлалыг боловсруулах шаардлага болно. Энэхүү зөвлөмж нь ус болон газрын менежментийн асуудалд бас хамааралтай. Агаарын чанарыг сайжруулахтай холбоотой зөвлөмжүүд нь дунд, өндөр өсөлттэй хувилбарын үед ялангуяа сумдын түвшинд **эн тэргүүнд** хэрэгжүүлэх асуудалд тооцогдож байна.

Хүснэгт 5.3 Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Агаарын чанар

Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж
Уурхайн нөлөөллийн бүс орчмын агаарын чанарын доройтол	Хөрсний элэгдэл, тоосжилтыг бууруулдаг тээврийн төлөвлөлт, дэд бүтцийг хөхиүлэн дэмжих, жишээ нь, бүсийн тээврийн төлөвлөлт, хатуу хучилттай зам, төмөр зам г.м.	Улс	Дундаж	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах явцад орон нутгийн түвшинд иргэд, олон нийттэй ярилцаж, зөвлөлдөх ажиллагаа хангалттай сайн хийгддэгүй; Газар зохион байгуулалтын төлөвлөлтөнд салбарын уялдаа, нэгдмэл чанар байдаггүй;	Төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг сайжруулах.
	Ард иргэдэд замгүй газраар олон салаа шинэ зам гарган зорчиж байгаагийн хор нөлөөний талаарх ойлголт өгөх, орчны тоосны түвшинг хэмжих, түүнчлэн олон нийтийн оролцоог хангасан тоосжилтыг хянах оролцооны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх.	Сум	Бага Дундаж Өндөр	Нутгийн иргэд тоосжилтын хяналт шинжилгээнд оролцох боломжийг олгосон заалт байхгүй.	Нутгийн иргэдэд түшиглэсэн хяналт шинжилгээг дэмжих үүднээс Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийг дагалдуулан холбогдох журмыг боловсруулах.
	Уул уурхайн үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган бууруулах, уг төлөвлөгөөнд тоосны нөлөөллийн бүсийг тодорхойлох, нөлөөлөлд өртсөн хүмүүсийг нүүлгэн суурьшуулах арга хэмжээг уг төлөвлөгөөнд тусгах.	Сум	Бага Дундаж Өндөр	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах явцад орон нутгийн түвшинд иргэд, олон нийттэй ярилцаж, зөвлөлдөх ажиллагаа хангалттай сайн хийгддэгүй; Газар зохион байгуулалтын төлөвлөлтөнд салбарын уялдаа, нэгдмэл чанар байдаггүй;	Төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг сайжруулах



Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж
	Уурхайн дэд бүтцийн улмаас хөрсний эвдрэл, бэлчээрийн доройтол үүсэх нь малчид, нутгийн иргэдийн санааг зовоосон асуудал болж байгааг анхааралдаа авах үүднээс тээврийн төлөвлөлтийн хүрээнд газар зохион байгуулалт, хөрс хамгаалах зорилтуудыг уялдуулан нэгтгэх.	Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	Тээврийн болон газар зохион байгуулалтын төлөвлөлтийн байгууллага хоорондын уялдаа, зохицуулалт сул.	Төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг сайжруулах.
	Уул уурхайн үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган бууруулах, уг төлөвлөгөөнд тоосны нөлөөллийн бүсийг тодорхойлж тухайн газруудад (ашигт малтмалын тээврийн том замуудын ойролцоо г.м.) суурьшил бий болохоос урьдчилан сэргийлэх.	Сум	Бага Дундаж Өндөр	Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тоосжилтод өртөх бүсийг тогтоон тусгадаггүй.	Тоосжилтод өртөх бүсэд бүтээн байгуулалт явуулахгүй байх үүднээс сумын төлөвлөлтийн байгууллагын чадавхийг дээшлүүлэх, түүнчлэн тоосжилтод өртөөд байгаа бүсэд одоо амьдарч байгаа оршин суугчдыг нүүлгэн суурьшуулах чиглэлийг боловсруулах.

5.2.4 Байгаль орчны менежмент

Байгаль орчны менежменттэй холбоотой 5 асуудлыг чухалд үзсэн ба үүнд, уул уурхайн компаниудын менежментийн үйл ажиллагаа, байгаль орчны менежмент, нөхөн сэргээлт, биологийн олон янз байдлын алдагдал, хог хаягдлын хуримтлал орж байна. Эдгээрийн ихэнх нь зөвхөн дундаж болон өндөр өсөлтийн хувилбарт хамаатай. Энэхүү асуудлуудын хүрээнд тодорхойлсон сул талууд нь хууль эрх зүйн орчинтой холбоотой бөгөөд сум, аймаг, улсын түвшинд хамааралтай байгааг Хүснэгт 5.2.4-ээс харж болохоор байна. **Хамгийн гол сул тал нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу уул уурхайн компаниудын боловсруулдаг байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний нээлттэй байдлыг хангах эрх зүйн шаардлага дутмаг** байгаа явдал юм. Мөн үүнтэй адилаар, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулахад орон нутгийн иргэдийн оролцоог бий болгосон, эсвэл оролцоонд түшиглэсэн хяналт шинжилгээг гүйцэтгэх талаарх эрх зүйн зохицуулалт дутмаг байна. Уул уурхайгаас биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг сааруулахад онцгой ач холбогдолтой дүйцүүлэн хамгааллын асуудлыг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар зохицуулсан ч, үүнийг хэрэгжүүлэх талаар нарийн зохицуулалт, аргачлал байхгүйг оролцогч талууд дурдсан юм.

Нөхцөл байдлын үнэлгээний 2.5.4-р хэсэгт **байгууллагын хариуцлагатай холбоотой эрх зүйн орчинд бусад сул талууд** байгаа талаар дурдсан. Эдгээр нь:

- Засгийн газрын өөр өөр түвшний байгууллагуудын үүрэг, хариуцлагын талаарх тодорхойгүй байдал;



- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тайлагнах асуудлаар сум, аймгийн түвшинд МХЕГ-т найддаг одоогийн нөхцөл байдалд БОНХЯ-ны үүрэг, хариуцлагын тодорхой бус байдал;
- Нийгмийн үр нөлөөний талаарх хариуцлага тодорхой бус;
- Улсын хэмжээнд байгаль орчны мэдээллийн сан хангалтгүй байгаа зэрэг болно.

Хүснэгт 5.4-ээс харвал уул уурхайн компаниудын байгаль орчны менежменттэй холбоотой ихэнх зөвлөмжүүд нь хууль эрх зүйн орчинд өөрчлөлт оруулахад чиглэгдэж байна. Эдгээрт уул уурхайн компаниуд байгаль орчны менежментийн үйл ажиллагаагаа төлөвлөхдөө орон нутгийн олон нийтийг оролцуулах, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах талаар журам, аргачлал боловсруулах, нөлөөлөлд өртсөн нутгийн иргэдийг газрын нөхөн сэргээлт, биологийн төрөл зүйлийн хамгаалалд оролцуулвал уурхайн компаниудыг урамшуулах хөшүүргийг бий болгох зэрэг орно. Эдгээр зөвлөмжүүдийг мөн **эн тэргүүнд** хэрэгжүүлэх шаардлагатай болно.

Хүснэгт 5.4 Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Байгаль орчны менежмент

Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж
Уул уурхайн компаниудын байгаль орчны менежмент	Багийн хурлаар уул уурхайн компаниудын татвар төлөлт, орон нутгийг хөгжүүлэх чиглэлээр хийж буй ажил, санаачилгын талаар мэдээлэх замаар орон нутгийн удирдлагын зүгээс уул уурхайн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах.	Сум	Дундаж Өндөр	Энэ үйл ажиллагаанд мөрдөх журам, дүрэм байхгүй.	Холбогдох журам, зааврыг боловсруулах.
	Орон нутгийн захиргаанаас хяналт шинжилгээг илүү ойр ойр хийдэг байх.	Аймаг	Дундаж Өндөр	Уул уурхайн компаниудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавих хөрөнгө, хүч дутагдалтай.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянах үйл ажиллагаанд хуваарилах төсвийг нэмэгдүүлэх, сумын байгаль орчны байцаагчдыг чадавхижуулах.
	Нутгийн засаг захиргаатайгаа хамтран ажилласанаар нутгийн иргэд уул уурхайн компаниудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад оролцохыг дэмжих.	Сум	Бага Дундаж Өндөр	Нутгийн иргэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад оролцох асуудлыг зохицуулсан журам байхгүй.	(i) Нутгийн иргэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад оролцох бололцоо олгох нэмэлт өөрчлөлтийг БОНБУ-ий хуулийн дагуу холбогдох журманд тусгах. (ii) Ашигт малтмалын хуулинд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад талуудыг оролцуулах талаар заалт оруулах.



Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж
	Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөг батлуулахын өмнө олон нийт, нутгийн иргэдээр хэлэлцүүлэхээр нээлттэй мэдээлэх.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөг батлуулахын өмнө олон нийт, нутгийн иргэдээр хэлэлцүүлэхээр нээлттэй мэдээлэхийг хууль, журмаар шаарддаггүй.	i) Нутгийн иргэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад оролцох бололцоо олгох нэмэлт өөрчлөлтийг БОНБУ-ий хуулийн дагуу холбогдох журманд тусгах. (ii) Ашигт малтмалын хуулинд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад талуудыг оролцуулах талаар заалт оруулах.
Байгаль орчны журам	Дүйцүүлэн хамгаалах бодлогыг бэхжүүлэх.	Аймаг Улс	Дундаж Өндөр	Дүйцүүлэн хамгаалах асуудлыг БОНБУ-ий хуульд заасан хэдий ч нарийвчлан зохицуулсан журам, аргачлал байхгүй.	Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны журам, аргачлалыг боловсруулах.
Уул уурхайн компаниудын нөхөн сэргээлт	Нутгийн иргэдийг газрын нөхөн сэргээлт хийхэд татан оролцуулах хөшүүргийг уул уурхайн компаниудад бий болгох.	Сум	Дундаж Өндөр	Урамшуулал, хөшүүрэг байхгүй.	Хөшүүргийг бий болгох холбогдох журам, зааврыг боловсруулах.
Биологийн олон янз байдалд үзүүлж буй нөлөөлөл	Уул уурхайн компаниуд нутгийн иргэдийг биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах хөшүүргийг бий болгох	Сум	Дундаж Өндөр	Урамшууллын хөшүүрэг байхгүй.	Урамшууллын бодлого, журмыг боловсруулах.
Хог хаягдал	Аюултай хог хаягдлыг зайлуулах байгууламж байгуулах, уурхайн талбай дахь аюултай хаягдлыг зайлуулах асуудалд тавих хяналтыг сайжруулах.	Улс	Бага Дундаж Өндөр	Уул уурхайн салбараас гарч байгаа аюултай хог хаягдлыг зайлуулах байгууламж байдаггүй.	Аюултай хог хаягдлыг зайлуулах шаардлагад нийцсэн үндэсний хэмжээний байгууламж байгуулахад дэмжлэг үзүүлэх үүднээс бэлтгэл ажлын санхүүжилтийн зэрэгцээ урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

5.3 НИЙГМИЙН АСУУДЛУУД

5.3.1 Хувиараа болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа

Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг зохицуулах нь хүндрэлтэй асуудал болохыг Нөхцөл байдлын үнэлгээ буюу 2-р бүлэг, мөн 4-р бүлэгт өгүүлсэн ба тус салбарыг албажуулах талаар Монголд ч, олон улсад ч ихээхэн судалгаа хийгдсэнийг өмнө дурдсан билээ.

Судалгаанууд хийгдсээр байгаа хэдий ч асуудлууд байсаар байна. Авч үзэж буй 3 хувилбарын аль алинд шийдвэрлэх шаардлагатай бодлогын түвшний хэд хэдэн сул тал байгааг дурдвал бичил уурхайн салбарыг гадуурхах, үл тоомсорлох байдал, эдийн засгийн үр нөлөө, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны санаа зовоосон асуудлууд зэрэг нөхцөл байдлын үнэлгээнд



тодорхойлсон асуудлууд орно. Эдгээр нь 3 хувилбарт аль алинд нь хамааралтай бөгөөд голдуу сум, аймгийн түвшинд байгааг Хүснэгт 5.5-д харуулав.

Салбарын гадуурхагдсан байдалтой холбоотой **гол сул тал нь чадавхи, нөөцийн дутмаг байдал** юм. **Байгаа эрх зүйн зохицуулалтыг оновчтой хэрэгжүүлдэггүй**, мөн бичил уурхайн салбарт илүү сайн үр дүнд хүрэх улс төрийн эрмэлзэл байхгүй байна. Бичил уурхайтай холбоотой байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хянах нөөц, чадавхи төрийн албан хаагчдад байхгүй, сум, аймаг, улсын түвшинд босоо зохицуулалт болон туршлага солилцох явдал хомс гэж оролцогч талууд үздэг байна.

Уг салбартай холбоотой эдийн засгийн үр нөлөөллийн талаар 4-р бүлэгт тодорхойлсон 4 арга хэмжээний зөвлөмжүүд нь дөрвүүлээ тус салбарт ур чадварыг бий болгохыг чухалчилсан байна. **Бичил уурхайтай холбоотой чадавхийг бэхжүүлэхэд тулгарч буй гол сул тал нь үндсэндээ уг салбарын талаарх нийгмийн үзэл бодол юм.** Нийгэмд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг Монголын эдийн засагт хувь нэмэр болох байнгын салбар гэж хүлээн зөвшөөрөхгүй, харин ч түр зуурын үзэгдэл гэж ойлгож байна.

Эцэст нь, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны талаар 5 арга хэмжээний зөвлөмжийг 4-р бүлэгт тодорхойлж, Хүснэгт 5.5-д жагсаав. Үндсэндээ, эдгээр арга хэмжээний зөвлөмж нь бичил уурхайн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий газар олгох талаарх одоогийн байгаа эрх зүйн орчныг сайжруулах, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах тухай юм. Эхний зөвлөмжийн тухайд гэвэл, одоогийн зохицуулалтаар бичил уурхайн үйл ажиллагааг хуульчилсан тогтоол байдаг. Гэвч уг зохицуулалтыг хэрэгжүүлэхгүй байгаагийн учир нь бичил уурхайд зориулан олгох газар байхгүй, үйл ажиллагаа явуулахаар хүсэлт гаргасан газар нь тусгай зөвшөөрлийн талбай эсвэл улсын геологийн нөөц газартай давхцадагтай холбоотой. Дараагийн зөвлөмжийн тухайд бол, **төсвийн хомсдлоос болж хувиараа ашигт малтмал олборлогчдод эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, мөн эрүүл мэндийн тодорхой асуудлаарх ойлголт дутмаг зэрэг сул тал** байгаа юм.

Дээр дурдсанчлан хувиараа ашигт малтмал олборлох салбарт байдаг хамгийн гол бэрхшээлтэй тал нь уг салбарыг гадуурхах явдал юм. Чадавхи сул, нөөцийн дутмаг байдал мөн энэ салбарын сул тал болдог. Цаашлаад, одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, журмыг үндэсний хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлж чадахгүй байна. Хэрэгжүүлэх шаардлагатай бодлогын зөвлөмжүүдийг Хүснэгт 5.5-д жагсаасан бөгөөд эдгээр нь хувиараа ашигт малтмал олборлогчдын асуудлыг шийдвэрлэхэд төрийн агентлагуудын чадавхийг бэхжүүлэх, бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулсан одоогийн хууль, журмыг хэрэгжүүлэхэд голчлон чиглэлээ. Энэ нь өсөлтийн гурван хувилбарын аль алинд нь хамааралтай ба эдгээр санал болгож буй зөвлөмжүүдийг **дунд хугацаанд** хэрэгжүүлвэл зохино.



Хүснэгт 5.5 Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Бичил уурхай

Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж
Хувиараа ашигт малтмал олборлох салбарыг гадуурхах	Одоогийн хууль эрх зүйн зохицуулалтыг мөрдүүлэх замаар бичил уурхайн салбарыг улам бүр албажуулах.	Улс	Бага Дундаж Өндөр	Одоогийн хууль эрх зүйн зохицуулалтыг үр дүнтэйгээр мөрддөггүй. Бичил уурхайн салбарын хууль эрх зүйн орчин, салбарын үр өгөөжийг сайжруулах улс төрийн хүсэл зориг үндэсний хэмжээнд бага.	Одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомжийг дараах чиглэлээр судалж үзэх: <ul style="list-style-type: none"> ○ Үндэсний хэмжээнд БУ-н хэвийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөх асуудлыг хэрхэн сайжруулж болох; ○ УУЯ-ны бүтцэд бичил уурхайн асуудлыг тусад нь эрхэлсэн дэд сайдтай болох. Үүнд энэхүү үйл ажиллагаанд зориулагдсан төсвийн эх үүсвэр мөн багтана.
	Чадавхижуулах, туршлага солилцох, бичил уурхайн салбарын удирдлага, зохицуулалтыг хариуцсан төрийн албаны ажилтнуудын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх сургалтыг явуулах.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	Төрийн байгууллагын ажилтнуудын мониторинг, үнэлгээний чадавхи тааруу. Адил түвшний байгууллагуудын уялдаа, хамтын ажиллагаа, сум, аймгийн хооронд, улсын хэмжээнд мэдлэг, туршлагаасаа хуваалцах нь бага.	Төрийн байгууллагын ажилтнуудын бичил уурхайн салбарын асуудлаар ажиллах чадварыг сайжруулах.
Хувиараа ашигт малтмал олборлох салбарын эдийн засгийн нөлөөлөл	Хувиараа ашигт малтмал олборлох салбарын тогтвортой хөгжлийг дэмжих үүднээс уурхайн ажлын үр чадвар, мөнгөн ус хэрэглэхгүй байх зорилтот хөтөлбөрийг санхүүжүүлэх, нөхөрлөлийг албан ёсоор байгуулах.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	Бичил уурхайн салбарыг Монгол улсын эдийн засагт хувь нэмэр оруулж чадахуйц тогтвортой салбар хэмээн хүлээн зөвшөөрөхөөс илүү түр зуурын үзэгдэл гэж үздэгээс энэ салбарт зохистой санхүүжилтийн механизм, дэмжлэг байдаггүй.	Зорилтот хөтөлбөрүүдэд төсөв хуваарилах.
	Хувиараа ашигт малтмал олборлогч иргэд бусад салбарт хөдөлмөр эрхлэх чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	Төрийн байгууллагын ажилтнууд хувиараа ашигт малтмал олборлогчдод хүрч, хамтран ажиллах туршлага, чадвар дутмаг.	Хувиараа ашигт малтмал олборлогчдын асуудлаар ажиллах төрийн байгууллагын ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх.
Хувиараа ашигт малтмал олборлогчидтой холбоотой эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, байгаль орчны асуудал	Сургалт, дагалдуулан сургах замаар хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн байгаль орчны менежмент, нөхөн сэргээлт, аюултай бодис ашиглах чиглэлээр чадавхи, хариуцлагыг сайжруулах.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	Хувиараа ашигт малтмал олборлогчдын мэргэжлийн чадавхи сул, боловсрол тааруу, ЭМАА-ны асуудалд хяналт тавьж, удирдах санхүүгийн эх үүсвэр хүрэлцээгүй.	Чадавхийг бий болгох хөтөлбөрийг санхүүжүүлэх төсөв хуваарилах.



Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж
	Бичил уурхайн үйл ажиллагаанд зориулан газар хуваарилах тухай одоогийн мөрдөгдөж буй журмыг сайжруулах.	Улс	Бага Дундаж Өндөр	Одоогийн мөрдөгдөж буй журмаар бичил уурхайн салбарыг албажуулсан хэдий ч 2012 онд бичил уурхайд тохиромжтой ихэнх газруудыг геологийн хайгуул хийх зориулалтаар төрийн нөөцөд авсан тул шинээр талбай олгогдохгүй, цаашлаад энэ салбарт хууль, журмын дагуу үйл ажиллагаа явуулах боломж бүрдэхгүй байна.	Бичил уурхайн журмыг хэрэгжүүлэх нөхцлийг бий болгох.
	Хувиараа ашигт малтмал олборлогчдын эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах.	Улс	Бага Дундаж Өндөр	Орон нутгийн эмнэлгүүд төсөв хүрэлцэхгүйн улмаас хэвтэж эмчлүүлэх зэрэг эрүүл мэндийн үйлчилгээг хувиараа ашигт малтмал олборлогчдод үзүүлдэггүй, хувиараа ашигт малтмал олборлогчдод хүргэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах бодлого байхгүй.	Орон нутгийн эмнэлгүүдийн төсвийн хуваарилалтад хувиараа ашигт малтмал олборлогчдыг тооцох.

5.3.2 Соёлын өв

Нөхцөл байдлын үнэлгээг гүйцэтгэх үеэр тодорхойлсон соёлын өвтэй холбоотой 2 асуудал бол соёлын биет болон биет бус өв алдагдах эрсдэл юм. Эдгээр асуудлыг шийдвэрлэх 6 арга хэмжээний зөвлөмжийг 4-р бүлэгт тодорхойлж, Хавсралт С-д тусгав. Энэхүү арга хэмжээний зөвлөмжүүд нь нөөц, чадавхийг бий болгохтой холбоотой ба зөвхөн дундаж болон өндөр өсөлттэй хувилбарт хамаарч байна. Хүснэгт 4.2-ээс харахад биет бус өвд үүсэж болзошгүй нөлөөллийн эрчим дээрх хоёр хувилбарт хоёуланд нь өндөр байхаар байна. Харин дундаж, өндөр өсөлтийн үед биет соёлын өвд нөлөөлөл үзүүлэх эрсдэл байна. Арга хэмжээ зөвлөмжүүд нь соёлын өвийг хамгаалсан компаниудыг урамшуулах, Соёлын өвийг хамгаалах тухай хуультай нийцээгүй үйл ажиллагаа явуулвал торгууль ногдуулан гүйцэтгэх, соёлын өвийн дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх талаарх хамтын ажиллагааг хөгжүүлж, хамгаалалтанд авах газрыг иргэдийн оролцоотойгоор тодорхойлох зэрэг болно.

Эдгээр арга хэмжээний зөвлөмжийг авч хэрэгжүүлэхэд саад болох бодлогын сул тал байхгүй байна (Хавсралт С). Хариуцсан байгууллагуудын (голдүү ССАЖЯ, БОНХЯ, сумдын Засаг даргын Тамгын газрууд) гол хийх ёстой зүйл нь арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх явдал л юм.

5.3.3 Хүний эрх ба олон нийтийн оролцоо

Уул уурхайн салбарын үр нөлөөний талаар авч үзэхэд монголчуудын сэтгэл зовоосон асуудлын жагсаалтанд байгаль орчны асуудлын зэрэгцээ хүний эрх болон нийгмийн асуудал нилээн дээгүүр гарч ирдэг. Нөхцөл байдлын үнэлгээнд тодорхойлсон хүний эрх, нийгмийн холбогдолтой 2 асуудал нь "иргэд, олон нийтийн оролцоо ба хүлээлт", "олон нийтийн эрх" байсан ба эдгээрийг оролцогч талууд хэлэлцүүлгийн үеэр ихээхэн чухал болохыг нь баталгаажуулсан юм. Эдгээр асуудал нь хөгжлийн 3 хувилбарт гурвууланд нь хамаарч, дундаж болон өндөр өсөлтийн хувилбарт нөлөөллийн эрчим нь өндөр байхаар байна (Хүснэгт 4.2).

4-р бүлэгт олон нийтийн оролцооны талаарх санаа зовоосон асуудлуудыг шийдвэрлэх 5 арга хэмжээний зөвлөмжийг тодорхойлов. Эдгээр зөвлөмж нь голчлон зөвлөлдөх, хэлэлцүүлэх үйл ажиллагаанд чиглэж байгаа юм. Жишээ нь, “үр дүнтэй оролцоог хангахын тулд орон нутгийн иргэдэд хангалттай мэдээлэл өгөх”, мөн “олон нийтийг оролцуулах талаар сайн дурын гарын авлага” боловсруулах зөвлөмжүүд орж байна. Олон нийтийн эрхтэй холбоотойгоор өөр 5 арга хэмжээний зөвлөмжийг оролцогч талууд санал болгосон юм. Тэдгээрийн хамгийн гол нь нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааг хэвшүүлж стандартчлах, байгаль орчны зохицуулалттай нийцүүлэн нийгмийн асуудлыг тооцож тусгах журам боловсруулах, газрын уламжлалт эрхийн талаар компаниудын ойлголт мэдлэгийг дээшлүүлэх зэрэг болно.

Дээрх арга хэмжээний зөвлөмжүүдийг хэрэгцүүлэхэд саад болж байгаа зохицуулалтын орчны гол сул тал, дутагдлуудыг Хавсралт С-д оруулав. Эдгээр сул талын ихэнх нь мөн чанартаа хууль эрх зүй орчинтой холбоотой юм. Тэр дундаа **голдуу нүүлгэн суурьшуулах асуудлыг зохицуулах, нийгмийн үр дүн, иргэдийн оролцооны хууль тогтоомжтой** холбоотой байна. Жишээ нь, Монголд хүний эрхийн мэдлэг хомс, эрхийнхээ талаар иргэдийн мэдлэг бага байдаг хэмээн оролцогч талууд тодорхойлов. Түүнээс гадна, орон нутгийн иргэдтэй зөвлөлддөг хэлэлцүүлгүүд нэр төдий болж, өнгөцхөн мэдээлэл солилцохоор хязгаарлагдаж, оролцоо, хамтын ажиллагаа нь хүчин төгөлдөр гэхийн аргагүй байдаг гэжээ.

Хүний эрх болон нийгмийн арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаарх сул талуудыг арилгахаар санал болгож буй бодлогын зөвлөмжүүдийн ихэнх нь компаний нийгмийн хариуцлагатай холбоотой санаачилгыг дэмжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, мөн нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааг зохицуулах талд чиглэгдэж байна (Хүснэгт 5.6). Бүлэг 4-т заасанчлан эдгээр бодлогын зөвлөмжүүдийг **хамгийн эн тэргүүнд** хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хүснэгт 5.6 Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Хүний эрх ба олон нийтийн оролцоо

Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж
Нутгийн иргэдийн оролцоо, хүлээлтийг удирдах	Уул уурхайн үйл ажиллагааны талаарх шийдвэр гаргах үйл явцад нутгийн иргэдийн оролцоог сайжруулах, нутгийн иргэдэд хангалттай мэдээлэл өгч, мэдлэг, ойлголт, чиглэлтэйгээр оролцох бололцоог хангах	Сум	Бага Дундаж Өндөр	Нутгийн иргэдэд өнгөц мэдээлэл сонсгох төдийгөөр ёс төдий оролцуулдаг тул энэ нь жинхэнэ оролцоо буюу хамтын ажиллагаа болдоггүй.	Уул уурхайн салбарт нийгмийн хариуцлагын гүйцэтгэлийг зохицуулах хууль тогтоомжийг боловсруулах хэрэгжүүлэх, НҮБ-ын холбогдох олон улсын гэрээ, харгалзах салбарын жишиг стандартын (ОУСК, Аюулгүй ажиллагаа, Хүний эрхийн сайн дурын зарчмууд) заалтуудыг хэрэгжүүлэх.
	Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх.	Улс	Бага Дундаж Өндөр	Компаний нийгмийн хариуцлагын талаарх хууль эрх зүйн баримт бичиг байхгүй.	Компаний нийгмийн хариуцлагын талаарх хууль эрх зүйн баримт бичгийг гаргах.



Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж
	Компаний нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж болох үйл ажиллагааны тухай нутгийн иргэд, уул уурхайн компаниудын дунд нэгдмэл ойлголттой болгох.	Улс	Бага Дундаж Өндөр	Компаний нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж болох үйл ажиллагааны тухай нутгийн иргэд, уул уурхайн компаниудын дунд нэгдмэл ойлголтгүйгээс бизнест саатал үүсч, нутгийн иргэдийн хүртэх өгөөж нь бага байна.	Компаний нийгмийн хариуцлагын талаарх хууль эрх зүйн баримт бичгийг гаргах.
Нутгийн иргэдийн эрх	Уул уурхайн компаниудын явуулж буй нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааг стандартчлах.	Улс	Дундаж Өндөр	Монгол улсад нүүлгэн суурьшуулалтыг зохицуулах хууль эрх зүйн орчин бүрдээгүйгээс уул уурхайн компаниудын явуулж буй нүүлгэн суурьшуулах үйл ажиллагаанд эмх замбараагүй байдал, ялгавартай байдал үүсэхэд хүргэж байна.	Уул уурхайн салбарт нүүлгэн суурьшуулах үйл ажиллагаа, түүний дотор нөлөөлөлд өртсөн хүмүүст эрх тэгш, шударга нөхөн олговор олгох асуудлыг зохицуулах хууль боловсруулан хэрэгжүүлэх.
	Байгаль орчны өнөөгийн тогтоомж, журмуудад нийцүүлэн нийгмийн хариуцлагыг зохицуулах заалтуудыг нэмж оруулах.	Улс	Бага Дундаж Өндөр	Засгийн газраас байгаль орчны үр нөлөө бүхий хууль тогтоомжийг хэрэгжүүлэх сайн алхмууд хийсэн ч хүний эрх, нийгмийн асуудлыг хэрхэн зохицуулах тал дээр анхаарлаа хандуулаагүй, зохицуулалтууд дутмаг байна.	Уул уурхайн салбарт нийгмийн хариуцлагын гүйцэтгэлийг зохицуулах хууль тогтоомжийг боловсруулан хэрэгжүүлэх, НҮБ-ын холбогдох олон улсын гэрээ, харгалзах салбарын жишиг стандартын (ОУСК, Аюулгүй ажиллагаа, Хүний эрхийн сайн дурын зарчмууд) заалтуудыг хэрэгжүүлэх.
	Уламжлалт газар ашиглах эрх, газар ашиглах эрхийн төрлүүдийн талаарх уул уурхайн компаниуд болон олон нийтийн ойлголт мэдлэгийг сайжруулах.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	Монгол улсад хүний эрхийн талаарх ойлголт мэдлэг дутмаг, иргэд, уул уурхайн компаниудын аль аль нь өөрсдийн эрхийнхээ талаар нимгэн мэдлэгтэй байдаг.	Бодлогын зөвлөмж шаардлагагүй.
	Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр төлөвлөлтгүй үүссэн суурьшлын бүсэд амьдарч байгаа хүмүүсийг нийгмийн үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах.	Сум	Дундаж Өндөр	Шилжин ирэгсдэд нийгмийн үйлчилгээг хүргэхийн тулд уул уурхайн ойролцоох бүсэд байгаа хот, сууринд нэмэлт төсөв хуваарилагддаггүй.	Урт хугацаанд бүсийн төлөвлөлтийг боловсронгуй болгох, ойрын ирээдүйд уул уурхайн бүсийн ойролцоох хот, сууринд төсвийг нэмж хуваарилах.

5.3.4 Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа

Уул уурхайн салбар өргөжиж эхэлсэн 1990-ээд оноос хойш тус салбараас эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөлөл оролцогч талуудын хувьд байнга санаа зовоосон асуудал байсаар ирсэн байна. Энэ нь ялангуяа хувиараа ашигт малтмал эрхлэгчидтэй илүү холбоотой. БОНУ, байгаль орчны стратегийн үнэлгээний явцад эрүүл мэндийн асуудлыг зохистойгоор шийдэх талаар олон улсын хандивлагчид, Эрүүл мэндийн яамнаас ихээхэн шахалт үзүүлсээр иржээ.

Энэхүү БОНСУ-ий явцад эрүүл мэнд, аюулгүй ажиллагаатай холбоотой 3 гол асуудлыг оролцогч талууд хөндсөн байна. Эдгээр нь нутгийн иргэдийн ЭМАА, ажлын байран дахь ЭМАА ба малын

ЭМАА бөгөөд ялангуяа сумын түвшинд дундаж, өндөр өсөлтийн хувилбарын хувьд нөлөөллийн эрчим "их", эсвэл "дунд" байхаар байна.

Орон нутгийн түвшинд гол сул тал нь хууль эрх зүй, зохицуулалтын орчинтой холбоотой байгаа ба жишээ нь, **осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нөхөн төлбөр, нөхөн сэргээх эмчилгээний талаарх хууль, зохицуулалт байхгүй** байгаа юм. Үүний зэрэгцээ, уул уурхайгаас болж эрүүл мэндээр хохирсон иргэдэд уул уурхайн орлогоос санхүүждэг сөрөг нөлөөлөлд өртсөн нутгийн иргэдэд зориулсан эрүүл мэндийн тусгай сангаас тусламж дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байгаа ч Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар ийм сан байгуулах боломж байхгүй байна.

Хувь хүний ажлын байран дахь ЭМАА-ны хувьд **олон улсын уул уурхайн ЭМАА-ны сайн туршлагыг Монголд нэвтрүүлэх хэрэгцээ** байгаа талаар нөхцөл байдлын үнэлгээ, талуудын хэлэлцүүлэгт дурдагдсан. Олон улсын туршлагыг нэвтрүүлж байх талаар заалт, шаардлага байхгүй байгаа нь бас нэг сул тал, дутагдал юм. Үүнээс гадна, уул уурхайн салбарын ЭМАА-ны үйл ажиллагааг хянах **МХЕГ-ын байцаагчдын чадварыг асуудал бас нэгэн сул тал** болж байна.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн бодлогын дутагдалтай талуудыг шийдвэрлэх асуудлаар санал болгож буй зөвлөмжүүдэд зохицуулалтын арга хэмжээ, чадавхийг бэхжүүлэх санаачилгууд багтлаа. Ажлын байрны осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлд олгох нөхөн олговор болон нөхөн сэргээх эмчилгээний асуудлыг шийдвэрлэх хууль шаардлагатай байна. Түүний дээр уул уурхайгаас шалтгаалан эрүүл мэндийн сөрөг нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдэд зориулсан Эрүүл мэндийн тусгай сан байгуулах тухай Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлтээр оруулж болох юм. Түүнчлэн Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн тухай хуулийг олон улсын шилдэг туршлагын дагуу тогтмол шинэчлэх үйл ажиллагааг санаачлах тухай санал орууллаа. Чадавхийг бэхжүүлэх зөвлөмжүүд нь уурхайд шалгалт хийж буй мэргэжилтнүүд эрүүл мэндтэй холбоотой асуудлыг таньдаг, шийдвэрлэдэг чадвартай байхад сургах мөн зам барилга, байгууллагын төлөвлөлтөөр чадавхи бэхжүүлэхэд чиглэгдэнэ. Энэхүү бодлогын зөвлөмжүүдийг **хамгийн эн тэргүүнд** хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 5.7 Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа

Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж
Нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа	Осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нөхөн олговор, нөхөн сэргээх эмчилгээний тогтолцоог боловсруулан, хэрэгжүүлэх.	Улс	Бага Дундаж Өндөр	Тогтолцоо байхгүй.	Осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нөхөн олговор, нөхөн сэргээх эмчилгээний хууль, эсвэл журмыг боловсруулах.



Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж
	Нөлөөлөлд өртсөн олон нийтэд зориулсан Эрүүл мэндийн санг үндэсний хэмжээнд байгуулж, уул уурхайгаас орсон орлогоос нөлөөлөлд өртсөн иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн үйлчилгээг хүргэх үйл ажиллагааг санхүүжүүлэх.	Улс	Дундаж Өндөр	Нөлөөлөлд өртсөн олон нийтэд зориулсан эрүүл мэндийн санг байгуулах зохицуулалт байхгүй.	Уул уурхайгаас орсон орлогоос нөлөөлөлд өртсөн иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, нөлөөлөлд өртсөн нутгийн иргэдийн эрүүл мэндийг сайжруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх. Нөлөөлөлд өртсөн олон нийтэд зориулсан эрүүл мэндийн санг байгуулах нэмэлт өөрчлөлтийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд оруулах.
Ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа	Олон улсын тэргүүний туршлага, арга ажиллагааг одоогийн мөрдөж буй хуулиудад нэгтгэх	Улс	Бага Дундаж Өндөр	Нэгтгэн зангидах систем байхгүй.	Одоогийн мөрдөж буй хуулиудын хүрээнд бий болсон тэргүүний туршлага, арга ажиллагааг нэгтгэн зангидах үйл явцыг боловсруулах.
	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг чадавхижуулах.	Улс	Бага Дундаж Өндөр	Чадавхижуулах хөтөлбөр байхгүй.	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг чадавхижуулах хөтөлбөрийг боловсруулах.
Малын эрүүл мэнд, аюулгүй байдал	Мал зам хөндлөн гарах гарцыг төлөвлөх үүднээс малчдыг тээврийн төлөвлөлтөнд оролцуулах.	Сум Аймаг Улс	Дундаж Өндөр	Нэг мөр болж тогтсон зүйл үгүй.	Замын зураг төслийн болон төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх.

5.4 ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДЛУУД

5.4.1 Засаглал ба орлогын менежмент

Засаглал ба орлогын менежментийн асуудлууд нь сум, аймаг, улсын аль ч түвшинд хамаарах ба дундаж, өндөр өсөлттэй хувилбарт нөлөөллийн эрчим нь “дунд” зэрэг байхаар байна (Хүснэгт 4.2). 4-р хэсэгт уул уурхайн орлогын менежмент, мөн уул уурхайн эдийн засгийн ашиг нь бусад салбарт хэрхэн нөлөөлж байгаа асуудлуудын талаар дурдлаа.

Уул уурхайн орлогын хуваарилалт ил тод бус, уул уурхайтай сум, аймаг түүнээсээ шууд ашиг тус хүртэж чадахгүй байна гэсэн ойлголт байна. Өөрөөр хэлвэл, уул уурхайн төслөөс хөгжлийн болоод орлогын ямар ашиг тус олж, хүртэж байгааг орон нутгийн иргэд тэр болгон олж харахгүй байгаа юм.

Энэхүү асуудлыг зохицуулахтай холбоотой **сул талууд нь үндсэндээ мэдээлэл солилцоо, хэлэлцүүлэгтэй холбоотой** юм. Орон нутгийн түвшинд орлогод дүн шинжилгээ хийдэг систем байхгүй ба уул уурхайн орлогыг сум, аймагт нь эргүүлэн хуваарилах заалт хууль, бодлогын алинд ч байхгүй байна. **Орлогын менежментийн асуудлаар бодлого боловсруулах хүрээнд мөн дутагдал, сул тал** байна хэмээн үзлээ. Бодлого боловсруулах нь Засгийн газрын үүрэг гэж үздэг ба орон нутагтай зөвлөлдөн санаа бодлыг нь тусгах механизм муу хэрэгжиж байна. Мөн үүний дээр, Засгийн газар солигдоход аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөг залгамжлан үлдэх тогтолцоо сул байна.

Уул уурхайд хэт түшиглэсэн байдлаас үүссэн эдийн засгийн гажуудлыг анхаарах асуудал хэмээн оролцогч талууд тодорхойллоо. Монгол орон эрдэс баялгийн үйлдвэрлэлээр дагнаж байгаа нь

эрдсийн бус салбаруудын хөгжлийг сулруулж байна. Үүнийг “Голланд өвчин” гэдэг. Мөн үүний зэрэгцээ, **эрдсийн бус салбаруудыг хөгжүүлэх санхүүгийн болон хүний нөөцийн чадавхи аймаг, сумын түвшинд хангалтгүй** байгаа юм.

Хүснэгт 5.8-д засаглал болон орлогын менежментийн талаарх анхаарах шаардлагатай асуудлуудтай холбоотой бодлогын зөвлөмжүүдийн саналыг багтаасан болно. Зөвлөмжүүдийн ихэнх нь уурхайн нөлөөлөлд өртөх сум, аймгуудад орлогыг тэгш хуваарилах хууль эрх зүй болон бодлогын механизмын асуудлуудад чиглэж байна. Санал болгож буй өөр нэг зөвлөмж нь сум, аймаг, үндэсний түвшний хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах үйл явцад орон нутгийн иргэдийн оролцоог заавал хангах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх явдал юм. “Голланд өвчин”-өөс урьдчилан сэргийлэх, эдийн засгийг төрөлжүүлэхэд саад болж буй бэрхшээлийг шийдэх бодлогын нэг зөвлөмж нь бизнес шинээр эхлэх, барилгын зөвшөөрөл авах, цахилгаанд холбогдох, хилийн худалдаа хийх зэрэг үйл ажиллагааг хязгаарлаж буй эрх зүйн баримт бичиг, бодлогыг хянаж сайжруулах арга хэмжээ болно. Санал болгож буй бодлогын энэхүү зөвлөмжүүдийг **дунд хугацаанд** хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хүснэгт 5.8 Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Засаглал ба орлогын менежмент

Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж
Орлогын менежмент	Улс, аймаг, сумдын аль алины түвшинд баялгийн хуваарилалтын илүү үр нөлөөтэй, ил тод арга арга хэмжээг хэрэгжүүлэх. Үндэсний, аймаг болон сумын түвшинд ил тод байдал дээшилснээр орлогын хуваарилалтын талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болно.	Улс	Бага Дундаж Өндөр	Одоогийн байдлаар уул уурхайгаас орж байгаа орлогыг янз бүрийн түвшинд цуглуулан, зарцуулалт нь тодорхой бус, нутгийн иргэд, хүмүүст энэ талаар мэдээлдэггүй. Тиймээс нутгийн хүмүүс, иргэд уул уурхайн төсөл, хөгжил, орлогын өгөөжийн хоорондын холбоог тэр бүр олж харж чаддаггүй.	Улсын төсөв боловсруулах ажилд шинжилгээ хийх, аймгуудад оруулж буй хувь нэмрийг нь харгалзан төсөв хуваарилах хууль эрх зүйн үндсийг бүрдүүлэх, уул уурхайн орлогоос төсвийг нэмж хуваарилах замаар аймгуудад уул уурхайн компаниудтай хамтран ажиллах хөшүүрэг урамшууллыг бий болгох.
	Хөгжлийн бодлого, стратеги, төлөвлөгөөг боловсруулахдаа орон нутгийн удирдлага, иргэдэд мэдээлэн, саналыг авдаг байх, орон нутгийн түвшинд гаргасан бодлогын баримт бичгүүдийг үндэсний бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах механизмыг боловсруулан хэрэгжүүлэх.	Сум Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	Орон нутгаас мэдээлэл авч оруулах механизм сул, Бодлого боловсруулах ажлыг төрийн байгууллагын хариуцах асуудал гэж үздэг. Засгийн газар солигдоход аймгийн хөгжлийн бодлогыг бие даан тогтвортой хэрэгжүүлэх боломжгүй.	Сум, аймаг, үндэсний хөгжлийг төлөвлөхөд иргэд, холбоод, орон нутгийнхан оролцож, түүнтэй танилцан судалж, саналаа өгөхийг хуулинд оруулах.
	Уул уурхай ихээр хөгжин уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд илүү өртөж буй сум, аймгуудад нэмэлт төсөв хуваарилах.	Улс	Бага Дундаж Өндөр	Уул уурхайгаас орж буй орлогыг, орлого оруулснаар нь аймаг, сумуудад буцаан хуваарилах асуудлыг зохицуулсан заалт байхгүй.	Аймгуудын оруулсан орлогыг харгалзан төсөв хуваарилах хууль зүйн зохицуулалтыг бий болгох.
Макро эдийн засгийн нөлөө	Эдийн засаг, бизнесийг хөгжүүлэх цогц хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр эрдэс баялгаас бусад салбарыг аймаг, сумуудад дэмжин хөгжүүлэх.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	Эрдэс баялгаас бусад салбарыг аймаг, сумуудад хөгжүүлэхэд санхүү, хүний нөөцийн чадавхи дутагдалтай.	Эрдэс баялгаас бусад салбарыг хөгжүүлэх орон нутгийн чадавхийг сайжруулах.



5.4.2 Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц

Одоогийн нөхцөл байдлын үнэлгээнд бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэцтэй холбоотойгоор нийгмийн үйлчилгээ, дэд бүтцэд учрах нэмэгдсэн дарамт, уурхай орчмын бүсэд ирэгсдийн шилжилт хөдөлгөөн, бүс нутгийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, зэрлэг ан амьтдын нүүдэл, хөдөлгөөн гэсэн 4 чухал асуудлыг авч үзсэн билээ.

Нийгмийн үйлчилгээнд учирч буй нэмэлт дарамтын асуудал нь дундаж болон өндөр өсөлттэй хувилбарт, сум, аймгийн түвшинд голдуу хамааралтай байхаар байна. Үүнтэй холбоотойгоор, **газар ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах явцад зөвлөлдөх үйл ажиллагааг сайжруулах үүднээс чадавхийг бэхжүүлэх, мөн газар ашиглалтын төлөвлөлтөд салбар хоорондын уялдааг сайжруулах** арга хэмжээг санал болгож байгаа ба учир нь энэ тал дээр дутагдал, сул тал их байна гэж үзлээ.

Хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлын хувьд, том уурхайн ойролцоо газрын наймааг хязгаарлах үүднээс газар олголтыг илүү ил тод болгох, мөн уул уурхайн тусгай зөвшөөрлийг бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах хэрэгтэй гэж талууд үзсэн байна. Үүний зэрэгцээ, том уурхай болон хувиараа ашигт малтмал олборлогчид үйл ажиллагаа явуулж байгаа газруудад үүссэн албан бус суурингуудыг хянаж зохицуулах, дахин албан бус суурингууд шинээр бий болохоос урьдчилан сэргийлэх үүднээс уул уурхайн салбарын эрэлт хэрэгцээг хангасан бүсийн цогц хөгжлийн төлөвлөгөө боловсруулах шаардлагатай байна. Энэ асуудлаар үүссэн **сул тал нь бүс нутгийн төлөвлөлтөнд уул уурхайн салбарын хөгжлийн асуудал тусгагдаагүй, мөн газар олголт ил тод бүс байгаа** явдал юм.

Эцэст нь, бүс нутгийн дэд бүтцийн хөгжлийн асуудлын хувьд, улсын хэмжээнд төлөвлөлт, тээвэр, байгаль орчны байгууллагуудын хоорондын уялдаа зохицуулалт сул, орон зайн төлөвлөлтийн систем хөгжөөгүй учраас орон зайн төлөвлөлт сул дорой байгааг анхаарах шаардлагатай байна.

Санал болгож буй бодлогын зөвлөмжүүдийн ихэнх нь байгууллагын төлөвлөлтийн чадавхи болон төлөвлөлтийн системийг сайжруулахад чиглэгдсэн болохыг Хүснэгт 5.9-ээс харж болохоор байна. Бүс нутгийн төлөвлөлт болон тээврийн дэд бүтэцтэй холбоотой бодлогын зөвлөмжүүдийг **дунд хугацаанд** хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 5.9 Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц

Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж
Инженерийн дэд бүтэц болон нийгмийн үйлчилгээний ачаалал нэмэгдэх	Хот байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд уул уурхайн онцлог асуудал, байгаль орчин, нийгмийн талаар анхаарал татаж буй асуудлыг тусган олон нийтийн оролцоотойгоор сайжруулж, хэрэгжүүлэх. Одоогийн байгаа газар зохион байгуулалт болон хот байгуулалтын төлөвлөгөөний уялдааг сайжруулах.	Сум Аймаг Улс	Дундаж Өндөр	Газар зохин байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахад олон нийтэд мэдээлэн таниулах, хэлэлцүүлэх, тэдний саналыг авах ажиллагаа хангалтгүй хийгддэг. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг салбарын хэмжээнд зангиддаггүй.	Төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх.



Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж
Уул уурхайн хөгжлийн бүс дэх хүн амын шилжин хөдөлгөөн	Уул уурхайн орлогоос санхүүжих аймгийн түвшний дэд бүтэц, орон сууцны сан байгуулах.	Аймаг	Дундаж Өндөр	Уул уурхайгаас орох орлогоос аймгийн дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхийг зөвшөөрсөн заалт байхгүй.	Уул уурхайгаас орох орлогоос аймгийн дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлэхэд ашиглахыг зөвшөөрөх тухай заалтыг Төсвийн тухай хуульд оруулах.
	Уул уурхайн хөгжилтэй холбоотойгоор хүн ам олноороо шилжин ирж буй аймаг, сумдад дэд бүтэц, үйлчилгээг хүртээмжтэй хүргэхийн тулд уул уурхайгаас орж буй орлогоос нэмэлт төсөв хуваарилах.	Сум Аймаг	Дундаж Өндөр	Уул уурхайн бүс нутаг дахь шилжилт хөдөлгөөнийг сааруулахад нэмэлт төсөв хуваарилахыг зөвшөөрөх тухай заалт байхгүй.	Уул уурхайн бүс нутаг дахь шилжилт хөдөлгөөнийг зохицуулах бодлого боловсруулах.
	Бичил болон томоохон хэмжээний уурхайн үйл ажиллагаа аль аль нь явагдаж буй албан бус суурингуудыг хянах, уул уурхайн хэрэгцээг хангасан бүсийн цогц төлөвлөгөөг боловсруулсанаар албан бус сууринг шинээр үүсэхээс сэргийлэх.	Сум Аймаг	Дундаж Өндөр	Уул уурхайн хөгжлийг бүс нутгийн төлөвлөлтөнд зохих байдлаар авч үздэггүй.	Бүс нутгийн төлөвлөлтийг сайжруулах.
Бүсийн дэд бүтцийн хөгжил	Байгаль орчин нийгмийн асуудлаарх нөлөөллийг багасгахын тулд орон зайн төлөвлөлт, тээвэр, байгаль орчны асуудал хариуцсан байгууллагуудын уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулах	Улс	Бага Дундаж Өндөр	Орон зайн төлөвлөлтийн тогтолцоо сул, төлөвлөлт, тээвэр, байгаль орчны асуудал хариуцсан байгууллагуудын уялдаа холбоо, зохицуулалт үндэсний хэмжээнд дутагддагаас орон зайн төлөвлөлт тааруу байна.	Бүс нутгийн төлөвлөлтийн системийг сайжруулах.
Зэрлэг амьтдын нүүдэл	Орон зайн төлөвлөлтөд экосистемийн хамгааллыг тусгах.	Аймаг Улс	Бага Дундаж Өндөр	Төлөвлөлт, байгаль орчны байгууллагуудын хооронд уялдаа, зохицуулалт байхгүй.	Төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх.

5.4.3 Хөдөлмөр эрхлэлт ба ур чадвар

4-р бүлэгт хөдөлмөр эрхлэлт, ур чадвартай холбоотой ЖДҮ-ийг хөгжүүлэх, уул уурхайн компаниудын ажлын байрны шинэ боломжууд, ур чадварыг дээшлүүлэх гэсэн 2 гол асуудлыг авч үзсэн. ЖДҮ-ийг хөгжүүлэх нь эдийн засгийг төрөлжүүлэх гол чухал арга юм. Эл асуудал нь Засгийн газрын бүхий л түвшинд, мөн өсөлтийн аль ч хувилбарт хамааралтай байна.

ЖДҮ-ийн салбарыг өргөжүүлэхэд учирч буй **хамгийн том саад тотгор бол зээл олголт ба түүний хүртээмж хязгаарлагдмал байгаа нөхцөл байдал** бөгөөд үүнд, мөн **зээлийн менежмент муу, зээлийн хүү өндөр** зэрэг асуудал нэрмээс болж байна хэмээн оролцогч талууд үзлээ. Нөгөө талаас, **уул уурхайн компаниудын тавьдаг олон улсын стандартад хүрэх хүчин чадал хөдөөгийн ЖДҮ-д байхгүй байгаа нь өөр нэг сул тал** болж байна.

Олон улсын уул уурхайн компаниудын бий болгож буй ажлын байртай холбоотой хамгийн боломжийн арга хэмжээний зөвлөмж нь сургалт болон ажлын байран дахь дадлага юм. Энэ талд харагдаж буй сул тал нь залуу мэргэжилтнүүдийг хөдөө орон нутагт татах цогц бодлого байхгүй байгаа явдал болно. Үүний зэрэгцээ, их сургуулиуд ихэнхдээ Улаанбаатарт байгаа нь хөдөөгөөс

хот руу чиглэсэн хүн амын нүүдлийг хөөрөгдөж, орон нутгийн эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байна.

Бүлэг 4-т хийсэн дүн шинжилгээгээр ЖДҮ-ийн салбарын хөгжилтэй холбоотойгоор бодлогын түвшинд аливаа зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үзсэн ба харин хариуцсан агентлагууд нь энэ чиглэлээр идэвхтэй ажиллах шаардлагатай байгаа юм. Бодлогын түвшинд анхаарах шаардлагатай асуудал нь дээд сургууль, мэргэжлийн сургалтын одоогийн хөтөлбөрийг сайжруулах, мөн уул уурхайн салбар хөдөө орон нутгийн хөгжлийг хөтөлгөч хүчин зүйлсийн нэг болохыг харгалзан үзсэн хөдөөгийн хөгжлийн нягт нарийн бодлого боловсруулах арга хэмжээ болно. Хөдөлмөр эрхлэлт ба ур чадварын талаарх зөвлөмжүүдийг **дунд хугацаанд** хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 5.10 Сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүд: Хөдөлмөр эрхлэлт ба ур чадвар

Чиглэл	Арга хэмжээний зөвлөмж	Түвшин	Өсөлтийн хувилбар	Эрх зүйн орчин, институци ба чадавхийн сул тал	Бодлогын зөвлөмж
Ур чадвар, чадамжийг хөгжүүлэх, уул уурхайн компаниудаас бий болгох ажлын байр	МСҮТ, их, дээд сургуулиудын сургалтын одоогийн хөтөлбөрт дадлагын цагийг нэмэж төгсөгчдийн ажлын байран дахь бэлэн байдлыг дээшлүүлэх.	Улс	Бага Дундаж Өндөр	Оюутнуудад практик мэдлэг хангалттай өгдөггүй.	МСҮТ, их, дээд сургуулиудын сургалтын одоогийн хөтөлбөрийг өөрчлөх.
	Үндэсний хэмжээнд хөдөөгийн хөгжлийн бодлогыг хөхиүлэн дэмжиж мэргэшсэн залуу мэргэжилтнүүд хөдөө орон нутагт ажиллахыг урин дуудах амьдралын тав тух, ажлын орчинг бий болгох. Энэхүү бодлогод орон сууцжуулалт, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хөгжил, татварын хөнгөлөлт, хөдөөгийн нэмэгдэл болон хөнгөлөлт, татаас зэргийг оруулж болох юм.	Сум Аймаг	Бага Дундаж Өндөр	Залуу мэргэжилтнүүдийг хөдөө орон нутаг руу татах цогц бодлого байхгүй.	Уул уурхайн хөгжил хөдөөгийн хөгжлийн нэг хөтөлгөч болохыг харгалзан хөдөөгийн хөгжлийн цогц бодлогыг боловсруулах.

5.4.4 Технологи

Уул уурхайд ашиглаж буй технологи байгаль орчин, нийгмийн үр дүнд нөлөөлдөг талаар нөхцөл байдлын үнэлгээнд дурдсан. Гол асуудал нь эрчим хүчинд хэмнэлттэй, орчин үеийн үйлдвэрлэл, боловсруулалтын арга техник, хаягдлын зохистой менежмент бүхий технологийг хэрэглэх явдал юм. Технологийн энэхүү хэрэгцээнд нийцсэн 2 арга хэмжээний зөвлөмжийг санал болгож байгаа ба эдгээрт хурдан нэвтрүүлж болохуйц хямд технологийн талаар судалгаа хийх, сургалт, дадлага хийх замаар технологийг нэвтрүүлэх үүднээс гадаадын инженерчлэлийн болон уурхайн компаниудтай олон улсын түншлэлийг хөгжүүлэх арга хэмжээ багтаж байна. Нөхцөл байдлын үнэлгээ, зөвлөлдөх хэлэлцүүлгээр энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарах хүндрэл, сул тал эрх зүй, институцийн орчинд илрээгүй тул аливаа нэмэлт бодлогын зөвлөмж хэрэгжүүлэх шаардлагагүй.



5.5 ДҮГНЭЛТ

Нөхцөл байдлын үнэлгээнд тодорхойлсон эн тэргүүний 12 асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж буй хууль эрх зүй, институцийн орчны сул талыг тодорхойлох дүн шинжилгээ хийх, мөн дүн шинжилгээний дүнд илрүүлсэн дутагдал, сул талыг арилгах бодлогын зөвлөмжүүдийг санал болгохыг тайлангийн энэ бүлэгт зорьсон билээ. Холбогдох хууль эрх зүйн орчин, чадавхи, нөөц/урамшууллын хөшүүргийн аль алинд нь сул тал байгаа тул эдгээр арга хэмжээний зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа нь харагдаж байна. Түүнчлэн, эдгээр сул талыг арилгахаар санал болгож буй бодлогын зөвлөмжүүд нь өсөлтийн гурван хувилбарт бүгдэд нь хамааралтай болно.

БОНСУ-ий үр дүнд эдгээр бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд зориулсан Үйл ажиллагааны төлөвлөгөөг санал болгож байгаа бөгөөд энэхүү төлөвлөгөөг сүүлчийн бүлэг (Бүлэг 6)-т оруулав.



6. ДҮГНЭЛТ БА БОНСҮ-ИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1 ТАНИЛЦУУЛГА

Монголын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн стратегийн энэхүү үнэлгээнд өсөлтийн гурван хувилбарыг авч үзсэн ба талуудыг өргөн хүрээнд оролцуулж, зөвлөлдөн гүйцэтгэлээ. Бүлэг 4-т танилцуулсан дүн шинжилгээнд хэрэв уул уурхайн салбар тогтвортойгоор буюу дундаж болон өндөр өсөлтийн аль нэг хувилбараар хөгжих тохиолдолд байгаль орчин, нийгмийн нөлөөлөл мэдэгдэхүйц их байх магадлалтай бөгөөд эдгээр нөлөөллийг бууруулах шаардлага байгааг тодорхойлов. Гол нөлөөллүүд нь ус ашиглалт, газар ашиглалт, уурхайн нөхөн сэргээлт, биологийн олон янз байдал, соёлын өв, хүний эрх болон эрүүл мэнд, аюулгүй ажиллагаатай холбоотой байна.

Нөлөөлөл нь өндөр өсөлтийн үед илүү байх хандлагатай байгаа ч дунд ба өндөр өсөлттэй хувилбарын хооронд нөлөөллийн ялгаа тийм их байхааргүй байна. Уул уурхайн салбар өндөр өсөлттэй байх үед засаглалыг сайжруулах нөөц бололцоо Засгийн газарт илүү гарах ч чадавхийг хөгжүүлэхэд цаг хугацаа шаардагдах болно. Хүний нөөцийг бэхжүүлэхэд дор хаяж 10 жил шаардагдах бөгөөд "хүлээгдэж буй" энэ хугацаанд байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл их хэмжээгээр хуримтлагдаж болзошгүй юм.

Бага өсөлттэй хувилбарын үед засаглалын хүчин чадал сайжрах магадлалтай ч үүнд урт хугацаа шаардагдана. Энэ хувилбарын хувьд байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, алдагдал бага байх боломжтой. Учир нь чадавхийг бэхжүүлэхэд урт хугацаа шаардагдах хэдий ч хүн ам эсвэл газар нутагт тийм ч их нөлөөлөл үзүүлэхгүй. Сумын түвшинд нилээд нөлөөлөл үзүүлж болзошгүй ч энэ нь цөөн тооны сумдад хамаарахаар байна. Том төслүүдийн хувьд сөрөг нөлөөллийг нуух бололцоогүй байдаг тул "Стратегийн орд" газруудыг түлхүү хөгжүүлэх энэ хувилбарын хувьд байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах арга хэмжээний гүйцэтгэл ерөнхийдөө дээшлэх магадлалтай.

Энэхүү үнэлгээний хүрээнд эхлээд уул уурхайн салбартай холбоотой "эн тэргүүний асуудал" (Нөхцөл байдлын үнэлгээ, БОНСҮ-ий явцад хийгдсэн хэлэлцүүлгүүдийн үеэр талуудын тодорхойлсон)-уудыг тодорхойлж, дараа нь эдгээр асуудлыг шийдвэрлэх "арга хэмжээний зөвлөмж"-үүдийг боловсруулсан. Дараагаар нь "хууль эрх зүй, институци, чадавхийн сул тал"-ыг тодорхойлон уг арга хэмжээний зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд ямар сул тал үүссэн байгааг шинжиллээ. Эцэст нь энэхүү сул талуудыг нөхөх бодлогын зөвлөмжүүдийг 4, 5-р бүлэгт боловсруулаад байна. 5-р бүлэгт хийсэн дүн шинжилгээний үр дүнд эдгээр санал болгож буй бодлогын зөвлөмжүүд нь өсөлтийн гурван хувилбарт ерөнхийдөө бүгдэд нь хамааралтай хэмээн дүгнэж болох юм.

Тус БОНСҮ-ий төгсгөлийн бүлэгт нэгдүгээрт, авч үзсэн хувилбар тус бүрийн хувьд үүсэх нөлөөллийн гол ялгааг дурдан 4-р бүлгийн үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Хоёрдугаарт, эн тэргүүний хэмээн тодорхойлсон 12 асуудлыг шийдвэрлэхээр боловсруулсан бодлогын зөвлөмжүүдийг ач холбогдолоор нь эрэмбэлэн хэрэгжүүлэх хугацааны хувьд төрийн холбогдох байгууллагуудад зөвлөмж өгсөн болно.

Зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацааг:

- Богино хугацааны: 2014 – 2017
- Дунд хугацааны: 2018 – 2020
- Урт хугацааны: 2021 – 2025 он гэсэн хугацаанд хуваав.

12 асуудал тус бүрийн хувьд холбогдох зөвлөмжүүдийг багтаасан хүснэгтүүдийг бэлтгэсэн ба эдгээрийг нэгтгэсэн БОНСУ-ий Үйл ажиллагааны төлөвлөгөөг Хавсралт С-д оруулав.

6.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛУУД

6.2.1 Ус

Бага өсөлттэй үед ч орон нутгийн түвшинд ус ашиглалтын асуудлаар ялангуяа Сэлэнгэ, Хөвсгөл болон Булган аймгуудад зөрчил маргаан гарах магадлалтай байна. Дундаж болон өндөр өсөлттэй үед хэрэв ус ашиглах өөр боломжит гарцуудыг олохгүй бол нилээд зөрчил үүсч мөн болзошгүй. Жишээлбэл, өндөр өсөлтийн үед Сэлэнгэ мөрний сав газарт 2021 он гэхэд уул уурхайн салбарын жилд ашиглах усны хэрэгцээ тухайн сав газрын ус ашиглалтын нөөцийн 163%-д хүрэх тооцоо байна.

Оролцогч талуудын дунд усны нөөцийн асуудлаар мэдлэг, ойлголтыг бий болгож чадавхижуулах шаардлага хамгийн эн тэргүүний асуудал хэвээр байсаар байна. Усны нөөцийн талаарх өгөгдөл, мэдээлэл хангалтгүй, мөн уурхайн ус ашиглалтаас үүсэх нөлөөлөл оролцогч талуудад тодорхой бус байгаа нь усны асуудлыг улам хурцатгаж байна. Хэдийгээр уурхайн үйл ажиллагаа нэмэгдэх хэрээр эрсдэл нэмэгдэнэ гэж үзэж байгаа ч усны асуудал өсөлтийн бүх хувилбаруудад хамгийн чухалд тооцогдож байгаа юм.

Усны асуудалтай холбоотой хийгдэх бодлогын шинэчлэлийг БОНХЯ, аймгийн Байгаль орчны газар болон сумын Засаг даргын Тамгын газар хариуцахаар байна. Хүснэгт 6.1-т тусгасан бодлогын 2, 4-р зөвлөмжүүдийн хувьд, БОНХЯ байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулан оролцоонд түшиглэсэн хяналт шинжилгээний аргачлалыг боловсруулж, харин аймаг, сумдууд эдгээр хууль, журмыг хэрэгжүүлнэ.

Хүснэгт 6.1 Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Ус

Бодлогын зөвлөмж	Хэрэгжүүлэх хугацаа, байгууллага
5 жил тутамд: (i) үндэсний хэмжээний усны нөөцийн судалгаа; (ii) үндэсний хэмжээний усны эрэлтийн судалгаа гэсэн 2 төрлийн иж бүрэн судалгааг хийх.	Дунд, урт хугацаанд БОНХЯ
Нутгийн иргэдийг усны хяналт шинжилгээнд оролцуулах зохицуулалт бүхий өөрчлөлтийг байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой хууль, журамд оруулах.	Богино хугацаанд БОНХЯ
Голуудын сав газрыг шаардлагатай судалгааг хийх эх үүсвэр, чадавхитай болгох.	Богино, дунд хугацаанд БОНХЯ
Оролцоонд түшиглэсэн хяналт шинжилгээг дэмжих үүднээс Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийг дагалдуулан холбогдох журмыг боловсруулах.	Богино хугацаанд БОНХЯ



6.2.2 Газар ба бэлчээр ашиглалт

Газар ашиглалтын асуудлаарх зөрчил маргаан нь дундаж болон өндөр өсөлтийн аль алинд нь ус ашиглалтын асуудалтай бараг ижил хэмжээнд чухал байна. Дундаж өсөлтийн үед уул уурхайн нөлөөлөлд өртөх хамгаалалттай газар нутаг Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Баянхонгор болон Говь-Алтай аймгуудад их байх магадлалтай. Бэлчээрийн талбайн доройтол, алдагдал Өмнөговь, Дорнод, Дундговь, Төв, Сэлэнгэ болон Хэнтий аймгуудад их байж болзошгүй. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын судалгаагаар уурхайн тоо нэмэгдэхэд нөлөөлөлд өртөх бэлчээрийн талбай хэр ихэсч болохыг харууллаа (4.2.2-р хэсэг).

Өндөр өсөлттэй хувилбарын үед уурхайн үйл ажиллагаа ихэссэнээр хамгаалалттай газар нутаг, бэлчээрийн талбайд газрын холбогдолтой маргаан зөрчлийг маш их нэмэгдүүлэхээр байна.

Газар ашиглалттай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд хамгийн олон арга хэмжээг авах шаардлагатай байгаа юм. Хүснэгт 6.2-т харуулснаар бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд БОНХЯ, Барилга, хот байгуулалтын яам, Зам тээврийн яам болон сумдын Засаг даргын Тамгын газрууд зэрэг олон байгууллагууд оролцох шаардлагатай байна.

Хүснэгт 6.2 Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Газар ба бэлчээр ашиглалт

Бодлогын зөвлөмж	Хэрэгжүүлэх хугацаа, байгууллага
Эх үүсвэрийг нэн шаардлагатай арга хэмжээнд ашигладаг болгохын тулд төсвийн ил тод байдлыг сайжруулах.	Дунд хугацаанд СЯ ЭЗХЯ
Уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглох бүс нутгийг тогтоох талаар хэрэгжүүлж буй санаачилгыг эцэслэн олон нийтэд мэдээлэх.	Богино хугацаанд БОНХЯ
Бэлчээрийн үр дүнтэй менежментийн хууль эрх зүйн үндсийг бий болгох.	Богино, дунд хугацаанд БХБЯ
Задгай бэлчээрийг малчдын бүлэгт түрээсээр эзэмшүүлэх эрх олгох хууль тогтоомжийг боловсруулан батлах.	Дунд хугацаанд БХБЯ
Уул уурхайн салбарт нүүлгэн суурьшуулалтын үйл ажиллагаа, түүний дотор нөлөөлөлд өртсөн хүмүүст олгох нөхөн олговрыг зохицуулах хууль, журмыг боловсруулах, хэрэгжүүлэх.	Богино, дунд хугацаанд БХБЯ
Задгай бэлчээрийг малчдын бүлэгт түрээсээр эзэмшүүлэх эрх олгох хууль тогтоомжийг боловсруулан батлах.	Дунд хугацаанд БХБЯ
Задгай бэлчээрийг малчдын бүлэгт түрээсээр эзэмшүүлэх эрх олгох хууль тогтоомжийг боловсруулан батлах.	Дунд хугацаанд БХБЯ
Оролцоонд түшиглэсэн хяналт шинжилгээг дэмжих үүднээс Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийг дагалдуулан холбогдох журмыг боловсруулах.	Богино хугацаанд БОНХЯ
Бэлчээрийн зүй зохистой менежментийн хууль эрх зүйн үндсийг бий болгох.	Богино, дунд хугацаанд БХБЯ
Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг тооцон тусгах үүднээс сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулах журмыг эргэн харах.	Богино хугацаанд БХБЯ
Ашигт малтмалын одоогийн хуулийн уурхайн хаалтын төлөвлөгөөний тухай заалтанд нутгийн иргэдийн саналыг оруулах заалтыг оруулах.	Богино хугацаанд УУЯ
Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны журмыг боловсруулах, хэрэгжүүлэх.	Богино, дунд хугацаанд БОНХЯ



Бодлогын зөвлөмж	Хэрэгжүүлэх хугацаа, байгууллага
Дэвшилтэт технологийг ашиглах хөшүүргийг бий болгох бодлого, аргачлалыг боловсруулах.	Богино, дунд хугацаанд БОНХЯ
Бизнесийн хөгжил болон бүсийн төлөвлөлтийг дэмжих үндэсний хэмжээний хөрсний чанарын үнэлгээний тогтолцоог бий болгох	Урт хугацаанд БХБЯ
(i) Уул уурхайн компаниуд байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулахдаа сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг харгалзан тусгах шаардлага тавих нэмэлт өөрчлөлтийг БОНБУ-ий хуулийн дагуу холбогдох журамд оруулах. (ii) Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөг (Ашигт малтмалын хуулиар ийм шаардлага тавигддаг) оролцогч талуудтай зөвлөлдөн боловсруулах шаардлагыг оруулах нь зүйтэй.	Богино хугацаанд БОНХЯ
Төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг сайжруулах.	Богино хугацаанд БХБЯ

6.2.3 Агаарын чанар

Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор агаарын чанарт тодорхой цэгэн эх үүсвэрээс нөлөөлөл үүсэх хандлагатай байдаг. Гэхдээ бага өсөлттэй хувилбарын үед гэлтгүй орон нутагт үзүүлэх нөлөөлөл нь их байж болзошгүй. Дунд ба өндөр өсөлтийн үед уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын сөрөг нөлөөлөл Өмнөговь, Дорнод, Төв, Дундговь, Сэлэнгэ болон Хэнтий аймгуудын уурхайтай сумдад их байх талаар 4.2.3-р хэсэгт дурдсан.

Хүснэгт 6.3-ээс харвал агаарын чанарыг дээшлүүлэхтэй холбоотой арга хэмжээг бүх түвшний олон байгууллагууд хамтран хэрэгжүүлэхээр байна.

Хүснэгт 6.3 Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Агаарын чанар

Бодлогын зөвлөмж	Хэрэгжүүлэх хугацаа, байгууллага
Нутгийн иргэдэд түшиглэсэн хяналт шинжилгээг дэмжих үүднээс Байгаль орчинд нөлөөлөл байдлын үнэлгээний хуулийг дагалдуулан холбогдох журмыг боловсруулах.	Богино хугацаанд БОНХЯ
Төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг сайжруулах.	Богино хугацаанд БХБЯ
Тоосжилтод өртөх бүсэд бүтээн байгуулалт явуулахгүй байх үүднээс сумын төлөвлөлтийн байгууллагын чадавхийг дээшлүүлэх, түүнчлэн тоосжилтод өртөөд байгаа бүсэд одоо амьдарч байгаа оршин суугчдыг нүүлгэн суурьшуулах чиглэлийг боловсруулах.	Богино хугацаанд БХБЯ

6.2.4 Байгаль орны менежмент

Уул уурхайн компаниудын байгаль орчны менежмент нь тусдаа асуудал бөгөөд өндөр өсөлттэй үед байгаль орчинд заавал их нөлөөлөл үүснэ гэсэн үг биш юм. Үнэн хэрэгтээ, бага өсөлттэй хувилбарын үед ч хэрэв олон улсын хөрөнгө оруулалт буурвал байгаль орчны стандартад нөлөөлж болзошгүй.

Байгаль орчны менежментийн асуудлаар уул уурхайн компаниудад хамаарах сул талыг шийдвэрлэх бодлогын зөвлөмжүүд нь голдуу хууль эрх зүйн орчны зохицуулалтын шинэчлэлтэй холбоотой байгааг Хүснэгт 6.4-ээс харж болохоор байна. Эрх зүйн орчны шинэчлэлийг голлон



БОНХЯ хийх ч иргэдийн оролцоотой хяналт шинжилгээ зэрэг хэрэгжилтийн асуудал сум, аймгийн түвшинд хамаарна.

Хүснэгт 6.4 Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Байгаль орчны менежмент

Бодлогын зөвлөмж	Хэрэгжүүлэх хугацаа, байгууллага
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянах үйл ажиллагаанд хуваарилах төсвийг нэмэгдүүлэх, сумын байгаль орчны байцаагчдыг чадавхижуулах.	Дунд хугацаанд БОНХЯ УУЯ
(i) Нутгийн иргэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад оролцох бололцоо олгох нэмэлт өөрчлөлтийг БОНБУ-ий хуулийн дагуу холбогдох журманд тусгах. (ii) Ашигт малтмалын хуулинд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад талуудыг оролцуулах талаар заалт оруулах.	Богино хугацаанд БОНХЯ УУЯ
Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны журам, аргачлалыг боловсруулах.	Богино хугацаанд БОНХЯ
Нөхөн сэргээлттэй холбоотой урамшуулал, хөшүүргийг бий болгох холбогдох журам, зааврыг боловсруулах.	Богино, дунд хугацаанд БОНХЯ
Аюултай хог хаягдлыг зайлуулах шаардлагад нийцсэн үндэсний хэмжээний байгууламж байгуулахад дэмжлэг үзүүлэх үүднээс бэлтгэл ажлын санхүүжилтийн зэрэгцээ урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Богино хугацаанд БОНХЯ

6.3 БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖҮҮД БА АРГА ХЭМЖЭЭ: НИЙГМИЙН АСУУДЛУУД

6.3.1 Хувиараа болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа

Хувиараа болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа нь өсөлтийн гурван хувилбарын үед бүгдэд нь сөрөг нөлөөтэй байна (Хүснэгт 4.3.1). Бага өсөлттэй хувилбарын үед хувиараа ашигт малтмал олборлохтой холбоотой асуудлыг шийдвэрлэх орлогын эх үүсвэр бага байх бөгөөд уул уурхайн компаниудад ажлын байр бага гарах магадлалтай. Дундаж өсөлттэй үед бичил уурхайн үйл ажиллагаа явуулах талбайтай холбоотой маргаан зөрчил нэмэгдэх ба хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа Сэлэнгэ, Дархан-Уул, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Увс, Өмнөговь, Дорноговь, Дундговь, Хөвсгөл болон Улаанбаатарт ихээхэн эрчимтэй явагдана. Өндөр өсөлттэй хувилбарын үед уул уурхайн салбарт ажил эрхлэлт эрчимтэй нэмэгдэх учраас хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа бага байх хэдий ч үргэлжилсээр байх тул олборлолт явуулах газартай холбоотой зөрчил маргаан ихээр гарч болзошгүй.

Санал болгож буй бодлогын зөвлөмжүүдийг Уул уурхайн яам хэрэгжүүлэхээр байна.



Хүснэгт 6.5 Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Бичил уурхай

Бодлогын зөвлөмж	Хэрэгжүүлэх хугацаа, байгууллага
Одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомжийг дараах чиглэлээр судалж үзэх: ○ Үндэсний хэмжээнд БУ-н хэвийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөх асуудлыг хэрхэн сайжруулж болох; ○ УУЯ-ны бүтцэд бичил уурхайн асуудлыг тусад нь эрхэлсэн дэд сайдтай болох. Үүнд энэхүү үйл ажиллагаанд зориулагдсан төсвийн эх үүсвэр мөн багтана.	Богино, дунд хугацаанд УУЯ
Төрийн байгууллагын ажилтнуудын бичил уурхайн салбарын асуудлаар ажиллах чадварыг сайжруулах.	Богино хугацаанд УУЯ
Зорилтот хөтөлбөрүүдэд төсөв хуваарилах.	Дунд хугацаанд УУЯ
Хувиараа ашигт малтмал олборлогчдын асуудлаар ажиллах төрийн байгууллагын ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх.	Богино хугацаанд УУЯ
Чадавхийг бий болгох хөтөлбөрийг санхүүжүүлэх төсөв хуваарилах.	Дунд хугацаанд БОНХЯ
Бичил уурхайн журмыг хэрэгжүүлэх нөхцлийг бий болгох.	Дунд хугацаанд УУЯ
Орон нутгийн эмнэлгүүдийн төсвийн хуваарилалтад хувиараа ашигт малтмал олборлогчдыг тооцох.	Богино хугацаанд ЭМЯ

6.3.2 Соёлын өв

Бага өсөлттэй үед бүтээн байгуулалт бага явагдах учраас газар хөндөлт буюу соёлын өвд үзүүлэх эрсдэл бага байхаар байна (Хэсэг 4.3.2). Цаашлаад, дундаж ба өндөр өсөлттэй хувилбарын үед өмнөх туршлагаас харахад Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг дагаж мөрдөх нь сул байсан тул соёлын өвийн чухал газруудад аюул учрах магадлалтай. Ялангуяа Өмнөговь болон Баянхонгор аймгууд хамгийн их ашигт малтмалын баялагтай, мөн палеонтологийн хамгийн их нөөцтэй тул нөлөөлөлд ихээр өртөж болзошгүй байна.

Боловсруулсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд саад болох бодлогын сул тал байхгүй байгааг Хэсэг 5.3.2-т тэмдэглэсэн. Гагцхүү хариуцлага хүлээсэн төрийн байгууллагууд (ССАЖЯ, БОНХЯ, сумдын Засаг даргын Тамгын газрууд) доорх үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна:

- Соёлын өвийн дэд бүтэц, чадавхийг бий болгох үүднээс хамтын ажиллагаагаа бэхжүүлэх.
- Соёлын биет бус өвийг хамгаалсан, өвийг хадгалсан уул уурхайн компаниудад зориулсан урамшууллын хөшүүргийг бий болгох.
- Уул уурхайгаас соёлын биет бус өвд үзүүлэх нөлөөллийг улсын түвшинд судлах, ингэснээр уул уурхайн салбараас соёлын өвд хэрхэн нөлөөлөх талаарх иргэдийн нийтлэг ойлголтыг бий болгох.
- Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг нутгийн иргэдийг сэргээгдэх эрчим хүч, харилцаа холбооны технологи зэрэг орчин үеийн технологиор ханган бэхжүүлэх.



- Соёлын өвийг хамгаалах төслүүдийг санаачлан, уул уурхайн болон аялал жуулчлалын компаниуд, нутгийн иргэдийн оролцоотойгоор боловсруулж, хэрэгжүүлэх. Уурхайн үйл ажиллагаанаас археологи, палеонтологийн өвд үзүүлэх нөлөөллийг хянахад малчид, олон нийтийг оролцуулах ажлыг зохион байгуулах.
- Уул уурхайн үйл ажиллагааны дүнд их ба дунд хэмжээгээр хөндөгдөх газар нутагт суурь судалгаа (археологи ба палеонтологийн) явуулах. Уг суурь судалгааг ердийн судалгаа явуулахаас богино хугацаанд, бага зардлаар урьдчилан гаргасан загварчлалыг хэрэгжүүлэх замаар гүйцэтгэх (Оюу Толгойн 2011 оны Соёлын өвийн хөтөлбөрийг үзнэ үү). Эдгээр судалгаануудад үндэслэн нутгийн иргэдийн оролцоотойгоор хамгаалалтын бүсийг тодорхойлж уг биет соёлын өвийн бүсэд уурхайн үйл ажиллагаа явуулахгүй байхыг уурхайн компанид мэдэгдэх.
- Их, дунд хэмжээгээр хөндөгдөж болзошгүй соёлын өвийн нөөц бүхий газар нутагт суурь судалгаа явуулах зардлыг уурхай болон бусад олборлох салбарын компаниудаар төлүүлэх, үүнд зориулсан сан байгуулах.
- Соёлын өвийг хамгаалах хуультай нийцээгүй тохиолдолд торгууль ногдуулан хэрэгжүүлэх.
- Уурхайн нөлөөнд өртөх соёлын өвийн эрэл хайгуулыг хариуцах болон нөөцийг хянах олон тооны мэргэжлийн археологич, палеонтологич, биет бус соёлын өвийн мэргэжилтнүүдийг агентлагуудын хүрээнд соёлын өвийг хамгаалах олон улсын шилдэг туршлагад сургах, чадавхижуулах ажлыг зохион байгуулах.
- Уул уурхайн эрчимтэй үйл ажиллагаа явагдаж байгаа газарт тэдгээр компанид зориулсан соёлын өвийг хамгаалах сургалтыг боловсруулж явуулахад нь сумдын захиргаадад дэмжлэг үзүүлэх.

6.3.3 Хүний эрх ба олон нийтийн оролцоо

Хүний эрх болон орон нутгийн иргэдийн оролцооны асуудал өсөлтийн бүх гурван хувилбарт чухал. Гэхдээ өндөр өсөлтийн үед зохицуулалтын орчинд ачаалал нэмэгдэх учир хүний эрх, орон нутгийн иргэдийн оролцооны асуудал илүү ихээр хөндөгдөнө. Дундаж өсөлттэй хувилбарын үед гарч болзошгүй газар чөлөөлөлт, нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааг хангалтгүй зохион байгуулах, уул уурхайн компаниудын нийгмийн чиглэлээр явуулж буй арга хэмжээний хяналт сул байх зэрэг асуудлууд өндөр өсөлттэй хувилбарт бүр илүү нэмэгдэнэ.

Хүний эрх, нийгмийн асуудалтай холбоотой сул талыг нөхөх бодлогын зөвлөмжүүдийн ихэнх нь компанийн нийгмийн хариуцлагын санаачилгыг дэмжсэн эрх зүйн тогтолцоо бий болгох, нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой байгаа юм (Хүснэгт 6.6). Эдгээр зөвлөмжүүдийг богиноос дунд хугацаанд аймаг, сумдын ИТХ-тай хамтран үндэсний түвшний олон байгууллагууд хамтран хэрэгжүүлэхээр байна.

Хүснэгт 6.6 Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Хүний эрх ба олон нийтийн оролцоо

Бодлогын зөвлөмж	Хэрэгжүүлэх хугацаа, байгууллага
Компаний нийгмийн хариуцлагын талаарх хууль эрх зүйн баримт бичгийг гаргах.	Дунд хугацаанд ЭЗХЯ
Компаний нийгмийн хариуцлагын талаарх хууль эрх зүйн баримт бичгийг гаргах.	Дунд, урт хугацаанд ЭЗХЯ
Уул уурхайн салбарт нүүлгэн суурьшуулах үйл ажиллагаа, түүний дотор нөлөөлд өртсөн хүмүүст эрх тэгш, шударга нөхөн олговор олгох асуудлыг зохицуулах хууль боловсруулан хэрэгжүүлэх.	Богино, дунд хугацаанд БХБЯ
Уул уурхайн салбарт нийгмийн хариуцлагын гүйцэтгэлийг зохицуулах хууль тогтоомжийг боловсруулан хэрэгжүүлэх, НҮБ-ын холбогдох олон улсын гэрээ, харгалзах салбарын жишиг стандартын (ОУСК, Аюулгүй ажиллагаа, Хүний эрхийн сайн дурын зарчмууд) заалтуудыг хэрэгжүүлэх.	Дунд хугацаанд ХАХНХЯ ЭЗХЯ УУЯ
Урт хугацаанд бүсийн төлөвлөлтийг боловсронгуй болгох, ойрын ирээдүйд уул уурхайн бүсийн ойролцоох хот, сууринд төсвийг нэмж хуваарилах.	Богино, дунд хугацаанд БХБЯ ЭЗХЯ

6.3.4 Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа

Эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай холбоотой сөрөг нөлөөллүүд өсөлтийн бүх гурван хувилбарт гарах магадлалтай. Бага өсөлттэй үед уурхайн үйл ажиллагаа бага байх боловч эрүүл мэндийг сайжруулах үйлчилгээнд зарцуулах Засгийн газрын орлого багасана. Дундаж өсөлттэй үед эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, журмын мөрдөлт сул байх магадлалтай бөгөөд эрүүл мэндийн асуудлыг хянах бэлтгэгдсэн байцаагчдын хүрэлцээ хангалтгүйн улмаас хууль, журмын хэрэгжилт алаг цоог байхаар байна. Энэ нөхцөл байдал өндөр өсөлттэй үед улам илүүтэйгээр мэдрэгдэнэ. Ялангуяа ойрын жилүүдэд буюу богино хугацаанд, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж муутай уурхайн үйл ажиллагаа эрчимтэй явагдах газар нутагт ажиглагдана.

Эрх зүйн зохицуулалт, чадавхийн сул талуудыг нөхөх бодлогын зөвлөмжүүдийн ихэнхийг богино болон дунд хугацаанд Эрүүл мэндийн яам голчлон хариуцаж хэрэгжүүлэхээр байна.

Хүснэгт 6.7 Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа

Бодлогын зөвлөмж	Хэрэгжүүлэх хугацаа, байгууллага
Осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нөхөн олговор, нөхөн сэргээх эмчилгээний хууль, эсвэл журмыг боловсруулах.	Богино, дунд хугацаанд ХЯ
Уул уурхайгаас орсон орлогоос нөлөөлд өртсөн иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, нөлөөлд өртсөн нутгийн иргэдийн эрүүл мэндийг сайжруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх. Нөлөөлд өртсөн олон нийтэд зориулсан эрүүл мэндийн санг байгуулах нэмэлт өөрчлөлтийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд оруулах.	Богино хугацаанд СЯ
Одоогийн мөрдөж буй хуулиудын хүрээнд бий болсон тэргүүний туршлага, арга ажиллагааг нэгтгэн зангидах үйл явцыг боловсруулах.	Богино хугацаанд ХЯ ХАХНХЯ
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг чадавхижуулах хөтөлбөрийг боловсруулах.	Богино хугацаанд МХЕГ



Замын зураг төслийн болон төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх.

Дунд хугацаанд

ЗТЯ

БХБЯ

6.4 ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДЛУУД

6.4.1 Засаглал ба орлогын менежмент

Бусад хоёр өсөлтийн хувилбартай харьцуулахад засаглал болон орлогын менежментийн асуудлаар өндөр өсөлттэй үед илүү дээр үр дүнд хүрэх бололцоотой. Ойрын жилүүдэд буюу богино хугацаандаа засаглал, орлогын менежмент муу явагдаж болох ч уурхайгаас олох орлого ихсэхийн хэрээр яваандаа засаглалын чадавхи сайжирна. Богино хугацаанд засаглалтай холбоотой бий болох асуудалд авлига, хээл хахууль, шамшигдуулалт, зохион байгуулалт болон аудитын хүчин чадал ядмаг байх, сүм, аймгийн түвшинд засаглалын бүтэц сул, хууль, журмын хэрэгжилт муу байх, уул уурхайн салбарын орлогын тэгш бус хуваарилалт зэрэг орж болно.

Ихэнх бодлогын зөвлөмжүүдийг богино эсвэл дунд хугацаанд Эдийн засгийн хөгжлийн яам, Уул уурхайн яам хариуцаж хэрэгжүүлэхээр байна (Хүснэгт 6.8).

Хүснэгт 6.8 Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Засаглал ба орлогын менежмент

Бодлогын зөвлөмж	Хэрэгжүүлэх хугацаа, байгууллага
Улсын төсөв боловсруулах ажилд шинжилгээ хийх, аймгуудад оруулж буй хувь нэмрийг нь харгалзан төсөв хуваарилах хууль эрх зүйн үндсийг бүрдүүлэх, уул уурхайн орлогоос төсвийг нэмж хуваарилах замаар аймгуудад уул уурхайн компаниудтай хамтран ажиллах хөшүүрэг урамшууллыг бий болгох.	Богино хугацаанд СЯ ЭЗХЯ
Сүм, аймаг, үндэсний хөгжлийг төлөвлөхөд иргэд, холбоод, орон нутгийнхан оролцож, түүнтэй танилцан судалж, саналаа өгөхийг хуулинд оруулах.	Богино хугацаанд ЭЗХЯ
Аймгуудын оруулсан орлогыг харгалзан төсөв хуваарилах хууль зүйн зохицуулалтыг бий болгох.	Богино хугацаанд СЯ ЭЗХЯ
Эрдэс баялгаас бусад салбарыг хөгжүүлэх орон нутгийн чадавхийг сайжруулах.	Урт хугацаанд ҮХААЯ

6.4.2 Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц

Бүс нутгийн төлөвлөлт, тээврийн дэд бүтцийн асуудлаар хөгжлийн хувилбар бүрийн хувьд давуу болон дутагдалтай талууд үүсэхээр байна. Бага өсөлттэй хувилбарын хувьд шинээр тээврийн дэд бүтэц баригдахгүй ч хөдөөнөөс хот суурин руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгдэж хүн амыг нийгмийн үйлчилгээгээр тэгш хангах асуудалд хүндрэл гарсаар байх магадлалтай. Одоогийн орон зайн төлөвлөлтийн систем сул байгаагийн уршгаар дунд өсөлтийн үед тээврийн сүлжээ улам үр ашиггүй, бүс нутгийн нутагшил суурьшлын асуудал сул төлөвлөгдөх хандлагатай байна. Өндөр өсөлтийн үед уул уурхайн өсөлт бүс нутгийн хөгжилд эерэг хувь нэмэр оруулан төвлөрлийг сааруулах боломжийг бий болгох ба үүнд, жишээлбэл, Хөвсгөл, Баян-Өлгий, Өмнөговь, Өвөрхангай, Дундговь ба Сэлэнгэ зэрэг аймгуудад хүн ам төвлөрөх шинжтэй байгаа юм. Гэвч зам, төмөр зам болон бусад дэд бүтцийн бүтээн байгуулалт байгаль орчинд таагүй нөлөө үзүүлнэ.

Бодлогын зөвлөмжүүдийн ихэнх нь төлөвлөлтийн байгууллагуудын чадавхи, төлөвлөлтийн системийг сайжруулах арга хэмжээтэй холбоотой байна (Хүснэгт 6.9). Газар ашиглалтын төлөвлөгөө боловсруулах явцад олон нийттэй зөвлөгөөн, хэлэлцүүлгийг илүү сайн хийх талаар чадавхийг дээшлүүлэх, газар ашиглалтын төлөвлөлтөнд салбар хоорондын зохицуулалт, уялдааг хангах арга хэмжээг БХБЯ, ГХГЗЗГ хэрэгжүүлэхээр байна. Мөн тус байгууллагууд нь хамтран уул уурхайн үйл ажиллагаанаас үүдсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах бодлогыг боловсруулах үүрэгтэй.

Хүснэгт 6.9 Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Бүс нутгийн төлөвлөлт ба тээврийн дэд бүтэц

Бодлогын зөвлөмж	Хэрэгжүүлэх хугацаа, байгууллага
Төлөвлөлтийн байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх.	Богино хугацаанд БХБЯ
Уул уурхайгаас орох орлогоос аймгийн дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлэхэд ашиглахыг зөвшөөрөх тухай заалтыг Төсвийн тухай хуульд оруулах.	Богино, дунд хугацаанд СЯ ЭЗХЯ БХБЯ
Уул уурхайн бүс нутаг дахь шилжилт хөдөлгөөнийг зохицуулах бодлого боловсруулах.	Богино хугацаанд БХБЯ
Бүс нутгийн төлөвлөлтийн системийг сайжруулах.	Богино, дунд хугацаанд БХБЯ

6.4.3 Хөдөлмөр эрхлэлт ба үр чадвар

Засаглал, орлогын менежментийн асуудлын нэгэн адил хөдөлмөр эрхлэлт, үр чадвартай холбоотой нөлөөлөл өндөр өсөлтийн хувилбарын үед эерэг байх магадлалтай. Уул уурхайн салбарт шууд ажил эрхлэлт нэмэгдэнэ. ЖДҮ-ийг дэмжих нөөц нэмэгдэж нэмүү өртөг шингээсэн үйлдвэрлэлийн салбар хөгжих ба мэдлэг, үр чадварыг сайжруулах нөөц бололцоо ихсэнэ.

Бага өсөлттэй хувилбарын үед нөхцөл байдал эсрэгээрээ байх ба үүнд, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа уурхайнуудад үр чадвартай ажилчдын эрэлт хэрэгцээ бага, сумдад бий болох шууд ажлын байр хязгаарлагдмал байна.

4, 5-р бүлэгт авч үзсэний дагуу, ЖДҮ-тэй холбоотойгоор аливаа бодлогын зөвлөмж хэрэгжүүлэх шаардлагагүй, харин зөвхөн үүрэг хүлээсэн төрийн байгууллагууд холбогдох арга хэмжээг идэвхтэй хэрэгжүүлэх хэрэгтэй (Хавсралт С-г үзнэ үү). Анхаарах шаардлагатай бодлогын зөвлөмж нь дээд боловсролын болон мэргэжлийн сургалтын одоогийн хөтөлбөрийг эргэн харах, мөн уул уурхайг орон нутгийн хөгжлийн түлхэх хүч хэмээн үзэж хөдөөгийн хөгжлийн бодлогыг цогцоор боловсруулах явдал юм.

Эдгээр бодлогын зөвлөмжүүдийг богино эсвэл дунд хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөрийн яам болон Эдийн засгийн хөгжлийн яам хариуцаж хэрэгжүүлэхээр байна.

Хүснэгт 6.10 Бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хугацаа, байгууллага: Хөдөлмөр эрхлэлт ба үр чадвар

Бодлогын зөвлөмж	Хэрэгжүүлэх хугацаа, байгууллага
МСҮТ, их, дээд сургуулиудын сургалтын одоогийн хөтөлбөрийг өөрчлөх.	Богино хугацаанд БШУЯ



Бодлогын зөвлөмж	Хэрэгжүүлэх хугацаа, байгууллага
Уул уурхайн хөгжил хөдөөгийн хөгжлийн нэг хөтөлөгч болохыг харгалзсан хөдөөгийн хөгжлийн цогц бодлогыг боловсруулах.	Богино, дунд хугацаанд ЭЗХЯ БХБЯ

6.4.4 Технологи

Уул уурхайн технологитой холбоотой гол асуудал нь уул уурхайн салбарт орчин үеийн үйлдвэрлэл, боловсруулалт, хаягдлын менежмент болон эрчим хүчний хэмнэлттэй технологийг хэрхэн ашиглах явдал юм (Хэсэг 4.4.1). Одоогийн нөхцөл байдлын үнэлгээнд, мөн хэлэлцүүлгийн үеэр, технологитой холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрх зүйн зохицуулалт, чадавхийн тал дээр дутагдал, сул тал байхгүй хэмээн тодорхойлсон тул бодлогын түвшинд аливаа зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагагүй.

Хэлэлцүүлгийн үр дүнд гарсан зарим сургамж, саналыг БОНСУ-ий цаашдын үйл ажиллагаанд тусгав. Үүнд, БОНСУ-ий багийн зүгээс уул уурхайн салбарт үүсээд буй байгаль орчин, нийгмийн асуудлуудыг нэгдсэн сэдэв дор бүлэглэхэд ашигласан ангилал оновчгүй байсан гэсэн оролцогчдын санал байлаа. “Байгалийн нөөцийн ашиглалт”, “дэд бүтцийн хөгжил”, болон “нийгэм-эдийн засгийн асуудлууд” гэсэн ангилалын оронд, оролцогчид “байгаль орчин”, “нийгэм”, болон “эдийн засгийн” асуудлууд гэж бүлэглэн ангилахыг илүүд үзсэн юм. Ингэснээр, энэхүү саналыг БОНСУ-ий үйл ажиллагаанд тусган оруулж, ангилалыг оролцогчдын саналын дагуу өөрчлөв.

Талуудтай зөвлөлдөх бүсийн анхны хэлэлцүүлэгт ашигласан материалууд

1. Хэлэлцүүлгийн хөтөлбөр;
2. Хэлэлцүүлгийг хөтлөн явуулах заавар;
3. Хэлэлцүүлэгт оролцогчдын нэрсийн жагсаалт (Хавсралтын хүснэгт А.1 Уулзалтанд оролцогчдын нэрс-ийг харна уу).



SUSTAINABILITY

EAST ASIA LLC



УУЛ
УУРХАЙН
ЯАМ



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН СТРАТЕГИЙН ҮНЭЛГЭЭ ТАЛУУДАЙ ЗӨВЛӨЛДӨХ БҮСИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Улаанбаатар хот, Улаанбаатар зочид буудал, Хархорин танхим

2014 оны 01 сарын 16

УУЛЗАЛТЫН ХӨТӨЛБӨР

09:00-09:30 Бүртгэл

Үдээс өмнөх хэлэлцүүлэг

09:30-09:40

Хурлын нээлт

Б.Нэргүй, Уул уурхайн яамны Уул уурхайн бодлогын хэлтсийн дарга

Сюзан Жайлс, Састэйнабилити Ийст Эйжия ХХК-ийн гүйцэтгэх захирал
(БОНСУ-ий багийг төлөөлөн)

09:40-10:00

Байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ (БОНСУ)-ий төслийн талаарх товч танилцуулга

Б.Баярмаа, Састэйнабилити Ийст Эйжия ХХК-ийн ахлах зөвлөх

10:00-10:20

Цайны завсарлага

10:20-11:20

Улс, аймаг, сумын түвшинд уул уурхайн салбартай холбогдон үүсээд буй байгаль орчин, нийгмийн гол асуудлууд

Б.Баярмаа, Састэйнабилити Ийст Эйжия ХХК-ийн ахлах зөвлөх

11:20-12:30

Байгаль орчин, нийгмийн асуудлуудын талаарх хэлэлцүүлэг

12:30-13:30

Үдийн завсарлага (Өдрийн хоол 1 давхарт рестораны Их танхимд)

Үдээс хойшхи хэлэлцүүлэг

13:30-14:10

Уул уурхайн салбарын өнөөгийн байдлын судалгаа

Уул уурхайн салбарын хөгжлийн асуудлууд

Б.Мөнхсүрэн, БОНСУ-ий багийн Уул уурхайн мэргэжилтэн

14:10-15:00

Уул уурхайн салбарын өнөөгийн байдлын асуудлаарх асуулт, хариулт

15:00-15:20

Цайны завсарлага

15:20-16:00

Уул уурхайн салбарын хөгжлийн бодлогын хувилбарууд

Саха Миянатан, БОНСУ-ий багийн Эдийн засгийн мэргэжилтэн

16:00-16:50

Уул уурхайн салбарын хөгжлийн бодлогын хувилбаруудын талаарх хэлэлцүүлэг

16:50-17:00

Төслийн дараагийн үе шатны талаарх танилцуулга



Асуулт, хариулт: Улс, аймаг, сумын түвшинд уул уурхайн салбартай холбогдон гарах байгаль орчин, нийгмийн гол асуудлууд

Хугацаа: 11:00-12:30

Хэлэлцэх асуудлууд	Үйл ажиллагаанууд																								
<p>1. Орхигдсон асуудлууд (10 минут)</p>	<ul style="list-style-type: none"> Оролцогчдод урьдчилан унших материалтай хамт гол асуудлуудыг жагсаансан хүснэгтийг өгсөн байна. Уг хүснэгтийг авчраагүй оролцогчдод дахин тарааж өгнө; Хүснэгтэнд байгаа асуудлуудыг дахин нэг хянаад, нөхцөл байдлын үнэлгээнд тусгагдсан байгалийн нөөцийн ашиглалт, дэд бүтцийн хөгжил, нийгэм-эдийн засгийн асуудлуудын хүрээнд орхигдсон асуудал байвал нэмэж хэлж өгөхийг оролцогчдоос хүснэ. (5 мин); Энэ хооронд хэлэлцүүлгийг хөтлөгч оролцогчдын хэлсэн орхигдсон асуудлуудыг дэлгэц цаас эсвэл самбар дээр бичиж авна. Хэлэлцүүлгийг хөтлөгч оролцогчдын гаргасан асуудлуудыг мэдээж нөхцөл байдлын үнэлгээнд тусгагдсан эсэхийг нягтлахаас гадна давхцаж байгаа асуудлуудыг оруулахгүй. Энэхүү үйл ажиллагаа нь оролцогчидтой хэлэлцэх, зөвшилцөлд хүрэх байдлаар явагдана. (5 минут); <p><i>Хэлэлцүүлгийг хөтлөгч оролцогчид болон БОНСУ-ий багаас тодорхойлж гаргасан байгаль орчин, нийгмийн гол асуудлуудын эцсийн хувилбарыг дэлгэц дээр үзүүлнэ. Ингэснээр бүх оролцогчид ижилхэн хүснэгт дээр ажиллана.</i></p>																								
<p>2. Улс/аймаг/сумын түвшний бүлгийн хэлэлцүүлэг (30 минут)</p>	<ul style="list-style-type: none"> Оролцогчдыг гурван бүлэгт хувааж (нэг бүлэг ойролцоогоор 5-10 хүнтэй) дараах байдлаар тайлбарлана: <ul style="list-style-type: none"> Нэгдүгээр бүлэг: Үндэсний түвшний асуудлууд; Хоёрдугаар бүлэг: Аймгийн түвшний асуудлууд; Гуравдугаар бүлэг: Сумын түвшний асуудлууд. Оролцогчдыг хамгийн сайн мэдээлэлтэй юм уу, сонирхолтой байгаа аль нэг бүлэгт сайн дураараа нэгдэхийг санал болгоно. Гэхдээ нэг бүлэгт ижилхэн тооны оролцогчид байх нь чухал юм. Тиймээс магадгүй зарим нэг оролцогчдын хувьд бүлэгт орох нь тэдний эхний сонголт биш байж болох юм; Бүлгүүдийг гурван түвшингээр буюу улсын, аймгийн, сумын түвшин гэж нэрлэнэ. Бүлгийн гишүүд ярилцах боломжтойгоор ширээ тойрон суух хэрэгтэй. Ширээ бүрт дэлгэц цаас, маркер тарааж өгсөн байна; Оролцогчдыг одоо байгаа асуудлуудыг тухайн түвшинд байгаа хамгийн чухал байдлаар нь ярилцаж гаргаж ирэхийг даалгана. Дараа нь бүлэг хэсэг тус бүрээр (байгалийн нөөцийн ашиглалт/дэд бүтэц/нийгэм-эдийн засгийн асуудлууд) гол 5 асуудлуудыг чухлаар нь эрэмбэлэх; Бүлэг бүр дэлгэц цаас, маркертэй байх ба дараах хүснэгтийн дагуу чухал асуудлуудаа жагсааж бичнэ: <table border="1" data-bbox="684 1697 1401 1944"> <thead> <tr> <th>Гол чухал 5</th> <th>Байгалийн нөөцийн ашиглалт</th> <th>Дэд бүтэц</th> <th>Нийгэм-эдийн засаг</th> </tr> </thead> <tbody> <tr><td>1</td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>2</td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>3</td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>4</td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>5</td><td></td><td></td><td></td></tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> Бүлгийн хэлэлцүүлэг болон гол чухал асуудлуудыг жагсаах 	Гол чухал 5	Байгалийн нөөцийн ашиглалт	Дэд бүтэц	Нийгэм-эдийн засаг	1				2				3				4				5			
Гол чухал 5	Байгалийн нөөцийн ашиглалт	Дэд бүтэц	Нийгэм-эдийн засаг																						
1																									
2																									
3																									
4																									
5																									



	(20 минут).
3. Бүлгийн танилцуулга (бүлэг тус бүр 5 минут) ба хэлэлцүүлэг (бүлэг тус бүр 10 минут), нийт: 45 минут	<ol style="list-style-type: none">4. Бүлэг тус бүр (улсын /аймгийн /сумын) өөрсдийн нэн тэргүүний гэж үзсэн асуудлуудыг оролцогчдод танилцуулна (бүлгийн танилцуулга нэг бүлэгт ойролцоогоор 5 минут).5. Хэлэлцүүлгийг хөтлөгч бүх оролцогчдыг тухайн асуудлуудыг хүлээн зөвшөөрсөн, хүлээн зөвшөөрөөгүй эсвэл түвшин бүрээр гаргасан нэн тэргүүний асуудлуудын жагсаалт хүлээн зөвшөөрөгдсөн эсэхийг баталгаажуулж хэлэлцэнэ (түвшин бүрийн хэлэлцүүлэг, бүлэг тус бүрт 10 минут).6. Хэлэлцүүлгийг хөтлөгч оролцогчдын гаргасан санал/бодлыг бүх оролцогчид харах боломжтой байдлаар тусдаа дэлгэц цаасан дээр тэмдэглэж авна.
4. Хэлэлцүүлгийг хөтлөгч түвшин тус бүрээр 5 чухал асуудлуудыг оролцогчдод нэгтгэн танилцуулаад шийдэгдээгүй аливаа санал зөрөлдөөн байвал тэмдэглэж авна. (5 минут)	



Талуудтай зөвлөлдөх бүсийн хоёр дахь хэлэлцүүлэг

Талуудтай зөвлөлдөх бүсийн хоёр дахь хэлэлцүүлэг нь эхний хэлэлцүүлэгтэй адил хэлбэрээр явагдсан бөгөөд улсын хэмжээнд олон оролцогч талуудыг хамруулан 2014 оны 2-р сарын 20-28-ны хооронд цуврал уулзалтуудыг зохион байгуулсан юм.

Зорилго

Хоёр дахь хэлэлцүүлгийн үндсэн зорилго нь:

- Өнөөдрийг хүртэл хийсэн ажлыг тоймлон танилцуулах.
- Уул уурхайн хөгжлийн бодлогын хувилбаруудыг танилцуулах.
- Өндөр, дундаж, бага өсөлттэй хувилбарууд тус бүрээр улсын, аймгийн болон сумын түвшинд уул уурхайн салбартай холбогдон гарах байгаль орчин, нийгмийн асуудлуудыг (гарах үр ашиг, хожих, хохирох, алдах зүйлс) оролцогчидтой зөвшилцөн, харилцан ярилцах зэрэг байв.

Оролцогчид

Эхний хэлэлцүүлгүүдэд оролцсон оролцогчид, талуудтай зөвлөлдөх бүсийн хоёр дахь хэлэлцүүлэгт мөн оролцов.

Баянхонгор аймгаас Цогтцэций явах зам нь Улаанбаатар хүрснээс хүндрэлтэй байсан тул тус аймгийн оролцогчид Улаанбаатар хотод зохиогдсон бүсийн хоёр дахь хэлэлцүүлэгт оролцлоо.

Мөн Өмнөговь аймгийн Цогтцэций суманд зохиогдох байсан бүсийн хоёр дахь хэлэлцүүлэг нь шүлхий өвчний улмаас тогтоосон хөл хориотой холбоотойгоор хоошилсон тул бүсийн энэ хэлэлцүүлгийн үр дүнг 2014 оны 3 сард хүргүүлсэн Уул уурхайн салбарын бодлогын хувилбаруудын тухай тайланд тусгаж чадаагүй юм. Гэсэн хэдий ч хэлэлцүүлгийг сүүлд нөхөн зохион байгуулж үр дүн, саналыг БОНСУ-ий энэхүү эцсийн тайланд бүрэн тусгасан болно.

Уулзалтуудад оролцогсдын тоог доорх хүснэгтэнд харуулав.

Хавсралтын хүснэгт А.5 Талуудтай зөвлөлдөх бүсийн хоёр дахь хэлэлцүүлэгт оролцогсдын тоо

Бүс нутаг	Уулзалт болсон газрууд	Оролцогсдын тоо
Баруун	Ховд	23
Говь	Цогтцэций	24
Зүүн	Чойбалсан	18
Хойд	Эрдэнэт	14
Хангай болон Төв	Улаанбаатар	35

Талуудтай зөвлөлдөх бүсийн хоёр дахь хэлэлцүүлэгт оролцогчдын жагсаалтыг Хүснэгт А1 Уулзалтанд оролцогчдын нэрс-ээс харна уу.

Хэлэлцсэн гол асуултууд

Талуудтай зөвлөлдөх бүсийн анхны хэлэлцүүлгийн үр дүнг тусган өнөөг хүртэл хийсэн ажлаа энэхүү хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр тоймлон танилцуулснаар хэлэлцүүлэг эхэлсэн бөгөөд дараагаар нь оролцогчдод уул уурхайн хөгжлийн хувилбаруудын талаарх танилцуулгыг хийв.

Оролцогчид нэг нь тус бүр 5 хүртэл хүнтэй бүлгүүдэд хуваагдаж, сум, аймаг болон улсын хэмжээнд тухайн хөгжлийн хувилбарууд тус бүрийн хувьд бий болж болзошгүй гол гол асуудлуудыг тодорхойлох ажлыг хийсэн юм. Тавьсан асуултуудын дагуу ажиллах боломжийг хангах үүднээс оролцогчдод зориулсан хөгжлийн хувилбаруудыг харуулсан газрын зургуудыг бэлдэн тараалаа (хөгжлийн хувилбарыг харуулсан газрын зурагт багтаасан мэдээлэл, мөн энэ зургийн дагуу оролцогчид тухайн хувилбар бүртэй холбогдох нөлөөллийг хэрхэн үнэлсэн мэдээллийг тайлангийн дараагийн хэсэгт оруулав). Тус газрын зургийг ашиглан бүлгүүд олон асуудлуудыг авч хэлэлцсэн бөгөөд газрын зураг дээр болон дэлгэц цаасан дээр доорх асуултуудын дагуу саналаа бичсэн юм (доор хавсаргав):

- Ирэх 10 жилийн хугацаанд сум, аймаг, болон улсын хэмжээнд уул уурхайн хөгжлийн хувилбар бүрийн хувьд байгаль орчин, нийгмийн ямар үр ашиг бий болох вэ? Тус хувилбарын хувьд хожих, хохирох, алдах, олох зүйлс юу байх вэ?
- Тус хөгжлийн хувилбарын хувьд хэн "хожих"/"хохирох" вэ?
- Энэхүү хувилбарын хувьд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хамгийн чухал үнэт зүйлс юу байх вэ?
- Тус хувилбараар хөгжих явцад юуг алдаж, орхигдуулж болохгүй вэ?



Хавсралтын фото зураг А.2 Хэлэлцүүлэгт оролцогчид хөгжлийн хувилбаруудын талаар ярилцаж байгаа нь

Оролцогчдод туслах зорилгоор, бүлгүүдэд нэмэлт жишээ асуултууд бүхий материал тараасан ба ингэснээр оролцогчдыг идэвхжүүлэн харилцан ярилцах боломжоор хангасан болно (доор хавсаргав).



Хавсралтын шигтгээ А.1 Хөгжлийн хувилбарыг харуулсан газрын зурагт орсон мэдээлэл

Хөгжлийн хувилбарыг харуулсан газрын зурагт орсон мэдээлэл

- Он, хамрах хүрээ, тухайн газрын биологийн төрөл зүйлийн онцлог төлөв байдал;
- Газрын гадарга болон гадаргын ус;
- Мал аж ахуй, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг уул уурхайн бүс нутгийн эдийн засгийн үндсэн үйл ажиллагаа;
- Ирэх арван жилийн хугацаанд хэрэгжих уул уурхайн төсөл болон одоо хэрэгжиж байгаа уул уурхайн төслүүд;
- Уул уурхайгаас бэлчээр болон мал сүргийн нүүдэл, шилжилтэнд нөлөөлж, түрэн орж ирж байгаа байдал;
- Хувиараа ашигт малтмал олборлох явдал дэлгэрснээр гол усны тогтолцоо болон өөр бусад байгалийн тогтолцоонд учруулсан хохирол;
- Түүхэн уул уурхайн талбай;
- Одоо байгаа дэд бүтэц болон одоо судалж байгаа, санал болгож байгаа зам харилцаа, төмөр зам, цахилгаан эрчим хүчний төсөл;
- Аймаг, сумын түвшинд одоо байгаа болон цаашид бий болох уул уурхайн байгууламж болон хот тосгон;
- Уул уурхайн эргэн тойрны хот суурин газрын хүн ам болон малчдын газрын хүртээмж;
- Малчдын амьжиргаа;

Хэлэлцүүлгийн хөтөлбөр

Талуудтай зөвлөлдөх бүсийн хоёр дахь хэлэлцүүлгийн хөтөлбөрийг доор хавсаргав.

Үр дүнгийн хураангуй

Талуудтай зөвлөлдөх бүсийн хоёр дахь хэлэлцүүлгүүдийн үеэр өндөр болон бага өсөлттэй хувилбаруудын хувьд уул уурхайн салбартай холбогдон үүсэх гол нөлөөллүүдийг үнэлсэн болно. Түүнчлэн оролцогчид хөгжлийн хувилбар бүрийн хувьд гарах үр ашиг, энэхүү үр ашгийг хүртсэнээр алдах, хохирох, хожих зүйлсийг мөн тодорхойлов. Ингэснээр асуудлыг өргөн хүрээнд харах боломж олдох ба мөн БОНСУ-г төслийн түвшний байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнээс ялгаатайг харуулж байгаа юм. Доорх хүснэгтэнд хэлэлцүүлгийн үеэр танилцуулсан уул уурхайн хөгжлийн хувилбаруудтай холбоотойгоор оролцогчдын тодорхойлсон гол гол асуудлуудын хураангуйлан харуулав.

Хавсралтын хүснэгт А.6 Талуудтай зөвлөлдөх бүсийн хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр оролцогчдоос ирүүлсэн саналууд

Өсөлтийн хувилбар	Ирэх 10 жилийн хугацаанд уул уурхайн хөгжлийн хувилбар бүрийн хувьд байгаль орчин, нийгмийн ямар үр ашиг бий болох вэ? Тус хувилбарын хувьд хожих, хохирох, алдах, олох зүйлс юу байх вэ?	Тус хөгжлийн хувилбарын хувьд хэн "хожих" вэ?	Тус хөгжлийн хувилбарын хувьд хэн "хохирах" вэ?	Цэвэр гарах үр ашиг
Сумын түвшинд				
Өндөр өсөлт	<ul style="list-style-type: none"> - Байгаль орчны тогтвортой байдал буурсан байна; - Нийгмийн дэд бүтэц болон төрийн үйлчилгээ сайжирсан байх бөгөөд гэхдээ, хүн ам нэмэгдсэнээс болж гэмт хэрэг ихэссэн байна; - Уламжлалт мал аж ахуй алдагдаж, соёл уламжлал алдагдана; - ЖДҮ хөгжин бизнесийн боломж сайжирч, хөдөлмөр эрхлэлт дээшилснээр, хөдөө орон нутгийн оршин суугчдын орлого нэмэгдэнэ; - Зам харилцаа, хашаа, уул уурхайн үйл ажиллагаа зэргээс шалтгаалж, малчид, мал сүргийн хөдөлгөөн хязгаарлагдаж, улмаар, амьдралын хэв маяг өөрчлөгдөнө; - Уул уурхайн ажлын байр нэмэгдсэнээс, малчид, тариаланчдын хүнсний хангамжид нөлөөлнө. Малчид, тариаланчдын тоо буурснаас, импортын хүнсний бүтээгдэхүүнээс хамаарах явдал нэмэгдэнэ. - Хөрсний элэгдэл, тоосжилт нэмэгдэж, бэлчээрийн дутагдал бий болно; - Шинэ хот, суурин газрууд бий болно; - Эдийн засаг өссөнөөс, боловсрол, эрүүл мэнд сайжирна; - Олон улсын харилцаа сайжирна; - Гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, олон улсын тавцанд Монгол улсын нэр хүнд нэмэгдэнэ; - Сумаас аймгийн төв, Улаанбаатарыг чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөн буурна; - Хэрвээ аливаа шийдвэрийг Засгийн газраас бүгдийг төлөөлөн хийх бол, сум ямар ч ашиг тус хүртэхгүй; 	<ul style="list-style-type: none"> - Улс; - Монголчууд; - Сум болон орон нутгийн оршин суугчид; - Уул уурхайн компаниудын удирдлага. 	<ul style="list-style-type: none"> - Сум болон малчид; - Ирээдүй үеийнхэн; - Бүх иргэд. 	<ul style="list-style-type: none"> - Хэрвээ хариуцлагатай уул уурхайн зарчмууд хэрэгжихгүй бол, уул уурхайн хөгжил суманд ямар ч ашиг тус өгөхгүй; - Улс, аймаг, сумын төсөв нэмэгдэнэ; - Орон нутгийн ард иргэдийн амьжиргаа сайжирна; - Орон нутгийн байгаль орчин муудаж, доройтоно.



Бага өсөлт	<p>Байгаль орчны асуудал болон доройтол багасаж, байгаль орчны тогтвортой байдал бий болно;</p> <ul style="list-style-type: none">- Үйлдвэрлэл, эдийн засгийн нөхцөл байдал, дэд бүтэц, үйлчилгээ, уул уурхайн ашиг тус өмнөх хэмжээндээ л байна;- Уламжлалт соёлыг хадгалж, хамгаална;- Нийгмийн үйлчилгээ өмнөх хэмжээндээ л байна;- Сумаас аймгийн төв, Улаанбаатарыг чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэнэ;- Ядуурал нэмэгдэнэ;- Хүн, мал сүрэгт эрүүл амьдрах орчин бий болно;- Сумын эдийн засгийн өсөлт буурч, мал сүргийн борлуулалт буурна;- Дэд бүтцийн хөгжил зогсоно;- Уул уурхайн үйл ажиллагаа явуулж байсан газрууд хаягдаж, нөхөн сэргээлт хийгдэхгүй (эдийн засаг хямарч, уул уурхайн компаниуд нөхөн сэргээлт хийх мөнгөгүй болно);- Уул уурхай багассанаар, байгаль орчныг хамгаалах менежментийн асуудал эн тэргүүний ач холбогдолтой байхаа болих бөгөөд ингэснээр энэ нь байгаль орчинд ерөнхийдөө сөрөг нөлөө үзүүлнэ. Мал аж ахуйд хэтэрхий их анхаарснаар бэлчээрийн даац хэтэрнэ.	<ul style="list-style-type: none">- Орон нутгийн малчид;- Зэрлэг ан амьтад;- Тусгай хамгаалалттай газрууд.	<ul style="list-style-type: none">- Уул уурхайн компаниуд болон хөрөнгө оруулагчид;- Ирээдүй үеийнхэн;- Орон нутгийн ард иргэд болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид;- Жижиг дунд үйлдвэрүүд;- Үйлдвэрлэлийн ашигт малтмалын хэрэглэгчид;- Мэргэжлийн хүмүүс болон мэргэжилгүй хүмүүс.	
Аймгийн түвшин				
Өндөр өсөлт	<ul style="list-style-type: none">- Хэрвээ Хариуцлагатай уул уурхайн санаачилга³⁴ үргэлжилвэл, нийгэм болон байгаль орчны нөлөөлөл ирээдүйд буурна. Усны нөөцийн асуудал чухал тулгамдсан асуудал хэвээр үлдэнэ;- Дэд бүтэц сайжрах бөгөөд гэхдээ, шилжин суурьших, хот суурин газар нэмэгдсэнээс, нийгмийн дэд бүтцийн ачаалал нэмэгдэнэ;- Төмөр зам зэрэг уул уурхайн байгууламж зэрлэг ан амьтдын нүүдэллэн амьдрах хэв маягийг тасалдуулж, зэрлэг ан амьтдын сүргийн тоо толгойг бууруулснаар ховор, зэрлэг ан амьтад сөргөөр нөлөөлнө. Гэхдээ, орон нутгийн төсөв илүү их орлоготой болж, байгаль орчны менежментийг явуулахад дэмжлэг үзүүлнэ. Тиймээс, орон нутгийн удирдлага байгаль орчныг хамгаалах чиглэлээр	<ul style="list-style-type: none">- Улс болон аймаг;- Монголчууд.	<ul style="list-style-type: none">- Байгалийн баялаг буурна.- Усны нөөц болон сүйрсэн дэд бүтцийн улмаас дагуул хот суурин газар руу шилжиж амьдарна.	

³⁴ Тогтвортой хөгжлийн төлөөх хариуцлагатай уул уурхайн санаачилга (ХУУС) нь төр засаг, иргэний нийгэм, уул уурхайн салбар, эрдэм шинжилгээний байгууллагуудын төлөөлөгчдийн байгуулсан, Монгол улсад хариуцлагатай уул уурхайн салбарыг хөгжүүлэх зорилго бүхий ашгийн бус, төрийн бус байгууллага болно. ХУУС нь 2006 онд хариуцлагатай уул уурхайн талаар хэлэлцэж ярилцсан олон оролцогч талуудын эхний уулзалтын үр дүнд бий болж байгуулагдсан билээ. Эдгээр ажлын бүлгүүд нь хариуцлагатай уул уурхайн тодорхойлт болон 8 үндсэн зарчмыг боловсруулсан бөгөөд эдгээрт үндэслэж, Хариуцлагатай уул уурхайн тунхаглалыг гаргасан байна. Энэ нь Хариуцлагатай уул уурхайн санаачилгыг бий болгох суурь үндэс болсон. 60 гаруй байгууллагууд Хариуцлагатай уул уурхайн тунхаглалыг дэмжиж байгаагаар илэрхийлсэн байна.



	<p>зарцуулах төсөв хөрөнгөтэй болж, экологийн тогтолцоог хамгаалах байгаль орчны төслийг хэрэгжүүлнэ;</p> <ul style="list-style-type: none">- Төмөр зам барьснаар орон нутаг ашигт тус хүртэх боловч амьтдын амьдрах орчинд нөлөөлнө. Түүнчлэн ЖДҮ хөгжих, замын зардал багассанаар бараа бүтээгдэхүүний үнэ буурах зэрэг ашиг тус гарна. Аюулгүй байдал болон тээвэрлэлт түргэн шуурхай болсноор хүнсний аюулгүй байдал сайжирна. Гэхдээ зам тээврийн осол аваар нэмэгдэнэ;- Бизнесийн болон хөдөлмөр эрхлэх боломж дээшлэхийн хэрээр амьжиргааны түвшин сайжирна. Гэхдээ, гэмт хэрэг нэмэгдэх, гэр бүл тогтворгүй болох, хүмүүсийн харилцаа өөрчлөгдөх зэргээр сөрөг үзэгдэл нэмэгдэнэ;- Үйлдвэрийн парк бий болон дэд бүтэц хөгжсөнөөр нүүж ирэх хүмүүсийн тоо нэмэгдэнэ. Хүн амын тоо нэмэгдсэнээр аймгуудад дарамт нэмэгдэж (усны нөөцийн ашиглалт г.м.) гэмт хэргийн тоо, халдварт өвчин, осол аваарын тоо нэмэгдэнэ;- Өөр бусад салбарыг орхигдуулан байж уул уурхай ихэд хөгжинө;- Эрсдлийг бууруулах үүднээс эдийн засгийн төрөлжүүлэх санаачлагыг дэмжих нь чухал болно;- Өөр бусад салбарт хөрөнгө оруулалт ихсэж, боловсролын түвшин нэмэгдэнэ. Шинэ болон өндөр технологийг хаа сайгүй ашигладаг болно (уул уурхай, эрүүл мэндийн салбар г.м.);- Хүн амын тоо нэмэгдсэнээр нийгмийн салбар ихээхэн хөгжих бөгөөд гэхдээ нөгөө талаар хүний эрхтэй холбоотой асуудал болон нийгмийн асуудал нэмэгдэнэ.			
Бага өсөлт	<ul style="list-style-type: none">- Газрын гадарга хэлбэрийг нөхөн сэргээнэ. Экологийн тэнцвэр сэргэж, бэлчээрийн талбай нэмэгдэнэ;- Энэ тохиолдолд бий болох байгаль орчны хохирол нь ой модгүй болох явдал бөгөөд орон нутгийн хүмүүс ойрхон байрлах нүүрсний уурхай алга болох үед модыг түлш байдлаар ашиглаж эхэлнэ;- Ажилгүйдэл нэмэгдэж, аймгийн орлого буурч, амьжиргаа улам бүр доройтож, жижиг дунд бизнесүүдийн боломж алга болно. Гэхдээ нөгөө талаар гэмт хэрэг, хууль бус үйл ажиллагаа багасана;- Орон нутгийн хөгжил саарч, ёс заншил, уламжлал хадгалагдана. Хүн болон мал сүргийн амьдрах орчин эрүүл байх бөгөөд гэхдээ уул уурхайгаас олох орон нутгийн орлого буурна;- Уул уурхайн үйл ажиллагаа багассанаар, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлж, тусгай хамгаалалттай газрын тоо нэмэгдэх, байгалийн баялгийн тогтвортой ашиглалт, газрын хэлбэр, гадаргыг хамгаалах зэрэг үр дүн гарна. Гэсэн хэдий ч, уул уурхайн салбарын хөгжил удааших нь байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Өөрөөр хэлбэл, зарим уул уурхайн компаниуд санхүүгийн бэрхшээлээсээ болж газраа нөхөн сэргээхгүйгээр, уул уурхайн талбайгаа хаях	<ul style="list-style-type: none">- Аймаг;- Оршин суугчид;- Малчид,- Ирээдүй үеийнхэн.	<ul style="list-style-type: none">- Уул уурхайн компаниуд, ажилчид.	



	явдал гарна. Нийгмийн үйлчилгээний хувьд, дэд бүтэц болон үйлчилгээ үзүүлэх явдал хуучин хэмжээндээ л байна. Гэхдээ, аймагт хийх хөрөнгө оруулалт, орон нутгийн төсөвт уул уурхайгаас олох орлого буурч, ажилгүйдэл ихэсэнэ. Энэ нь сургууль цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн үйлчилгээнд сөргөөр нөлөөлнө.			
Улсын хэмжээнд				
Өндөр өсөлт	<ul style="list-style-type: none">- Хөгжил нэмэгдэнэ. Ажилгүйдэл, ядуурал буурна. Хөдөлмөр эрхлэх боломж нэмэгдэнэ. Өндөр технологийг ашиглах явдал нэмэгдэнэ. Боловсрол, мэргэжлийн ур чадварын түвшин сайжирна. Бүх салбарт гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ. Нөгөө талаар, үнэ ханшийн бууралт, үймээн самуун, аюулгүй байдал, уламжлалт амьдралын хэв маяг, соёл зан заншил алга болох зэрэг хөндлөнгийн нөлөө харагдахуйц байдлаар бий болно. Бэлчээр талхлагдах, өвөлжөө хаваржаа устах зэргээр малчдын эрх зөрчигдөнө;- Хөндөгдсөн газруудыг нөхөн сэргээх боловч, байгалийн баялаг болон байгаль орчин өөр болсон байна.	<ul style="list-style-type: none">- Улс;- Монголчууд;- Тусгай зөвшөөрөл эзэмшигчид.		<ul style="list-style-type: none">- Улсын түвшинд цэвэр үр ашиг их гарах ч, сум болон аймгийн түвшинд хожих, хохирох зүйлсийн аль аль нь их байна.
Бага өсөлт	<ul style="list-style-type: none">- Байгаль орчны сөрөг нөлөөлөл буурч, эерэг нөлөөлөл нэмэгдэнэ. Байгаль орчны үр ашиг нэмэгдэх бөгөөд экологийн систем тэнцвэртэй болно;- Гадаадын хөрөнгө оруулалт буурснаас, дэд бүтэц сул хөгжинө. Бага өсөлттэй байх хувилбарт, хөдөө аж ахуй, мал аж ахуй, аялал жуулчлал зэрэг өөр бусад салбарууд хөгжих боломжтой. Нийгмийн нөлөөлөл нэмэгдэнэ, жишээ нь, ажилгүйдэл, хөдөө орон нутгаас хот орон руу шилжих г.м. Хүний хөгжил хоцрогдоно.	<ul style="list-style-type: none">- Байгаль орчин;- Малчид болон мал аж ахуй.	<ul style="list-style-type: none">- Улс, тусгай зөвшөөрөл эзэмшигчид.	



БОНСУ-ий цаашдын ажилд тусган оруулах гол сургамжууд

Монгол улсад өнгөрсөн 10 жилийн турш хамгийн их яригдаж хэлэлцсэн зүйл бол уул уурхайтай холбоотой асуудлууд юм. Ялангуяа, өнгөрсөн хугацаанд өөр бусад аймгийн хүмүүс хоорондоо болон төр засгийн янз бүрийн байгууллагын төлөөлөлтэй уул уурхайн асуудлаар тэр бүр ярилцаад байх боломжгүй байснаас, уул уурхайн нөлөөлөлд өртөгч оролцогчид тус уулзалтын үйл ажиллагааг ихээхэн сонирхож байв. Уулзалтын үеэр хэлэлцэх асуудлаас давж гарсан сэдвээр оролцогчид ярилцах нь олонтоо тохиолдож байлаа. Хэлэлцүүлэг бүрт 4-5 бүлэг байгуулагдаж, бүлэг бүр нь өөрсдийн яриа хэлэлцүүлгийн үр дүнг бусад оролцогчдод танилцуулж байв. Хэлэлцүүлгийг хөтлөгчид нь хэлэлцэх хугацаа дуусч байгаа талаар оролцогчдод байнга сануулж байлаа. Олон бүлэг байсан хэдий ч бүгд танилцуулга хийх нь хүмүүст хоорондоо ярилцаж, хэлэлцсэнээ бусдад танилцуулж, харилцан ярилцах боломжийг олгож байсан сайн стратеги байв.

Ерөнхийдөө хэлэлцэх ярилцах зүйл их байсан учраас, уулзалтыг хоёр өдөр зохион байгуулж болох байсан бөгөөд ингэснээр, оролцогчид хурлын хэлэлцэх асуудлаас давж гарсан асуудлаар харилцан ярилцах боломжийг олгох байсан. Гэхдээ, оролцогчдын цаг хугацааны боломж болон БОНСУ-ий төслийн төсвийн хязгаарлалт зэргээс шалтгаалан урт уулзалтыг зохион байгуулах боломжгүй байв.

Талуудтай зөвлөлдөх бүсийн хоёр дахь хэлэлцүүлэгт ашигласан материалууд

1. Хэлэлцүүлгийн хөтөлбөр;
2. Хэлэлцүүлгийг хөтлөн явуулах заавар;
3. Хэлэлцүүлэгт ашигласан газрын зургийн жишээ;
4. Хэлэлцүүлэгт оролцогчдын нэрсийн жагсаалт (Хавсралтын хүснэгт А.1 Уулзалтанд оролцогчдын нэрс-ийг харна уу).

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН СТРАТЕГИЙН ҮНЭЛГЭЭ
ТАЛУУДАЙ ЗӨВЛӨЛДӨХ БҮСИЙН ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
Улаанбаатар хот, Улаанбаатар зочид буудал, Хархорин танхим
2014 оны 02 сарын 20

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХӨТӨЛБӨР

08:30-09:00	Бүртгэл
Үдээс өмнөх хэлэлцүүлэг	
09:00-09:10	Хурлын нээлт Сюзан Жайлс, Састэйнабилити Ийст Эйжия ХХК-ийн гүйцэтгэх захирал
09:10-09:20	Өмнө хийгдсэн ажлуудын танилцуулга Саха Миянатан, БОНСУ-ий багийн Эдийн засгийн мэргэжилтэн
09:20-10:30	Уул уурхайн салбарын хөгжлийн бодлогын хувилбарууд Саха Миянатан, БОНСУ-ий багийн Эдийн засгийн мэргэжилтэн
10:30-10:45	Цайны завсарлага
10:45-12:30	Хэлэлцүүлэг: Улсын түвшинд уул уурхайн салбартай холбогдон үүсэх байгаль орчин, нийгмийн гол асуудлууд (өндөр, дундаж, бага өсөлттэй хөгжлийн хувилбар тус бүрийн хувьд)
12:30-13:30	Үдийн завсарлага (Өдрийн хоол 1 давхарт рестораны Их танхимд)
Үдээс хойшхи хэлэлцүүлэг	
13:30-15:15	Хэлэлцүүлэг: Аймгийн түвшинд уул уурхайн салбартай холбогдон үүсэх байгаль орчин, нийгмийн гол асуудлууд (өндөр, дундаж, бага өсөлттэй хөгжлийн хувилбар тус бүрийн хувьд)
15:15-15:30	Цайны завсарлага
15:30-17:15	Хэлэлцүүлэг: Сумын түвшинд уул уурхайн салбартай холбогдон үүсэх байгаль орчин, нийгмийн гол асуудлууд (өндөр, дундаж, бага өсөлттэй хөгжлийн хувилбар тус бүрийн хувьд)
17:15-17:20	Төслийн дараагийн үе шатны талаарх танилцуулга



Уул уурхайн салбарын хөгжлийн хувилбаруудтай холбогдон үүсэх байгаль орчин, нийгэм, эдийн засгийн асуудлууд

Хугацаа: 10.45 – 17.15 (завсарлагын хамт)

Хамрах хүрээ (хугацаа)	Гол асуултууд	Үйл ажиллагаа	Ашиглах материал
Сумын түвшин (10.45 – 12.30) (1'45" = 105 минут)	<i>Сумын</i> түвшинд ирэх 10 жилд уул уурхайн хөгжлийн тухайн хувилбартай холбоотойгоор байгаль орчин, нийгмийн ямар үр ашиг гарах вэ? Юу хожисноор юу алдаж, орхигдох вэ?	<ol style="list-style-type: none">Бүлэг бүр 2 зураг ашиглана:<ol style="list-style-type: none">Зураг 1: 2014 он – Дундаж өсөлтЗураг 2: 2025 он – Бага, дундаж, өндөр өсөлтийн хувилбар. Бүлэг бүр өөр өөр зураг (Зураг 2) дээр ажиллана.Хөтлөгч дээрх 2 зургийг бүлэг тус бүрт тайлбарлана. Үүнд, тухайн сумын байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын асуудлууд багтана.¹ <i>Хугацаа: 10 минут</i>Бүлэг тус бүрийн хэлэлцэх асуудал:<ol style="list-style-type: none">Зураг 1-ийг харна уу. Уг зураг 2014 оны нөхцөл байдлыг харуулсан байна. Та өөрийгөө зурагт харуулсан суманд амьдарч байгаагаар төсөөлнө үү (дундаж өсөлт, 2014 он).Уг зурагт харуулсан нөхцөл байдалтай холбоотойгоор байгаль орчин, нийгэм, эдийн засгийн ямар асуудлууд байгааг хэлэлцэнэ үү.Тухайн суманд байгаа байгаль орчин, нийгэм, эдийн засгийн асуудлуудыг зураг дээр дүрслэнэ үү (эсвэл дэлгэц цаасан дээр). Мөн зурагт дүрсэлсэн асуудлуудын талаар бүлгээр хэлэлцэн дэлгэц цаасан дээр бичнэ үү. <i>Хугацаа: 15 минут</i>Дараагаар нь Зураг 2-ийг харна уу. Уг зурагт тухайн сумын хөгжил 2025 онд ямар байхыг төсөөлсөн байна. Та өөрийгөө уг суманд 2025 онд амьдарч байгаагаар төсөөлнө үү.Тус хувилбараар ирээдүйд тухайн суманд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн ямар асуудлууд гарч болох талаар зураг дээр дүрслэнэ үү (эсвэл дэлгэц цаасан дээр). Бүлгээр хэлэлцэх явцдаа уг хөгжлийн хувилбарын хувьд байгаль орчин, нийгмийн ямар үнэт зүйлсийг хадгалж үлдэх нь чухал талаар мөн ярилцана уу. Энд хавсаргасан хэлэлцэх асуудлуудын жишээнээс мөн санаа авч болох юм. <i>Хугацаа: 30 минут</i>Бүлэг тус бүрт тавих асуултууд:<ol style="list-style-type: none">Одоогийн болон ирээдүйн зургуудыг харьцуулан хэлэлцэнэ үү. Уул уурхайн хөгжлийн тухайн хувилбартай холбоотойгоор ямар эерэг үр дүн гарах вэ? Энэхүү эерэг үр дүн гарснаар юу орхигдож, алдагдах вэ? Тус хувилбарын хувьд хэн хожих вэ? Хэн хохирох вэ? Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд хамгийн чухал үнэт зүйлс юу вэ? Алдагдуулж, орхигдуулж болшгүй зүйлс юу вэ? <i>Хугацаа: 20 минут</i>Бусад оролцогчдод үр дүнг танилцуулах:<ol style="list-style-type: none">Хөгжлийн энэхүү хувилбарын хувьд байгаль орчин, нийгмийн хамгийн чухал асуудлуудын талаар тайлбарлана.Тус хувилбараар хөгжвөл байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд алдаж, орхигдуулж болшгүй чухал зүйлс юу вэ? <i>Хугацаа: 30 минут</i>	Зураг 1 (2014 он): <ul style="list-style-type: none">Дундаж өсөлт Зураг 2 (2025 он): <ul style="list-style-type: none">Сум – бага өсөлттэй, эсвэлСум – дундаж өсөлттэй, эсвэлСум – өндөр өсөлттэй хувилбар. Бүлэг бүр дэлгэц цаас, маркер ашиглана (5 бүлэг).



Хамрах хүрээ (хугацаа)	Гол асуултууд	Үйл ажиллагаа	Ашиглах материал
Аймгийн түвшин (13.30 – 15.15)	<i>Аймгийн түвшинд ирэх 10 жилд уул уурхайн хөгжлийн тухайн хувилбартай холбоотойгоор байгаль орчин, нийгмийн ямар үр ашиг гарах вэ? Юу хожисноор юу алдаж, орхигдох вэ?</i>	<p>6. АЙМГИЙН ТҮВШИНД ДАВТАНА: Бүлэг бүр 2 зураг ашиглана:</p> <p>a. Зураг 1: 2014 он – Дундаж өсөлт</p> <p>b. Зураг 2: 2025 он – Бага, дундаж, өндөр өсөлтийн хувилбар. Бүлэг бүр өөр өөр зураг (Зураг 2) дээр ажиллана.</p> <p>7. Хөтлөгч дээрх 2 зургийг бүлэг тус бүрт тайлбарлана. Үүнд, тухайн аймгийн байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын асуудлууд багтана.¹ <i>Хугацаа: 10 минут</i></p> <p>8. Бүлэг тус бүрийн хэлэлцэх асуудал:</p> <p>a. Зураг 1-ийг харна уу. Уг зураг 2014 оны нөхцөл байдлыг харуулсан байна. Та өөрийгөө зурагт харуулсан аймагт амьдарч байгаагаар төсөөлнө үү (дундаж өсөлт, 2014 он).</p> <p>b. Уг зурагт харуулсан нөхцөл байдалтай холбоотойгоор байгаль орчин, нийгэм, эдийн засгийн ямар асуудлууд байгааг хэлэлцэнэ үү (сумын түвшинд хэлэлцсэн асуудлуудыг давтах шаардлагагүй).</p> <p>c. Тухайн аймагт байгаа байгаль орчин, нийгэм, эдийн засгийн асуудлуудыг зураг дээр дүрслэнэ үү (эсвэл дэлгэц цаасан дээр). Мөн зурагт дүрсэлсэн асуудлуудын талаар бүлгээр хэлэлцэн дэлгэц цаасан дээр бичнэ үү. <i>Хугацаа: 10 минут</i></p> <p>d. Дараагаар нь Зураг 2-ийг харна уу. Уг зурагт тухайн аймгийн хөгжил 2025 онд ямар байхыг төсөөлсөн байна. Та өөрийгөө тус аймагт 2025 онд амьдарч байгаагаар төсөөлнө үү.</p> <p>e. Тус хувилбараар ирээдүйд тухайн аймагт байгаль орчин, нийгэм, эдийн засгийн ямар асуудлууд гарч болох талаар зураг дээр дүрслэнэ үү (эсвэл дэлгэц цаасан дээр). Бүлгээр хэлэлцэх явцдаа уг хөгжлийн хувилбарын хувьд байгаль орчин, нийгмийн ямар үнэт зүйлсийг хадгалж үлдэх нь чухал талаар мөн ярилцана уу. Энд хавсаргасан хэлэлцэх асуудлуудын жишээнээс мөн санаа авч болох юм. <i>Хугацаа: 30 минут</i></p> <p>9. Бүлэг тус бүрт тавих асуултууд:</p> <p>a. Одоогийн болон ирээдүйн зургуудыг харьцуулан хэлэлцэнэ үү. Уул уурхайн хөгжлийн тухайн хувилбартай холбоотойгоор ямар эерэг үр дүн гарах вэ? Энэхүү эерэг үр дүн гарснаар юу орхигдож, алдагдах вэ? Тус хувилбарын хувьд хэн хожих вэ? Хэн хохирох вэ? Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд хамгийн чухал үнэт зүйлс юу вэ? Алдагдуулж, орхигдуулж болшгүй зүйлс юу вэ? <i>Хугацаа: 25 минут</i></p> <p>10. Бусад оролцогчдод үр дүнг танилцуулах:</p> <p>a. Хөгжлийн энэхүү хувилбарын хувьд байгаль орчин, нийгмийн хамгийн чухал асуудлуудын талаар тайлбарлана.</p> <p>b. Тус хувилбараар хөгжвөл байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд алдаж, орхигдуулж болшгүй чухал үнэт зүйлс юу вэ? <i>Хугацаа: 30 минут</i></p>	<p>Зураг 1 (2014 он):</p> <ul style="list-style-type: none">• Дундаж өсөлт <p>Зураг 2 (2025 он):</p> <ul style="list-style-type: none">• Аймаг – бага өсөлттэй, эсвэл• Аймаг – дундаж өсөлттэй, эсвэл• Аймаг – өндөр өсөлттэй хувилбар. <p>Бүлэг бүр дэлгэц цаас, маркер ашиглана (5 бүлэг).</p>
Улсын түвшин (15.30 – 17.10)	<i>Улсын түвшинд ирэх 10 жилд уул уурхайн хөгжлийн</i>	<p>11. УЛСЫН ТҮВШИНД ДАВТАНА: Бүлэг бүр 2 зураг ашиглана:</p> <p>a. Зураг 1: 2014 он – Дундаж өсөлт</p> <p>b. Зураг 2: 2025 он – Бага, дундаж, өндөр өсөлтийн хувилбар. Бүлэг бүр өөр өөр зураг (Зураг 2) дээр ажиллана.</p>	<p>Зураг 2 (2014 он):</p> <ul style="list-style-type: none">• Дундаж өсөлт <p>Зураг 2 (2025 он):</p> <ul style="list-style-type: none">• Улс – бага өсөлттэй,



Хамрах хүрээ (хугацаа)	Гол асуултууд	Үйл ажиллагаа	Ашиглах материал
	тухайн хувилбартай холбоотойгоор байгаль орчин, нийгмийн ямар үр ашиг гарах вэ? Юу хожисноор юу алдаж, орхигдох вэ?	<p>12. Хөтлөгч дээрх 2 зургийг бүлэг тус бүрт тайлбарлана (байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал зэрэг).¹ <i>Хугацаа: 5 минут</i></p> <p>13. Бүлэг тус бүрийн хэлэлцэх асуудал:</p> <p>a. Зураг 1-ийг харна уу. Уг зураг 2014 оны нөхцөл байдлыг харуулсан байна. Улсын хэмжээнд уул уурхайн салбарын нөхцөл байдлын талаар ярилцана уу.</p> <p>b. Уг зурагт харуулсан нөхцөл байдалтай холбоотойгоор байгаль орчин, нийгэм, эдийн засгийн ямар асуудлууд байгааг өргөн хүрээнд бодолцон хэлэлцэнэ үү (сум, аймгийн түвшинд хэлэлцсэн асуудлуудыг давтах шаардлагагүй).</p> <p>c. Улсын хэмжээнд үүсээд байгаа байгаль орчин, нийгэм, эдийн засгийн асуудлуудыг зураг дээр дүрслэнэ үү (эсвэл дэлгэц цаасан дээр). Мөн зурагт дүрсэлсэн асуудлуудын талаар бүлгээр хэлэлцэн дэлгэц цаасан дээр бичнэ үү. <i>Хугацаа: 10 минут</i></p> <p>d. Дараагаар нь Зураг 2-ийг харна уу. Уг зурагт улсын хэмжээнд хөгжил 2025 онд ямар байхыг төсөөлсөн байна Тус хувилбараар ирээдүйд улсын хэмжээнд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн ямар асуудлууд гарч болох талаар зураг дээр дүрслэнэ үү (эсвэл дэлгэц цаасан дээр). Бүлгээр хэлэлцэх явцдаа уг хөгжлийн хувилбарын хувьд байгаль орчин, нийгмийн ямар үнэт зүйлсийг хадгалж үлдэх нь чухал талаар мөн ярилцана уу. Энд хавсаргасан хэлэлцэх асуудлуудын жишээнээс мөн санаа авч болох юм. <i>Хугацаа: 20 минут</i></p> <p>14. Бүлэг тус бүрт тавих асуултууд: Одоогийн болон ирээдүйн зургуудыг харьцуулан хэлэлцэнэ үү. Уул уурхайн хөгжлийн тухайн хувилбартай холбоотойгоор ямар эерэг үр дүн гарах вэ? Энэхүү эерэг үр дүн гарснаар юу орхигдож, алдагдах вэ? Тус хувилбарын хувьд хэн хожих вэ? Хэн хохирох вэ? Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд хамгийн чухал үнэт зүйлс юу вэ? Алдагдуулж, орхигдуулж болшгүй зүйлс юу вэ? <i>Хугацаа: 25 минут</i></p> <p>15. Бусад оролцогчдод үр дүнг танилцуулах:</p> <p>a. Хөгжлийн энэхүү хувилбарын хувьд байгаль орчин, нийгмийн хамгийн чухал асуудлуудын талаар тайлбарлана.</p> <p>b. Тус хувилбараар хөгжвөл байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд алдаж, орхигдуулж болшгүй чухал үнэт зүйлс юу вэ? <i>Хугацаа: 30 минут</i></p>	<p>эсвэл</p> <ul style="list-style-type: none">Улс – дундаж өсөлттэй, эсвэлУлс – өндөр өсөлттэй хувилбар. <p>Бүлэг бүр дэлгэц цаас, маркер ашиглана (5 бүлэг).</p>
Дүгнэлт (17.10 – 17.15)	Байгаль орчин, нийгмийн холбогдолтой гарах үр ашиг, сөрөг нөлөөг бодолцон үзсэнээр хөгжлийн хувилбарт нэр өгнө үү.	<p>Бүлгээр хэлэлцэх асуудлууд:</p> <ol style="list-style-type: none">Хөтлөгч өндөр, дундаж, бага зэрэг өсөлт гэсэн нэрүүдийн оронд тухайн хувилбарт тохирох нэр сонгох ярилцлага өрнүүлнэ.Бүх оролцогчид хэлэлцсэнээр нэр сонгоно.Хөтлөгч оноосон нэрийг тэмдэглэж авна. <p><i>Хугацаа: 15 минут</i></p>	Бүлэг бүр дэлгэц цаас, маркер ашиглана (5 бүлэг).

¹ Бэлдэх зургууд



БОНСУ-ий баг – Бэлдэх шаардлагатай зургийн жагсаалт

	Бага	Дундаж – бага, өндөр өсөлттэй харьцуулах зорилгоор ашиглана	Өндөр
Сум	<ul style="list-style-type: none"> Одоогоор сул зогсолттой 1 том уурхай, эсвэл Уурхайгүй 1 сум 	Одоогийн байдал (2014 он)	<ul style="list-style-type: none"> 1 том уурхай (стратегийн), эсвэл 1 эсвэл хэд хэдэн жижиг уурхай
Аймаг	<ul style="list-style-type: none"> 1 стратегийн/ том уурхай эсвэл Харьцуулах боломжтой хэд хэдэн жижиг уурхай, эсвэл Сул зогсолттой 1 стратегийн уурхай ба жижиг уурхай 	Одоогийн байдал (2014 он)	<ul style="list-style-type: none"> 1 эсвэл хэд хэдэн стратегийн орд, эсвэл Харьцуулах боломжтой хэд хэдэн жижиг уурхай (жишээлбэл, 5+жижиг уурхайнууд)
Улс	<ul style="list-style-type: none"> 30% нь стратегийн орд 1-2 сул зогсолттой уурхай Жижиг уурхайнууд зогсоно (өсөлтөд нөлөөлөхүйц) Бага өсөлт/ шинээр дэд бүтэц баригдахгүй 	Одоогийн байдал (2014 он) - Дундаж өсөлт + одоо байгаа бүх уурхай	<ul style="list-style-type: none"> Бүх стратегийн орд Бүх жижиг уурхай (өсөлтөд нөлөөлөхүйц)

Хэлэлцүүлгийн үеэр ярилцах асуудлууд

Өнөө үед бодит байгаа буюу ирээдүйд үүсч болзошгүй байгаль орчин, нийгмийн ямар асуудлууд байж болох талаар хэлэлцэх үеэр оролцогчид авч үзэж болох зарим асуултуудыг доор жагсаав. Та бүхэн асуулт тус бүрт хариулах АЛБАГҮЙ боловч эдгээрийг бүлэг дотроо хэлэлцүүлэг өрнүүлэхэд ашиглаж болно.

Эдгээр асуултууд нь бүсүүдэд зохион байгуулсан Талуудтай зөвлөлдөх бүсийн анхны хэлэлцүүлгийн үеэр тодорхойлсон 'нэн тэргүүний 5 асуудал'-тай холбоотой юм.

Хөгжлийн энэхүү хувилбар нь байгаль орчинд хэрхэн нөлөөлж болох вэ?

- Усны нөөц – хөгжлийн энэ хувилбарын дагуу усны нөөцийн төлөөх тэмцэл ихсэх үү, буурах үү? Ус ашиглагч бүхэн өөрт шаардлагатай усны нөөцийг ашиглах нөхцлөөр хангагдахын тулд өөр ямар эх үүсвэр хэрэгтэй вэ? Энэ нь хэрэгжих боломжтой юу?
- Амьдрах орчны доройтол буюу амьдрах орчны нөхөн сэргээлт – хөгжлийн түвшний улмаас амьдрах орчин хэсэгчлэгдсэн хуваагдсан үү? Амьдрах орчны энэхүү алдагдлыг нөхөх буюу сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор өөр бусад газар нутгийг хадгалж хамгаалсан үү? Энэ шийдвэрийг хэн гаргадаг вэ?
- Агаарын чанар ба тоосжилт үүсэх/бохирдол – хөгжлийн энэ хувилбарын дагуу агаарын чанарт хэрхэн нөлөөлөх вэ? Энэ хувилбарын хүрээнд агаарын бохирдол/тоосжилтын хүлцэж болох түвшин юу вэ? Нөлөөлөлд хамгийн их өртөгч хэн байх вэ?
- Уул уурхайн компаний байгаль орчны менежмент – менежментийн хэм хэмжээ гэдэг нь аймаг, сумын буюу улсын хэмжээнд гаргах ёстой шийдвэр мөн үү? Компаниуд бүгд өөрсдийн байгаль орчны нөлөөлөлд тогтсон нэг хэм хэмжээний дагуу менежмент хийх шаардлагатай юу? Эдгээр хэм хэмжээг хэрэгжүүлж мөрдүүлэхэд зохих чадавхи бүхий хүн хүч хангалттай бий юу? Хөгжлийн энэ хувилбарын дагуу байгаль орчинд шинэ технологи хэрхэн эерэг буюу сөргөөр нөлөөлөх вэ? Хуримтлагдах нөлөөлөл бий юу?
- Уул уурхайн хуучин талбайн нөхөн сэргээлт – орхигдсон хуучин олборлолтын талбайг хэн нөхөн сэргээх үүрэгтэй вэ? Үүнийг хэрхэн санхүүжүүлэх вэ? Нөхөн сэргээлт явагдсаны дараа эдгээр талбайг хэрхэх вэ?

Ирээдүйн дэд бүтцийн хөгжил ямар байх вэ?

- Ашигт малтмалыг хэрхэн тээвэрлэдэг вэ? Ашигт малтмалыг хаашаа зөөвөрлөдөг вэ? Хэн



зөөвөрлөдөг вэ?

- Газар ашиглалт өөрчлөгдөх: дэд бүтэц барьж байгуулах боломжийг олгохын тулд одоо байгаа буюу шинэ газар нутгийг эвдэлж доройтуулсан/цэвэрлэсэн үү?
- Ийм түвшний тээвэрлэлтийн дэд бүтэцтэй байх үед иргэд/бусад зам ашиглагчдын замын хөдөлгөөний аюулгүй байдал хэрхэх вэ? Зам дээр илүү аюултай байх уу эсвэл бага аюултай байх уу? Аюулгүй байдлыг хэрхэн хангах вэ?
- Үржил шимт газар нутаг хаана байна? Үржил шимт газар нутгуудыг дэд бүтцийн хөгжлөөс хадгалж/хамгаалж үлдэх боломжгүй бол яах вэ?
- Хөгжлийн энэ хувилбарын дагуу бэлчээрийн газруудыг сумын төвүүдтэй ойр буюу төвөөс хол байлгаж болох уу? Энэхүү зай алслалын үр дагавар юу вэ? Бэлчээр ашиглах шийдвэрийг хэн гаргадаг вэ?
- Нийгмийн үйлчилгээг (сургууль, эмнэлэг, спортын талбай гэх мэт) хэрхэн хадгалах вэ? Эдгээр нийгмийн үйлчилгээнд ирэх дарамт тус хөгжлийн хувилбарын хүрээнд их байх уу бага байх уу? Эдгээр үйлчилгээг хүртдэг хүмүүс их байдаг уу, бага байдаг уу? Эдгээрийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд хангалттай хүн бий юу? Эдгээр нийгмийн үйлчилгээний багтаамж чадамжаас давсан илүү олон хүн ам байна уу? Үүнд хэрхэн менежмент хийх вэ? Нийгмийн салбарт уул уурхайн хөгжил хэрхэн тус буюу хор болох вэ?

Ирээдүйн хөгжлийн хувилбарын дагуу олон нийтэд юу тохиолдох вэ?

- Уул уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаа газрын орон нутгийн иргэд хэрхэн ашиг тус хүртэж чадах вэ? Уул уурхайн үйл ажиллагаа явагддаггүй газрын орон нутгийн иргэд яах вэ? Орон нутагт үүсэх ашиг орлогоос хүмүүс 'алдах' уу 'хожих' уу? Орон нутгийн иргэд хэрхэн ашиг тус хүртэх тухай хэн шийдвэр гаргах вэ?
- Ирээдүйд хүний эрхийг хэрхэн хангах вэ? Нөөц баялаг бүх иргэдэд эн тэнцүү хүртэж байна уу? Буулт бий юу? Зарим хүмүүс буюу бүлгүүд бусдын эрх ашгийн төлөө хохирч үлддэг үү?
- Уламжлалт амьдрал ахуй, соёл нь ирээдүйн хөгжлийн хувилбарт хадгалагдан үлдэх үү? Уламжлалт амьдрал ахуйн ямар талыг хадгалж үлдэх боломжтой вэ? Юу алдаж магадгүй вэ? Юу хожих боломжтой вэ?
- Ирээдүйн хөгжлийн хувилбараас үүсэх эрүүл мэнд, аюулгүй байдлын ямар асуудлууд байна вэ? Орон нутгийн иргэдэд аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдлын асуудал авчрах шилжин ирэх хүн ам байна уу? Өөр аймаг сумаас мөн гадаад орноос шилжиж ирэн орон нутгийн иргэдийн эрүүл мэндийн нөхцөл байдлыг өөрчлөх ажилчид байна уу? Хөгжлийн түвшин нь орон нутгийн иргэд шим тэжээлээр илүү баялаг хоол хүнсний хангамжаар сайжрах явдалтай уялдах уу?
- Энэхүү хөгжлийн хувилбар орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийн тоо, төрлийг хэрхэн өөрчлөх вэ? Ажлын байрны төрөл нэмэгдэх үү, буурах уу? Тухайн газар нутагт бизнес эрхлэх боломж нэмэгдэх үү, эсвэл буурах уу?
- Ирээдүйн хөгжлийн хувилбарт бичил уул уурхай эрхлэгчид хэрхэх вэ?


Анхаарах зүйлс: ирээдүйн хөгжлийн хувилбаруудын хүрээнд хэнд, юунд ашигтай болон хортой байх вэ?

- Орон нутаг, аймгийн удирдлагууд ба засгийн газар;
- Орон нутгийн иргэд;
- Уул уурхайн компаниуд;
- Байгаль орчин;
- Улаанбаатар хотын иргэд;
- Зэрлэг амьтдад чухал газрууд;
- Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид ба орон нутгийн бизнесүүд;
- Уул уурхайн бүтээгдэхүүний хэрэглэгчид;
- Зэрлэг амьтад;
- Шилжин ирэх хүн ам;
- Шилжин нүүх хүн ам;
- Ядуу, эмзэг бүлгийн хүмүүс;
- Мэргэшилтэй, мэргэшилгүй хүмүүс;
- Мал сүрэг;
- Соёл уламжлал;
- Өөр бусад зүйлс.



Хавсралтын зураг А.1

Хэлэлцүүлэгт ашигласан газрын зургийн жишээ





3, 4-Р ҮЕ ШАТ

Уг шатанд БОНСҮ-ий төслийн эцсийн тайлангийн төсөлд багтсан зөвлөмжүүдийг талуудтай хэлэлцэх зорилгоор Төслийн үр дүнг хэлэлцэх үндэсний зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан юм. Тус уулзалтанд өмнөх зөвлөлдөх уулзалтуудад оролцож байсан оролцогчид мөн оролцсон болно.

Мөн энэ шатанд Уул уурхайн яамнаас зохион байгуулсан Нээлттэй өдөрлөгт БОНСҮ-ий төслийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор төслийн баг уригдан оролцсон бөгөөд уг өдөрлөг нь Улаанбаатар хотын Чингис хааны талбайд болсон юм. Энэхүү арга хэмжээнд оролцсоноор иргэдэд төслийн танилцуулгыг тараан тэдний сонирхсон асуултанд хариулах, санал бодлыг нь сонсох боломж олдсон билээ.

Зөвлөмж боловсруулах үе шатанд ашигласан материалууд

1. Хэлэлцүүлгийн хөтөлбөр;
2. Хэлэлцүүлэгт оролцогчдын нэрсийн жагсаалт (Хавсралтын хүснэгт А.1 Уулзалтанд оролцогчдын нэрс-ийг харна уу);
3. Уул уурхайн яамны Нээлттэй өдөрлөгт ашигласан танилцуулга.



SUSTAINABILITY

EAST ASIA LLC



УУЛ
УУРХАЙН
ЯАМ



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

**УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН СТРАТЕГИЙН ҮНЭЛГЭЭ
ТӨСЛИЙН ҮР ДҮНГ ХЭЛЭЛЦЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ**
Улаанбаатар хот, Улаанбаатар зочид буудал, Хөх Асар танхим
2014 оны 6 дугаар сарын 12

ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТЫН ХӨТӨЛБӨР

08:30-09:00	Бүртгэл
Үдээс өмнөх хэлэлцүүлэг	
09:00-09:10	Уулзалтын нээлт Б.Нэргүй, Уул уурхайн яамны Уул уурхайн бодлогын хэлтсийн дарга Сюзан Жайлс, Састэйнабилити Ийст Эйжия ХХК-ийн гүйцэтгэх захирал
09:10-09:40	Уул уурхайн салбарын хөгжлийн бодлогын хувилбарууд Док. Саха Миянатан, Байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ (БОНСУ)-ний багийн эдийн засгийн зөвлөх
09:40-10:40	Хөгжлийн хувилбаруудтай холбогдон үүсэх байгаль орчин, нийгэм, эдийн засгийн эн тэргүүний асуудлууд ба шийдвэрлэх арга хэмжээ Док. Дэвид Аннандэйл, БОНСУ-ий багийн ахлагч
10:40-10:55	Цайны завсарлага
10:55-12:30	Шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэх өнөөгийн институци болон хууль эрх зүйн орчны сул талууд ба бодлогын зөвлөмжүүд БОНСУ-ий Үйл ажиллагааны төлөвлөгөө (төслийн хувилбар) Док. Дэвид Аннандэйл, БОНСУ-ий багийн ахлагч Б.Баярмаа, Састэйнабилити Ийст Эйжия ХХК-ийн ахлах зөвлөх
12:30-12:45	Асуулт, хариулт
12:45-13:45	Үдийн завсарлага (Өдрийн хоол 1 давхарт рестораны Их танхимд)
Үдээс хойшхи хэлэлцүүлэг	
13:45-15:30	Хэлэлцүүлэг: БОНСУ-ий Үйл ажиллагааны төлөвлөгөө (Бүлгийн хэлэлцүүлэг)
15:30-15:45	Цайны завсарлага
15:45-17:20	Хэлэлцүүлэг: БОНСУ-ий Үйл ажиллагааны төлөвлөгөө (Бүлгийн хэлэлцүүлгийн үргэлжлэл)
17:20-17:30	Хаалт Док. Дэвид Аннандэйл, БОНСУ-ий багийн ахлагч



SUSTAINABILITY

EAST ASIA LLC

Монгол Улсын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ

БОНСУ гэж юу вэ?

Байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ (БОНСУ) нь бодлогын түвшинд хийгддэг стратегийн үнэлгээ бөгөөд институци, засаглал, улс төрийн тогтолцооны эдийн засаг зэрэг олон чухал асуудлыг хамрахын зэрэгцээ нийгмийн үнэлгээг байгаль орчны үнэлгээтэй ижил хэмжээнд авч үздэгээрээ онцлог юм. Байгаль орчин, нийгмийн менежментийг зөв явуулах нь уул уурхайн салбарын амжилтанд ихээхэн чухал болох нь нэгэнт тодорхой болоод байна.

БОНСУ нь судалгааны ажлыг олон нийтийн оролцооны үйл явцтай хослуулан уул уурхайн салбарын өсөлттэй холбогдон бий болох байгаль орчин, нийгмийн эн тэргүүний асуудлын талаар бодлогын хэлэлцүүлгийг талуудтай өрнүүлдэг. Энэхүү БОНСУ-ий үр дүнд уул уурхайн салбарын шинэчлэлийг дэмжсэн тодорхой зөвлөмжүүд бүхий тайланг боловсруулах юм.

БОНСУ-ий зорилго

Монгол Улс болон ард иргэдэд үзүүлэх байгаль орчин, нийгэм-эдийн засгийн нөлөөлөл, боломжийг тооцон үзсэн, уул уурхайн салбарын тогтвортой бөгөөд эрх тэгш хөгжлийг дэмжихэд Монгол Улсын Засгийн газраас эн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлох.

Зорилтууд:

- Монгол Улсын уул уурхайн салбарын хурдацтай өсөлт хөгжилтэй холбоотойгоор гарах байгаль орчин, нийгмийн гол асуудлууд болон боломжуудыг тодорхойлох.
- Уул уурхайн салбарт хийгдэж буй шинэчлэл, хууль эрх зүйн орчныг сайжруулах ажлуудын талаар мэдээлэх;
- Монгол Улсын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг сайжруулах талаар тодорхой арга хэмжээг санал болгох.

БОНСУ-г гүйцэтгэх хугацаа

2013 оны 10 сараас 2014 оны 7 сар.

БОНСУ-ий санхүүжилт

Тус үнэлгээг гүйцэтгэх ажлыг Уул уурхайн яам Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа болно.

БОНСУ-г гүйцэтгэгчийн тухай

Састэйнабилити Ийст Эйжия ХХК нь Монгол Улсын уул уурхайн салбарт байгаль орчин, нийгмийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг тэргүүлэх компаниудын нэг бөгөөд энэхүү БОНСУ-г гүйцэтгэхээр сонгогдсон болно.

Састэйнабилити компани нь 2001 оноос Монгол Улсын байгалийн нөөцийн салбарт үйл ажиллагаа явуулж байна. Бид олон улсын стандартад нийцэх байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг хангасан төслүүдийг Монгол Улсад хэрэгжүүлэх өргөн мэдлэг, туршлага бүхий компани юм.

БОНСУ-ий гол алхамууд

ҮЕ ШАТ 1: НӨХЦӨЛ БАЙДАЛ БОЛОН ТАЛУУДЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ:

- 1.1 БОНСУ-ий Ажлын төлөвлөгөөг боловсруулах.
- 1.2 Талуудын дүн шинжилгээг гүйцэтгэх.
- 1.3 Ажлын төлөвлөгөөг хэлэлцэх үндэсний зөвлөлдөх уулзалт.
- 1.4 Уул уурхайн салбарын хөгжлийн бодлогын хувилбаруудыг тодорхойлох.
- 1.5 Уул уурхайн салбарын хөгжилтэй холбогдон бий болох байгаль орчин, нийгмийн гол асуудлуудыг тодорхойлох.

ҮЕ ШАТ 2: БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН АСУУДЛУУДЫГ ЭРЭМБЭЛЭХ.

- 2.1 Байгаль орчны асуудлуудыг эрэмбэлэх.
- 2.2 Нийгмийн асуудлуудыг эрэмбэлэх.
- 2.3 Уул уурхайн салбарын хөгжлийн бодлогын хувилбаруудын талаарх тайлан боловсруулах.

ҮЕ ШАТ 3: ИНСТИТУЦИ, ЧАДАВХИ, УЛС ТӨРИЙН ТОГТОЛЦООНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ:

- 3.1 Хууль эрх зүй, зохицуулалт, институци, чадавхийн сул талын үнэлгээ.

ҮЕ ШАТ 4: ЗӨВЛӨМЖ, ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ:

- 4.1 БОНСУ-ий Үйл ажиллагааны төлөвлөгөө.
- 4.2 Үнэлгээний үр дүнг хэлэлцэх үндэсний зөвлөлдөх уулзалт.
- 4.3 Талуудтай зөвлөлдөх үйл явцыг баримтжуулах.

БОНСУ-ий талаарх танилцуулга

Монголын түүхийн болоод байгаль орчин, уул уурхайн бодлогын хувьд тохиромжтой цаг үед уг БОНСУ-г хийж байна. Монгол улс нь цаашдын хөгжлийн чиглэлээ сайтар удирдан чиглүүлж, ойлгохыг зорьж байгаа учраас энэ цаг хугацааг тохиромжтой цаг үе гэж үзэж байгаа юм. Уул уурхайн салбарын эдийн засгийн ач холбогдол, байгаль орчин, нийгмийн асуудал бэрхшээл зэргээс шалтгаалж тус салбарын ирээдүйд сорилт, бэрхшээл тулгараад байгаа бөгөөд тус БОНСУ-ээр эдгээр бэрхшээлийг даван туулах, уул уурхайн салбар дахь байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг дэмжих тодорхой арга хэмжээг санал болгохоор зорьж байгаа билээ.

Оролцооны үйл явц

БОНСУ-г гүйцэтгэхэд талуудын оролцоо маш чухал юм. Оролцогч талуудтай зөвлөлдсөнөөр орон нутгийн чадавхийг бэхжүүлэх, талуудыг идэвхижүүлэх, уул уурхайн салбартай холбоотой байгаль орчин, нийгмийн асуудлуудыг сайтар ойлгох, тодорхойлох боломжтой. Састэйнабилити тус БОНСУ-г гүйцэтгэж эхэлснээс хойш улс даяар талуудтай зөвлөлдөх олон тооны уулзалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулаад байна. Эдгээрээс дурдвал:

- Тус БОНСУ-г гүйцэтгэх төлөвлөгөө, аргачлалыг танилцуулж хэлэлцүүлэх "Төслийн төлөвлөгөөг хэлэлцэх үндэсний зөвлөлдөх уулзалт".
- Уул уурхайн салбартай холбоотой байгаль орчин, нийгмийн асуудлуудыг тодорхойлж эрэмбэлэх зорилго бүхий "Талуудтай зөвлөлдөх бүсийн анхны хэлэлцүүлэг".
- БОНСУ-ий хүрээнд авч үзсэн уул уурхайн салбарын хөгжлийн хувилбаруудын хувь бий болох байгаль орчин, нийгмийн асуудлууд, мөн тухайн хувилбаруудын хувьд хожих, хохирох зүйлс болоод гарах ашиг тусыг тодорхойлох "Талуудтай зөвлөлдөх бүсийн хоёр дахь хэлэлцүүлэг".
- Уул уурхайн салбар, мөн эмзэг бүлэг зэрэг чухал асуудлуудаар мэдлэг, мэдээлэл бүхий гол талуудтай хийсэн олон тооны ярилцлага орно.

Мөн бид 6 дугаар сард "Төслийн үр дүнг хэлэлцэх үндэсний зөвлөлдөх уулзалт"-ыг зохион байгуулахаар төлөвлөж байгаа ба энэ үеэр БОНСУ-ий үр дүнд боловсруулсан зөвлөмжүүдийг талуудад танилцуулан санал солилцох юм.

БОНСУ-ээс гарах үр дүн

Дээр дурдсан зорилтуудыг биелүүлснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Уул уурхайн салбарын шинэчлэлийн талаарх бодлогын түвшний хэлэлцүүлэг улам өргөжсөн байх.
- Монгол Улсын Засгийн газраас уул уурхайн салбарыг шинэчлэх хугацаанд авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаль орчин, нийгмийн Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан байх.



Энэхүү БОНСУ-тэй холбоотой санал, асуудлаар бидэнтэй холбогдохыг хүсвэл дараах хаягаар хандана уу.

Састэйнабилити Ийст Эйжия ХХК

Сан Бизнес Центр 501 тоот,
Ерөнхий сайд Амарын гудамж-29,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Улаанбаатар

Утас: +976 7011 4921
Имэйл: mongolia@sustainability.net.au
www.sustainability.net.au



Гол талуудтай хийсэн ярилцлага

Гол оролцогч талуудтай хийсэн ярилцлагын зорилго нь уул уурхайн салбарт үүсээд буй байгаль орчин, нийгмийн гол асуудлуудыг судлах, оролцогч талуудтай холбоотой асуудлууд болон ярилцлагад оролцогчийн төлөөлж байгаа бүлгийн ашиг сонирхлыг ойлгох, талууд хоорондын уялдаатай болон зөрчилдөж буй ашиг сонирхлыг судлах, уул уурхайн бодлогын өөрчлөлтөд санал зөвлөмж боловсруулах, цаашдын уул уурхайн бодлого ярилцлагад оролцогчийн төлөөлж буй бүлэгт хэрхэн нөлөөлж болох талаар судлах, БОНСҮ-ээс хүлээж буй үр дүнг тодруулах явдал байв. Гол оролцогч талуудтай хийсэн ярилцлага нь төслийн үйл ажиллагааны турш явагдсан бөгөөд тодорхой үе шаттай холбоогүй болно. Ярилцлагын талаарх мэдээллийг дараах хүснэгтүүдэд оруулав.

Хавсралтын хүснэгт А.7 Ярилцлагад оролцогчдын нэрс:

#	Байгууллага
1	Монголын Уул уурхайн үндэсний ассоциаци
2	Тогтвортой хөгжлийн төлөөх хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ
3	Монголын Байгаль орчны иргэний зөвлөл
